

# “ПАРЛАМЕНТ”

(Судалгааны эмхэтгэл)



## ТОЙМ АГУУЛГА

- Эдийн засаг
- Нийгэм
- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй


UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

“Парламент” судалгааны эмхэтгэл (XXXIV боть)-ийг  
Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргав.

Хянасан: Т.Баярмаа  
Ц.Норовдондог (Ph.D)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл

Хэвлэлийн эх бэлтгэсэн:



## ГАРЧИГ

### I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСАГ

- 1.1 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого ба санхүүжилтийн тогтолцоо: гадаадын зарим орны туршлага  
*И.Жаргалзаяабямба, Р.Нургүл*
- 1.2 Виртуал хөрөнгийн эрх зүйн зохицуулалт ба олон улсын бодлогын чиг хандлага: Монгол Улс болон гадаадын зарим орны туршлага  
*Г.Алтан-Оч (Ph.D), О.Билгүүтэй, Ш.Батцэнгэл, Г.Уянга*
- 1.3 Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний талаарх харьцуулсан лавлагаа: Монгол Улс болон гадаадын зарим орны мэдээлэл  
*Д.Халиун, Ш.Батцэнгэл, И.Жаргалзаяабямба, Р.Нургүл*
- 1.4 Нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт: Монгол Улсын нөхцөл байдал ба гадаадын зарим орны туршлага  
*Ш.Батцэнгэл, О.Билгүүтэй, И.Жаргалзаяабямба, Г.Уянга*
- 1.5 Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн бодлогын асуудал: Монгол Улсын нөхцөл байдал ба гадаадын зарим орны туршлага  
*Д.Халиун, Ш.Батцэнгэл, И.Жаргалзаяабямба, Р.Нургүл*

### II БҮЛЭГ. НИЙГЭМ

- 2.1 Цахим орчинд үйлдэгдэж буй хүчирхийлэл, хүүхэд хамгаалал, эрх зүйн зохицуулалт: олон улсын туршлага  
*Д.Аюуш, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа*
- 2.2 Амьд ба амьгүй донор, насны байдал, түүний ар гэрт үзүүлэх тусламж дэмжлэгийн талаарх олон улсын зөвлөмж ба гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт  
*Д.Амаржаргал (Ph.D), Б.Батцэцэг, О.Нарантуяа*
- 2.3 Ковид-19 ба НҮБ-ын гүйцэтгэсэн үүрэг: лавлагаа, мэдээлэл  
*Д.Амаржаргал (Ph.D), Б.Батцэцэг, Д.Жигваагүнсэл, О.Нарантуяа, Р.Оргилмаа*
- 2.4 Ковид-19 цар тахалтай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний санхүүжилтийн ил тод байдал (авлигын үзүүлэлттэй хамааралтай эсэх)  
*Д.Аюуш, Ш.Батцэнгэл*

### III БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ

- 3.1 Гадаадын зарим орны улсын болон уул уурхайн салбарын дундаж цалингийн талаарх мэдээлэл, лавлагаа  
*Д.Халиун, Р.Нургүл, И.Жаргалзаяабямба*
- 3.2 Морин тойруулгын бооцоот уралдааны эрх зүйн орчны харьцуулсан судалгаа  
*Г.Алтан-Оч (Ph.D), Б.Батцэцэг*
- 3.3 Кибер аюулгүй байдлын олон улсын зохицуулалт  
*О.Билгүүтэй*
- 3.4 Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, дагалдах хууль, журмуудын талаарх лавлагаа, мэдээлэл  
*Р.Нургүл*

## БҮЛЭГ I

---

### ЭДИЙН ЗАСАГ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО БА САНХҮҮЖИЛТИЙН  
ТОГТОЛЦОО: ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*И.Жаргалзаяабямба, Р.Нургүл*

**АГУУЛГА**

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО БА САНХҮҮЖИЛТИЙН  
ТОГТОЛЦОО: ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

**1. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС**

1.1 ЖДҮ-ийг дэмжих талаар төрөөс явуулж буй бодлого, арга хэмжээ, салбарын ерөнхий мэдээлэл

1.2 ЖДҮ-ийг дэмжих төрийн байгууллагын бүтэц, санхүүжилтийн тогтолцоо

1.3 Цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

1.4 Салбарын статистик мэдээнүүд

**2. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС**

2.1 ЖДҮ-ийг дэмжих талаар төрөөс явуулж буй бодлого, арга хэмжээ, салбарын ерөнхий мэдээлэл

2.2 ЖДҮ-ийг дэмжих төрийн байгууллагын бүтэц, санхүүжилтийн тогтолцоо

2.3 Цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

2.4 Салбарын статистик мэдээнүүд

ХАВСРАЛТ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ



## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

### Судалгааны зорилго

Судалгаанд гадаадын зарим орнуудын төрөөс ЖДҮ-ийг дэмжих талаар явуулж буй бодлого, салбарын ерөнхий мэдээлэл болон ЖДҮ-ийг дэмжих санхүүжилтийн эх үүсвэр, санхүүжилтийн тогтолцооны талаарх туршлагыг харьцуулан судалсан.

### Судалгааны хамрах хүрээ

Судалгааны сэдвийн хүрээнд дараах асуудлуудыг авч үзлээ. Үүнд:

- ЖДҮ-ийг дэмжих талаар төрөөс явуулж буй бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, салбарын ерөнхий мэдээлэл
- ЖДҮ-ийг дэмжих төрийн байгууллагын бүтэц, санхүүжилтийн тогтолцоо;
- ЖДҮ-ийн салбарын статистик мэдээлэл;
- ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Судалгааны захиалгад дурдсаны дагуу Казахстан, Солонгос улсуудын туршлагыг дэлгэрүүлэн авч үзэхээс гадна жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр олон улсын түвшинд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, мэдээллийн тоймыг хамруулан авч үзэв.

### Судалгааны арга зүй

Судалгаанд холбогдох хууль тогтоомж, баримт мэдээллийг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх зэрэг арга зүйг ашиглав.

**Түлхүүр үг:** *Жижиг, дунд үйлдвэрлэл, ЖДҮ, бизнес эрхлэлт*

**Keywords:** *Small and medium enterprises, SMEs, entrepreneurship*

### Судалгааны үр дүнгийн тойм

Улс орны эдийн засгийн тогтвортой өсөлт нь жижиг, дунд бизнесийн (ЖДҮ) хөгжлөөс шууд хамааралтай байдаг. ЖДҮ сайн хөгжсөн улс оронд дундаж давхарга, шинэ ажлын байр, "эрүүл" өрсөлдөөний орчин бүрэлдэн бий болж, энэ бүхний үр дүнд тухайн улсын иргэдийн амьжиргааны түвшинд сайн нөлөө үзүүлдэг байна.

ЖДҮ нь улс орны төдийгүй дэлхийн эдийн засагт чухал байр суурь эзэлж байна. Үүнийг олон улсын, бүс нутгийн болон үндэсний хэмжээнд хийсэн янз бүрийн судалгаа, шинжилгээ харуулдаг. Тухайлбал, НҮБ-ын 2020 оны тайланд тэмдэглэснээр, ЖДҮ эрхлэгчдийн ангилалд дэлхийн нийт аж ахуйн нэгжийн 90 орчим хувь багтдаг бөгөөд тэдгээрт хөдөлмөрийн чадвартай хүмүүсийн 70 орчим хувь ажилладаг. Түүнчлэн ЖДҮ нь дэлхийн ДНБ-ний 50 хувийг бүрдүүлдэг ажээ. Европын статистикийн газрын 2017 оны мэдээнд, Европын холбооны санхүүгийн бус салбар дахь аж ахуйн нэгжүүдийн 98.9%-ийг 49-өөс доош тооны ажиллагсадтай жижиг, 0.9%-ийг 50-249 ажиллагсадтай дунд аж ахуйн нэгж эзэлдэг бол нийт компаниудын дөнгөж 0.2% -ийг том компаниуд эзэлсэн гэжээ.<sup>1</sup>

**ЖДҮ-ийн санхүүжилт.** Том корпорациуд, компаниудтай харьцуулахад жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн хувьд бизнесээ санхүүжүүлэх боломж нь хязгаарлагдмал, зардал өндөр байдаг. Энэ нь жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн бизнесээ тогтвортой явуулж, өргөжүүлэх боломжийг хязгаарлан том корпораци, компаниудтай өрсөлдөх чадваргүй болгодог.

<sup>1</sup> <https://ach.gov.ru/upload/pdf/Covid-19-SME.pdf>

Тиймээс төрөөс жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бизнесээ тогтвортой эрхэлж, өргөжүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлого хэрэгжүүлэх шаардлага бий болдог.

Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ дараах үндсэн арга хэрэгслийг ашиглана.

#### 1. Жижиг, дунд аж ахуйн нэгжид зээл олгох

ЖДҮ-ийг дэмжих бодлогын хүрээнд олгох зээлийг 2 аргаар шийдвэрлэдэг.

а. Төсвөөс эсвэл олон улсын санхүүгийн байгууллагын хүрээнд хямд эх үүсвэр бүрдүүлж жижиг, дунд аж ахуйн нэгжид зориулсан бага хүүтэй зээл олгох;

б. Санхүүгийн байгууллагуудад хүүгийн зөрүүг төрөөс нөхөн олгох замаар жижиг, дунд аж ахуйн нэгжийг бага хүүтэй зээлээр хангах;

Жижиг, дунд аж ахуйн нэгжид олгох бодлогын зээлийг **банк**, эсвэл **банк бус санхүүгийн байгууллага**, эсвэл **бичил санхүүгийн байгууллагуудаар** дамжуулан олгодог.

#### 2. Зээлийн батлан даалт гаргах.

Жижиг, дунд, эсвэл старт-ап аж ахуйн нэгжүүдийг эрсдэлтэй гэж үзэн уламжлалт санхүүгийн байгууллагууд зээл олгохоос цааргалах, эсвэл барьцаа хөрөнгө шаардах зэрэг хүндрэлүүд гардаг. **Зээлийн батлан даалтын сан** нь зээлийн эрсдэлийн баталгаа гаргаснаар жижиг, дунд аж ахуйн нэгжид олгох зээлийн хүрэлцээг нэмэгдүүлдэг.

#### 3. ЖДҮ-д зориулсан лизинг үйлчилгээ

Жижиг, дунд аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа явуулах, өргөжүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад нь зориулан лизингийн санхүүжилт олгоно. Голчлон төрөөс тусгайлсан Лизингийн санхүүжилтийн компани байгуулан түүгээр дамжуулж жижиг, дунд аж ахуйн нэгжид олгох лизингийн үйлчилгээг хүргэдэг.

#### 4. Хөрөнгө оруулалтын болон Венчур хөрөнгө оруулалтын сан

Шинээр үйл ажиллагаагаа эхлүүлэх, эсвэл үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь зориулж жижиг, дунд аж ахуйн нэгж, старт-ап бизнесүүдэд зориулж эхлэлтийн капиталд хөрөнгө оруулалт оруулдаг. Аж ахуйн нэгжүүд өөрийн хувьцааний тодорхой хэсгийг Хөрөнгө оруулалт болон Венчур хөрөнгө оруулалтын санд өгч эхлэлтийн капитал буюу хөрөнгө оруулалтын санхүүжилтийг босгодог.

Венчур хөрөнгө оруулалтын сан нь ихэвчлэн ирээдүйд IPO хийх зорилготой жижиг, дунд бизнест хөрөнгө оруулалт хийдэг. Технологийн старт-ап компаниуд венчур хөрөнгө оруулалтын сангаар санхүүжилтээ босгоно.

Төрийн эсвэл хувийн хөрөнгө оруулалт болон венчур хөрөнгө оруулалтын сан байж болно. Хөгжингүй орнуудад хувийн хөрөнгө оруулалт болон венчур хөрөнгө оруулалтын сан голлох үүрэгтэй байдаг бол хөгжиж буй болон буурай хөгжилтэй оронд төрийн хөрөнгө оруулалтын сан болон венчур сан голлох үүрэгтэй байна.

Цөөн тохиолдолд зорилтот аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, борлуулалт, маркетинг болон ашиглалтын зардлыг хязгаарлагдмал хүрээнд төрөөс шууд санхүүжүүлэх бодлого хэрэгжүүлдэг.

Ковид-19 цар тахлын ЖДҮ-д үзүүлж буй нөлөө<sup>2</sup>. Олон улсын валютын сангийн мэдэгдснээр ЖДҮ нь Ковид-19 цар тахлын эдийн засгийн харилцаанд үзүүлэх олон талт сөрөг нөлөөнд онцгой өртөмтгий байна. Нэг талаас, зах зээлийн нийлүүлэлт эрс буурсан. Өөрөөр хэлбэл, цар тахлаас шалтгаалж ажилтнууд өвчтэй, чөлөөтэй байх, эсвэл сургуулиудыг түр хааснаас болж хүүхдүүдээ харахаас өөр аргагүй байдал үүсэх, мөн компаниуд хорио цээрийн арга хэмжээ болон бусад хязгаарлалтаас болж үйлдвэрлэлийн хангамж зогсох, ажиллах хүч хомсдох, хөдөлгөөний хязгаарлалт зэрэг нөхцөл байдлын улмаас үйлдвэрлэлийн хэмжээ буурсан байна. Нөгөө талаас, бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт гэнэтийн огцом буурсан нь орлого буурахад хүргэж, хөрөнгө мөнгөний дутагдлаас болж жижиг, дунд бизнесүүд үйл ажиллагаагаа явуулахад бэрхшээл үүсч байна. Үүний гол шалтгаан цар тахлын халдварын айдас, ажлаас халагдах, эсвэл цалин багасах зэргээс үүдэн хүмүүсийн хувийн орлого хязгаарлагдаж хэрэглээний түвшин өөрчлөгдөж байгаатай холбоотой. Энэхүү нөхцөл байдлын үр нөлөө нь ЖДҮ эрхлэгчдэд илүү хүнд тусч байна.

Улс орнуудын Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээ нь компаниудад Ковид-19 цар тахал болон түүнтэй тэмцэх хариу арга хэмжээний улмаас үүссэн хүндрэл бэрхшээлийг даван туулахад туслах зорилготой юм. Энэ хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн.

- Ажлын цагийг богиносгох, ажилтнуудыг ажлаас түр чөлөөлөх, өвдсөн тохиолдолд чөлөө авахад цалингийн зардалд татаас олгох;
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэл, өр, түрээсийн төлбөрийг хойшлуулах;
- Арилжааны банкуудын ЖДҮ-д зээл олгох чадварыг нэмэгдүүлэх зээлийн баталгааг нэвтрүүлэх, өргөжүүлэх, хялбаршуулах;
- Төрийн байгууллагуудаар дамжуулан ЖДҮ эрхлэгчдэд шууд зээл олгох;
- Орлогын бууралтыг нөхөх зорилгоор ЖДҮ болон бусад компаниудад буцалтгүй тусламж, татаас олгох;
- Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд ажлын болон технологийн (дижитал) шинэ хэв маягт дасан зохицох, хязгаарлалтын арга хэмжээг үл харгалзан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шинэ зах зээл, борлуулалтын суваг олоход туслах бүтцийн арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Хямрал ЖДҮ-д хэрхэн нөлөөлж байгааг хянах, ЖДҮ-тэй холбоотой бодлогын менежментийг сайжруулах тусгай схемийг нэвтрүүлэх.

Түүнчлэн зарим орны Засгийн газрын ЖДҮ-д үзүүлэх дэмжлэг нь борлуулалтын шинэ болон альтернатив зах зээлийг олох, экспортыг дэмжих, дижиталчлалыг дэмжих, зайнаас ажиллах горимд шилжих, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, мэргэжлийн сургалт, давтан сургахад чиглэсэн байна.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагыг тоймлон авч үзье.

### **Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)**

Дэлхий даяар Ковид-19 цар тахлын халдвар тархсанаар БНСУ-ын эдийн засаг урьд өмнө байгаагүй хямралтай тулгарсан. Санхүүгийн болон мөнгөний бодлогыг ашиглан хямралыг даван туулахын тулд Засгийн газар нөөцийн сан, төсвийг нэмэлтээр тодотгож, нийгэм, эдийн засаг, иргэд, аж ахуйн нэгжүүдээ дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн.

<sup>2</sup> <https://ach.gov.ru/upload/pdf/Covid-19-SME.pdf>



Ковид-19 цар тахлын халдварын эсрэг БНСУ-ын 2020 онд авч хэрэгжүүлж буй бодлого нь санхүүгийн дэмжлэгийг 4 багц хэлбэрээр гаргаж, төсвийг нэмэлтээр тодотгож батлуулсан байна. Солонгосын Төв банк банкны хүүгээ 0.25%-иар бууруулсан байна. Засгийн газар гадаад валютын ханшийг тогворжуулах зорилгоор гадаад валютын своп хэлцэлд гарын үсэг зурж, гадаад валютын фьючерсийн арилжааны хязгаарыг нэмэгдүүлж, хямралд өртсөн иргэдэд үзүүлэх тусламжийг хэрэгжүүлжээ<sup>3</sup>.

Солонгос Улс ЖДҮ-ийг дэмжих төрийн байгууллагын бүтцийн хувьд ЖДҮ хариуцсан яам болон агентлагтай байна. ЖДҮ, Гарааны бизнесийн яам нь жижиг, дунд үйлдвэр, бичил бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, инновацийг дэмжихэд чиглэсэн байна. Яам нь тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор харьяа 9 байгууллагыг удирдан чиглүүлдэг. ЖДҮ-ийн тогтвортой өсөлт, хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Агентлаг байгуулагдсан байна. Яам нь ЖДҮ-ийн бичил, жижиг бизнес эрхлэгчид тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд санхүүжилтийн шалгуур, бодлогын зээлжих чадвар, төвлөрсөн бодлого, үр дүн, үнэлэх, хяналт тавих, бүс нутгийн хамтын ажиллагааг хангах, дотоод дахь бизнесийн эргэлтийг хурдасгах, дэд бүцийг дэмжих зэрэг олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна. Зээлийн бодлогод онцгой анхаарч, ЖДҮ-ийг дэмжих бодлого, хөнгөлөлттэй зээлийг олгох, санхүүжилт олгох, аж үйлдвэрийг тогтворжуулахад чиглэсэн дэмжлэгүүдийг хэрэгжүүлдэг.

2020 онд төрөөс коронавирусын халдварын дэгдэлтийг зогсоохын тулд хатуу хязгаарлалтын арга хэмжээг авахаас гадна төсвийн тодотголыг 4 удаа баталснаар өрх гэр, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд туслах, санхүүгийн дэмжлэгийг 4 багцаар нийт 277 их наяд вон (ДНБ-ний 14.4%)-ы хөрөнгийг зарцуулсан байна. Эхний багцад 4 их наяд вонын өртөгтэй яаралтай тусламжийн арга хэмжээнүүд, хоёр дахь багцад хямралд өртсөн өрх гэр, аж ахуйн нэгжид 20 их наяд вон, гурав дахь багцад бизнесийн ачааллыг хөнгөвчлөх, зээлээс чөлөөлөх 50 их наяд вон, дөрөв дэх багцад санхүүгийн зах зээлийг тогтворжуулах 100 их наяд вон, бизнес эрхлэгчдийг санхүүжүүлэх 58.3 их наяд вон, орлого багатай өрх гэр бүлд 9.1 их наяд вон, аж үйлдвэрийг тогтворжуулахад 40 их наяд вон, ЖДҮ цалин, ажилгүй иргэдэд мөнгөн тусламжийг 10.1 их наяд вонын дэмжлэгүүдийг төсвийн тодотголоор батлуулж олгосон байна. Үүнээс үзэхэд, Солонгос улс нь цар тахлын халдварын үед өрх гэр, аж ахуйн нэгж, ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэгээрээ бусдад туршлага болохуйц орны жишээ юм.

### **Бүгд Найрамдах Казахстан Улс (БНКаУ)**

Бизнес эрхлэлтийг дэмжих, түүнд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2010 оноос "Бизнесийн замын зураглал-2020" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь бизнес эрхлэгчдийг дэмжих гол хөтөлбөр юм. Хөтөлбөрийг Үндэсний эдийн засгийн яам хариуцан хэрэгжүүлсэн бөгөөд 2010 оноос хойш 13 мянган төсөлд татаас олгож, 5 мянган төсөлд баталгаа гаргасан. Түүнчлэн 2010-2017 онуудад 900 тэрбум тенгений татвар төлсөн. Мөн хугацаанд 89.1 мянган ажлын байр бий болгож, 13.4 тэрбум тенгетэй тэнцэх хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувь 2015 онд 24.9% байсан бол 2019 онд 31.7% болж өссөн байна.

2019 онд хөтөлбөрт санхүүгийн дэмжлэгийг сайжруулахад чиглэсэн өөрчлөлтүүдийг

<sup>3</sup> <https://ecck.or.kr/wp-content/uploads/2020/03/Tackling-COVID-19-Health-Quarantine-and-Economic-Measures-of-South-Korea.pdf>

оруулсан бөгөөд 2025 он хүртэл сунгах шийдвэр гаргаж доорх үр дүнд хүрэхээр төлөвлөсөн.

- ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувийг хамгийн багадаа 33.8% -д хүргэх;
- Хөтөлбөрт хамрагдагсдын татварын орлогыг 2017 оны түвшнээс 2 дахин өсгөх;
- Хөтөлбөрт оролцогчид шинээр 30 мянган ажлын байр бий болгох;
- ДНБ-ний бүтцэд боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийг хамгийн багадаа 13.4% -д хүргэх;
- Эдийн засагт дунд бизнес эрхлэгчдийн эзлэх хувийг хамгийн багадаа 13.7% -д хүргэх;

Мөн ажлын байр, бизнес эрхлэлтийг дэмжих "Хөдөлмөр", "Бүс нутгуудыг хөгжүүлэх-III", эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн төслүүдэд зээл олгох "Энгийн зүйлийн эдийн засаг" зэрэг хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

Казахстанд бизнес эрхлэх нөхцөл байдал тогтмол сайжирч, бизнес эрхлэгчдийг дэмжих төрийн янз бүрийн механизмууд бий болж байгаа боловч ЖДҮ-ийг хөгжүүлэх боломж бүрэн хангагдаж чадаагүй байна. Төрөөс бизнесийн үйл ажиллагааг дижитал хэлбэрт оруулах, түүнд бизнес эрхлэгчдийг татан оролцуулах, ингэснээр бизнесийн үйл ажиллагааг оновчтой болгон, үйлдвэрлэл, борлуулалтын зардлыг бууруулж, ЖДҮ эрхлэгчдийг дэлхийн зах зээлийн сүлжээнд нэвтрэх боломжийг олгоход анхаарал хандуулж байна.

ЖДҮ-ийг дэмжих төрийн байгууллагын бүтэц, санхүүжилтийн тогтолцоо. Бизнес эрхлэлтийн асуудлыг Үндэсний эдийн засгийн яамны Бизнес эрхлэлтийг хөгжүүлэх газар хариуцан ажиллаж байна. Мөн ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр "Атамекен" үндэсний бизнес эрхлэгчдийн танхим, "Даму" бизнес эрхлэлтийг хөгжүүлэх сан зэрэг байгууллагууд ажиллаж байна.

ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор төрөөс арилжааны банкуудад хөрөнгө байршуулж банкууд эргэлтийн журмаар олгох бөгөөд төрөөс жил бүр шинээр хөрөнгө хуваарилдаг.

ЖДҮ-д санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн гол оператор нь "Даму" бизнес эрхлэлтийг хөгжүүлэх сан юм. Сан нь өөрийн хөрөнгөөр болон орон нутгийн эрх бүхий байгууллагууд, олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөрөнгө босгох замаар санхүүжих хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг. Бүс нутгийн хөтөлбөрийн хүрээнд тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудад 8.5% хүртэл хүүтэй зээл олгоно. Олон улсын хөтөлбөрийн хүрээнд зээлийг зах зээлийн нөхцөлөөр, салбарын хязгаарлалтгүйгээр олгодог.

Цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ<sup>4</sup>. Ковид-19 цар тахлын улмаас тус улсад онцгой нөхцөлийн дэглэм баримтлах болсон. Иймд төрөөс цар тахал болон түүний эсрэг хариу арга хэмжээний улмаас хүнд нөхцөлд орсон ЖДҮ-ийг дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн.

- 2020 оны 3-р сард 3 сарын хугацаанд бүх төрлийн татвар болон бусад заавал төлөх төлбөрийг 3 сарын хугацаатай хойшлуулах, 2020 оны 3-р сарын 20-ны өдрөөс үл хөдлөх хөрөнгийн түрээсийн төлбөрийг 3 сараар зогсоосон.
- ЖДҮ эрхлэгчдэд 600 тэрбум тенгетэй тэнцэх хэмжээний 8 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгосон.

<sup>4</sup> <https://strategy2050.kz/ru/news/kak-malyi-i-sredniy-biznes-vliyaet-na-konkurentosposobnost-kazahstana/>

- "Энгийн зүйлсийн эдийн засаг" төрийн хөтөлбөрийн хүрээнд 1 их наяд (ДНБ-ний 1½ хувь) төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.
- "Бизнесийн замын зураглал" хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд 1.8 их наяд төгрөгийг хуваарилсан.
- Банк болон бусад зээлдүүлэгчдийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, шаардлага хангасан зээлдэгчид Ковид-19 цар тахлаас өмнөх үеийн зээлийн ангиллыг царцаах зэргээр дэмжлэг үзүүлсэн.
- 2020 оны 7-р сарын эхээр дахин хорио цээрийн дэглэм тогтоосны дараа хорио цээрийн улмаас ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээлийн хүүг (6 хувь) бууруулж, эмзэг бүлгийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх хугацааг сунгасан.

"Бизнесийн замын зураглал", ЖДҮ эрхлэгчдэд зориулсан эргэлтийн хөрөнгийг дэмжих зэрэг арга хэмжээг 2021 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО БА САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО: ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

#### 1. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

##### 1.1 ЖДҮ-ийг дэмжих талаар төрөөс явуулж буй бодлого, арга хэмжээ, салбарын ерөнхий мэдээлэл

БНСУ-ын ЖДҮ, Гарааны Бизнесийн Яам (ЖДҮГБЯ) нь жижиг, дунд үйлдвэр, бичил бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, инновацийг дэмжихэд чиглэсэн төрийн байгууллага юм. Дараах гурван чиглэлээр Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Аж ахуйн нэгжүүдийн бизнесийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.
- Шинээр үүсгэн байгуулж буй бизнес эрхлэгчдэд шинэ санааг хөгжүүлж, хөрөнгө оруулалт хийх, хөнгөлөлттэй зээл олгох, санхүүжилт олгодог.
- Бичил аж ахуйн нэгжүүдийг дэмжих, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх зорилгоор бизнесээ амжилттай эхлүүлэх, үйл ажиллагааг амжилттай явуулах боломжийг олгох бодлогын аргуудыг хэрэгжүүлдэг.<sup>5</sup>

Яам нь ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд учирч болох нөхцөлөөс урьдчилан сэргийлэн хууль тогтоомж дүрэм журам, бодлогыг боловсруулан хэрэгжүүлдэг байна. ЖДҮ-ийн омбудсмен, аж үйлдвэртэй холбоотой асуудлуудыг тодорхойлж, бичил, жижиг бизнес эрхлэгчид тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд санхүүжилтийн шалгуур, бодлогын зээлжих чадвар, төвлөрсөн бодлого, үр дүн, үнэлэх, хяналт тавих, бүс нутгийн хамтын ажиллагааг хангах, дотоод дахь бизнесийн эргэлтийг хурдасгах, дэд бүтцийг дэмжих зэрэг олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна.

Мөн үр дүнд чиглэсэн зээлийн бодлогод онцгой анхаардаг. Яам нь урт хугацаатай зээлээр барилга байгууламж барих компаний бизнесийн чадавхаас үл шалтгаалан, ЖДҮ эрхлэгчдэд зээлийг олгодог. Мөн ЖДҮ-ийн ажлын байрыг нэмэгдүүлэх, зээл олгох, зээлийн хүүг бууруулах, зээлийн баталгаа зэрэг хөнгөлөлт үзүүлэхээр төлөвлөж байна. Энэ нь нэг компанид олгох зээлийн хэмжээг хязгаарлаж, зээлийн хөтөлбөрүүдийн үр ашгийг аль болох

<sup>5</sup> <https://www.mss.go.kr/site/eng/01/2010100000002019110619.jsp>

олон компаниудад хүртээх боломжийг олгодог.

ЖДҮГБЯ нь ЖДҮ эрхлэгчдийн бизнесийг дахин эхлүүлэхэд хоёр дахь боломжийг олгох, зардлыг бууруулах, ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх, тогтолцоонд шинэчлэл хийсэн бодлого хэрэгжүүлдэг. Үүнд:

1. ЖДҮ-ийн нөхцөл байдлыг сайтар судалж, дахин эхлүүлэх, сэргэн босох, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
2. ЖДҮ эрхлэгчид гарч болзошгүй алдаанаас урьдчилан сэргийлж бодлого боловсруулж, зөвлөх үйлчилгээ үзүүлж, зээл олгоно.
3. ЖДҮ эрхлэгчид дахин бизнес эхлүүлэх зорилгоор зээл олгох орчинг бүрдүүлж өгнө.

Тус яам нь:

- Хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Бизнесийн орчин (зах зээл, борлуулалтыг өргөжүүлэх);
- Гарааны бизнес (Startups);
- Венчур бизнес (Venture);
- Технологийн шинэчлэл;
- Хүний нөөц;
- Бичил бизнес;
- Уламжлалт зах зээл;
- Хамтын хөгжил дэвшил;
- Орон нутгийн бизнес;
- Экспорт гэсэн 11 чиглэлд ЖДҮ-ийг дэмжих бодлого, хөнгөлөлттэй зээлийг хэрэгжүүлдэг.<sup>6</sup>

ЖДҮ эрхлэгчдэд зориулсан хууль тогтоомж, бодлогуудаас гадна Солонгосын эдийн засгийг сайжруулах зорилгоор инновацийн бодлогыг дэмжихэд чиглэгддэг.

## **1.2 ЖДҮ-ийг дэмжих төрийн байгууллагын бүтэц, санхүүжилтийн тогтолцоо**

Солонгос Улсын хувьд ЖДҮ хариуцсан яам, агентлагтай байна. Үүнд:

- Жижиг Дунд Үйлдвэр, Гарааны Бизнесийн Яам (Ministry of SMEs and Startups Agency-MSS)
- ЖДҮ Гарааны Бизнесийн Агентлаг (Korea SMEs and Startups Agency- KOSME) байна.

ЖДҮГБ-ийн Яам (MSS). БНСУ-ын Засгийн газраас 2017 оны 7 дугаар сарын 26-ны өдөр хуучнаар Жижиг Дунд Бизнесийн Удирдах Газрыг, Жижиг Дунд Үйлдвэр, Гарааны Бизнесийн Яам (Ministry of SMEs and Startups Agency-MSS) болгон шинэчлэн байгуулсан байна.

БНСУ-ын ЖДҮГБЯ (MSS) нь тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор дараах 9 харьяа байгууллагыг удирдан чиглүүлдэг байна. Үүнд:

1. Солонгосын Зээлийн Батлан Даалтын Сангийн Холбоо;
2. Жижиг, Дунд Бизнесийн Корпораци (SBC);
3. Солонгосын Технологи, Мэдээллийн Хөгжлийн Агентлаг (TIIPA);

<sup>6</sup>ЗГ хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГ <https://smefund.gov.mn/news/9/single/436>

4. Жижиг Бизнесийн Дистрибьюшн Төв (SBDC);
5. Жижиг Үйлдвэр, Маркетингийн Үйлчилгээ (SEMAS);
6. БНСУ-ын Гарааны Бизнес ба Бизнес Эрхлэлтийг Хөгжүүлэх Институт (KISED);
7. БНСУ-ын Венчур Хөрөнгө Оруулалтын Корпораци (KVIC);
8. БНСУ-ын Жижиг Бизнесийн Институт (KOSBI);
9. Солонгосын Технологийн Санхүүжилтийн Корпораци (KIBO) болно<sup>7</sup>.

Зураг 1. БНСУ-ийн ЖДҮ-ийн санхүүжилт.

#### БНСУ-ын ЖДҮ-ийн санхүүжилт



Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас 2020 онд гаргасан “Дэлхийн санхүүгийн хямралаас хойш үеийн ЖДҮ-ийн санхүүгийн бодлогууд, хөгжил, хандлагууд” тайланд сүүлийн жилүүдэд БНСУ-ын Засгийн газар технологи инновацийн чадавхыг ашиглах, шинэ төсөл хэрэгжүүлэх арга хэмжээ авч байгаа нь ЖДҮ эрхлэгчид санхүүжилтэд хамрагдах өөрчлөлт хийсэн гэж тэмдэглэсэн байна.

БНСУ-ын Засгийн газраас сүүлийн жилүүдэд мэдлэгт суурилсан, ЖДҮ эрхлэгчдэд олон удаагийн дэмжлэг тусламж үзүүлсэн. БНСУ-ын Хөгжлийн банк IP эрх худалдан авах, худалдах, барьцаалах зорилгоор зээл олгохдоо “Техно банк”-аар хэрэгжүүлдэг<sup>8</sup>.

Солонгосын Зээлийн Батлан даалтын Сан нь зээл олгох, үнэт цаас, тодорхойлох зорилгоор IP үнэлгээний 95%-ийн андеррайтерийн үйлчилгээ үзүүлдэг байна. Солонгосын Оюуны өмчийн газар (KIPO) нь Солонгосын зохион бүтээлийг дэмжих нийгэмлэг (KIPA)-ээр үнэлгээ хийлгэх ба санхүүжүүлдэг байна.

*ЖДҮ ба Гарааны Бизнесийн Агентлаг (KOSME)*<sup>9</sup>. Korea SMEs & Startups Agency (KOSME) нь ЖДҮ эрхлэгчдэд зориулсан санхүүгийн болон санхүүгийн бус хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Агентлаг нь ЖДҮ эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бизнесийн бүтцийг шинэчлэн өөрчлөх зэрэгт санхүүжилт олгодог.

*Жижиг Бизнесийн Институт (KOSBI)*. Жижиг Бизнесийн Институт (KOSBI) нь ЖДҮ-тэй холбоотой асуудлаар үндэсний хэмжээнд судалгаа хийх, ЖДҮ-ийн бодлогыг тодорхойлох,

<sup>7</sup> Ministry of SMEs and Startups <https://www.mss.go.kr/site/eng/01/20104000000002019110651.jsp>

<sup>8</sup> <https://www.oecd.org/industry/smes/Trends-SME-Finance-Policy-July-2020.pdf>

<sup>9</sup> <https://www.mss.go.kr/site/eng/01/20104000000002019110651.jsp>



өсөлтийг хурдасгах, дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор байгуулагдсан судалгааны хүрээлэн юм.

*Гарааны Бизнес ба Бизнес Эрхлэлтийг Хөгжүүлэх Институт (KISED)*. Гарааны бизнес сургалтыг зохион байгуулах, бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх, статистик, судалгаа, бодлого боловсруулах, хүний нөөцийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

*Жижиг Үйлдвэр, Маркетингийн Үйлчилгээ (SEMAS)*. Жижиг үйлдвэр, маркетингийн үйлчилгээ SEMAS нь бичил үйлдвэр болон уламжлалт зах зээлийг дэмжих зорилгоор хоёр их наяд вонын бичил аж ахуйн нэгжүүдийн зах зээлийг дэмжих сан юм. 6 бүсийн төв, 60 төв ажиллуулдаг. Бичил аж ахуйн нэгжүүдийн тогтвортой бизнесийн орчныг хангахын тулд бичил бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт, зөвлөгөө өгдөг.

*Технологи, Мэдээллийн Хөгжлийн Агентлаг (TIPA)*. БНСУ-ын ЖДҮ-ийн Технологи, Мэдээллийн Хөгжлийн Агентлаг (TIPA) нь ЖДҮ-ийн технологийн шинэчлэлийн үндэс суурийг тавих үүрэг хүлээсэн, бодлогын талаар судалгаа хийх, урт хугацааны төлөвлөгөө боловсруулах, инновацийн төслүүдийн эрэлт хэрэгцээг үнэлэх, холбогдох судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн технологийг түгээх, үнэлэх чиг үүрэгтэй.

*Korea Venture Investment Corporation (KVIC)*. Венчур Хөрөнгө оруулалтын Корпораци (KVIC) нь сангийн менежментийн венчур, капиталын зах зээлд тогтвортой хөрөнгийн эх үүсвэр гаргаж, ЖДҮ ба венчур компаниудын өсөлтийг хурдасгадаг.

*Технологийн Санхүүжилтийн Корпораци (KIBO)*. ЖДҮ эрхлэгчдэд технологийн санхүүжилтийг хөнгөвчлөх, үндэсний эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой. KIBO нь барьцаалах хөрөнгийн хязгаарлалттай, өрсөлдөх чадвартай ЖДҮ эрхлэгчдэд зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлдэг.

*Жижиг Бизнесийн Дистрибьюшн Төв (SBDC)*. ЖДҮ эрхлэгчдийн гаргасан төсөл, маркетингийн туслалцаа, онлайннар дамжуулан бизнесийн зах зээлд нэвтрэх сувгийг олоход нь дэмжлэг үзүүлдэг байна.

### **1.3 Цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ**

БНСУ-ын Төрөөс коронавирусийн халдварын дэгдэлтийг зогсоохын тулд хатуу хязгаарлалтын арга хэмжээг авахаас гадна 2020 онд төсвийн тодотголыг 4 удаа баталснаар өрх гэр, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд туслах, санхүүгийн дэмжлэгийг (4 багцаар) нийт 277 их наяд вон (ДНБ-ний 14.4%)-ыг (1\$=1,160.9100 вонтой тэнцэх) хөрөнгө зарцуулсан гэж Сангийн яам дурджээ<sup>10</sup>. Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2020 онд Санхүүгийн дэмжлэгийг 4 багц болгон хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Санхүүгийн дэмжлэгийн эхний багц: (2020 оны 2-р сар): 4 их наяд вонын өртөгтэй яаралтай тусламжийн арга хэмжээ (дотоод болон орон нутгийн татварын бодлогын дэмжлэг; эрүүл мэнд болон эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлтийг дэмжих; түүхий эд туслах материалыг хурдасгах; тархалтад нэрвэгдсэн ЖДҮ эрхлэгчдэд тусламжийн сан, бичил бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн дэмжлэг);

Санхүүгийн дэмжлэгийн хоёр дахь багц: (2-р сарын 28): Өрх гэр бүл тархалтад нэрвэгдсэн үйлдвэрүүдэд 20 их наяд вон (аялал жуулчлал, экспорт) 2020 оны 1-р төсвийн тодотгол (2020 оны 3-р сарын 17): 11.7 их наяд вон (10 тэрбум ам.доллар, ДНБ-ний 0.6%); Шинэ

<sup>10</sup> [South Korea's parliament approves fourth extra budget of 7.8 trillion won | Reuters](#)

зарлагад 10.9 их наяд, орлогод залруулга хийхэд 0.8 их наяд вон - Шинэ зардалд өвчнийг хяналтанд авах, тархвараас урьдчилан сэргийлэх (1 их наяд вон), жижиг бизнес эрхлэгчдэд олгох зээл (4.1 их наяд вон), хэрэглээний купон, өдөр өнжүүлэхэд хамрагдах эрхийн бичиг зэрэг нийгмийн халамж (3.5 их наяд вон) орон нутгийн эдийн засаг (1.2 их наяд вон) зэрэг санхүүгийн дэмжлэгүүд хамруулжээ.

Санхүүгийн дэмжлэгийн гурав дахь багц: (2020 оны 3-р сарын 19): аж ахуйн нэгж, өрх гэр бүлд туслах санхүүгийн дэмжлэгийн багц; бизнес эрхлэгч, зээлдэгчдийн ачааллыг хөнгөвчлөх, зээлээс чөлөөлөх, хямралаас гаргахад (50 их наяд вон) багтаажээ.

Санхүүгийн дэмжлэгийн дөрөв дэх багц: (2020 оны 3-р сарын 24) : бизнес эрхлэгчдийг дэмжих, зах зээлийн тогтвортой байдал, санхүүгийн зах зээлийг тогтворжуулах 100 их наяд вон (80 тэрбум ам.доллар) зэрэг арга хэмжээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх:

- Бизнес эрхлэгчдийг санхүүжүүлэх (58.3 их наяд вон) - яаралтай тусламжийн зээл, баталгаа, ЖДҮ ба аж үйлдвэрийн конгломератад үзүүлэх тэтгэмжийг өргөжүүлэх;
- Корпорацийн бондын зах зээл болон богино хугацааны мөнгөний зах зээлийг тогтворжуулах; бондыг тогтворжуулах сан (20 их наяд вон); компанийн бонд гаргахад нэмэлт санхүүжилт (4.1 их наяд вон); богино хугацааны мөнгөний зах зээлийг тогтворжуулах зорилгоор хөрвөх чадварыг хангах;
- Хөрөнгийн зах зээлийг тогтворжуулах арга хэмжээг шийдвэрлэх; - Хөрөнгийн зах зээлийн капиталжуулах санг байгуулах (10.7 их наяд вон); эрэлтийг нэмэгдүүлэх татварын дэмжлэг;

*Яаралтай тусламж, дэмжлэг:* (2020 оны 3-р сарын 30): орлогын түвшин доогуур 70 хувьд багтсан өрх гэр бүлд яаралтай тусламж дэмжлэг, хоёр дахь төсвийн гүйцэтгэлийн дараа батлагдсан гэр бүлийг (9.1 их наяд вон) үндэслэн гэрчилгээ олгох.

Аж үйлдвэр тогтворжуулах сан: (2020 оны 4-р сарын 22): Засгийн газар 7 гол салбар болох агаарын тээврийн, усан онгоц болон усан онгоцны үйлдвэр, автомашин, машин механизм, цахилгаан эрчим хүч, харилцаа холбооны салбарт 40 их наяд вонын нэмэлт дэмжлэг үзүүлсэн.

*Цалингийн санхүүжилт:* (2020 оны 4-р сарын 22): Жижиг бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд цалин олгох, ажилгүйчүүдэд зориулсан дэмжлэг үзүүлэх; бэлэн мөнгөөр хомсдолтой компаниудад хөрвөх чадварт зэрэг нийт 10.1 их наяд вонын дэмжлэг, санхүүжилт олгосон байна.

2020 оны 2 дахь төсвийн тодотгол: (2020 оны 4-р сарын 30): Үндэсний Ассамблейгаас 12.2 их наяд вонын төсвийн нэмэлт санхүүжилтийг батлав (7.6 их наяд вон байсныг шинэчилсэн) Үүнд: өрх гэр бүлд 1 сая вон хүртэлх тусламж дэмжлэгийн хөтөлбөрийг санхүүжүүлэх, хэрэглээг дэмжих зорилгоор купон болон бэлэн мөнгө хэлбэрээр олгосон тусламжуудыг хамруулжээ.

2020 оны 3 дахь төсвийн тодотгол: (2020 оны 7-р сарын 3) нийт 35.1 их наяд вон (ДНБ-ний 1.8%)-аар батлуулсан: тодотголд (11.4 их наяд вон); компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд 23.7 их наяд вонын нэмэлт зардал; хөдөлмөр эрхлэлт, нийгмийн аюулгүй байдлыг өргөжүүлэх; өвчний хяналтанд авах; дижитал болон ногоон салбарт зарцуулах хөрөнгүүдийг багтаажээ.

2020 оны 7 дугаар сарын 14: Солонгосын шинэ хэлэлцээр: Үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэг болох дижитал эдийн засаг, ногоон технологи, нийгмийн аюулгүй байдлын сүлжээнд 2020

оны төсвийн тодотголоор 6.3 их наяд вон санхүүжилт олгожээ. 2022 онд 67.7 их наяд вонын хөрөнгө оруулалт; 2025 онд 160 их наяд вонын хөрөнгө оруулалт, 1.9 сая ажлын байр бий болгохоор төлөвлөсөн байна.

2020 оны 9 дүгээр сарын 22: Үндэсний Ассамблей 4 дэх төсвийн тодотголыг баталжээ. Жижиг бизнес болон ЖДҮ-ийг дэмжихэд 7.8 их наяд вонын нэмэлт санхүүжилт олгох (3.9 их наяд төсөв); ажил эрхлэлт (1.5 их наяд); бага орлоготой өрх гэр бүлд (0.4 их наяд); өдөр өнжүүлэх болон бусад (2 их наяд) төсөвлөсөн байна.

2021 оны 3 дугаар сарын 2: Жижиг бизнес эрхлэгчид, ажилтнуудыг хөнгөвчлөх, ажил эрхлэлтийг дэмжих, вакциныг нэвтрүүлэх, бага орлоготой өрхүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд 15 их наяд вонын (ДНБ-ний 0.8%) нэмэлт төсөв төлөвлөжээ.

Санхүү: 2-р сарын 27: Солонгосын банк ЖДҮ эрхлэгчид болон жижиг худалдаачдыг дэмжих зорилгоор Банкны Зээл Олгоход Зуучлах Байгууллага (Bank Intermediated Lending Support Facility) мөнгөний дээд хязгаарыг 5-30 их наяд воноор тогтоожээ. (Цаашид 5-р сарын 13-наас 35 их наяд вон болгон өсгөх төлөвтэй)

3 дугаар сарын 16: Солонгосын Банк бодлогын хүүг 50 нэгжээр бууруулж 0.75 хувь болгох шийдвэр гаргасан. ВОК банкнаас жижиг бизнес эрхлэгчдэд олгох зээлийг дэмжих зорилгоор Банкны Зээл Олгоход Зуучлах Байгууллагын хүүг 0.50-0.75%-иас 0.25% болгон бууруулсан.

3 дугаар сарын 19: ВОК нь АНУ-ын Холбооны нөөцийн газартай 6 сарын хугацаанд 60 тэрбум долларын валютын солилцоо хийхээр гэрээ байгуулсан байна. ВОК нь бондын зах зээлийг тогтворжуулах зорилгоор 1.5 их наяд (1.2 тэрбум ам. доллар) вонын Засгийн газрын бонд худалдаж авсан.

**ЖДҮ эрхлэгчдэд:** (шинэчилсэн 2021 оны 1 дүгээр сарын 22)<sup>11</sup>

*Санхүүжилт:* Засгийн газраас 3 дугаар сарын 4-нд ЖДҮ эрхлэгчдэд сар бүр нэг хүнд 70,000 вонын санхүүжилтийг 4 сарын хугацаанд олгохоор болсон байна.

*Татвар төлөлтийн хугацааг хойшлуулах:* 2020 оны 3 дугаар сард тархалтад нэрвэгдсэн ЖДҮ эрхлэгчид татвар төлөлтийг нэг сараар хойшлуулах хүсэлт гаргаж, онцгой нөхцөл байдлын улмаас 9 сараар хойшлуулсан.

Татварыг бууруулах:

- Ковид-19 цар тахлын гамшигт нэрвэгдсэн онцгой бүс нутагт байрладаг ЖДҮ эрхлэгчид, өөрөөр хэлбэл, Дэгү, Гёнсан, Бонхва, Чондо мужуудад 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс ААНОАТ болон бизнесийн татварыг 60 хүртэлх хувиар бууруулсан. Нийт хөнгөлөлтийн дээд хязгаарыг 200 сая воноор тогтоожээ.
- 2020 онд жилдээ 80 сая вонын борлуулалттай хувиараа бизнес эрхэлдэг жижиг бизнес эрхлэгчдэд НӨАТ-ыг бууруулжээ.

БНСУ-ын Засгийн газар эдийн засгийн сэргэлтийг дэмжих зорилгоор 2021 оны төсвийн төслийг нийт 558.8 их наяд воноор төсөвлөж байна. 2021 оны төсвийн төсөл нь 2020 оны төсвийн хүрээний мэдэгдлээс 8.5%-иар өссөн ба 2020 оны төсвийн гүйцэтгэлээс Ковид-19 цар тахлын үед гурван удаагийн нэмэлт төсөв батлуулсантай харьцуулахад 1.6%-иар өссөн. Засгийн газрын орлого нь 2021 онд 1.2% буюу 483 их наяд вон хүрэх төлөвтэй байна.

<sup>11</sup> [Korea COVID19 country profile 230321.pdf \(unescap.org\)](https://www.unescap.org/publications/korea-covid19-country-profile-230321.pdf)



ДНБ-ний 5.4%-тай тэнцэх Засгийн газрын өр хүлээгдэж байна.<sup>12</sup>

БНСУ-ын Засгийн газар нь төсвийг тэлэх, эдийн засгийг нэмэгдүүлэхийн тулд ажил эрхлэлт болон ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үйлдвэр, үйлчилгээний бүтцийн өөрчлөлт, мэдээлэл, сүлжээ, хиймэл оюун ухааны салбаруудыг хөгжүүлэх, аж үйлдвэрийн технологи, инновацийн арга хэмжээнүүдийг онцлон хэрэгжүүлж байна.<sup>13</sup>

#### 1.4 Салбарын статистик мэдээнүүд

Дэлхийн эдийн засгийн төлвийг 2021 оны 1 дүгээр сарын байдлаар шинэчлэн боловсруулахад ОУВС нь БНСУ дахь ДНБ-ний өсөлтийг 2021 онд 3.1%-иар, 2022 онд 2.9%-иар буурна төсөөлжээ. Мөн төсвийн алдагдлыг 2021 онд -1% хэвээр, 2022 онд -1.7%-д хүрнэ гэж таамагласан байна. Улсын өрийг 2020 онд ДНБ-ний 41.9%-иар, 2021 онд 48.4%-иар, 2022 онд 52.2% болон өсөх төлөвтэй байна гэжээ. Инфляцийн түвшин 2020 онд 0.5% байсан бол 2021 онд 0.9% байх төлөвтэй байна.<sup>14</sup>

Хүснэгт 1. ДНБ-ний үзүүлэлт

Үндсэн үзүүлэлтүүд	2018	2019	2020	2021төс	2022төс
ДНБ (тэрбум ам.доллар)	1	1	1	1	1
ДНБ (Тогтмол үнэ, %)	2.9	2	-1	3.6	2.8
Нэг хүнд ногдох ДНБ (ам.доллар)	33	31	31	34	36
Засгийн газрын баланс (ДНБ%-иар)	2.7	0.6	-2.1	-2.4	-2.2
Улсын өр (ДНБ % -иар)	40	42.2	48.7	53.2	57.2
Инфляцийн түвшин (%-иар)	1.5	0.4	0.5	1.4	0.9
Ажилгүйдлийн түвшин (ажиллах хүчин %)	3.8	3.8	3.9	4.6	4.1
Хөрөнгө (тэрбум ам.доллар)	77.47	59.68	75.28	76.62	74.68
Урсгал хөрөнгө (ДНБ%-иар)	4.5	3.6	4.6	4.2	4

Эх сурвалж: ОУВС - Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын мэдээллийн сан, 2020

#### БНСУ-ын ЖДҮ-ийн товч танилцуулга

Солонгосын банк болон Санхүүгийн хянан шалгалтын алба (FSS)-ны тодорхойлолтоор ЖДҮ гэдэг нь: жилийн борлуулалтын орлогын дундаж нь 500 тэрбум воноос багагүй, стандарт хангасан аж ахуйн нэгжийг хэлнэ гэжээ. ЖДҮ эрхлэгчдийн ажилчдын тоогоор нь дараах байдлаар ангилдаг байна. Үүнд:

- Бичил бизнес эрхлэгчид (1-9 ажилчид)
- Жижиг бизнес эрхлэгчид (10-49 ажилчид)
- Дунд бизнес эрхлэгчид (50-299 ажилчид)
- ЖДҮ эрхлэгчид (1-299 ажилчид)
- Томоохон үйлдвэр эрхлэгчид (300 дээш ажилчид) болно.

<sup>12</sup> [https://asianbondsonline.adb.org/korea/market\\_summary/kr\\_market\\_summary\\_202009.pdf](https://asianbondsonline.adb.org/korea/market_summary/kr_market_summary_202009.pdf)

<sup>13</sup> 2021, 2022 оны ДНБ-ний өсөлтийн төсөөллийг ОУВС-ийн 2021 оны 1-р сард шинэчлэн боловсруулжээ.


<sup>14</sup> <https://www.nordeatrade.com/fi/explore-new-market/south-korea/economical-context>

## Хүснэгт 2. ЖДҮ-ийн ажиллагсдын тоо, ААН, ажиллах хүч

Ажиллагсдын тоо	ААН	%	Ажиллах хүч	%
Нийт ААН	4,019,872	100	21,626,094	100
ЖДҮ (1-299)	4,015,849	99.9	18,464,334	85.4
Бичил (1-9)	3,695,031	91.9	8,836,861	40.9
Жижиг (10-49)	275,776	6.9	5,260,131	24.3
Дунд (50-299)	45,042	1.1	4,367,342	20.2
Том (300+)	4,023	0.1	3,162,570	14.6

Эх сурвалж: *Financing SMEs and Entrepreneurs: An OECD Scoreboard*

Солонгосын ЖДҮГБЯамны 2020 оны 2 дугаар сарын шинэчилсэн статистикийн мэдээгээр ЖДҮ нь нийт аж ахуйн нэгжийн 99%, нийт ажиллах хүчний 83.1 %, экспортын 34% эзэлж байна.<sup>15</sup>



ЖДҮ ажил эрхлэлт (ажиллагсдын тоогоор)

- бичил жижиг бизнес эрхлэгчид 43%-ийг буюу 8.97 сая <sup>16</sup>
- жижиг бизнес эрхлэгчид 21% буюу 4.28 сая;
- дунд бизнес эрхлэгчид 19% буюу 3.86 сая
- том бизнес эрхлэгчид 17% буюу 3.49 сая байна.

## 2. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

### 2.1 ЖДҮ-ийг дэмжих талаар төрөөс явуулж буй бодлого, арга хэмжээ, салбарын ерөнхий мэдээлэл

Иргэдийн бизнес эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэлтэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Казахстан Улс 2010 оны 4-р сараас "Бизнесийн замын зураглал-2020" төрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ нь бизнес эрхлэгчдийг дэмжих гол хөтөлбөр юм.

Уг хөтөлбөрийг Казахстан Улсын Үндэсний эдийн засгийн яам хариуцан хэрэгжүүлсэн. Эхэндээ хөтөлбөр нь уул уурхайн бус, импортыг орлох салбарын аж ахуйн нэгжүүдийг дэмжихэд чиглэгдэж байв. Хэрэгжих явцдаа хүрээгээ тэлж хөдөө орон нутаг, жижиг болон монотаун хотуудын бизнес эрхлэгчид хамрагдах болсон. Хөтөлбөрийн хэрэгжилтэд төв,

<sup>15</sup> <https://www.mss.go.kr/site/eng/02/20202000000002019110610.jsp>

<sup>16</sup> Ministry of SMEs and Startups <https://www.mss.go.kr/site/eng/02/20202000000002019110610.jsp>

орон нутгийн эрх бүхий байгууллагууд, “Даму” бизнес эрхлэлтийг хөгжүүлэх сан, “Атамекен” үндэсний бизнес эрхлэгчдийн танхим, арилжааны банкууд оролцсон. Хөтөлбөр нь зээлийн хүүгийн татаас, зээлийн баталгаа, буцалтгүй тусламж, сургалт, зөвлөх үйлчилгээ зэрэг дэмжлэгүүдийг үзүүлсэн байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн эхний жилүүдээс үр дүнгээ өгч эхэлсэн. Хөтөлбөрийн гол оператор Байтерек холдингийн мэдээлснээр 2010 оноос хойш 13 мянган төсөлд татаас олгож, 5 мянган төсөлд баталгаа гаргаж өгсөн. Түүнчлэн 2010-2017 онуудад хөтөлбөрт 457.1 тэрбум тенге хуваарилагдаж, 900 тэрбум тенгений татвар төлсөн. Мөн хугацаанд 89.1 мянган ажлын байр бий болгож, 13.4 тэрбум тенгетэй тэнцэх хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувь 2015 онд 24.9% байсан бол 2019 онд 31.7% болж өссөн байна. Түүнчлэн, ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувийг 2025 онд 35%, 2050 онд 50% болгох зорилт дэвшүүлжээ.

Казахстан Улс нь бизнес эрхлэлтийн түвшинг тодорхойлох «Doing Business»-д бизнес эрхлэлтийг хялбар болгох үзүүлэлтээр 2010 онд 63-р байранд байсан бол 2020 онд 25-р байр хүртэл ахисан байна.

2019 онд "Бизнесийн замын зураглал-2020" хөтөлбөрт санхүүгийн дэмжлэгийг сайжруулахад чиглэсэн өөрчлөлтүүдийг оруулж, хөтөлбөрийг 2025 он хүртэл сунгах шийдвэр гаргасан. Хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлснээр 2025 онд дараах зорилтот үр дүнд хүрэхээр төлөвлөсөн байна.

- ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувийг хамгийн багадаа 33.8% -д хүргэх;
- Хөтөлбөрт хамрагдагсдын татварын орлогыг 2017 оны түвшингээс 2 дахин өсгөх.
- Хөтөлбөрт оролцогчид шинээр 30 мянган ажлын байр бий болгох;
- ДНБ-ний бүтцэд боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийг хамгийн багадаа 13.4%-д хүргэх;
- Эдийн засагт дунд бизнес эрхлэгчдийн эзлэх хувийг хамгийн багадаа 13.7%-д хүргэх.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2020-2024 онд төсөвт 421 тэрбум тенге төсөвлөгдсөн.

Казахстанд ажлын байр, иргэдийн бизнес эрхлэлтийг дэмжих "Хөдөлмөр", "Бүс нутгуудыг хөгжүүлэх-III", эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн төслүүдэд зээл олгох "Энгийн зүйлийн эдийн засаг" зэрэг хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

ЖДҮ-ийг хөгжүүлэх нь улс орны хувьд чухал ач холбогдолтой. Иймээс Улсын Ерөнхийлөгч Касым Токаев ЖДҮ-ийг дэмжихэд онцгойлон анхаарал хандуулж байгаа бөгөөд Казахстаны ард түмэнд хандаж хэлсэн үгэндээ "Үр дүнтэй жижиг, дунд бизнес нь улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг, хот, орон нутгийн хөгжилд баттай үндэс суурь болно" гэж онцолсон. Ерөнхийлөгч ЖДҮ-ийг дэмжиж хөгжүүлэх чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгсөн байна.

- 2020 онд бичил, жижиг бизнес эрхлэгчдийг үндсэн үйл ажиллагааны татвараас (орлогод) гурван жилийн хугацаатай чөлөөлөх;
- бичил, жижиг бизнес эрхлэгчдэд шалгалт, урьдчилан сэргийлэх хяналт тавихыг гурван жилийн хугацаагаар зогсоох;
- Жижиг, дунд бизнесийг төрөөс дэмжих тогтолцоог шинээр авч үзэх.

Түүнчлэн Ерөнхийлөгч бизнес эрхлэхэд саад бэрхшээл үүсгэхийг төрийн эсрэг гэмт хэрэг гэж үзэхээ мэдэгдэж, түүнийг хууль тогтоомжоор баталгаажуулах уриалга гаргасан байна.

Сүүлийн жилүүдэд Казахстанд бизнес эрхлэх нөхцөл байдал тогтмол сайжирч, бизнес эрхлэгчдийг дэмжих төрийн янз бүрийн механизмууд бий болж байгаа боловч ЖДҮ-ийг хөгжүүлэх боломж бүрэн хангагдаж чадаагүй байна. Төрөөс бизнесийн үйл ажиллагааг дижитал хэлбэрт оруулах, түүнд бизнес эрхлэгчдийг татан оролцуулах, ингэснээр бизнесийн үйл ажиллагааг оновчтой болгон, үйлдвэрлэл, борлуулалтын зардлыг бууруулж, ЖДҮ эрхлэгчдийг дэлхийн зах зээлийн сүлжээнд нэвтрэх боломжийг олгоход анхаарал хандуулж байна.

Бизнесийн уур амьсгалыг сайжруулах 8 дахь багц шинэчлэлд томоохон найдвар тавигдаж байгаа бөгөөд энэ нь тус улсад ЖДҮ ба иргэдийн бизнес эрхлэлтийг хөгжүүлэх хөшүүрэг болно гэж үзсэн. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлт нэмэгдэж, улмаар "Казахстан - 2050" стратегийн гол зорилго буюу дэлхийн хөгжингүй 30 орны тоонд хүрэхэд дэмжлэг болно гэсэн хүлээлттэй байна. Энэхүү гол зорилгод хүрэх нэг чухал алхам нь ЖДҮ-ийг хөгжүүлэхэд оршино /2050 онд ЖДҮ-ийг ДНБ-ний 50-иас доошгүй хувьд хүргэх/.

## **2.2 ЖДҮ-ийг дэмжих төрийн байгууллагын бүтэц, санхүүжилтийн тогтолцоо**

Казахстанд бизнес эрхлэлтийн асуудлыг Үндэсний эдийн засгийн яамны Бизнес эрхлэлтийг хөгжүүлэх газар хариуцан ажиллаж байна.

Тус газар нь төрийн зөвшөөрөл олгох тогтолцоог боловсронгуй болгох, бизнес эрхлэгч субъектүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, бизнес эрхлэлтийг хөгжүүлэхэд таатай нөхцөлөөр хангах, хамгаалах чиглэлээр хяналтын ажлыг зохион байгуулах болон төрийн бодлогыг боловсруулах үндсэн үүргийг хэрэгжүүлдэг.

Бизнес эрхлэлтийг хөгжүүлэх газар нь дараах бүтэцтэй.<sup>17</sup>

- Төрийн зөвшөөрөл олгох болон өөрийгөө зохицуулах тогтолцоог хөгжүүлэх хэлтэс
- Төрийн хяналтыг хөгжүүлэх хэлтэс
- Хувийн хэвшлийн бизнес эрхлэгчдийг дэмжих, хамгаалах хэлтэс
- Бодлого зохицуулалтын хэлтэс.

Түүнээс гадна ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр “Атамекен” Казахстан Улсын бизнес эрхлэгчдийн үндэсний танхим, “Даму” бизнес эрхлэлтийг хөгжүүлэх сан зэрэг байгууллагууд ажиллаж байна.

**“Атамекен” Казахстан Казахстан Улсын үндэсний бизнес эрхлэгчдийн танхим** нь жижиг, дунд, том бизнес эрхлэгчдийн эрх ашгийг төлөөлж, дотоод, гадаад худалдаа зэрэг бизнес эрхлэх бүхий л салбарыг хамааран үйл ажиллагаа явуулдаг. Танхимын гол үүрэг бизнесийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, бизнесийн үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж боловсруулах үйл явцад бизнес эрхлэгчдийг өргөнөөр хамруулан оролцуулахад оршино.

<sup>17</sup> <https://www.gov.kz/memleket/entities/economy/documents/details/52610?lang=ru>, Положение о Департаменте развития предпринимательства

Танхимын үйл ажиллагаа нь үндэсний болон гадаадын хөрөнгө оруулагчдад бизнес, хөрөнгө оруулалтын орчин бүрдүүлэх, тогтвортой байдлыг хангах, тус улсад бизнес эрхлэх нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн.

**“Даму” бизнес эрхлэлтийг хөгжүүлэх сан.** ЖДҮ-д санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн гол оператор “Даму” бизнес эрхлэлтийг хөгжүүлэх сан юм.

Сангийн зорилго нь иж бүрэн, үр дүнтэй дэмжлэг үзүүлэх хэрэгслийг хэрэгжүүлэх замаар Казахстаны бичил, жижиг, дунд үйлдвэрийг тогтвортой хөгжүүлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд оршино.

Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд Сан хөгжлийн 2 үндсэн стратегийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

1. Гарааны болон үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр:

- Бичил бизнес эрхлэх зээлийг өргөжүүлэх, бичил санхүүгийн байгууллага болон зээлийн түншлэлийг дэмжих хэрэгслийг боловсруулан хэрэгжүүлэх;
- Үйл ажиллагаа явуулж буй бичил, жижиг, дунд бизнесийн байгууллагуудын санхүүгийн хөтөлбөрүүдэд хамрагдах хүрээг нэмэгдүүлэх;
- Дэмжлэг үзүүлэх бичил, жижиг, дунд бизнесийн байгууллагуудын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх.

2. Сангийн тогтвортой хөгжил:

- Санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрээс хөрөнгө татах;
- Санхүүгийн гүйцэтгэлийн төлөвлөсөн түвшинд хүрэх;
- Бизнесийн үйл явцыг автоматжуулах;
- Компанийн засаглалын түвшинг дээшлүүлэх.

Санхүүжилтийн тогтолцоо<sup>18</sup> Казахстаны Засгийн газар бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийг гарааны бизнес эрхлэхэд олноор татан оролцуулах чиглэлээр ажиллаж ирсэн. ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг өргөжүүлэхийн тулд тус улсад хөнгөлөлттэй зээл, бичил санхүүжилт, хөнгөлөлттэй зээлийн хүү, зээлийн баталгаа, бизнес эрхлэхэд чиглэсэн олон хөтөлбөр хэрэгжиж байна. /ЖДҮ-ийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн гол оператор нь Даму бизнес эрхлэлтийг хөгжүүлэх сан/.

ЖДҮ-ийг дэмжихийн тулд тэдгээрт зээл олгох боломжоор хангах явдал чухал байдаг. Зах зээл дэх хөрвөх чадварын хомсдолтой үед ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор төрөөс арилжааны банкуудад хөрөнгө байршуулдаг. 2018 онд ЖДҮ-ийн зээлийн санхүүжилтийн хөрөнгийг хамгийн их байршуулсан бөгөөд зээлийн гол хэсгийг 2014-2016 онд боловсруулах үйлдвэрлэл дэх ЖДҮ-ийг дэмжих зорилгоор жилийн 6%-ийн хүүтэй зээлийг хуваарилсан. Үүнийг банкууд эргэлтийн журмаар олгодог. Төрөөс жил бүр шинээр хөрөнгө хуваарилдаг байна.<sup>19</sup>

Бизнесийг дэмжих, хөгжүүлэх Засгийн газрын хөтөлбөр “Бизнесийн замын зураглал” 2010 оноос Казахстан Улсын Үндэсний эдийн засгийн яамны удирдлага дор хэрэгжиж эхэлсэн.

Хөтөлбөр эхэндээ уул уурхайн бус, импортыг орлох салбарын аж ахуйн нэгжийг дэмжихэд

<sup>18</sup> <https://www.oecd-ilibrary.org/sites/20ee7990-en/index.html?itemId=/content/component/20ee7990-en>

<sup>19</sup> <https://www.oecd-ilibrary.org/sites/20ee7990-en/index.html?itemId=/content/component/20ee7990-en>

чиглэгдэж байв. Цаг хугацаа өнгөрөхөд энэ нь салбарын хязгаарлалтад хамрагдахгүй хөдөө орон нутаг, жижиг болон монотаун хотуудын бизнес эрхлэлтийг дэмжих болсон. Хөтөлбөрийн хэрэгжилтэд төв, орон нутгийн эрх бүхий байгууллагууд, Даму бизнес эрхлэлтийг хөгжүүлэх сан, Атамекен үндэсний бизнес эрхлэгчдийн танхим, арилжааны банкууд оролцсон. Хөтөлбөрийн санал болгож буй дэмжлэгийн төрлүүдэд зээлийн хүүгийн татаас, зээлийн баталгаа, буцалтгүй тусламж, сургалт, зөвлөх туслалцаа зэрэг орно.

Төрийн дэмжлэгт аж ахуйн нэгжүүдийг илүү их хамруулах зорилгоор Засгийн газраас 2018 онд татаас, баталгааг авах нөхцөлийн талаар хөтөлбөрт зарим нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нэгдүгээрт, татаас эсвэл, батлан даалтад хамрагдах боломжтой зээлийн хүү тогтмол байсныг хөвөгч хэлбэрт шилжүүлж, Үндэсний банкны суурь хүүтэй уяж 5% болгосон. Хоёрдугаарт, татаасын хэмжээ зээлийн хүүгийн 50%-иас хэтрэхгүй байна. Гуравдугаарт, татаас олгох дээд хугацаа нь сунгах сонголтгүйгээр 5 жилээс илүүгүй болсон. Дөрөвдүгээрт, татаас авах боломжтой зээлийн дээд хэмжээ 2 500 сая тенге болж буурсан.

Зээлийн хүүгийн татаас<sup>20</sup> Зээлийн хүүгийн татаасыг зорилтот сегментээс хамааран хэд хэдэн чиглэлд олгоно. Салбарын хязгаарлалтгүй төслүүдийг монотаун, жижиг хот, хөдөө орон нутагт хэрэгжүүлэхэд татаас нь нэрлэсэн хүүгийн 50% (Үндэсний банкны суурь хүүгээс 5%-иас хэтрэхгүй байх) байна. Зээлийн дээд хэмжээ 750 сая тенге. Татаасын хугацаа таван жил хүртэл байна. Тэргүүлэх салбаруудад хэрэгжиж буй төслүүдийн хувьд татаас нь нэрлэсэн хүүгийн 40% хүртэл байдаг (энэ нь Үндэсний банкны суурь хүүгээс 5%-иас хэтрэхгүй байх ёстой). Зээлийн дээд хэмжээ 2 500 сая тенге. Татаасны хугацаа таван жил хүртэл байна;

Зээлийн баталгаа<sup>21</sup> Зээлийн баталгааг зорилтот сегментээс хамааран янз бүрийн нөхцөлөөр хангаж өгдөг.

- Залуу болон гарааны бизнес эрхлэгчдэд 20 сая хүртэлх тенгений зээлийн 85% хүртэл баталгаа өгдөг.
- Салбарын хязгаарлалтгүй төслүүдэд монотаун, жижиг хот, хөдөө орон нутагт 180 сая хүртэлх тенгений зээлийн 50% хүртэл баталгаа өгдөг.
- Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт хэрэгжүүлэх төслүүдэд 360 сая хүртэлх тенгений зээлийн 50% хүртэлх баталгаа олгоно.
- Боловсруулах үйлдвэрлэлийн төслүүдэд 1.850 сая хүртэлх тенгений зээлийн 20% хүртэл баталгаа өгдөг.

Казахстаны санхүүгийн зах зээл дэх шинэ бүтээгдэхүүний хувьд зээлийн баталгаа маш хурдацтай түгээмэл хэрэглэгдэж байна.

“Нурлы жол” хөтөлбөрийн хүрээнд боловсруулах үйлдвэрлэлийн ЖДҮ-ийн санхүүжилт, Засгийн газар, Үндэсний банкны хамтын ажиллагааны төлөвлөгөө. Казахстаны Засгийн газар арилжааны банкуудаар дамжуулан үйлдвэрлэлийн салбар дахь ЖДҮ эрхлэгчдэд боломжийн зээл олгох зорилгоор 2014-2015 онд 200,000 сая тенгений санхүүжилт олгосон. ЖДҮ эрхлэгчид 6%-ийн хүүтэй, 1850 сая хүртэлх тенгений зээлийг 10 жилийн хугацаатай авах боломжтой. 2018 оны эцсийн байдлаар 2 314 төслийг нийт 509 465 сая тенгегээр санхүүжүүлжээ.

<sup>20</sup> <https://www.oecd-ilibrary.org/sites/20ee7990-en/index.html?itemId=/content/component/20ee7990-en>

<sup>21</sup> <https://www.oecd-ilibrary.org/sites/20ee7990-en/index.html?itemId=/content/component/20ee7990-en>



“Даму” бизнес эрхлэлтийг хөгжүүлэх сангийн хөтөлбөрүүд.<sup>22</sup> “Даму” сан нь өөрийн хөрөнгөөр болон орон нутгийн эрх бүхий байгууллагууд, олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөрөнгө босгох замаар санхүүжих хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлдэг. Бүс нутгийн хөтөлбөрийн хүрээнд тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудад 8.5% хүртэл хүүтэй зээл олгоно. Олон улсын хөтөлбөрийн хүрээнд зээлийг зах зээлийн нөхцөлөөр, салбарын хязгаарлалтгүйгээр олгож байна.

Өөрийн хөтөлбөрүүдийн хувьд “Даму” сан болон түүний түнш байгууллагууд (банк, лизингийн компани, бичил санхүүгийн байгууллага) 2018 оны жилийн эцсийн байдлаар 33300 гаруй төслийг 493 367 сая тенгегээр санхүүжүүлжээ.

2017 онд тус сан бусад төрийн байгууллагуудын хамт бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт ба иргэдийн бизнес эрхлэлтийг 2017-2021 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр “Хөдөлмөр”-ийн оператороор ажиллаж эхэлсэн. “Даму” сан нь хот суурин газрын бизнес эрхлэгчдэд зориулсан жилийн 6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл олгох үүрэгтэй. 2018 оны жилийн эцсийн байдлаар хот суурин газар дахь 1699 төслийг нийт 20.091 сая тенгегээр санхүүжүүлжээ.

“Даму” сан 2017 онд хотын эрчим хүчний хэмнэлттэй төслүүдэд хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх зорилгоор НҮБХХ-ээс 3 сая ам.долларын санхүүжилт татсан байна. Эдгээр хөрөнгийг ЖДҮ-ийн хүүгийн татаас болон зээлийн баталгаанд өгөхөд ашиглаж байна. 2018 оны эцэст нийт 806.6 сая тенгегийн зээлийн дүн бүхий 6 төсөлд гарын үсэг зурсан.

Улсын Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаев 2020 оны 9-р сарын 1-ний өдөр Казахстаны ард түмэнд хандан хэлсэн үгэндээ Засгийн газарт эдийн засгийн хямралд өртсөн салбаруудын бүх ЖДҮ-ийн зээлийн хүүг жилийн 6% болгон бууруулж хөнгөлөлт үзүүлэх үүрэг өгсөн. Энэ хүрээнд “Даму” сан нь эдийн засгийн хямралд хамгийн их өртсөн салбар дахь санхүүгийн агентууд, бизнес эрхлэгчдийн зээлийг хөнгөлөлттэй хэлбэрээр олгож эхэлсэн.

### **2.3 Цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ**

Казахстанд ДНБ-ний бодит өсөлт 2020 онд -2.6 хувь байсан. Эдийн засгийн агшилт нь үйлчилгээний салбарын идэвхжил сул, ОПЕК+ хэлэлцээрийн дагуу газрын тосны олборлолтыг бууруулж байгаатай холбоотой бөгөөд Засгийн газраас хэрэгжүүлсэн томоохон дэмжлэг (2020 оны 3-р сард хэрэгжүүлсэн, ДНБ-ний 9 хувьтай тэнцэх) нь эдийн засгийн уналтыг багасгахад нөлөөлжээ. (Уг дэмжлэгийн хүрээнд нийгмийн чухал ач холбогдолтой бараа бүтээгдэхүүний зохицуулалттай үнэ, эмзэг бүлгийн өрхөд олгох мөнгөн тусламж, хүнд хэцүү салбар, жижиг, дунд үйлдвэрүүдэд чиглэсэн тусламжийг багтаасан.)<sup>23</sup>

Энэ дэмжлэгийн хүрээнд Ковид-19 цар тахлын хямралыг даван туулах, нийгэм, эдийн засгийн сэргээх арга хэмжээний багцыг 2020 оны 3-р сард хэрэгжүүлж эхэлсэн. Үүнд ажилгүй болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд олгох мөнгөн дэмжлэг, тэтгэвэр, нийгмийн тэтгэмжийн нэмэгдэл, эрүүл мэндийн нэмэлт зардлууд, ажил эрхлэлт, бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийг багтаасан. ЖДҮ-ийг дэмжих хүрээнд:

Энэхүү хүнд хэцүү үед ЖДҮ-ийг дэмжихийн тулд 2020 оны 3-р сард 3 сарын хугацаанд бүх төрлийн татвар болон бусад заавал төлөх төлбөрийг 3 сарын хугацаатай хойшлуулах, 2020 оны 3-р сарын 20-ны өдрөөс үл хөдлөх хөрөнгийн түрээсийн төлбөрийг 3 сараар зогсоох

<sup>22</sup> <https://www.oecd-ilibrary.org/sites/20ee7990-en/index.html?itemId=/content/component/20ee7990-en>

<sup>23</sup> <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>

зэрэг арга хэмжээ авсан.

Төрийн тэргүүн цар тахлын улмаас хүнд нөхцөлд буй ЖДҮ эрхлэгчдэд 600 тэрбум тенгетэй тэнцэх хэмжээний 8 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгохыг Үндэсний банк болон Санхүүгийн зах зээлийг зохицуулах агентлагт даалгасан.

ЖДҮ-ийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд туслах арга хэмжээний хамт "Энгийн зүйлсийн эдийн засаг" төрийн хөтөлбөрийн хүрээнд 1 их наяд (ДНБ-ний 1½ хувь) тенгений хөнгөлөлттэй зээл олгосон.

Тээврийн дэд бүтцийг шинэчлэх зарим томоохон төслүүдийг багтаасан "Бизнесийн замын зураглал" хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд 1.8 их наяд тенгег хуваарилжээ.

Сонгогдсон аж ахуйн нэгж, хувиараа бизнес эрхлэгчид мөн татварын шинэ урамшуулалд хамрагдах боломжтой болсон.

Эдийн засгийн өсөлтийг сэргээхээр сүүлд хэрэгжүүлсэн багц арга хэмжээний /Төсвийн нийт өртөг 2021 оны ДНБ-ний 0.7 орчим хувьтай тэнцэх/ хүрээнд 2020 оны 7-р сарын эхээр дахин хорио цээрийн дэглэм тогтоосны дараа ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээлийн хүүг 6 хувь хүртэл бууруулж, эмзэг бүлгийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх хугацааг сунгасан байна.

Түүнчлэн иргэд болон ЖДҮ эрхлэгчдийг дэмжих зорилгоор банкууд, мөн бусад зээлдүүлэгчдэд зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, шаардлага хангасан зээлдэгчид Ковид-19 цар тахлаас өмнөх үеийн зээлийн ангиллыг царцаах зэргээр дэмжлэг үзүүлсэн.

Дэмжих зарим арга хэмжээг, тухайлбал, "Бизнесийн замын зураглал", ЖДҮ эрхлэгчдэд зориулсан эргэлтийн хөрөнгийг дэмжих зэрэг арга хэмжээг 2021 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

## 2.4 Салбарын статистик мэдээнүүд

2020 оны 1-р сарын байдлаар Казахстанд ЖДҮ эрхлэлт 1 325 615 байсан бол оны төгсгөлд 1 357 311-д хүрсэн байна. /Зураг 1/




Бүс нутгаар авч үзвэл ЖДҮ эрхлэлт Алматы (197066), Нур-Султан (144769) хотуудад, мөн Алматы (123181), Туркестан (140605) зэрэг бүс нутгуудад илүү сайн хөгжсөн бол Павлодар (45809), Өрнөд Казахстан (45035), Хойд Казахстан (30331) зэрэг бүс нутгуудад хамгийн бага тоотой байна. Ийнхүү бүс нутгуудад ЖДҮ эрхлэлт харилцан адилгүй байгаа нь газарзүйн байршил, хүн амын тоо, бүс нутгийг хөгжил, эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал,



бизнесийн үйл ажиллагааны түвшин болон бусад олон хүчин зүйлээс хамаардаг. /Зураг 2/

**Зураг 2. ЖДҮ-ийн тоо бүс нутгаар 2020 оны байдлаар**



Жил бүр шинээр бүртгүүлэх ЖДҮ эрхлэгчдийн тоо нэмэгдэж байгаа боловч бүгд үйл ажиллагаа явуулдаггүй. Тухайлбал, 2015 онд 1481454 ЖДҮ эрхлэгч бүртгүүлснээс 1242579 нь үйл ажиллагаа явуулсан. 2019 онд 1603839 бүртгүүлж түүний 1330244 нь үйл ажиллагаа явуулсан. Энэхүү зөрүүнээс харахад бизнес эрхлэгчид бүртгүүлсэн мөртлөө үйл ажиллагаа явуулахад хараахан бэлэн болоогүй байгаад бизнес эрхлэх мэдлэг хангалтгүй, эрх бүхий хүмүүсийн бий болгосон хиймэл саад бэрхшээл, үйл ажиллагааны чиглэлээ зөв сонгоогүй, тодорхой бус байдал болон бусад олон хүчин зүйл нөлөөлдөг байна. /Зураг 3/

Хэдий ийм зөрүү байдаг ч ЖДҮ эрхлэгчид жил бүр нэмэгдэж байгаа нь улс орны эдийн засагт эерэг нөлөөлж байна. Энэхүү өсөлт нь мэдэгдэхүйц бага боловч улсын төсөвт орох орлогыг нэмэгдүүлдэг.

**Хүснэгт 1. ЖДҮ-ийн тоо улсын хэмжээнд 2015-2019 он<sup>24</sup> /тоо хэмжээ/**

	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
бүртгүүлсэн ЖДҮ-ийн субъект	1 481	1 498	1 540	1 577	1 603
	454	243	592	747	839
бүртгүүлснээс үйл ажиллагаа явуулж буй	1 242	1 106	1 145	1 241	1 330
	579	353	994	328	244

<sup>24</sup> <https://stat.gov.kz/search/item/WC16200011247>

**Зураг 3. ЖДҮ-ийн тоо /2015-2019/**




ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувь 2015 онд 24,9% байсан бол 2019 онд 31,7% хүрч тогтмол өсөлтийг үзүүлжээ. ЖДҮ дотроо жижиг бизнес ДНБ-д жинтэй хувь нэмэр оруулдаг, харин дунд бизнес багахан хувь эзэлж байна. /Зураг 4, хүснэгт 2/

**Хүснэгт 2. ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувь 2015-2019 он /хувиар/<sup>25</sup>**

	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
жижиг, дунд үйлдвэрлэл	24,9	26,8	26,8	28,4	31,7
жижиг үйлдвэрлэл	20,0	22,1	22,2	22,6	25,5
дунд үйлдвэрлэл	4,9	4,7	4,6	5,8	6,2

**Зураг 4. ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувь 2015-2019 он**



Казахстаны Бизнес эрхлэлтийн тухай хуульд жижиг болон дунд үйлдвэрлэлийг ажиллагсдын тоо, жилийн дундаж орлогоор доорх байдлаар тодорхойлсон байна.

**Хүснэгт 3. Жижиг болон дунд үйлдвэрлэлд ажиллагсдын тоо, жилийн дундаж орлого<sup>26</sup>**

	Ажиллагсдын тоо	Жилийн дундаж орлого
Жижиг үйлдвэрлэл	16-100	300 000 сарын тооцооллын индекс
Дунд үйлдвэрлэл	101-250	3 000 000 сарын тооцооллын индекс

Жич: Сарын тооцооллын индекс нь 2020 оны байдлаар **2778** төнгөтэй, 2021 оны байдлаар **2917** төнгөтэй тэнцүү байна.<sup>27</sup>

Жил өнгөрөх тусам ЖДҮ-д ажиллагсдын тоо өсөх хандлагатай байна. ЖДҮ нь жижиг


<sup>25</sup> <https://stat.gov.kz/search/item/WC16200011247>

<sup>26</sup> <https://www.oecd-ilibrary.org/sites/20ee7990-en/index.html?itemId=/content/component/20ee7990-en#tablegrp-d1e138756>

<sup>27</sup> [https://egov.kz/cms/kk/articles/article\\_mci\\_2012](https://egov.kz/cms/kk/articles/article_mci_2012), Казахстан Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тооцоо, торгууль, татвар болон бусад төлбөрийг тооцоход ашигладаг.

үйлдвэрлэл, дунд үйлдвэрлэл, хувийн бизнес, хөдөө аж ахуй буюу фермер гэсэн субъектүүдээс бүрддэг. ЖДҮ-д ажиллагсдын тоо жижиг болон хувийн бизнест илүү өндөр байгаа бол хөдөө аж ахуй буюу фермерт бага тоотой байна. /Зураг 5/

**Зураг 5. ЖДҮ-д ажиллагсдын тоо 2015-2019 он**




Зураг 6-д ЖДҮ-ийн бүтээгдэхүүний хэмжээг ЖДҮ-ийн тоо болон түүнд ажиллагсдын тоотой зэрэгцүүлэн харуулав. ЖДҮ-ийн бүтээгдэхүүний хэмжээ тогтмол өсөлттэй байгаа бөгөөд 2015 онд 15699405 байсан бол 2019 онд 32386960 хүртлээ өсчээ. Харин 2020 оны хувьд энэ тоо 32725460 болж хүрчээ. ЖДҮ-д ажиллагсад болон үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-ийн тоо мөн тогтмол өсөлттэй байна. /2020 оны тоо урьдчилсан статистик болно/.



2015-2019 онуудад ЖДҮ-ийн нэмэгдсэн өртөг тогтмол өссөөр ирсэн бөгөөд 2015 онтой харьцуулахад 2019 онд 2 дахин нэмэгджээ. /Зураг 7/

### Зураг 7. ЖДҮ-ийн нэмэгдсэн өртөг 2015-2019 он



### Хүснэгт 4. Салбарын статистик мэдээнүүд

	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020.VII.01 <sup>28</sup>
ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувь /хувиар/	24,9%	26,8%	26,8%	28,4%	31,7%	28,4%
ЖДҮ-ийн тоо /үйл ажиллагаа явуулж буй /мянган а.а.н/	1 242,6	1 106,4	1 146,0	1 241,3	1 330,2	1345,9
ЖДҮ-д ажиллагсдын тоо /мянган хүн/	3 183,8	3 166,8	3 190,1	3 312,5	3 448,7	3252,9
ЖДҮ-ийн бүтээгдэхүүний хэмжээ, /тэрбум.тенге/	15 699,4	19 609,0	23 241,1	26 473,0	32 387,0	13 033,0
ЖДҮ-ийн нэмэгдсэн өртөг /тэрбум.тенге/	10 196,7	12 584,0	14 257,3	17 569,9	22 029,2	8077,0

Жич: 2021 оны 4-р сарын байдлаар Казахстаны ЖДҮ-тэй холбогдох 2020 оны статистик бүрэн гараагүй, урьдчилсан байдлаар гарсан байна. Мөн статистик мэдээнүүд 2020 оны харилцан адилгүй хугацааных байсан тул жигдлэх үүднээс энэ хүснэгтэд 2020 оны 1-р улирлын байдлаар авав.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>28</sup>[https://atameken.kz/uploads/content/files/%D0%9E%D1%82%D1%87%D0%B5%D1%82%20%D0%9C%D0%A1%D0%9F%20%20%D0%BF%D0%BE%D0%BB%D1%83%D0%B3%D0%BE%D0%B4%D0%B8%D0%B5%202020\\_\\_%D1%84%D0%B8%D0%BD\\_%20\(1\).pdf](https://atameken.kz/uploads/content/files/%D0%9E%D1%82%D1%87%D0%B5%D1%82%20%D0%9C%D0%A1%D0%9F%20%20%D0%BF%D0%BE%D0%BB%D1%83%D0%B3%D0%BE%D0%B4%D0%B8%D0%B5%202020__%D1%84%D0%B8%D0%BD_%20(1).pdf)

## ХАВСРАЛТ

Санхүүгийн дэмжлэгийн 4 багцыг дэлгэрэнгүйгээр харуулав.

Санхүүгийн дэмжлэгийн эхний багц ( 02 дугаар сарын 5-12-ны өдөр)

Солонгосын Засгийн газар эдийн засгийг хөгжүүлэх 2-4 дахь Сайд нарын хурлаар нийт 4 их наяд воныг эхний ээлжинд яаралтай тусламж үзүүлсэн.

2 дахь Сайд нарын эдийн засгийг хөгжүүлэх уулзалт (2 дугаар сарын 5 )	Дотоод, орон нутгийн татварын бодлогын дэмжлэг
	Эрүүл мэнд, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлтийг дэмжлэг
	Түүхий эд, туслах материал үйлчилгээ
3 дахь Сайд нарын эдийн засгийн хөгжүүлэх уулзалт (2 дугаар сарын 7 )	Цар тахлын нөлөөнд нэрвэгдсэн ЖДҮ-ийн тусламжийн сан /зээл, баталгаа, экспорт, импортын санхүүжилт /
	Бичил бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн тусламжийг өргөжүүлэх / зээл, баталгаа /
	Худалдааны шударга бус үйл ажиллагаанд хяналт тавих
4 дахь Сайд нарын эдийн засгийн хөгжүүлэх уулзалт (2 дугаар сарын 12 )	Андеррайтеринг өндөр түвшинд хийх, дебит дансны даатгал ба даатгалын шимтгэл
	Импорт, түүхий эд болон туслах материалын худалдан авах орныг тодорхойлох
	ЖДҮ болон бичил бизнес эрхлэгчдэд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг өргөжүүлэх

Санхүүгийн дэмжлэгийн 2 дахь багц (2 дугаар сарын 28-ны өдөр)

Солонгосын Засгийн газар Ковид-19 цар тахлын халдварын эсрэг хоёр дахь тусламжийн багцыг эхний багцтай хамт, нийт 20 их наяд вонын дэмжлэг үзүүлжээ. Үүнд:

- Засгийн газрын нөөц сан нь халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, орон нутгийн засаг захиргаа, үйлдвэрлэл хангамжийн импорт, жижиг худалдаа эрхлэгчдийг дэмжих бодлогод 4 их наяд вонын санхүүжилтийг олгожээ.
- Ковид-19 цар тахал халдварын нөлөөнд нэрвэгдсэн өрх гэр, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн болон татварын дэмжлэг үзүүлэх, түрээслэгч, түрээслүүлэгчийн татварын 50%-ийг хөнгөлөх, автомашин худалдан авсан хувь хүний татварт хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх зорилгоор 7 их наяд вонын санхүүжилт олгосон.
- Санхүүгийн байгууллага болон олон нийтийн байгууллагаар дамжуулан 9 их наяд вонын зээл, зээлийн баталгаа, хөрөнгө оруулалт хийсэн.

Ковид-19 цар тахлын халдварт өвчний эсрэг орон нутгийн эдийн засгийг дэмжих зорилгоор нэмэлт төсвөөр санхүүжүүлсэн байна.

### Ковид-19 цар тахлын халдварын үед Засгийн газрын авах 10 арга хэмжээ

1.	Халдварт өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх ажлыг дэмжих
2.	Дэгү хот болон Чёндо мужийн иргэдийг 7 сая маскаар хангах
3.	Эхний хагас жилд түрээслэгч, түрээслүүлэгчийн татварын 50%-иар хөнгөлөх замаар түрээсийг бууруулах
4.	Жилдээ 60 сая вон ба түүнээс бага орлоготой бизнес эрхлэгчдэд НӨАТ-ын хөнгөлөлт үзүүлэх
5.	ЖДҮ эрхлэгчдэд, жижиг худалдаачдын бизнесийн үйл ажиллагааг дэмжиж санхүүгийн тусламжийг өргөжүүлэх

6.	Хүнд цохилтонд өртсөн аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
7.	Орон нутгийн эдийн засаг, уламжлалт зах зээлийг дэмжих зорилгоор орон нутгийн чадварын / gift/ гэрчилгээ олголтод 3.5 сая вонын тусалцаа үзүүлэх
8.	Чөлөөт цагаараа хүүхдээ асрах эцэг, эхчүүдэд 5 өдөрт хоногийн 50000 вонын тэтгэмжийг олгоно.
9.	Хэрэглээг дэмжих: Автомашины худалдан авалтад хувь хүний хэрэглээний татварыг 70%, цахилгааны хэмнэлттэй, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл худалдан авалтын 10%-ийг буцаан олгох
10.	Соёлын арга хэмжээ худалдан авахад хэрэглэгдэх, фермийн бүтээгдэхүүн, худалдан авахад хөнгөлөлттэй купон гаргаж, аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн цалин хөлс, зардлыг олгоно.

Санхүүгийн дэмжлэгийн 3 дахь багц ( 3 дугаар сарын 19-ны өдөр)

Солонгосын Засгийн газар Ковид-19 цар тахлын халдварт нэрвэгдсэн аж ахуйн нэгж, өрх гэр бүлд туслах зорилгоор 50 их наяд гаруй вонын санхүүгийн тусламжийг зарласан. Энэ багц нь бизнес эрхлэгч, мөнгө зээлдэгчдийн ачааллыг хөнгөвчлөх, хямралаас гаргах хөтөлбөрүүдээс бүрдсэн бөгөөд дараах 9 хөтөлбөрийг санхүүгийн дэмжлэгийн 3 дахь багцад хамруулсан байна.

1.Бизнесээ өргөжүүлэхэд туслах	Жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих: Нийт 12 их наяд воныг бизнесийн үйл ажиллагаа, 1.5%-2.35%- ийн хүүтэй зээлийг эхний ээлжинд санхүүжүүлнэ.
	ЖДҮ, жижиг бизнесийн зээлийн батлан даалтыг хангах: БНСУ-ын Технологийн Санхүүгийн Корпораци, Зээлийн Батлан Даалтын сан, орон нутгийн зээлийн батлан даалтын сангууд 5.5 их наяд вонын баталгаа олгоно.
	Жижиг худалдаа эрхлэгчдэд 3 их наяд вонын 100%-ийн зээлийн баталгаа олгоно.
2. Зээлдэгчийн ачааллыг хөнгөвчлөх	ЖДҮ, жижиг бизнес эрхлэгчдийн төлөх зээлийг хойшлуулах: Банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийг 6 сарын хугацаатай хойшлуулах.
	ЖДҮ, жижиг бизнес эрхлэгчдэд зээлийн хүүгийн төлбөрийг зогсоох: 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 6 сарын хугацаанд
	Өр төлбөрийг бууруулах: Солонгосын Хөрөнгийн Менежментийн Корпорацийн өр төлбөрийн үлдэгдэл, зээлийн зөвлөгөө, нөхөн сэргээх үйлчилгээнд гарсан өр төлбөрийг бууруулах арга хэмжээ авна.
3. Зээлийг хязгаарлах	Корпорациудад үйл ажиллагааг өргөжүүлэхийн тулд бонд, зах зээлийг тогтворжуулах
	Ирэх 3 жилийн хугацаанд нийт 6.7 их наяд вонын хэмжээтэй P-CBO (Primary Collateralized Bond Obligation) гаргана. (Эхний ээлжинд 1.7 их наяд вон, нэмэлтээр 5 их наяд вон)
	Үнэт цаасны зах зээлийг тогтворжуулах сан байгуулах: Санхүүгийн салбарын хамтарсан хөрөнгө оруулалттай, хувьцааны индексийн бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн.

Солонгосын банк болон Холбооны нөөцийн газар нь АНУ-ын долларын хөрвөх чадварыг хангах зорилгоор валютын своп хэлцлийг түр хугацаагаар (swap line) байгуулна. Энэ нь Солонгос вонын оронд АНУ-ын долларын хөрвөх чадварыг 60 тэрбум доллараар 6 сарын хугацаанд дэмжлэг үзүүлнэ. АНУ-ын долларын санхүүжилт нь зах зээл дэх ачааллыг бууруулах, өрх гэр, бизнес эрхлэгчдэд зээлийн нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Санхүүгийн дэмжлэгийн 4 дэх багц (3 дугаар сарын 24-ны өдөр)

1.Бизнес эрхлэгчдэд үзүүлэх санхүүжилт 58.3 их наяд вон	Бичил бизнес эрхлэгчдэд зээл олгох, баталгаа гаргах, хугацаа хэтэрсэн өр төлбөрийг 29.2 их наяд вонын нэмэлт санхүүгийн дэмжлэгийг санхүүжүүлэх
	ЖДҮ ба Аж үйлдвэрийн конгломерат (conglomerates) өргөжүүлэх
2.Корпорацийн бондын зах зээл, богино хугацааны мөнгөний зах зээлийг тогтворжуулах	Бондын зах зээлийг тогтворжуулах санд нийт 20 их наяд вон ( эхний үе 10 их наяд вон, нэмэлтээр 20 их наяд вон)
	Корпорацийн бонд гаргахад зориулж нэмэлт санхүүжилт (4.1 их наяд вон)
	Богино хугацааны мөнгөний зах зээлийг тогтворжуулах ( хувьцааны санхүүжилтийн зээл, ААН арилжааны үнэт цаас, богино хугацааны цахим бонд худалдан авах, санхүүжүүлэх)
3.Хөрөнгийн зах зээлийг тогтворжуулах	Дуудлага худалдаанд ногдуулсан журам (Хөрөнгийн менежментийн дуудлага худалдааны хязгаар, зээлийн хязгаарыг нэмэгдүүлэх)
	Ацапитал (асаритал) дуудлага худалдаанд 10.7 их наяд вонын үнэт цаасны зах зээлийн капиталжуулалтын сан байгуулах
	Хөрөнгийн зах зээл дэх эрэлтийг нэмэгдүүлэх татварын дэмжлэг

**Хүснэгтийн жагсаалт**

Судалгааны тойм

БНСУ:

Хүснэгт1. ДНБ-ний үзүүлэлт

Хүснэгт 2. ЖДҮ-ийн ажиллагсдын тоо, ААН, ажиллах хүч

Казахстан:

Хүснэгт 1. ЖДҮ-ийн тоо 2015-2019 он /тоо хэмжээ/

Хүснэгт 2. ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувь 2015-2019 он /хувиар/

Хүснэгт 3. Жижиг болон дунд үйлдвэрлэлд ажиллагсдын тоо, жилийн дундаж

орлого

Хүснэгт4. Салбарын статистик мэдээнүүд

**Зургийн жагсаалт**

БНСУ

Зураг 1. БНСУ-ын ЖДҮ-ийн санхүүжилт

Зураг 2. БНСУ-ын ЖДҮ-ийн мэдээлэл

Казахстан

Зураг 1. ЖДҮ-ийн тоо улсын хэмжээнд 2020 оны 1-12 сарын байдлаар

Зураг 2. ЖДҮ-ийн тоо бүс нутгаар 2020 оны байдлаар


Зураг 3. ЖДҮ-ийн тоо 2015-2019 он /бүртгүүлсэн болон бүртгүүлснээс үйл ажиллагаа явуулж буй/

Зураг 4. ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувь 2015-2019 он

Зураг 5. ЖДҮ-д ажиллагсдын тоо 2015-2019 он

Зураг 6. ЖДҮ-ийн бүтээгдэхүүний хэмжээ, ЖДҮ болон түүнд ажиллагсдын тоо 2015-2019 он

Зураг 7. ЖДҮ-ийн нэмэгдсэн өртөг 2015-2019 он



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Казахстан

- <https://www.oecd-ilibrary.org/sites/20ee7990-en/index.html?itemId=/content/component/20ee7990-en>
- <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>
- <https://stat.gov.kz/search/item/WC16200011247>
- <https://www.oecd-ilibrary.org/sites/20ee7990-en/index.html?itemId=/content/component/20ee7990-en#tablegrp-d1e138756>
- <https://strategy2050.kz/ru/news/kak-malyy-i-sredniy-biznes-vliyaet-na-konkurentosposobnost-kazahstana/>
- <https://ach.gov.ru/upload/pdf/Covid-19-SME.pdf>
- [https://assets.ey.com/content/dam/ey-sites/ey-com/ru\\_ru/news/2020/05/government-support-measures-for-moscow-during-covid-19.pdf](https://assets.ey.com/content/dam/ey-sites/ey-com/ru_ru/news/2020/05/government-support-measures-for-moscow-during-covid-19.pdf)

### БНСУ

- <https://ecck.or.kr/wp-content/uploads/2020/03/Tackling-COVID-19-Health-Quarantine-and-Economic-Measures-of-South-Korea.pdf>
- <https://www.mss.go.kr/site/eng/01/20101000000002019110619.jsp>
- <https://smefund.gov.mn/news/9/single/436>
- <https://www.adb.org/sites/default/files/publication/668331/adbi-wp1206.pdf>
- <https://www.nordeatrade.com/fin/explore-new-market/south-korea/economical-context>
- [Korea\\_COVID19 country profile 230321.pdf \(unescap.org\)](#)
- [South Korea's parliament approves fourth extra budget of 7.8 trillion won | Reuters](#)
- [https://asianbondsonline.adb.org/korea/market\\_summary/kr\\_market\\_summary\\_202009.pdf](https://asianbondsonline.adb.org/korea/market_summary/kr_market_summary_202009.pdf)
- <https://www.mss.go.kr/site/eng/01/20104000000002019110651.jsp>



# ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ОЛОН УЛСЫН БОДЛОГЫН ЧИГ ХАНДЛАГА: МОНГОЛ УЛС БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

Г.Алтан-оч (Ph.D), О.Билгүүтэй,  
Ш.Батцэнгэл, Г.Уянга

## АГУУЛГА

### СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

### СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

1. Дижитал буюу цахим хөрөнгийн тухай ойлголт
  - 1.1 Криптовалют буюу цахим мөнгө гэж юу вэ?
  - 1.2 Криптовалютын арилжаа хэрхэн хийгддэг вэ?
  - 1.3 Криптовалютын төрөл
  - 1.4 Цахим мөнгөний харилцаанд оролцогчид, тэдгээрийн онцлог
  - 1.5 Цахим мөнгийг яагаад худалдаж авдаг вэ?
  - 1.6 Цахим мөнгөний давуу, сул тал, аюул, боломж
  - 1.7 Цахим мөнгөний үнэд нөлөөлөгч хүчин зүйлс
  - 1.8 Цахим мөнгөтэй холбоотой зарим статистик мэдээлэл
2. Виртуал хөрөнгийн чиг хандлага
  - 2.1 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гарч болзошгүй эрсдэл
  - 2.1 Виртуал хөрөнгөтэй холбоотой эрсдэл
  - 2.2 ФАТФ-ын тайлангийн дагуух виртуал хөрөнгийн систем
  - 2.3 Виртуал хөрөнгөд тавигдах ФАТФ-ын шаардлага
  - 2.4 Виртуал хөрөнгийн чиг хандлага
3. Улс орнуудын виртуал хөрөнгийн зохицуулалт
  - 3.1 Малта
  - 3.2 Сингапур
  - 3.3 БНХАУ
  - 3.4 Япон улс
  - 3.5 Солонгос
  - 3.6 Татварын орчин
4. Монгол Улсын криптовалютын зах зээл

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ



## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгаанд “Виртуал хөрөнгийн эрх зүйн зохицуулалт, олон улсын бодлогын чиг хандлага”

сэдвийн хүрээнд цахим мөнгө болон виртуал хөрөнгийн талаарх ойлголт, практик хэрэглээ, виртуал хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал болон цаашдын хөгжлийн талаар баримталж буй дэлхийн нийтийн бодлогын чиг хандлага, эрх зүйн зохицуулалтын талаарх бусад орнуудын туршлага болон Монгол Улсын практик туршлагыг харьцуулан судаллаа.

Виртуал хөрөнгө гэдэг нь дижитал хэлбэрээр арилжих, шилжүүлэх боломжтой, төлбөр тооцоо, хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглаж болох үнэ цэнэ бүхий дижитал буюу биет бус хөрөнгө юм.<sup>29</sup>

Анх 1983 онд Америкийн шифрлэгч Дэвид Чаум нь “eCash” хэмээх нууцлал өндөртэй шифрлэгдсэн цахим мөнгө зохиож байсан ба Gemini компанийн саяханы явуулсан судалгаанаас харахад, насанд хүрсэн америк хүний гуравны хоёр нь криптог сонирхож байгаа дүн гарчээ. Тиймээс ойрын үед зах зээл маш их тэлэх төлөвтэй байгаа бөгөөд магадгүй үүнээс ч илүү чухал ач холбогдолтой зүйл бол ирэх саруудад крипто хөрөнгө оруулагчдын төрөлжилт явагдах төлөвтэй байна. Харин Монгол Улсын криптовалютын зах зээлийн хувьд 2017 оны сүүлчээс эрчимтэй хөгжиж эхэлсэн бөгөөд иргэд, аж ахуйн нэгжүүд криптовалютыг хөрөнгө оруулалтын хэрэгслээр сонирхож, эхэндээ социал сувгаар дамжуулан зохицуулалтгүйгээр өөр хоорондоо арилжаалж байсан бол өдгөө гадаадын биржүүдэд бүртгүүлэх, арилжаанд оролцох сонирхол ихээр нэмэгдэж байгаа дүр зураг ажиглагдаж байна.

ФАТФ-аас 2014 онд анх виртуал валют болон түүнээс үүдэн гарч болзошгүй мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаар тайлан, дүгнэлт гаргаж байсан бол түүнээс хойш 2015 онд Виртуал валютын эрсдэлийг зохицуулах зөвлөмжийг гаргасан. 2018 онд виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгөөр үйлчилгээ үзүүлэгч гэсэн нэр томъёог тодорхойлон үүн дээрээ үндэслэн 2019 оны 6 дугаар сард гаргасан зохицуулалтын зөвлөмждөө виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгөөр үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотой зохицуулалтын асуудлыг тусгасан байдаг аж.

Энэхүү харьцуулсан судалгаанд БНХАУ, БНСУ, Япон, Малта, Сингапур улсуудын виртуал хөрөнгийн талаар баримталж байгаа бодлого, эрх зүйн зохицуулалтын талаар судалсан. Сонгон авсан улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг ажиглан дүгнэвэл:

- Хятад улсын хувьд криптовалют нь хууль ёсны зөвшөөрөгдсөн төлбөрийн хэрэгсэл биш<sup>30</sup> бөгөөд санхүүгийн байгууллагууд криптовалютыг хүлээн авах, холбогдох санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглодог байна. Гэсэн хэдий ч Хятад улс цахим юанийн туршилтаа хийж байна.
- Япон болон Сингапур улсад виртуал хөрөнгийг Төлбөрийн үйлчилгээний тухай хуулиар (Payment Services Act) зохицуулж байна.
- Солонгос улсын засгийн газар виртуал валютын арилжааг хянах үүднээс журам боловсруулсан байна.
- Малта улс нь Виртуал санхүүгийн хөрөнгийн үйлчилгээтэй холбоотой 3 хуулийг 2018 онд баталсан байна. Үүнд:
  - Виртуал санхүүгийн хөрөнгийн тухай хууль /The Virtual Financial Assets Act<sup>31</sup>/

<sup>29</sup> “Виртуал хөрөнгийн тухай” судалгаа Монголбанк 2021

<sup>30</sup> The term 虚拟货币 (“virtual currencies”) is used in Chinese

<sup>31</sup> <https://legislation.mt/eli/cap/590/eng/pdf>

- Шинэлэг технологийн зохицуулалт, үйлчилгээний тухай хууль /The Innovative Technology Arrangements and Services Act<sup>32</sup>/
- Дижитал инновацийн албаны тухай хууль /The Malta Digital Innovation Authority Act<sup>33</sup>/ зэрэг юм.

Энэхүү судалгааны ажил нь дараах 4 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

- Дижитал буюу цахим хөрөнгийн тухай ойлголт
- Виртуал хөрөнгийн чиг хандлага
- Улс орнуудын виртуал хөрөнгийн зохицуулалт
- Монгол улсын криптовалютын зах зээл

**Түлхүүр үг:** Криптограф (шифрлэж нууцлах), Валют, Криптовалют, Крипто, Токен (им тэмдэг, жетон), Койн (зоос), Блокчейн, Блоклох, Биткойн, Алткойн (Уламжлалт бус зоос), Зах зээлийн капиталжуулалт (үнэлгээ), Нэгдсэн бүртгэл, Олборлох, Хэшинг (хэсэгчлэх), Хаяг, Хувийн нууц түлхүүр, Нийтийн нууц түлхүүр, Бирж, Крипто түрийвч

**Keyword:** Cryptography, Currency, Cryptocurrency, Crypto, Token, Coin, Blockchain, Block, Bitcoin, Altcoin, Market Capitalization, Distributed Ledger, Mining, Hashing, Address, Private Key, Public Key, Exchange, Crypto Wallet

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

### 1. Дижитал буюу цахим хөрөнгийн тухай ойлголт

Анх 1983 онд Америкийн шифрлэгч Дэвид Чаум нь “ecash” хэмээх нууцлал өндөртэй шифрлэгдсэн цахим мөнгө зохиожээ. Дараа нь буюу 1995 онд тэрээр хэрэглэгчээс программ хангамж шаарддаг, хүлээн авагч руу мөнгийг илгээхээс өмнө шифрлэгдсэн түлхүүр үгийг ашигладаг криптографийн цахим төлбөрийн эхэн үеийн хэлбэр болох “Digicash”-г бодит байдал дээр туршсан юм. Үүний гол давуу тал нь тухайн цахим мөнгийг банк, засгийн газар болон гуравдагч этгээд хянах боломжгүй болгосонд оршиж байлаа. Америкийн “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл” 1996, 1997 онуудад криптовалют, криптовалютын системийн талаар “Америкийн хуулийн тойм” сэтгүүлд өгүүлэл бичиж нийтлүүлсэн байдаг.

2009 онд анхны криптовалют болох Биткойныг Сатоши Накамото хэмээх нууцлагдмал нэгэн бүтээсэн гэж үздэг. Тэрээр санамсаргүй олон өгөгдлүүдийг эмх цэгцтэй үр дүн болгож гаргадаг алгоритм болох шифрлэлтийн Hash функц “SHA-256”-г ажлынхаа схемд ашигласан түүхтэй.

#### 1.1 Криптовалют буюу цахим мөнгө гэж юу вэ?

Криптовалют нь ажил гүйлгээний үр дүнг оролцогч талуудтай холбодог, валют эзэмшигчийн мэдээллийг хүчирхэг криптографаар дамжуулан мэдээллийн бааз хэлбэртэйгээр компьютерийн журналд найдвартайгаар бүртгэн хадгалдаг, солилцоо, зуучлалын үүргийг гүйцэтгэдэг цахим хэрэгсэл юм. (Криптограф нь криптовалютын цахим

<sup>32</sup> <https://legislation.mt/eli/cap/592/eng/pdf>

<sup>33</sup> <https://legislation.mt/eli/cap/591/eng/pdf>



### Эх сурвалж: *Number of crypto coins 2013-2021 | Statista*


Түүнээс гадна өмнөх блокийн мэдээлэл өөрчлөгдсөн бол бусад блокийн мэдээлэл ч устаж, хүчингүй болсон байдаг. Мөн блокт байрлуулсан мэдээлэлд хэн нэгэн оролцогч хөндлөнгөөс нөлөөлөн өөрчлөлт оруулах боломжгүй юм.

Ерөнхийдөө блокчэйн буюу бэлэн бус төлбөр тооцоонд ашиглагддаг бүртгэл тооцооны дэвтрийг энэхүү криптографаар дамжуулан хувиргаснаар криптовалюта үүсч байдаг гэж хэлж болно. Арилжаанд оролцогчид өөр өөрсдийн “address” буюу хаягтай байх бөгөөд валют шилжүүлэх үедээ хүлээн авагчийн хаягийг зааж өгдөг. Хаяг хэн нэгэнд мэдэгдвэл энэ нь нууцлал алдаж байгаа зүйл огтхон ч биш. Ажил гүйлгээ хийх үед криптовалюта нь “wallet” буюу зориулалтын цахим түрийвчинд орох бөгөөд хэрэглэгч өөрийн хувийн нууц үгийг ашиглаж түрийвчинд шилжиж орсон мөнгийг татаж авах боломжтой байна.<sup>37</sup> Нууцлалын зэргийг ямар түвшинд байлгахыг хүсч байгаагаас шалтгаалж хэрэглэгч цахим түрийвчийг сонгох боломжтой байдаг. Хувийн нууц<sup>38</sup> түлхүүр нь “Фермагийн их теорем”, “Эйлерийн тэнцэтгэл” зэрэгтэй холбоотой алгебрийн асар өндөр түвшний нарийвчлал, логик, нүсэр тооцоололд тулгуурлаж тодорхойлогддог тул хэн нэгэн хүн үүнийг тайлж олох боломж бараг үгүй юм. Мөн “public key” гэсэн ойлголт байх бөгөөд энэ нь ажил гүйлгээг шифрлэх үүрэгтэй. Валют хүлээн авагч нь өөрийн хувийн нууц түлхүүрийг ашиглан шифрийг тайлан шилжүүлгийг хүлээж авах боломжтой болдог байна.

### 1.3 Криптовалютын төрөл<sup>39</sup>

Криптовалютын нэр төрөл, тоо хэмжээ сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж байгааг дараах графикаас харж болно. Ялангуяа 2019, 2020, 2021 онуудад тоо хэмжээ нь өмнөх жилүүдээс огцом өссөн байна.

Зураг 2. Криптовалютын тоо 2013 (1)-2021(8)



Эх сурвалж: *Number of crypto coins 2013-2021 | Statista*

**Altcoin:** Энэ нь биткойноос бусад цахим валютыг илэрхийлнэ. Түүний түгээмэл төрлүүд нь

- ✓ Peercoin
- ✓ Litecoin
- ✓ Dogecoin
- ✓ Auroracoin

<sup>37</sup> [Cryptocurrency wallet - Wikipedia](#)

<sup>38</sup> [Public Keys and Private Keys | How they work with Encryption \(comodo.com\)](#)

<sup>39</sup> [Just a moment... \(sofi.com\)](#)

✓ Namecoin зэрэг болно.

**Токен:** Altcoins-оос ялгаатай нь токenuудыг анх удаа олон нийтэд санал болгох (Initial Coin Offering) замаар гаргадаг. Токenuудыг дараах байдлаар ангилж болно:

- Үнэ цэнийн (Биткойнтой адил)
- Аюулгүй байдлын (дансаа хамгаалах зорилгоор)
- Ашиглалтын (тодорхой хэрэглээнд зориулагдсан)

Эдгээр нь мөнгөний үүргийг бус харин функцийн үүргийг гүйцэтгэдэг. АНУ-ын доллартай адилаар үнэ цэнийг илэрхийлдэг боловч токenuуд нь дангаараа үнэ цэнэтэй биш юм. Токенүүд нь шифрлэлтийн нэгэн төрөл бөгөөд ялангуяа мөнгөн шилжүүлэг, төлбөр тооцоо зэрэг ажил гүйлгээний криптографийг харуулсан урт тоо, үсэг зэрэг тэмдэглэгээтэй холбоотой ойлголт. Товчоор хэлбэл, токен нь олон янзаар хэрэглэгддэг онцлогтой. Тухайлбал, Bitcoin, Ethereum зэрэг нь токены төрөлд орно.

Хамгийн түгээмэл тархсан криптовалютуудыг доор харуулав:

- Peercoin,
- Dogecoin
- Auroracoin
- Namecoin
- Omni
- Nxt
- Waves
- Counterparty
- Bitcoin
- Bitcoin Cash
- Litecoin
- Ethereum
- Ripple
- Stellar
- NEO
- Cardano
- IOTA

#### 1.4 Цахим мөнгөний харилцаанд оролцогчид, тэдгээрийн онцлог

Цахим мөнгөний харилцаанд тодорхой сонирхол, үүрэг бүхий олон оролцогчид ордог бөгөөд тэдгээр нь өөр өөрсдийн сонирхол, эрх, үүрэгтэй байдаг гэж хэлж болно. Дараах зурагт цахим мөнгөний харилцаанд оролцогч талуудыг системчлэн харуулав.

Зураг 3. Цахим мөнгөний харилцаанд оролцогчид

Татагдан оролцогчид	Дэмжигчид, нөлөө үзүүлэгчид	Хөрөнгө оруулагчид	Зээлдүүлэгчид	Бизнесийн байгууллагууд
Цахим мөнгө хөгжүүлэгчид	Цахим мөнгөний харилцаанд оролцогчид			Олборлогчид
Хэрэглэгчид				Олборлох төхөөрөмжийг нийлүүлэгчид
Судалгааны хүрээлэн				Хамтран олборлогчид
Шинжлэх ухааны байгууллагууд	Арилжаачид	Татварын байгууллага	Үнийн савлагаа үүсгэгчид	Засгийн газар

Эх сурвалж: [What stakeholders are involved in the blockchain strategy system? | GetSmarter Blog](#)



### 1.5 Цахим мөнгийг яагаад худалдаж авдаг вэ?<sup>40</sup>

Цахим мөнгө худалдаж авах шалтгааныг дараах байдлаар ангилан тодорхойлж болно:

1. Хөрөнгө оруулалтын зорилгоор буюу өгөөж олох
2. Бараа үйлчилгээг худалдаж авах
3. Засгийн газрын зохицуулалтаас мөнгөн хөрөнгө, эзэмшиж буй баялгаа хараат бус байлгах, тухайлбал инфляцийн нөлөөллөөс хамгаалах гэх зэрэг
4. Үнэ цэнийг хамгаалах буюу хуримтлалын зорилгоор, энэ нь үргэлж биелээд байдаггүй. Цахим мөнгөний үнэ өндөр хэлбэлзэлтэй байх тохиолдол цөөнгүй байдаг

### 1.6 Цахим мөнгөний давуу, сул тал, аюул, боломж<sup>41</sup>

Үйлдвэржилт, мэдээллийн технологийн оролцоо нэмэгдэж буй өнөө цаг дор дижитал буюу цахим валютыг чухалд үзэж хөрөнгө оруулалтын зорилгоор бусад фиат валютаас дээгүүрт тооцох хандлага нэмэгдэж байна. Ингээд цахим мөнгөний давуу болон сул талууд юу болохыг авч үзье.

#### Цахим мөнгөний давуу тал

- Инфляцаас хамгаална.

Нийлүүлэлт нь хязгаарлагдмал, аажмаар өсдөг. Эрэлт өсөхөд үнэ цэнэ нь нэмэгдэх учраас урт хугацаанд үнийн өсөлтөөс хамгаалагдсан хэрэгсэл гэж тооцогдож байна.

- Өөрийгөө зохицуулан удирдана.

Цахим валютыг олборлох, арилжих, гүйлгээнд хэрэглэх зэрэг үйл явц нь оролцогч талуудад нээлттэй байдаг. Өөрөөр хэлбэл, систем нь өөрөө өөрийгөө удирдаж, зохицуулна. Ажил гүйлгээний мэдээлэл, байнгын бүртгэл хөтлөлт нь цахим валютын нэгдмэл байдлыг бүрдүүлж, олон нийтийг арилжаанд тэгш эрхтэйгээр оролцох боломжоор хангана.

- Аюулгүй байдал буюу нууцлал

Хандалтын болон системийн нууцлал өндөртэй. Ажил гүйлгээ болон хэрэглэгчийн нууцлалыг блокчэйнийн технологи, математикийн төвөгтэй бодлогуудаар дамжуулан маш өндөр түвшинд хадгалж чаддаг.

- Ажил гүйлгээг харьцангуй хялбараар хийх боломжтой.

Цахим мөнгийг төрөл бүрийн валютыг ашиглан худалдан авч болно. Цахим мөнгийг арилжих замаар оролцогсод өөрт хэрэгцээтэй байгаа валютыг харьцангуй бага шимтгэлтэйгээр олж авах боломжтой.

- Төвлөрсөн бус

Үүсгэн байгуулагчаас эхлээд их хэмжээний цахим мөнгө эзэмшиж байгаа хүмүүс, зах зээлд шинээр нийлүүлэхээр бэлтгэж байгаа байгууллагууд бүгд цахим мөнгөнд анхаарлаа хандуулж, хяналт тавьж байдаг. Төвлөрсөн бус байх нь засгийн газрын мэдэлд байдаг уламжлалт мөнгөний хэлбэртэй харьцуулахад мөнгийг монополь байдлаар эзэмшихээс сэргийлж, үнэ цэнэ нь тогтвортой байх боломжийг бүрдүүлж өгдөг.

<sup>40</sup> [3 Good Reasons to Buy Bitcoin -- and 2 Bad Ones \(fool.com\)](#)

<sup>41</sup> [Advantages and Disadvantages of Cryptocurrency in 2020 - GeeksforGeeks](#)

- Зардлын хэмнэлттэй ажил гүйлгээ хийх боломжийг олгодог.

Виза, Раурал зэрэг ажил гүйлгээг баталгаажуулах гуравдагч талын оролцоог үгүйсгэж чаддаг. Учир нь ажил гүйлгээний шимтгэл нэн багатай байна.

- Ажил гүйлгээг маш богино хугацаанд хийдэг.

Баталгаажуулалттай холбоотой харьцангуй цөөн тооны саад, сорилт байдаг тул дотоодын болон олон улсын төлбөр тооцоо, ажил гүйлгээг маш богино хугацаанд хийдэг.

### **Цахим мөнгөний сул тал**

- Хууль бус ажил гүйлгээнд ашиглах боломжтой.

Нууцлал, найдвартай байдлын зэрэг нь өндөр тул засгийн газрын зүгээс цахим мөнгө эзэмшигчдийн мэдээллийг мөшгих, хянах боломж хязгаарлагдмал байна. Хуулийн дагуу олж аваагүй мөнгөө хэн нэгэн хүн цахим мөнгө худалдаж авах замаар эх сурвалжийг нь нуух оролдлого хийх боломжтой.

- Мэдээлэл алдагдвал санхүүгийн алдагдал хүлээнэ.

Хэдийгээр найдвартай байдал өндөртэй ч мэдээлэл алдагдвал ялангуяа хувийн нууц түлхүүрээ алдсан хэрэглэгч өөрийн цахим мөнгөө алдана. Энэ үед цахим түрийвч дотор нь байгаа мөнгөний хамтаар түгжигдэнэ.

- Төвлөрөл багатай хэдий ч удирдан зохицуулах байгууллага оршиж байдаг.

Цахим мөнгө нь төвлөрсөн нэг удирдлагаас ангид байдаг онцлогтой. Гэхдээ зах зээлд байгаа зарим цахим мөнгөний хэмжээ, урсгал нь түүнийг бүтээгчид болон холбогдох зарим байгууллагын хяналтад байсаар байдаг. Учир нь эзэмшигчид цахим мөнгөний үнэд огцом өөрчлөлт бий болгох боломжтой байхыг үгүйсгэхгүй. Их хэмжээний арилжаа үнийн өөрчлөлтийн өндөр хэлбэлзлийг бий болгодог. Тухайлбал, Биткойны үнэ 2017 онд хэд дахин өссөн юм.

- Зарим цахим мөнгө зөвхөн цөөн тооны засгийн газрын баталгаатай мөнгөнд хөрвөх боломжтой байдаг.

Цөөн тооны валютад хөрвөх хязгаарлалтыг зааж өгсөн нь зарим талаар зардлыг нэмэгдүүлэх нөлөөтэй. Тухайлбал, зохицуулах байгууллагын эрх зүйн орчны хүрээнд зааж өгснөөс бусад валютад цахим мөнгөө хөрвүүлэхийн тулд арилжааны нэмэлт шимтгэл төлөх шаардлагатай болдог тохиолдлууд байна.

- Олборлолтын хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөө

Цахим мөнгөний гол олборлогчид Хятад улсад байгаа бөгөөд өндөр чадалтай, эрчим хүч их хэрэглэдэг компьютерийг олборлолтондоо ашиглаж байна. Эрчим хүчний өндөр хэрэглээг хангахын тулд нүүрс ихээр хэрэглэж байгаа бөгөөд энэ нь агаарын бохирдлыг нэмэгдүүлж байна.

- Хакердуулах боломжтой

Хэдийгээр найдвартай байдал өндөртэй хэдий ч биржүүд тийм ч найдвартай биш. Ихэнх биржүүд хэрэглэгчийн нэвтрэх нэрийг зохих шаардлагын дагуу ажиллуулахын тулд арилжаанд оролцогчийн цахим түрийвчийн мэдээллийг хадгалдаг. Энэ мэдээлэл нь хакеруудад алдагдаж, олон тооны дансанд нэвтрэх боломжийг олгосноор цахим мөнгийг нэг данснаас нөгөө данс уруу шилжүүлэх боломжтой болно. “Bitfinex” болон “Mt Gox” зэрэг



биржүүдээс олон сая долларын цахим мөнгө алдагдсан тохиолдол гарсан байдаг.

- Цуцлах боломжгүй байдал

Хэрэв хэн нэгэн андуурч цахим мөнгөө буруу цахим хаяг уруу санаандгүй шилжүүлвэл, мөнгө илгээсэн тал өөрийн шилжүүлсэн цахим мөнгийг буцааж олж авах боломжгүй байна. Зарим хүмүүс худал хэлж цахим мөнгөний шилжүүлгийг бусдаар хийлгэх тохиолдол гарахыг үгүйсгэхгүй. Нэгэнт шилжүүлсэн мөнгөө буцааж олж авах боломжгүй учраас бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэхгүйгээр цахим мөнгөтэй болох сэдэл ч бусдад төрж болно. Ингээд дурдсан давуу, сул талуудыг баяжуулан нэгтгэж, цахим мөнгөний Свот шинжилгээг авч үзвэл дараах байдалтай байна.<sup>42</sup>

#### Давуу тал

- Төлбөрийн уян хатан хэрэгсэл болдог. Өндөр хяналтгүй.
- Ажил гүйлгээ богино хугацаанд хийгддэг.
- Цахим мөнгө өнгөрсөн хугацаанд маш их хэмжээгээр өссөн.
- Хэн ч цахим мөнгийг бусдад шилжүүлэх боломжтой.
- Хяналт тавих дан ганц төвлөрсөн удирдлагагүй.
- Цахим мөнгө нь нэргүй, гэхдээ практикт нэргүй хэрэглэгч байх нь амаргүй байдаг.

#### Сул тал

- Энэ нь бодит үнэ цэнэгүй.
- Хакердуулж мөнгөө алдах боломжтой.
- Сүлжээ нь зөвхөн хязгаарлагдмал тооны ажил гүйлгээг зөвшөөрч болно.
- Цахилгаан их хэрэглэж хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Олон тооны гэмт бүлэглэлийн биткойныг хурааж авсан тохиолдлууд гарч байсан.

#### Боломж

- Үнэ нь тогтвортой өсөх боломжтой.
- Олон нийт технологи болон сүлжээний орчинг засаж, цахим мөнгөөр хийгдэх ажил гүйлгээний нийт зардлыг бууруулж болно.
- Олон нийт технологи болон сүлжээг өөрчлөх санаачлага гаргаж, цахим мөнгө олборлогчдын эрчим хүчний хэрэглээг багасгаж, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж болно.
- Гол валютууд үнэ цэнээ алдаж, бизнесүүд алдагдал хүлээж эхэлбэл хүмүүс эдийн засгийн нөхцөл байдалтай холбоогүй байдаг онцлогтой цахим мөнгийг эрэлхийлж болно.
- Дэлхий дахинд бий болсон эдийн засгийн тогтворгүй байдал нь хүмүүсийг мөнгөө цахим мөнгө хэлбэрээр нууж, баялгаа хамгаалах үйлдэл хийхэд хүргэж болох юм.

#### Аюул

- Засгийн газрын баталгаагүй.
- Хүмүүс хакердуулах боломж багатай болон зардал шаардахгүй илүү сайн мөнгө шилжүүлэх аргыг олж болох юм.
- Цахим мөнгөтэй холбогдсон хууль бус их хэмжээний мөнгө нь хүмүүсийн цахим мөнгө ашиглах сонирхлыг бууруулж магадгүй.
- Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө нь хэрэглээг нь бууруулах шалтгаан болох боломжтой.
- Квантын компьютерууд болон зарим шинэ алгоритмууд гэнэт гарч ирэн цахим мөнгөний системийг нурааж болно.

<sup>42</sup> [\(PDF\) The SWOT Analysis of Crypto-currency and Bitcoin \(researchgate.net\)](#)

## 1.7 Цахим мөнгөний үнэд нөлөөлөгч хүчин зүйлс<sup>43</sup>

Цахим мөнгийг төв банкнаас гаргадаггүй, цахим мөнгөнд засгийн газрын баталгаа байдаггүй. Тийм ч учраас мөнгөний бодлого, инфляц, эдийн засгийн өсөлт зэрэг уламжлалт мөнгөний ханшид нөлөө үзүүлэгч хүчин зүйлс нь цахим мөнгөнд нөлөө үзүүлэхгүй. Харин цахим мөнгөний үнэд дараах хүчин зүйлс нөлөөлдөг гэж үздэг байна. Үүнд:

- ❖ Цахим мөнгөний эрэлт, нийлүүлэлт
- ❖ Олборлолт хийх замаар гаргаж авсан цахим мөнгөний үйлдвэрлэлийн зардал
- ❖ Блокчэйнд ажил гүйлгээг бүртгүүлж, баталгаажуулсны төлөө цахим мөнгө олборлогчдод төлсөн урамшуулал, хөлс
- ❖ Блокчэйнээр ажил гүйлгээ хийсний төлөөх шимтгэлийн хувь
- ❖ Өрсөлдөгч цахим мөнгөнүүд, тэдгээрийн тоо хэмжээ
- ❖ Арилжаа нь явагддаг биржүүд
- ❖ Ажил гүйлгээг нь зохицуулах эрх зүйн орчин, хуулийн зохицуулалт
- ❖ Цахим мөнгөний системийн дотоод засаглал

### Цахим мөнгөтэй холбоотой гол ойлголтуудыг нэгтэн үзэхүй


Асуултууд	Хариулт
Цахим мөнгө санаачлан хөгжүүлэгч хэрхэн ашиг олдог вэ?	Олборлолтын шагнал, ажил гүйлгээний шимтгэл
Хэн хамгийн сайн олборлолт хийх вэ?	Хамгийн сайн, хамгийн өндөр чадалтай компьютер ашиглаж буй хүмүүс, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлдэг компаниуд олборлолтыг хамгийн сайн хийдэг.
Хамгийн шилдэг цахим мөнгө ямар шинж чанартай байх вэ?	Цахим мөнгөний шинж чанарыг тодорхойлогч үзүүлэлтүүд, тухайлбал нууцлал, аюулгүй ажиллагаа, хэрэглээний энгийн хялбар байдал хэр зэрэг байгаагаас тухайн цахим мөнгөний үнэ цэнэ ямар байх нь тодорхойлогдоно. Эдгээр үзүүлэлтийн чанар харьцангуй сайн байвал ажил гүйлгээний шимтгэл нь ч өндөр байх боломжтой.
Цахим мөнгөний бирж гэж юу вэ?	Цахим мөнгөний арилжаа явуулах тусгай биржүүд байдаг. Эдгээр нь цахим мөнгийг бусад төрлийн хөрөнгүүдтэй, уламжлалт засгийн газрын баталгаат мөнгө болон бусад цахим мөнгөтэй солилцох боломжийг олгосон зориулалтын платформууд юм.
Цахим мөнгөний биржийн ямар шимтгэлүүд байдаг вэ?	Trading fee буюу арилжааны шимтгэл, Deposit/Withdrawal Fees буюу цахим мөнгийг байршуулах болон татан авахтай холбоотой шимтгэл, Interest/Borrowing/Liquidation Fees буюу зээл авч цахим мөнгөний арилжаанд оролцоход ногдох шимтгэл зэрэг шимтгэлүүд байна.
Цахим мөнгөний биржийн шимтгэлүүдийн хувь хэмжээ юунаас хамаарч тогтох вэ?	Бирж аль болох богино хугацаанд үйлчилгээг үзүүлж, хэр сайн арилжааг зохион байгуулж чадаж байгаагаас шимтгэлийн хэмжээ нь тогтоогдож байдаг. Зарим биржүүд шимтгэлийн хувь хэмжээндээ хөнгөлөлт үзүүлэх ч тохиолдол байна.

*Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл*

<sup>43</sup> [\(PDF\) Factors Influencing Cryptocurrency Prices: Evidence from Bitcoin, Ethereum, Dash, Litecoin, and Monero \(researchgate.net\)](#)


## 1.8 Цахим мөнгөтэй холбоотой зарим статистик мэдээлэл

Зураг 4. Биткойн, алт, S&P 500 индексийн динамик




Эх сурвалж: [cryptocurrencies data images 2020](#)

Зураг 5. Цахим мөнгөний капиталжуулалт буюу зах зээлийн үнэлгээ/дэлхий дахинд/




Эх сурвалж: [Search | Statista](#)

Зураг 6. Биткойны капиталжуулалт буюу зах зээлийн үнэлгээ



Эх сурвалж: [Search | Statista](#)



Эх сурвалж: [All Cryptocurrencies | CoinMarketCap](#)

## 2. Виртуал хөрөнгийн чиг хандлага

### 2.1 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гарч болзошгүй эрсдэл<sup>44</sup>

Виртуал хөрөнгө болон цахим мөнгө нь хоёулаа дижитал валютууд юм. Ялгаа нь цахим мөнгийг Фиат валют (Хууль ёсны валют) баталгаажуулж байдаг гэж хэлж болох бөгөөд фиат валютын гүйлгээний нэгээхэн төрөл, механизм болгож ашигладаг. Хэдийгээр виртуал хөрөнгийг фиат мөнгө шууд утгаараа дэмждэггүй ч, түүнийг шинээр бүтээж, цахимаар эзэмшиж, төлбөр шилжүүлэх зорилгоор ашиглаж болно.

Блокчэйн, биткойн, крипто хөрөнгө, виртуал валют... гэх зэрэг үгс нь дэлхий нийтийн үнэ цэнийг өөрчилж чадах шинэлэг технологийг дүрсэлсэн цоо шинэ ойлголтууд болоод байна. Блокчэйн нь 10 гаруй жилийн өмнө үүссэн. Блокчэйн үүссэн цагаас хойш виртуал хөрөнгө өргөн дэлгэрч, төлбөрийн хэрэгсэл болж эхлээд байгаа юм.

ФАТФ нь виртуал хөрөнгөд голчлон анхаардаг бөгөөд онолын хэсэгт дурдсанчлан энэ нь маш олон ашиг тустай. Виртуал хөрөнгийн тусламжтайгаар төлбөр төлөх үйл явц илүү хялбар, хурдан хийгддэг болсон юм. Виртуал хөрөнгийг тогтмол санхүүгийн үйлчилгээ авах боломжгүй хүмүүст зориулсан шинэлэг хэрэгсэл ч гэж үзэж болно. Гэхдээ зохицуулалт байхгүй бол гэмт хэрэгтэн, террористуудын санхүүгийн гүйлгээ хийхдээ ашигладаг виртуал мөнгөний зоорь болох ч эрсдэлтэй.

“Их 20”-ийн дэмжлэгтэйгээр виртуал хөрөнгийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор ФАТФ дэлхийн хэмжээний стандартыг гаргасан. Виртуал хөрөнгө гэсэн нэр томъёо нь дижитал хэлбэрээр арилжаалагдах, шилжүүлэх эсвэл төлбөр хийж болох үнэ цэнийн дижитал үзүүлэлтийг илэрхийлсэн ойлголт юм.

2018 онд Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах төв байгууллага виртуал хөрөнгө, түүний үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой зөвлөмжид өөрчлөлт оруулсан. Оруулсан өөрчлөлтийг 2015 оны Виртуал валютын эрсдэлд суурилсан аргачлалын заавар нэртэй тайланд хавсаргасан байдаг. ФАТФ нь виртуал хөрөнгөтэй холбоотойгоор терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах үйл ажиллагаа их байгааг тогтоосон байна. Виртуал хөрөнгийн гүйлгээ нь алсын зайнаас хурдан хийгддэг, захиргааны харьяалалгүй, нэр нь үл мэдэгдэх зэрэг онцлогтой байх тул виртуал хөрөнгийн харилцааг нэгдсэн зохицуулалтад оруулах шаардлагатай болсон.

ФАТФ-ын стандартууд нь санхүүгийн салбарын нэгэн адил виртуал хөрөнгийн хамгаалалт, шударга зарчмуудаар хангаж өгнө. ФАТФ-ын боловсруулсан дүрмийн дагуу виртуал хөрөнгийг фиат валютаар сольж болох бөгөөд нэг виртуал активаас нөгөөд шилжүүлэг хийхдээ мөн зохих дүрмийг мөрдлөг болгоно.

### 2.2 Виртуал хөрөнгөтэй холбоотой эрсдэл

Виртуал хөрөнгө нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой дараах эрсдэлүүдийг бий болгож болзошгүй юм.

<sup>44</sup> [http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/bulletin/FATF-Booklet\\_VA.pdf](http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/bulletin/FATF-Booklet_VA.pdf)

- Интернет дэх виртуал хөрөнгийн гүйлгээнд нэрээ нууцлах явдал их байгаа нь хувь хүмүүс болон гүйлгээнд хамрагдсан хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлоход бэрхшээлийг үүсгэдэг.
- Виртуал хөрөнгийн эрсдэлтэй гэж тооцогддог нэг үзүүлэлт бол үнийн өндөр хэлбэлзэл, үнийн таамаглал хийхэд төвөгтэй байдаг явдал байна.
- Виртуал хөрөнгийн гүйлгээ нэгэнт хийгдсэн бол түүнийг буцаах боломжгүй.
- Виртуал хөрөнгө нь фиат мөнгө рүү хялбар шилжих бөгөөд AML/CFT (мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх)-ийн шаардлагыг хангахгүй байж болзошгүй.
- Хэд хэдэн улс оронд хийгдсэн гүйлгээ AML/CFT-тэй нийцэж байгаа эсэх, хяналт, хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа нь тодорхой бус байгаа нь нотлогдсон.
- Хяналтын төв байгууллага байхгүй байгаа нь виртуал хөрөнгөтэй холбоотой сэжиг бүхий гүйлгээнд хяналт тавих, хэв шинжийг нь тодорхойлох боломжийг олгохгүй байгаа бөгөөд мөнгө угаах гэмт хэргээс сэргийлэхэд чиглэгдсэн програм хангамж одоогоор байхгүй байна.
- Хууль сахиулах байгууллага нь мөрдөн байцаалт хийх, виртуал хөрөнгийг хураах зорилгоор дан ганц төв байр эсвэл аж ахуйн нэгжийг (удирдагч) онцлон шалгаж болохгүй.
- Мөрдөн байцаалтаар гүйлгээний ул мөрийг илрүүлэхэд хэцүү.
- Виртуал хөрөнгийн системд Интернетээр (гар утсаар дамжуулан) нэвтрэх боломжтой бөгөөд хил дамнасан төлбөр тооцоо, мөнгөн шилжүүлэг хийхэд ашиглаж болно. Энэ нь гэмт хэргээс олсон орлогоо нуун дарагдуулж, далдлах сэдлийг бий болгож, тухайн бүс нутгийн гэмт хэрэгт гарах үйл явцыг өдөөж болзошгүй.
- Хөрөнгө, гадаад валют их хэмжээгээр гадагш шилжихэд хүргэж төлбөрийн балансад тэнцвэртэй бус байдлыг бий болгож, улс орнуудын эдийн засагт хохирол учруулж болно.
- Виртуал хөрөнгө, түүний гүйлгээ нь терроризмын санхүүжүүлэлтэд өртөмтгий.
- Виртуал хөрөнгийн гүйлгээг “даркнэт” ашиглан хийж болох бөгөөд энэ нь дарк вэб дэх хууль бус худалдаанд ихэвчлэн хэрэглэгддэг.
- Виртуал хөрөнгийг арилжаалахад хууран мэхлэх, залилангийн хэрэг үүсэх эрсдэлтэй.

### **2.3 ФАТФ-ын тайлангийн дагуух виртуал хөрөнгийн систем**

Виртуал хөрөнгийн системийн голлох оролцогчид нь:

1. Удирдагч нь төлбөрийн дэвтэр хөтлөх, виртуал хөрөнгийг эргүүлэн авах эрхтэй, төвлөрсөн виртуал хөрөнгийг гаргадаг, түүнийг ашиглах дүрмийг тогтоодог хүн, эсвэл аж ахуйн нэгж юм.
2. Олборлогч нь виртуал хөрөнгийн систем дэх гүйлгээг баталгаажуулахад ашигладаг нотолгооны системд ярвигтай алгоритмуудыг шийдвэрлэдэг тусгай програм ажиллуулж төвлөрсөн бус виртуал хөрөнгийн сүлжээнд оролцдог хүн эсвэл аж ахуйн нэгж юм.
3. Арилжигч гэдэг нь виртуал хөрөнгийг бодит мөнгөн тэмдэг, хөрөнгийн сан юм уу худалдааны бусад хэлбэрийн виртуал хөрөнгөөр солих бизнес эрхэлдэг хүн эсвэл аж ахуйн нэгж юм. Арилжигч нь бэлэн мөнгө, мөнгөн гуйвуулга, кредит карт, болон бусад виртуал хөрөнгө зэрэг төрөл бүрээр төлбөрөө авдаг. Хувь хүн ихэвчлэн арилжигчаар дамжуулан дансанд виртуал хөрөнгө байрлуулах, авахын тулд ашигладаг. Bitfinex,

Coinbase, Bitstamp, Poloniex, Coinmama, CEX.IO гэх зэрэг алдартай арилжигч газрууд бий.

4. Хэрэглэгч гэдэг нь виртуал хөрөнгө олж, бодит ба виртуал бараа, үйлчилгээнд зарцуулдаг, хувийн хэрэгцээндээ шилжүүлэн ашигладаг хүн эсвэл аж ахуйн нэгжийг хэлнэ. Хэрэглэгчид виртуал хөрөнгийг хэд хэдэн аргаар олж авах боломжтой. Тухайлбал,
  - Арилжигчаас эсвэл шууд удирдагчаас бодит мөнгөөр худалдан авах боломжтой.
  - Олборлогч нь виртуал хөрөнгөөр төлбөр төлдөг тодорхой үйл ажиллагаа эрхэлж олно (жишээлбэл, сурталчилгаанд хариу өгөх, онлайн судалгааг бөглөх, бодит эсвэл виртуал бараа, үйлчилгээ үзүүлэх).
  - Виртуал хөрөнгийн валютыг өөрөө олборлох.
5. Виртуал хөрөнгийн хэтэвч нь биткойн ба бусад виртуал хөрөнгийг хадгалах, эзэмших, шилжүүлэх програм.
6. Хэтэвчийн үйлчилгээ үзүүлэгч гэдэг нь биткойн ба бусад виртуал хөрөнгийг хадгалах, эзэмших, шилжүүлэх виртуал хэтэвч өгдөг байгууллага юм. Хэтэвчээр үйлчилгээ үзүүлэгч нь виртуал хөрөнгийн гүйлгээг хэрэглэгч, арилжигч, худалдаачинд илүү хялбар болгох аргаар виртуал хөрөнгийн системийг хялбарчилна. Хэтэвчийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн виртуал хөрөнгийн үлдэгдлийг тэнцвэртэй байлгаж, мөн хадгалалт, гүйлгээний аюулгүй байдлыг хангана. Bitcoin Core протокол, Electrum, Exodus, Jaxx, Copay, Coinbase, Blockchain зэрэг алдартай хэтэвч байдаг.

Оролцогчдын байдлаас шалтгаалан виртуал хөрөнгийг төвлөрсөн, төвлөрсөн бус гэж ангилна.

#### Виртуал хөрөнгө:

Шалгуур	Төвлөрсөн/ <i>centralized</i>	Төвлөрсөн бус/ <i>decentralized</i>
Програм хангамжийн архитектур	Төвлөрсөн	Тараах (Блокчэйн)
Гаргагч	Удирдагч/ <i>administrator</i>	Олборлогч
Арилжааны хүү	Харьцах	Хөвөгч
Хөрвөх чадвар	Фиат валютаар солилцоно	Фиат валютаар солилцоно
Оролцогчид	Удирдагч, Арилжигч, Хэрэглэгч	Олборлогч, Арилжигч, Хэрэглэгч
Жишээ	E-gold, WebMoney, Linden Dollars	Bitcoin, Onecoin, Litecoin, Ripple

#### 2.4 Виртуал хөрөнгөд тавигдах ФАТФ-ын шаардлага

ФАТФ дараах виртуал хөрөнгөтэй холбоотой дараах заавруудыг тухай бүрт нь гаргаж ирсэн байдаг.

- “Виртуал валют: Үндсэн ойлголт, AML/CFT-ийн болзошгүй эрсдлүүд” гэсэн нийтлэл, заавруудыг 2014 оны 6-р сард гаргасан.
- “Виртуал валютын эрсдэлд суурилсан аргачлалын заавар”-ыг 2015 оны 6-р сард гаргасан.
- ФАТФ "виртуал хөрөнгө" (VA)7, "виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч" (VASP) гэсэн хоёр шинэ нэр томъёоны тайлбарыг гарган баталж, 2018 оны 10-р сард “Зөвлөмж 15”-ыг шинэчилсэн.
- 2019 оны 6-р сард виртуал хөрөнгөтэй холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (L/TF) эрсдэлээс үүдэн ФАТФ-ын шаардлагыг тодорхой болгох



зорилготойгоор ФАТФ “Зөвлөмж 15-д” тайлбар тэмдэглэл нэмж оруулсан. “Виртуал хөрөнгийн эрсдэлийг удирдах, бууруулахын тулд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааны эсрэг (AML/CTF) зорилгод нийцүүлэн зохицуулж, тусгай зөвшөөрөл олгодог, бүртгэдэг, хяналт тавьдаг, ФАТФ-ын зөвлөмжид дурдсан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлдэг үр дүнтэй системд хамрагдах ёстой.” гэсэн шаардлагыг ФАТФ-ын зүгээс тавьдаг. ФАТФ нь хэрэглэгчдэд дүн шинжилгээ хийж, байнгын хяналт тавьж, сэжигтэй гүйлгээг тайлагнах, бүртгэл хөтлөх, виртуал хөрөнгийг ашиглаж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх болон бусад арга хэмжээ авахыг харьяалагдах байгууллагуудаас шаарддаг.

2019 оны зургаан сард виртуал хөрөнгө, түүний үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотой асуудалд ФАТФ-ын зөвлөмж хэрхэн үйлчлэх тухай тодруулга өгөх зорилготой 40 зөвлөмжид тайлбар тэмдэглэл хэлбэрийн шинэ заавар гаргасан байна. Энэхүү зөвлөмж нь виртуал хөрөнгө, түүний үйлчилгээ үзүүлэгчдэд өгөх хянагч, зохицуулагчдын хариу үйлдлийг ойлгох, боловсруулахад тухайн үндэстний эрх баригчид болон санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ ухамсарлан виртуал хөрөнгийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй хувийн хэвшлийн байгууллагуудад туслах зорилготой.

ФАТФ-ын зөвлөмж нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг виртуал хөрөнгийн өсөн нэмэгдэж буй хэрэглээнд хариу үйлдэл үзүүлэхээс гадна санхүүгийн салбарт хэрэглэгддэг бараа үйлчилгээ, хурдацтай хөгжиж буй дижитал технологийн орчинд ашиглагдана. Уламжлалт санхүүгийн бүтээгдэхүүнийг орлох шинэлэг финтек бүтээгдэхүүнүүд нь хүний нэрийг нууцлах тул мөнгө угаах ажлаа үргэлжлүүлэх боломжтой гэмт хэрэгтэн, террористуудын анхаарлыг өмнө нь ихэд татаж байсан юм.

“Зөвлөмж 15”-ын өгсөн тайлбар тэмдэглэл нь виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой асуудалд ФАТФ-ын шаардлага хэрхэн хэрэгжих талаар нэмэлт тодруулга өгөх зорилготой бөгөөд доорх асуудлуудыг хамаарна:

- Виртуал хөрөнгийн үйл ажиллагаа, ашиглалт, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид эрсдэлд суурилсан аргачлал (*RBA-risk based approach*)-ыг хэрэгжүүлэх
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд Мөнгө Угаах/Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (AML/CTF) зорилгоор шалгалт хийх, хяналт тавих
- Тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ (хэрэглэгчдийн дүн шинжилгээ (*CDD-customer due diligence*), бүртгэл хөтлөлт, сэжигтэй гүйлгээний тайлан (*STRF-suspicious transaction reporting*)) гаргах
- Хориг арга хэмжээ болон бусад албадлагын арга хэмжээ
- Олон улсын хамтын ажиллагаа

## 2.5 Виртуал хөрөнгийн чиг хандлага

### 21.04.28 АНУ-ын Төлөөлөгчдийн танхим Дижитал хөрөнгийн шинэтгэлийн хууль батлав.

4-р сарын 20-ны Мягмар гарагт БНН-ын Patrick McHenry санаачилсан H.R. 1602 код бүхий Шинэтгэлийн саадыг арилгах тухай хуулийг АНУ-ын Төлөөлөгчдийн танхим баталлаа. Уг хууль нь тухайн салбарын зохицуулагчид болох Үнэт цаас, биржийн комисс (SEC) болон

Таваарын фючерсийн арилжааны комисс (CFTC)-ийн криптогийн талаар баримтлах бодлогыг тодотгосон байна.

Хуулийг батлах үеэр McHenry хэлэхдээ: “Уг хуулийн дагуу дээрх хоёр зохицуулагчид дижитал хөрөнгийн асуудлаар хамтарсан ажлын хэсэг байгуулах шаардлагатай. Ингэснээр манай зохицуулагчид болон зах зээлд оролцогчдын хоорондох харилцан ойлголцлын эхлэлийг тавих бөгөөд байдлыг илүү ойлгомжтой болгоно.”<sup>45</sup>

#### **21.04.23 Биткойны (Bitcoin/BTC) давамгайллын үзүүлэлт 50%-иас доош уналаа.**

Сүүлийн 3 жилийн хугацаанд зах зээл дэх Биткойны давамгайл байдлын үзүүлэлт анх удаа 50%-иас доош уналаа. Тиймээс ойрын үед уламжлалт бус (алтернатив) койнуудын дахин нэг давалгаа эхлэх шинж байдалтай байна. Өнгөрсөн цөөхөн хоногт Эфир (Ethereum/ETH) үнэ өссөн нь үүний нотолгоо болно.<sup>46</sup>

#### **21.04.23 АНУ-д явуулсан шинэ судалгаа криптогийн сонирхол маш ихээр нэмэгдсэнийг харууллаа.**

Саяхан Gemini компанийн явуулсан судалгаанаас харахад, насанд хүрсэн америк хүний гуравны хоёр нь криптог сонирхож байна. Тиймээс энэ нь маш их тэлэлт бий болгох бөгөөд магадгүй үүнээс ч илүү чухал ач холбогдолтой зүйл бол ирэх саруудад крипто хөрөнгө оруулагчдын төрөлжүүлэлт явагдах төлөвтэй байна. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар, энэ нь криптогийн эрүүл зах зээлд урт хугацаандаа эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй юм.<sup>47</sup>

#### **21.04.23 Venmo крипто арилжаа нээхээр боллоо.**

PayPal компанийн төлбөрийн мобил (гар утасны) үйлчилгээний Venmo компани нь зарим крипто валютыг сонгон дэмжлэг үзүүлэн ажиллаж эхэллээ. Ингэснээр түүний 70 сая гаруй хэрэглэгчид 1 ам. долларын үнэ цэнэ бүхий бага хэмжээний ч бай хамаагүй Биткойн (BTC), Лайткойн (LTC), Эфир (ETH) болон Биткойнкэш (BCH) гэсэн крипто валютаар наймаа/худалдан авалт (болон валютын авах/зарах арилжаа) хийх боломж тун удахгүй бүрдэх болно. Түүнээс гадна уг тавцан (платформ) нь криптог хэрхэн олж авах болон хэрэглэх талаар төрөл бүрийн гарын авлага болон зөвлөмжийг санал болгож байна.<sup>48</sup>

#### **21.04.22 Цахим юанийг Бээжингийн олимпоор олон улсын тамирчид, зочид хэрэглэж магадгүй байна.**

Хятад улс цахим юанийн туршилтаа үргэлжлүүлсээр байгаа билээ. Энэ хүрээнд тэд 2022 онд Бээжинд болох Өвлийн олимпоор гадны тамирчид, зочдод цахим юань хэрэглэх бололцоо олгож магадгүй байна.

Өнгөрсөн Ням гарагт Хятадын Төв банкны Ерөнхий орлогч Ли Бо: “Цахим мөнгөний туршилт нь өнгөрсөн жил 4 хотод болон Өвлийн олимпын орднуудад нээлтээ хийснээс хойш амжилттай үргэлжилж байна” хэмээн хэлсэн нь ийн таамаглахад хүргээд байгаа юм. Уг туршилт нь одоогоор 10 хотыг хамраад байгаа бөгөөд ойролцоогоор 100 сая хүнд хүрээд байна.

Цахим мөнгөний хэрэгжилт нь тэдний хувьд маш чухал зүйл бөгөөд нэвтрүүлж чадвал Хятад нь өөрийн валютын албан ёсны цахим хувилбарыг үүсгэсэн анхны томоохон улс

<sup>45</sup> Crypto News Weekly Roundup <https://freebitco.in>

<sup>46</sup> Changelly.com

болох юм. Бусад улс орнуудын жишээг харвал, Европын Төв банк цахим еврог судалж байгаа бол Английн Төв банк өнгөрсөн даваа гарагт өрх гэр, бизнесийн хэрэглээнд зориулж цахим мөнгө гаргах бололцоог судалж үзнэ гэдгээ мэдэгджээ.

Хятадын төрийн албан хаагчид дижитал юань худалдан авалтыг илүү амар, аюулгүй болгох, банкны дансгүй иргэдэд туслах шинэ үеийн валют хэмээн сайшааж байна. Гэвч дижитал юань нь хүмүүсийн хаана байгааг болон мөнгөө юунд зарцуулж байгаа талаар асар их мэдээллийг засгийн газарт өгөх бөгөөд энэ нь уг мэдээллийг засгийн газраас буруугаар ашиглах вий гэх хардлагыг төрүүлж байгаа юм.<sup>49</sup>

#### **21.04.22 Английн Төв банк цахим мөнгө судлах ажлын хэсэг байгууллаа.**

Английн төв банк болон Хатан хааны төрийн сан хамтран Их Британид төв банкны цахим мөнгө нэвтрүүлэх тухай судлах ажлын хэсэг байгууллаа. Уг ажлын хэсэг нь Их Британид цахим мөнгө нэвтрүүлэх нөөц бололцоог судлах юм байна.

Даваа гарагт буюу 4 сарын 19-нд энэ тухай зарлахдаа, дээрх 2 зохицуулагч байгууллага Их Британид төв банкны цахим мөнгө гаргах эсэхээ шийдээгүй байгаа ба түүний боломжит хэрэглээ болон эрсдлүүдийг судална гэж мэдэгдсэн юм.

Энэ талаар Их Британийн Сангийн сайд Риши Сунак: "Бид нээлттэй, ногоон, технологийн хувьд илүү дэвшилтэт санхүүгийн үйлчилгээний салбарыг бий болгохыг зорьж байгаа. Хөгжиж буй финтекүүдийг дэмжих, дижитал санхүүгийн хязгаарыг ахиулж, санхүүгийн зах зээлээ улам үр ашигтай байлгах алхмууд биднийг урагш хөтөлнө гэж найдаж байна. Бид санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг сайжруулах зорилгоор уг салбарын үйлчилгээг дижиталжуулах ажлын хүрээнд блокчэйн технологийг судалж буй компаниудад Сэндбокс зохицуулалтад орох бололцоог олгож байгаа. Цахим мөнгөний хувьд зах зээлд нэвтэрсэн тохиолдолд бэлэн мөнгө, мөнгөн дэвсгэртэйг орлохгүй. Харин цуг хэрэглэгдэх болно" гэж зохицуулагчдад хандан хэллээ.

Ийнхүү Английн Төв банк цахим мөнгийг маш эрчимтэй судалж байгаагаа илэрхийллээ. Учир нь ажлын хэсгээс гадна, цахим мөнгөний тасаг, цахим мөнгөний судалгааны болон технологийн форумуудыг шинээр үүсгэн байгуулаад байна. Эдгээр шинэ санаачилгууд нь Английн Төв банк дижитал валютын талаар хэлэлцүүлгийн хуудас гаргаснаас нэг жилийн дараа гарч байна. Тухайн үед Төв банк нь цахим мөнгийг сонирхож байгаагаа мэдэгдэж байсан бөгөөд "энэ цаг үе бол мөнгө, төлбөр тооцоонд ихээхэн өөрчлөлт орж буй эрин үе юм" гэж үзсэн байна. Харин өнгөрсөн жил Английн Төв банк нь Канадын банк, Японы банк, Европын Төв банк, Шведийн Свиригес Риксбанк, Швейцарийн Үндэсний банк зэрэг бусад 5 Төв банктай хамтран групп байгуулж, Төв банкны цахим мөнгөний ашиглалтын боломжит хувилбаруудыг судалжээ.

Төв банкны цахим мөнгөний тайланд саяхан тэмдэглэсэнээр: "Дэлхийн Төв банкууд дижитал валютыг судалж байна. Жишээ нь, Европын Төв банк өнгөрсөн онд цахим мөнгөний тал дээр онцгойлон ажлын алба байгуулсан ба уг банк нь дижитал евро гаргах шийдвэрийг хараахан гаргаагүй байна. Харин Хятадын дижитал юань худалдаанд гарахад бараг бэлэн болоод байна" гэжээ.<sup>50</sup>

<sup>49</sup> CNN Business <https://edition.cnn.com/2021/04/19/investing/china-digital-yuan-us-dollar-intl-hnk/index.html>

<sup>50</sup> The Block <https://www.theblockcrypto.com/post/102109/bank-of-england-hm-treasury-new-taskforce-cbdc-digital-currency>

### **21.04.12 ОХУ дижитал рублийн ажлаа эрчимжүүлж байна**

ОХУ-ын Төв банк энэ оны эцэс гэхэд дижитал рублийн анхны загвараа хөгжүүлэхээр ажиллаж байна. Төв банк нь дижитал рубль гаргагч мөн платформын оператор байх хоёр шатлалт хэрэглээний загварыг ашиглахаар болжээ.

Ингэснээр Хятадын дижитал юанийн нэгэн адил арилжааны банкууд дижитал рублийн платформ дээр үйлчлүүлэгчдэдээ цахим түрийвч нээж, эдгээр түрийвчээрээ дамжуулан үйл ажиллагаа явуулах боломжтой болох юм.

Өөрөөр хэлбэл, иргэд, аж ахуйн нэгжүүд ердийн банкны аппликэйшнээр дамжуулан уг валютыг ашиглах боломжтой болно гэсэн үг юм. Дижитал рублийн гол санааг Засаг даргын нэгдүгээр орлогч Ольга Скоробогатов танилцуулахдаа, ОХУ-ын Төв банк нь блокчэйн дээр суурилсан бүртгэлийн (DLT) платформоо хөгжүүлэхдээ нээлттэй эх код ашиглах тухай дурдлаа.

Харин Төв банкны цахим валютын ажлыг эрчимжүүлэх шийдвэрийг ОХУ-ын Төв банкнаас тайлбарлахдаа: “Энэ технологи нь өрх, аж ахуйн нэгжүүдийн зардлыг бууруулж, төлбөрийн хурдыг нэмэгдүүлж, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно” гэжээ.<sup>51</sup>

### **3. Улс орнуудын виртуал хөрөнгийн эрх зүйн зохицуулалт**

2018 оны 6 дугаар сард Конгрессийн Судалгааны алба (CRS)-наас гаргасан дэлхийн 130 гаруй орны криптовалютын хууль, эрх зүйн орчныг судалсан судалгааны дүгнэлтээс үзэхэд, одоогоор дэлхийн бусад орнууд криптовалютын эрх зүйн орчинг бүрдүүлэхдээ ерөнхийдөө мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон татварын хууль, өөрийн орны хууль эрх зүйн орчинд нийцүүлэн зохицуулсан байдалтай байна.

#### **3.1 Малта**

Малта улсад Binance, OKeX, ZBX зэрэг томоохон крипто биржүүд байгуулагдан виртуал хөрөнгийн үйл ажиллагаа явуулдаг. 2021 оны 3 дугаар сарын байдлаар Малта улсад виртуал санхүүгийн хөрөнгийн 16 агент, Виртуал санхүүгийн хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй 2 байгууллага тогтмол үйл ажиллагаа явуулж байна.<sup>52</sup> Малта улс нь Блокчейн, ICO/initial coin offerings/ болон Виртуал санхүүгийн хөрөнгийн үйлчилгээтэй холбоотой 3 хуулийг 2018 онд баталсан юм. Ерөнхийдөө дижитал санхүүгийн хөрөнгийг дараах гурван хуулиар зохицуулж өгсөн байдаг. Үүнд:

- Виртуал санхүүгийн хөрөнгийн тухай хууль /The Virtual Financial Assets Act<sup>53</sup>/
- Шинэлэг технологийн зохицуулалт, үйлчилгээний тухай хууль /The Innovative Technology Arrangements and Services Act<sup>54</sup>/
- Малта улсын дижитал инновацийн албаны тухай хууль /The Malta Digital Innovation Authority Act<sup>55</sup>/ зэрэг юм.

Малта улсын “Виртуал санхүүгийн хөрөнгийн тухай” хууль нь 2018 онд батлагдсан. Хуулийн тодорхойлолтын дагуу криптовалютыг Виртуал Санхүүгийн Хөрөнгө (VFA) гэж ангилж

<sup>51</sup> Finextra <https://www.finextra.com/newsarticle/37842/russia-pushes-ahead-with-digital-ruble>

<sup>52</sup> <https://www.mfsa.mt/publications/corporate-publications/statistics/licenses-statistics/>

<sup>53</sup> <https://legislation.mt/eli/cap/590/eng/pdf>

<sup>54</sup> <https://legislation.mt/eli/cap/592/eng/pdf>

<sup>55</sup> <https://legislation.mt/eli/cap/591/eng/pdf>

болох бөгөөд уг хууль нь хэрэглэгчдийг хамгаалж, салбарын болон түүний оролцогч талуудын өсөлтийг дэмжих цогц дүрмийг агуулсан болно. Энэхүү хуульд криптовалют гаргаж буй хүмүүст болон брокерууд, портфолио менежерүүд, кастодиан, eWallet үйлчилгээ эрхлэгчид, хөрөнгө оруулалтын зөвлөхүүд, криптовалютын бирж зэрэг бусад үйлчилгээ үзүүлэгчдэд тавих хатуу шаардлагыг тусгасан байна.

Виртуал санхүүгийн хөрөнгийн тухай хуулийн гол зорилго нь нийт үйлдвэрлэгчид болон хөрөнгө оруулагчдыг сайн хамгаалалтад байлгахад чиглэгдэх бөгөөд дижитал зах зээлийн дотоод зохицуулалтын харилцаа, зах зээлийг удирдах, лиценз эзэмшигчид хууль бусаар дотоод мэдээллийг ашиглах зэрэг зах зээлийг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх шаардлагыг багтаасан байна. Малтагийн Виртуал Санхүүгийн Хөрөнгийн тухай хуульд "виртуал санхүүгийн хөрөнгө" гэсэн нэр томъёо бүхий криптовалютыг багтаасан болно. Виртуал санхүүгийн хөрөнгийн тухай хуульд виртуал санхүүгийн хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч бүх байгууллагууд Малтагийн санхүүгийн үйлчилгээний газраас (MFSA)<sup>56</sup> тусгай зөвшөөрөл авах ёстой гэж заасан байдаг бөгөөд тусгай зөвшөөрөл авсан байгууллагууд доорх үйлчилгээнүүдийг үзүүлэхийг нь хүлээн зөвшөөрдөг.

1. Захиалга хүлээн авах, дамжуулах;
2. Бусад хүмүүсийн өмнөөс захиалга гүйцэтгэх;
3. Өөрийн дансаар ажил гүйлгээ хийх;
4. Портфолио буюу багцын удирдлагыг хэрэгжүүлэх;
5. Итгэмжлэх, нэр дэвшүүлэх үйлчилгээ үзүүлэх;
6. Хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх;
7. Виртуал санхүүгийн хөрөнгийг байршуулах;
8. Виртуал санхүүгийн хөрөнгийн биржийн үйл ажиллагаа явуулах.

**Виртуал санхүүгийн хөрөнгийн тухай хууль** нь нийт 13 бүлэгтэй. Үүнд:

- Бүлэг I. Удиртгал
  - ✓ Энэ бүлэгт нэр томъёоны тайлбарыг тусгасан байна.
- Бүлэг II. Виртуал Санхүүгийн Хөрөнгийн анхны санал
  - ✓ "DLT хөрөнгө /*Distributed ledger technology asset*" гэдэг нь виртуал токен, виртуал санхүүгийн хөрөнгө, цахим мөнгө болон санхүүгийн хэрэгслийг хэлэх бөгөөд уг санхүүгийн хэрэгслүүдийн зохицуулалт
  - ✓ Виртуал санхүүгийн хөрөнгө гаргахын тулд агентад бүртгүүлэх ёстой талаар энэхүү бүлэгт оруулсан байна.
- Бүлэг III. Лицензийн шаардлага
  - ✓ Эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийг эзэмшээгүй тохиолдолд аливаа этгээдийг виртуал санхүүгийн үйлчилгээ үзүүлж чадахгүй.
- Бүлэг IV. Лицензийн өргөдөл, зөвшөөрөл, цуцлалт гэх мэт
  - ✓ Зөвшөөрөл олгох шаардлага
- Бүлэг V. Захиргааны зөвлөл ба лиценз эзэмшигчдийн үүрэг
  - ✓ Үнэт цаас гаргагчид байнгын дараах үүргүүдийг хүлээнэ. Эдгээр нь
    - Бүртгэлийг 5-аас доошгүй жил хөтлөх
    - Үнэт цаас гаргагчийн өмнөөс ВСХ агентлагаас ирүүлсэн "Дагаж мөрдөх мэдэгдэл"

<sup>56</sup> <https://www.mfsa.mt/>



- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан
- Аудитын тайлан.
- ВСХАС дууссаны дараа “Үнэт цаас гаргагч” нь жил бүр дагаж мөрдөх журам гаргаж, хяналтын хураамж төлөх ёстой.” зэрэг болно.
- Бүлэг VI. Зах зээлийг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх
- Бүлэг VII. Зохицуулах, мөрдөн шалгах эрх мэдэл
- Бүлэг VIII. Аудиторын үүрэг
  - ✓ Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн аудитор нь эрх бүхий байгууллагад шаардлагатай журам, хэлбэрээр лиценз эзэмшигчийн систем, аюулгүй байдлын талаар жил бүр эрх бүхий байгууллагад тайлагнана.
- Бүлэг IX. Гомдол арилгах болон хориглох арга хэмжээ, нууцлал
- Бүлэг X. Бусад заалтууд
- Бүлэг XI. Түр зуурын заалтууд.

Виртуал санхүүгийн хөрөнгийн тухай хуулийн дагуу зөвшөөрөл авах өргөдөл гаргагч шалгалтанд хамрагдах ёстой. Шалгалтын үнэлгээ нь шаардлага хангасан хувьцаа эзэмшигчид, ашиг хүртэгч өмчлөгч, захирал, ахлах менежер, мөнгө угаалтын байцаагч (МУБ) болон бусад ажилтнуудад хамаатай. Үнэлгээний агуулга нь байгууллагын төлбөрийн чадвар, мэргэжлийн ур чадвар дээр суурилдаг. Виртуал санхүүгийн хөрөнгийн хуулийн 3-р бүлэгт виртуал санхүүгийн хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн ангилал тус бүрийн хувьд хангавал зохих анхдагч шаардлагуудыг мөн оруулсан байна.


Виртуал санхүүгийн хөрөнгийн хуульд заасны дагуу үйлчилгээ үзүүлэгчид нь эрсдэлийн менежментийн бодлого, журмыг хэрэгжүүлдэг эрсдэлийн менежментийн чиг үүргийг хэрэгжүүлэгч нэгжтэй байх ёстой. Энэхүү хуульд мөн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахад баримтлах бодлогыг заавал хэрэгжүүлэхийг шаардсан заалтууд орсон байдаг. Түүнчлэн ангилал бүрийн хувьд олгох зөвшөөрөлд нь тавигдах тусгай шаардлагыг хангахыг заасан байна. Жишээлбэл, зөвшөөрөл эзэмшигч нь үйлчлүүлэгчдийн хөрөнгийг эзэмших, хянах эрхтэй байх тохиолдолд хөрөнгийг тусгаарлагдсан дансанд хадгалах ёстой. Ангилал 4-ийн хүрээнд дижитал хөрөнгө эсвэл виртуал санхүүгийн хөрөнгийн арилжааны платформыг удирдахтай холбоотой үүрэг хариуцлагуудыг тодорхойлж өгсөн байна. Тухайлбал, арилжааны өмнө болон арилжааны дараа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ил тод байдлыг хангах үүрэгтэй.

Малта улсын “Шинэлэг технологийн зохицуулалт, үйлчилгээний тухай” хууль нь 2018 онд батлагдсан юм. Энэ хууль нь нийт 5 бүлэгтэй. Үүнд:

- Part I Удиртгал
- Part II Хүлээн зөвшөөрөх зарчим
- Part III Инновацийн технологийн зохицуулалтын гэрчилгээ
- Part IV Үйлчилгээ үзүүлэгчдийн бүртгэл
- Part V Бусад заалтууд

Малтагийн санхүүгийн үйлчилгээний газраас гаргасан виртуал санхүүгийн хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх лиценз дараах 4 төрлийн ангилалд байдаг:

- Ангилал 1: Нэг буюу хэд хэдэн виртуал санхүүгийн хөрөнгө, виртуал санхүүгийн хөрөнгийг байршуулахтай холбоотой захиалга хүлээн авах, дамжуулах, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх эрх бүхий зөвшөөрөл эзэмшигчид;





- Ангилал 2: Лиценз эзэмшигчид виртуал санхүүгийн хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ үйлчлүүлэгчдийн хөрөнгө, мөнгийг эзэмшиж, хянах боломжтой;
- Ангилал 3: Виртуал санхүүгийн хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй боловч виртуал санхүүгийн хөрөнгийн бирж ажиллуулах эрхгүй лиценз эзэмшигчид. 3-р зэрэглэлийн зөвшөөрөл эзэмшигчид нь виртуал санхүүгийн хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ үйлчлүүлэгчдийн хөрөнгө, мөнгийг эзэмшиж, хянах боломжтой;
- Ангилал 4: Виртуал санхүүгийн хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий зөвшөөрөл эзэмшигчид. 4-р ангиллын зөвшөөрөл эзэмшигчид нь виртуал санхүүгийн хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ үйлчлүүлэгчдийн хөрөнгө эсвэл мөнгийг эзэмшиж, хянах боломжтой.

### **Ерөнхий шаардлага**

Үнэт цаас гаргагч нь Малтад хууль ёсны дагуу байгуулагдсан хуулийн этгээд байх бөгөөд давхар хяналтын зарчмын дагуу бизнесийг дор хаяж хоёр хүн удирдан зохион байгуулах ёстой байдаг байна. Эхлээд үнэт цаас гаргагчийн бизнесийг хянадаг Захиргааны зөвлөлийг томилох ёстой. Харин үнэт цаас гаргагч нь дараах албан тушаалтнуудыг томилно.

- ✓ Системийн аудитор (шаардлагатай бол);
- ✓ ВСХ-ийн ажилтан;
- ✓ Итгэмжлэгч;
- ✓ Аудитор;
- ✓ Мөнгө угаалтын байцаагч ('МУБ').

### **Бүртгэлийн үйл явц**

Бүртгүүлэх үйл явц нь дараах алхмаас бүрдэнэ:

1. Санхүүгийн хэрэгслийн шалгалт хийх;
2. ВСХ-ын ажилтан томилох;
3. ВСХ ажилтан үнэт цаас гаргагчаас тохирох шалгалтыг авах;
4. Кибер аюулгүй байдал болон аюулгүй мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгох;
5. Гэрээ байгуулах.

### **Сэндбокс зохицуулалт**

МСҮГ нь Малта улсын Финтекийн салбарт санхүүгийн тогтвортой инновацийг дэмжих, зохицуулалтын тодорхой бус байдлыг бууруулах зорилгоор Малта улсын хууль эрх зүйн орчинд "Сэндбокс зохицуулалт"-ыг хэрэгжүүлэх санаачлагад түшиглэж багц журам гаргасан. Журамд "Сэндбокс зохицуулалт"-ыг үндэслэсэн хэд хэдэн зарчмуудыг гаргаж жагсаасан байна. Гаргасан зарчмуудад:

- Инновацийг дэмжих;
- Үр өгөөжтэй хөрөнгө оруулагч, хэрэглэгчдийг хамгаалах;
- Зохицуулалтын нөлөөний талаарх компанийн ойлголтыг өргөжүүлэх;
- Мэдлэгээ хуваалцах зэрэг орно.

Сэндбокс зохицуулалтад нэгдэх өргөдөл гаргагчдад бий болох давуу талууд нь:

- Инновацийг аюулгүй, өргөн орон зайд туршиж, санал болгох;
- Хэрэглэгч, үйлчилгээ үзүүлэгчийг хамгаалах;

- Эрх мэдэлтнүүд болон компаниудыг нээлттэй харилцан яриа, хэлэлцээрээр хангах;
- Хэрэглэгч болон үйлчилгээ үзүүлэгчдийн хэрэгцээ, хүсэл сонирхлыг эрх мэдэлтнүүд хэт чангаар зохицуулахгүй байх;
- Эрх мэдэлтнүүд компанид өндөр хяналт тавьдаг тул эрсдэл бага байх зэрэг болно.

### 3.2 Сингапур

Сингапур улсын мөнгөний удирдлагын газар *Monetary Authority of Singapore (MAS)* нь дижитал токеныг зохицуулагч байгууллага юм. Сингапур улс нь 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр “Төлбөрийн үйлчилгээний хууль<sup>57</sup>”-ыг баталсан бөгөөд энэхүү хуульд нь крипто валют, дижитал токены төлбөрийн хэрэгслээр ашиглагдах үйл ажиллагааг зохицуулах заалтуудыг тусгасан. Энэхүү хуулиар дараах төлбөрийн үйлчилгээнүүдийг зохицуулна.

- (а) данс олгох үйлчилгээ;
- (б) дотоодын мөнгө шилжүүлэх үйлчилгээ;
- (в) хил дамнасан мөнгө шилжүүлэх үйлчилгээ;
- (д) арилжаачны худалдан авах үйлчилгээ;
- (д) цахим мөнгө гаргах үйлчилгээ;
- (е) дижитал төлбөрийн токены үйлчилгээ;
- (ж) мөнгө солих үйлчилгээ.

“Төлбөрийн үйлчилгээний акт”-д дижитал токеныг дараах шинж чанаруудтай гэж тодорхойлсон. Эдгээр нь:

- Нэгжээр илэрхийлэгддэг;
- Аль ч валютаар илэрхийлэгдээгүй бөгөөд нэгж дижитал токены ард түүний үнэ цэнийг баталгаажуулсан фиат мөнгө эсхүл валют байхгүй;
- Олон нийт эсхүл арилжаанд оролцож буй талууд аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдах, худалдан авахдаа төлбөрийн хэрэгслээр ашиглахыг хүлээн зөвшөөрсөн;
- Электрон хэлбэрээр арилжаалагдаж, хадгалагдаж, шилжүүлэгддэг;
- Сингапурын төв банкнаас тодорхойлсон бусад шинж чанарыг хангасан зэрэг болно.

Дижитал төлбөрийн хэрэгсэл нь одоогоор Сингапур улсад нарийн зохицуулалтад байхгүй байгаа бөгөөд дижитал төлбөрийн хэрэгслийг үнэт цаас аль эсхүл мөнгөн тэмдэгттэй адилтган тооцож зохицуулдаггүй. Гэхдээ 2021 оны 1 дүгээр сард Сингапурын парламентын хоёр дахь удаагийн хэлэлцүүлгээр Төлбөрийн үйлчилгээний тухай хуулийн төсөл (PS тухай хууль)-ийн нэмэлт өөрчлөлт батлагдсанаар одоогийн төлбөрийн үйлчилгээний хуулийн үйлчлэх хүрээ өргөжсөн бөгөөд энэ хууль нь виртуал активын үйлчилгээ эрхлэгчдийг зохицуулахад чиглэгдэх юм.<sup>58</sup> Одоогийн мөрдөгдөж байгаа хуулиар дижитал төлбөрийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь “Төлбөрийн үйлчилгээний акт”-ын дагуу тусгай зөвшөөрөл авна.

### 3.3 БНХАУ

Хятад улсад криптовалют нь хууль ёсны зөвшөөрөгдсөн төлбөрийн хэрэгсэл биш<sup>59</sup> бөгөөд

<sup>57</sup> <https://sso.agc.gov.sg/Acts-Supp/2-2019/Published/20190220?DocDate=20190220>

<sup>58</sup> [https://www.parliament.gov.sg/docs/default-source/default-document-library/payment-services-\(amendment\)-bill-41-2020.pdf](https://www.parliament.gov.sg/docs/default-source/default-document-library/payment-services-(amendment)-bill-41-2020.pdf)

<sup>59</sup> The term 虚拟货币 (“virtual currencies”) is used in Chinese

санхүүгийн байгууллагууд криптовалютыг хүлээн авах, холбогдох санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглодог. Цахим койн (coin) ашиглахыг 2017 онд хориглосон бөгөөд криптовалютын арилжааны платформууд үндсэндээ зогссон. Криптовалютыг эзэмших, шилжүүлэх хувь хүмүүсийн хэрэглээг тусгайлан зохицуулдаггүй ч Эдийн засгийн тухай хуульд хамруулдаг байна.

### **Blockchain-ээр үүсгэсэн хөрөнгийн хандлага.**

Хятад улс криптовалют-ийг хууль ёсны төлбөрийн хэрэгсэл эсвэл жижиглэнгийн төлбөрийн хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрдөггүй. Засгийн газрын хэд хэдэн мэргэжлийн байгууллагууд хамтран олон нийтэд биткойны эрсдэлийн талаар 2013 оны 12-р сард анхааруулсан ба мэргэжилтнүүд биткойныг виртуал бүтээгдэхүүн хэмээн тодорхойлсон. Мөн В itcoin арилжааны үйлчилгээ эрхэлдэг вэбсайтуудад мөнгө угаахтай тэмцэх үүргээ биелүүлэхийг сануулсан байна<sup>60</sup>. 2017 оны 9-р сарын 4-ний өдөр дахин койн арилжих эрсдэлийн талаар олон нийтэд сэрэмжлүүлэг өгсөн ба үүнд Bitcoin, Ethereum зэрэг криптовалютуудыг онцолсон байна. Ethereum нь тухайн улсын албан ёсны санхүүгийн байгууллагаас гаргадаггүй тул хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны төлбөрийн хэрэгсэл биш хэмээн зарласан. Криптовалют нь Fiat<sup>61</sup> валюттай адил эрх зүйн статусгүй бөгөөд зах зээл дээр Криптовалютаар гүйлгээ хийхийг зөвшөөрдөггүй<sup>62</sup>. Засгийн газрын мэргэжилтнүүд шаардлага хангаагүй вэбсайтууд болон платформууд, гар утасны програмууд, аппликейшнуудыг стороос хасах, энэ төрлийн бизнес эрхлэгчийн зөвшөөрлийг хураасан байна.

### **Санхүүгийн байгууллагуудын хяналт**

Хятад дахь санхүүгийн байгууллагууд криптовалют арилжих, холбогдох санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг бүрэн хориглодог. 2013 он түүний дараа 2017 онд гарсан захирамжийн дагуу Хятад дахь санхүү, төлбөрийн байгууллагууд биткойнтой холбоотой үйлчилгээ тэр дундаа биткойны бүтээгдэхүүн үйлчилгээ, биткойныг худалдаж авах, зарах, бүртгэх, арилжих, төлбөр тооцоо хийх, клиринг эсвэл бусад үйлчилгээ хийхийг хоригложээ. Санхүүгийн байгууллагуудад биткойн авах, биткойныг клиринг хэрэгсэл болгон ашиглах (clearing tool), биткойныг Хятадын юань эсвэл гадаад валютаар арилжихыг хориглодог.<sup>63</sup>

### **Криптовалютын зохицуулалт**

2017 оны захирамжийн дагуу койн арилжих буюу token борлуулах, эргэлтэд оруулах замаар виртуал валютыг өсгөх нь албан бус буюу үндсэндээ хууль бус үйл ажиллагаа юм. Мөн уг захирамж нь иргэдэд хууль бусаар token буюу үнэт цаас гаргах, хууль бусаар хөрөнгө босгох, пирамид худалдаа үүсгэх нь санхүүгийн луйвар гэдгийг анхааруулсан байна.

<sup>60</sup> People's Bank of China (PBOC), Ministry of Industry and Information Technology (MIIT), China Banking Regulatory Commission (CBRC), China Securities Regulatory Commission (CSRC), and China Insurance Regulatory Commission (CIRC), Notice on Precautions Against the Risks of Bitcoins (Dec. 3, 2013) (2013 Circular), <http://www.miit.gov.cn/n1146295/n1652858/n1652930/n3757016/c3762245/content.html> (in Chinese), archived at <https://perma.cc/S4DN-DXHD> (all translations by author).

<sup>61</sup> Fiat мөнгө гэдэг нь засгийн газраас гаргасан, алт гэх мэт түүхий эдээр баталгаажуулах валют юм.

<sup>62</sup> PBOC, Cyberspace Administration of China, MIIT, State Administration for Industry and Commerce, CBRC, CSRC, and CIRC, Announcement on Preventing Financial Risks from Initial Coin Offerings (Sept. 4, 2017) (2017 Circular), <http://www.pbc.gov.cn/goutongjiaoliu/113456/113469/3374222/index.html> (in Chinese), archived at <https://perma.cc/N88N-5CV5>.

<sup>63</sup> 5 Xie Xu, China to Stamp Out Cryptocurrency Trading Completely with Ban on Foreign Platforms, SOUTH CHINA MORNING POST (Feb. 7, 2018), <http://www.scmp.com/business/banking-finance/article/2132009/chinastamp-out-cryptocurrency-trading-completely-ban>, archived at <https://perma.cc/42H4-F2AW>.

Хэдийгээр койн болон криптовалютын арилжааны платформуудад хориг тавьсан ч гэсэн хувь хүмүүс криптовалют эзэмших, арилжих тусгайлсан нарийн зохицуулалт байхгүй байна. Нэг талаараа криптовалют нь эдийн засгийн үнэ цэнэтэй өмч гэж үзэж болох бөгөөд БНХАУ-ын Иргэний эрх зүйн ерөнхий хуулиар (General Rules on the Civil Law of the People's Republic of China) хамгаалагддаг байна. Жишээлбэл, 2018 оны 10-р сарын 25-ны өдөр Шенжений Олон улсын арбитрын шүүх криптовалют эзэмших, шилжүүлэхтэй холбоотой, гэрээний маргаантай холбоотой хэргийн дүн шинжилгээг нийтэлсэн.

### 3.4 Япон улс

Япон улсад виртуал валют арилжааны бизнесийг Төлбөрийн үйлчилгээний тухай хуулиар (Payment Services Act) зохицуулж байна. Виртуал валютын биржийн бизнес эрхлэгчид орон нутгийн санхүүгийн товчоонд бүртгүүлсэн байх ёстой байдаг байна. 2019 оны 3-р сард өргөн барьсан Төлбөрийн үйлчилгээний тухай хууль болон бусад актуудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд виртуал валютын нэрийг "крипто хөрөнгө" болгон өөрчлөх, крипто хөрөнгөтэй холбоотой зохицуулалтууд болон койны талаар тусгасан байна.

Виртуал валютын (Virtual Currency) тодорхойлолт:

Төлбөрийн үйлчилгээний тухай хуульд "виртуал валют"<sup>64</sup>-ыг дараах байдлаар тодорхойлсон байна.

- Цахим системээр дамжуулан бараа бүтээгдэхүүн худалдан авах, түрээслэх, үйлчилгээ үзүүлэхэд төлбөр болгон ашиглах, мөн арилжиж болох, үнэ цэнэ бүхий эд хөрөнгө юм.
- Цахим системээр дамжуулан хэд хэдэн хүмүүс хоорондоо арилжиж, шилжүүлж болох үнэ цэнэ бүхий эд хөрөнгө юм.<sup>65</sup>

Уг хуулинд виртуал валют нь цахим систем дээр электрон хэлбэрээр хадгалагддаг гэдгийг онцолсон ба үүнд валют, валютаар илэрхийлэгдсэн хөрөнгийг тооцохгүй гэж заасан байна.<sup>66</sup>

Виртуал валютын тодорхойлолт нь одоогоор санхүүгийн хэрэгсэл, биржийн тухай хуульд (Financial Instruments and Exchange Act) оруулаагүй (байхгүй) байна.

#### **Виртуал валютын арилжааны зохицуулалт**

Төлбөрийн үйлчилгээний тухай хуульд<sup>67</sup> заасны дагуу зөвхөн орон нутгийн санхүүгийн товчоонд (local finance bureau) бүртгэлтэй бизнесийн операторууд виртуал валют арилжааны бизнес эрхлэх эрхтэй байдаг. Арилжаа гүйцэтгэгч оператор компани нь Японд байрладаг тухайн улсын оршин суугч байх ёстой. "Гадаадын виртуал валют арилжааны бизнес" гэдэг нь Японы төлбөрийн үйлчилгээний тухай хуулийн дагуу засгийн газар болон албан ёсны системд бүртгэгдсэн (гадаад тал ч мөн адил) виртуал валютыг арилжих үйлчилгээг хэлнэ. Уг хууль нь мөн виртуал валютын бизнес эрхлэгчдийг мэдээлэл дата-гаа хамгаалах хамгаалалтын системтэй байхыг шаарддаг байна.<sup>68</sup> Виртуал валютын бизнес эрхлэгчид үйлчлүүлэгчдийн мөнгө эсвэл виртуал валютыг өөрсдийн хөрөнгөөс гадна тусад

<sup>64</sup> In Japanese, the term 仮想通貨 ("virtual currency") is used

<sup>65</sup> 資金決済に関する法律 [Payment Services Act], Act No. 59 of 2009, amended by Act No. 62 of 2016, art. 2, para.

<sup>66</sup> [Payment Services Act], Act No. 59 of 2009, amended by Act No. 62 of 2016

<sup>67</sup> Payment Services Act No. 59 of 2009

<sup>68</sup> Id. art. 63-8.

нь удирдах ёстой. Ийм менежментийн хэрэгжилтийг мэргэшсэн нягтлан бодогчид эсвэл нягтлан бодох бүртгэлийн компаниуд хянадаг.<sup>69</sup> Виртуал валютын бизнес эрхлэгчид виртуал валютын гүйлгээний нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, жилийн тайланг Санхүүгийн Үйлчилгээний Агентлагт (Financial Services Agency) өгсөн байх шаардлагатай.<sup>70</sup> Санхүүгийн Үйлчилгээний Агентлагт нь виртуал валютын бизнес эрхлэгчдэд хяналт шалгалт хийх, материал тайланг үзэх, шаардлагатай тохиолдолд 6 хүртэлх сараар үйл ажиллагааг зогсоох эрхтэй байдаг байна.

### **Хууль бус мөнгө угаахтай тэмцэх журам**

Хууль бус мөнгөн орлогыг шилжүүлэхээс хамгаалах тухай хуульд (The Act on Prevention of Transfer of Criminal Proceeds) виртуал валютын бизнес эрхлэгчид “мөнгө угаахтай тэмцэх журамд” заасан шаардлагыг биелүүлэх ёстой.<sup>71</sup> Виртуал валютын бизнес эрхлэгчид нээлттэй аккоунтыг шалгаж дансны мэдээлэл, гүйлгээний бүртгэл хөтөлж, сэжигтэй гүйлгээ хийгдсэн тохиолдолд эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй. Харин койны хувьд мөрдөж буй ямар нэгэн зохицуулалт одоогоор (2019 оны 1 сар) тодорхойгүй байна.<sup>72</sup>

### **Татвар**

Үндэсний татварын газар (The National Tax Agency) нь виртуал валютын борлуулалтаас олсон ашгийг зарчмын хувьд орлогын албан татварын тухай хуулийн (Income Tax Act) дагуу, хөрөнгийн ашиг бус бусад орлого (Miscellaneous income) хэмээн үзэж түүнд татвар ногдуулдаг байна.<sup>73</sup>

## **3.5 Солонгос**

2017 оны 12 дугаар сарын 13-нд Солонгосын засгийн газар виртуал валютын арилжааг хянах үүднээс шинэ журмын төслөө танилцуулсан. Үүнд: виртуал валютын данс нээлгэх үйлчилгээ үзүүлдэг банкууд шинээр данс нээхдээ данс эзэмшигч нарын мэдээллийг шалгаж баталгаажуулах, насанд хүрээгүй болон гадаад иргэнд данс нээж өгөхгүй байх; Санхүүгийн байгууллагууд виртуал валютад хөрөнгө оруулах, эзэмшихийг хориглох; Эрх бүхий зохицуулах байгууллага нь виртуал валютын биржүүдийн арилжаанд оролцогчдыг жинхэнэ нэрээр баталгаажуулах, дансны нууц үгийн хамгаалалтыг сайжруулах, хэлцэл болгоны үнэ ба хэлцлийн хэмжээний мэдээллийг ил тод болгохыг шаардах; Арилжааны ашгийн татвар ногдуулах тухай хэлэлцэх; виртуал валюттай холбоотой луйвар, залилангийн талаар илүү хатуу арга хэмжээ авах тухай зүйл заалтууд багтсан байна.

## **3.6 Татварын орчин<sup>74</sup>**

### **Крипто татвар төлөх ёстой юу?**

АНУ-ын хөрөнгө оруулагчийн крипто татварын талаар ерөнхий зөвлөмжөөс үзэхэд, криптог

<sup>69</sup> Id. art. 63-11.

<sup>70</sup> Id. art. 63-14.

<sup>71</sup> [Act on Prevention of Transfer of Criminal Proceeds], Act No. 22 of 2007, amended by Act No. 67 of 2017, art. 2, para. 2, item 31.

<sup>72</sup> Explanatory Material, supra note 20, at 4. See also Taro Awataguchi, Japan, in BLOCKCHAIN AND CRYPTOCURRENCY REGULATION 2019

<sup>73</sup> [Regarding Calculation Method of Income Relating to Virtual currency (Information), Individual Taxation Information], No. 4 (Dec. 1, 2017), <http://www.nta.go.jp/law/joho-zeikaishaku/shotoku/shinkoku/171127/01.pdf>, archived at <https://perma.cc/M22N-53MF>.

<sup>74</sup> <https://www.coinbase.com/learn/tips-and-tutorials/crypto-and-bitcoin-taxes-US>



худалдан авах болон худалдаалах явцыг Дотоод орлогын алба /Internal Revenue Service IRS/ валют бус хөрөнгө гэж үздэг тул татвар ногдуулах боломжтой байдаг. Үүний үр дүнд зоос худалдах, үнэ цэнийг нь тооцох боломжтой гоёлын автомашин зэрэг хөрөнгийн төрөлд хамааралтай татварын дүрэм, журам (гэхдээ үл хөдлөх хөрөнгийн татварын журам биш) нь биткойн, ethereum болон бусад крипто валютыг ч мөн хамардаг байна.

Крипто худалдааны орлого зэргийг хамруулсан татварын тайлангаа хүргүүлээгүй бол Дотоод орлогын албанаас торгууль ногдуулна.

### **Криптогийн татвар төлөх эсэхээ тодорхойлох**

Татвар төлөх эсэхээ тодорхойлохын тулд крипто гүйлгээг үнэлэх хэрэгтэй болдог байна.

#### **Юунд татвар ногдуулдаг вэ?**

Гүйлгээг америк доллараар хэмжсэн зах зээлийн үнээр тооцож тайлагнах ёстой. Тиймээс пицца биткойноор авсан гэж үзвэл доллараар пиццаны үнэд дүйцэх хэмжээний үнэ цэнэтэй биткойн зарцуулах хэрэгтэй.

#### **Айрдроп ба татварын нөлөөлөл**

Айрдропоор үнэгүй крипто хүлээн авсан бол түүнийг хэрхэн хэрэглэх нь татвар ногдуулахад нөлөөлнө. Айрдроп бол бэлэг тараах, сугалаанд хожихтой адил тул тухайн цаг үеийн зах зээлийн бодит үнээр үнэлэгдсэн ердийн орлого гэж үзэн татвар ногдуулах ёстой.

Энэ мөнгө таны хэтэвчинд орсон боловч биржүүд энэхүү протоколыг хараахан дэмжиж эхлээгүй учир ямар нэг үйлдэл хийх боломжгүй байгаа бол татвар ногдуулахгүй. Шилжүүлэх, худалдах, арилжих юм уу өөр ямар нэг байдлаар криптог ашиглах боломжтой болсон үед л үүнд татвар ногдуулна.

#### **Хандив болон криптог бэлэглэх үеийн татварын нөлөөлөл**

Бэлгийг хүлээн авагч: Криптог бэлгэнд авсан азтай нэгэн бол криптогоо зарах хүртэл татвар төлөхгүй. Хэрэв худалдах бол танд криптог өгсөн хүнтэй ижил суурь зардал төлөх болно.

Бэлэг өгсөн хүн: Татвар төлөлгүйгээр нэг хүнд 15,000 доллартай тэмцэх хэмжээний крипто бэлэглэж болно. Нэг хүнд 15,000 доллараас хэтэрвэл бэлгийн татварын мэдүүлэг өгөх шаардлагатай.

Хандив: ДОО-гаас батлагдсан хандивын байгууллагад крипто хандивлаж байгаа бол хандивласан крипто валютынхаа зах зээлийн бодит үнэтэй тэнцэх хандивын хасалт нэхэмжилж болно.

#### **Ашиг, алдагдлыг тооцох**

Үйл ажиллагааныхаа тухай бүрэн ойлголттой болсон бол одоо гүйлгээнийхээ ашиг, алдагдлыг тооцоолох хэрэгтэй. Энэ нь гүйлгээ бүрээ нягталж, суурь зардлаа тодорхойлон, ашиг, алдагдал гарсан эсэхийг тооцно гэсэн үг.

#### **Нэмэлт мэдээлэл:**

Алдагдал хүлээснээр тухайн татвар төлсөн жилдээ хөрөнгийн нөхөн олговор ба нэмэлт 3,000 доллар авах боломжтой. Автомашин алдагдлаас ялгаатай нь биткойн болон бусад крипто валютын алдагдлыг хорогдуулах боломжтой гэсэн үг юм.

**Крипто гүйлгээндээ зарим нэг татварын үйлчилгээ авах арга (өөрөөр хэлбэл**



### **Тусгай тэмдэглэгээний арга, LIFO)**

Маш их хэмжээний крипто валют өөр өөр цаг үед худалдан аваад түүнийхээ багахан хэсгийг худалдсан бол анхны крипто худалдан авсан үеийн зардлыг зарагдсан крипто дээр ашиглах уу, сүүлийн худалдан авалтынхыг уу, эсвэл Тусгай тэмдэглэгээний аргыг ашиглах уу гэдэг асуудалтай тулгарна. ДОА нь крипто валютыг хувьцааны нэг адил хөрөнгө гэж үздэг тул капитал хөрөнгөд хамаардаг зарчим крипто гүйлгээнд ч мөн адил хамаарна.

### **Сугалаа загварт оногдох татварын хариуцлага**

Сугалааны үр дүнд үнэгүй крипто хүлээн авсан бол уг үнэгүй крипто нь хонжвороос авсан мөнгөтэй адил гэж үзэх тул тухайн цаг үеийн зах зээлийн бодит үнээр үнэлэгдсэн ердийн орлого гэж үзэн татвар ногдуулна. Зах зээлийн бодит үнэ гэдэг нь криптог хүлээн авсан өдрийн үнэ юм.

Энэ мөнгө таны хэтэвчинд орсон боловч Койнбаз юм уу бусад биржүүд энэхүү протоколыг дэмжиж эхлээгүй учир ямар нэг үйлдэл хийх боломжгүй байгаа бол хараахан татвар ногдуулахгүй. Шилжүүлэх, худалдах, арилжих юм уу өөр ямар нэг байдлаар криптог ашиглах боломжтой болсон үед л үүнд татвар ногдуулна.

### **Чухал нэр томьёо**

Татварын тайлан гаргах үед нэлээд олон мэргэжлийн нэр томьёо таарах байх. Хамгийн нийтлэг нь:

- Капитал хөрөнгө- Капитал хөрөнгө гэдэг нь крипто, байшин, бонд, хувьцаа зэрэг таны өмчилдөг бүх төрлийн өмчийг хэлнэ.
- Зардлын суурь арга- Таны суурь бол крипто худалдан авахад төлсөн төлбөр, түүнтэй холбогдох зардлыг доллараар тооцсон өртөг юм.
- Суурь зардал- Биткойн, эфир, болон бусад крипто валютыг хувиараа борлуулан, арилжихад суурь зардлыг хэрхэн хамруулах тухай ДОА-гаас гаргасан албан ёсны гарын авлага байдаггүй.
- Эхэлж авсныг, эхэлж зарагдах (ЭАЭЗ) арга- Энэ нь таны худалдан авсан эхний хөрөнгө, таны худалдах болон солилцох эхний хөрөнгө байна гэсэн үг юм. Таны ашиг, алдагдал портфолио дахь таны хамгийн хуучин хөрөнгөд төлсөн үнээр тооцогддог ба хөрөнгийн үнэ нь тухайн худалдаа болон солилцоо хийгдсэн цаг үеийн үнээр тооцогдоно. Энэ бол уламжлалт хөрөнгө оруулалтыг хамгийн нийтлэг арга юм.
- Тусгай тэмдэглэгээний арга буюу сүүлд авсан нь эхэлж зарагдах арга (САЭЗ)- Тусгай тэмдэглэгээний арга нь борлуулсан эсвэл солилцсон хөрөнгөө татварын мэргэжилтэнд тусгайлан тэмдэглэж өгдөг арга юм. САЭЗ арга нь сүүлд авсан хөрөнгө нь эхэлж борлуулах эсвэл солилцох хөрөнгө болдог арга юм. Эдгээр аргын алийг ч хэрэглэсэн татварын мэргэжилтэнтэй зөвлөх хэрэгтэй.
- Зах зээлийн бодит үнэ- Татвар төлөлтийн үед зах зээлийн бодит үнэ гэдэг нь гүйлгээ хийгдэх үеийн криптогийн долларын үнэлгээ юм.
- Ашиг- Хөрөнгөөс олж авах ашгийг хэлнэ. Жишээ нь: таны биткойны үнэ цэнэ нэмэгдсэн ч, таных хэвээр байгаа бол эдгээр ашиг нь “анзаарагдаагүй” болдог. Та хөрөнгөө худалдаад тухайн ашгийнхаа мөнгөн үнэ цэнийг хүлээн авсан бол ашиг нь “анзаарагдсан” болох бөгөөд татвар ногдуулах болно.
- Үл хөдлөх хөрөнгөтэй ижил төрлийн хөрөнгө ба крипто- Хөрөнгө оруулагчид гүйлгээнийхээ татвараас зайлсхийн, крипто валютын шууд хөрвүүлэлтийг (жишээ нь

биткойныг эфир болгох) “үл хөдлөх хөрөнгөтэй ижил төрлийн” гэж үзэн нэхэмжлэх боломжтой эсэх тухай олон асуулт байдаг боловч 2018 оны эхээр татварын хууль өөрчлөгдөж, ижил төрлийн арилжаа нь зөвхөн үл хөдлөх хөрөнгийн гүйлгээнд хамаарахаар болжээ.

- Урт ба богино хугацааны ашиг- Та капитал хөрөнгө борлуулахдаа урт юм уу богино хугацааных эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Урт хугацааных гэдэг нь та тухайн хөрөнгөө зарцуулах, худалдаалахаас өмнө жил гаран өөртөө байлгасан гэсэн үг бол богино хугацаа нь жилээс бага хугацаанд таны өмчид байсан гэсэн үг юм. Урт хугацааны хөрөнгийн ашиг нь богино хугацааныхаас илүү таатай татвар ногдуулдаг.
- Алдагдал- Та хөрөнгөө суурь зардлаас доогуур үнээр худалдсан үед алдагдал гардаг. Таны крипто нь дээрх тодорхойлолтын дагуу капитал хөрөнгө учраас тухайн хөрөнгийн капиталын алдагдлыг тухайн татварын жилд бусад хөрөнгөөс олсон орлогыг нөхөхөд ашиглаж болно.
- Энгийн хөрөнгө- Энгийн хөрөнгөнд бараа материал, арилжихад бэлэн бараа материал (өөрөөр хэлбэл, бизнес эрхлэгчдийн зарж борлуулдаг бараа, үйлчилгээ), худалдаа, бизнесээр дамжуулан олж авсан хөрөнгө орно. Та өөрийн криптог энгийн хөрөнгө гэж үзэж байгаа бол татварын мэргэжилтэнтэй зөвлөлдөөрэй.
- Орлого- Ерөнхийдөө өөрийн хөрөнгөө худалдаад авсан мөнгийг орлого гэж нэрлэдэг. Та криптогоо доллараар худалдсан бол таны хүлээн авсан мөнгө илэрхий байх болно. Харин өөр криптогоор (өөрөөр хэлбэл та криптог өөр крипто руу “шилжүүлсэн”) худалдсан бол хүлээн авсан криптоны долларын үнээр орлогоо тооцно. Таны орлогоос суурь зардал (таны анхны криптод төлсөн мөнгө) хасч ашгийг тодорхойлдог.

#### 4. Монгол Улсын криптовалютын зах зээл

Монголын криптовалютын зах зээлийн хувьд 2017 оны сүүлээс эрчимтэй хөгжиж эхэлсэн ба иргэд, аж ахуйн нэгжүүд криптовалютыг хөрөнгө оруулалтын хэрэгслээр сонирхож эхлэн сошиал сувгаар дамжуулан зохицуулалтгүйгээр өөр хоорондоо арилжаалах болон гадаадын биржүүдэд бүртгүүлэх, арилжаанд оролцох сонирхол маш их нэмэгдсэн.

Санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварын Монгол улсын санхүүгийн зах зээлд нэвтрэхийг дэмжих зорилгоор 2021.03.01-ны өдөр Сэндбокс зохицуулалтын орчны журмыг баталсан байна.

Дотоодын криптовалютын зах зээлийн 2020 оны эцсийн байдлаарх албан бус судалгаагаар олон нийтэд нээлттэй тогтмол үйл ажиллагаа явуулж буй дотоодын 1 бирж, зуучлалын үйлчилгээ үзүүлж буй 20 гаруй иргэд<sup>75</sup>, аж ахуйн нэгж байна (2021.04.01-ний өдрөөс DAX<sup>76</sup> хэмээх 2 дахь онлайн бирж тогтмол үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна).

Дотоодын биржүүдэд албан ёсны бүртгэлтэй нийт 150 гаруй мянган иргэд, аж ахуйн нэгж байгаа бөгөөд жилд эдгээр иргэд, аж нэгж 500 гаруй тэрбум төгрөгийн арилжаа, гүйлгээ хийсэн байна. Харилцагчдын 1 орчим хувь гадаадын 10 гаруй улсаас бүртгүүлэн, арилжаанд оролцсон байна. Дотоодын биржүүдийн хувьд:

**Trade.mn** биржийн платформыг 2017 оны 10 сард үүсгэн байгуулсан ба 70 гаруй мянган хэрэглэгчидтэй 200 гаруй тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна. Одоогоор энэхүү онлайн

<sup>75</sup> Виртуал хөрөнгийн тухай судалгаа Монголбанк 2021

<sup>76</sup> Ард Санхүүгийн Нэгдлийн охин компани АрдЭкс ХХК

бирж дээр 14 нэр төрлийн криптовалюта арилжаалагдаж байна.

**BitMonex** арилжааны платформ 2020 оны 5 сараас үйл ажиллагаа эхлүүлэхээр зарласан ч системийн хувьд арилжаа хийж эхлээгүй байна.

**Криптовалютын зуучлагчдын хувьд**; Ард санхүүгийн нэгдэл ХК өөрийн хөгжүүлж буй ард апплекэйшнээр дамжуулан охин компаниудын хувьцаагаа токенжуулан криптовалюта худалдах, худалдан авах боломжийг олгож байна.

**Монголын цахим валют арилжааны төв** фэйсбүүк пэйж хуудсаараа дамжуулан криптовалютыг зуучлан худалдах, худалдан авах үйлчилгээ үзүүлж байна.

Дотоодын иргэд, хөрөнгө оруулагчид голлон Bitcoin /BTC/, Ethereum /ETH/, Tether /USDT/, Ripple /XRP/, Litecoin /LTC/ зэрэг олон улсын крипто зах зээлийн тэргүүлэгч валютуудад хөрөнгө оруулж байгаа бөгөөд дотоодын биржүүд эдгээр криптовалютыг бүртгэж, арилжаалж байна.

Эдгээр криптовалютын ханш 2021.04.26-ны байдлаар.<sup>77</sup>

Төрөл	Сүүлийн ханш	Өөрчлөлт
BTC/MNT	151.000.000	-2.08%
ETH/MNT	6.747.968	013%
LTC/MNT	668.002	-2.31%
XRP/MNT	3.101	-3.45%
ARD/MNT	197	-0.48%
BAT/MNT	3.170	-2.52%

Одоогоор манай улсад харьяалагдах Ardcoin /ARDX/ нь анхны, ганц койн бөгөөд Ethereum сүлжээний ERC20 ухаалаг гэрээний платформ дээр 2019 оны 1-р сард бүртгэгдсэн.



<sup>77</sup> <https://trade.mn/mn/publicExchange/trade/BTC/MNT>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- What Is Cryptocurrency? Beginners Guide to Digital Cash - nerdwallet
- Blockchain: everything you need to know (investopedia.com)
- How does a blockchain work - simply explained - youtube
- What is blockchain? Blockchain technology explained simply - youtube
- Number of crypto coins 2013-2021 | statista
- Cryptocurrency wallet - wikipedia
- Public keys and private keys | how they work with encryption (comodo.com)
- Just a moment... (sofi.com)
- 3 good reasons to buy bitcoin -- and 2 bad ones (fool.com)
- Advantages and disadvantages of cryptocurrency in 2020 - geeksforgeeks
- The swot analysis of crypto-currency and bitcoin (pdf) (researchgate.net)
- Factors influencing cryptocurrency prices: (pdf) evidence from bitcoin, ethereum, dash, Litecoin, and monero (researchgate.net)
- Cryptocurrencies data images 2020
- Search | statista
- All Cryptocurrencies | coinmarketcap
- <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Virtual-currency-key-definitions-and-potential-aml-cft-risks.pdf>
- [http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/bulletin/FATF-Booklet\\_VA.pdf](http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/bulletin/FATF-Booklet_VA.pdf)
- <https://www.imf.org/external/pubs/ft/bop/2018/pdf/18-11.pdf>
- The Block <https://www.theblockcrypto.com/post/102109/bank-of-england-hm-treasury-new-taskforce-cbdc-digital-currency>
- Finextra <https://www.finextra.com/newsarticle/37842/russia-pushes-ahead-with-digital-ruble>
- <https://www.mfsa.mt/publications/corporate-publications/statistics/licenses-statistics/>
- (PDF) Factors Influencing Cryptocurrency Prices: Evidence from Bitcoin, Ethereum, Dash, Litecoin, and Monero (researchgate.net)
- <https://trade.mn/mn/publicExchange/trade/BTC/MNT>
- <https://legislation.mt/eli/cap/590/eng/pdf>
- <https://legislation.mt/eli/cap/592/eng/pdf>
- <https://legislation.mt/eli/cap/591/eng/pdf>
- <https://www.mfsa.mt/>



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ  
ХАРЬЦУУЛСАН ЛАВЛАГАА: МОНГОЛ УЛС БОЛОН  
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ МЭДЭЭЛЭЛ**

*Д.Халиун, Ш.Батцэнгэл,  
И.Жаргалзаяабямба, Р.Нургүл*

**АГУУЛГА**

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН  
ЛАВЛАГАА: МОНГОЛ УЛС БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ МЭДЭЭЛЭЛ

Нэг.МОНГОЛ УЛС

Хоёр.ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

- 2.1. Оросын Холбооны Улс
- 2.2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- 2.3. Япон Улс
- 2.4 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгаанд захиалгын дагуу Монгол Улс болон гадаадын зарим орны нийгмийн даатгалын шимтгэлийн /НДШ/ одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хувь хэмжээний талаарх лавлагаа, мэдээллийг гаргав.

**Судалгааны хамрах хүрээ.** Лавлагаа, мэдээлэл 2 хэсгээс бүрдэнэ.

Нэгдүгээр хэсэгт, Монгол Улсын НДШ-ийн хувь хэмжээ хэзээ, хэрхэн өөрчлөгдсөн талаарх тойм мэдээлэл, уг шимтгэлийн одоо мөрдөгдөж буй хувь хэмжээ, Ковид-19 өвчлөлийн тархалттай холбоотойгоор нийгэм, эдийн засгийг дэмжих арга хэмжээний хүрээнд үзүүлсэн НДШ-ийн хувь хэмжээний хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар судалсан.

Хоёрдугаар хэсэгт, Япон, Орос, Хятад, Герман зэрэг орнуудын НДШ-ийн хувь хэмжээг судалсан болно.

### Судалгааны үр дүнгийн тойм

Монгол Улсад НДШ-ийн хувь хэмжээ 1995 онд 29-31%, 2008 онд 21-23%, 2013 онд 21-23%, 2017 онд 21-23%, 2018 онд 23-25%, 2019 онд 24-26%, 2021 онд 26-28% болж тус тус өөрчлөгдсөн байна. /Дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү/

Судалгаанд авагдсан орнуудын хувьд НДШ-ийн 2021 онд мөрдөж буй хувь хэмжээ дараах байдалтай байна.

	Монгол Улс	Япон Улс	ОХУ	ХБНГУ
<b>НДШ /хувиар/</b>	26-28% <sup>78</sup>	29.7%	30.2%	39.8%

БНХАУ-д ажил олгогчоос 25.5-36%, ажилтнаас 10.5% байна. (2019 оны байдлаарх мэдээлэл олдсон)

/Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү/



<sup>78</sup> Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын хувь хэмжээ 0.8%, 1.8%, 2.8% байгаатай холбоотой 26-28% байна.



## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН ЛАВЛАГАА: МОНГОЛ УЛС БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ МЭДЭЭЛЭЛ

#### Нэг. МОНГОЛ УЛС

#### Монгол Улсын нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээнд оруулсан өөрчлөлт

Монгол Улсад 1990 оноос хойш НДШ-ийн хувь хэмжээ харьцангуй тогтвортой, зарим жилүүдэд буурсан үзүүлэлттэй явж ирсэн боловч 2018 оноос эхлэн жил дараалан бага зэрэг өссөн байна. НДШ-ийн өөрчлөлтийг даатгалын төрөл, огноогоор харуулав.

#### Албан журмын даатгал:

Хүснэгт 1. МУ-ын НДШ-ийн хувь хэмжээнд 1995, 2008 онуудад оруулсан өөрчлөлт /хувиар/

Хуульд оруулсан өөрчлөлт		НДТХ-ийн 15 дугаар зүйлийн 1, 7 хэсэг	НДТХ-д 2007.11.30-ний өдөр оруулсан өөрчлөлт		
АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧ		1995.01.01-2007.12.31	2008.01.01-2012.12.31		
№	Даатгалын төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ (хувиар)			
		Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос
1	Тэтгэврийн даатгал	13.5	5.5	7.0	7.0
2	Тэтгэмжийн даатгал	1	1	0.5	0.5
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	1.0, 2.0, 3.0	-	1.0, 2.0, 3.0	-
4	Ажилгүйдлийн даатгал	0.5	0.5	0.5	0.5
5	Эрүүл мэндийн даатгал	3.0	3.0	2.0	2.0
Нийт		19, 20, 21	10	11, 12, 13	10
Бүгд		29%, 30%, 31%		21%, 22%, 23%	

Дээрх хүснэгтэд албан журмын даатгуулагч болох ажил олгогч, даатгуулагч нь нийгмийн даатгалын шимтгэлийг ямар хувь хэмжээтэй төлөхийг харуулав. Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх журмын тухай хуулиудад (НДТХХЖТХ) 2008, 2013, 2017, 2018, 2019, 2021 онуудад нийгмийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээг өөрчлөхтэй холбоотой нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.

2008 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын 142-р тогтоолд нийгмийн даатгалын шимтгэл, түүн дотроо үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалыг тухайн үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан ялгаатай хувь хэмжээтэй байхаар тодорхойлж жагсаалтыг баталсан байх тул үүнийг харгалзаж НДШ-ийн төлөх нийт дүнг мөн ялгаатай байдлаар харуулав.

Хүснэгт 2. МУ-ын НДШ-ийн хувь хэмжээнд 2013, 2017 онуудад оруулсан өөрчлөлт /хувиар/

Хуульд оруулсан өөрчлөлт	НДТХ-д 2012.10.25-ны өдөр оруулсан өөрчлөлт		НДТХ-д 2017.4.14-ны өдөр оруулсан өөрчлөлт НДТХХЖТХ-д 2017.4.14-ний өдрийн өөрчлөлт	
<b>АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧ</b>	2013.01.01-2016.12.31		2017.01.01-2017.12.31	
	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ (хувиар)			
Даатгалын төрөл	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос
Тэтгэврийн даатгал	7.0	7.0	7.0	7.0
Тэтгэмжийн даатгал	0.8	0.8	1	0.8
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	1.0, 2.0, 3.0	-	0.8, 1.8, 2.8	
Ажилгүйдлийн даатгал	0.2	0.2	0.2	0.2
Эрүүл мэндийн даатгал	2.0	2.0	2	2
Нийт	11, 12, 13	10	11, 12, 13	10
Бүгд	21%, 22%, 23%		21%, 22%, 23%	

Хүснэгт 3. МУ-ын НДШ-ийн хувь хэмжээнд 2018, 2019, 2021 онуудад оруулсан өөрчлөлт /хувиар/

Хуульд оруулсан өөрчлөлт	НДТХХЖТХ-ийн 2017.4.14-ний өөрчлөлт		НДТХХЖТХ-ийн 2017.4.14-ний өөрчлөлт		НДТХХЖТХ-ийн 2019.12.20-ны өөрчлөлт	
<b>АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧ</b>	2018.01.01-2018.12.31		2019.01.01-2020.12.31		2021	
	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ (хувиар)					
Даатгалын төрөл	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос
Тэтгэврийн даатгал	8.0	8.0	8.5	8.5	9.5	9.5
Тэтгэмжийн даатгал	1	0.8	1	0.8	1	0.8
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	0.8, 1.8 ба 2,8		0.8, 1.8 ба 2,8		0.8, 1.8 ба 2,8	
Ажилгүйдлийн даатгал	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2
Эрүүл мэндийн даатгал	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0
Нийт	12, 13, 14	11	12.5, 13.5, 14.5	11.5	13.5, 14.5, 15.5	12.5
Бүгд	23%, 24%, 25%		24%, 25%, 26%		26%, 27%, 28%	

Хүснэгтээс үзвэл, 2018 онтой харьцуулахад тэтгэврийн даатгал ажил олгогч болон даатгуулагчийн хувьд тус бүр 1.5 хувь, нийт дүнгээрээ 3 хувиар өссөн байна.

**Сайн дурын даатгал**

Сайн дурын даатгал нь нийгмийн даатгалын шимтгэлийн нийт дүнд харьцангуй бага хувийг эзэлдэг бөгөөд 2018 оноос хойш сайн дурын даатгуулагчийн тэтгэврийн даатгал 1.5 хувиар

нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. МУ-ын НДШ-ийн хувь хэмжээнд 1995, 2008, 2018, 2019, 2021 онуудад оруулсан өөрчлөлт /сайн дурын, хувиар/

САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧ		1995.01.01- 2007.12.31	2008.01.01- 2017.12.31	2018.01.01- 2018.12.31	2019.01.01- 2020.12.31	2021
№	Даатгалын төрөл	Нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, дээд хэмжээнээс ихгүй дүнгээс				
1	Тэтгэврийн даатгал	9.5	10	11	11.5	12.5
2	Тэтгэмжийн даатгал	1	1	1	1	1
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	1	1	1	1	1
Нийт		11.5	12	13	13.5	14.5

УИХ-аас 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хуулийн дагуу нийгмийн даатгалын хувь хэмжээг өөрчилж, цар тахлын улмаас эдийн засгийн нөхцөл байдал хүндрэх эрсдэлийг бууруулах үүднээс нийгмийн даатгалын хувь хэмжээг хөнгөлж, чөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн үйлчлэл нь 2021 оны 7-р сарын 1-нд дуусах юм. Цаашид цар тахлын нөхцөл байдал хэрхэхээс хуулийг хэрхэн авч үзэх нь хамаарахаар байна.

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлсөн байдал, хувиар /2020 оны 4-р 9-ний өдрийн хуулиар/

Хуульд орсон өөрчлөлт	2020.4.9-ний өдрийн хуулиар		
	2020 оны 4-9 сард чөлөөлсөн шимтгэлийн хувь		
Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос	Нийт чөлөөлсөн НДШ
Тэтгэврийн даатгал	8.5	8.5	17
Тэтгэмжийн даатгал	1	0.8	1.8
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	0.2	0.2	0.4
Ажилгүйдлийн даатгал	0.8, 1.8, 2.8		0.8, 1.8, 2.8
Эрүүл мэндийн даатгал			
Нийт шимтгэлийн хувь	10.5-12.5	9.5	20.0-22.0

Хүснэгт 6. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлсөн байдал, хувиар /2020.8.28-ны өдрийн, 2020.11.13-ны өдрийн хуулиар/

2020.8.28-ны өдрийн хуулиар			2020.11.13-ны өдрийн хуулиар		
2020 оны 10-12 сард чөлөөлсөн шимтгэлийн хувь			2021 оны 1-6 сард чөлөөлсөн шимтгэлийн хувь		
Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос	Нийт чөлөөлсөн НДШ	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос	Нийт чөлөөлсөн НДШ
3.5	3.5	7	1	1	2
1	0.8	1.8	1	0.8	1.8
0.2	0.2	0.4	0.2	0.2	0.4

0.8, 1.8, 2.8		0.8, 1.8, 2.8	0.8, 1.8, 2.8		0.8, 1.8, 2.8
5.5-7.5	4.5	10.0-12.0	3.0-5.0	2	5.0-7.0

## Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

### 2.1. Оросын Холбооны Улс

Хүн ам: 2021 оны 1-р сарын 1-ний байдлаар 146 171 015 байна.

ДНБ: 2020 онд ДНБ-ний нэрлэсэн хэмжээ 106.607 их наяд рубль байна.<sup>79</sup>

Нийгмийн даатгалын шимтгэлийн төрөл<sup>80</sup>

- ОХУ-ын Тэтгэврийн санд төлөх албан журмын тэтгэврийн даатгалын шимтгэл;
- ОХУ-ын Нийгмийн даатгалын санд төлөх хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсэн болон амаржсаны албан журмын нийгмийн даатгалын шимтгэл;
- ОХУ-ын Холбооны Эрүүл мэндийн даатгалын санд төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэл;
- Осол гэмтлийн даатгалын шимтгэл (үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний албан журмын нийгмийн даатгалын шимтгэл).

Нийгмийн даатгалын хувь хэмжээ 2021 оны байдлаар<sup>81</sup>

Даатгалын төрөл	Хувь хэмжээ /хувиар/
1. Албан журмын тэтгэврийн даатгал	22%- Хязгаар тогтоосон бөгөөд хэрэв орлогын хэмжээ 1465000 рублиэс дээш бол суутгалын хэмжээг 10% болгон бууруулна.
2. Албан журмын эрүүл мэндийн даатгал	5,1%
3. Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсэн болон амаржсаны албан журмын даатгал	2,9%- Хязгаар тогтоосон бөгөөд хэрэв орлогын хэмжээ 966000 рублиэс хэтэрсэн бол төлбөр төлөхгүй ( 0%)
4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний албан журмын даатгал	0,2% /ангиллаас хамаарч 0,2-8,5%/
<b>НИЙТ</b>	<b>30,2%</b>

2021 онд шимтгэлийн дээд хязгаарыг нэмэгдүүлсэн. Тэтгэврийн шимтгэлийн хувьд дээд хязгаар 1465000 рубль бөгөөд шимтгэлийг 22%-иар (ЖДҮ эрхлэгчдийн хувьд тусгай хөнгөлөлт эдлэх болсон бөгөөд 2021 оны 4-р сараас эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 22%, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш цалинтай тохиолдол 10%) төлнө. Дээд хязгаар 1465000 рублиэс хэтэрсэн тохиолдолд шимтгэлийг 10% болгон бууруулна. (2020 онд дээд хязгаар 1292000 рубль байсан).

Нийгмийн даатгалын шимтгэлийн хувьд дээд хязгаар нь 966000 рубль болж өссөн (2020

<sup>79</sup> <https://www.kommersant.ru/doc/4671959>

<sup>80</sup> [https://www.audit-it.ru/terms/taxation/strakhovye\\_vznosy.html](https://www.audit-it.ru/terms/taxation/strakhovye_vznosy.html)

<sup>81</sup> <https://ppt.ru/art/nalogi/v-fondi>

онд 912000 рубль байсан). Дээд хязгаараас хэтэрсэн тохиолдолд шимтгэл тооцохгүй.

Ажилчдын цалин өндөр байх тусам шимтгэлийн хэмжээ нэмэгдэх тул ажил олгогчийн татварын ачаалал нэмэгддэг.

Албан журмын даатгалд хамрагдах аж ахуйн нэгжийн зардлыг бууруулахын тулд тогтоосон хязгаараас хэтэрсэн тохиолдолд ОХУ-ын Татварын тухай хуульд тарифыг бууруулахаар тусгасан байна. Энэ нь ажил олгогч ажилчдынхаа бодит цалин хөлсийг нуухгүй мэдээлэх нөхцөл бүрдүүлэх зорилготой юм.

## 2.2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Хятадын хүн ам тоо: 1,439,323,776<sup>82</sup> (2020 оны байдлаар)

ДНБ: 2020 онд 15.66 их наяд ам. доллар (101.6 их наяд юань)

БНХАУ-ын нийгмийн даатгал нь “Орон нутгийн нийгмийн даатгал”, “Хувийн тэтгэврийн данс” гэсэн хоёр шатлалтай. “Орон нутгийн нийгмийн даатгал”-д даатгуулагч шимтгэл төлдөггүй, ажил олгогч цалингийн дунджаас 20%-иар шимтгэл төлдөг. Даатгуулагчаас гарах шимтгэл хувийн тэтгэврийн дансанд хуримтлагддаг онцлогтой. Энэ нь хагас хуримтлалын тогтолцооны шинжийг хадгалсан ч даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувь хэмжээ маш бага (татвар ногдуулах орлогын 3%) байдаг тул эрсдэлийг хаах, даатгуулагчийн амьдралыг цаашид хангах баталгаа болж чаддаггүй сул талтай.<sup>83</sup>

Хятадын нийгмийн даатгал нь дараах төрлүүдээс бүрдэнэ.

- Тэтгэврийн даатгал
- Ажилгүйдлийн даатгал
- Эрүүл мэндийн даатгал
- Үйлдвэрийн осол, гэмтлийн даатгал
- Жирэмсэн эхчүүдийн даатгал

АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧ	2019 оны байдлаар	
	Ажил олгогч	Ажилтан
1 Тэтгэврийн даатгал	20%	8%
2 Ажилгүйдлийн даатгал	0.5-1%	0.5%
3 Эрүүл мэндийн даатгал	5-12%	2%
2 Үйлдвэрлэлийн осол гэмтлийн даатгал	0.5-2%	-
5 Жирэмсэн эхчүүдийн даатгал	0.5-1%	-
<b>Нийт</b>	<b>25.5-36%</b>	<b>10.5%</b>

### Цар тахлын үеийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээ<sup>84</sup>

БНХАУ нь Ковид -19 цар тахлын дэгдэлтийг саармагжуулахын тулд нийгмийн аюулгүй байдлын шинэ бодлогыг 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдрөөс Хүний нөөц, Нийгмийн Хамгааллын Яам (*Ministry of Human Resources and Social Security*)-аас нийгмийн даатгалын шимтгэлийн талаар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Төрийн Зөвлөлийн Байнгын Хороо (*Standing Committee of the State Council*) нь 2020 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар аж ахуйн нэгжүүдийн ачааллыг хөнгөвчлөх

<sup>82</sup> <https://www.worldometers.info/world-population/china-population/>

<sup>83</sup> <http://eagle.mn/r/60195>

<sup>84</sup> <https://assets.kpmg/content/dam/kpmg/xx/pdf/2020/03/fa20-046.pdf>

зорилгоор нийгмийн даатгалын шимтгэлийг тодорхой хугацаанд бууруулж, чөлөөлөх арга хэмжээг шийдвэрлэсэн. Төрийн Зөвлөлийн Байнгын Хорооны шийдвэрээр Орон нутгийн Нийгмийн Аюулгүй Байдлын Төв (*Local Social Security Bureau*)-д Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үед нийгмийн даатгалын шимтгэлийг зохицуулах, тогтолцоог бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Аж ахуйн нэгжүүд дараах нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах буюу чөлөөлөхөөр тогтжээ. Үүнд:

- Хубэй (Hubei) муж 2020 оны 2-6 дугаар сарын хугацаанд: Хятадын нийгмийн даатгалын тогтолцоонд хамрагдсан бүх аж ахуйн нэгжүүдийн тэтгэврийн болон ажилгүйдлийн даатгалын шимтгэл, үйлдвэрлэлийн осол, гэмтлийн даатгалын шимтгэлийн ажил олгогчоос олгох шимтгэлийг чөлөөлнө.
- Бусад муж, хотууд (Хубэйгаас бусад) 2020 оны 2-6 дугаар сарын хугацаанд: Бичил, ЖДҮ эрхлэгчдийн тэтгэврийн болон ажилгүйдлийн даатгалын шимтгэл, үйлдвэрлэлийн осол, гэмтлийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос олгох шимтгэлийг чөлөөлнө.
- 2020 оны 2-4 дүгээр сарын хугацаанд: Томоохон аж ахуйн нэгжүүдийн ажил олгогчдын тэтгэвэр, ажилгүйдэл, үйлдвэрлэлийн осол, гэмтлийн даатгалын шимтгэлийг 50%-иар бууруулжээ.
- Орон нутгийн эрх баригчид Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үеэр орон нутгийн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор хот болон мужуудад мөн нийгмийн даатгалын шимтгэлийг хойшлуулах арга хэмжээ авсан байна. Үүнд:
- Шанхай (Shanghai), Сычуань (Sichuan) хотуудад нийгмийн даатгалын шимтгэлийг хойшлуулах;
- Шанхай (Shanghai), Гуанжоу (Guangzhou), Сычуань (Sichuan) хотуудын нийгмийн хамгаалалтын асуудлууд ажил олгогчоос олгох шимтгэлийг хойшлуулах;
- Нанжин (Nanjing), Сүжөү (Suzhou), Сямэн (Xiamen), Чэнду (Chengdu), Чиндао (Qingdao) мужуудад ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн хугацааг хойшлуулах;

Ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах арга хэмжээ нь ажлын өртөгт нөлөөлдөг. Төрийн Зөвлөлийн Байнгын Хорооноос 2020 оны 3 дугаар сарын 4-ны өдрийн байдлаар ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах, чөлөөлөх шийдвэрийг дараах хүснэгтээр тогтоожээ.

(2020 оны 3 дугаар сарын 4 өдрийн байдлаар)

НДШ-ийг бууруулсан хэмжээ				
Муж/ хот	ЭМД	Үйлдвэрлэлийн ослын даатгал	Ажилгүйдлийн даатгал	Тэтгэврийн даатгал
Шанхай	0.5%			
Гуанжоу		50%	Коэффициент 0.6-0.4% ба түүнээс дээш 0.8-0.63 хүртэл	
Сычуань		20-50% ААН нэмэгдэлгүй.	1%	19%-16%

Эх сурвалж: <https://assets.kpmg/content/dam/kpmg/xx/pdf/2020/03/fa20-046.pdf>



Дээрх хүснэгтээс:

- Шанхай (Shanghai) хотод эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 2020 онд түр хугацаагаар 0.5%-иар бууруулсан.
- Гуанжоу (Guangzhou) хотод үйлдвэрлэлийн осол, гэмтлийн даатгалын шимтгэлийг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд 50%-иар бууруулсан.
- Гуанжоу (Guangzhou) хотод ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 2020 оны 12 дугаар сарын дуустал хугацаанд бууруулсан.
- Сычуань (Sichuan) хотод үйлдвэрлэлийн осол, гэмтлийн даатгалын шимтгэлийг өмнөх 2018 оныг үндэслэн 20-50%-иар бууруулсан. Үүнд: 23 сар болон түүнээс дээш 24 сар хүртэлх үеийг хамруулсан. Үйлдвэрлэлийн осол, гэмтлийн даатгалын шимтгэлийг хүүгийн бодлогын дагуу ААН-д нэмэгдүүлэхгүй.
- Нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулсан хэмжээг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хэрэгжүүлнэ.

Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн хугацааг хойшлуулсан. Үүнд:

- Ковид-19 цар тахалд нэрвэгдсэн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй болж, нийгмийн даатгалын шимтгэлээ төлөх боломжгүй болсон тохиолдолд өргөдөл гаргаж 6 сарын хугацаагаар хойшлуулсан үед нэмэлт шимтгэл төлөхгүй. Үүнд: Нанжин (Nanjing), Сүжөү (Suzhou), Сямэн (Xiamen), Чэнду (Chengdu), Чиндао (Qingdao) мужуудад 6 сар хүртэлх хугацаагаар хойшлуулсан.
- Ажилчдынхаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг төлж чадахгүй, үйл ажиллагаа нь алдагдсан аж ахуйн нэгжүүд 3 сараас дээш хугацаагаар ажиллагсдынхаа амьжиргааны зардлыг 1 жилээс илүүгүй хугацаагаар хойшлуулах хүсэлт гаргаж болно. Үүнд: Чиндао (Qingdao) муж (ЭМД-ыг 6 сараас дээш) хамгийн дээд тал нь 1 жилийн хугацаатай хойшлуулжээ.

Ажилгүйдлийн даатгал болон нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгохоор шийдвэрлэв. Үүнд:

- Шэньжэнь (Shenzhen), Чанша (Changsha), Сиань (Xiamen) аж ахуйн нэгжүүдийн ачааллыг бууруулахын тулд ажилгүйдлийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгожээ.
- Жэжян (Zhejiang) мужид аж ахуйн нэгжүүдэд 1-3 сарын ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олгохоор тогтжээ.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (International Labour Organization)-ын 2021 оны 1-3 дугаар сарын БНХАУ-ын Нийгмийн хамгааллын бодлогыг хянах тайланд дараах асуудлуудыг хөнджээ.

Хятад Улс нь нийгмийн хамгааллын талаар дараах бодлогыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн осол, гэмтлийн даатгалын таван жилийн төлөвлөгөө. 2021 оны 1 дүгээр сард Хүний нөөц, нийгмийн хамгааллын яам бусад 7 газартай хамтран “Үйлдвэрлэлийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх таван жилийн төлөвлөгөөг (2021-2025) боловсруулж гаргасан. Энэ төлөвлөгөө нь үйлдвэрлэлийн осол

гэмтлээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, нөхөн олговор олгох гэсэн гурвалсан тогтолцоог боловсронгуй болгох чиглэлийг баримталсан.

- Ажилгүйдлийн даатгал болон үйлдвэрлэлийн осол, гэмтлийн даатгалын шимтгэлийг бууруулах бодлогыг баримталжээ. Үүнд: нийгмийн даатгалын шимтгэлийг үе шаттайгаар бууруулж, чөлөөлөхдөө түр зуурын бодлогыг баримталжээ. Нийгмийн даатгалын гурван шимтгэл болох тэтгэврийн болон ажилгүйдлийн даатгал, үйлдвэрийн осол, гэмтлийн даатгалуудыг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хураан авсан байна. Мөн цар тахлын үед эрсдэлд өртсөн аж ахуйн нэгжийн ажилгүйдлийн даатгал, үйлдвэрлэлийн осол, гэмтлийн даатгалыг үе шаттайгаар бууруулах бодлого баримталж, хугацааг нь 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хугацаагаар нэг жилээр сунгасан байна. 2015-2019 онуудад муж улсуудын нийгмийн даатгалын шимтгэлийг шат дараалан бууруулж ирсэн ба аж ахуйн нэгжүүдийн шимтгэлийн зардлыг нийтдээ нэг их наяд юаниар бууруулсан арга хэмжээг авч байжээ.

Хятадын Засгийн газар 2020 онд нийгмийн даатгалын гурван шимтгэлийг бууруулж, ачааллыг чөлөөлснөөр аж ахуйн нэгжүүдэд 1.54 их наяд юань (үүнээс тэтгэврийн даатгалд 1.33 их наяд юань), 104.2 тэрбум юаниар ажлын байрыг хадгалах, тогтворжуулах зорилгоор ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг буцаан олгосон байна.

### 2.3. Япон Улс

Япон Улсын хүн ам: 126.17 сая хүн (2020 оны байдлаар)<sup>85</sup>

ДНБ: 539,071.6 тэрбум иен, (2021.03.09-ны байдлаар)<sup>86</sup>

Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ<sup>87</sup>

Японы Улсын нийгмийн даатгал нь дараах төрлүүдээс бүрдэнэ:

- Тэтгэврийн даатгал;
- Эрүүл мэндийн даатгал;
- Ажилгүйдлийн даатгал;
- Ажилтны ослын нөхөн төлбөр.

Ажилтны ослын нөхөн төлбөрийг ажил олгогч хариуцах бол бусад даатгалыг ажил олгогч болон ажилтан хоёр хамтран хариуцна.

Эрүүл мэндийн даатгал болон тэтгэврийн даатгалд 5 ба түүнээс дээш ажилтан тогтмол ажиллуулдаг бүх корпорациуд болон албан газрууд албан журмаар хамрагдана. Эдгээр даатгалд хамрагдах ажилтнууд нь холбогдох ААН-ийн үндсэн ажилтнууд болон ажлын өдөр буюу цаг нь үндсэн ажилтны ажиллах өдөр, цагийн дөрөвний гурав ба түүнээс дээш хувийг эзэлдэг ажилтнууд хамрагдана. Дээрхэд хамаарахгүй хэдий ч дараах нөхцөлийг хангаж байгаа ажилтан мөн албан журмаар даатгалд хамрагдана. Үүнд: 1) долоо хоногт ажиллах цаг нь 20 цагаас дээш, 2) 1 буюу түүнээс дээш ажиллах бол, 3) 88,000 иенээс дээш цалинтай бол, 4) оюутан биш бол, 5) тодорхой ажлын байранд ажилладаг бол. Үүнд: жилд 6 сараас дээш 500-аас дээш ажилтан ажиллуулдаг, эсхүл 500 доош ажилтантай ажил олгогч, ажилтан даатгалд хамрагдах гэрээ байгуулсан бол.

<sup>85</sup> <https://www.stat.go.jp/english/data/handbook/c0117.html>

<sup>86</sup> <https://www.mofa.go.jp/policy/economy/japan/index.html>

<sup>87</sup> <https://www.nenkin.go.jp/international/japanese-system/employeespension/employee.html>

АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧ		2020 оны 10 дугаар сарын байдлаар <sup>88</sup>	
		Ажил олгогч	Ажилтан
1	Тэтгэврийн даатгал	9.15	9.15
2	Эрүүл мэндийн даатгал	4.935% (40 буюу түүнээс дээш настай бол 5.83%)	4.935% (40 буюу түүнээс дээш настай бол 5.83%)
3	Ажилгүйдлийн даатгал	0.6%	0.3%
2	Ажилтны ослын нөхөн төлбөр	0.3%	-
5	Хүүхдийн тэтгэмжийн даатгал	0.36%	-
<b>Нийт</b>		<b>15.345%</b> (40 буюу түүнээс дээш настай бол 16.24%)	<b>14.385%</b> (40 буюу түүнээс дээш настай бол 15.28%)

## 2.4 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын хүн ам: 83.1 сая хүн (2021 оны байдлаар)<sup>89</sup>

ДНБ: 3,332 тэрбум евро (2021 оны байдлаар)<sup>90</sup>

Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ<sup>91</sup>

Японы Улсын нийгмийн даатгал нь дараах төрлүүдээс бүрдэнэ:

- Эрүүл мэндийн даатгал
- Асаргааны даатгал
- Тэтгэврийн даатгал
- Ажилгүйдлийн даатгал
- Ослын даатгал

Нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч ба ажилтан ойролцоогоор тэнцүү хуваадаг бөгөөд зөвхөн ослын даатгалын зардлыг ажил олгогч дангаар хариуцдаг. Нийтдээ ажил олгогчийн НДШ-д эзлэх хувь нь ажилтны нийт цалингийн 21 орчим хувьтай тэнцдэг.

АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧ		2021 оны байдлаар <sup>92</sup>	
		Ажил олгогч	Ажилтан
1	Тэтгэврийн даатгал	9.3%	9.3%
2	Эрүүл мэндийн даатгал*	7.3%	7.3%
3	Ажилгүйдлийн даатгал	1.2%	1.2%
4	Ажилчны ослын нөхөн төлбөр	1.14%**	-
5	Асаргааны даатгал	1.525%	1.525%***
<b>Нийт</b>		<b>20.465%</b>	<b>19.325%</b>

<sup>88</sup> [https://www.jetro.go.jp/en/invest/setting\\_up/section4/page9.html](https://www.jetro.go.jp/en/invest/setting_up/section4/page9.html)

<sup>89</sup> [https://www.destatis.de/EN/Themes/Society-Environment/Population/Current-Population/\\_node.html](https://www.destatis.de/EN/Themes/Society-Environment/Population/Current-Population/_node.html)

<sup>90</sup> [https://www.destatis.de/EN/Themes/Economy/National-Accounts-Domestic-Product/\\_node.html](https://www.destatis.de/EN/Themes/Economy/National-Accounts-Domestic-Product/_node.html)

<sup>91</sup> <https://www.pwc.com/gx/en/hr-management-services/pdf/social-security-country-profiles-august-2014.pdf>

<sup>92</sup> <https://www.gtai.de/gtai-en/invest/investment-guide/employees-and-social-security/the-german-social-security-system-65600>

<https://www.gtai.de/resource/blob/73624/575666dc6ed592cb9d15f136d66bbbeb/Employees.pdf>

КОВИД-19 цар тахлын улмаас эдийн засгийн хүндрэлийг даван туулах урамшууллын багц хөтөлбөрийн хүрээнд 2021 оныг дуустал НДШ-ийн дээд хязгаарыг тогтоосон бөгөөд ажил олгогч, ажилтны төлөх шимтгэл нийлээд 40 хувиас хэтрэхгүй байна.

\* Эрүүл мэндийн даатгалын компани тус бүр ажил олгогч ба ажилтанд ногдуулж болзошгүй нэмэлт шимтгэл (тэнцүү хувиар). Холбооны эрүүл мэндийн яамнаас тогтоосон 2021 оны дундаж шимтгэлийн хэмжээ 1.3% байна.

\*\* Германы нийгмийн ослын даатгал (DGUV)-аас гаргасан тоо статистик (ослын даатгалын дундаж шимтгэлийн хувь-2019 оны байдлаар.)

\*\*\* 23-аас дээш насны хүүхэдгүй ажилтнууд 0.25% сувиллын даатгалын нэмэлт төлбөр төлдөг. Саксоны холбооны муж улсад тусгай журам мөрдөгддөг.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Япон улс

- <https://www.nenkin.go.jp/international/japanese-system/employeespension/employee.html>
- <https://www.stat.go.jp/english/data/handbook/c0117.html>
- <https://www.mofa.go.jp/policy/economy/japan/index.html>
- [https://www.jetro.go.jp/en/invest/setting\\_up/section4/page9.html](https://www.jetro.go.jp/en/invest/setting_up/section4/page9.html)

### ОХУ

- <https://www.kommersant.ru/doc/4671959>
- [https://www.audit-it.ru/terms/taxation/strakhovye\\_vznosy.html](https://www.audit-it.ru/terms/taxation/strakhovye_vznosy.html)
- <https://ppt.ru/art/nalogi/v-fondi>

### БНХАУ

- <https://www.worldometers.info/world-population/china-population/>
- <https://edition.cnn.com/2021/04/15/economy/china-q1-gdp-record-intl-hnk/index.html>
- <https://fortune.com/2021/04/16/china-gdp-economy-2021-q1-recovery-losing-steam/>
- <http://eagle.mn/r/60195>
- <https://assets.kpmg/content/dam/kpmg/xx/pdf/2020/03/fa20-046.pdf>
- [https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms\\_780427.pdf](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_780427.pdf)
- <https://www.china-briefing.com/news/wp-content/uploads/2017/09/Chinas-Social-Security-System-1.jpg>

### ХБНГУ

- <https://www.pwc.com/gx/en/hr-management-services/pdf/social-security-country-profiles-august-2014.pdf>
- [https://www.destatis.de/EN/Themes/Society-Environment/Population/Current-Population/\\_node.html](https://www.destatis.de/EN/Themes/Society-Environment/Population/Current-Population/_node.html)
- [https://www.destatis.de/EN/Themes/Economy/National-Accounts-Domestic-Product/\\_node.html](https://www.destatis.de/EN/Themes/Economy/National-Accounts-Domestic-Product/_node.html)
- <https://www.gtai.de/gtai-en/invest/investment-guide/employees-and-social-security/the-german-social-security-system-65600>
- <https://www.gtai.de/resource/blob/73624/575666dc6ed592cb9d15f136d66bbbeb/Employees.pdf>

# НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ЧӨЛӨӨЛӨЛТ: МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ БА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Дүн шинжилгээ)

*Ш.Батцэнгэл, О.Билгүүтэй,  
И.Жаргалзаяабямба, Г.Уянга*

## АГУУЛГА

## УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

1.НӨАТ-ын тухай ойлголт

НӨАТ-ын үүрэг, давуу болон сул талууд

2.НӨАТ-ын суурийг чөлөөлснөөр гарах эдийн засгийн үр дагаврыг тооцох нь

3.Монгол Улс дахь НӨАТ болон НӨАТ-ын чөлөөлөлтийн өнөөгийн байдал, динамик хандлага

НӨАТ Монгол Улсад

НӨАТ болон ДНБ-ний хамаарлын шинжилгээ

4.Монгол Улсын НӨАТ-ын чөлөөлөлтийн салбарын судалгаа

5.Монгол Улсын болон гадаадын зарим улс орнуудын НӨАТ-ын болон НӨАТ-аас чөлөөлөх бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийн судалгаа

5.1.Европын Холбоо

5.2.Бүгд Найрамдах Солонгос Улс

5.3.Бүгд Найрамдах Латви Улс

5.4.Тайвань

ХАВСРАЛТ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ





## УДИРТГАЛ

Судалгаанд Монгол Улсын болон гадаадын зарим улс орнуудын нэмэгдсэн өртгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийн өнөөгийн байдлыг судалж, чөлөөлөлтийн суурийг өөрчлөх, өргөжүүлэхтэй холбоотой ерөнхий санал, дүгнэлтийг боловсруулав.

**Судалгааны хамрах хүрээ:** Судалгааны явцад Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, түүний бүтэц бүрэлдэхүүн, төсөв, татварын орлого, нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлттэй холбоотой мэдээлэлд тоон болон чанарын шинжилгээ хийж, Монгол, Европын холбоо, БНСУ, Тайвань, Латви зэрэг орнуудын нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийг харьцуулан судаллаа.

Судалгааны 1-р хэсэгт нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалтын үйл явц, үүрэг, давуу, сул талуудыг тайлбарласан болно.

Судалгааны 2-р хэсэгт НӨАТ-ын чөлөөлөлтийг хэрэгжүүлэхэд гарах эдийн засгийн засгийн үр дагаврыг хэрхэн тооцвол зохистой болохыг тогтооход хөтөч болох онолын ойлголтуудыг системтэйгээр авч үзсэн.

Судалгааны 3-р хэсэгт НӨАТ болон НӨАТ-ын чөлөөлөлтийн өнөөгийн байдлыг дэлгэрэнгүй шинжлэн судалсан.

Судалгааны 4-р хэсэгт Монгол Улсын НӨАТ-ын чөлөөлөлтийн салбарын судалгааг авч үзсэн бөгөөд салбарын ДНБ-д эзлэх НӨАТ-ын чөлөөлөлтийг салбараар судалсан болно.

Судалгааны 5-р хэсэгт гадаад улс орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалтыг судлагдахуун болгон авч үзсэн болно.

**Түлхүүр үг:** *Нэмэгдсэн өртгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт, татварын орлогын бүтэц, төсвийн орлого, дотоодын нийт бүтээгдэхүүн, эцсийн хэрэглээ*

**Keywords:** *Value added tax, value added tax exemption, tax revenue structure, public budget revenue, gross domestic product, final consumption*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

НӨАТ-ын суурийг чөлөөлөхөд татварын орлого буурч, хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн татварын дараах орлого нэмэгдэх сайн талтай хэдий ч төсвийн зарлагын санхүүжилт дутагдах сөрөг үр дагаврыг бас араасаа дагуулж байдаг. Бий болсон дутагдлыг санхүүжүүлэхдээ зээлийн эх үүсвэрийг ашиглах бөгөөд энэ нь хувийн секторын хөрөнгө оруулалтыг бууруулах нөлөөтэй болохыг тайлбарлаж, ерөнхий үр дүнг нэгтгэхдээ ямар хүчин зүйлсийг харгалзах учиртайг 1-р хэсэгт тодорхойлсон.

Гадаад улс орнуудтай харьцуулан судлахад НӨАТ нь Азийн орнуудад дунджаар 11.6 хувь, Америк, Номхон далайн орнуудад дунджаар 13.34 хувь, Африкийн орнуудад 16 хувь, Европын улсуудад дунджаар 19.97 хувь байна. НӨАТ-ын хувь нь дэлхийн дунджаар 15.43 хувь байгаа нь манай улсынхтай харьцуулахад 5.43 хувиар өндөр байгаа юм.

Судалгаанд авагдсан Латви Улс бараа үйлчилгээний онцлогоос шалтгаалж 5-21 хувийн хооронд НӨАТ ногдуулдаг бол БНСУ, Тайвань, Латви Улсуудын татварын орлогод эзлэх НӨАТ-ын хувийн жин ерөнхийдөө ойролцоо буюу 20-27 хувийн хооронд байна. Тайванийн хувьд НӨАТ-ын хувь харьцангуй бага буюу 5 хувь байгаа нь НӨАТ-ын нийт татварын орлогод эзлэх хувийг нь бага болгоход нөлөөлсөн гэж дүгнэж болохоор байна. Монгол Улс болон дээрх 3 улсын ДНБ-ний өсөлт нь хол зөрөөгүй буюу 2.63-4.26 хувийн хооронд байгаа нь улс орнууд өөр өөрсдийнхөө эдийн засгийн онцлогт тохирсон төсөв, татварын бодлого хэрэгжүүлдэгтэй холбоотой гэж хэлж болно.

Бидний хийсэн судалгаанаас манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг эзэлдэг эцсийн хэрэглээнд нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулдаг тул энэхүү татвар нь төсвийн орлогыг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг, тоо хэмжээ нь харьцангуй тогтвортой, өндөр ач холбогдолтой болох нь харагдаж байна. Түүнчлэн, нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт нь жил дараалан нэмэгджээ. Тухайлбал, сүүлийн 4 жилийн туршид НӨАТ-ын чөлөөлөлтийн ДНБ-д эзлэх хэмжээ нь 2.3 хувиас 4.3 хувь болж өссөн бол төлөгдвөл зохих байсан НӨАТ-т эзлэх хувь нь 29 хувиас 42 хувь болж өсжээ. Өөрөөр хэлбэл, энэ хэмжээгээр НӨАТ-ын чөлөөлөлт нь үйлдвэрлэгч, ялангуяа эцсийн хэрэглэгчдэд эерэг таатай боломжийг олгосон байна.

Аливаа албан татварын чөлөөлөлтийн нэг гол зорилго нь онолын хувьд эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэгдсэн байдаг гэж хэлж болно. Сүүлийн 4 жилийн байдлаар ДНБ, НӨАТ-ын чөлөөлөлт хоёр ерөнхийдөө ижил чиглэлтэй байгаа ч 2020 онд чөлөөлөлт өссөн байхад ДНБ тодорхой хэмжээнд буурсан байна.<sup>93</sup> Энэ нь эдийн засгийн өсөлтөнд татвар, чөлөөлөлтөөс гадна олон хүчин зүйлс нөлөөлдөг болохыг харуулж байгаа юм. 2020 онд эцсийн хэрэглээ өндөр хэвээр байсан ч хөрөнгө оруулалтын зардал хумигдсан нь ДНБ-ийг бууруулжээ.

Нэгэнт НӨАТ нь ДНБ-тэй эерэг хамааралтай, ДНБ-ний шалтгаан болж байгаа болохоор НӨАТ-ын хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй юм гэсэн дүгнэлтэд туйлшрахгүйгээр хэрэглээ зонхилсон эдийн засгийн бүтцийг анзаарч, чөлөөлөлт нь НӨАТ-ын дүнг багасгах нөлөөтэй хэдий ч НӨАТ-ын чөлөөлөлтийн хэмжээ, өөрчлөлтийн онцлогийг харгалзан чөлөөлөлтийн суурийг өөрчлөх, өргөжүүлэх асуудлыг макро эдийн засгийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн харилцан шүтэлцээнд тулгуурлан судалж, эдийн засгийн үр дагаврыг нь нарийвчлан тооцох

<sup>93</sup> Зураг 10-аас харна уу.

нь чухал юм.

Монгол улсын татварын орлогын ДНБ-д эзлэх хэмжээ дэлхийн улс орнуудын дундажтай ойролцоо буюу 24 хувь, НӨАТ-ын хувь дэлхийн дундажтай харьцуулахад 5.43 хувиар бага, чөлөөлөлтийн хэмжээ жил бүр нэмэгдсээр байна. Нийт татварын орлогын 26 хувийг эзэлдэг нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийн татварын нийт орлогод эзлэх хувь ч сүүлийн 4 жилийн турш жил бүхэн нэмэгдэж 10-аас 19 хувьд хүрчээ.

Түүнээс гадна Монгол Улсын НӨАТ-ын чөлөөлөлтийг салбараар нь судлахад НӨАТ-ын чөлөөлөлтийн ДНБ-д эзлэх хувь хамгийн өндөр байгаа эхний 5 салбарт:

- Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа (Зээл олгох үйлчилгээ, даатгалын үйлчилгээ, валют солих үйлчилгээ)
- Үйлчилгээний бусад үйл ажиллагаа (дэлгэрэнгүйг хавсралт файлаас харах боломжтой)
- Уул уурхай олборлолт (Газрын тос, экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүн, борлуулсан алт)
- Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа (дэлгэрэнгүйг хавсралт файлаас харах боломжтой)
- Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа гэсэн салбарууд орж байна.

Харин НӨАТ-ын чөлөөлөлтийн ДНБ-д эзлэх хувь хамгийн бага байгаа 5 салбарт:

- Мэргэжлийн болон техникийн үйл ажиллагаа
- Боловсрол (Боловсролын болон мэргэжлийн сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээдийн эрхлэн гүйцэтгэж байгаа дүрэмд нь заасан боловсрол, мэргэжил олгох үйлчилгээ)
- Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа
- Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа
- Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын завсар, үйлчилгээ гэсэн салбарууд тус тус багтаж байна.

ДНБ-д эзлэх хувь нь харьцангуй бага байгаа салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийн өсөлтийг татварын суурийн чөлөөлөлтөөр дамжуулан дэмжих нь чухал байдаг. Тэгвэл судалгааны 5-р хэсэгт чөлөөлөлтийн ДНБ-д эзлэх хувь харьцангуй бага байгаа, гадаад улсын НӨАТ-ын хуульд чөлөөлөгдөхөөр заасан хэдий ч манай улсын хуульд чөлөөлөгдөхөөр тусгагдаагүй гэсэн 2 шалгуурыг үндэслэл болгож, чөлөөлөх эсэх талаар судлах боломжтой бараа үйлчилгээнүүдийг тодорхойлвол эдгээрт:

- Усалгааны зориулалтаар нийлүүлсэн ус
- Хөдөө аж ахуйн техник хэрэгсэлд ашиглах цахилгаан
- Зохиогчийн эрхийг ашигласны төлбөр
- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ
- Бүх шатны боловсролын үйлчилгээ
- Орон сууц, орон сууцны газрын түрээс
- Үл хөдлөх хөрөнгө, газрын худалдаа
- ТҮЦ, гудамжинд наймаа эрхлэгсдийн бараа, үйлчилгээ гэсэн нэр төрлүүд багтаж байна.

Эцэст нь дээр дурдсан хүчин зүйлүүдийг харгалзаж, нэмэгдсэн өртгийн албан татварын

суурийг өргөжүүлэх асуудлыг макро эдийн засгийн урт, дунд хугацааны зорилтууд, хязгаарлагдмал санхүүгийн нөөцийн хуваарилалтын сувгууд болох хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн мөнгөн орлогын хуваарилалт, засгийн газрын зардлын үр ашиг, мөнгө санхүү, зээлийн орчны хүрээнд нарийвчлалтай судлаж, нягт нямбай хандах нь зүйтэй гэж хэлэх байна.

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

### 1.НӨАТ-ын тухай ойлголт<sup>94</sup>


НӨАТ гэж юу вэ?

Бараа, үйлчилгээний хэрэглээнд ногдуулах татварыг нэмэгдсэн өртгийн албан татвар гэнэ. НӨАТ-ыг үйлдвэрлэлийн шат дамжлага бүрд ногдуулж, төлж байдаг. Үүнд: түүхий эд, материал худалдан авах, түүнийг боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг бөөний үнээр нийлүүлэх, жижиглэнгийн худалдаа эрхлэх зэрэг үйл ажиллагааг хамруулж болно.

Үйлдвэрлэлийн эдгээр шат дамжлага бүр бэлэн бүтээгдэхүүний "өртгийг нэмдэг" тул энэхүү татварыг нэмэгдсэн өртгийн албан татвар гэж нэрлэдэг. Үйлчилгээний хувьд НӨАТ-ыг тухайн үйлчилгээ эцсийн хэрэглэгчдэд хүрэх үед ногдуулдаг. Тиймээс аж ахуйн нэгж, иргэн бүгд худалдан авч буй бүтээгдэхүүндээ татвар төлдөг гэсэн үг. "Ер нь НӨАТ-ыг чөлөөлөхийн зорилго нь эдийн засагт төдийлөн өндөр үүрэг гүйцэтгээгүй байгаа салбарын үйлдвэрлэлийг дэмжих явдал байдаг гэж хэлж болно".<sup>95</sup>

Түүнчлэн үйлдвэрлэгч, бөөний худалдаа эрхлэгчид түүхий эд материал, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, бэлэн бүтээгдэхүүн худалдан авах тутамдаа НӨАТ төлдөг. Тэд өөрийн хагас болон бэлэн боловсруулсан бүтээгдэхүүнийг борлуулах үедээ худалдан авагчдаас НӨАТ-ыг цуглуулна. Татварын төсөвт төлөгдөх хэсэг нь бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн татвар болон худалдан авагчдаас цуглуулсан татвар хоёрын зөрүү байдаг.

Зураг 7. НӨАТ-ын дүнг тооцоолох жишээ



Эх сурвалж: [jishee.jpg](http://jishee.jpg) (638×479) ([bp.blogspot.com](http://bp.blogspot.com))

<sup>94</sup> НӨАТ-ын тухай хууль

<sup>95</sup> Harvey S.Rosen Public finance, Taxation and income distribution, 2011

## НӨАТ-ын үүрэг, давуу болон сул талууд

Аль ч татвар дараах үүргийг эдийн засагт гүйцэтгэдэг гэж үзэж болно.<sup>96</sup>

- 1) Нөөцийг хуваарилах
- 2) Орлогын дахин хуваарилах
- 3) Эдийн засгийг тогтворжуулах

Явцуу утгаараа татвар нь эдийн засагт доорх үүргүүдийг гүйцэтгэдэг байна.<sup>97</sup>

- ✓ Баялгийг дахин хуваарилах
- ✓ Эдийн засгийн өсөлтийг дэмжих
- ✓ Орлогын тэгш бус байдлыг багасгах
- ✓ Үнийн түвшинг тогтворжуулах
- ✓ Хэрэглээг урамшуулах
- ✓ Тодорхой салбарыг хамгаалах
- ✓ Шинэ салбарын үйл ажиллагааг дэмжих
- ✓ Орлого, хуримтлалыг нэмэгдүүлэх зэрэг болно.

НӨАТ ч мөн өөрийн ногдох суурь, хөнгөлөлт, чөлөөлөлт, хувь хэмжээгээр дамжуулан дээрх үүргийг үнийн түвшний өөрчлөлтөөр дамжуулан гүйцэтгэдэг. Тухайлбал, зарим салбарт НӨАТ-ыг чөлөөлж болно, эсвэл НӨАТ-ын хувь хэмжээг багасгаж болно. Эдгээр тохиолдолд бизнесүүдийн болон иргэдийн цэвэр орлого нэмэгдэж, хэрэглээ, хуримтлал өсөх, нийт мөнгөн орлогын хуваарилалтад өөрчлөлт орох, эдийн засгийн өсөлтөд ахиц гарах, орлогын тэгш байдлын түвшин сайжрах зэрэг үр дүнгүүд бий болж байдаг.

### НӨАТ-ын давуу тал<sup>98</sup>

- Хянан нягтлах боломж өндөртэй тул татвараас зайлсхийх боломж харьцангуй багатай;
- Бусад шууд бус татваруудтай харьцуулахад удирдахад хялбар ;
- Татварын ачааллыг үйлдвэрлэл, борлуулалтын үе шат бүхэнд ногдуулдаг тул нээлттэй, хэрэглэгчдэд ногдох ачаалал нь тодорхой;
- Нийт үнэд биш нэмэгдсэн өртөгт ногдуулдаг учраас үнийг төдийлөн өсгөхгүй;
- Маш олон тооны татвар төлөгчтэй тул төсвийн орлогын найдвартай, томоохон эх үүсвэр болж байдаг;
- Суурь нь өргөн бөгөөд бүхий л төрлийн бизнесүүдэд ногдуулах боломжтой.

### НӨАТ-ын сул тал

- Төлбөрийн иж бүрэн тооцооны системд тулгуурладаг тул хэрэгжүүлэхэд зардал өндөр;
- Ойлгож таних, үе шат бүхэнд нэмэгдсэн өртгийг тооцоход хялбар биш;
- Мөн чанарын хувьд регрессив шинжтэй. Өөрөөр хэлбэл, орлого багатай хүмүүс өндөр орлоготой хүмүүстэй харьцуулахад орлогынхоо харьцангуй их хувийг энэ төрлийн татварыг төлөхөд зарцуулдаг;

<sup>96</sup> Taxation (slideshare.net)

<sup>97</sup> Монгол Улсын 2019 оны татварын орлогод хийсэн шинжилгээ, Ш.Батцэнгэл

<sup>98</sup> <https://qsstudy.com/business-studies/advantages-disadvantages-value-added-tax>

- Худалдан авалт, борлуулалтыг бүхэлд нь бүртгэж байх шаардлагатай байдаг учраас захиргааны зардлыг нэмэгдүүлдэг;
- Хэрэглэгчид энэ төрлийн татварын талаар мэдлэгтэй байхгүй бол нэхэмжлэлийн дүнг буруу ойлгож, татвар төлөхөөс цааргалж байж болох юм;
- Зөвхөн эцсийн хэрэглэгч татварын ачааллыг үүрдэг;
- Үнийн түвшинг нэмэгдүүлэх нөлөө үзүүлдэг.

## 2.НӨАТ-ын суурийг чөлөөлснөөр гарах эдийн засгийн үр дагаврыг тооцох нь

Эдийн засгийн үр дагаврыг бүрэн гүйцэд тооцох нь нарийвчилсан тооцоолол, судалгааг шаардсан төвөгтэй ажиллагааг шаарддаг гэж хэлж болно. Тоймлон тодорхойлохын тулд дотоодын нийт бүтээгдэхүүнийг нийт эрэлт, нийлүүлэлтийн буюу зардал, орлогын хандлагаар тодорхойлдог Кейнсийн тэнцэтгэлийг ашиглах боломжтой. Энэ нь.<sup>99</sup>

$$\text{Aggregate demand (нийт эрэлт)} = C + I + G + (X - M) = C + S + \text{Tax} =$$

$$\text{Aggregate supply (нийт нийлүүлэлт)} \text{ гэсэн тэнцэтгэл юм. Энэхүү тэнцэтгэл нь гарсан зардал бүхэн нь хэн нэгний орлого, орж ирсэн орлого бүхэн нь хэн нэгнээс гарсан зардал байна гэсэн утгыг агуулна.}$$

C	Өрхийн эцсийн хэрэглээ
I	Хувийн хөрөнгө оруулалт
G	Засгийн газрын зардал
X	Экспорт
I	Импорт
GDP	Дотоодын нийт бүтээгдэхүүн

Дээрх тэнцэтгэлийг арай өөрөөр  $\text{Tax} = \text{GDP} - (C + S)$ ,  $C + S = \text{GDP} - \text{Tax}$  гэсэн хэлбэрээр бичиж болно. Энэ нь хэрэв татвар буурвал иргэд, аж ахуйн нэгжийн татварын дараах орлого буюу хэрэглээ, хуримтлалын хэмжээ нэмэгдэх болохыг харуулна. Тэгвэл НӨАТ-ын чөлөөлөлтийн суурийг нэмэгдүүлснээр эдийн засагт, хэрэглээ, хуримтлалын хэмжээ нэмэгдэх болох нь тодорхой байна гэж хэлэх боломжтой.

НӨАТ-ын чөлөөлөлтөөр дамжиж бий болсон НӨАТ-ын бууралт нь эдийн засаг болон төсвийн орлогод ямар нөлөө үзүүлэхийг тодорхойлохдоо юуны өмнө нөлөөллийн сувгуудыг тогтоох нь чухал байдаг. Нөлөөллийн сувгийг тойм байдлаар мөнгөн орлогын хуваарилалтын, бүтээгдэхүүний шинж чанарын, мөнгө санхүүгийн орчны гэсэн хүрээгээр ангилж боломжтой бөгөөд дараах тохиолдлуудыг авч үзэж болно.

*Үйлдвэрлэгчийн үнэ буурах:* Энэ үед хэрэглэгчийн тухайн бүтээгдэхүүн үйлчилгээнд зарцуулах зардлын хэмжээ багасна. Аль эсвэл хэрэглэгч зардлаа нэмэхгүйгээр тухайн болон өөр бараа үйлчилгээний бодит худалдан авалтаа өсгөнө. Өссөн худалдан авалт нь зардлыг өсгөнө, нэмэгдсэн зардал нь бусад бизнесийн салбарын орлогыг нэмэгдүүлнэ, нэмэгдсэн орлого нь зардлыг өсгөнө гэх зэргээр тодорхой хугацааны туршид нөлөөллөө үзүүлнэ. Ер нь үнэ нь буурсан салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадвар дээшилж, үйлдвэрлэл, борлуулалт ч дүнгийн хувьд нэмэгдэх боломж бүрдэх юм. Үнэ буурах тохиолдол нь өрсөлдөөнт зах зээлд үйл ажиллагаа явуулдаг салбарын бизнест нийтлэг тохиолдоно. Оролцогчдод чөлөөлөгдсөн хөрөнгө болон өссөн орлогоо зардлаа нэмэгдүүлэхэд бус санхүүгийн зах зээлд байршуулах сонголтын өөр нэгэн хувилбар бий.

<sup>99</sup> [Keynesian economics - Wikipedia](#)



*Үйлдвэрлэгчийн үнэ буурахгүй байх:* Энэ үед бизнесийн байгууллагын татварын дараах цэвэр орлогын хэмжээ нэмэгдэнэ. Ашиг нь өссөн бизнесийн байгууллага зардлын өсөлтөөр дамжуулан үндсэн болон эргэлтийн хөрөнгөө өсгөх, цалингийн болон үйл ажиллагааны зардлаа нэмэгдүүлэх, аль эсвэл санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх боломжтой. Үнэ буурахгүй байх тохиолдол нь өрсөлдөөнт бус монополь, олигополи зах зээлүүдийн хувьд илүүтэй ажиглагдана.

Дээрх тохиолдлуудад эдийн засаг дахь хэрэглээ, хуримтлалын хэмжээ нэмэгдэж байна. НӨАТ-ын суурийн зарим хэсгийн чөлөөлөлт нь хугацааны тодорхой нэг цэгээс эхлэн хэрэгжих бөгөөд эдийн засгийн тасралтгүй үргэлжлэх цогц цикл үйл явцын бүрэлдэхүүн хэсэг болж нөлөөллөө бий болгоно. Тухайлбал, экспорт, импорт, ажил эрхлэлт, орлого хуваарилалт, үнийн түвшинд ч нөлөөлнө. Санхүүгийн зах зээлд шинээр байршсан мөнгөн хөрөнгө нийлүүлэлтийг тодорхой хэмжээнд өсгөж Төв банкны бие даасан бодлого болон эрэлт, нийлүүлэлтийн өөрчлөлтийн үр дүнд мөнгөний өртөг буюу санхүүжилтийн зардал тодорхойлогдож байдаг.

Тэгвэл өөрчлөлтийн салшгүй хэсэг болгон НӨАТ-ын зарим суурийг чөлөөлснөөр харгалзаж үзвэл зохих дараагийн нэг зүйл бол засгийн газрын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах үйл явцын үр дүнг тооцоолох явдал байна. Улс орнуудын засгийн газрын зардал нэрлэсэн дүнгээрээ үргэлж өсөж байдаг. Засгийн газрын зардлыг санхүүжүүлэх орлого дутагдвал бизнесийн мөчлөгийн тодорхой нэг цэгээс эхлэн санхүүжилтийн эх үүсвэрийг дайчлах шаардлагатай болно. Аливаа үр дүн мөнгөн сангаас эхтэй ч зардлын үр дүнд тодорхойлогддог гэж хэлж болох бөгөөд НӨАТ-ын чөлөөлөлтийн өсөлтийн нөлөөгөөр хэрэглээ тодорхой хэмжээгээр өсөж, хуримтлал нэмэгдэж хувийн секторын хөрөнгө оруулалт тэлэх боловч татвар буурсан үед засгийн газрын зардал хэвээр юм уу аль эсвэл өсөж байвал хувийн секторын хөрөнгө оруулалтад зориулах байсан хуримтлал багасна. Үр дүнд нь хувийн секторын хөрөнгө оруулалт хумигдана.<sup>100</sup>

$$C(1) + I(\uparrow, \downarrow) + G + (X - M) = C(1) + S(p) + S(g) + Tax \downarrow = \text{Aggregate supply}$$

$$C(0) + I(0) + G + (X - M)(0) = C(0) + S(0) + Tax(0)$$

$$S = S(p) + S(g) > S(0) \quad C(1) > C(0)$$

Хаалтанд 0 гэсэн индекстэй үзүүлэлтүүд нь өөрчлөлт хийхээс өмнөх үеийн, хаалтанд 1 гэсэн индекстэй үзүүлэлтүүд нь өөрчлөлт хийсний дараах үеийн үзүүлэлтүүд болно.

$C(1)$	Чөлөөлөлтийг нэмэгдүүлсний дараах эцсийн хэрэглээ
$C(0)$	Чөлөөлөлтийг нэмэгдүүлэхээс өмнөх үеийн эцсийн хэрэглээ
$S(p)$	Хувийн секторын хуримтлал
$S(g)$	Засгийн газрын хуримтлал
$S$	Нийт хуримтлал

НӨАТ-ын чөлөөлөлттэй холбоотойгоор хугацааны тухайн нэг цэгээс эхэлсэн хөрөнгө оруулалт, хэрэглээний өөрчлөлтийн нөлөө, мөнгөн орлогоор дамжин хэрэгжих харилцан үйлчлэл, экспорт, импорт, дээр дурдсан макро эдийн засгийн бусад хүчин зүйлсийг тооцож эдийн засгийн өсөлт өмнөхөөс хэр зэрэг болохыг харьцуулан дүгнэх боломжтой.

Тухайлбал, засгийн газрын санхүүжилтийн дутагдлыг дотоод эх үүсвэрийг ашиглаж бонд гаргана гэвэл энэ нь хувийн хөрөнгө оруулалтыг бууруулах шалтгаан болох юм. Цаг

<sup>100</sup> [The expenditure-output, or Keynesian cross, model \(article\) | Khan Academy](#)

хугацаа, тоо хэмжээнээс шалтгаалж мөнгөний өртөгт ч өөрчлөлт орж болно. Гадаад эх үүсвэрийг ашиглавал мөнгөний нийлүүлэлт өсөх, гадаад өрийн хэмжээ нэмэгдэж, хүүгийн зардал төлөх нөхцөл байдал үүснэ. Үр дүнг тодорхой хугацааны уртаар хэмжих бөгөөд НӨАТ-ын чөлөөлөлтийн нөлөөг бие дааж үнэлэх нь зүйтэй юм.

Нөгөө талаас аливаа татварын орлого нэмэгдэх нь эдийн засгийн тэлэлтийг дагаад аяндаа бий болох үйл явц боловч тухайн улсын эдийн засагт ямар үр нөлөөтэйгээр оршин байгааг тодорхойлох нь төр, засгийн бодлогын шийдвэрт харгалзаж үзвэл зохин хүчин зүйл болж байдаг гэж хэлж болно. Ер нь татварын хэмжээг нэмэгдүүлэх нь хувийн хэрэглээ, эдийн засаг дахь хуримтлалыг багасгах нөлөө үзүүлдэг бөгөөд засгийн газрын зардлыг нэмэгдүүлэх, ялангуяа хувийн хэрэглээ буураагүй тохиолдолд хувийн хөрөнгө оруулалтыг агшаах нөлөөг бий болгодог.

$$C + I \downarrow = Y - (G \uparrow + (X - M))$$


Засгийн газрын зардал нь дээр дурдаад өнгөрсөн макро эдийн засгийн үр дүнгийн үзүүлэлтүүдэд мөн нөлөөлнө. Тухайлбал, төсвийн зарлагын өсөлт нь бодит секторын орлогыг нэмэгдүүлэх нөлөөтэй. Ингэж нэмэгдсэн орлого нь цаашид худалдан авалтын өсөлтийг дэмжинэ. Шууд худалдан авалтын өсөлтийн нөлөөллөөс гадна засгийн газрын зардал нэмэгдэх нь боловсрол, эрүүл мэнд гэх зэрэг нийгмийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дамжуулан улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн дунд, урт хугацааны баталгааг хангаж байдаг.

### 3. Монгол Улс дахь НӨАТ болон НӨАТ-ын чөлөөлөлтийн өнөөгийн байдал, динамик хандлага

#### НӨАТ Монгол Улсад

Дараах зурагт Монгол Улсын татварын орлогын бүтэц бүрэлдэхүүний дундажийг харуулав.

Зураг 8. Монгол Улсын татварын орлогын бүтэц



Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Татварын орлогын 25.6 орчим хувийг НӨАТ дангаараа эзэлж байна. НӨАТ нь бараа үйлчилгээний үнэд ногддог шууд бус татвар бөгөөд орлогын буюу шууд татварууд болох НДШ, ХХОАТ, ААНОАТ зэрэг нь нийт татварын орлогын 40 гаруй хувийг эзэлж байна. Харин шууд бус татварууд болох НӨАТ, гадаад худалдааны орлого буюу гаалийн албан татвар, онцгой албан татвар зэрэг нь татварын нийт орлогын мөн 40 гаруй хувийг, үлдсэнийг нь тусгай зориулалтын орлого, өмчийн татвар эзэлж байна.

Доорх хүснэгтэд сүүлийн 4 жилийн ДНБ-ний бүтэц болон татварын мэдээллийг харуулав. Хүснэгттэй холбоотой зарим нэг боловсруулалтыг зураг, дүрслэлээр илэрхийлж арын хэсэгт тайлбар хийх болно.

Хүснэгт 1. Монгол Улсын ДНБ, төсвийн орлогын бүтэц бүрэлдэхүүн (сая төгрөг)

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
GDP	27,876,297.2	32,411,224.1	37,392,629.1	37,329,545.7
TAXR	6,315,131.9	8,207,105.3	9,749,060.5	8,501,795.2
VAT	1,618,492.1	2,196,412.6	2,484,413.4	2,205,219.1
VATE	652,866.78	1,132,832.95	1,523,351.89	1,615,791.94
C	18,472,370.3	21,381,021.3	24,892,965.6	26,630,278.1
I	8,744,376.4	12,830,512.1	14,740,319.4	9,075,062.3
NX	659,550.5	(1,800,309.3)	(2,240,655.9)	1,624,205.3

Эх сурвалж: Сангийн яам, 1212.mn

Хүснэгт 2. Татварын орлогын харьцангуй хэмжигдэхүүн, эцсийн хэрэглээний ДНБ-д эзлэх хувь


TAXR/GDP	0.23	0.25	0.26	0.23
VAT/TAXR	0.26	0.27	0.25	0.25
C/GDP	0.66	0.66	0.67	0.71

Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Үүнд:

GDP	ДНБ	VATE	НӨАТ-ын чөлөөлөлт
TAXR	Татварын орлого	C	Эцсийн хэрэглээ
VAT	НӨАТ	I	Хөрөнгийн хуримтлал


Зураг 9. Татварын орлогын ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Татварын ачаалал буюу ДНБ-д эзлэх татварын орлогын хувь 23-25-ийн хооронд тогтвортой байна гэж хэлж болохоор байна. Энэ нь дэлхийн 179 орны дундаж 21.2 хувь байгаатай харьцуулахад арай жаахан өндөр юм. Нөгөө талаас үүнийг ДНБ-тэй тогтвортой хамаарлаар татварын орлого нэмэгдэж байна гэж үзэх боломжтой. Татварын ачааллыг төрийн оролцоог илэрхийлсэн үзүүлэлт гэж үздэг. Өндөр хөгжилтэй зарим орнуудын хувьд тухайлбал Франц, Австри зэрэг улсад татварын ачаалал 40 орчим хувьтай байгаа нь төрийн эдийн засаг дахь оролцоо өндөртэй улс орон заавал хөгжиж байгаа юм уу аль эсвэл буурай хөгжилтэй орны ангилалд харьяалагддаггүй болохыг харуулж байна.


Зураг 10. Нэмэгдсэн өртгийн албан татварын нийт татварын орлогод эзлэх хувь



Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Татварын орлогын 21-31 орчим хувийг НӨАТ дангаараа бүрдүүлж байгаа нь НӨАТ манай улсын хувьд ач холбогдол өндөртэй татвар мөн болохыг харуулж байна. 2015 онд батлагдсан шинэ хуулийн зохицуулалт нь НӨАТ-ын төлөлтийг тодорхой хэмжээгээр бууруулсан хэдий ч 2016 оноос хуулийн хэрэгжилтийн чанар дээшилж татварын орлогод эзлэх хувь тогтвортой болжээ.

Зураг 11. НӨАТ, ДНБ, Татварын орлогын динамик




Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

ДНБ-ний нэрлэсэн хэмжээ байнга өсөж байгаа тул татварын орлого, НӨАТ-ын хэмжээ ч бас нэмэгдэж байна. Харин 2020 онд НӨАТ-ын хэмжээ бага зэрэг багасжээ. Эцсийн хэрэглээний нэрлэсэн дүн болон ДНБ-д эзлэх хувь өссөн байгаагаас хэдий инфляцийн нөлөө байх боловч хэрэглэгчид орлогоо эцсийн хэрэглээнд зориулах хандлага нэмэгдсэн гэж дүгнэж болно. Энэ нь иргэд дэлхий дахинд тулгамдаж буй цар тахалтай холбоотойгоор өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүнийг өмнөхөөс ихээр худалдан авч нөөц бүрдүүлж байсантай тодорхой хэмжээгээр холбоотой. Харин эцсийн хэрэглээ нэмэгдсэн байхад төлсөн НӨАТ-ын хэмжээ буурсныг НӨАТ-ын чөлөөлөлт бага зэрэг өссөн, хэрэглээний үнийн буюу инфляцийн түвшин өмнөх оныхоос нам байснаас нэмэгдсэн өртөг харьцангуй бага

болсон, 50 хүртэлх сая төгрөгийн орлоготой жижиг бизнесүүд үйл ажиллагаагаа тодорхой түвшинд явуулж чадаж байсан, хэрэглэгчдийн НӨАТ-ын буцаан олголтын хүсэлт гаргах эрчим нэмэгдсэн зэрэгтэй холбон тайлбарлах боломжтой.


Зураг 12. Эцсийн хэрэглээний ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Эцсийн хэрэглээний ДНБ-д эзлэх хувийн жин 66-73 хувийн хооронд утгаа авч байна. Сүүлийн 3 жилд энэ үзүүлэлт тогтвортой нэмэгджээ.


Зураг 13. Хөрөнгийн хуримтлал, цэвэр экспорт, эцсийн хэрэглээний график



Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Эцсийн хэрэглээний нэрлэсэн хэмжээ тасралтгүй өссөн байгаа болохыг графикаас харж болно. ДНБ-ийг зардлын аргаар тодорхойлох үзүүлэлтүүдээс эцсийн хэрэглээ дангаараа өсөлтийн утгыг жигд авч байсан байна.

Зураг 14. НӨАТ-ын чөлөөлөлтийн татварын орлогод эзлэх хувь



Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Зураг 8-аас нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийн нийт татварын орлогод эзлэх хувь жил бүр тасралтгүй нэмэгдэж 10-19 хувийн хооронд утгаа авчээ. Энэ нь хэрэв нэмэгдсэн өртгийн татварыг чөлөөлөөгүй бол татварын орлого, тухайлбал 2020 онд 19 хувиар нэмэгдэх боломжтой байсан болохыг харуулна.

#### НӨАТ болон ДНБ бүтээгдэхүүний хамаарлын шинжилгээ

Сул гишүүнгүй регрессийн тэгшитгэл

$$\text{VATG} = 17.00634317 * \text{GDPG}$$

Тайлбарлах чадварыг нь харгалзан сул гишүүнгүй үнэлгээ хийлээ.

VATG

GDPG

Корреляцийн хамаарал

	GDPG	VATG
GDPG	1	0.8714
VATG	0.8714	1

НӨАТ-ын өсөлт

ДНБ-ний өсөлт

Хамаарлын шинжилгээнээс ДНБ болон НӨАТ-ын өсөлт хоёр нь шууд хамааралтай болох нь тодорхой байна. Ерөнхийдөө ДНБ өсөхөд татварын бааз суурь тэлж татвар өсдөг гэсэн онолын дүгнэлттэй гарсан үр дүн тохирч байна.

Учир шалтгааны эх сурвалжийг тогтоох Гранжерийн тест  
Pairwise Granger Causality Tests

Date: 03/17/21 Time: 09:25

Sample: 1991 2019

Lags: 2

Null Hypothesis:	Obs	F-Statistic	Prob.
VAT does not Granger Cause GDP	27	7.12357	0.0041
GDP does not Granger Cause VAT		14.6178	9.E-05

Хугацааны хоёр нэгжийн хоцрогдолтойгоор НӨАТ болон ДНБ нь харилцан нэгнийхээ шалтгаан болж байдаг байна. Танзани, Нигерь, Өмнөд африк зэрэг улсуудын хувьд НӨАТ болон татварын орлого нь эдийн засгийн өсөлтийн шалтгаан болж байсан бэлэн



судалгаанууд байна.<sup>101</sup> Манай улсын эдийн засагт хэрэглээ нь ДНБ-ний дийлэнх хэсгийг эзэлж байгаа бөгөөд эдгээр хоёр үзүүлэлт нь хоорондоо шууд хамааралтай байгаа юм. Нөгөө талаас нэмэгдсэн өртгийн албан татварыг эцсийн хэрэглээнд ногдуулдаг тул энэхүү татвар нь хэрэглээгээр дамжин ДНБ-ний шалтгаан болж байна гэж дүгнэн хэлж болно. Ер нь татварын орлого өсөхөд ДНБ нэмэгддэг гэж дүгнэх нь логикийн хувьд үндэслэл багатай байж болох хэдий ч татварын орлого нэмэгдсэнээр төсвийн зарлага өсөж, өссөн төсвийн зарлага нь нийгмийн хөгжлийг хангах, эдийн засгийн өсөлтийг дэмжих баталгааг бий болгож байдаг, энэ нь тоон шинжилгээний хамаарлаар биелэгдэж байна ч гэж үзэх боломжтой.

Дараах хүснэгтээс эцсийн хэрэглээний ДНБ-д эзлэх хувь хамгийн багадаа 66 хувь, НӨАТ-ын чөлөөлөлтийн ДНБ-д эзлэх хувь 2.3-4.3 хувийн хооронд байгааг харж болно. НӨАТ-ын чөлөөлөлтийн нийт төлөгдвөл зохих НӨАТ-д эзлэх хувийг тооцоолохдоо чөлөөлөгдсөн НӨАТ-ыг төлөгдсөн НӨАТ, чөлөөлөгдсөн НӨАТ хоёрын нийлбэрт хуваав.

НӨАТ-ын чөлөөлөлт нь нэрлэсэн дүн болон харьцангуй утгын хувьд сүүлийн 4 жилийн байдлаар тасралтгүй нэмэгдэж байгаагаас энэхүү татварын чөлөөлөлт ерөнхийдөө өсөж байна гэж хэлж болохоор байна.

Зураг 15. НӨАТ-ын чөлөөлөлтийн үзүүлэлтүүд


Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Хэрэглээний ДНБ-д эзлэх хувь	0.663	0.66	0.666	0.713
НӨАТ-ын чөлөөлөлтийн нийт төлөгдвөл зохих НӨАТ-д эзлэх хувь	29%	34%	38%	42%
НӨАТ-ын чөлөөлөлтийн хэмжээ (сая төгрөг)	652,866.78	1,132,832.95	1,523,351.89	1,615,791.94
ДНБ (сая төгрөг)	27,876,297.20	32,411,224.10	37,392,629.10	37,329,545.70
НӨАТ-ын чөлөөлөлтийн ДНБ-д эзлэх хувь	2.3%	3.5%	4.1%	4.3%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

НӨАТ-ын чөлөөлөлт 2017-2020 оны хооронд тасралтгүй нэмэгдсэн байхад ДНБ хэрхэн өөрчлөгдсөн болохыг доорх зурагт харуулав. НӨАТ-ын чөлөөлөлт, ДНБ хоёрын графикаас эдгээр хоёр үзүүлэлт нь ерөнхийдөө ижил чиглэлтэй байгаа нь харагдаж байна. Гэхдээ 2020 онд чөлөөлөлт нэмэгдсэн байхад ДНБ буурсан байгаа нь эдийн засгийн өсөлтөнд чөлөөлөлтөөс гадна олон хүчин зүйлс нөлөөлдөг болохыг харуулж байна.

<sup>101</sup> [ijefr4\(7\)226-234.pdf \(arpgweb.com\)](#), [Tax revenue and economic growth in developing country: an autoregressive distribution lags approach \(sciendo.com\)](#), [The relationship between Tax and Economic Growth: A South African perspective \(uct.ac.za\)](#)

Зураг 16. НӨАТ-ын чөлөөлөлтийн төлөгдвөл зохих байсан НӨАТ-д эзлэх хувь, ДНБ болон чөлөөлөлтийн өөрчлөлтийн хандлага



Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

НӨАТ-ын чөлөөлөлтийг нэмэгдүүлэх нь НӨАТ-ын нийт хэмжээг багасгах нөлөө үзүүлнэ. Нэгэнт НӨАТ нь ДНБ-тэй эерэг хамааралтай, ДНБ-ний шалтгаан болж байгаа болохоор НӨАТ-ын хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй юм гэсэн дүгнэлтэд туйлшран автахгүйгээр хэрэглээ зонхилсон эдийн засгийн бүтцийг анзаарч, чөлөөлөлт нь НӨАТ-ын дүнг багасгах нөлөөтэй хэдий ч НӨАТ-ын чөлөөлөлтийн хэмжээ, өөрчлөлтийн онцлогийг харгалзан чөлөөлөлтийн суурийг өөрчлөх, өргөжүүлэх асуудлыг макро эдийн засгийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн харилцан шүтэлцээнд тулгуурлан бие даан судалж, эдийн засгийн үр дагаврыг нь нарийвчлан тооцох нь чухал байна.

#### 4. Монгол Улсын НӨАТ-ын чөлөөлөлтийн салбарын судалгаа

Энэ хэсэгт Монгол Улсын НӨАТ-аас чөлөөлөгдсөн сууриуд, чөлөөлсөн татварын хэмжээг салбарын ДНБ-д харьцуулан нэгтгэж аль салбарт чөлөөлөлт их аль эсвэл бага байгааг гаргаж ирсэн болно.

Дараах хүснэгтэд салбар бүрд харьяалагдах НӨАТ-ын чөлөөлөлтийн хэмжээг харьцангуй хэмжигдэхүүнийг буюу тухайн салбарын ДНБ-д эзлэх НӨАТ-ын хэмжээг харуулав.

Хүснэгт 3. Монгол Улсын НӨАТ-ын чөлөөлөлтийн салбарын ДНБ-д эзлэх хувь

НӨАТ-аас чөлөөлөгдсөн салбар	2017	2018	2019	2020
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.346%	32.604%	5.949%	2.201%
Боловсрол	0.143%	0.278%	0.209%	0.430%
Боловсруулах үйлдвэрлэл	0.256%	1.398%	1.017%	0.841%
Мэргэжлийн шинжлэх ухаан, болон техникийн үйл ажиллагаа	0.055%	0.920%	0.044%	0.162%
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	6.313%	15.555%	17.448%	17.998%
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.837%	2.039%	3.773%	3.378%
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.025%	0.217%	0.010%	0.202%
Уул уурхай, олборлолт	7.821%	9.214%	12.251%	13.638%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.196%	0.202%	0.288%	0.373%

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.512%	0.810%	0.651%	1.340%
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0.913%	1.713%	1.637%	2.021%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.690%	1.129%	0.599%	1.040%
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар, үйлчилгээ			0.00002%	0.00003%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

НӨАТ-ын чөлөөлөлтийн салбарын ДНБ-д эзлэх хувийг сүүлийн 4 жилийн мэдээллийг ашиглан дундаж утгаар нь тооцоолоод ихээс бага уруу нь эрэмбэлбэл доорх хүснэгтэд харуулсан үр дүн гарч байна.

Хүснэгт 4. Монгол Улсын НӨАТ-ын чөлөөлөлтийн салбарын ДНБ-д эзлэх дундаж хувь /ихээс бага уруу эрэмбэлсэн байдлаар/


№	НӨАТ-аас чөлөөлөгдсөн салбар	Эзлэх хувь
1	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	14.33%
2	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	10.78%
3	Уул уурхай, олборлолт	10.73%
4	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2.51%
5	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1.57%
6	Боловсруулах үйлдвэрлэл	0.88%
7	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.86%
8	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.83%
9	Мэргэжлийн шинжлэх ухаан, болон техникийн үйл ажиллагаа	0.30%
10	Боловсрол	0.27%
11	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.26%
12	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.11%
13	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар, үйлчилгээ	0.00003%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Дээрх хүснэгтээс НӨАТ-ын хамгийн өндөр чөлөөлөлттэй эхний 5 салбарт санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээний бусад үйл ажиллагаа, уул уурхай олборлолт, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа гэсэн салбарууд орж байна. Харин хүснэгтээс НӨАТ-ын хамгийн бага чөлөөлөлттэй эхний 5 салбарт мэргэжлийн үйл ажиллагаа болон техникийн үйл ажиллагаа, боловсрол, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын завсар, үйлчилгээ гэсэн салбарууд тус тус багтаж байна.

НӨАТ чөлөөлөлтийн салбарт эзлэх хувийг ихээс бага уруу гэсэн чиглэлтэйгээр эрэмбэлснийг графикаар харуулбал дараах байдалтай байна.

Зураг 17. Монгол Улсын НӨАТ-ын чөлөөлөлтийн салбарын ДНБ-д эзлэх дундаж хувь /ихээс бага уруу эрэмбэлсэн байдлаар/



Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

НӨАТ-ын чөлөөлөлтийн тухайн салбарын ДНБ-д харьцуулсан хэмжээ хамгийн өндөр байгаа салбарын чөлөөлөлтийн нэрлэсэн хэмжээ хамгийн их байх албагүй юм. Учир нь салбар бүрийн ДНБ-ний хэмжээ өөр өөр байгаа. Нэрлэсэн дүнгээрээ хамгийн их чөлөөлөлттэй эхний 5 салбарт уул, уурхай олборлолт, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбар орж байгаа бол нэрлэсэн дүнгээрээ хамгийн бага НӨАТ-ын чөлөөлөлттэй 5 салбарт үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, боловсрол, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, мэргэжлийн шинжлэх ухаан, болон техникийн үйл ажиллагаа, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар, үйлчилгээ гэсэн салбарууд тус тус орж байна. НӨАТ-ын чөлөөлөлтийн нэрлэсэн хэмжээг салбар бүрийн хувьд дараах хүснэгтэд эрэмбэлэн харуулав.

Хүснэгт 5. НӨАТ-ын чөлөөлөлтийн хэмжээ, салбараар ( сая төгрөг)

№	Салбар	Дүн
1	Уул уурхай, олборлолт	843,045.70
2	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	244,231.60
3	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	36,251.50
4	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	32,225.20
5	Боловсруулах үйлдвэрлэл	29,533.90

6	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	17,487.10
7	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	10,531.00
8	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	4,971.10
9	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4,951.00
10	Боловсрол	3,841.50
11	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1,651.50
12	Мэргэжлийн шинжлэх ухаан, болон техникийн үйл ажиллагаа	1,326.60
13	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар, үйлчилгээ	0.9

Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

## 5. Монгол Улсын болон гадаадын зарим улс орнуудын НӨАТ-ын болон НӨАТ-аас чөлөөлөх бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийн судалгаа

НӨАТ нь дэлхийн бусад улс орнуудад түгээмэл байсан үйлдвэрлэгчдийн худалдааны татвар, бөөний худалдааны татвар, худалдан авалтын татвар, үйлдвэрлэлийн төвшний НӨАТ зэрэг шууд бус татварын 4 төрлийг орлон гарч ирсэн.<sup>102</sup> Шууд бус татваруудын хүндрэлтэй, үр ашиггүй байдал нь НӨАТ-ыг дэлхийн даяар түргэн хугацаанд нэвтрэхэд хүргэсэн гэж хэлж болно. Ялангуяа татварын шинэчлэлүүд нь ихэвчлэн бизнес эрхлэлт, бизнесийн шийдвэр гаргахад сөрөг нөлөө үзүүлдэг гүйлгээний татваруудыг өөрчилж, хүчингүй болгоход чиглэгдэж байсан. Ерөнхийдөө нээлттэй эдийн засаг бүхий дэлхийн улс орнууд эцсийн хэрэглэгчдэд буюу хувь хүмүүсийн хэрэглээнд шууд бус татвар ногдуулдаг тогтолцоо уруу тасралтгүй шилжиж байна. НӨАТ-тай холбоотойгоор улс орнуудын төр, засгийн газар НӨАТ-ын чөлөөлөлтийн суурьд багагүй ач холбогдол өгдөг бөгөөд агуулгын хувьд НӨАТ-ын тэглэлт, чөлөөлөлт хоёр нь өөр хоорондоо адилгүй ойлголтууд юм.

*Тэглэлт буюу zero tax:* Энэ нь борлуулалтад ногдуулдаггүй боловч худалдан авалтад төлсөн татвараа, тухайлбал НӨАТ-өө буцааж авч болдог. Ингэснээр харьцангуйгаар үнэ буурах нөлөөллийг ч үзүүлэх боломжтой.


*Чөлөөлөлт буюу tax exempt:* Тэг хувьтай татвартай адил борлуулалтад ногдуулахгүй, гэхдээ худалдан авалтад төлсөн НӨАТ-өө буцааж авахгүй учраас үнэд харьцангуй өсөлтийн нөлөө үзүүлнэ.<sup>103</sup> НӨАТ нь Азийн орнуудад дунджаар 11.6 хувь, Америк, Номхон далайн орнуудад дунджаар 13.34 хувь, Африкийн орнуудад 16 хувьтай байна. Харин Европын улсуудад дунджаар 19.97 хувьтай байгаа нь дэлхийн дундажтай (15.43) харьцуулахад 4 орчим хувиар өндөр байгааг дараах зургаас харж болно.<sup>104</sup>

<sup>102</sup> НӨАТ ба хэрэглээний татварын хувилбаурууд. Р.Кревер. www.iltod.gov.mn

<sup>103</sup> <https://www.taxpolicycenter.org/briefing-book/what-difference-between-zero-rating-and-exempting-good-vat#:~:text=For%20a%20%E2%80%9Czero%2Drated%20good,on%20inputs%20to%20produce%20it.>

<sup>104</sup> [https://home.kpmg/mn/en/home/misc/search.html?sp\\_p=any&q=indirect%20tax&sort=\\_score&page=1&sp\\_c=9](https://home.kpmg/mn/en/home/misc/search.html?sp_p=any&q=indirect%20tax&sort=_score&page=1&sp_c=9)

Зураг 18. НӨАТ-ын хувь хэмжээ бүс нутгаар, 2021 он (хувь)



Хүснэгт 6. Ази, Номхон Далайн бүс нутгийн орнуудын НӨАТ-ын чөлөөлөлтийн хувь хэмжээ<sup>105</sup>

№	Улсын нэр	Татварын төрөл	Стандарт хувь хэмжээ	Бууруулсан хувь хэмжээ, тэг хувь эсвэл чөлөөлөлт
1	Australia	Бараа ажил үйлчилгээний татвар	10%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Goods and services tax (GST)		
2	Cambodia	НӨАТ	10%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Value-added tax (VAT)		
3	China	НӨАТ	13%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Value-added tax (VAT)		
4	Fiji Islands	НӨАТ	9%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Value-added tax (VAT)		
5	India	Service tax	5%-28%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Үндэсний худалдааны татвар		
		Central sales tax (CST)		
6	Indonesia	НӨАТ	10%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Value-added tax (VAT)		
7	Japan	Хэрэглээний татвар	10%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Consumption tax		
8	Korea (South)	НӨАТ	10%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Value-added tax (VAT)		
9	Laos	НӨАТ	10%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Value-added tax (VAT)		
10	Malaysia	Худалдааны болон үйлчилгээний татвар	Sales 10%	“О” хувь хэмжээ болон

<sup>105</sup> <https://assets.kpmg/content/dam/kpmg/xx/pdf/2019/10/2019-aspac-indirect-tax-guide-summary-table.pdf>



		Sales tax and service tax (GST)	Service 6%	НӨАТ-ын чөлөөлөлттэй
11	Myanmar	Хэрэглээний татвар	5%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Consumption tax		
12	New Zealand	Бараа ажил үйлчилгээний татвар	15%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Goods and services tax (GST)		
13	Papua New Guinea	Бараа ажил үйлчилгээний татвар	10%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Goods and services tax (GST)		
14	Philippines	НӨАТ	12%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Value-added tax (VAT)		
15	Singapore	Бараа ажил үйлчилгээний татвар	7%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Goods and services tax (GST)		
16	Sri Lanka	НӨАТ	15%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Value-added tax (VAT)		
17	Taiwan	Бизнесийн үйл ажиллагаа эрхэлсний татвар	5%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Business tax Бизнесийн орлогын татвар Gross Business Receipt Tax [GBRT])	0.1%-25%	
18	Thailand	НӨАТ	7%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Value-added tax (VAT)		
19	Vietnam	НӨАТ	10%	“О” хувь хэмжээ болон НӨАТ-ын чөлөөлөлттэй
		Value-added tax (VAT)		

## 5.1.Европын Холбоо

Европын Холбоо нь одоогоор Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Урьд нь байсан Европын нүүрс гангийн нийгэмлэг, болон Европын Эдийн Засгийн нийгэмлэгийг 1958 онд нийлүүлж, 6 улсын гишүүнчлэлтэйгээр Европын Нийгэмлэг байгуулагджээ. Эхний жилүүдээс гишүүн орнууд нэмэгдсээр, бүх талын үйл ажиллагаа нь өргөжин 1992 оны "Маастрихт"-ын гэрээгээр тохиролцож Европын Холбоо хэмээх одоогийн нэрээ авч 1993 оны 11 дүгээр сарын 1-нээс холбооны үйл ажиллагаа хүчин төгөлдөр болсон байдаг.

### НӨАТ-ын хувь хэмжээ<sup>106</sup> /2021 оны байдлаар/

Европын Холбооны НӨАТ-ын удирдамжийн дагуу (*European VAT Directives*) НӨАТ-ын дүрмийг баталж, НӨАТ-ын стандарт хэмжээг багадаа 15%-иас буулгахгүй байх зарчмыг тогтоожээ. Гишүүн 27 улс (*Их Британийн Нэгдсэн Вант Улсаас бусад*) НӨАТ-ын стандарт хувь хэмжээг тогтооход чөлөөтэй оролцох боломжтой. Европын Холбооны гишүүн орнууд хамгийн бага нь 5 буюу түүнээс дээш байх хоёр хувь хэмжээний аль ихээр нь НӨАТ-ын хувь хэмжээг бууруулахыг зөвшөөрсөн байдаг.

Зарим улс орнуудын НӨАТ-ын хувь хэмжээ хэлбэлзэлтэй байгаа бөгөөд Европын Холбоонд элсэхийн өмнө НӨАТ-ынхаа хувь хэмжээг 30 гаруй хувиар бууруулсан байна. Гишүүн орнууд ихэнх тохиолдолд цахим мэдээлэл, дотоодын түлш, бензин шатахуун, бэлэн хувцас, эмэгтэйчүүдийн эрүүл ахуйн бүтээгдэхүүн зэрэг бараа, үйлчилгээний НӨАТ-ын хувь

<sup>106</sup> <https://www.avalara.com/vatlive/en/vat-rates/european-vat-rates.html>

хэмжээг бууруулах эрхтэй байдаг байна.

### **Европын Холбооны НӨАТ-ын чөлөөлөлт<sup>107</sup>**

Европын Холбооны гишүүн орнуудын НӨАТ-аас чөлөөлөгдсөн байх ёстой бараа, ажил, үйлчилгээнд олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа, эмнэлэг, нийгмийн үйлчилгээ, боловсрол, санхүүгийн болон даатгалын үйлчилгээ, барилгын хангамж зэргийг багтаажээ. Европын Холбооны бараа бүтээгдэхүүний экспортыг НӨАТ-ын татвараас мөн чөлөөлдөг байна.

НӨАТ-аас чөлөөлсөн тохиолдолд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг суутган тооцохыг хориглоно. *Жишээ нь: Нийтийн шуудангийн үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлнө. Шуудангаар илгээмж явуулж буй хүмүүсээс НӨАТ-ыг нэхэмжлэдэггүй боловч шуудангийн газар НӨАТ-ыг төлсөн байдаг. НӨАТ-ын суурьд зөөвөрлөх машин, шуудангийн хайрцаг зэрэг худалдан авсан бүх зүйлс багтана.*

### **НӨАТ-ын тэглэлт болон чөлөөлөлтийн байдал**

Зарим бараа үйлчилгээний хувьд борлуулагч нь худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг буцааж авах тохиолдол байдаг. Тухайлбал, Европоос гуравдагч орон уруу бараа экспортлоход болон дотоодын үйлдвэрлэгч өөр улс орон уруу бүтээгдэхүүн экспортлоход энэ нь хүчинтэй. Эцсийн хэрэглэгч бүх татварыг төлдөг гэдгээрээ тэг хувь хэмжээтэй “zero tax” нь чөлөөлөлт буюу exemption бүхий татвартай адил. Гэхдээ худалдан авалтад төлсөн НӨАТ-аа буцааж авч болдог Tax exempt татварыг жинхэнэ zero rate татвараас ялгаж ойлгох нь чухал.

Тодорхой бараа үйлчилгээг Европын холбоо zero tax-тай болгож болдог. Энэ нь эцсийн бүтээгдэхүүн дээр НӨАТ ногдохгүй, харин худалдан авалтад төлсөн НӨАТ нь буцаан суутгагдана гэсэн үг юм. НӨАТ-ын чөлөөлөлтөөс гадна үүнтэй ижил төстэй өөр ангилал бий. Европын Холбооны аль нэг улсын хэрэглэгчдэд НӨАТ-тай борлуулалт хийх тусгай схемүүд байдаг. Тухайлбал, Европын Холбооны гишүүн орнуудын “Шинэ тээврийн хэрэгслийн борлуулалт” (Sale of new means of transport)-аас НӨАТ-ыг чөлөөлдөг. НӨАТ-ыг Европын Холбооны Улсад төлөх хариуцлагыг хэрэглэгч өөрөө хариуцна.

*Европын Холбоо НӨАТ-ын чөлөөлөлтийг 3 хэсэгт хуваасан байна.*

1. Суутгалгүй тооцсон чөлөөлөлт- *Exemptions without the right to deduct* (Нийтийн ашиг сонирхолд нийцсэн бараа, үйлчилгээ)
2. Суутгал тооцох эрхтэй чөлөөлөлт- *Exemptions with the right to deduct* (Экспорт, ЕХ-ны дотоодын үйлдвэрлэгчдийн экспорт)
3. Бусад чөлөөлөлт- *Other exemptions* (Импорт, ЕХ-ны импортын худалдан авалт)

## **5.2.Бүгд Найрамдах Солонгос Улс**

БНСУ-ын НӨАТ-ын хувь хэмжээ 10 хувьтай байна.

Тус улс нь дэлхийн улс орнууд дотроо татвар төлөлтөөр дээгүүрт бичигддэг. Доорх графикаас БНСУ-ын татварын орлогын хамгийн их хувиудыг НӨАТ, ХХОАТ, ААНОАТ эзэлж байгааг харж болно.<sup>108</sup>

<sup>107</sup> [https://ec.europa.eu/taxation\\_customs/business/vat/eu-vat-rules-topic/exemptions\\_en](https://ec.europa.eu/taxation_customs/business/vat/eu-vat-rules-topic/exemptions_en)


<sup>108</sup> [http://cdn.mta.mn/2muG1RE5Qkqd\\_R59a8zy-](http://cdn.mta.mn/2muG1RE5Qkqd_R59a8zy-)

[Q/mta.mn/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB%D1%8B%D0%BD%20%D1%81%D0%B0%D0%BD/%D0%A1%](http://cdn.mta.mn/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB%D1%8B%D0%BD%20%D1%81%D0%B0%D0%BD/%D0%A1%)

## БНСУ-ын татварын орлогын бүтэц<sup>109</sup>

Татварын орлогын бүтцээс НӨАТ тухайн улсын татварын орлогод чухал үүрэг гүйцэтгэдэг болох нь харагдаж байна.


Зураг 19. БНСУ-ын татварын орлогын бүтэц



Солонгос Улс бордоо, ургамал хамгааллын бодис, тэжээл, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, хүлэмжийн тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлдөг. Мөн хөдөө аж ахуйд ашиглах шатахууныг бүх төрлийн татвараас чөлөөлдөг байна. БНСУ 1940-өөд оны төгсгөл 1950-иад оны эхнээс хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулж нэгдмэл төлөвлөлт, бодлогыг хэрэгжүүлсэн нь эдийн засаг, нийгмийн хөгжилд нь түлхэц болсон. Газар тариалангийн салбарыг хөгжүүлэхдээ төрийн болон төрийн оролцоотой банкаар дамжуулан газар тариалан эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, үнэ тарифын зохицуулалт хийх, татвар, даатгалын тогтолцоог уян хатан болгох зэрэг бодлого, хууль эрх зүйн зохицуулалтыг амжилттай хэрэгжүүлсэн юм.

Хүснэгт 7. БНСУ-ын нэг хүн ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (2015-2020)<sup>110</sup>

Зураг 20. ДНБ-ний өсөлт



Хүснэгт 8. Нэг хүнд ногдох ДНБ

	Он	ДНБ-ний өсөлт (%)	Нэг хүнд ногдох ДНБ (мянган ам. доллар)
Korea	2015	2.81%	28.7
	2016	2.95%	29.2
	2017	3.16%	31.6
	2018	2.91%	33.4
	2019	2.04%	31.8
	2020	-1.88%	30.6
	2021	2.8%	-

D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD%D1%8B%20%D0%B0%D0%B6%D0%B8%D0%BB//Tatvariin%20bolovsrol%20olgo%20ni\_Ishbaljirmaa,Sarangerel.pdf

<sup>109</sup> <http://kostat.go.kr/portal/korea/index.action> БНСУ-ын статистикийн мэдээлэл

<sup>110</sup> <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.KD.ZG?end=2019&locations=KR&start=2015&view=chart>  
<https://data.worldbank.org/indicator/NY.GDP.PCAP.CD?end=2019&locations=KR&start=2015>

**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль<sup>111</sup>**

Тус улсын НӨАТ-ын тухай хууль нь 9 бүлэг, 76 зүйлтэй. НӨАТ-ын чөлөөлөлттэй холбоотой харилцааг зохицуулах заалтууд, чөлөөлөлтийн сууриудыг 2 дугаар бүлгийн 26, 27-р зүйлүүдэд зааж өгсөн байдаг. (Дэлгэрэнгүйг холбогдох эх сурвалжаас үзэж танилцана уу.)

**5.3.Бүгд Найрамдах Латви Улс**

Латви улсын НӨАТ-ын хувь хэмжээг 2021 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар харуулбал дараах байдалтай байна:<sup>112</sup>

Хүснэгт 9. НӨАТ-ын хувь хэмжээ

д/д	Бараа, ажил үйлчилгээний тодорхойлолт	НӨАТ хувь хэмжээ
1.	Бараа, ажил үйлчилгээ, импортын бараа, Латви Улсын оршин суугч бус этгээдэд үзүүлж буй эмнэлгийн үйлчилгээ	21%
2.	Жагсаалтад орсон эм, эмнэлгийн хэрэгсэл, нярай хүүхдийн төрөлжсөн хоол, дотоодын нийтийн тээврийн үйлчилгээ, ном /цахим мэдээлэл орохгүй/, сонин сэтгүүл, хөнгөлөлттэй тогтмол хэвлэл, уран зохиолын анхны хэвлэл, зочид буудал, төвлөрсөн халаалтын төлбөр, байрны үйлчилгээ	12%
3.	Бүх төрлийн угаасан, цэвэрлэсэн, зүссэн, савласан жимс, хүнсний ногоонууд /хөлдөөсөн, давсалсан, хатаасан жимс ороогүй/ Энэ 5%-ийг 2018.01.01-2023.12.31-ний өдөр хүртэл хүчинтэй байхаар тусгасан байна.	5%
4.	Гишүүн орнуудад НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн иргэд өөр гишүүн орнуудаас бүтээгдэхүүн худалдаж авах үеийн НӨАТ-ын чөлөөлөлт. (Нийлүүлэгч нь худалдан авалтад төлсөн НӨАТ-аа буцааж авах нөхцөлтэй)	0%
5	Экспортын болон дотоодод чөлөөтэй нийлүүлэгдэхгүй бараа, үйлчилгээний борлуулалт, дипломат ажилтнуудад зориулсан бараа, ажил үйлчилгээ, гадаад тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бараа, ажил, үйлчилгээ	0%

Мөн Боловсрол, санхүү, эмнэлгийн болон даатгалын үйлчилгээ, асаргааны төв, ашигласан үл хөдлөх хөрөнгө, борлуулалт, барилгын үйлчилгээ зэрэг хэд хэдэн үйлчилгээг татвараас чөлөөлдөг байна.

ЭЗХАХБ-ын дундажтай харьцуулсан Латви улсын татварын орлогын бүтцийг 2018 оны байдлаар доорх хүснэгтэд үзүүлэв.<sup>113</sup>

Хүснэгт 10. Татварын орлогын бүтэц

д/д	Орлогын татварын төрөл	Латви Улс /хувиар/	ЭЗХАХБ /хувиар/
1	Хувь хүний орлогын албан татвар	19	24
2	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	3	10
3	Нийгмийн даатгалын шимтгэл	29	26
4	Цалингийн татвар	0	1
5	Үл хөдлөхийн татвар	3	6
6	НӨАТ /бараа, ажил, үйлчилгээний татвар	27	20
7	Бараа, бүтээгдэхүүний татвар /VAT/GST/	18	13

<sup>111</sup>

<https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=value+added+tax&x=24&y=31#iBgcolor10>

<sup>112</sup> <https://taxsummaries.pwc.com/latvia/corporate/other-taxes>

<sup>113</sup> Revenue Statistics OECD


8	Бусад	1	1
---	-------	---	---

Латви улсын ДНБ-д үйлчилгээний салбар, дэд бүтэц, аж үйлдвэрийн салбар нэлээд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ДНБ-нийх нь 90 гаруй хувийг эзэлдэг. Байгалийн онцлогт түшиглэж хөдөө аж ахуй, ойн аж ахуйн салбараа түлхүү хөгжүүлсэн улс юм.<sup>114</sup>

ЭЗХАХБ-ын дундажтай харьцуулбал Латви Улсын татварын орлого дараах бүтэцтэй. Үүнд:

- НДШ, НӨАТ-ын бараа, үйлчилгээний татварын орлого ихэнхийг бүрдүүлдэг /НӨАТ / БҮТ багтаагүй/;
- Хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хөрөнгийн татварын орлого бага хувь эзэлдэг;
- Ажил олгогчоос төлсөн НДШ-ийн орлого байхгүй.

Зураг 21. Татварын орлогын бүтцийн харьцуулалт<sup>115</sup>



### Латви улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/<sup>116</sup>

Латви улсын 2020 оны ДНБ-ийг өнгөрсөн онтой харьцуулахад 3.6%-иар буурсан байна. Дэлхийн 196 орноос ДНБ-ий жагсаалтад Латви улс 100 дугаарт оржээ. Латви улсын ДНБ-ний жилийн дундаж 2018 онд 34,329 сая ам.доллар байсан бөгөөд 2019 онтой харьцуулахад энэ нь 208 сая ам.доллар-аар бага байгаа юм. 2020 онд 25,722 сая ам.доллар болж өмнөх жилээс 8,399 сая доллар-аар мөн буурчээ.

Хүснэгт 11. Латви улсын ДНБ

Зураг 22. Жилийн ДНБ

Он	Жилийн ДНБ / сая \$/
2015	27,104
2016	27,745
2017	30,262
2018	34,329
2019	34,121

<sup>114</sup> [Latvia | History - Geography | Britannica](#)

<sup>115</sup> Revenue Statistics OECD

<sup>116</sup> <https://countryeconomy.com/gdp/latvia>

2020	25,722
------	--------




Латви улсын нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 2018 онд 17,747\$ байсан бол 2019 онд 17,772 \$ болж 25 ам.доллар-аар нэмэгдсэн байна. Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээгээр эрэмбэлж үзэхэд дэлхийн 196 орноос 51 дүгээр байранд Латви улс оржээ. Латви улсын нэг хүнд ногдох ДНБ-ний эзлэх хувийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 12. Нэг хүнд ногдох ДНБ

Он	Нэг хүнд ногдох ДНБ / ам.доллар/
2015	13,647
2016	14,091
2017	15,518
2018	17,747
2019	17,772

Зураг 23. Нэг хүнд ногдох ДНБ



### Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль<sup>117</sup>

Энэ хууль нь 2012 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Сеймээр батлагдаж, 2013 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн байна. 2013-2020 онуудад хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулсан байна. Нийт 8 бүлэг, 146 зүйл ангитай. НӨАТ-ын чөлөөлөлтийг хуулийн 7 дугаар бүлгийн 52-54 дүгээр зүйлд тусгажээ.

Хуулийн 52 дугаар зүйлд: Шуудангийн болон эмнэлгийн үйлчилгээ, шинжээчийн дүгнэлт /хөдөлмөрийн чадвараа алдсан, тэтгэвэр тогтоолгох гэх мэт/ клиник оношилгоо, лаборатор, хэвтэн эмчүүлэгчидтэй холбоотой бүх зардал, хүний эд эрхтэн, цус, шүдний эмнэлгийн үйлчилгээ, нийгмийн халамж, үйлчилгээтэй холбоотой бүртгэл, шинэчлэл, сайн үйлсийн аян, хүүхэд, залуучуудын бүх шатны боловсрол, сурагчидтай холбоотой зардлууд, ажилгүй иргэдийн сургалтын үйл ажиллагаа, соёлын бүх арга хэмжээ, үзвэр үйлчилгээ, банк, даатгал, хөрөнгийн зуучлал, хөрөнгө оруулалт, цахим сүлжээ, үл хөдлөх, орон сууц түрээслэх зэрэг бараа, үйлчилгээнүүдэд татвар ногдуулдаггүй болохыг заажээ.

Засгийн газраас тогтоосон журмын дагуу дараах бараа, ажил, үйлчилгээг татвараас чөлөөлдөг. Үүнд: Бүх шатны боловсролын байгууллагад үзүүлэх үйлчилгээ, соёлын үйлчилгээ, санхүүгийн гүйлгээ, мөрийтэй тоглоом, сугалаа, үл хөдлөх хөрөнгө, түрээсийн орон сууц болон эмнэлгийн үйлчилгээнүүдийг хамруулжээ.

<sup>117</sup> <https://likumi.lv/ta/en/en/id/253451>



Энэ хуулийн 52<sup>1</sup> дугаар зүйлд: Бие даасан бүлгийн гишүүд анх бүлэг байгуулагдсан тухайгаа төсвийн орлогын газарт бичгээр мэдэгдэж, гэрээ байгуулан татвараас чөлөөлүүлнэ.

53 дугаар зүйлд: Гаднаас импортоор орж ирж буй бараа үйлчилгээнд татвар ногдуулахгүй байхыг заажээ. Үүнд: Байгалийн хийн систем, сүлжээ, ачааны хөлөг онгоц, хий, байгалийн хий, алсын шугам хоолойн хий, цахилгаан дулааны энерги, хөргөх сүлжээ, гаалийн болон худалдааны бараа, ЕХ-ны Атомын энерги, Төв банк, Хөрөнгө оруулалтын банкны протокол, гэрээнүүд, ОУ-ын конвенцийн гэрээ, ОУ-ын байгууллагууд, НАТО-гийн гэрээ хэлэлцээр, Зэвсэгт хүчний байгууллагын албан хаагчид, дипломат болон консулын төлөөлөгчийн газрууд, загас агнуурын эрхлэх аж ахуй, боомтын үйлчилгээ, буцаан импортлосон экспортын бараа, аялагчийн хувийн тээш, ачаа зэрэг бүтээгдэхүүн үйлчилгээг оруулсан байна.

Мөн хуулийн 54 дүгээр зүйлд: ЕХ-ны нутаг дэвсгэрт бараа худалдан авахад татвар ногдуулахгүй гэжээ. Үүнд дээрх хуулийн 53 дугаар зүйлийн 3,4,5,9 дэх хэсэгт зааснаар 22 еврогоос хэтрэхгүй бараа импортлох бол татвараас чөлөөлнө. Зарим нийгмийн гишүүдийг гаалийн татвараас чөлөөлөх, хууль ёсны татвар төлөгч этгээд Улсын төсөвт татвар төлөх үүрэгтэйг тус тус заажээ. (НӨАТ-ын чөлөөлөлтийн дэлгэрэнгүйг тухай хуулийн заалтаас үзнэ үү.)

#### 5.4. Тайвань

Тайванийн<sup>118</sup> НӨАТ-ын хувь хэмжээ 5 хувьтай байна. Бараа ажил үйлчилгээний үнэ тарифаар дамжуулан авч буй шууд бус татварыг хоёр төрлийн аргаар ногдуулдаг.

Тайванийн татварын орлогын бүтцийг дараах хүснэгтэд харуулав.<sup>119</sup>


Хүснэгт 13. Тайванийн татварын орлогын бүтэц

Он	2015	2016	2017	2018	2019
Нийт	2 134 857	2 224 075	2 251 246	2 386 945	2 470 519
Гаалийн татвар	110 978	114 971	114 957	120 057	123 042
Орлогын татвар	936 731	1 006 360	986 412	1 077 079	1 148 814
Үл хөдлөх хөрөнгө, бэлэглэлийн төлбөр	32 736	47 515	51 085	31 825	34 926
Барааны татвар	183 131	181 907	178 467	180 111	176 878
Үнэт цаасны гүйлгээний татвар	82 033	70 855	89 967	101 171	91 205
Фьючерс гүйлгээний татвар	3 783	3 706	4 190	6 100	4 695
Архи тамхины татвар	44 160	45 627	50 235	69 603	68 649
Бизнесийн татвар	360 899	378 354	384 978	415 409	420 908
Санхүүгийн үйл ажиллагааны татвар	25 137	23 746	23 124	24 474	26 159

<sup>118</sup> <https://www.pwc.com/sg/en/tax/assets/vat-gst-guide-2019.pdf>

<sup>119</sup> <https://eng.stat.gov.tw/ct.asp?xItem=41884&ctNode=6354&mp=5>, <https://www.ntbt.gov.tw/English>

Зураг 24. Тайванийн татварын орлогын бүтэц



Тайванийн эдийн засагт аж үйлдвэрийн салбар давамгайлдаг. Уул уурхай, байгалийн нөөц баялгийн ашиглалтын салбар эдийн засагт нь харьцангуй бага үүрэгтэй байдаг онцлогтой.<sup>120</sup> Аж үйлдвэрийн салбараас гадна хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур зэрэг салбаруудын үйлдвэрлэл түлхүү хөгжсөн. Мэдээллийн технологи, үйлчилгээний салбар эдийн засагт нь харьцангуй өндөр хувь нэмэр оруулдаг.

#### Тайванийн дотоодын нийт бүтээгдэхүүн<sup>121</sup>

Тайванийн 2020 оны жилийн эцсийн байдлаар нэг хүнд ногдох ДНБ 26,910.2 ам.доллар /GDP per capita US\$/ байна.

Хүснэгт 14. Тайванийн нэг хүнд ногдох ДНБ

Он	Нэг хүнд ногдох ДНБ/ам.доллар/
2015	22,941
2016	23,161
2017	25,154
2018	25,750
2019	25,893
2020	26,910

UIH.MN  
СҮДАЛГААНЫ САН

#### Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль<sup>122</sup>

Бизнесийн үйл ажиллагаа эрхэлсний татвар /Business tax/ нь 1931.06.13-ны өдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү хууль нь нийт 7 бүлэг, 56 зүйлтэй. Хуулийн 2 дугаар бүлгийн 8-р зүйлд дараах бараа үйлчилгээ нь татвараас чөлөөлөгдөнө гэж заажээ.

<sup>120</sup> [Taiwan - Economy | Britannica](#)

<sup>121</sup> <https://eng.stat.gov.tw/ct.asp?xItem=41884&ctNode=6354&mp=5>

<sup>122</sup> <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=G0340080>

- Бизнесийн орлогын татвар/Gross Business Receipt Tax/: Санхүүгийн байгууллагууд, хоол хүнс, ундааны тусгай бизнес эрхлэгчид, жижиг бизнес эрхлэгчдэд зориулагдсан. Бизнесийн онцлогоос хамааран хоол хүнс, ундаа үйлдвэрлэгчдийн татварын хувь 15%-25%, жижиг бизнес эрхлэгчдэд 0.1%-1% хувийн татвар ногдуулна.
- Бизнесийн үйл ажиллагаа эрхэлсний татвар/Business tax/: үлдсэн татвар төлөгчдийн жишиг хувь хэмжээгээр ногдуулдаг.

Өмнө нь авч үзсэн Монгол Улсын болон бусад улс орнуудын үзүүлэлтүүдийг нэгтгэж дараах хүснэгтэд харуулъя.

Хүснэгт 15. Татвар, эдийн засгийн үзүүлэлтүүдийн харьцуулалт

Үзүүлэлт		Монгол	Олон улсад		
			БНСУ	Тайвань	Латви
НӨАТ-ын хувь хэмжээ		10	10	5	[5; 21]
Татварын орлогын бүтэц	<b>НӨАТ</b>	<b>25.6</b>	<b>29</b>	<b>20</b>	<b>27</b>
	ХХОАТ	10.2	24	54	19
	ААНОАТ	15.4	24		3
	ОАТ	9.4	5	3	12.6
	Бусад	29.4	18	18	38.4
Эдийн засгийн өсөлт, сүүлийн 5 жилийн дундаж		4.26	2.77	2.63	3.14

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хүснэгтэд үзүүлсэн нэгтгэлээс улс орнуудын татварын орлогод эзлэх НӨАТ-ын хувийн жин ерөнхийдөө ойролцоо буюу 20-27 хувийн хооронд байна. Тайванийн хувьд НӨАТ-ын хувь харьцангуй бага байгаа нь НӨАТ-ын нийт татварын орлогод эзлэх хувийг нь бага болгоход нөлөөлсөн гэж дүгнэж болохоор байна. ДНБ-ний өсөлт нь хол зөрөөгүй буюу 2.63-4.26 хувийн хооронд байгаа нь улс орнууд өөр өөрсдийнхөө эдийн засгийн онцлогт тохирсон хөгжлийн, төсөв, татварын бодлого хэрэгжүүлдэгтэй холбоотой.

### НӨАТ-ын чөлөөлөлтийн суурийн харьцуулсан судалгаа

Энэ хэсэгт сонгож авсан улс орнуудын НӨАТ-ын хуульд чөлөөлөхөөр тусгасан, манай улсын НӨАТ-ын тухай хуульд тусгагдаагүй НӨАТ-ын чөлөөлөлтийн суурийг харьцуулан тодорхойлсон болно. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын НӨАТ-ын хуульд заасан НӨАТ-ын чөлөөлөлтийн сууриас илүү НӨАТ-ын өөр ямар суурь улс орнуудад үйлчилж байгаа болохыг харуулахыг зорив.

Хүснэгт 16. НӨАТ-ын чөлөөлөлтийн суурийн ялгаа

№	НӨАТ-аас чөлөөлөгдсөн салбар	Чөлөөлөлтийн суурийн нэмэгдэл		
		БНСУ	Тайвань	Латви
1	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа		Деривативын буюу үүсмэл санхүүгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлсний орлого	Төлбөрийн хэрэгслийн үйлчилгээ, үүсмэл үнэт цаасны хөрөнгө оруулалтын үйлчилгээ, кастодион банкны үйлчилгээ, хөрөнгө оруулалтын сангуудын менежмент, хөрөнгө оруулалтын сангууд, зуучлагч байгууллагын төлбөрийн

				хэрэгсэл болон мөнгөний зах зээлийн хэрэгслээр хийсэн арилжаа, зээлийн батлан даалтын үйлчилгээ
2	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Нийтийн холбоо, шуудан, сугалааны тасалбар	Хоршоодын гишүүддээ худалдсан бараа үйлчилгээ, Холбоодын гишүүддээ худалдсан бараа, холбоодод үзүүлсэн төрийн дэмжлэг, хандивын тоглолтын цэвэр орлого, хорих ангид гараар урласан бараа	Шуудангийн үйлчилгээ, цахим хэлбэрээр явуулсан мөрийтэй тоглоом, хонжворт сугалааны үйлчилгээ
3	Уул уурхай, олборлолт			
4	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Өдөр өнжүүлэх болон халамжийн төвийн үйл ажиллагаа	Аж ахуйн нэгжүүдэд төрөөс үзүүлсэн тусламж дэмжлэг, Засгийн газрын даалгасан шуудан холбооны үйлчилгээ, батлан хамгаалахын зэр зэвсэг	Нийгмийн халамжид нийлүүлэгч болохоор тусгагдсан хүмүүсийн нийтийн үйлчилгээ, олон нийтийн эрх ашгийг хангах байгууллагаас хүүхэд залуучуудыг хамгаалах зорилгоор нийлүүлсэн ажил, үйлчилгээ
5	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэгсэл		
6	Боловсруулах үйлдвэрлэл	Шахмал түлш, шугамын ус		
7	Цахилгаан, хий, уур, агааржуулалт			Импортын хий, дулаан, цахилгаан, хөргөх сүлжээний төхөөрөмж
8	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Боловсруулаагүй хүнсний бүтээгдэхүүн, хүнсний бус фермийн аж ахуйн бараа, газар	Усалгааны зориулалтаар нийлүүлсэн ус, загас агнуур, тариаланчид, мал аж ахуй, ургацын дайвар бүтээгдэхүүн, загасчны өөрийнх нь барьсан загас, цагаан, улаан буудай тээрэмдэх, худалдах үйлчилгээ, хөдөө аж ахуйн техник, хэрэгсэлд ашиглах цахилгаан, загас агнуурын хэрэгсэл	
9	Мэргэжлийн шинжлэх ухаан, болон техникийн үйл ажиллагаа	Шинжлэх ухааны танхим, музей, галерей, ботаникийн цэцэрлэг		Номын сан, урлагийн болон хандивын тоглолтууд, зохиогчийн эрхийг ашигласны төлбөр
10	Боловсрол	Ном, номын сангийн үйлчилгээ, сонин сэтгүүл, урлагийн бүтээл,	Сурах бичиг, онцгой мэргэжлийн эрдэм шинжилгээний бүтээл, мэргэжлийн сургуулийн дотор	Хүүхэд харах үйлчилгээ, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, бүх шатны боловсролын үйлчилгээ, сурагчдыг

		зохиогчийн өмч	зарагдах бараа, үйлчилгээ, сэтгүүл, сурталчилгаа, телевизийн нэвтрүүлэг	тээвэрлэх үйлчилгээ, суралцагчдыг мэргэжлийн дадлагаар хангах үйлчилгээ,
11	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Орон сууц, орон сууцны газрын түрээс	Хуульд заасан зарим аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгийн борлуулалт, Үл хөдлөх хөрөнгө, газрын худалдаа,	Үл хөдлөх хөрөнгийн борлуулалт, оршин суухаас бусад зорилгоорх түрээсийн үйлчилгээ,
12	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа			
13	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар, үйлчилгээ		Төрөөс үзүүлсэн монополь үйлдвэрүүдийн бараа, үйлчилгээ, ТҮЦ, гудамжинд наймаа эрхлэгсдийн бараа, үйлчилгээ, Засгийн газрын тендерээр худалддаг үлдэгдэл болон хуучирсан бараа	Гаалийн татвар ногдуулахгүй импортын бараа, үйлчилгээ, импортлогчийн оруулж ирэх эрүүл мэндийн бүтээгдэхүүн, гаалийн байгууллагад мэдүүлсэн хувийн ачаа тээш, татвар төлөгчөөр бүртгэгдсэн иргэний худалдан авалтаас нь татвар аваагүй хувийн хэрэгцээний болон тансаг зэрэглэлийн бараа

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Ямар НӨАТ-ын суурийг Монгол Улсад нэвтрүүлэх боломжтой болохыг чөлөөлөлтийн нэр төрлийн харьцуулсан судалгаа, манай улсын эдийн засаг, салбарын онцлог, НӨАТ-ын чөлөөлөлтийн салбарт эзлэх хувийн жингийн динамик судалгаа зэргийг ашиглан дараах байдлаар тодорхойлох боломжтой гэж үзлээ.

Хүснэгт 17. Хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн НӨАТ-ын чөлөөлөлтийн суурь

№	НӨАТ-аас чөлөөлөгдсөн салбар	Эзлэх хувь	Чөлөөлөлт	+, ++ <sup>123</sup>
1	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	14.33%	Деривативын бүтээгдэхүүн	+
2	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	10.78%	Холбоодын гишүүддээ худалдсан бараа, холбоодод үзүүлсэн төрийн дэмжлэг, хандивын тоглолтын цэвэр орлого,	+
3	Уул уурхай, олборлолт	10.73%		
4	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2.51%	Олон нийтийн эрх ашгийг хангах байгууллагаас хүүхэд залуучуудыг хамгаалах зорилгоор нийлүүлсэн ажил, үйлчилгээ	+
5	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1.57%	Импортлогчийн оруулж ирэх эрүүл мэндийн бүтээгдэхүүн	+
6	Боловсруулах үйлдвэрлэл	0.88%	Шахмал түлш, шугамын ус	+
7	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.86%	Импортын хий, дулаан, цахилгаан, хөргөх сүлжээний төхөөрөмж	+
8	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.83%	Усалгааны зориулалтаар нийлүүлсэн ус, хөдөө аж ахуйн техник, хэрэгсэлд ашиглах цахилгаан	++

<sup>123</sup> + Хэрэгжүүлэх боломжтой, ++ хэрэгжүүлэх боломж өндөртэй

9	Мэргэжлийн шинжлэх ухаан, болон техникийн үйл ажиллагаа	0.30%	Зохиогчийн эрхийг ашигласны төлбөр	++
10	Боловсрол	0.27%	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, бүх шатны боловсролын үйлчилгээ	++
11	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.26%	Орон сууц, орон сууцны газрын түрээс, үл хөдлөх хөрөнгө, газар худалдаа	++
12	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.11%		
13	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар, үйлчилгээ	0.00003%	ТҮЦ, гудамжинд наймаа эрхлэгсдийн бараа, үйлчилгээ	+

++ Тэмдэглэгээтэй салбарууд нь чөлөөлөлтийг хэрэгжүүлэх боломж өндөртэй салбарууд байх боломжтой. Учир нь эдгээр салбарууд нь нэрлэсэн дүнгээрээ<sup>124</sup> болон НӨАТ-ын чөлөөлөлтийн салбарын ДНБ-д эзлэх хувь нь харьцангуй бага байгаа онцлогтой байгаа юм.

## ХАВСРАЛТ

### Монгол Улсын НӨАТ-ын тухай хуулиас “Нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт”

Гаалийн байгууллагаас баталсан, зорчигчдод татваргүй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн хэмжээ бүхий биедээ авч яваа хувийн хэрэглээний бараа;

Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн салбарын хэрэгцээнд зориулан импортоор оруулсан бараа;

гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа;


- 1) Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэглээнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, автотээврийн хэрэгсэл;
- 2) Зэвсэгт хүчин, цагдаа, улсын аюулгүй байдлыг хангах, шүүхийн шийдвэр биелүүлэх, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын болон авилгатай тэмцэх газрын хэрэгцээнд зориулан импортоор оруулж байгаа зэвсэг, тусгай техник хэрэгсэл;
- 3) Агаарын зорчигч тээврийн хөлөг, түүний сэлбэг;
- 4) Орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа байр буюу түүний зарим хэсгийг борлуулсны орлого;
- 5) Эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэн;
- 6) Хийн түлш, түүний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин механизм, техник хэрэгсэл, тоноглол;
- 7) Гадаад улсад захиалгаар хийлгэсэн Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт;
- 8) Борлуулсан алт;
- 9) Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршилтын бүтээгдэхүүн;
- 10) Энэ хуулийн 12.1.7-д зааснаас бусад экспортод гаргасан *ашигт малтмалын* бүтээгдэхүүн;
- 11) Банк, банк бус санхүүгийн байгууллага болон бусад хуулийн этгээдээс банк, тусгай зориулалтын компани, орон сууцны санхүүжилтийн компанид хөрөнгөөр

<sup>124</sup> Хүснэгт 4-өөс харах боломжтой.



- баталгаажсан үнэт цаас гаргах зориулалтаар шилжүүлсэн зээл, санхүүгийн түрээсийн гэрээнээс үүсэх аливаа шаардах эрх;
- 12) Газар тариалан эрхлэгчийн дотооддоо тарьж борлуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, суулгац, жимс жимсгэнэ, үйлдвэрлэсэн гурил;
  - 13) Монгол улсын нутаг дэвсгэрт үйлдвэрийн аргаар төхөөрч бэлтгэн дотооддоо борлуулсан тураг болон шулж ангилсан мах, боловсруулаагүй дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүн;
  - 14) Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоодын түүхий эдээр боловсруулан дотооддоо борлуулсан хүнсний сүү, сүүн бүтээгдэхүүн;
  - 15) Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, үйлдвэрлэн борлуулсан жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл;
  - 16) Инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодис;
  - 17) Импортоор оруулж байгаа бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, банз, модон бэлдэц, хагас боловсруулсан модон материал;
  - 18) Экспортод гаргасан түүхий болон угаасан, самнасан ноолуур, арьс шир
  - 19) Соёлын өвийг судалж шинжлэх, сэргээн засварлахад ашиглах материал, техник, тоног төхөөрөмж, бодис, багаж хэрэгсэл;
  - 20) Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын болон тэдгээрт ажиллагсдын хувийн хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээг тухайн улсад албан татвараас чөлөөлдөг бол тэр улсаас монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын болон тэдгээрт ажиллагсдын хувийн хэрэгцээнд зориулж монгол улсын нутаг дэвсгэрт худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ;
  - 21) Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, зөөврийн компьютерийн хувьд 30 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй, ижил төрлийн хоёроос илүүгүй бараа бүхий хувь хүний нэр дээр илгээсэн улс хоорондын шуудангийн илгээмж;
  - 22) Гэрээлэгч болон туслан гүйцэтгэгч нь газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан хайгуулын нийт хугацаанд болон ашиглалтын эхний таван жилд импортолсон тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглол, түүхий эд, материал, химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгсэл;
  - 23) Газрын тос болон уламжлалт бус газрын тостой холбогдсон тайлан материал, дээж болон газрын тос;
  - 24) Чөлөөт бүсэд зорчигчийн худалдаж авсан гурван сая төгрөг хүртэл үнийн дүнтэй бараа;
  - 25) Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг;
  - 26) Тусгай зориулалтын бус автомашин худалдан авахад энэ хуулийн 13.1.4 дэх заалт хамаарахгүй.
  - 27) Худалдах зориулалтаар шинээр барьсан орон сууцны зориулалттай байр, үүнд энэ хуулийн 13.1.7 дахь заалт хамаарахгүй.
  - 28) Дараах үйлчилгээг албан татвараас чөлөөлнө:
  - 29) Валют солих үйлчилгээ;

- 30) Мөнгө хүлээн авах, шилжүүлэх, баталгаа, төлбөрийн нэхэмжлэл гаргах, вексель, хадгаламжийн данстай холбогдсон банкны үйлчилгээ;
- 31) Даатгал, даатгалын зуучлал, давхар даатгал, эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ;
- 32) Үнэт цаас, хувьцаа гаргах, шилжүүлэх, борлуулах, хүлээн авах, тэдгээрт баталгаа гаргах үйлчилгээ;
- 33) Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.6-д заасан санхүүгийн хэрэгслийг анхдагч, хоёрдогч зах зээл болон биржийн бус зах зээлд бүртгүүлэх, гаргах, арилжих, шилжүүлэх, борлуулах, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаа болон тэдгээрт баталгаа гаргах үйлчилгээ;
- 34) Зээл олгох үйлчилгээ;
- 35) Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг байршуулсны хүүг олгох, шилжүүлэх үйлчилгээ;
- 36) Банкны болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны зээлийн хүү, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.4-т заасан хүү, 10.1.3-т заасан хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл, санхүүгийн түрээсийн хүү, ногдол ашиг, зээлийн баталгааны хураамж, даатгалын гэрээний хураамж төлөх үйлчилгээ;
- 37) Орон сууцны зориулалтаар баригдсан зориулалтын дагуу ашиглагдаж байгаа байрыг болон түүний тодорхой хэсгийг хөлслүүлэх үйлчилгээ;
- 38) Боловсролын болон мэргэжлийн сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээдийн эрхлэн гүйцэтгэж байгаа дүрэмд нь заасан боловсрол, мэргэжил олгох үйлчилгээ;
- 39) Эрүүл мэндийн үйлчилгээ;
- 40) Шашны байгууллагын үйлчилгээ;
- 41) Төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ. Үүнд засгийн газар, түүний агентлагууд, төсөвт байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ хамаарна;
- 42) Автотээврийн тухай хуулийн 3.1.11-д заасан нийтийн тээврийн үйлчилгээ;
- 43) Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд гадаад улсын аялал жуулчлалын байгууллагатай гэрээ байгуулж жуулчдыг нь хүлээн авах, уг үйлчилгээг төлөвлөх, сурталчлах, бичиг баримтыг нь бүрдүүлэх зэрэг гадаадын жуулчдад үзүүлсэн /туроператор/ үйлчилгээ;
- 44) Соёлын өвийг сэргээн засварлах үйлчилгээ;
- 45) Оршуулгын үйлчилгээ;
- 46) Ирээдүйн өв санд улсын төсвөөс хуваарилсан орлого эх үүсвэр, сангийн хөрөнгө оруулалтын орлого.
- 47) Мал эмнэлгийн үйлчилгээ;
- 48) Нотариатын үйлчилгээ;
- 49) Жилийн 50 саяас доош төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ борлуулсан этгээд /импортоор оруулахаас бусад/-ийг албан татвараас чөлөөлнө.
- 50) Эм, эм бэлдмэл, эмнэлгийн багаж, техник хэрэгсэл үйлдвэрлэх, худалдан борлуулахад энэ хуулийн 13.5.10 дахь заалт хамаарахгүй.
- 51) Энэ хуулийн 13.5.14-т заасан үйлчилгээнд жуулчдад үйлчлэх бааз, ресторан, жуулчин тээвэрлэх, газарчлах болон зочид буудлын үйлчилгээ хамаарахгүй.
- 52) Бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэлийн дотоод эргэлтэд ашигласнаас бусад хэлбэрээр бусдад үнэ төлбөргүй шилжүүлсэн буюу хувийнхаа хэрэгцээнд ашигласан бол нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхгүй. Энэ хуулийн



- 13.1.15, 13.1.16, 13.1.17-д заасан барааг дамжуулан борлуулж байгаа этгээдэд энэ хуулийн 13.1 дэх хэсэг хамаарахгүй.
- 53) Гадаад улсын засгийн газар, олон улсын байгууллагаас хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар авсан бараа, буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, хөнгөлөлттэй зээлийн хүрээнд гадаад улсын засгийн газар, олон улсын байгууллагаас өгсөн санхүүжилт /мөнгөн хөрөнгө/-ээр дотоодын зах зээлээс худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээг албан татвараас чөлөөлөхөд мөрдөх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.
- 54) Засгийн газрын бус байгууллагууд засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр санхүүжилт авч төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг бүрэн буюу хэсэгчлэн гүйцэтгэж байгаа үйлчилгээ 13.5.12-т хамаарахгүй.
- 55) Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, тэдгээрт ажиллагсдад энэ хуулийн 13.1.23-т заасан албан татварын чөлөөлөлтийг эдлүүлэхдээ төлсөн албан татварыг буцаан олгох зарчмыг баримтална.
- 56) Монгол Улсын засгийн газраас гадаад улсын засгийн газар, олон улсын байгууллагатай байгуулж соёрхон баталсан олон улсын гэрээний дагуу санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээ;
- 57) Энэ хуулийн 13.14-д заасан төсөл, арга хэмжээний нэр, түүнийг хэрэгжүүлэгч этгээд, төслийн санхүүжилтийн дүн, төсөл хэрэгжүүлэх хугацааг засгийн газар батална.

**Солонгос улсын НӨАТ-ын тухай хуулиас  
“Нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт”**

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн I-р бүлгийн Ерөнхий заалтад “хуулийн зорилго нь холбогдох журмуудыг тогтоох, нэмэгдсэн өртгийн албан татварыг шударгаар ногдуулах, татвар төлөгчдийн татвар төлөх үүргээ биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, татварын мөнгөн санг өсгөхөд хувь нэмэр оруулахад оршино” хэмээн тодорхойлсон байдаг (Enforcement Date 01. Jan, 2020).

Мөн тус хуулийн III бүлгийн 26-р зүйлд НӨАТ-ын татвараас чөлөөлөх тухай заасан байдаг.<sup>125</sup> Үүнд:

26 дугаар зүйл (Татваргүй бараа, үйлчилгээ) Дараах бараа, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө:<sup>126</sup>

- 1) Боловсруулаагүй хүнсний бүтээгдэхүүн; (хөдөө аж ахуйн гаралтай, далайн гаралтай, хоол хүнсэнд ашигладаг ойгоос гаргасан дагалдах бүтээгдэхүүн)
- 2) БНСУ-д үйлдвэрлэсэн хүнсний бус зориулалттай Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон хөдөө аж ахуйн бараа, фермийн аж ахуйн бараа, далайн тоног төхөөрөмж, ойн бүтээгдэхүүн;
- 3) Шугамын ус;
- 4) Шахмал түлш;
- 5) Эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэглэл (Menstrual hygiene products);
- 6) Эмнэлгийн болон эрүүл мэндийн үйлчилгээ (Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон мал эмнэлгийн үйлчилгээ);
- 7) Боловсролын үйлчилгээ (Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон);

<sup>125</sup> Section 2 tax exemptions

<sup>126</sup> 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 16101 тоот акт

- 8) Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ; (Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон)
- 9) Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон ном (номын сангийн үйлчилгээ), сонин, сэтгүүл, Мэдээний харилцаа холбоог сурталчлах тухай хуулиар тогтоосон нэвтрүүлэг;
- 10) Шуудангийн марк, тэмдэгтүүд; (орлогын тэмдэг, гэрчилгээний тэмдэг, сугалааны тасалбар)
- 11) Санхүүжилт, даатгалын үйлчилгээ; (Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон)
- 12) Орон сууц, түүний дагалдах газрыг түрээслэх; (Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон)
- 13) Өдөр өнжүүлэх төв, халамжийн төв;
- 14) Газар;
- 15) Зохиогчийн өмч, хөгжмийн зохиол, мэргэжлийн түвшинд үзүүлэх хувийн үйлчилгээ; (Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон)
- 16) Урлагийн бүтээл, урлагийн арга хэмжээ, соёлын арга хэмжээ;
- 17) Шинжлэх ухааны танхим, музей, уран зургийн галерей, амьтны хүрээлэн, ботаникийн цэцэрлэг;
- 18) Нийтийн ашиг сонирхолд зориулсан шашин шүтлэг, буяны үйлс, тэтгэлэг, тусламж;
- 19) Төр, орон нутгийн засаг захиргаатай холбоотой бараа болон үйлчилгээ.

Дээрх дурдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг НӨАТ-аас хуулиар чөлөөлдөг байна.

**Тайванийн НӨАТ-ын тухай хуулиас  
“Нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт”**

- 1) Үл хөдлөх хөрөнгийн (газар) худалдаа
- 2) Тариалангийн талбайд усалгааны зориулалтаар нийлүүлсэн ус
- 3) Эмнэлэг, поликлиник, сувиллын газруудаас үзүүлж буй эмнэлгийн үйлчилгээ, эм бэлдмэл, тасгийн байр, хүнсний бүтээгдэхүүн
- 4) Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр зохих журмын дагуу байгуулагдсан, нийгмийн халамжийн байгууллага, нийгэмлэг, хөдөлмөрийн байгууллагууд болон засгийн газраас үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээнүүд
- 5) Сургууль, цэцэрлэг, боловсролын болон бусад соёлын байгууллагуудаас үзүүлж буй боловсролын үйлчилгээ, засгийн газрын даалгавраар үзүүлж буй соёлын үйлчилгээнүүд
- 6) Хэвлэлийн салбараас гаргасан, хууль тогтоомжийн дагуу засгийн газраас олгосон чиг үүргийн дагуу боловсролын төрөл бүрийн түвшний сургуулиудад ашиглах сурах бичиг, засгийн газраас үзүүлж буй онцгой мэргэжлүүдийн эрдэм шинжилгээний бүтээлүүд
- 7) (Устгагдсан)
- 8) Мэргэжлийн сургуулийн оюутнуудын ажиллуулдаг, гаднын этгээдэд үйлчилдэггүй дэлгүүрийн зарж борлуулдаг бараа, үйлчилгээ
- 9) Хууль ёсны бүртгэлтэй сонин, сэтгүүл хэвлэн нийтлэгчид, мэдээллийн агентлагууд, телевиз, өргөн нэвтрүүлгийн станцуудын үйлдвэрлэн борлуулсан сонин, сэтгүүл, мэдээний товхимол, сурталчилгаа, телевизийн нэвтрүүлгүүд
- 10) Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг хоршоодын гишүүддээ худалдсан бараа, үйлчилгээ; аж ахуй нэгжүүдэд төрөөс үзүүлж буй тусламж дэмжлэг

- 11) Хуульд заасны дагуу тариаланчид, загасчид, ажилчид, худалдаа, аж үйлдвэрийн нэгдлүүд гишүүддээ худалдан борлуулсан бараа, үйлчилгээ, засгийн газраас эдгээр холбоодод үзүүлж буй тусламж дэмжлэгүүдийн менежментийн төлбөрийг “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлд арилжаалах тухай хууль”-ийн 27 дугаар зүйлд заасны дагуу тооцож суутгана. Энэхүү хууль нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд бөөнөөр худалдан борлуулахад ашиглахад зориулагдсан бөгөөд тариаланчдын холбоо, загасчдын холбоо, хоршоо, төрийн байгууллагуудын хувьцаа эзэмших хэмжээ 70 гаруй хувь байдаг.
- 12) Хуулийн дагуу зохион байгуулагдсан буяны болон тусламжийн байгууллагуудын зохион байгуулсан тендер, хандивын тоглолт, хандивын худалдааны орлогоос шаардагдах зардлуудыг хассаны дараах орлого
- 13) Холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдан, олон нийтэд нээлттэй бус үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит байгууллага, үйлдвэр, халамжийн байгууллагын ажилчдын зарж борлуулж буй бараа үйлчилгээ
- 14) Цагдан хорих ангийн гараар урласан бэлэн бүтээгдэхүүнүүдийг худалдан борлуулах дэлгүүрүүдийн бараа, үйлчилгээ
- 15) Шуудан, харилцаа холбооны газраас хуулийн дагуу үзүүлж буй үйлчилгээ; засгийн газрын үүрэг даалгаврын дагуу үзүүлж буй үйлчилгээ
- 16) Төрийн өмчит монополь үйлдвэрүүд болон монополь бараа борлуулах эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн хуулиар тогтоосон үнээр зарж буй монополь бараа бүтээгдэхүүн
- 17) Татварын тасалбарыг тамгалах марк, шуудан илгээмжийн маркны худалдаа, үйлчилгээ
- 18) Явган болон гудамжны наймаачдийн (ТҮЦ) худалдан борлуулж буй бараа, үйлчилгээ
- 19) Тэжээл, боловсруулаагүй хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн; эсхүл хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, тариаланчид, загасчдын борлуулсан ургацын дайвар бүтээгдэхүүн.
- 20) Загасчны өөрийн гараар барьж, худалдан борлуулж буй загас
- 21) Цагаан будаа, улаан буудайн гурилын худалдаа, будаа тээрэмдэх үйлчилгээ
- 22) Бизнесийн татвараа хоёрдугаар хэсгийн 4 дүгээр бүлэг заасны дагуу тооцдог аж ахуй нэгжийн тогтмол худалдаа хийдэггүй үндсэн хөрөнгийн борлуулалт
- 23) Цэргийн, засгийн газрын болон боловсролын байгууллагууд, тэдгээрийн хараат хүмүүс, ажилчид, оюутнууд, тариаланчид, загасчид, экспорт, автомашины гуравдагч этгээдийн хариуцлагын албан журмын даатгал, даатгалын байгууллагуудын төлсөн давхар даатгалын хураамжийг хамарсан засгийн газраас даатгуулахад даатгалын байгууллагаас хүлээн зөвшөөрсөн даатгалын бодлого
- 24) Хуулийн дагуу засгийн газрын бүх түвшний гаргасан бонд болон үнэт цаасны гүйлгээний татвар ногдуулсан үнэт цаас.
- 25) Бүх шатны засгийн газрын тендерээр худалдаалдаг үлдэгдэл буюу хуучирсан бараа
- 26) Батлан хамгаалах байгууллагуудын зэвсэг, байлдааны хөлөг онгоц, нисэх онгоц, танк, цэргийн зориулалттай тагнуулын холбооны хэрэгслийн борлуулалт

- 27) Бордоо, пестицид, мал эмнэлгийн эм, хөдөө аж ахуйн техник хэрэгсэл, тариалангийн талбайн тээврийн хэрэгсэл, ийм төрлийн техник хэрэгсэлд ашигладаг мазут, цахилгаан
- 28) Далайн эрэг эсвэл далайн эрэг дээрх загас агнуурын зориулалттай загас агнуурын завь, тоног төхөөрөмж, тор, түлшний тос
- 29) Банкны аж ахуй нэгжүүдийн төв, салбар нэгжүүдийн хоорондох хөрөнгийн урсгалын хүү, төлбөр тооцоо гүйцэтгэгчийн суурьшлын тогтоосон журмаар итгэлцлийн сангаас бүрдүүлсэн итгэмжлэл, хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн орлого, төлбөр тооцоо нь оршин суугч алдагдлын эрсдэлийг үүрч, ашиглагдаагүй эд зүйлс ломбардуудаар борлуулсны орлого нь үндсэн зээл ба хүүгийн авлагын нийлбэр дүнгээс хэтрэхгүй бол
- 30) Үйл ажиллагааны хураамжийг тооцоогүй алтан гулдмай, алтан тоосго, алтан ялтас, алтан зоос, алтан чимэглэл
- 31) Засгийн газрын зөвшөөрлөөр байгуулагдсан шинжлэх ухаан, технологийн байгууллагуудаас нийлүүлдэг судалгаа
- 32) Үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн дериватив бүтээгдэхүүн, компанийн бонд, санхүүгийн бонд, Тайванийн долларын банк хоорондын хэлэлцээрийн шинэ зээл, гадаад валютын хэлэлцээрийн зээлийн борлуулалтын хэмжээ зэрэг бүтээгдэхүүний шимтгэл (үйлчилгээний хураамж тооцоогүй бол)

**Латви улсын НӨАТ-ын тухай хуулиас  
“Нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт”**

52 дугаар зүйл. Бараа, ажил, үйлчилгээнд татвар ногдуулахгүй.

(1) Дараах бараа, ажил, үйлчилгээнд татвар ногдуулахгүй:

1) Бүх нийтийн шуудангийн үйлчилгээ нийлүүлэгч байгууллагын шуудангийн үйлчилгээ:

А) Хоёр килограмм жингээс хэтрэхгүй шуудангийн илгээмжийг ангилах, тээвэрлэх, хүргэх;

Б) Арван килограмм жингээс хэтрэхгүй шуудангийн илгээмжийг ангилах, тээвэрлэх, хүргэх;

2) Хуулийн дагуу зөвшөөрөлтэй нийлүүлдэг шуудангийн үйлчилгээний урьдчилгаа төлбөр;

3) Дараах эмнэлгийн үйлчилгээнүүд:

А) Засгийн газрын тогтоол, батлагдсан хууль тогтоомжид заасны дагуу анагаах ухааны технологийг ашиглан эмнэлгээс нийлүүлдэг эмчилгээ, үйлчилгээ (эрүүгийн болон иргэний хэргийн шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлтээс бусад, хөгжлийн бэрхшээлийг шинжлэх, эрүүл мэндийн нөхцөл, хөдөлмөрийн чадварыг үнэлэх анагаах ухааны улсын комисс, эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, ажиллах чадварын талаарх дүгнэлт, цэргийн албан хаагчдын эрүүл мэндийн нөхцөл байдал, тэтгэвэр тогтоолгох, эмчилгээний заалт, гоо сайхны мэс засал зэрэг үйлчилгээ);


Б) Хууль дүрмийн дагуу эрх үүргээ хэрэгжүүлэхийн тулд шаардагдах эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, хөдөлмөрийн хүнд болон хортой нөхцөлийг зайлшгүй тодорхойлох үйлчилгээ;

4) Энэ зүйлийн 3 дугаар хэсэгт заасан эмнэлгийн үйлчилгээг хангахад зайлшгүй



шаардлагатай эмчилгээтэй холбоотой дараах үйлчилгээнүүд:

- А) Хууль тогтоомжид заасны дагуу эмнэлгийн тээврийн хэрэгслээр өвчтөнийг тээвэрлэх;
- Б) Эмчилгээ хийлгэх өвчтөнд эмнэлгээс хоолоор үйлчлэх;
- В) Хэвтэн эмчлүүлэх эмнэлгээс өвчтөн, сахиур хамт эмчлүүлэх өрөө тасалгаагаар хангах үйлчилгээ;
- Г) Эрүүл мэндийн байгууллагуудын заавал биелүүлэх шаардлага, эмнэлгийн гэрчилгээ, үйлчилгээ;
- Д) Бусад эрүүл мэндийн байгууллагад үзүүлэх клиник оношлогоо, лабораторийн үйлчилгээ;
- 5) Хүний эд эрхтэн, сүү, цусан хангамжууд (үүнд: цусны сийвэн ба цусны эд эсүүд);
- 6) Шүдний эмчилгээ, үйлчилгээ;
- 7) Шүдний техникч, шүдний эрүүл ахуйч, эмч, хиймэл шүдний үйлчилгээ;
- 8) [2017 оны 4-р сарын 20];
- 9) Нийгмийн халамж үйлчилгээ, мэргэжлийн болон нийгмийн шинэчлэл, нийгмийн халамж үйлчилгээ, бүртгэлийн газар, хүн амын бүртгэл, нийтийн хоолны үйлчилгээ, бусад хөтөлбөрүүд;
- 10) Олон нийтийн сайн үйлсийн аян, түүнтэй холбоотой байгууллагаас хүүхэд болон залуучуудыг хамгаалах зорилгоор бараа, ажил үйлчилгээ нийлүүлэх;
- 11) Бага насны хүүхдийн болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас нийлүүлдэг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ;
- 12) Ерөнхий боловсрол, мэргэжлийн болон их дээд боловсрол, боловсролын чиглэлээр улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын байгууллагын үйлчилгээ, дээр дурдсан боловсролын байгууллагуудаас үзүүлж байгаа үйлчилгээ, нийлүүлж буй бүтээгдэхүүн;
- 13) Бусад улсын боловсролын байгууллагууд энэ зүйлийн 12 дахь хэсэгт дурдсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээр боловсролын байгууллагуудыг хангах, үйлчилгээ;
- 14) Ерөнхий боловсрол, мэргэжлийн болон их дээд боловсролын хөтөлбөрийн хүрээнд хичээл заадаг багш нарт үзүүлэх үйлчилгээ;
- 15) Орон нутгийн засаг захиргааны тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэй орон нутгийн засаг захиргааны төсвөөс санхүүждэг сургуулийн сурагчдыг тээвэрлэх үйлчилгээ;
- 16) Хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий газраас зохион байгуулсан ажилгүй иргэдийг мэргэжлийн сургалтад сургах, дадлага хийлгэх үйлчилгээ;
- 17) Дараах соёлын үйлчилгээнүүд:
  - А) Театр, циркийн урлагийн тоглолтууд;
  - Б) Концерт;
  - В) Хүүхдэд зориулагдсан арга хэмжээ, сайн дурын сонирхогчдын уран бүтээлийн үйл ажиллагаа, буяны зорилгоор зохион байгуулсан арга хэмжээ;
  - Г) Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн музей, номын сан, үзэсгэлэн, амьтны хүрээлэн, ботаникийн цэцэрлэг, соёл, боловсролын арга хэмжээ;
  - Д) Номын сангийн фондын мэдээллүүдийг олон нийт ашиглах, фондод нэвтрэх үйлчилгээ;





18) Зохиогчийн эрх ашигласны төлбөр, түүнтэй холбогдсон эрх, ашиглалтын гүйцэтгэгч, фонограмм үйлдвэрлэгчээс хүлээн авсан төлбөр;

19) Латви улсын банкинд алт, зоосон мөнгө, мөнгөн тэмдэгт нийлүүлэх үйлчилгээ;

20) Даатгал, давхар даатгалын үйлчилгээ, туслах даатгалын үйлчилгээ;

21) Дараах санхүүгийн ажил гүйлгээ:

А) Зээлдүүлэгч зээл олгох (зуучлалыг оролцуулан), түүнчлэн зээлийн менежмент, зээлийн гүйцэтгэл;

Б) Зээлийн болон мөнгөний бусад баталгаа (зуучлалыг оролцуулан), зээлдүүлэгчийн зээлийн баталгаа хийсэн гүйлгээ;

В) Хөрөнгө оруулалт, харилцах данс, эргэн төлөгдөх бусад сангуудыг татан төвлөрүүлэх, бэлэн ба бэлэн бус төлбөрийн хэрэгслээр төлбөр хийх, итгэмжлэгдсэн этгээдийн (итгэлжлэл) үйл ажиллагааны үйлчилгээ;

Г) Төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ (зуучлалыг оролцуулан), төлбөрийн хэрэгслүүд болон бусад мөнгөний зах зээлийн худалдаа хийх (зуучлалыг оролцуулан), шинжлэн нөлөөлөх зорилгоор нийлүүлсэн төлбөрийн хэрэгслээс бусад;

Д) Хөрөнгө оруулалт, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын үйлчилгээ (зуучлалыг оролцуулан) (хадгалалт, кастодиан банкны хяналт, бусад хяналт шалгалтыг оролцуулан);

22) Хөрөнгө оруулалтын менежментийн сангуудад төрөөс санхүүждэг тэтгэврийн тогтолцооны хөрөнгө оруулалт, хаалттай, нээлттэй тэтгэврийн сан, эрсдэлийн капитал сан, даатгалын компаниуд, бусад хөрөнгө оруулалтын менежмент хууль ёсны шийдвэр гаргах эрх мэдэлтэй хөрөнгө оруулалтын сан (техникийн нөөц, баталгааны санг оруулаад);

23) Цахим сүлжээ, харилцаа холбоогоор дамжуулан үйлчилгээг зохион байгуулдаг мөрийтэй тоглоом, сугалаанаас ашиг олох үйлчилгээ;

24) Ашиглагдахгүй үл хөдлөх хөрөнгө болон барилгын газрын борлуулалтыг шинжлэх, бусад үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах;

25) Оршин суугчдад үзүүлэх дараах үйлчилгээ:

А) Орон сууц түрээслэх (орон байрны үйлчилгээнээс бусад-зочид буудал, мотель, хөдөө орон нутгийн аялал жуулчлалын бааз, жуулчны байр)

В) [2015 оны 11-р сарын 30].

(2) Энэ хэсгийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу олон нийтийн үйлчилгээ эрхэлдэг, бусад үйлчилгээг эрхлэн явуулж байхдаа тогтмол ашиггүй байсан тохиолдолд үйлчилгээний татвараас чөлөөлнө. Хэрэв ашигтай тохиолдолд олсон ашгаа дээрх үйлчилгээг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаанд хөрөнгө оруулсан тохиолдолд чөлөөлөлт хүчинтэй.

(3) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу болон төрийн захиргаанд бүртгүүлсэн татвар ногдуулах этгээд, холбогдох бүтээгдэхүүний орлогын татварыг суутгаагүй бол бараа, ажил үйлчилгээнд татвар ногдуулахгүй.

(3<sup>1</sup>) Татвар ногдох гүйлгээг (тансаг зэрэглэлийн бараанаас хувийн хэрэгцээнд зориулсан барааг оролцуулан бүртгэгдсэн татвар ногдуулах этгээд, бусад үйлчилгээ) бүртгэгдсэн татвар ногдуулах этгээдийн татварыг суутгаагүй, худалдан авах, ашиглахад зориулсан бараа, ажил үйлчилгээнд татвар ногдуулахгүй.

(4) Засгийн газраас тогтоосон журмын дагуу дараах бараа, ажил, үйлчилгээг татвараас

чөлөөлнө.

2) Төрд хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий болон мэргэжлийн боловсрол, их, дээд боловсрол, түүнчлэн дээр дурдсан боловсролын байгууллагуудын үйлчилгээнүүд;

3) Ерөнхий боловсрол, мэргэжлийн болон их, дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрээнд хувиараа хичээл заадаг багш нарт үзүүлэх боловсролын үйлчилгээ;

4) Соёлын үйлчилгээ;

5) Санхүүгийн гүйлгээ;

6) Мөрийтэй тоглоом, сугалаа;

7) Үл хөдлөх хөрөнгө;

8) Оршин суугчдад нийлүүлсэн түрээсийн орон сууцны үйлчилгээ;

9) Эмнэлгийн үйлчилгээ

52<sup>1</sup> дугаар зүйл. Бие даасан бүлгийн гишүүд татвар ногдуулахгүй байх үйлчилгээ

Энэ үйлчилгээнд дараах нөхцөлд бие даасан бүлгийг татвараас чөлөөлнө.

1) Энэ бүлгийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25 дугаар зүйлээс бусад хэсэгт энэ хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу татвар ногдуулахгүй;

2) Үйлчилгээнд бие даасан бүлгийн гишүүдэд татвар ногдуулахгүй байх шаардлагатай;

3) Үйлчилгээний үнэ цэнэ нь өртгийн үнэ;

4) Үйлчилгээний нийт зардлын дүнг төлөвлөгөөний дагуу тухайн бүлгийн гишүүд хариуцдаг;

5) Зах зээлд үр дүнтэй өрсөлдөх чадвартай оролцогчийн үйл ажиллагаа (одоогийн болон боломжит) зах зээлд өрсөлдөх оролцогчдын нөхцөл байдалд нөлөөлөхгүй тул гажуудал үүсгэдэггүй.

(2) Энэ хэсгийн 1 дэх хэсэгт дараах нөхцөлийг хангасан байх ёстой.

1) Бие даасан бүлэг, түүний гишүүдийн хооронд үйлчилгээ үзүүлэхдээ бичгээр гэрээ байгуулсан байна;

2) Бие даасан бүлгийн гишүүдэд татвар ногдуулна.

3) Бие даасан бүлгийн гишүүн нь татвар ногдуулах гүйлгээ хийсэн бол татвараас чөлөөлөгдсөн гүйлгээг нотолсон бүртгэлийг 52 дугаар хэсгийн 1 дэх хэсэгт заасны дагуу гаргана, энэ хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн 2, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25 дахь хэсэгт зааснаас бусад, эсхүл энэ бүлгийн гишүүдэд хамааруулахгүй.

3) Бүлгийн гишүүдэд үйлчилгээ үзүүлж эхлэхээс өмнө бие даасан бүлэг байгуулагдсан тухайгаа болон эдгээр бүлгийн гишүүд төсвийн орлогын газарт гэрээний дагуу бичгээр мэдэгдэнэ.

53 дугаар зүйл. Татвар ногдуулахгүй импортын бараа, үйлчилгээ

(1) Энэ хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан барааг гадаадаас оруулахад /импорт/ татвар ногдуулахгүй.

(2) Импортоор оруулах байгалийн хийн систем, түүнтэй холбогдсон сүлжээ, ачааны хөлөг онгоцны хий, байгалийн хийн алсын шугам хоолойнд шахдаг хий, цахилгаан дулааны энерги, хөргөх сүлжээ бүхий холбогдох бараанд татвар ногдуулахгүй.

(3) 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 1186/2009 оны зөвлөлийн журамд заасны

дагуу гаалийн татвар ногдуулдаггүй бараа бүтээгдэхүүнийг импортлох, барааны ачаанаас бусад тохиолдолд гаалийн татвараас чөлөөлөх, нийгмийн бүлэгт (кодчилсон хувилбар) журмын 23 дугаар зүйлд дурдсанаар татвар ногдуулахгүй.

(4) 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 1186/2009 оны зөвлөлийн журмын 23-р зүйлд дурдсан барааны ачаанаас гаалийн татварыг чөлөөлөх, нийгмийн бүлэг (кодчилсон хувилбар)-д татвар ногдуулахгүй, энэ нь бараа нь 22 еврогоос хэтрэхгүй үнэтэй байна.

(5) Худалдааны зорилгоор бараа импортлоход нийт үнэ 22 еврогоос хэтрэхгүй бол татвар ногдуулахгүй.

(7) Бараа импортлоход дараах тохиолдолд татвар ногдуулахгүй.

1) Европын холбооны байгууллагууд, тэдгээрийн төлөөлөгчид, европын атомын энергийн нийгэмлэг, европын төв банк, европын хөрөнгө оруулалтын банк, европын холбооны эрх зүйн актуудаар байгуулагдсан байгууллагууд нь 1965 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Европын холбооны протокол, гэрээнд заасны дагуу хязгаарлахад;

2) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдаагүй, холбогдох гишүүн улсын эрх бүхий байгууллагууд хүлээн зөвшөөрсөн олон улсын байгууллагууд, олон улсын конвенцууд, гэрээ;

3) Европын холбооны нутаг дэвсгэр дэх олон улсын байгууллага, тэдгээрийн төлөөлөгчид, олон улсын конвенцийн гэрээнд заасан хязгаарлалт;

4) Хойд атлантын гэрээний байгууллагын (НАТО) нь олон улсын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх, НАТО-д нэгдсэн бусад улсын зэвсэгт хүчний анги нэгтгэлүүд (бүгд найрамдах Латви улсын үндэсний зэвсэгт хүчин) тэдгээрийн бүрэлдэхүүнд багтсан хүмүүс;

5) Европын холбооны 1965 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн давуу эрх, дархлааны тухай протоколыг хэрэглэсэн бүгд найрамдах Латви улсад бүртгэлтэй гишүүн орнууд болон гуравдагч орнуудын дипломат болон консулын төлөөлөгчийн газрууд

(8) Загасны аж ахуй эрхэлдэг этгээд, загас агнуурын аж ахуй эрхэлж байгаа этгээдийг боловсруулалт хийгдээгүй, маркетингийн зориулалттай хадгалалтанд хамаарагдсан боомт зэрэгт татвар ногдуулахгүй.

(9) Барааг түр хугацаагаар экспортолсны дараа дахин импортлоход тухайн барааг экспортолсон этгээд, гаалийн албан татвараас чөлөөлөх шаардлагад нийцсэн тохиолдолд татвар ногдуулахгүй.

(10) Гуравдагч улс буюу нутаг дэвсгэрээс (аялагч) ирэх иргэдийн хувийн тээш, авчирсан барааг импортлоход татвар ногдуулахгүй (барааг худалдаалах зорилгогүй бол)

(11) Аялагч ирэх хугацаа, ачаа, тухайн ачаа ачихдаа бүртгэгдсэн тухайг нотлох байгууллагад үзүүлэх, ачааг аялал хийх компанид авч явахыг энэ зүйлийн 10 дахь хэсэгт дурдсаныг хувийн ачаа гэж үзнэ.

(12) Бараа импортлох нь энэ зүйлд дурдсан дараах бүх нөхцөлүүдтэй нийцэж байгаа тохиолдолд энэ зүйлийн 10 дахь хэсгийн дагуу худалдаалах зорилгоор бараа импортлохгүй гэж үзнэ.

1) Ердийн бараа импортлохгүй;

2) Зөвхөн аялагчийн хувийн болон гэр бүлийн хэрэгцээнд бэлэглэх зориулалттай барааг импортлоно.

(13) Энэ зүйлийн 12 дугаар хэсэгт дурдсан худалдааны барааг импортлохгүй.

(14) Аялагчийн хувийн ачаа тээшинд оруулж ирсэн бараанд дараах нөхцөл, барааны үнийн хязгаарлалтыг харгалзан татвар ногдуулахгүй.

1) Нэг хүнд ногдох барааны нийт дүн дараах хэмжээнээс хэтрэхгүй байна.

А) Аялагч газраар ирсэн бол 300 евро;

Б) Аялагч агаарын болон далайн тээврээр ирсэн бол 430 евро;

2) 15-аас доош насны аялагчдын хувьд нэг хүнд ногдох барааны нийт үнэ 285 еврогоос хэтрэхгүй;

3) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан барааны нийт үнэд дараах зүйлийг хамааруулаагүй болно:

А) Түр хугацаагаар оруулж ирсэн, эсхүл түр хугацаагаар экспортолсны дараа буцаан импортолсон хувийн ачаа тээшийн үнэ;

Б) Аялагчийн хувийн хэрэгцээнд шаардлагатай эм, эмнэлгийн бүтээгдэхүүний үнэ;

В) Энэ зүйлийн 15 дахь хэсэгт тодорхойлогдсон бараа үнэ;

4) Нэг барааны үнийг хэсэгт хуваагдахгүй.

(15) Онцгой албан татварын тухай хуулийн дагуу барааны тоо хэмжээ, хязгаарлалт, аялагчийн хувийн тээшинд импортоор оруулж буй тамхи, болон согтууруулах ундаа, уух ундаанд татвар ногдуулахгүй.

54 дүгээр зүйл. Европын холбооны нутаг дэвсгэрт татвар ногдуулахгүй байх бараа худалдан авах.

(1) Энэ хуулийн 52 дугаар зүйлд заасны дагуу хилээр нэвтрүүлэх европын холбооны нутаг дэвсгэрт чөлөөлөлтийг хэрэглэж болох худалдан авах бараанд татвар ногдуулахгүй.

(2) Европын холбооны нутаг дэвсгэр энэ хуулийн 53 дугаар зүйлийн 3,4,5,9 дэх хэсэгт заасны дагуу импортыг татвараас чөлөөлөх худалдан авах бараанд татвар ногдуулахгүй.

(3) Европын холбооны нутаг дэвсгэрт худалдан авах дараах бараанд татвар ногдуулахгүй.

1) Европын холбооны нутаг дэвсгэрт бүртгэлтэй татвар ногдуулах этгээд, өөр нэг улсын гишүүн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлдэггүй, бүртгэгдсэн татвар ногдуулах этгээдийн худалдан авах бараанд татвар ногдуулахгүй;

2) Барааг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан өөр нэг улсын гишүүн, татварт ногдуулах этгээд, үүсгэн байгуулсан гишүүн бусад улсаас шууд илгээх үед;

3) Энэ зүйлийн 86 дахь хэсэгт заасны дагуу бүртгэгдсэн татвар ногдуулах этгээд нь татварыг улсын төсөвт төлөх үүрэгтэй.

(4) Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасан өөр нэг улсын гишүүн бүртгэгдсэн татвар ногдуулах этгээдийг төсвийн орлогын албанд НӨАТ ногдуулах этгээд бүртгүүлсэн тохиолдолд энэ хэсгийн 3 дахь хэсэгт заасны дагуу татвар төлөхтэй холбоотой харилцааг зохицуулна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- НӨАТ-ын тухай хууль
- <https://qsstudy.com/business-studies/advantages-disadvantages-value-added-tax>
- <https://www.quora.com/What-are-the-advantages-and-disadvantages-of-a-VAT>
- Harvey S.Rosen Public finance, Taxation and income distribution, 2011
- Монгол Улсын 2019 оны татварын орлогод хийсэн шинжилгээ, Ш.Батцэнгэл
- Keynesian economics - Wikipedia
- The expenditure-output, or Keynesian cross, model (article) | Khan Academy
- Латви Улсын орлогын статистик. 2020  
<https://www.oecd.org/tax/tax-policy/revenue-statistics-latvia.pdf>
- Латви Улсын НӨАТ тухай хууль  
<https://likumi.lv/ta/en/en/id/253451>
- Европын Холбооны 2021 оны НӨАТ-ын хувь хэмжээ  
<https://www.avalara.com/vatlive/en/vat-rates/european-vat-rates.html>
- Европын Холбооны НӨАТ-ын чөлөөлөлт  
[https://ec.europa.eu/taxation\\_customs/business/vat/eu-vat-rules-topic/exemptions\\_en](https://ec.europa.eu/taxation_customs/business/vat/eu-vat-rules-topic/exemptions_en)
- <https://www.avalara.com/vatlive/en/vat-rates/international-vat-and-gst-rates.html>
- <https://taxsummaries.pwc.com/latvia/corporate/other-taxes>
- Revenue Statistics OECD  
<https://stats.oecd.org/Index.aspx?DataSetCode=REVLVA>
- <https://countryeconomy.com/gdp/latvia>
- Taxation (slideshare.net)
- Taiwan - Economy | Britannica  
<https://eng.stat.gov.tw/ct.asp?xItem=41884&ctNode=6354&mp=5>
- <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=G0340080>
- <https://www.pwc.com/sg/en/tax/assets/vat-gst-guide-2019.pdf>
- <https://eng.stat.gov.tw/ct.asp?xItem=41884&ctNode=6354&mp=5>
- <https://www.ntbt.gov.tw/English>
- <https://likumi.lv/ta/en/en/id/253451>
- Latvia | History - Geography | Britannica
- Revenue Statistics OECD  
<https://countryeconomy.com/gdp/latvia>
- <https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=value+added+tax&x=24&y=31#liBgcolor10>
- <https://taxsummaries.pwc.com/latvia/corporate/other-taxes>
- <https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=value+added+tax&x=24&y=31#liBgcolor10>
- <https://taxsummaries.pwc.com/latvia/corporate/other-taxes>
- <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.KD.ZG?end=2019&locations=KR&start=2015&view=chart>
- <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.PCAP.CD?end=2019&locations=KR&start=2015>



# ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ: МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ БА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Дүн шинжилгээ)

*Ш.Батцэнгэл, Д.Халиун,  
И.Жаргалзаяабямба, Р.Нургүл*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

1. Онол, арга зүй

- 1.1. Эдийн засгийн салбаруудын ангилал, тэдгээрийн онцлог
- 1.2. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын онцлог
- 1.3. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжилд нөлөөлөгч хүчин зүйлс

2.Эмпирик судалгааны хэсэг/Монгол Улс/

- 2.1. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг бүрдүүлэгч салбарын үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, онцлог
- 2.2. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал
- 2.3. Хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

3. Гадаад орнуудын туршлага

3.1. Итали Улс


- 3.1.1. Итали Улсын ДНБ-ний өнөөгийн байдал, бүтэц, онцлог
- 3.1.2. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал
- 3.1.3. Аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

3.2 Америкийн Нэгдсэн Улс

- 3.2.1. Америкийн Нэгдсэн Улсын ДНБ-ний өнөөгийн байдал, бүтэц, онцлог
- 3.2.2. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал
- 3.2.3. Аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого
- 3.2.4. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

3.3. БНХАУ

- 3.3.1. Хятад Улсын ДНБ-ний өнөөгийн байдал, бүтэц, онцлог
- 3.3.2. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал
- 3.3.3. Аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого
- 3.3.4. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ



### 3.4. Их Британи

3.4.1. Их Британи Улсын ДНБ-ний өнөөгийн байдал, бүтэц, онцлог

3.4.2. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал

3.4.3. Аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого

3.4.4. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

### 3.5. Энэтхэг Улс

3.5.1. ДНБ-ний өнөөгийн байдал, бүтэц, онцлог

3.5.2. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал

3.5.3. Аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого

3.5.4. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ



## УДИРТГАЛ

Судалгаанд Монгол Улсын болон гадаадын зарим улсын дотоодын нийт бүтээгдэхүүний бүтэц, аж үйлдвэрийн салбарын тойм, түүний бүрэлдэхүүн хэсэг болох хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх чиглэлд төрөөс баримталж буй бодлого, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэргийг дэлгэрэнгүй судаллаа.

Судалгааны явцад хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжил, авсан арга хэмжээний үр дүн Монгол Улсад ямар байгаа, мөн гадаадын улс орнууд үйлдвэрлэлийн салбараа хөгжүүлэхдээ ямар бодлого баримталж, ямар арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ямар үр дүнд хүрсэн болохыг онолын судалгаагаар гаргаж авсан хүчин зүйлсийн хүрээнд системтэй тодорхойллоо. Уг судалгаагаар аж үйлдвэрлэлийн салбар, тэр дундаа хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх онолын болон практик үндэслэлийг тодорхойлж, бусад орнуудын сайн туршлага, хөгжлийн бодлого, стратегийг дэлгэрүүлэн авч үзсэн тул цаашид Монгол Улсад хөнгөн үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого, эрх зүйн орчныг тодорхойлоход мэдээллийн эх сурвалж болгон ашиглах боломжтой.

**Судалгааны хамрах хүрээ:** Сэдвийн хүрээнд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, ДНБ-д эзлэх үндсэн салбаруудын хувийн жин, аж үйлдвэрийн салбарын тойм, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүний ангилал бүрийн хувьд тооцож гаргасан статистик мэдээлэл зэргийг холбогдох эх сурвалжуудаас боловсруулалт хийх замаар цуглуулж дүгнэлтэндээ тусгалаа. Монгол Улсын хөнгөн үйлдвэрлэлийн хөгжилтэй холбоотой чанарын мэдээлэлд шинжилгээ хийснээс гадна судалгаанд авагдсан Хятад, АНУ, Энэтхэг, Их Британи, Итали зэрэг орнуудын үйлдвэрлэлийн хөгжилтэй холбоотой чанарын болон тоон мэдээллийг онолын чиг баримжаатай түүвэрлэн авч боловсруулалт хийлээ.

**Түлхүүр үг:** Дотоодын нийт бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн салбар, хөнгөн үйлдвэрлэлийн салбар, аж үйлдвэрийн хөгжлийн бодлого, хөтөлбөр

**Keywords:** Gross domestic product, industrial sector, light industry, development policy for the industrial sector, program

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгааны эхний бүлэгт онол, арга зүйн судалгаа хийсэн болно. Онол арга зүйн судалгааны хүрээнд эдийн засгийн салбаруудын ангилал, тэдгээрийн онцлог, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын онцлог, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжилд нөлөөлөгч хүчин зүйлс зэргийг тодорхойлсон бөгөөд эдгээр нь хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр цэгцтэй мэдээлэл авах, гүнзгийрүүлсэн судалгаа хийх зэрэгт хэрэг болох юм. Хөнгөн үйлдвэрлэлийн хөгжилд нөлөөлөгч хүчин зүйлсийг олон төрлийн эх сурвалж ашиглан тодорхойлсон бөгөөд давхцаагүй байдлаар дараах хүчин зүйлс нөлөөтэй байдаг болохыг гаргаж авсан. Эдгээр нь өрсөлдөөн, байршил, технологи, засгийн газрын бодлого, хүний нөөц, байгалийн хүчин зүйлс, санхүүжилт, зах зээл, менежерийн ур чадвар, түүхий эд, макро эдийн засаг, дэд бүтэц зэрэг болно.

Онолын хувьд аж үйлдвэрийн салбарт боловсруулах үйлдвэрлэлийн салбар ордог, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хөнгөн үйлдвэрлэлийн салбар багтдаг тул улс орнууд хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийг аж үйлдвэрийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлж байна. Манай улсын хөнгөн үйлдвэрлэлийн салбарт дараах бүтээгдэхүүнүүд орж байна. Эдгээр нь:

- ✓ Нэхмэл
- ✓ Химийн бүтээгдэхүүн
- ✓ Хувцас үйлдвэрлэл
- ✓ Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх үйл ажиллагаа
- ✓ Резин болон хуванцар бүтээгдэхүүн
- ✓ Арьс ширэн эдлэл
- ✓ Мод, модон эдлэл
- ✓ Тавилга, цахилгаан хэрэгсэл зэрэг болно.

Судалгааны II бүлэгт Монгол Улсын хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн түүхэн болон өнөөгийн нөхцөл байдалтай холбоотой тоон болон чанарын шинжилгээ хийв. Тоон шинжилгээний хүрээнд ДНБ-ний үндсэн бүрэлдэхүүнийг эдийн засгийн секторын бүтцээр нь задлан авч үзсэн бөгөөд шинжилгээний үр дүнд аж үйлдвэрийн салбарын дийлэнх хэсгийг буюу 68 хувийг уул уурхайн олборлолт, 27 орчим хувийг боловсруулах үйлдвэрлэл, үлдсэн хэсгийг цахилгаан, усан хангамжийн үйлдвэрлэл эзэлж байгааг тодорхойлсон нь манай улсын аж үйлдвэрийн салбарт боловсруулах үйлдвэрлэлээсээ илүүтэй уул уурхайн салбар томоохон байр суурь эзэлж байгаа болохыг харуулж байна.

Боловсруулах үйлдвэрлэлийн салбар ДНБ-ний 9.4 хувийг эзэлж байна. Энэ нь дэлхийн дундаж үзүүлэлт болох 12.6<sup>127</sup> хувиас даруй 3.2 хувиар доогуур үзүүлэлт байгаа тул боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь манай улсын хувьд чухал ач холбогдолтой юм. Нөгөө талаас боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан усан хангамж зэрэг үйлдвэрлэлийн салбарууд нь ДНБ-тэй хамгийн өндөр эерэг хамааралтай байгаа болох нь корреляцийн шинжилгээнээс харагдаж байна. Энэ нь манай улс боловсруулах салбарынхаа үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ДНБ-ний өсөлтийг хангах боломж байгаа болохыг харуулж байна.

Сүүлийн 4 жилийн байдлаар хөнгөн үйлдвэрлэлийн салбарын дундаж өсөлт нь аж үйлдвэрийн салбарын дундаж өсөлтөөс арай доогуур буюу 18.4 хувь байгаа бөгөөд энэ нь

<sup>127</sup> Manufacturing, value added (% of GDP) | Data (worldbank.org)

боловсруулах үйлдвэрлэлийн салбарын дундаж өсөлт болох 16.7 хувиас 1.7 хувиар өндөр байна. Ноос, ноолуурын салбарын үйлдвэрлэл хөнгөн үйлдвэрлэлийн салбарын үнэмлэхүй их хувийг буюу 69.6 хувийг эзэлж байгаагаас манай улсын хөнгөн үйлдвэрлэлийн салбар мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний түүхий эд болох ноос, ноолуураас өндөр хамааралтай байна гэж дүгнэж болно.

Мөн судалгааны II бүлэгт Монгол Улс хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа болохыг тодорхойлох зорилгоор онолын судалгаагаар гаргаж авсан үйлдвэрлэлийн салбарт нөлөөлөх хүчин зүйлсийг ашиглан чанарын судалгааг хийсэн болно.

**Санхүүжилтийн хүрээнд** хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд арилжаанаас банкнаас зээл авах, олон улсын төсөл хөтөлбөрүүд болон Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтэд хамрагдаж хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг олж авч байна. Сүүлийн 4 жилд ноос, ноолуур, арьс шир, сав баглаа боодол, дахин боловсруулах үйлдвэрлэлд төрөөс нийт 595.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ. Энэ нь засгийн газраас “Ноолуур” /2018-2021/, “Сав, баглаа боодол” /2017-2021/, “Үйлдвэржилт 21:100” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаатай холбоотой. Харин модон эдлэл, оёдол, нэхмэлийн бүтээгдэхүүнүүдийн хувьд төрөөс дэмжсэн санхүүжилт хараахан алга байна.

Төрөөс олгож байгаа санхүүжилтийн дийлэнх хэсгийг “Хөгжлийн банк”-аар дамжуулан зээл хэлбэрээр олгосон бөгөөд ноос, ноолуурын чиглэлийн томоохон үйлдвэрүүдийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх, түүхий эдийн ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд зориулжээ. Гэхдээ цөөн тооны томоохон аж ахуйн нэгжүүд “*санхүүжилт хүссэн дүн нь 20.0 тэрбум төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютын дүнгээс дээш байх*” гэсэн хөгжлийн банкны төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангаж байна. Тухайлбал 2021 онд Засгийн газраас ажлын байрыг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд ноос, ноолуурын чиглэлийн 83 компаниас 5 нь 20 тэрбум-аас доошгүй төгрөгийн санхүүжилт хэрэгтэй гэсэн хүсэлтийг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд гаргажээ.

Нөгөө талаас хөнгөн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй цөөнгүй тооны үйлдвэр, аж ахуйн газрууд жилийн 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой байгаа нь тэдгээр аж ахуйн нэгжүүдийн хувьд жижиг дунд үйлдвэрийн хүрээнд төрөөс олгож буй бага хүүтэй зээлийн санхүүжилтэд хамрагдах боломжийг хязгаарлаж байгаа юм. Учир нь манай улсын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд “жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэлх орлоготой аж ахуйн нэгжийг жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч гэнэ” хэмээн заасан байдаг.

Эндээс хөнгөн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр аж ахуйн газруудад санхүүжилтийн боловсронгуй өөр арга хэлбэрүүд шаардлагатай байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

**Татварын зохицуулалтын хүрээнд** ашигт малтмал, согтууруулах ундаа, газрын тосны бүтээгдэхүүнээс бусад салбарт үйл ажиллагаа явуулж буй 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн орлоготой бизнес эрхлэгчдэд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 хувийн хөнгөлөлт үзүүлэх зохицуулалт одоо мөрдөгдөж буй аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн хүрээнд үйлчилж байна. Түүнчлэн инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодис НӨАТ болон гаалийн татвараас, импортоор оруулж байгаа бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, банз, модон бэлдэц, хагас боловсруулсан модон материал, экспортод гаргасан арьс шир НӨАТ-ын татвараас

тус тус чөлөөлөгдөж байхаар холбогдох хуулиудын зохицуулалтуудад тусгажээ.

**Хүнс хөдөө аж ахуй хөнгөн** үйлдвэрийн яамнаас холбогдох төрийн бус байгууллагатай хамтарч ажилладаг, хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэхэд чиглэгдсэн болон бусад сургалтуудыг зохион байгуулж байгаагаас гадна зах зээлийг өргөжүүлэх чиглэлээр дотоод, гадаадын үзэсгэлэн худалдааг зохион байгуулж байна.

Монгол Улсын хөнгөн үйлдвэрлэлийн хүрээнд хэрэгжүүлж буй бодлогуудаас **санхүүжилт, инновацитай холбоотой бодлогын** зорилтуудын хэрэгжилт бага байгаа нь чанарын судалгаагаар тогтоогдсон. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын гол төлөөлөл болсон ноос, ноолуурын салбар нийт түүхий эдийнхээ 20 хүрэхгүй хувийг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулан ашиглаж байгаа нь ноос ноолуурын салбарт нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл харьцангуй сул хөгжсөн болохыг харуулж байна. Ерөнхийдөө бусад салбарын хувьд ч түүхий эдийн нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байх боломжтой ч үйлдвэрлэлийнх нь хэмжээ харьцангуй бага байгаа юм.

**Хөнгөн үйлдвэрлэлийн салбар бүс нутгийн** хэмжээнд жигд хөгжөөгүй, үйлдвэржилт хөтөлбөрийн хүрээнд “Шинэ ховд” үйлдвэрлэл, “Дархан арьс ширний цогцолбор” баригдаж байгаа бөгөөд ихэнх үйлдвэрүүд нь Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж байна.

Иймд хөнгөн үйлдвэрлэлийн салбарт инновацийг нэвтрүүлэх, өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, санхүүжилтийг нь хүртээмжтэй болгох, өсгөх, гадаад, дотоод зах зээлийг нэмэгдүүлэх, бүс нутгийн хэмжээнд жигд хөгжлийг нь хангах, түүхий эдийн ханган нийлүүлэлтийн кластерийн зохион байгуулалтад оруулах ажлыг хэвшүүлэхэд чиглэгдсэн цэгцтэй, далайцтай арга хэмжээнүүдийг төрөөс авах хэрэгтэй байна.

Судалгааны III хэсэгт АНУ, Их Британи, Хятад, Энэтхэг, Итали улсуудын дотоодын нийт бүтээгдэхүүн, аж үйлдвэр болон үйлдвэрлэлийн салбарын ерөнхий байдлыг харуулах тоон мэдээллийг боловсруулж гаргаснаас гадна эдгээр орнуудын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөрийн агуулга, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэргийг дэлгэрэнгүй судаллаа.

Судалгаанд авагдсан эдгээр орнуудын боловсруулах үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь манай улсынхаас хавьгүй өндөр байгаа нь манай улсын хувьд боловсруулах үйлдвэрлэлийн салбараа цаашид хөгжүүлэх шаардлага байгаа болохыг харуулж байна.

Улс орнууд үйлдвэрлэлийн урт хугацаатай бодлогыг тууштай авч хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжүүлж буй үйлдвэрлэлийн бодлого, хөнгөн үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг улс орон бүрээр харуулвал дараах байдалтай байна.

Агуулга	Итали	АНУ	БНХАУ	Британи	Энэтхэг
<b>Хөтөлбөр</b>	Industria 4	Make it in America	Made in chine 2025	Аж үйлдвэрийн стратеги	“Тогтвортой аж үйлдвэрийн хөгжлийн 2018-2022 оны хөтөлбөр” “Үндэсний Үйлдвэрлэлийн Бодлого Make in India” болон Start up India хөтөлбөр
<b>Тэргүүлэх чиглэл</b>	Нэхмэлийн үйлдвэрлэл	Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Хими, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Химийн үйлдвэрлэл	Резин болон хуванцар бүтээгдэхүүн ий үйлдвэрлэл Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх үйл ажиллагаа	Хувцас үйлдвэрлэл  Нэхмэл	Резин болон хуванцар бүтээгдэхүүн  Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	Эмийн бүтээгдэхүүн, эмнэлгийн бүтээгдэхүүн  Нэхмэлийн үйлдвэрлэл
----------------------	---	------------------------------------	--	---

Ерөнхийдөө манай улсын хувьд засгийн газраас авч хэрэгжүүлж буй хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд харьцангуй бага харгалзаж үздэг хөнгөн үйлдвэрлэлд нөлөөлөгч хүчин зүйлс үйлдвэрлэл өндөр хөгжсөн орнуудад нэн чухалд тооцогдож, төр засгийн газар нь тэдгээрийг бодлого үйл ажиллагаандаа тусгаж, тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байна. Чухалд тооцогдож байгаа хүчин зүйлсэд санхүүжилт болон инноваци гэсэн хоёр үзүүлэлт орж байгаа юм. Бизнесийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг улс орнууд хувийн хөрөнгө оруулалтын болон төр, хувийн хэвшлийн хамтын оролцоонд тулгуурласан хамтын сан байгуулах замаар бизнес эрхлэгчдэд ногдол ашгаа хойшлуулж, төлбөрийн чадварын эрсдэлээс зайлсхийх боломжийг олгосон өмчийн санхүүжилтийг бүтээлчээр ашиглах замаар бий болгож байна.

Түүнээс гадна инноваци нь үйлдвэрлэлийн хөгжилд хамгийн чухал үзүүлэлт мөн гэдгийн хүлээн зөвшөөрч шинэ технологийг хөгжүүлэхтэй холбоотой төрөл бүрийн дэмжлэг үзүүлж байгаа нь харагдаж байна. Тухайлбал, инновацийн сан байгуулагдаж, мэдлэгт суурилсан өндөр технологийг гаргаж авах, гаргаж авсан технологио нутагшуулах чиглэлээр төр болон хувийн хэвшил, судалгааны хүрээлэнгүүд хоорондоо нягт хамтран ажиллаж байна.

Ерөнхийдөө улс орнууд өөрийн онцлогт тохирсон эдийн засаг, аж үйлдвэрийн бодлогыг хэрэгжүүлж байгаа бөгөөд шинэ технологи, үйлдвэрлэл явуулах таатай орчинд суурилсан үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхийг нийтлэг байдлаар эрмэлзэж байна. Жишээ нь Хятад улс хатуу тогтоосон валютын ханшны бодлого, макро эдийн засгийн тогтвортой байдал, хямд ажиллах хүчний нөөц, өндөр технологи болон сэлбэг хэрэгслийн импорт, хурдны галт тэрэг, дэд бүтцийн хөгжил, үлэмж хэмжээний зах зээл, их хэмжээний үйлдвэрлэл<sup>128</sup>, кластерийн оновчтой сүлжээ зэргээр дамжуулан үйлдвэрлэлийн орцууд, нэгж бүтээгдэхүүний өртгийг бууруулах нөхцлийг бүрдүүлж байгаагийн зэрэгцээ харьцангуй бага зардлаар бүтээгдсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн нь дэлхийн улс орнуудын хэрэглэгчдийн анхаарал, сонирхлыг татаж, их хэмжээний борлуулалт хийх боломжийг олгож байна.

Түүнээс гадна үйлдвэрлэл өндөр хөгжсөн орнууд хүний нөөцийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, шинжлэх ухааныг хөгжүүлэх, санхүүжилтийн сонирхолтой арга хэлбэрүүдийг ашиглах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, төрийн худалдан авалтын аж үйлдвэрийн салбарыг дэмжихэд чиглэгдсэн стратегийг хэрэгжүүлэх, төрийн бодлогуудын уялдаа холбоог сайжруулах, дэд бүтцийг таатай болгох зэрэг олон төрлийн нэгдмэл арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Улс орнуудын зүгээс үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн олон сонирхолтой арга хэмжээг судалгаанд оруулсан тул судалгааны дэлгэрэнгүйгээс эдгээрийн

<sup>128</sup> Их хэмжээний үйлдвэрлэл нь тогтмол зардлын нөлөөгөөр нэгж бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулдаг.



талаар дэлгэрэнгүй уншиж танилцах боломжтой.

## **СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ**

### **1. Онол, арга зүй**

#### **1.1 Эдийн засгийн салбаруудын ангилал, тэдгээрийн онцлог**

Хөнгөн үйлдвэрлэл нь manufacturing буюу боловсруулах үйлдвэрлэлд хамаарах бөгөөд боловсруулах үйлдвэрлэл нь аж үйлдвэрийн (Industrial) салбарын нэгэн гол төлөөлөл юм. Орчин үед улс орнууд өөрсдийн ДНБ-ийг ижил нэг стандартаар тооцож байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар тооцоходоо эдийн засгийн салбар нэгжүүдийн үйлдвэрлэлийн хэмжээг нэгтгэж ерөнхий үр дүнг тодорхойлдог. Түүнээс гадна хамгийн тойм байдлаар ДНБ-ийг хөдөө аж ахуй, аж үйлдвэр, үйлчилгээний салбаруудаас бүрдэнэ гэж үздэг.

Хөдөө аж ахуйн салбарт мал аж ахуй, газар тариалан ойн аж ахуй, ан агнуур, загас агнуур зэрэг ордог бөгөөд энэхүү салбарын үйл ажиллагаа нь технологи, хүнд метал үйлдвэрлэлийн хүчин зүйлсэд нь бага оролцдог онцлогтой байдаг.

Аж үйлдвэрийн салбарт боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, цахилгаан хий, усан хангамж гэх зэрэг салбарууд орно. Тэгвэл эндээс Industry буюу аж үйлдвэрийн салбар нь ДНБ-ний томоохон хэсэг бөгөөд энэ ангилалд боловсруулах үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хөнгөн үйлдвэрлэлийн салбар тус тус харьяалагдана гэж эхэнд хэлсэн ангиллыг урвуугаар нь тодорхойлж болно. Аж үйлдвэрийн салбарын нэлээд хэсэг нь (industrial sector) хүнд машин механизм, нүсэр технологийг ашиглаж байгалийн нөөц баялгийг байгаа чигээр нь олборлож гаргах, үйлдвэрлэлийн гол орцууд, дэд бүтцийг бий болгоход чиглэгддэг бөгөөд гаргаж авсан байгалийн нөөц баялаг, бий болгосон бүтээн байгуулалт нь боловсруулах салбарын үйлдвэрлэлийн гол түүхий эд, өсөлт хөгжлийнх нь үндэс болж байдаг. Харин боловсруулах салбарын бий болгосон бүтээгдэхүүнийг үйлчилгээний салбараар дамжуулан эцсийн хэрэглэгчдэд хүргэдэг.

Үйлчилгээний салбарын ангилалаас тооцоход сонирхол татдаг гэж хэлж болох хоёр төрөл байдгийн нэг нь санхүүгийн салбар, нөгөөх нь төрийн удирдлагын салбар юм. Санхүүгийн салбарын хувьд санхүүгийн үйлчилгээ үзүүлсний цэвэр орлого ДНБ-д тооцогдож байдаг онцлогтой. Тухайлбал, банкны зээлийн болон хадгаламжийн хүүний зөрүү, даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн ялгавар, санхүүгийн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсний шимтгэл хураамж зэргийг ДНБ-д тооцож оруулж байдаг.

Санхүүгийн үйлчилгээ үзүүлсэний төлбөр, хураамжийн хэмжээ нь үндэсний тооцооны систем дэх санхүүгийн салбарын оролцоог харуулах бөгөөд эдийн засаг дахь нийт мөнгөн орлогын нэгээхэн хэсэг болж байдаг. Нөгөө талаас санхүүгийн үйлчилгээ авсан бизнесүүд шимтгэл хураамжийг өөрсдийн орлогоос төлөх бөгөөд шимтгэл хураамж төлсний дараа үлдэх мөнгөн орлого нь бизнесийн мөнгөн орлогын бие даасан бүрэлдэхүүн болж үндэсний тооцооны системд бүртгэгдэж байдаг.

ДНБ-ийг салбарын үйлдвэрлэлээр тооцоход сонирхол татдаг нэгэн бүрэлдэхүүн хэсэг бол “төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал” гэсэн ангилал юм. Үүнд боловсрол, соёл урлагийн үйлчилгээ, гадаад харилцаа, батлан хамгаалах, нийгмийн хэв журам, аюулгүй байдал зэрэг үйлчилгээнүүдийг хамруулдаг. Эдгээрийг засгийн газрын худалдан авалтын зардалтай харьцуулахад хавьгүй бага байх



бөгөөд энэ нь нэг талаас эдийн засгийн мөнгөн орлогын хуваарилалтын бүрэлдэхүүн, нөгөө талаас төрөөс үзүүлж буй нийгмийн бараа бүтээгдэхүүнийг харуулдагтай холбоотой гэж хэлж болно.

Засгийн газрын зардал нь ДНБ-ний 30 орчим хувийг эзэлдэг байхад, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал гэсэн ДНБ-ний ангилалд хамаарах бүрэлдэхүүн хэсгийн ДНБ-д эзлэх хэмжээ дунджаар 4 хувь байгаа нь ДНБ-ийг салбаруудын гүйцэтгэх үүргээр тодорхойлох үед засгийн газрын зардал бүхэн тухайн жилд нийгмийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ болдоггүй, бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоход чиглэгдэж төр, захиргааны байгууллагуудын материаллаг агуулгыг нь хангаж байдаг болохыг харуулж байгаа юм. Үйлчилгээний салбарыг манай улс хэрхэн ангилж байгаа болохыг дор харуулав.

- ✓ Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ
- ✓ Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа
- ✓ Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ
- ✓ Мэдээлэл, холбоо
- ✓ Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа
- ✓ Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа
- ✓ Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа
- ✓ Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа
- ✓ Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал
- ✓ Боловсрол
- ✓ Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа
- ✓ Урлаг, үзвэр, тоглоом, наадам
- ✓ Үйлчилгээний бусад үйл ажиллагаа
- ✓ Бүтээгдэхүүний цэвэр татвар

## **1.2 Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын онцлог**

Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын бусад салбараас ямар ялгаатай болохыг системтэйгээр тайлбарлахын тулд боловсруулах салбарын онцлогийг товч авч үзэх нь зүйтэй юм. Боловсруулах салбар нь түүхий эд материалыг тодорхой арга хэрэгсэл, хөдөлмөр, машин тоног төхөөрөмж, химийн урвал зэргийг ашиглан эцсийн бүтээгдэхүүн болгож хувиргах үйл явцыг удирдан зохион байгуулах цогц үйл ажиллагааг эрхэлдэг.

Томоохон боловсруулах салбарын үйлдвэрүүд нь угсрах, бүтээх зориулалтын үйл явц, дэвшилтэт технологийг ашиглаж бараа, бүтээгдэхүүнийг их хэмжээгээр үйлдвэрлэх боломжтой байдгаараа давуу талтай байна. Үр өгөөжтэй боловсруулах үйлдвэрлэлийн арга техник нь тоо хэмжээний давуу талыг ашиглан үлэмж хэмжээний бүтээгдэхүүнийг харьцангуй бага зардлаар үйлдвэрлэх боломжийг үйлдвэрлэл эрхлэгчдэд олгодог. Нөгөө талаас цахилгаан, дулаан, түрээс зэрэг тогтмол зардлуудын нөлөөгөөр бүтээгдэхүүний тоо хэмжээний өсөлт нэгж бүтээгдэхүүний нийт өртгийг бууруулах боломжтой болгоно.

Ерөнхийдөө боловсруулах үйлдвэрлэл нь өртөг нэмэх үйл явц бөгөөд энэ нь эцсийн нэгж бүтээгдэхүүнд ашигласан түүхий эд материал, гаргасан бусад зардлуудаасаа илүү өндөр үнээр бүтээгдэхүүнээ борлуулах боломжийг олгодог чухал салбар тул олон нийтийн мэдээ, мэдээллийн хэрэгслүүд боловсруулах үйлдвэрлэлийн талаар байнга мэдээлж, эдийн

засагч, судлаачид энэ төрлийн үйлдвэрлэлийн талаар тогтмол судалж, үнэлэлт, дүгнэлт өгч байдаг.

Хөнгөн үйлдвэрлэл нь үндсэн хөрөнгө буюу харьцангуй бага капитал ашигладаг онцлогтой. Энэ салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь завсрын үйлдвэрлэгчдийн түүхий эдийг гэхээсээ илүү эцсийн хэрэглэгчдэд чиглэгдсэн байдаг. Үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг түлхүү хэрэглэдэг онцлогтой салбарын үйлдвэрлэлтэй харьцуулахад хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөө нь харьцангуй бага байх тул хүн ам оршин сууж байгаа хот, суурин газраас холгүй үйлдвэрлэл явуулахыг нь зөвшөөрдөг.

Хүнд үйлдвэрлэлтэй харьцуулахад хөнгөн үйлдвэрлэл нь мөн нэлээд тохиолдолд харьцангуй бага хэмжээний түүхий эд материал, эрчим хүчийг хэрэглэдэг, үйлдвэрийн барилга байрлах талбай нь ч харьцангуй бага байх боломжтой байдаг.

Ийм жишээнд компьютер, гар утас, электроникийн болон түүний эд ангиудыг угсрах үйлдвэрүүдийг оруулж болно. Ерөнхийдөө хөнгөн үйлдвэрүүд нь автозам болон төмөр замын замын ойролцоо, нэг дор төрөлжсөн байдлаар, бизнесийн парк, аж үйлдвэрийн бүс нутаг, хөрөнгө оруулалт, шинжлэх ухааны паркуудад байрладаг. Түүнээс гадна хөнгөн үйлдвэрлэлийн салбар нь хүнсний бүтээгдэхүүн, цаас, хуванцар бүтээгдэхүүн, арьс шир, нэхмэл эдлэл, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөнөөр агуулдаг. Гэхдээ хөнгөн үйлдвэрлэлийн салбарын зарим үйлдвэр их хэмжээний агаарын бохирдол үүсгэх сөрөг нөлөөтэй байдаг бөгөөд үүнийг нь төрөөс байнга хянаж байх учиртай юм.

Хүнд үйлдвэрлэлийн салбартай харьцуулахад улирлын онцлогоос шалтгаалж үйлдвэрлэл нь зогсох, өөрчлөгдөх шалтгаан бараг байхгүй. Тухайлбал, уул уурхайн үйлдвэрлэл урин улиралд ихэнхдээ явагдаж байдаг. Түүнээс гадна хөнгөн үйлдвэрлэлийн үйлдвэрээс гарсан хог хаягдал нь харьцангуй авсаархан, тээвэрлэхэд бүсчлэлийн болон бусад хязгаарлалтад ордоггүй, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь ч овор, жин багатай байдаг. Хөнгөн үйлдвэрлэлийн салбар нь эцсийн хэрэглэгч бүрт бүтээгдэхүүнээ хүргэдэг онцлогтойгоос шалтгаалан түүхий эд материалд ихээр анхаардаг байхад хүнд үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрүүд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь бусад бизнесийн, ялангуяа боловсруулах салбарын үйлдвэрүүдийн хэрэгцээнд нийцсэн байхыг чухалд үздэг. Тийм ч учраас хөнгөн үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрүүдийн хувьд түүхий эд материалаасаа ойр байх нь нэн ач холбогдолтой байдаг бол хүнд үйлдвэрлэлийн салбар нь түүхий эд материалаасаа ойр байх нь өөрөөс нь хамаарахуйц, хэрэгжүүлэх боломжтой зүйл биш юм.

Ер нь хүнд үйлдвэрлэлийн салбар томоохон хэмжээний үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт хийж байдаг, бүтээгдэхүүн нь нэг стандарттай байх тул өрсөлдөөний орчин султай, нэгэнт үндсэн хөрөнгийн шингээлт ихтэй байдаг учраас ихэнхдээ урт хугацаат эх үүсвэрийг дайчилж, санхүүжилтийнхээ асуудлыг шийддэг онцлогтой байна. Харин хөнгөн үйлдвэрлэлийн салбар нь харьцангуй бага хөрөнгө оруулалт хийдэг, бүтээгдэхүүн нь технологийн өөрчлөлт, хөгжлөөс шалтгаалж өөрчлөгдөж, хөгжиж байдаг болохоор өрсөлдөөний орчин өндөртэй, харьцангуй өндөр хэмжээний эргэлтийн хөрөнгө, богино хугацаат санхүүжилт нь хөрөнгө, эх үүсвэрийн онцлогийг тодорхойлж байдаг.

Манай улсын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь хөнгөн үйлдвэрлэлийн салбарт дараах бүтээгдэхүүн үйлчилгээг хамруулан бодлого, үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Үүнд:

- ✓ Ноос ноолууран бүтээгдэхүүн
- ✓ Арьс ширэн бүтээгдэхүүн
- ✓ Оёмол бүтээгдэхүүн
- ✓ Мод, модон эдлэл
- ✓ Хэвлэлийн үйлдвэрлэл
- ✓ Сав баглаа боодлын үйлдвэрлэл
- ✓ Барилгын материал
- ✓ Дахин боловсруулах үйлдвэр
- ✓ Гоо сайхны бүтээгдэхүүн зэрэг орж байна.

### 1.3 Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжилд нөлөөлөгч хүчин зүйлс

Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжилд нөлөөлөгч хүчин зүйлс нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хөгжилд нөлөөлөгч хүчин зүйлстэй олон талаараа төстэй юм. Учир нь мөн чанарын дурдсан хоёр салбар ижил бөгөөд боловсруулах салбарын үйлдвэрлэлийн нэгээхэн гол төлөөлөгч нь хөнгөн үйлдвэрлэлийн салбар гэж тооцогддог. Иймд аж үйлдвэрийн болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хөгжилд ямар хүчин зүйлс нөлөөлдөг болохыг олон төрлийн эх сурвалж ашиглаж тодорхойлсныг юуны өмнө товч авч үзье.

Зураг 25. Үйлдвэрлэлийн хөгжилд нөлөөлөгч хүчин зүйлс

	Өрсөлдөөн	Байршил	
Технологи	Үйлдвэрлэлийн хөгжил		Засгийн газрын бодлого
Хүний нөөц			Байгалийн хүчин зүйлс
Санхүүжилт			Зах зээл
Менежерийн ур чадвар	Түүхий эд	Макро эдийн засаг	Дэд бүтэц

#### ✓ **Технологи**

Технологийн хөгжил нь үйлдвэрлэлийн гарцад нөлөөлөх чухал хүчин зүйл юм. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл явцад сэдэл өгч, механик сайжруулалт хийх нь үйлдвэржилтийг ахисан шатанд хүргэн хурдасгаж, шинжлэх ухаан технологийн хэрэглээг идэвхжүүлэн урьд нь судлагдаагүй, төсөөлөө ч үгүй байсан, олон зүйлсийг шинээр бий болгож, хүмүүсийн сэтгэл ханамжийг үлэмж дээшлүүлдэг. Технологийн хүчин зүйлүүдэд механикжуулалт, Ноу хау, бүтээгдэхүүний дизайн зэрэг ордог бөгөөд эдгээр нь үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулах нөлөөг үзүүлдэг. Тухайлбал технологийн шинэ нээлт, хагас болон бүрэн автомат машинууд, үйлдвэрлэлийн процесст хийгдсэн өөрчлөлтүүд зэрэг нь бүтээгдэхүүний шинж чанарыг өөрчлөхийн зэрэгцээ гарцыг ч өсгөн нэмэгдүүлдэг.



#### ✓ **Хүний нөөц**

Ямар ч үйлдвэрийн газарт хүний хүчин зүйл маш чухал үүрэгтэй. Хэрэв хүний хүчин зүйл буюу хөдөлмөрийн нөөц гүйцэд бэлтгэгдээгүй, ур чадвар нь хангалттай бус, мөн

хөдөлмөрийн нөөцийг дэмжигч хүчин зүйлс зохих үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэхтэй холбоотой хийгдсэн бүхий л алхам, үйл явц үр дүнгүй болно. Ажилчдын гүйцэтгэл, хандлага үйлдвэрлэлийн бүхий л салбарын үйл ажиллагаанд чухал нөлөөтэй. Хүний нөөцийн чанарын хүрээнд ажилчдын ур чадвар, ажилчдын бэлэн байдал, ажилчдын ажиллах орчин гэсэн гурван үзүүлэлтийг чухалд үзэх учиртай байдаг.

түвшинд бүрдээгүй байвал



shutterstock.com · 1294326856

#### ✓ **Санхүүжилтийн боломж**

Технологийн сайжруулалт хийх, ажилчдын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний санхүүгийн нөөц байхгүй бол үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжийг өсгөх томоохон төлөвлөгөө үйлдвэрийн ямар ч газрын хувьд мөрөөдөл төдий зүйл байх болно. Механикжуулалтын түвшин хэдий чинээ их байх ёстой болно, тэр хэмжээгээр үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж, санхүүжилтийн хэрэгцээ өндөр байна.



Санхүүжилт, ялангуяа урт хугацаат санхүүжилт, өмчийн санхүүжилт нь судалгаа хөгжил, сурталчилгааны компанит ажил, ажилчдын орчин нөхцлийн таатай байдал, машин, тоног төхөөрөмжийн сайжруулалт зэрэгт нөлөөгөө шууд үзүүлж байдаг гэж хэлж болно.

#### ✓ **Менежерийн ур чадвар**

Менежерийн ур чадварын ач холбогдол технологийн дэвшлийг дагаад өсөн нэмэгдэж байна. Мэргэжлийн менежерүүд технологийн хөгжил, дэвшлийг илүүтэй ашиглах шаардлагатай болж байна. Орчин үеийн бизнесүүд харьцангуй их хэмжээний бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэж байгаа бөгөөд төсөөлөл, нэгдсэн шинжилгээ, дүгнэлт, бэлэн байдал зэрэг чадваруудад өндөр ач холбогдлыг өгч бүтээгдэхүүн үйлчилгээг нэг ижил стандарттай болгоход анхаарал тавих ёстой болж байна. Менежерүүд өөрсдийн мэргэжлийг ур чадварын өндөр түвшинд эзэмшсэн байхаас гадна бизнесийн эзэд, ажилчид, хэрэглэгч, нийлүүлэгч, засгийн газар, нийгэмд чиглэгдсэн нийтийн хариуцлагыг ойлгож, ухамсарлах ёстой болж байна. Хэрэв менежерүүд байгууллагаа үр ашигтай удирдахыг хүсч л байгаа бол удирдах ур чадвар туйлаас чухал. Менежерүүд үзэл баримтлалтай, хүний харилцааны олон талт чадварыг эзэмшсэн, техникийн тодорхой ур чадваруудыг эзэмшсэн байж гэмээнэ үйлдвэрлэлийн үйл ажиллагааны чанар, бүтээмжийг дээшлүүлж чадах юм.



#### ✓ **Засгийн газрын бодлого**

Засгийн газрын аж үйлдвэрлэлийн чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлого үйлдвэрлэлийн хөгжилд маш чухал нөлөөтэй. Засгийн газар нь хадгаламж, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн нэг сектороос өөр нэг сектор уруу мөнгө, хөрөнгийн урсгал шилжих үйл явц, байгалийн нөөц баялгийг сахин хамгаалалт зэрэгт чиглэгдсэн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх ёстой. Зарим нэг үйлдвэрүүдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх,



үндэсний сонирхолд нийцсэн идэвхжүүлэх, хязгаарлах бодлогыг хэрэгжүүлэх шаардлага хөгжлийн хувьд чухлаар тавигддаг. Засгийн газар бизнесийн өсөлт хөгжилд чөдөр тушаа болж байгаа татварын бодлогыг эргэн харж, өөрчлөх, сайжруулалт хийх, монополь буюу давамгайл байдлаар аж ахуйн нэгжүүд, үйлдвэрийн газрын өсөлт, тэлэлтэд хяналт тавих, хэрэглэгч болон ажилчдыг эрсдэлд оруулах аюулаас урьдчилан зэрэг арга хэмжээг авч байх учиртай юм. Түүнээс гадна төр, засгийн газар нийгмийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтээр дамжуулан хүний нөөцийн боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны хөгжил, стандартын шаардлага, цаг үеэ олсон хууль эрх зүйн орчны шинэчлэлт, тогтвортой байдал, дэд бүтцийн орчин зэрэг үйлдвэрлэлийн гол орцуудын үйлдвэрлэлд шууд болон шууд бусаар дэмжлэг үзүүлэхүйц үйл ажиллагааг явуулж байх ёстой байдаг.



#### ✓ **Байгалийн хүчин зүйлс**

Биет нөлөөлөл, газар зүй, цаг агаарын нөхцөл байдал үйлдвэрлэлийн хөгжилд томоохон нөлөөг үзүүлж байдаг. Эдгээр хүчин зүйлсийг ямар түвшинд авч үзэх нь тухайн үйлдвэрлэлийн онцлог, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний мөн чанар, биет нөхцөл байдлын нөлөөллийг хянах боломж зэргээс шалтгаалдаг.

Геологийн болон физикийн хүчин зүйлүүд нь нүүрсний уурхай зэрэг олборлох үйлдвэрлэлийн салбарын бүтээмжийг тодорхойлоход нэн чухал үүрэгтэй. Тухайлбал нүүрсний уурхайн үйлдвэрлэл, бүтээмж нь уурхайн гүн, нүүрсний давхаргын нягтаршил, тухайн газар нутгийн өндөрлөг, нөөц оршиж байгааг газрын хэлбэр, овойлт зэргээс ихээхэн хамаарч байдаг. Харин оёдол, үр тарианы тээрмийн үйлдвэрлэл, нэхмэл бүтээгдэхүүнүүд, саван, чихэр, нарийн, бүдүүн ширхэгтэй хөвөн, даавуу зэрэг үйлдвэрүүдийн хувьд газар зүй, геологи, физикийн буюу биет хүчин зүйлүүд нь харьцангуй бага нөлөөтэй.

#### ✓ **Зах зээл**

Зах зээлийн багтаамж ямар байгаагаас бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тоо хэмжээ шууд шалтгаалдаг. Хэрэв зах зээл багтаамж өндөртэй, хэрэглэгчдийн худалдан авалт харьцангуй эрчимтэй байвал бүтээгдэхүүний борлуулалт, үйлдвэрлэл өсөх, ашиг орлого нэмэгдэх боломж илүүтэй бүрдэж байдаг. Зах зээлийн багтаамж бага, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь шинж чанарын хувьд амьдралын мөчлөгийнхөө дээд юм уу аль эсвэл уруудах түвшинд хүрсэн бол борлуулалтын хэмжээ буурч, тогтмол зардлын нөлөөгөөр цэвэр ашиг нь багасч байдаг. Нөгөө талаас хэрэглэгчдийн ангилал, тухайлбал байршил, орлого, нас, хүйс, сонирхол, соёл зэрэг хүчин зүйлүүд нь худалдан авалтын хандлага буюу зах зээлийн ерөнхий багтаамж, төлвийг тодорхойлдог.



#### ✓ **Дэд бүтэц**

Дэд бүтцийн хувьд эрчим хүч, дулаан, усан хангамж, агаарын болон хуурай зам, гүүр, усан замын тээвэр, холбоо, тээвэр ложистик зэрэг бүтээн байгуулалтын салбарын

нөхцөл байдал, чанарын үзүүлэлт нь үйлдвэрлэлийн хөгжилд нөлөөгөө шууд үзүүлж байдаг гэж хэлж болно. Эдгээр салбаруудын үйлдвэрлэлийн хэмжээ, өртөг ямар байхаас эцсийн бүтээгдэхүүний ялангуяа үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүний зах зээлийн үнэ шалтгаалдаг. Учир нь дэд бүтцийн салбарын оролцоогүй бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн үйл явц бараг байдаггүй. Харьцангуй дэд бүтцийн салбар нь сайтар хөгжсөн улс орны бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, борлуулалтын өртөг хямд, өрсөлдөх чадвар нь сайн байна.

#### ✓ **Байршил**

Үйлдвэрлэлийн байршил бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтад мөн л чухал нөлөөг үзүүлдэг. Үйлдвэрлэл явуулж буй газар ашиглаж буй түүхий эдээсээ, суурин хүн амаас буюу хэрэглэгчдээсээ хэр зэрэг зайтай байх нь тээврийн зардалд шууд нөлөөлдөг. Мөн эрчим хүчний хангалтын хүчин чадал тухайн бүс нутаг, суурин газрын байрлалаас шалтгаалж харилцан адилгүй байж болно. Зарим үед томоохон үйлдвэрийн газрууд цахилгааны бие даасан үйлдвэрийг үйл ажиллагаандаа зориулан барьж байгуулах ч тохиолдол байдаг. Мөн үүрэн болон суурин холбооны тоног төхөөрөмжийг ямар бүс, нутагт орших, хэдэн тооны хэрэглэгчдэд зориулж, ямар хүчин чадалтайгаар суурилуулснаас шалтгаалж тухайн үйлдвэрийн газрын харилцаа холбооны зардал тодорхойлогдох боломжтой.



Төрөөс явуулж буй бүс нутгийн хөгжлийн бодлого, үзүүлж буй төрөл бүрийн дэмжлэг зэрэг нь үйлдвэрлэлийн хөгжилд нөлөөлөх нь дамжиггүй юм. Мөн тухайн бүс нутагт хөдөлмөрийн ямар нөөц байгаа, ажиллах хүчний ур чадвар, бэлтгэлжилтийн түвшин ямар байгаагаас үйлдвэрлэлийн бүтээмж, хөгжил шалтгаалж байдаг.

#### ✓ **Түүхий эд материалын нөөц**

Түүхий эд материалын нөөцийн олдоц, нийлүүлэлт нь зах зээлд ямар байгаа, хэдэн төгрөг, доллар зарцуулсны үр дүнд бий болдог, ямар үнээр үйлдвэрлэгчдэд нийлүүлэгдэж байгаа, хэдэн км-ийн зайд орших үйлдвэр, аж ахуйн газраас түүхий эдийн татан авалтыг хийж байгаа зэрэг нь бүтээгдэхүүний үйлдвэрлэл, өртөг үнэд шууд нөлөөлж байдаг.

Олдоц сайтай, хямд үнэтэй, ойроос хангалт, татан авалтыг хийж байгаа бол үйлдвэрлэлийн өртөг, зардал харьцангуй бага байна. Бүтээгдэхүүн, үйлчилгээний шууд зардлын дөрвөн үндсэн бүрэлдэхүүн болох үндсэн материал, хөдөлмөр, элэгдэл хорогдлын шимтгэлийн нийлбэрт үндсэн материалын зардал бие даасан, томоохон хэсгийг эзэлдэг.

#### ✓ **Өрсөлдөөний орчин**

Ижил төстэй бизнес эрхлэгчдийн тоо, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэмжээ, хэрэглэгчдийн хэрэглээний давтамж, бүтээгдэхүүний шинж чанар, үнэ, өртөг зэрэг нь өрсөлдөөний орчныг ерөнхийд нь тодорхойлдог. Төсөөтэй үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдийн тоо олон, бүтээгдэхүүний нийлүүлэлт их хэмжээтэй байх тутам тухайн бизнесийг өрсөлдөөн харьцангуй өндөртэй орчинд ажиллаж байна гэж үздэг. Өрсөлдөөний орчныг өрсөлдөөний зэрэг буюу өрсөлдөөний хүч, орлох бүтээгдэхүүний бэлэн байдал, худалдан авагчдын хэлэлцээр буюу тогтвортой харилцаа, нийлүүлэгчдийн хэлэлцээр, гэрээ, үнийн санал, шинэ өрсөлдөгчдийн аюул зэрэг хүчин

УИИМАН  
СҮДАЛГААНЫ САН




зүйлүүдийн хувьд тодорхойлж болно. Эдгээр хүчин зүйлсийг Портерийн таван хүч гэж нэрлэдэг.

### Макро эдийн засаг, салбарын нөхцөл байдал

Макро эдийн засаг, салбарын нөхцөл байдал нь тухайн үйлдвэрийн газар, бизнесийн үйл ажиллагаа явагдах эдийн засгийн ерөнхий орчинг тодорхойлж өгдөг гэж хэлж болно. Макро эдийн засаг болон салбарын нөхцөл байдлын хүрээнд нөлөөлөгч хүчин зүйлсийг дараах зурагт харуулав.

Зураг 26. Гадаад эдийн засгийн орчин




Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Зурагт харуулсан схемийг дэлгэрүүлж авч үзвэл доорх байдалтай байна. Тухайлбал,

- ✓ Гадаад эдийн засгийн нөхцөл, экспорт, импорт, валютын ханш
- ✓ ДНБ-ний өсөлт
- ✓ Ажилгүйдэл
- ✓ Төсвийн алдагдал
- ✓ Орлого хуваарилалт
- ✓ Инфляц
- ✓ Олон нийтийн хүлээлт, сэтгэл хөдлөл
- ✓ Мөнгөний болон сангийн бодлого
- ✓ Нийт эрэлт, нийт нийлүүлэлтэд гарсан өөрчлөлт, шок
- ✓ Бизнесийн мөчлөг буюу ДНБ-ний өсөлт, бууралт
- ✓ Салбарын шинжилгээ

Зураг 27. Салбарын амьдралын мөчлөг

Гадаад эдийн засгийн өөрчлөлт, нөлөөлөлд зохистой хариу үйлдэл үзүүлдэг, макро эдийн засгийн үзүүлэлтүүд үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд тааламжтай, өөрчлөлт нь тогтвортой, мөнгө, санхүүгийн бодлого нь оновчтой буюу үр дүнтэй, эрэлт, нийлүүлэлт үндэсний хэмжээнд тогтвортой өсөн нэмэгдсэн, бизнесийн мөчлөгийг дагасан болон сөрсөн онцлогтой байх хэдий ч үйл ажиллагаагаа жигд явуулж чаддаг сайн удирдлагатай, салбарын амьдралын мөчлөг нь өндөр өсөлтийн шатандаа байгаа бизнесийн орлого, ашиг өндөр байсаар байх боломжтой байдаг.



Эх сурвалж: Bodie Kane Marcus

Онолын хувьд ерөнхийдөө дараах хүчин зүйлс үйлдвэрлэлийн салбарт нөлөөлдөг байна:

- ✓ Санхүүжилтийн боломжит төрлүүд
- ✓ Түүхий эдийн нөөцөд түшиглэсэн бүс нутгийн cluster-ын хөгжил, хамтын ажиллагаа
- ✓ Дэд бүтцийн орчин, ложистик
- ✓ Тодорхой үйлдвэрлэлд төрөөс олгож буй зээл, санхүүжилтийн төрлүүд (ОУ-н байгууллага)
- ✓ Гадаадын хөрөнгө оруулалт
- ✓ Татвар, татаасын хөнгөлөлт
- ✓ Шинжлэх ухаан технологи, инновацийн хүрээнд үзүүлж буй дэмжлэг, хамтын ажиллагаа
- ✓ Өрсөлдөөний бодлого, импорт болон орлох бүтээгдэхүүнээс хамгаалсан..
- ✓ Хүний нөөцийг хөгжүүлэх, жишээ нь мэргэжлийн сургалтууд
- ✓ Дотоод, гадаадын зах зээлийн өргөжилт

## 2. Эмпирик судалгааны хэсэг/Монгол улс/

### 2.1 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг бүрдүүлэгч салбарын үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, онцлог

Юуны өмнө ДНБ-ний 2015-2019 оны хооронд ямар байсан болохыг тойм байдлаар авч үзье.

Хүснэгт 18. Монгол Улсын ДНБ, ДНБ-ийг бүрдүүлэгч үйлдвэрлэлийн салбарын үндсэн бүрэлдэхүүний динамик


Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Хөдөө аж ахуй	3,091,999	2,798,773	2,865,391	3,495,733	4,026,563
Аж үйлдвэр	6,208,007	7,163,041	9,662,572	11,466,960	12,924,680
Барилга	977,999	949,053	1,029,777	1,191,064	1,411,043
Үйлчилгээ	12,872,380	13,032,000	14,318,557	16,257,467	18,918,555
ДНБ	23,150,386	23,942,866	27,876,297	32,411,224	37,280,841

Эх сурвалж: 1212.mn, СЕГ

Дээрх зургаас Монгол Улсын ДНБ, түүнийг бүрдүүлэгч салбарууд 2019 оныг хүртэл жил бүр өсөлттэй байсан болохыг харж болно.

Зураг 28. ДНБ-ний бүтэц, дундаж утгаар

Монгол Улсын ДНБ-ний бүтцээс нийт үйлдвэрлэлийн дунджаар 52 хувийг үйлчилгээ, 37 хувийг үйлдвэрлэл, үлдсэн 11 хувийг хөдөө аж ахуйн салбар тус тус эзэлж байна. Дэлхийн дунджаар ДНБ-ний 6 орчих хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байгаагаас манай улсын эдийн засаг хөдөө аж ахуйн салбараар харьцангуй өндөр хамааралтай болох нь харагдаж байна.




Эх сурвалж: 1212.mn, СЕГ

Industry буюу нийт үйлдвэрлэлээс барилгын салбарыг салгаж эдийн засгийн секторуудыг үйлчилгээ, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, барилга гэсэн бүтэцтэйгээр харвал 2015-аас 209

оны хооронд нэрлэсэн динамик үзүүлэлт нь дараах байдалтай байна.

Зураг 29. Үндсэн салбаруудын үйлдвэрлэлийн динамик




Эх сурвалж: 1212.mn, CEF

Дээрх зургаас эдийн барилга, ХАА-н салбарын үйлдвэрлэл тогтвортой, харин аж үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэл өсч байгаа нь эдгээр салбарт, ялангуяа үйлчилгээний салбарт цаашид өсөлтийн боломж байгаа болох нь харагдаж байна. Үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь дэлхийн дунджаар 63<sup>129</sup> хувь байгаа.

Эдийн засгийн салбаруудын өсөлтийн динамикаас үйлчилгээ болон барилгын салбарын өсөлт жигд байхад хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн салбарын өсөлт харьцангуй жигд бус зарим жилүүдэд өсөлттэй, зарим жилүүдэд бууралттай байна. Энэ нь үйлчилгээний салбар суурь салбаруудын үйлдвэрлэлийг дагаад өсдөг, барилгын салбарыг төрөөс жигд дэмжиж байгаатай холбоотой.

Зураг 30. Салбаруудын өсөлтийн динамик




Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Эдийн засгийн салбаруудын дундаж өсөлт аж үйлдвэрийн салбарын хувьд 20.4 хувь буюу хамгийн өндөр, хөдөө аж ахуйн салбарын хувьд 7.5 хувь буюу хамгийн бага байна. Аж

<sup>129</sup> [Share of economic sectors in the global gross domestic product \(GDP\) from 2008 to 2018 | Statista](https://www-statista-com.translate.googleusercontent.com/?q=Share+of+economic+sectors+in+the+global+gross+domestic+product+(GDP)+from+2008+to+2018+|+Statista)

үйлдвэрийн салбарын өсөлт нь жигд биш байгаа, зарим жилүүдэд энэ үзүүлэлт бууралттай байсан хэдий ч утга нь харьцангуй өндөр байсан тул салбарын дундаж өсөлт хамгийн өндөр утгыг авчээ.


Зураг 31. Салбаруудын дундаж өсөлт



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

2019 оны байдлаар үйлчилгээний салбарыг задалж ДНБ-ийг эдийн засгийн секторын бүтцээр нь үзвэл аж үйлдвэрийн дийлэнх хэсгийг буюу 68 хувийг уул уурхайн олборлолт, 27 орчим хувийг боловсруулах үйлдвэрлэл, үлдсэн хэсгийг цахилгаан, усан хангамжийн үйлдвэрлэл эрхэлж байгаагаас манай улсын аж үйлдвэрийн салбарт уул уурхайн салбар томоохон байр суурь эзэлж байгаа болохыг харуулна. Үүнийг уул уурхайн үйлдвэрлэл нийт ДНБ-ний 23.2 хувийг дангаараа эзэлж байгаагаар мөн нотолж болно.

Зураг 32. ДНБ-д эзлэх салбарын үйлдвэрлэл /хувиар/



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Дээрх зургаас боловсруулах үйлдвэрлэлийн салбар ДНБ-ний 9.4 хувийг эзэлж байна. Энэ

нь дэлхийн дундаж үзүүлэлт болох 12.6<sup>130</sup> хувиас даруй 3.2 хувиар доогуур үзүүлэлт байгаа тул боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь манай улсын хувьд чухал ач холбогдолтой юм.

Мөн ДНБ-ийг бүрдүүлэгч салбаруудын үйлдвэрлэлүүдийн корреляцын шинжилгээ хийж үзэхэд үр дүн дараах байдалтай байна.

	GDP	CONS	EDU	EWS	FAI	HEALTH	MAN	MI	PASS	OTHER	TRADE	ART
GDP	1.00	0.61	0.81	0.93	0.78	0.81	0.94	0.90	0.79	0.95	0.89	0.71
CONS	0.61	1.00	0.47	0.48	0.53	0.53	0.53	0.48	0.49	0.63	0.72	0.52
EDU	0.81	0.47	1.00	0.71	0.90	0.97	0.75	0.65	0.96	0.76	0.63	0.84
EWS	0.93	0.48	0.71	1.00	0.69	0.73	0.88	0.84	0.70	0.86	0.78	0.72
FAI	0.78	0.53	0.90	0.69	1.00	0.89	0.69	0.62	0.83	0.75	0.60	0.86
HEALTH	0.81	0.53	0.97	0.73	0.89	1.00	0.74	0.66	0.95	0.75	0.64	0.88
MAN	0.94	0.53	0.75	0.88	0.69	0.74	1.00	0.86	0.72	0.84	0.79	0.62
MI	0.90	0.48	0.65	0.84	0.62	0.66	0.86	1.00	0.66	0.79	0.74	0.56
PASS	0.79	0.49	0.96	0.70	0.83	0.95	0.72	0.66	1.00	0.74	0.65	0.79
OTHER	0.95	0.63	0.76	0.86	0.75	0.75	0.84	0.79	0.74	1.00	0.94	0.70
TRADE	0.89	0.72	0.63	0.78	0.60	0.64	0.79	0.74	0.65	0.94	1.00	0.56
ART	0.71	0.52	0.84	0.72	0.86	0.88	0.62	0.56	0.79	0.70	0.56	1.00

Корреляцын дээрх шинжилгээний үр дүнгээс бусад үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан усан хангамж зэрэг үйлдвэрлэлийн салбарууд нь ДНБ-тай хамгийн өндөр эерэг хамааралтай байгаа болох нь харагдаж байна. Бусад үйлчилгээний хувьд харьцангуй өндөр дүнтэй байсан, цахилгаан усан хангамж нь бүх төрлийн үйлдвэрлэлийн орцод ордог тул ДНБ-тэй шууд бөгөөд эерэг өндөр хамааралтай гарсан гэж дүгнэх боломжтой. Харин боловсруулах үйлдвэрлэлийн ДНБ-тэй хамаарах хамаарал бусад салбарын үйлдвэрлэлийнхээс харьцангуй өндөр буюу 0.94 байгаа нь манай улс боловсруулах салбарынхаа үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ДНБ-ний өсөлтийг илүүтэй хангах боломж байгаа болохыг харуулж байна.

GDP	ДНБ
CONS	Барилга
EDU	Боловсрол
EWS	Цахилгаан хий, усан хангамж
FAI	Санхүү, даатгалын үйл ажиллагаа
HEALTH	Эрүүл мэнд
MAN	Боловсруулах үйлдвэрлэл
MI	Уул уурхайн олборлолт
PASS	Төрийн удирдлага
OTHER	Бусад үйлчилгээ
TRADE	Худалдаа
ART	Урлаг соёлын үйлчилгээ




## 2.2 Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал

Хөнгөн үйлдвэрлэлийн салбар аж үйлдвэрийн салбарын дунджаар 6 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 27 хувийг эзэлж байна. Үүнийг дараах зургаас харж болно.

<sup>130</sup> [Manufacturing, value added \(% of GDP\) | Data \(worldbank.org\)](https://data.worldbank.org/Manufacturing,value%20added%20(%20of%20GDP))


Зураг 33. Боловсруулах үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн хувийн жин



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Аж үйлдвэрийн салбарт хамаарах боловсруулах үйлдвэрлэлийн салбарт эзлэх хөнгөн үйлдвэрлэлийн салбарын дундаж өсөлт нь аж үйлдвэрийн салбарын дундаж өсөлтөөс арай доогуур буюу 18.4 хувь байгаа бөгөөд энэ нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын дундаж өсөлт болох 16.7 хувиас 1.7 хувиар өндөр байна.

Зураг 34. Үйлдвэрлэлийн салбаруудын өсөлт




Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын нэрлэсэн хэмжээ 2015-2019 оны хооронд буюу сүүлийн жилүүдэд өссөөр байгаа болохыг дээрх зургаас харж болно. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг бүтцийнх нь хувьд авч үзвэл дараах зурагт харуулсан байдалтай байна.



Зураг 35. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын бүтэц



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Дээрх зургаас нэхмэл буюу ноос, ноолуурын салбарын үйлдвэрлэл хөнгөн үйлдвэрлэлийн салбарын үнэмлэхүй их хувийг буюу 69.6 хувийг эзэлж байгаа болох нь харагдаж байна. Харин хамгийн бага хувийг цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл эзэлж байна. Эндээс манай улсын хөнгөн үйлдвэрлэлийн салбар мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний түүхий эд болох ноос, ноолуураас өндөр хамааралтай байна гэж дүгнэж болно.

Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдлыг үйлдвэрийн тоо, ажиллах хүчин, үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импорт зэрэг тухайн салбарын хөгжлийг илэрхийлэх үндсэн үзүүлэлтүүдтэй холбож дэлгэрэнгүй авч үзвэл дараах хүснэгтүүдэд үзүүлсэн байдалтай байна.

Хүснэгт 19. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын үндсэн мэдээлэл

Салбар	Үйлдвэр	Ажиллах хүчин	Үйлдвэрлэл /Тэрбум төг/	Борлуулалт /Тэрбум төг/
Ноос, ноолуур	327	10,000	381.8	293.8
Арьс шир	150	4,225	31.7	29.4
Оёдол	300	2,506	68.8	62.4
Модон эдлэл, тавилга	450	6,000	21.7	23.7
Хэвлэл	300	4,000	46.0	44.1

Сав баглаа боодол	50	2,000	42.0	41.1
Дахин боловсруулах	27	2,000	14.1	15.5
Гоо сайхан, ахуйн хими	30	200	8.0	4.0
Нийт	1,634	30,931	614.1	514.0

Эх сурвалж: ХХААХҮ-ийн яам

Дээрх хүснэгтээс ноос, ноолуур, оёдол, хэвлэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл манай улсын хөнгөн үйлдвэрлэлийн салбарт хамгийн өндөр хувийг эзэлдэг, хамгийн олон ажиллах хүчнийг ажиллуулдаг болох нь тодорхой харагдаж байна. Өнөөдрийн байдлаар Монголын ноолуур боловсруулах салбарын жилд бэлтгэгдэх нийт ноолууран түүхий эдийн 87 шахам хувийг “Угаасан”, “Самнасан” байдлаар экспортолж нэмүү өртөг шингээсэн эцсийн бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж чадахгүй байна.<sup>131</sup>

Хүснэгт 20. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын үндсэн мэдээлэл

Барааны нэр	Экспорт			Импорт		
	2018	2019	2020	2018	2019	2020
Ноос, ноолуур, нэхмэл бүтээгдэхүүн	409.8	434.6	477.3	90.2	85.0	85.8
Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	17.0	14.1	7.4	8.3	7.1	3.9
Мод, модон эдлэл	0.3	0.6	0.3	34.0	43.5	45.4
Цаас болон картон, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүн	0.04	0.05	0.4	61.6	56.4	53.1
Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс	1.6	1.2	0.6	226.8	260.3	223.1
Бусад	6.3	7.1	6.1	68.3	62.5	57.5
Нийт	435.04	457.65	492.1	489.2	514.8	468.8

Эх сурвалж ХХААХҮ-ийн яам:

Дээрх хүснэгтээс ноос, ноолуур, нэхмэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хамгийн их экспортыг эзэлдэг, импортын дүнгээр хамгийн өндөр хувийг хуванцар эдлэл эзэлдэг болох нь тус тус харагдаж байна. Харин арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл хамгийн бага импортыг, цаас болон картон, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүн хамгийн бага экспортыг тус тус эзэлж байна.

### 2.3 Хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр Төр, засгийн газраас хийж хэрэгжүүлсэн арга хэмжээг онолын судалгаагаар тодорхойлсон хүчин зүйлсийн хувьд ангилан хөнгөн үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүний ангилал бүрийн хувьд системтэй тодорхойллоо. Мэдээллийг дараах эх сурвалжуудаас авсан болно. Эдгээр нь:

- ✓ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2016-2020
- ✓ Жил бүрийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл
- ✓ Тухайн жилийн Яамны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан
- ✓ Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан

<sup>131</sup> [Монгол улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, дэлхийн зах зээл дээр монгол брэндийг бий болгох бизнес төсөл \(2014-2020\) \(mofa.gov.mn\)](http://mofa.gov.mn)

- ✓ Хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд, тэдгээрийн хэрэгжилт: Ноолуур хөтөлбөр, үйлдвэржилт хөтөлбөр, сав баглаа боодол үндэсний хөтөлбөр зэрэг болно.

Хүснэгт 21. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ

Төрөл	Чанар	Санхүүжилт /тэрбум төгрөг/	Түүхий эдийн нөөц	Cluster-ийн зохион байгуулалт, бүсчлэл, ложистик
Ноос, ноолуур	Олон улсад бүтээгдэхүүнээ гаргах “Хаан ширхэгт тохирлын тэмдэг”	569.216	Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хүрэлцээтэй	5 компани кластерын зарчмаар ажиллаж байна.
Арьсан эдлэл	Дархан -Уул аймгийн арьс ширний үйлдвэрт Франчайзинг нэвтрүүлэх, технологи нутагшуулах шинжилгээний 2 лаборатори	17.8	Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хүрэлцээтэй	Эмээлт орчимд ХАА-н биржийн ложистикийн төв байгуулж ажиллаж байна. “Шинэ ховд” үйлдвэрлэл технологийн парк, “Дархан арьс ширний цогцолбор” баригдаж байгаа.
Мод, модон эдлэл	Стандартчлал хэмжил зүйн газар	-	Бусад улс оронтой харьцуулахад хүрэлцээ бага	Хөнгөн болон хүнсний үйлдвэрийн хүний нөөцийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтны хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг БСШУСЯ, ХНХЯамдтай хамтран хэрэгжүүлэх, Япон зэрэг оронд дадлагажигч явуулж сургах чиглэлээр санал солилцож, судалгааг эхлүүлж байна.
Сав баглаа боодол	Стандартчлал хэмжил зүйн газар	1.06	Цаас, ноос, арьс ширний хэмжээ хүрэлцээтэй гэж үзнэ.	“Шинэ ховд” үйлдвэрлэл технологийн парк байгуулагдаж байна.
Дахин боловсруулах	13 төрлийн хог хаягдал дахин боловсруулах 20 үйлдвэрийн барилга байгууламжийн эскиз зураг	7.3	Хог хаягдал их тул нөөц хүрэлцээтэй	
Нэхмэл	Хувцас судлалын төвийн инновацийн лаборатори”-ийн нээлт	-	Ноос, ноолуур дээр тулгуурлах тул хүрэлцээтэй	
Оёдол	Стандартчлал хэмжил зүйн газар	-	Цаас, модны нөөцөөр тодорхойлогдон о.	

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Дээрх хүснэгтээс бүтээгдэхүүний чанарыг дотоодод Стандартчлал хэмжил зүйн үндэсний газраас тогтоож стандартын баталгаа өгдөг, ноос ноолууран бүтээгдэхүүн нь олон улсын стандартыг хангасан байгаа болох нь харагдаж байна. Төрөөс олгож байгаа санхүүжилтийн дийлэнх хэсгийг “Хөгжлийн банк”-аар дамжуулан зээл хэлбэрээр олгосон бөгөөд ноос, ноолуурын чиглэлийн томоохон үйлдвэрүүдийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх, түүхий

эдийн ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд зориулжээ. Гэхдээ цөөн тооны аж ахуйн нэгжүүд “санхүүжилт хүссэн дүн нь 20.0 тэрбум төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютын дүнгээс дээш байх” гэсэн хөгжлийн банкны төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангаж байна. Тухайлбал 2021 онд Засгийн газраас ажлын байрыг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд ноос, ноолуурын чиглэлийн үйлдвэрүүдийн 10 хүрэхгүй хувь нь 20 тэрбумаас доошгүй төгрөгийн санхүүжилт хэрэгтэй гэсэн хүсэлтийг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд гаргажээ.

Нөгөө талаас хөнгөн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй цөөнгүй тооны үйлдвэр, аж ахуйн газрууд жилийн 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой байгаа нь тэдгээр аж ахуйн нэгжүүдийн хувьд жижиг дунд үйлдвэрийн хүрээнд төрөөс олгож буй бага хүүтэй зээлийн санхүүжилтэд хамрагдах боломжийг хязгаарлаж байгаа юм. Учир нь манай улсын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд “жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэлх орлоготой аж ахуйн нэгжийг жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч гэнэ” хэмээн заасан байдаг.

Эндээс хөнгөн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр аж ахуйн газруудад санхүүжилтийн боловсронгуй өөр арга хэлбэрүүд шаардлагатай байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.<sup>132</sup> Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд түүхий эдийн нөөц ерөнхийдөө хүрэлцээтэй байна. Үүнийг нөөцийн боловсруулалтын түвшин өндөр биш байгаатай холбон тайлбарлаж бас болно.

Хөнгөн үйлдвэрлэлийн салбар бүс нутгийн хэмжээнд жигд хөгжөөгүй, үйлдвэржилт хөтөлбөрийн хүрээнд “Шинэ ховд” үйлдвэрлэл, “Дархан арьс ширний цогцолбор” баригдаж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн эдгээр байгууламжууд байгуулагдсаны дараа түүхий эдийг нэгдсэн зохион байгуулалттайгаар бэлтгэх боломж илүүтэй нэмэгдэнэ гэж үзэж байгаа. Томоохон зургаар нь харахад бүс нутгийн хэмжээнд хөнгөн үйлдвэрлэл жигд хөгжсөн, үүнтэй холбоотойгоор cluster-ийн зохион байгуулалтад орсон дүр зураг харагдахгүй байгаа юм.



<sup>132</sup> ХХААХҮЯ-ны хөнгөн үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтнээс ярилцлагын аргаар судалгаа авав.

Хүснэгт 22. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ

Салбарын ангилал	Татвар, татаасын дэмжлэг, импортын хамгаалалт	Дэд бүтэц, Технологи, инноваци	ТББ-тай хамтын Ажиллагаа, сургалт, хүний нөөц	Зах зээлийн өргөжилт
Ноос, ноолуур	<p>ААНОАТ-ын хөнгөлөлт</p> <p>НӨАТ-ын чөлөөлөлт: Экспортод гаргасан түүхий болон угаасан, самнасан ноолуур, арьс шир;</p> <p>Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам</p>	<p>Шинэ ховд" үйлдвэр технологийн паркийг байгуулж байгаа бөгөөд дэд бүтцийн ажлын гүйцэтгэл 90 хувь</p> <p>Дархан арьс ширний цогцолбор 14 барилга, байгууламжаас 6 барилгын ажил эхэлж, гүйцэтгэл 22.9%-тай.</p>	<p>Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн</p> <p>Сургалт: 11</p>	<p>"Улаанбаатар түншлэл"</p> <p>"Монгол экспо" үзэсгэлэн худалдаа</p> <p>ХААБ-ний хураамжийг 0.2 хувь болгосон.</p> <p>Ноосны түүхий эдийн хэлцэл хийсэн.</p>
	Арьсан эдлэл			<p>ААНОАТ-ын хөнгөлөлт</p> <p>НӨАТ-ын чөлөөлөлт: Экспортод гаргасан арьс шир;</p>
Мод, модон эдлэл	<p>ААНОАТ-ын хөнгөлөлт</p> <p>НӨАТ-ын чөлөөлөлт: Импортоор оруулж байгаа бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, банз, модон бэлдэц, хагас боловсруулсан модон материал;</p>	-	<p>Монголын ойчид, модны үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо</p> <p>Сургалт: 5</p>	<p>Улаанбаатар түншлэл-2020" Олон улсын үзэсгэлэн худалдаа, "Монгол экспорт экспо-2020</p>
Сав баглаа боодол	<p>Гааль, нэмэгдсэн өртгийн албан татвар</p> <p>Инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодис;</p>	-	<p>Сав, баглаа боодлын холбоо</p> <p>Сургалт: 3</p>	<p>Каталоги 1000 ш, 2 анимейшн, 5 цуврал зурагт материал</p>
Дахин боловсруулах	<p>ААНОАТ-ын хөнгөлөлт</p> <p>Гааль, нэмэгдсэн өртгийн албан татвар</p> <p>Инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодис;</p>	-	<p>Монголын Хог Хаягдлыг Дахин Боловсруулах Үндэсний Холбоо</p> <p>Сургалт: 2</p>	<p>Улаанбаатар түншлэл-2020" Олон улсын үзэсгэлэн худалдаа, "Монгол экспорт экспо-2020</p>

Оёдол	ААНОАТ-ын хөнгөлөлт	-	ХҮСХХүрээлэнгийн харьяа “Нэхмэлийн гүйцэтгэн боловсруулалтын сургалтын материаллаг бааз тоног төхөөрөмж бүхий төв  Сургалт: 4	БНХАУ-ын Alibaba Taobao, Wechat зэрэг сүлжээнд, БНСУ-ын Emart сүлжээнд Гоё жүүс албан ёсоор худалдаанд гарч байна.  Экспорт Олон улсын танилцуулах үзэсгэлэнг Вашингтон, Оттава, Торонто хотноо зохион байгуулав
Хөвлөл	ААНОАТ-ын хөнгөлөлт	-	Мэргэжилтэй боловсролтой ажилчид-хүний хөгжил" сургалт  Сургалт:1	Улаанбаатар түншлэл-2020” Олон улсын үзэсгэлэн худалдаа, "Монгол экспорт экспо-2020

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хөнгөн үйлдвэрлэлийн салбарт, ялангуяа энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд бизнес эрхлэгчдийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлж байна. 2019 онд батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн татварын тайланд тусгасан, доор дурдсанаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, албан татвар төлөгчийн ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлнө гэж заасан байдаг. Түүнчлэн аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд байнгын үйл ажиллагаа явуулдаг, хуулийн этгээдийн ерөнхий захиргаа нь тухайн орон нутагт бүртгэлтэй, орон нутгийн татварын албатай харьцдаг, ажлын байр бий болгож /нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан/ байгаа энэ хуулийн 5.3.1-д заасан албан татвар төлөгчийн тухайн аймаг, сумын нутаг дэвсгэр дээр явуулсан үйл ажиллагаанаас олсон энэ хуулийн 7.4.1-д заасан албан татвар ногдох орлогод ногдох албан татварыг аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар хөнгөлнө гэж заасан байдаг.

Инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодис НӨАТ болон гаалийн татвараас, импортоор оруулж байгаа бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, банз, модон бэлдэц, хагас боловсруулсан модон материал, экспортод гаргасан арьс шир НӨАТ-ын татвараас тус тус чөлөөлөгдөж байхаар холбогдох хуулиудын зохицуулалтуудад тусгажээ.

“Шинэ ховд” үйлдвэр технологийн парк, Дархан арьс ширний цогцолборыг эс тооцвол хөнгөн үйлдвэрлэлийн хөгжилд чиглэгдсэн тусгайлсан дэд бүтцийн орчныг хөгжүүлэх ажил хийгдээгүй байна. Ерөнхийдөө шинэ дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх, хөгжүүлэх чиглэлээр хийгдсэн үйл ажиллагаа хараахан байхгүй байна хэмээн дүгнэж болохоор байна.

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас холбогдох төрийн бус байгууллагатай



хамтарч ажилладаг, хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх болон сургалтууд зохион байгуулдаг болох нь харагдаж байна. Зах зээлийг өргөжүүлэх чиглэлээр дотоод, гадаадын үзэсгэлэн худалдааг зохион байгуулж байна.

### **Салбарт хэрэгжиж буй хөтөлбөр**

#### “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр 2016 оны 287 дугаар тогтоол

Улаанбаатар хотын хэмжээнд хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид хүнсний зориулалтын бус хуванцар сав, хэрэглэлийг ашиглах зөрчлийг бүрэн таслан зогсоож, ЕБС-ийн 90 хувь хүнсний зориулалтын сав хэрэглэж байна.

#### Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр, ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоол

2017-2020 онуудад нийт 81 үйлдвэр байгуулагдсан байна. Үүнээс нийслэлд 5, орон нутагт 76 үйлдвэр байна. Нийтдээ 4100 орчим ажлын байр бий болсон байна.

#### “Ноолуур” хөтөлбөр, ЗГ-ын 2018 оны 47 дугаар тогтоол


Хөтөлбөрийн үр дүнд ноолуураа угааж, самнах үйлдвэрлэлийн хүчин чадал бүрэн суурилагдаж, ээрэх, нэхэх, сүлжих үйлдвэрлэлийн хүчин чадал 30-60 хувиар нэмэгдэж, ноос, ноолуурын салбарын нийт экспорт 2019 онд 434.7 сая ам.долларт хүрч, 2018 онтой харьцуулахад 6.0 хувиар, 2017 онтой харьцуулахад 29 хувиар өссөн байна. Харин өнгөрсөн онд Ковидтой холбоотойгоор экспорт өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

### **Хууль**

- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2019 он
- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль, 2009 он
- Технологи дамжуулах тухай хууль, 1998 он
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 2015 он /Энэ хуулийн 14.1.4 дэх заалтад 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./
- Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай, 1996 он
- Ойн тухай хууль, 2012 он
- Зээлийн батлан даалтын сангийн тухай, 2012 он
- Хог, хаягдлын тухай хууль, 2017 он
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /шинэчилсэн найруулга/, 2019 он
- Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай, 1995

### **УИХ-ын тогтоол**

- Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай, 2003 оны 54 дүгээр тогтоол
- Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, 2007 оны 52 дугаар тогтоол
- Стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрөл батлах тухай, 2008 оны 30 дугаар тогтоол
- Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай, 2012 оны 74 дүгээр тогтоол



## Засгийн газрын тогтоол

- Аж үйлдвэрийг сэргээх, хөгжүүлэх бодлогыг батлах тухай, 1998 оны 157 дугаар тогтоол
- 2001 оныг “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх жил” болгох тухай, 2000 он
- Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр, 2003 оны 207 дугаар тогтоол
- Сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангах зарим арга хэмжээний тухай, 2004 оны 237 дугаар тогтоол
- Сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангах зарим арга хэмжээний тухай, 2005 оны 32 дугаар тогтоол
- Жагсаалт батлах тухай /үйлдвэрийн тоног төхөөрөмжийн нэр төрөл/, 2005 оны 193
- Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний тухай, 2007 оны 222 дугаар тогтоол
- Хөтөлбөр батлах тухай (Хэвлэлийн үйлдвэрлэл), 2008 оны 53 дугаар тогтоол
- Үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн зохион байгуулах тухай, 2008 оны 4 дүгээр сарын 123 дугаар тогтоол
- Үйлдвэрлэл эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай, 2008 оны 5 дугаар сарын 191 дүгээр тогтоол
- 2009 оныг “Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил” болгох тухай, 2008 оны 12 сар
- Хөтөлбөр батлах тухай (МУ-ыг үйлдвэржүүлэх), 2009 оны 299 дүгээр тогтоол
- Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл батлах тухай, 2009 оны 178 дугаар тогтоол
- Журам, чиглэл батлах тухай (Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих тухай), 2011 оны 104 дүгээр тогтоол
- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай, 2011 оны 103 дугаар тогтоол
- Журам батлах тухай (Ноолууран утас, ноос боловсруулах үйлдвэрийг дэмжих, урамшил олгох), 2011 оны 221 дүгээр тогтоол
- “Үйлдвэржилтийн шинэ эрин үе” зарласныг дэмжих тухай, 2012 оны 118 дугаар тогтоол
- Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр батлах тухай, 2012 оны 171 дүгээр тогтоол
- Үйлдвэрлэлийг дэмжих тухай, 2013 оны 141 дүгээр тогтоол
- Арьс, ширний үйлдвэрлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай, 2013 оны 249 дүгээр тогтоол
- Сурагчийн дүрэмт хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай, 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 250 дугаар тогтоол
- Арьс, ширний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт батлах тухай, 2013 оны 8 дугаар сарын 300 дугаар тогтоол
- Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай, 2014 оны 1 дүгээр сарын 18 дугаар тогтоол
- Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай, 2014 оны 3 дугаар сарын 87 дугаар тогтоол
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай, 2014 оны 176 дугаар тогтоол
- Арьс, ширний үйлдвэрлэлийн төсөл дэмжих тухай, 2014 оны 198 дугаар тогтоол

- Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай, 2014 оны 352 дугаар тогтоол
- Арьс, ширний үйлдвэрлэлийн цогцолборын байршлын тухай , 2014 оны 356 дугаар тогтоол
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зарим арга хэмжээний тухай, 2015 оны 66 дугаар тогтоол
- Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрийн төслүүдийг санхүүжүүлэх тухай, 2015 оны 312 дугаар тогтоол
- Жагсаалт батлах тухай, 2015 оны 336 дугаар тогтоол
- Журам батлах тухай, 2016 оны 4 дүгээр сарын 193 дугаар тогтоол
- Түр журам батлах тухай, 2016 оны 138 дугаар тогтоол
- Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл байгуулах тухай, 2017 оны 19 дүгээр тогтоол
- “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр батлах тухай, 2018 оны 36 дугаар тогтоол
- “Ноолуур” хөтөлбөр батлах тухай, 2018 оны 47 дугаар тогтоол
- Жагсаалт батлах тухай” 2018 оны 234 дүгээр тогтоол
- Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2019 оны 156 дугаар тогтоол

Одоогийн байдлаар хөнгөн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих, зохицуулахтай холбоотой нийт 11 хууль, УИХ-ын 6 тогтоол, Засгийн газрын 38 тогтоол хэрэгжиж байна.

### Цаашид хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр

Хүснэгт 23. Цаашид авч хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрүүд, зорилтууд

1	2020-2050 АЛСЫН ХАРАА-2050 /Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол	Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.
2	Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно. Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.
3	2015-2025 Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого /Монгол улсын их хурлын 2015 оны 104 дүгээр тогтоол/	Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чухал үүрэгтэй эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь салбарын нэг мөн.

4	2015-2030 Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого/2015 оны 62 дугаар тогтоол/	Үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн салбарыг Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд оршино.
5	Хөнгөн үйлдвэрлэлийн урт хугацааны бодлогын чиглэл	Уламжлалт болон дэвшилтэт технологиор түүхий эдийг боловсруулж, аюулгүй байдлыг хангасан шим тэжээллэг, баталгаат хүнсээр хүн амыг тогтвортой хангах
6	Салбарын судалгаа ба хөгжлийн урт хугацааны бодлогын чиглэл:	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдлэгт суурилсан тогтвортой хөгжлийн чиг баримжаатай хөгжүүлэх, инновацийг нэвтрүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх
7	Салбарын хөрөнгө оруулалт, худалдааны урт хугацааны бодлогын чиглэл:	Улс, орон нутгийн төсвөөс ХХАА-н салбарт зарцуулагдах хөрөнгийг нэмэгдүүлэх Хөдөө аж ахуйн чөлөөт бүсийг байгуулан, алслагдсан бүс нутагт экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжих
		Үнэ цэнийн сүлжээний санхүүжилтийн цогц бүтцийг бий болгож, шаардлагатай шатанд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
		Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтворжуулахад даатгал, давхар даатгалын тогтолцоо, лизингийн үйлчилгээг
		Мал, амьтан, таримал ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалах тогтолцоонд шилжүүлэх

Эх сурвалж: ХХААХҮЯ

Цаашид манай улс аж үйлдвэрийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал үүрэгтэй хэмээн үзэж, дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх бодлогын зорилтыг дэвшүүлсэн байна.

### 3. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

#### 3.1 Итали Улс

##### 3.1.1 Итали Улсын ДНБ-ний өнөөгийн байдал, бүтэц, онцлог<sup>133</sup>

Итали улсын ДНБ 2019 оны байдлаар Дэлхийн ДНБ-ний 2.3 хувийг эзэлж байгаа бөгөөд, нэрлэсэн дүнгээр 1 хүнд ногдох ДНБ \$34,997-тай тэнцүү байна. ДНБ-д эзлэх хувь хэмжээг үйлдвэрлэлийн үндсэн бүтцийн хувьд авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 1.93 хувь, аж үйлдвэрийн салбар 21.42 хувь, үйлчилгээний салбар 66.27 хувийг тус тус эзэлж байна.

Итали Улс Европын холбоонд элссэн нь тус улсын эдийн засагт сөргөөр нөлөөлсөн бөгөөд 1999-2015 онд ДНБ-ний өсөлт 0% байсан. Итали Улсад Африк, Албани, Румын, Өмнөд Америкийн оршин суугчдын цагаачилж байна. Сүүлийн үед зөвхөн албан ёсны мэдээллээр Италийн хүн амд 4 сая цагаач нэмэгдсэн нь ДНБ-ний хэмжээ улам бүр буурахад хүргэсэн байна.

Италийн эдийн засаг 2020 онд Дэлхийн 2-р дайнаас хойших хамгийн хүнд уналттай тулгарч, 8.9%-иар унасан. Эдийн засаг 1.6 их наяд еврогоос доош унасан нь 1997 оноос хойших хамгийн доод үзүүлэлт юм. Төсвийн алдагдал өнгөрсөн онд 155.6 тэрбум евро буюу ДНБ-ний 9.5%-ийг эзэлж байна. Төсвийн алдагдал нэмэгдэж байгаа нь COVID-19 цар тахлын гамшигт нэрвэгдсэн бизнес эрхлэгчид, хүн амыг дэмжих зардалтай холбоотой юм. Улсын өр 2019 онд ДНБ-ний 134.6% байсан бол өнгөрсөн онд ДНБ-ний 155.6% болж өссөн байна.

<sup>133</sup> <https://www.nordeatrade.com/fi/explore-new-market/italy/economical-context>


## ДНБ-ний бүтэц 2020 (сая евро)

Хөдөө аж ахуй	30,866.1
Уул уурхай	5,609.2
Цахилгаан, дулаан, хий	36,729.4
Боловсруулах үйлдвэрлэл	227,572.7
Ус, цахилгаан, дулаан	36,832.4
Барилга	63,334.1
Үйлчилгээ	1,053,286.0
Бөөний худалдаа Жижиглэнгийн худалдаа Тээвэр, агуулахын үйл ажиллагаа, хоолны үйлчилгээ	276,794.9
Мэдээлэл холбоо	59,778.5
Санхүүгийн зуучлал	80,509.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	206,072.3
Мэргэжлийн болон техникийн үйл ажиллагаа	137,157.3
Төрийн удирдлага: батлан хамгаалах үйл ажиллагаа, нийгмийн хамгаалал	238,753.8
Урлаг соёлын үйлчилгээ	54,641.2

Эх сурвалж: *Italy - OECD Data*

### Аж үйлдвэрийн салбарын тойм

Аж үйлдвэрийн салбарт орох салбаруудын ДНБ-д эзлэх хувийг 2020 оны байдлаар харвал дараах байдалтай байна.



Эх сурвалж: *Судлаачийн боловсруулснаар*

### Тэргүүлэх чиглэл

Итали Улс нь 2020-2021 онд Европын Холбооны гишүүн орнуудын дунд эдийн засгийн хэмжээгээр 3-р байрыг эзэлж байна. Италийн аж үйлдвэрийн түвшин бүс нутгаас ихээхэн хамаардаг, улсын хойд хэсэгт олон үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг бол өмнөд хэсэгт хөдөө аж ахуй голчлон хөгжсөн байдаг. Үйлдвэрлэлийн тэргүүлэгч салбар нь машин үйлдвэрлэл юм. Түүнчлэн, төмөрлөгийн үйлдвэрлэл, нефть химийн болон хөнгөн үйлдвэрүүд нь Италийн эдийн засагт чухал үүргийг гүйцэтгэдэг.

Тус улсын машин үйлдвэрлэлд автомашин үйлдвэрлэл тэргүүлэх байрыг эзэлдэг бол унадаг дугуй, мопед үйлдвэрлэхээс гадна хөдөө аж ахуйн тактор, машин техник, автобус, трамвай зэрэг олон нийтийн тээврийн хэрэгслийг мөн үйлдвэрлэдэг. Гэр ахуйн цахилгаан хэрэгслийн хувьд угаалгын машин, хөргөгчний үйлдвэрлэлийг онцолж болох юм.

Мөн тус улс нь байгалийн хий, калийн давс, доломит, мөнгөн усны хүдэр болон бусад олон ашигт малтмалыг олборлодог. Жижиг нутаг дэвсгэрийн улмаас үйлдвэрлэлийн хог хаягдал

маш ихээр хуримтлагддаг учир улсын хэмжээнд хог хаягдлыг устгах, боловсруулах хөтөлбөр боловсруулж байна. 2011 оноос аж үйлдвэрлэлийн симбиоз буюу циркуляр/тойрог эдийн засгийн дэмжих чиглэлээр төсөл хөтөлбөр боловсруулж, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

2020 оны сүүлийн зургаан сарын хугацаанд үйлдвэрлэл 1.4%-иар өсөж, автомашин үйлдвэрлэлийн салбар 10.8%-иар өссөн байна.

- Ашигт малтмал, түүхий эдийн олборлолт муу хөгжсөн;
- Машин үйлдвэрлэлийн салбар тэргүүлэх байрыг эзэлдэг;
- Нефть химийн ба химийн үйлдвэрлэлээр дэлхийд 12-т, Европ тивд 3-р байрыг эзэлдэг;
- Хүнсний үйлдвэрлэл, түүнийг дагаад хөнгөн үйлдвэрлэл сайн хөгжсөн;
- жижиг, дунд үйлдвэрлэлийн эзлэх хувь өндөр, үр дүнтэй үйлдвэрийн кластерыг хөгжүүлсэн.

2002 оноос хойш Итали Улс лирээс еврод шилжсэнээр Италийн хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар Ази болон Зүүн Европын орнуудтай харьцуулахад буурсан.

Импортын гол түншүүд нь Герман, Франц, БНХАУ, ОХУ, Нидерланд, Испани юм. Экспортын хувьд Итали нь Герман, Франц, АНУ, Швейцар, Испанитай хамтран ажилладаг.

Италийн үндсэн аж үйлдвэрлэлийн салбарын тэргүүлэх чиглэл

- Машин үйлдвэрлэл
- Нэхмэлийн үйлдвэрлэл
- Химийн үйлдвэрлэл
- Хүнсний үйлдвэрлэл,
- Төмөрлөгийн үйлдвэрлэл
- Цахилгаан үйлдвэрлэл
- Усан онгоцны үйлдвэрлэл: Эндээс нэхмэл болон химийн үйлдвэрлэл нь хөнгөн үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл болж байна.

Дээрхээс гадна Итали Улсад дараах үйлдвэрлэл явагддаг.

- эмийн үйлдвэрлэл;
- харилцаа холбооны тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл;
- үнэртэн, гоо сайхны үйлдвэрлэл.

Итали Улс тоглоом, загварчлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр мөн үйл ажиллагаа явуулдаг.

#### Машин үйлдвэрлэл

Машин үйлдвэрлэл нь Италийн үйлдвэрлэлийн гол салбаруудын нэг бөгөөд нийт ажилчдын 2/5 нь тус салбарт ажилладаг байна. Нийт үйлдвэрлэсэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гуравны нэг нь энэ салбарт ногдож байна. Тус салбар нь дотоодын зах зээлийг машин, механизмаар бүрэн хангадаг. Хөдөө аж ахуйн машин техник, тракторын үйлдвэр сайн хөгжсөн.

Машин үйлдвэрлэл нь төрөлжсөн салбар бөгөөд дараах салбарууд хамаарна. Үүнд:

- ✓ Автомашины үйлдвэрлэл;



- ✓ Машин хэрэгсэл үйлдвэрлэл;
- ✓ Компьютерийн технологийн үйлдвэрлэл;
- ✓ Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж үйлдвэрлэл;
- ✓ Аж ахуйн нэгжид зориулсан тоног төхөөрөмж;
- ✓ Электроникийн үйлдвэрлэл.

Машин, моторт тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлээс гадна машин үйлдвэрлэлийн салбар нь ажлын тоног төхөөрөмж, тооцоолох төхөөрөмж, багаж хэрэгсэл, цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл зэрэг салбаруудыг хамардаг.

#### Хөнгөн үйлдвэр

Нэхмэлийн үйлдвэрлэл нь үйлдвэрлэлийн хэмжээгээрээ хоёрдугаарт ордог. Хөвөн даавууны гол үйлдвэрүүд Италийн хойд хэсэг, засаг захиргааны бүс болох Ломбарди, Пьемонтод байрладаг. Эдгээр газарт усны хангамж элбэг, мөн ойролцоо Альпийн усан цахилгаан станцууд байдаг бөгөөд энэ нь хямд цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэлд ашиглах боломжийг олгодог байна.

Италийн Үндэсний статистикийн хүрээлэнгээс гаргасан мэдээллээр Италийн үйлдвэрлэлийн салбараас экспортолж буй бүтээгдэхүүний 8 хувийг загварын салбар эзэлдэг бөгөөд тус салбар нийт 400,000 ажилтан, 45,000 орчим компани үйл ажиллагаа явуулдаг байна.

#### Боловсруулах үйлдвэр

Ноосыг Тоскана, Пьемонт, Венециудад боловсруулдаг. Торгыг Комо, Тревисо хотод үйлдвэрлэдэг. 2021 оны хувьд Итали Улс даавуу, хувцас, гутал, тавилга үйлдвэрлэх, экспортлох чиглэлээр дэлхийн улс орнуудын дунд тэргүүлэгчдийн нэг болсон. Гутал үйлдвэрлэлийн хувь Итали нь Хятад, АНУ-ын дараа орж байна.

#### Химийн үйлдвэрлэл

Итали Улс нефть химийн бодис, полимер, синтетик утас үйлдвэрлэх чиглэлээр түлхүү үйлдвэрлэл эрхэлдэг бөгөөд томоохон үйлдвэрүүд голчлон энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг. Химийн үйлдвэрлэлийн гол төв нь Милан хот, томоохон үйлдвэрүүд нь өмнөд хэсэг, боомтууд дагуу төвлөрдөг. Химийн үйлдвэрлэлд 2800 гаруй компани, 112000 мэргэжлийн өндөр ур чадвар бүхий ажилтнууд ажилладаг.

#### Хүнсний үйлдвэр

Дарс үйлдвэрлэл, гурил, гоймонгийн үйлдвэрлэл нь тус үйлдвэрийн гол салбарууд юм. Гоймон үйлдвэрлэх томоохон төв нь Неаполь хотод байрладаг.

Жимс, загас, махыг ихээр нөөшилдөг. Сүү, сүүн бүтээгдэхүүний ихэнх хувийг тус улсын хойд хэсэгт үйлдвэрлэдэг. Италид 5000 гаруй сортын дарс байдаг бөгөөд тэдгээрийн гуравны нэгийг экспортолдог. Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд зориулж тус улсын төсвөөс татаас, дэмжлэг тогтмол олгодог. Усан үзмийн талбайг өргөжүүлэх, талбайн шинэ нөөцийг бүрдүүлэхэд анхаарч ажилладаг.

#### Хөдөө аж ахуй

Газар дундын тэнгист ойрхон газар нутгууд нь хөдөө аж ахуйг хөгжүүлэх үржил шимт хөрстэй, нийт нутаг дэвсгэрийн 31% тариалангийн талбай юм. Италийн тариаланчдын тариалдаг гол ургац бол улаан буудай. Гэхдээ хойд бүс нутагт ч гэсэн эрдэнэ шиш, овъёос,

арвай, цагаан будаа тариалдаг, жимс, чидун жимс, усан үзэм зэргийг далайн эрэг хавиар ургуулдаг.

Тус улсын өмнөд болон төвийн бүс нутгууд нь цитрус болон бусад жимс, төмс, манжин, улаан лооль, вандуй тариалахад тохиромжтой нөхцөлүүдтэй. Итали Улс бүхэлдээ жилд 3.3 сая гаруй тонн цитрус жимс, 5.5 сая тонн улаан лооль, 10 орчим сая тонн усан үзэм үйлдвэрлэдэг бөгөөд үүний 90%-ийг дарс үйлдвэрлэхэд ашигладаг.

Мөн дээрх бүс нутагт маалинга, хөвөн тариалдаг бөгөөд том тариалан эрхэлдэг газар цөөн боловч жижиг фермүүд олон байдаг.

Итали бол махны үйлдвэрлэлээрээ Европт тэргүүлэгчдийн нэг юм. Хойд хэсэгт жижиг фермүүд гол төлөв үхэр, гахай үржүүлдэг. Сардинийн арал дээр хонь өсгөдөг. Шувууны аж ахуй нь томоохон хотуудын ойролцоо байрладаг. Өмнө зүгт далайн хоол, загас боловсруулах үйлдвэрүүд байдаг боловч ерөнхийдөө загас агнуур муу хөгжсөн. Хэдийгээр хөдөө аж ахуй эрхлэгчдийн тоо өндөр боловч нийт улсын 75%-ийг хүнсээр хангах хүчин чадалтай байна.

### Эрчим хүч

Италид эрчим хүчний олон эх үүсвэр байдаггүй. Газрын тос нь эрчим хүчний 70%-ийг бүрдүүлдэг. Энэ үзүүлэлтээр Итали Улс нь Японтой төстэй юм. Тус улс жилд 1.5 сая тонн газрын тос олборлодог бол хэрэглээ нь 75 сая тонн юм. Тиймээс Итали нь Орос, Саудын Араб, Ливиэс импортолдог. Байгалийн хийн үйлдвэрлэл нь хэрэгцээний 46% хангадаг бол үлдсэн 54%-ийг Орос, Алжир, Нидерландаас импортолдог. Мөн нүүрсний 80%-ийг импортолдог бөгөөд гол түншүүд нь АНУ, Өмнөд Африк юм.

Төмөрлөгийн үйлдвэрүүд импортын түүхий эдийг ашигладаг. Тиймээс дээрх үйлдвэрлэлүүд нь далайн эрэг дагуу байрладаг. Тус улс нь хүйтэн ган, ган хоолой үйлдвэрлэлээр алдартай. Өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэлийн гол бүтээгдэхүүн нь хөнгөн цагаан, мөнгөн ус, цайр, хар тугалга юм. Итали Улс нь Европын хар төмөрлөгийн 40%-ийг үйлдвэрлэдэг бөгөөд металл боловсруулалтаар 6-р байр эзэлдэг.

2020 оны байдлаар Италид цөмийн эрчим хүч байхгүй байна. 1970 он хүртэл Америк загваруудаар атомын цахилгаан станц барьж байсан хэдий ч Чернобылийн атомын цахилгаан станцад гарсан ослын дараа эдгээр төслүүдээс татгалзахаар шийдвэрлэсэн.

2020 онд Итали Улс эрчим хүчний альтернатив эх үүсвэр, ялангуяа салхин эрчим хүчний хэрэглээгээрээ дэлхийд зургадугаарт жагссан. Нийт хүчин чадал нь 5797 МВт бөгөөд Хятад (44,733 МВт), АНУ (40,180 МВт), Герман (27,215 МВт), Испани (20,676 МВт), Энэтхэг (13,065 МВт) зэрэг улсын дараа орж байна.

2019 оны Италийн үйлдвэрлэлийн гарц 297.99 тэрбум доллар байсан нь өмнөх оныхоос 5.07%-иар буурсан үзүүлэлт байна.

Зураг 36. Итали Улсын үйлдвэрлэлийн гарц



Эх сурвалж: <https://www.macrotrends.net/countries/ITA/italy/manufacturing-output>

### 3.1.2 Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал

Хүснэгт 24. Итали Улсын хөнгөн үйлдвэрлэлийн хэмжээ, мян. евро (2016-2019)

Огноо	2015	2016	2017	2018	2019
Дэд салбар					
13: Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	16053866	14387022	16077873	16469896	18149454
14: Хувцас үйлдвэрлэл	9539178	10494099	11283642	15054136	19512952
15: Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	18723501	17905257	21406067	19095912	22454882
16: Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл; сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл	9766663	9544048	10941664	9619201	8645899
17: Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21271206	21753851	24013849	21538773	22208789
18: Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	8167150	8992540	9397926	10152239	9237216
19_20: Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	37675999	36999027	45562043	38142008	34912420
21: Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	12728010	13291521	16865084	14386608	12542816
22: Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	33794214	34190708	38898763	36554710	29990346

23: Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	23104091	23376995	26660434	20993185	23569465
26: Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10274727	10206949	12357167	12593743	13061627
27: Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл	24822535	24453573	28853200	27531306	24969544
31: Тавилга үйлдвэрлэл	17663486	17943185	19857522	19059720	19726359

Эх сурвалж: Италийн Статистикийн үндэсний хүрээлэн, <https://www.istat.it>

### 3.1.3 Аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ<sup>134</sup>

Эдийн засгийн хөгжлийн яам (ЭЗХЯ) аж үйлдвэрийн бодлогыг тодорхойлж, Боловсрол, их сургууль, эрдэм шинжилгээний яам (БИСЭШЯ) нь зарим судалгаа шинжилгээний ажлыг удирдан зохион байгуулдаг бол, *Cassa Depositi e Prestiti* (CDP) хөрөнгө оруулалтын банк нь аж үйлдвэрийн салбарын санхүүжилттэй холбоотой асуудлыг хариуцах “албан бус” нэгж байна. ЭЗХЯ-наас боловсруулж буй бодлогыг судалгаа шинжилгээний ажил ба инноваци, олон улсын худалдаа, Шинэ бизнес эрхлэх, Орон нутаг, үйлдвэрлэлийн хөгжил зэрэг томоохон “хэвтээ” зорилгуудыг хэрэгжүүлэх зорилготой юм. Дээрх бодлогын арга хэмжээ нь ЕХ-ны хөтөлбөрүүдтэй ижил чиглэлүүдэд чиглэгдэж байгаа бөгөөд үндэсний болон ЕХ-ны тэргүүлэх чиглэлүүдийг уялдуулахыг зорьсон байна. Тухайлбал, Horizon 2020, Европын долоон томоохон нийгмийн сорилтууд, Европын дижитал хөтөлбөр гм.

Эдийн засгийн хөгжлийн яам (ЭЗХЯ)<sup>135</sup> нь Италийн аж үйлдвэрийн бодлого, олон улсын худалдаа, харилцаа холбоо, эрчим хүчний бодлого боловсруулах, бодлогын удирдлагаар хангах Засгийн газрын нэгж юм. Үйлдвэрлэлийн яам (2001 он хүртэл Үйлдвэр, худалдаа, гар урлалын яам)-ыг өөрчлөн 2006 онд Эдийн засгийн хөгжлийг яамыг байгуулан, 2008 онд Харилцаа холбооны яам, Олон улсын худалдааны яамыг нэгтгэсэн.

Шинэ технологи, эрчим хүч, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үндэсний агентлаг<sup>136</sup>-аас 2011 оноос эхлэн Аж үйлдвэрлэлийн симбиоз буюу циркуляр/тойрог эдийн засгийн дэмжих чиглэлээр бүс нутгийн хэмжээнд үйлдвэрлэлийн симбиозыг хэрэгжүүлэх арга зүй, хэрэгслийг бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг бүс нутаг дахь симбиозтой болох боломжийг дэмжих зорилгоор Үйлдвэрлэлийн симбиозын платформыг бий болгосон байна.

#### “Industria 4.0” Үндэсний төлөвлөгөө<sup>137</sup>

2017 оны 3-р сараас Франц, Герман, Итали улсууд үйлдвэрлэлийн салбарыг дижитал хэлбэрт шилжүүлэх, Европын Холбооны энэ чиглэлээр явуулж буй хүчин чармайлтыг дэмжих чиглэлээр гурван талт хамтын ажиллагааг эхлүүлсэн. Энэхүү хамтын ажиллагаа нь ХБНГУ-ын Аж үйлдвэрийн Платформ 4.0, Францын Alliance Industrie du Futur, Италийн Piano Impresa 4.0 зэрэг үндэсний стратегийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг нэгтгэж байна.

Удирдах хороо нь улс бүрээс зургаан гишүүнээс бүрдэж, Эдийн засгийн яамдын Аж үйлдвэрийн газрын гурван захирлаар ахлуулдаг. Ажлын хэсэг нь институт, шинжлэх ухаан,

<sup>134</sup> [http://www.isigrowth.eu/wp-content/uploads/2016/01/working\\_paper\\_2016\\_2.pdf](http://www.isigrowth.eu/wp-content/uploads/2016/01/working_paper_2016_2.pdf)

<sup>135</sup> <https://ec.europa.eu/growth/tools-databases/regional-innovation-monitor/organisation/centro-i/ministry-economic-development-italy>

<sup>136</sup> <https://www.urbanwins.eu/industrial-symbiosis-platform-in-italy/>, <http://www.industrialsymbiosis.it>

<sup>137</sup> <https://www.mise.gov.it/index.php/en/201-contents/2038848-trilateral-cooperation-between-italy-france-and-germany-for-industry-4-0>

үйлдвэрлэлийн төлөөллөөс бүрдэх бөгөөд хороодод дараах байдлаар тайлагнана:

#### WG1 -Стандартчилал

Удирдагч: Plattform Industrie 4.0 (Герман)

Зорилго: үйлдвэрлэлийг дижиталчлах холбогдох техникийн стандартыг тодорхойлох, зохицуулалтын хүрээг уялдуулах хэлбэрийг санал болгох.

#### WG2 - SMEs оролцоо ба туршилтын ор

Удирдагч: Piano Impresa 4.0 (Итали)

Зорилго: Гурван улсын I4.0 технологийг ашиглахтай холбоотойгоор зураглах, сурталчлах, сүлжээнд хамруулах замаар ЖДҮ эрхлэгчдийг дижиталчлах үйл явцыг дэмжих.

#### WG3 - Европын түвшний бодлогыг дэмжих бүлэг

Удирдагч: Alliance Industrie du Futur (Франц)

Зорилго: Бодлогын хөтөлбөрүүд болон түүнтэй холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээний шилдэг туршлагаудыг солилцох, олон улсын форум (ялангуяа ЕХ-ны байгууллагуудын хувьд)-д харилцан уялдаа бүхий байр суурь боловсруулах.

Итали Улсын “Industria 4.0” үндэсний төлөвлөгөө<sup>138</sup> нь 2017-2020 оны хооронд богино, дунд хугацаанд олон төрлийн арга хэмжээ авахаас гадна урт хугацааны үр ашигтай хүрээний суурийг хамтад нь хангахад чиглэсэн. Стратегийн арга хэмжээ нь инноваци, өрсөлдөх чадвар, ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгдэж байна. Түүнчлэн, Industria 4.0-ийн хүчин чармайлтыг дэмжих чиглэлээр нэмэлт арга хэмжээнүүдийг янз бүрийн чиглэлээр хэрэгжүүлж байна. Засгийн газар уг санаачилгын хүрээнд нийтдээ 18 тэрбум еврогийн санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлжээ.

#### 3.1.3.1 Итали Улсын хөнгөн үйлдвэрлэлд төрөөс үзүүлдэг дэмжлэг<sup>139</sup>

Тус улсад хөнгөн үйлдвэрлэлийн хөгжүүлэхэд төрөөс тухайлсан дэмжлэг үзүүлэх, тусдаа арга хэмжээ байдаггүй хэдий ч Италийн хөнгөн үйлдвэрлэл нь дэлхийн хамгийн өндөр хөгжилтэй үйлдвэрлэлийн нэг юм. Түүнчлэн, Итали Улс нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хамгийн том экспортлогчдын нэг бөгөөд энэ нь дэлхий даяар эрэлт хэрэгцээтэй өндөр, чанарын хувьд ихээхэн үнэлэгддэг.

Италийн хөнгөн үйлдвэрлэлийн салбар нь тус улсын хамгийн чухал салбаруудын нэг юм. Тус салбарын амжилтын үндэс нь инноваци, загвар, бүтээлч хэв маягийг үйлдвэрлэлийн технологитой хослуулах чадвар оршино. Италийн хөнгөн үйлдвэрлэлийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид голдуу бүрдүүлдэг.

ЕХ-ны бүх орнуудын нэгэн адил Итали Улсад хөнгөн үйлдвэрт чиглэсэн дэмжлэг байдаггүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Харин тус улсад жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийн нэлээд өргөн хүрээ бүхий тогтолцоотой. Энэхүү үйл ажиллагааны гол зохицуулагч нь Итали Улсын Эдийн засгийн хөгжлийн яам, улсын аж үйлдвэр эрхлэгчдийн холбоо “Конфиндустри”- тай шууд холбоотой ажилладаг бөгөөд энэ нь аж үйлдвэр, бүс

<sup>138</sup> [https://ati.ec.europa.eu/sites/default/files/2020-06/DTM\\_Industria4.0\\_IT%20v2wm.pdf](https://ati.ec.europa.eu/sites/default/files/2020-06/DTM_Industria4.0_IT%20v2wm.pdf)

<sup>139</sup> [http://www.eurasiancommission.org/ru/act/prom\\_i\\_agroprom/dep\\_prom/SiteAssets/Материалы%20в%20разделе%20Аналитика/Отраслевые%20обзоры/Аналитическая%20записка%20по%20рос%20поддержке%20ЕС%20лекая%20промышленность.pdf](http://www.eurasiancommission.org/ru/act/prom_i_agroprom/dep_prom/SiteAssets/Материалы%20в%20разделе%20Аналитика/Отраслевые%20обзоры/Аналитическая%20записка%20по%20рос%20поддержке%20ЕС%20лекая%20промышленность.pdf)



нутгийн холбоод, нэгдлүүд юм.

Бүс нутгийн Худалдааны танхимууд нь орон нутгийн банк, санхүүгийн байгууллагуудын оролцоотой консорциум байгуулж томоохон дэмжлэгүүдийг үзүүлдэг. Түүнчлэн "SACE" (экспортын зээлийн даатгал)<sup>140</sup>, "Simest" (гадаад дахь Италийн хөрөнгө оруулалтыг хамгаалах) зэрэг байгууллагууд дэмжлэг үзүүлдэг.

Үүний зэрэгцээ, жижиг, дунд бизнесийг дэмжихэд төрөөс идэвхтэй оролцдог хэдий ч ЖДҮ эрхлэгчдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олгодоггүй байна. Одоогийн байдлаар Италийн бүх бизнес эрхлэгчид холбооны түвшинд татвар ногдуулдаг бол бизнесийн үйл ажиллагаанд бүс нутгийн болон орон нутгийн татвар ногдуулдаггүй байна. Татвартай холбоотойгоор ЖДҮ эрхлэгчид зарим тохиолдолд давуу тал эдэлдэг бол эдгээр нь санхүүгийн гэхээсээ техникийн шинж чанартай байдаг. Жишээлбэл, зарим тохиолдолд ЖДҮ эрхлэгчдэд татвараа сар бүр бус харин улирал тутам төлөхийг зөвшөөрдөг байна.

Ийнхүү Италийн ЖДҮ эрхлэгчдэд үзүүлэх төрийн дэмжлэгийн тогтолцоо татварын салбарт төвлөрөөгүй байгаа боловч жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн гадаад эдийн засгийн үйл ажиллагааг төрөөс дэмжих тогтолцооны хүрээнд үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл олгох, ЖДҮ-ийг бий байгуулахад залуу бизнес эрхлэгчдийг дэмжих, Италийн бизнес эрхлэгчдэд нэн чухал шинэ технологийг хөгжүүлэхэд зохион байгуулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг хэлбэрээр илэрхийлэгдэж байна. Тухайлбал:

а) *хөнгөлөлттэй зээл олгох*. Итали Улсын хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгжүүдийн өөрсдийн хэрэгцээнд зориулж тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах зардлыг хөнгөлөлттэй зээлээр олгохоор заасан.

Худалдан авсан машин, тоног төхөөрөмж нь шинэ, хамгийн багадаа 500 еврогийн үнэтэй, Итали Улсын нутаг дэвсгэрт ашиглагдах нөхцөлөөр хөнгөлөлт олгоно. Зээлийн хэмжээ нь тээвэрлэлт, суурилуулалт, ашиглалтад оруулах зардлыг багтаана. Санхүүжилтийн техникийн туслалцаа нь худалдан авагчаас худалдагчид вексель бичиж, дараа нь холбогдох банкуудад бүртгүүлэх замаар хийгддэг. Ийм зээлийг 5-аас дээшгүй жилийн хугацаатай олгох ба дээд хэмжээ нь 1.5 сая евро байна.

б) *Инновацилаг аж ахуйн нэгжийг байгуулахад дэмжлэг үзүүлэх*. 317/1991 хуулиар шинэ технологи хөгжүүлэхэд ЖДҮ эрхлэгчдэд зохион байгуулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх механизмыг тодорхойлсон болно. Энэ хуулийн дагуу аж ахуйн нэгжүүдэд эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй зээл, хөнгөлөлттэй зээл олгох ажлыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ.

- өндөр технологийн тоног төхөөрөмж худалдан авах ("инновацийн систем" гэж нэрлэдэг);

- хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийг хангах "ноу-хау", хэрэглээний програм, баримт бичиг хэлбэрээр шинэ технологи олж авах;

- тэдний бүрэлдэхүүнд багтсан аж ахуйн нэгжүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилгоор консорциум байгуулах;

- шинэлэг "туршилтын" аж ахуйн нэгж байгуулах;

- судалгаа, боловсруулалтын ажлыг хэрэгжүүлэх.

ЖДҮ эрхлэгчид эдгээр чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг тохиолдолд тухайн аж ахуйн нэгжийн холбогдох зардлыг нөхөхөд төр оролцохыг хуулиар зохицуулсан байдаг.

<sup>140</sup> <https://www.sace.it/en>



Инновацийн үйл ажиллагаанд ЖДҮ-ийн зардлыг хамруулах хувь хэмжээ нь тухайн аж ахуйн нэгжийн хэмжээ, байршил (өмнөд бүсэд тусгай үнийг тогтоодог) болон хөрөнгө оруулалтын объект (СБА, орчин үеийн тоног төхөөрөмж, технологийг олж авах, хөгжүүлэх борлуулалтын шинэ зах зээлийг эзлэх).

в) *Шинээр үйлдвэр байгуулах, одоо үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-ийг өргөтгөх, шинэчлэх, өөрчлөн байгуулах, нутаг дэвсгэрийн нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын төслүүдийг дэмжих.*

Санхүүгийн тусламжийн хэмжээ нь улс орны хойд хэсэгт аж ахуйн нэгжийн нийт хөрөнгө оруулалтын 10%, өмнөд хэсгийн хамгийн хоцрогдсон бүс нутагт 65% хүртэл хэлбэлздэг. Төслүүдийг орон нутгийн төсвөөс орон нутгийн нийгэм, эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг үндсэн шалгуур болгон шалгаруулж, санхүүжүүлнэ.

д) *консорциум зэрэг холбоод байгуулах.* Бүс нутгийн түвшинд бүс нутгийн эрх баригчдын хяналтан дор консорциум зэрэг холбоо байгуулахад ЖДҮ-д санхүүгийн туслалцаа үзүүлэх механизм байдаг. Ийм тусламжийг эдгээр байгууллагын хөрөнгө оруулалтын зардалд хөнгөлөлттэй зээл олгох замаар хэрэгжүүлдэг.

Эдгээр нөхцөлд олгосон зээлийн хэмжээ нь өмнөд бүсийн аж ахуйн нэгжүүдийн консорциумуудын зардлын 80%, бусад бүс нутагт 60% хүртэл байж болно.

д) *шинэчлэлийн зардалд хөнгөлөлттэй зээл олгох.* 598/1994 оны хуулиар үндсэн хөрөнгийн дараах элементүүдийг худалдан авахад зориулж ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл хэлбэрээр тусламж үзүүлэхээр заасан.

- аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тохирсон машин, тоног төхөөрөмж, автоматжуулсан технологийн шугам;

- патент ба лиценз;

- аж ахуйн нэгжийн зураг төслийн товчооны лабораторийн тоног төхөөрөмж;

- байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал. Санхүүжилтийг хөрөнгө оруулалтын зардлын 70%-иар нийт 1.5 сая орчим евро хэтрэхгүй хэмжээгээр хөнгөлөлттэй үнээр 7 жил хүртэл хугацаагаар санхүүжүүлдэг бөгөөд энэ нь Италийн банкны дахин санхүүжүүлэх түвшингээс 23%-иар доогуур байна.

е) *санхүүгийн эх үүсвэр олж авах боломжийг хөнгөвчилсөн.* "Аж ахуйн нэгжийг дэмжих тухай" 2013 оны 6-р сарын 21-ний өдрийн 69 тоот тогтоол-хуульд ЖДҮ-д зээл олгох, шаардлагатай зээлийн баталгааг авах (Батлан даалтын санд хандах), урамшуулал олгох журмыг хялбарчлах арга хэмжээ авахаар тусгасан. Италийн төв ба хойд бүсийн аж үйлдвэрийн салбар дахь гэрээнүүдийг дахин санхүүжүүлэх (150 сая евро хуваарилсан), дотооддоо болон хөгжиж буй орнуудад хамтарсан үйлдвэр байгуулахад венчур капиталын квотын санхүүжилтийг баталгаажуулах хөнгөлөлттэй зээл олгох тухай хуульд тусгасан болно.

г) *цахилгааны тарифыг бууруулах.* Хэрэглэгчийн ангиллаас хамааран аж ахуйн нэгжүүдийн нийт 800 сая евроны цахилгааны тарифыг бууруулсан. 2015 онд Италийн эрх баригчид энэхүү хөтөлбөрт зориулж 1.5 тэрбум евро хуваарилсан байна.

н) *өрсөлдөөнийг хөгжүүлэх.* Тус улсын бизнесийн уур амьсгалыг сайжруулах зорилгоор 2014 онд Италийн Засгийн газар эдийн засгийн өсөлт, өрсөлдөөний хөгжлийг хангахад чиглэсэн тогтоолыг баталсан. Тодруулбал, Италийн аж ахуйн нэгжүүд 2015 оны 6-р сарын 30-ны өдөр хүртэл шинэ тоног төхөөрөмж худалдан авахад 15%-ийн татварын

хөнгөлөлт, эрчим хүч хэрэглэгчдийн ангилалд тохирсон татварын хөнгөлөлт үзүүлснээр ЖДҮ эрхлэгчдэд аж ахуйн нэгжийн дүрмийн санг дор хаяж 40% -иар нэмэгдүүлэх боломжтой болсон.

i) *санхүүгийн байгууллагуудыг өргөжүүлэх.* Засгийн газраас даатгалын компаниуд, хөрөнгө оруулалтын сангуудад аж ахуйн нэгжийг санхүүжүүлэхийг зөвшөөрсөн, өмнө нь зөвхөн банкууд энэ үйл ажиллагаа эрхлэх боломжтой байв. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар энэхүү багц арга хэмжээ нь улс орны эдийн засгийн бодит салбарт 20 орчим тэрбум еврогийн хөрөнгө татах юм.

к) *инновацийг дэмжих.* Инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор аж ахуйн нэгжүүд 2014-2016 онуудад судалгаа шинжилгээ, боловсруулалтын ажлын зардлын өсөлтийн 25%-ийн татварын хөнгөлөлт эдлэх эрхийг авсан. Суутгалын дээд хэмжээг жилд 5 сая еврогоор тогтоосон. Энэхүү давуу эрхээ ашиглахын тулд аж ахуйн нэгж жилд доод тал нь 30 мянган евро судалгаа шинжилгээ, боловсруулалтын ажилд зарцуулах ёстой байна.

### 3.2 Америкийн Нэгдсэн Улс<sup>141</sup>

#### 3.2.1 Америкийн Нэгдсэн Улсын ДНБ-ний өнөөгийн байдал, бүтэц, онцлог

2020 оны байдлаар АНУ-ын ДНБ дэлхийн ДНБ-ний 24 хувийг эзэлж, 1 хүнд ногдох ДНБ 53240.00 ам доллар-тай тэнцэж байна. ДНБ-д эзлэх хувь хэмжээг үйлдвэрлэлийн салбарын үндсэн бүтцийн хувьд авч үзвэл ХӨАА 0.9 хувь, Аж үйлдвэр 18.9 хувь, үйлчилгээ 80.2 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 25. ДНБ-ний бүтэц 2020 (тэрбум ам доллар)

Санхүүгийн зуучлал	4660.5
Мэргэжлийн болон техникийн үйл ажиллагаа	2673.6
Төрийн удирдлага: батлан хамгаалах үйл ажиллагаа, нийгмийн хамгаалал	2645.7
Боловсруулах үйлдвэрлэл	2269.19
Боловсрол, эрүүл мэнд	1807.55
Бөөний худалдаа	1217.73
Жижиглэнгийн худалдаа	1200.89
Мэдээлэл холбоо	1161.44
Урлаг, орон сууц, хоолны үйлчилгээ	679.73
Барилга	897.57
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	595.87
Бусад үйлчилгээ	421.92
Цахилгаан, дулаан, усан хангамж	336.88
Уул уурхайн олборлолт	192.46
Хөдөө аж ахуй	175.8


Эх сурвалж: *Value added to U.S. GDP by industry 2020 | Statista*

<sup>141</sup> usda-strategic-plan-2018-2022.pdf

## Аж үйлдвэрийн салбарын тойм

Зураг 37. ДНБ-д эзлэх хувь

Боловсруулах үйлдвэрлэл	10.8%
Цахилгаан, дулаан, усан хангамж	1.6%
Уул уурхайн олборлолт	0.9%



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

### Тэргүүлэх чиглэл

Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэл

- ✓ Газрын тос
- ✓ Байгалийн хий
- ✓ Ган
- ✓ Авто тээврийн хэрэгсэл
- ✓ Сансрын тоног төхөөрөмж
- ✓ Химийн үйлдвэрлэл, химийн бүтээгдэхүүн
- ✓ Харилцаа холбоо
- ✓ Цахилгаан бараа
- ✓ Хоол боловсруулах үйлдвэрлэл
- ✓ Өргөн хэрэглээний бараа
- ✓ Уул уурхай
- ✓ Мэдээллийн технологи

Хөнгөн үйлдвэрийн тэргүүлэх чиглэл

- ✓ Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- ✓ Резин болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- ✓ Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх үйл ажиллагаа

### 3.2.2 Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал

Хүснэгт 26. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ

Нэхмэл	18.79
Хувцас үйлдвэрлэл	9.5
Мод, модон эдлэл	6
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх үйл ажиллагаа	80.2
Цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	4.3
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	41.3
Тавилга үйлдвэрлэл	19
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	605.8
Резин болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл	240

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

### 3.2.3 Аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого<sup>142</sup>

#### Хөгжлийн стратеги ба аж үйлдвэрийн бодлого, үндэслэл, бүтэц<sup>143</sup>

Америкийн нэгдсэн улс үйлдвэрлэлийн хөгжилд дараах хүчин зүйлсийн нөлөөлөл өндөр байсан гэж үзсэн байдаг. Эдгээр нь:

- ✓ Төмөр зам
- ✓ Засгийн газрын бодлого
- ✓ Байгалийн нөөц
- ✓ Цагаачлал
- ✓ Шинэ бүтээл
- ✓ Бизнесийн шинэ туршлага: Хэвтээ ба босоо интеграцчилал: өрсөлдөөнийг арилгах янз бүрийн арга замууд энэ үед бий болсон (бизнесийг илүү үр дүнтэй болгодог) зэрэг юм.

Ерөнхийдөө үйлдвэрлэгчид эдийн засгийн үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ явуулах, боловсруулалт, инновацид хөрөнгө оруулалт хийх, бараа бүтээгдэхүүнийг экспортлох талаараа цар хүрээний хувьд бусдаас хавьгүй илүү байдаг гэж хэлж болох тул АНУ дараах үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуулж, бодлого үйл ажиллагаандаа тусгах замаар үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

#### Татвар ба зохицуулалтын шинэчлэл

АНУ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах дэлхийн хамгийн сайн орчин, газар байх болно гэсэн уриаг хэрэгжүүлж ирсэн. Үүний тулд судалгаа, боловсруулалт, үйлдвэрлэлийг дэмжих татвар, зохицуулалтын орчин заавал хэрэгтэй юм.

#### Илүү сайн боловсрол, тасралтгүй сургалт

Хүний нөөц бол хөгжлийн хамгийн анхдагч эх сурвалж болохын зэрэгцээ үйлдвэрлэлийн чухал орц болж байдаг.

#### Нээлттэй зах зээл болон дэлхийн худалдааны хуулийн хэрэгжилт

Зах зээл хэдий чинээ нээлттэй байна тэр хэрээр үйлдвэрлэлийн хөгжил эрчимжих боломж өндөр байна. Ялангуяа дэлхийн болон бүс нутгийн худалдааны байгууллагад элсэн орж, холбогдох шаардлагыг хангаснаар хөнгөлөлт эдлэх зэрэгтэй холбоотой эерэг, таатай боломжуудыг ашиглах боломжтой болно.

#### Холбооны засгийн газрын суурь болон хэрэглээний судалгааг дэмжих үйл ажиллагаа

Судалгааны чанар технологийн хөгжлийг тодорхойлж байдаг тул холбооны засгийн газраас судалгаа шинжилгээний чанарыг нэмэгдүүлэх, үр дүнг нь бодит амьдралд нэвтрүүлбэл үйлдвэржилтийн хөгжил илүү сайн байх боломжтой.

#### Дэд бүтэц болон эрчим хүчний стратеги

Дэд бүтцийн хангалттай сайн орчингүйгээр үйлдвэрлэл явуулах боломжгүй тул дэд бүтцийн орчин хүрэлцээтэй байгаа эсэхэд үнэлгээ өгч, ямар хэмжээний дэд бүтэц ирээдүйд хэрэгтэй байгаа талаар тооцоо судалгаа хийж байх нь үйлдвэрлэлийн тасралтгүй хөгжлийг хангахад

<sup>142</sup> India's Industrial Policy (drishtias.com)

<sup>143</sup> IndustrialpolicyintheUnitedStates.pdf

чухал.

### **3.2.4 Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Сүүлийн жилүүдэд мэдлэг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх явдлыг дэлхийн улс орнууд, ялангуяа өндөр хөгжилтэй орнууд үйлдвэрлэлийн ирээдүйн хөгжлийн суурь байх болно гэж үзэж байна. АНУ 2014 онд “АНУ-ын Үйлдвэрлэл, Инновацийг сэргээн хөгжүүлэх” акт батлагдсан байдаг. Энэхүү хуулийн зорилтууд нь:

- ✓ АНУ-ын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг сайжруулах;
- ✓ АНУ-ын дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- ✓ Үйлдвэрлэлийн дэвшилтэт судалгаа, инноваци, технологи дахь АНУ-ын манлайллыг идэвхжүүлэх;
- ✓ Өндөр түвшний үйлдвэрлэлийн боловсон хүчний хөгжил, мэргэжлийн ур чадварыг хангах;
- ✓ Ажлын байрыг хадгалах, бий болгох зэрэгт оршиж байна.

### **АНУ дахь аж үйлдвэрийн бодлого**

“Бид аж үйлдвэрийн бодлого явуулдаггүй” гэж мэдэгддэг хэдий ч АНУ тодорхой салбар, аж үйлдвэрийг дэмжин сурталчлах тал дээр бусад улс орнуудаас илүү идэвхтэй байсан. Гэхдээ АНУ аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг үргэлж боловсруулж, хэрэгжүүлж байсан гэж хэлж болно.

### **АНУ-ын аж үйлдвэрийн бодлогын мөн чанар**

2009 оны 2-р сарын 17-нд Обама Америкийн сэргээн босголт, хөрөнгө оруулалтын тухай (American Recovery and Reinvestment Act) хуульд гарын үсэг зурсан юм. Энэ хуулийн үр нөлөөг одоогийн холбооны засгийн газрын буцалтгүй тусламж, үзүүлсэн татварын хөнгөлөлтүүдээс харж болно. 2000-2015 оны хооронд АНУ-ын холбооны Засгийн газар 68 тэрбум долларын буцалтгүй тусламж үзүүлж, бизнес эрхлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлсэн байдаг. Ингээд Америкийн аж үйлдвэрийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, туршлагыг танилцуулъя.

### **Засгийн газрын худалдан авалт**

Хорьдугаар зууны үед АНУ холбооны төсвийнхөө нэлээд хэсгийг цэргийн чадавхыг бэхжүүлэхэд зарцуулсан. Энэ нь цэрэг дайны холбогдолтой төрийн худалдан авах ажиллагааны асар өндөр дүнтэй гэрээнүүдийг байгуулахад хүргэсэн. Хүйтэн дайн нь цэргийн стратегийг агаарын, цөмийн, автоматжуулсан, алсын удирдлага зэрэг шинэ чадавхыг бэхжүүлэх шалтгаан болж өгсөн юм. Ерөнхийдөө засгийн газрын худалдан авалт аж үйлдвэрийн хөгжлийг сайн дэмжиж өгдөг гэж үздэг.

### **Худалдааны бодлого**

АНУ-ын засгийн газар дотоодын үйлдвэрүүдэд гадаадын зах зээлд нэвтрэхэд нь улам бүр туслалцаа үзүүлэх болжээ. Обама засгийн газраас жижиг бизнес эрхлэгчидтэй холбооны гэрээ байгуулахыг чухалд үзсэн бөгөөд Холбооны гэрээгээр дамжин хийгдэх худалдан авалтын хангалтын 23 хувийг жижиг, дунд үйлдвэрүүдэд (ЖДҮ) олгохоор Засгийн газар Америкийн сэргээн босголт, хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу үүрэг хүлээсэн юм. Нийтдээ холбооны засгийн газрын гэрээний үнийн дүнгийн 32.6 хувьтай тэнцэх бараа үйлчилгээг жижиг бизнес эрхлэгчдээс худалдаж авсан байдаг. Үнийн дүн нь ойролцоогоор 221 тэрбум доллар-тай тэнцэж байв.

## **Гарааны хөрөнгө буюу Венчур капитал (venture capital)**

АНУ-ын холбооны олон агентлагууд өөрсдийн олон нийтийн хөрөнгө оруулалтын (VC) санхүүжилтийг хэрэгжүүлэх санаачлагыг гаргасан юм. Гэхдээ ашиг олох зорилготой хувийн сангуудаас ялгаатай нь төрийн байгууллагууд сангийн хөрөнгийг арилжааны зориулалттай технологийг хөгжүүлэх, нутагшуулах, хэлбэржүүлэхэд ашигладаг.

Агентлагууд нь ихэвчлэн жижиг бизнесүүдийн захирлуудын зөвлөлд гишүүнчлэлийн үүрэг гүйцэтгэж, туршилт хийх аль эсвэл зохион байгуулалт, техникийн хамтын ажиллагаагаар дамжуулан шинэ технологийг хөгжүүлэх үйл ажиллагаанд гар бие оролцдог. Энэ нь өндөр технологийн ЖДҮ эрхлэгчдэд таатай орчныг бүрдүүлэх сайн нөлөөтэй тул арилжааны хувьд ашигтай байхын зэрэгцээ шинэлэг технологийг хөгжүүлэхэд хялбар байдлыг бий болгож байлаа.

Холбооны засгийн газрын анхны Венчур капиталыг Тагнуулын төв газар (CIA) 1999 онд байгуулсан түүхтэй. Төсөв нь 28 сая доллар байсан бөгөөд энэхүү сангийн зорилго нь зах зээлд борлогдох боломжтой, ТТГ-ын шаардлагад нийцүүлэн ашиглах аль эсвэл үйл ажиллагаанд нь дасан зохицох боломжтой шинэ технологийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах явдал байв.

Эдгээр төрлийн технологийг өндөр технологийн ЖДҮ эрхлэгчид улам бүр боловсронгуй болгож байсан хэдий ч уламжлалт аргаар худалдан авах боломж хязгаарлагдмал байсан юм. Холбооны засгийн газар ЖДҮ-ээс инновацийг хөгжүүлснийх нь дараа гаргаж авсан технологийг нь худалдаж авахыг илүүд үзсэн. ТТГ ихэвчлэн удаан хугацаагаар хүлээсний дараа бэлэн болсон технологийг худалдаж авдаг байсан бөгөөд технологи нь маш боловсронгуй байсан хэдий ч цөөнгүй тохиолдолд агентлагийн үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байв.

Агентлаг нь жижиг пүүсүүдэд хувьцааны хөрөнгө оруулалт хийх, стратегийн зөвлөгөө өгөх, зохион байгуулалтын удирдамжаар хангах, бусад венчур капиталистуудтай хөгжлийн түншлэл хийх замаар технологийн хөгжлийг дэмжсэн.

Өөрөө хөрөнгө оруулалт хийснээр ТТГ нь ЖДҮ-ийн инновацийн үйл ажиллагаатай танилцах боломжтой болохын зэрэгцээ тэдний судалгааны зарим хэсгийг хэсэгчлэн удирдан чиглүүлэх боломжтой болж байсан юм. Түүнчлэн холбооны агентлаг нь лаборатори эсвэл худалдан авах ажиллагааны агентлаг шиг ажилладаг байв. Тусгай зөвшөөрөл худалдан авах, технологи хөгжүүлэх чиглэлээр компаниудтай гэрээ байгуулж, зарим бизнесийн түншүүдэд бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд өөрийн лабораторийг ашиглахыг санал болгож байлаа.

АНУ-ын мужууд Венчур капиталын санг түгээмэл ашиглаж байна. 2015 онд Нью-Йорк муж "Инновацийн венчур капиталын сан"-г байгуулав. 100 сая долларын төсөвтэй байгуулагдсан энэхүү сан нь өндөр өсөлттэй шинэ бизнесүүдийг дэмжихийг гол зорилгоо болгон ажилладаг. Ялангуяа шинэ технологийг сурталчлах, эдийн засгийн өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлэхэд сангийн үйл ажиллагаа чиглэж байна. 2013 онд Обамагийн үед байгуулагдсан "Улсын Жижиг Бизнесийн Зээлийн Санаачлага" (SSBCI) -тай хамтран байгуулагдсан улсын хэмжээний 36 Венчур капиталын 30 муж улсад сан ажиллаж байсан юм.

### **Том үйлдвэрүүдийг зориуд дэмжих нь**

АНУ уналтад орсон дотоодын үйлдвэрүүдэд тусалж, дэмжлэг үзүүлж байсан түүхтэй.



Гангийн үйлдвэр, Chrysler гэх зэрэг эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтөд шийдвэрлэх ач холбогдолтой зарим үйлдвэрүүдийг дэмжиж, шаардлагатай гэж үзвэл өрсөлдөх чадвартай болгохын тулд компаний засаглалын бүтцэд хөндлөнгөөс оролцож байлаа. Үүний нэг жишээ нь АНУ-ын Засгийн газар 2008 онд General Motors (GM) -ийг худалдаж авсан явдал юм.

Санхүүгийн хямралын дараа Буш, Обамагийн засаг захиргаа хоёулаа санхүүгийн үйлчилгээний салбарт хөндлөнгөөс оролцсон. Тэд АНУ-ын эдийн засгийн богино хугацааны тогтвортой байдал, урт хугацааны өсөлтөд санхүүгийн салбарын шинэчлэл нэн чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзсэн байдаг.

### **Татварын бодлого**

Хувийн хөрөнгө оруулалтын салбарт татварын хөнгөлөлт үзүүлэхээс гадна болон тодорхой нөхцөлөөр татаас өгдөг. АНУ-ын татварын хөнгөлөлтийн бодлогын ихэнх нь муж улсын түвшинд хэрэгждэг.

Сүүлийн дөчин жилийн хугацаанд муж улсууд нутаг дэвсгэр дээрээ бизнесийг хөгжүүлэх, эрхлэх компаниудыг татах, аль хэдийн байгуулагдсан компанийг авч үлдэхийн тулд хоорондоо өрсөлдөж ирсэн байдаг. Татвар нь муж улсын эдийн засгийн хөгжлийн стратегийн гол хэрэгсэл бөгөөд татварыг эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг бий болгох, хадгалах, өндөр үнэ цэнэтэй технологид түшиглэсэн аж үйлдвэрийн салбар компаниудыг бий болгох зорилтот зорилгоор ашигладаг. 2002 онд муж улсын болон орон нутгийн бизнес эрхлэгчдийн үзүүлсэн татварын урамшууллын хэмжээ жил бүр 50 тэрбум доллар-аас буудаггүй байсан.

Татварын хөнгөлөлттэй холбоотой хөтөлбөрүүдийн зорилго нь муж доторх бизнес эрхлэгчдийн харилцан ялгаатай төрөл бүрийн хэрэгцээг хангах замаар муж улсын эдийн засгийг хөгжүүлэхэд оршино. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр муж улсууд одоогийн бизнесээ хөгжүүлэх, хадгалан үлдэх, бизнесийн ерөнхий уур амьсгалыг таатай болгох, дэд бүтцийг сайжруулах, шинэ бизнес эрхлэхэд нь бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлдэг.

2015 онд АНУ-д татварын хөнгөлөлттэй холбоотой 1934 хөтөлбөр хэрэгжиж байжээ. Эдгээр хөтөлбөрийн ихэнхийг мужийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх агентлаг удирддаг. Тэргүүлэх агентлаг нь татварын хөнгөлөлт, буцалтгүй тусламж, зээл, хувьцааны хөрөнгө оруулалт, татвараас чөлөөлөх зэрэг бизнес эрхлэгчдэд үр өгөөж өгөх олон хөшүүргийг үйл ажиллагаандаа ашигладаг. 2015 онд татварын хөнгөлөлт нь татварын 69 төрлийн хөнгөлөлт бүхий урамшууллын хөтөлбөрөөр дамжин хэрэгжсэн байдаг. Татварын урамшууллын хөтөлбөр нь улсын хэмжээнд хэрэгжүүлж буй төрийн захиргааны хөтөлбөрүүдийн 45 хувийг эзэлдэг.

Түүнчлэн хөрөнгө оруулалтын томоохон байгууламжийг бий болгох, өсгөхөд нь түлхэц үзүүлэх зорилгоор томоохон хөрөнгө оруулалтын зарим хэсгийг үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлөх саналыг гарган хэрэгжүүлдэг.

Үйлдвэрлэл нь олон шалтгаанаар мужуудын ашиг сонирхлыг татдаг гэж хэлж болно. Нэгдүгээрт, үйлдвэрийн газрууд нь ажиллагсдад ихэвчлэн харьцангуй өндөр цалин, тэтгэмж санал болгодог. Хоёрдугаарт, томоохон үйлдвэрүүд ханган нийлүүлэгчдийг ойр хавиасаа олохыг эрмэлздэг тул тухайн мужид орших үйлдвэр, аж ахуйн газруудын орлогыг нэмэгдүүлэх, илүү олон ажлын байр бий болгох боломжийг олгодог гэж үздэг байна.

## **Санхүүгийн хүртээмж**

Жижиг бизнес хариуцсан удирдах байгууллага (Small Business Administration) нь 1953 онд хувийн зах зээл дэх өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, жижиг бизнес эрхлэгчдийн ашиг сонирхлыг дэмжих зорилгоор байгуулагдсан.

Одоогийн байдлаар бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор олон төрлийн хөтөлбөрөөр дамжуулан жижиг бизнес эрхлэгчдийг дэмжиж байна. Холбооны гэрээ байгуулах, жижиг бизнес эрхлэгчдийн хөрөнгийн хүртээмжийг сайжруулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, зээлийн баталгаа гаргах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулахын зэрэгцээ шинэ бизнесийг бий болгох, өргөжүүлэхэд дэмжлэг болох сургалтуудыг явуулж байна. Эдгээр арга хэмжээнүүд нь нэгдэж, олгосон санхүүжилтийн ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, зээлийн эргэн төлөлтийг сайжруулах нөлөөг үзүүлнэ гэж үзсэн. Түүнчлэн зээлдүүлэгчийн олгосон зээлийн тодорхой хэсэгт SBA нь баталгаа гаргадаг. Зээлдүүлэгч нь зээлийн холбоо, зохицуулалттай банк эсвэл олон нийтэд түшиглэсэн зээлийн байгууллага байж болно.

Үйлдвэрлэл явуулдаг бизнесүүдийн ажилчдын дундаж тоонд интервал тогтоодог бөгөөд энэ нь үйлдвэрлэлийн төрлөөс хамаарч 500-аас 1500-ийн хооронд хэлбэлздэг. Барилгын салбарын бизнесүүдийн жилийн дундаж орлогыг мөн доод, дээд утгынх нь хувьд тодорхойлж 15-36,5 сая долларын хооронд байна гэж үзжээ. Ингэж хязгаарлалтууд тогтоох нь зээл, санхүүжилтийн бодлогыг харилцан ялгаатайгаар боловсруулж хэрэгжүүлэхэд тустай гэж үзсэн байдаг.

Америкийн сэргээн босголт, хөрөнгө оруулалтын тухай хууль нь жижиг бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулж, SBA-ийн дэмжлэгтэйгээр зээлдэгчдэд төлөх төлбөрийн хэмжээг бууруулсан.

Жижиг бизнесийн зээлийн сан (Small Business Lending Fund) нь олон нийтийн хөгжлийн зээлийн сан (community development loan funds) болон банкуудад санхүүжилт олгож байлаа. Санхүүжилтийн зорилго нь жижиг бизнес эрхлэгчдэд олгох зээлийг нэмэгдүүлэх, урамшуулах явдал байв.

Санхүүжилт авсан байгууллагууд нь жижиг бизнесийн зээлийн сангийн дэмжлэгтэйгээр авсан санхүүжилтээсээ хэд дахин өндөр дүнтэй зээлийг бодитойгоор олгосон нь дамжиггүй юм.

## **Экспортын дэмжлэг**

Худалдааны саадыг арилгах нь чухал боловч АНУ-ын үе үеийн засгийн газрууд АНУ-ын экспортлогчдыг илүү өрсөлдөх чадвартай болгох замаар экспортыг дэмжих алхмуудыг хийсээр ирсэн байна. Экспортыг дэмжих хүрээнд экспортыг дэмжих хөтөлбөрүүдийг сурталчлах, экспортын санхүүжилт болон АНУ-ын экспортлогчдод гадаад зах зээлийн талаар боловсрол зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Худалдааны яамны нөлөөллийн төв (Department of Commerce's Advocacy Centre) нь АНУ-ын пүүсүүдэд гадаадын худалдан авалтын гэрээг байгуулахад нь тусалдаг. Энэхүү төв нь 2010 оны 1-р сараас 2012 оны 9-р сарын хооронд АНУ-ын олон зуун бизнес эрхлэгчдэд АНУ-ын экспортын нийт 111 тэрбум орчим долларын өртөгтэй гадаад худалдан авалтын гэрээг байгуулахад нь туслах зорилгоор байгууллагууд хоорондын бүлгийн зохицуулалтыг хийсэн.

Түүнчлэн АНУ-ын экспортыг гадаадын худалдан авагчдад сурталчлахад холбооны засгийн газрын зүгээс хүчин чармайлт гаргасан. АНУ, Гадаад худалдааны алба нь АНУ-ын экспортлогчид болон гадаадын худалдан авагчдын хоорондын харилцааг зохион байгуулах, гадаад зах зээлийг хөгжүүлэх, худалдааг сурталчлах арга хэмжээг зохион байгуулах зэрэг олон арга хэлбэрүүдийг ашиглаж экспортыг дэмжиж байна.

АНУ-ын экспортлогчид Экспорт-импортын банк (Ex-Im Bank) -аар дамжуулан санхүүжилт авах боломжтой. Түүнээс гадна энэхүү банк нь АНУ-ын бараа бүтээгдэхүүнийг гадаадын компаниуд худалдаж авахад нь тэдэнд туслах зорилгоор зээлийн баталгаа гаргадаг, мөн зээл олгодог, даатгалын үйлчилгээг үзүүлдэг. 2015 оны 1-р сард Обама “Экспорт, Импортын” банк нь “Made in America” бүтээгдэхүүний Энэтхэг Улсад чиглэсэн экспортыг 1 тэрбум доллараар санхүүжүүлнэ” гэж мэдэгдэж байсан. Энэ ч үр дүнгээ өгсөн.

Үүний үр дүнд холбооны засгийн газар ЖДҮ эрхлэгчдээс экспортыг санхүүжүүлэхийн тулд илүү их зээл авахыг санал болгож байв. 2012 онд “Экспорт, Импортын” банк нь жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан экспортын санхүүжилтийн дээд хэмжээг 6.1 тэрбум доллар гэж тогтоосон. Энэ нь 2012 онд 3300 гаруй жижиг бизнес эрхлэгчдэд экспортын борлуулалтаа өргөжүүлэхэд нь тусалсан юм. “Экспорт, Импортын” банк нь санхүүжилтийн 81 хувь нь жижиг бизнес эрхлэгчдэд ашиг тусаа бодитойгоор өгсөн гэж дүгнэжээ.

#### **Үйлдвэрлэлийг дэмжих нь**

Энэ салбар нь ойролцоогоор 12 сая ажилчинтай. 2014 онд хувийн хэвшлийн судалгааны хөгжлийн зардлын 75 хувийг, нийт барааны экспортын 86 хувийг эзэлж байна. АНУ-ын үйлдвэрлэлийн салбар нь нэг улсад хамаатай гэж төсөөлбөл зөвхөн энэ үзүүлэлтээрээ 2014 онд дэлхийн найм дахь том эдийн засагтай орны тоонд орох байлаа.

Обамагийн засаг захиргааны үйлдвэрлэлийн салбарыг сэргээх стратегийн чухал зорилтыг ‘Make it in America’ хөтөлбөрт багтаажээ. 2010-2012 оны хооронд Обама үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх, инновацийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, патентын системийг хөгжүүлэх, ажлын байрны өсөлтийг бий болгох, АНУ-ын үйлдвэрлэлийг дэмжих гэсэн дөрвөн хүрээний томоохон зорилтуудыг тусгасан “Америкт үүнийг хий” гэсэн эрх зүйн бичиг баримтыг баталсан юм. Жишээ нь 2010 оны АНУ-ын Үйлдвэрлэлийг сайжруулах тухай (United States Manufacturing Enhancement Act) хуульд АНУ-ын үйлдвэрлэгчдийн ашигладаг түүхий эд, зуучлагчдын түүхий эдийн зуучлагчдын тарифыг бууруулах, судалгаа хөгжлийн ажилд татаас өгөх, дэд бүтцийг сайжруулахтай холбоотой тодорхой заалтуудыг тусгасан юм.

Сүүлд нь Обама ‘Buy American’ заалтыг хуульд нэмж тусган, дотоодын үйлдвэрлэгч компаниудын хувьд АНУ-ын төрийн худалдан авах ажиллагааны гэрээнд оролцоход хялбар байдлыг бий болгосон. Холбооны засгийн газар гадаад орнуудын өрсөлдөгчидтэй өрсөлдөхүйц байхын тулд бараа бүтээгдэхүүний экспортын 88 хувийг эзэлж байгаа энэ салбарын урт хугацааны бүтцийн өөрчлөлтийг дэмжихийг хичээв.

Энэ нь АНУ-ын гадаад худалдааны алдагдлыг арилгахад үйлдвэрлэл чухал үүрэг гүйцэтгэж чадна гэдэгт Холбооны засгийн газар итгэсэн хэрэг байсан юм. Шинэ технологид түшиглэсэн өндөр технологийн үйлдвэрлэл нь гадаадын цөөн тооны, өрсөлдөгч, өндөр бүтээмж, цалин хөлс зэргээс шалтгаалан онцгой ач холбогдолтой байв. Гэсэн хэдий ч АНУ өндөр технологийн батерей, салхин цахилгаан үүсгүүр, нарны зай хураагуур, биотехнологи, өндөр хурдны төмөр зам, компьютерт суурилсан архитектур зэрэг өндөр технологийн олон

салбарт сорилттой тулгарч байв.

Автомашин дэвшилтэт үйлдвэрлэлийн зээлийн хөтөлбөр, АНУ-ийн сэргээн босголт, хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу Нано технологийн чиглэлээр хийгдэх судалгаа, хөгжлийн санхүүжилт зэрэг аж үйлдвэрийн зорилтот салбарын бодлоготой холбоотой арга хэмжээнүүдийг үйлдвэрлэлийн салбарыг илүү өрсөлдөх чадвартай болгоход чиглүүлэхийг чухалчлан бодлогын хэрэгжилтийг хангаж ажилласан байдаг.

### **ЖДҮ эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэг**

2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараа Ерөнхийлөгч Б.Обама ЖДҮ эрхлэгчид Америкт гурван ажлын байр тутмын хоёрыг өөртөө шингээж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, улс орон даяар шинэ үйлдвэрүүдийг бий болгож байна хэмээн онцлон тэмдэглээд АНУ-ын аж үйлдвэрийн бодлогыг шинэчлэн боловсруулсан байдаг. АНУ-ын жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих дэмжлэгийг тоймлон харвал дараах байдалтай байна.

- ✓ Зээлийн баталгаа
- ✓ Хөнгөлөлттэй зээл
- ✓ Экспортын зээл
- ✓ Татварын хөнгөлөлт
- ✓ Жижиг бизнесийн инновацийн судалгаа хөтөлбөр, энэ нь жижиг бизнесүүдийг урт хугацаат санхүүжилтийнхээ тодорхой хэсгийг заавал судалгаа хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулах ёстой болохыг зохицуулсан байдаг тул пүүсийн нэр хүндийг өсгөх нөлөөг үзүүлж, улмаар венчур капиталын санхүүжилтийг олж авахад хялбар байдлыг бий болгодог байна.
- ✓ Технологийн бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүжилтийн дэмжлэг
- ✓ Татаас өгөх
- ✓ Төрийн худалдан авах ажиллагааны гэрээ
- ✓ Тарифын хөнгөлөлт
- ✓ Судалгаа шинжилгээний ажилд татвараас хөнгөлөх
- ✓ Санхүүгийн хүртээмжтэй байдлыг хангах
- ✓ Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих
- ✓ Төрийн хүнд суртлыг багасгах зэрэг болно.

## **3.3 БНХАУ**

### **3.3.1 Хятад улсын ДНБ-ний өнөөгийн байдал, бүтэц, онцлог<sup>144</sup>**

2020 оны байдлаар БНХАУ-ын ДНБ дэлхийн ДНБ-ний 17 хувийг эзэлж, 1 хүнд ногдох ДНБ 11,819 ам доллартай тэнцэж байна. ДНБ-д эзлэх хувь хэмжээг үйлдвэрлэлийн салбарын үндсэн бүтцийн хувьд авч үзвэл ХӨАА 7.7 хувь, Аж үйлдвэр 37.7 хувь, үйлчилгээ 54.5 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 27. ДНБ-ний бүтэц 2020 он тэрбум ам. Доллар

Хөдөө аж ахуй	1234.19
Уул уурхайн олборлолт	401.321
Боловсруулах үйлдвэрлэл	4590.6
Цахилгаан, дулаан	320.614


<sup>144</sup> Innovative-China-New-Drivers-of-Growth,%20industrial%20policy.pdf

Барилга	1055.79
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	1482.29
Тээвэр	709.526
Зочид буудал	280.393
Мэдээлэл холбоо	503.917
Санхүүгийн зуучлал	1248.22
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1030.05
Лизингийн болон бизнесийн үйлчилгээ	417.78
Мэргэжлийн болон техникийн үйл ажиллагаа	309.186
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	90.9091
Өрхийн үйлчилгээ, засвар үйлчилгээ	280.668
Боловсрол	571.06
Эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ	363.18
Урлаг, спорт, соёлын үйл ажиллагаа	126.889
Төрийн удирдлага	649.42

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

### Аж үйлдвэрийн салбарын тойм <sup>145</sup>

Уул уурхайн олборлолт	2.6%
Боловсруулах үйлдвэрлэл	29.3%
Цахилгаан, дулаан	2.0%



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

### Тэргүүлэх чиглэл

#### Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэл

- ✓ Уул уурхай
- ✓ Хүдэр боловсруулах
- ✓ Төмөр
- ✓ Ган
- ✓ Хөнгөн цагаан
- ✓ Болон бусад металлууд
- ✓ Нүүрс
- ✓ Машин үйлдвэрлэл
- ✓ Нэхмэл эдлэл
- ✓ Хувцас
- ✓ Газрын тос
- ✓ Цемент
- ✓ Химийн бодис
- ✓ Бордоо

#### Хөнгөн үйлдвэрийн тэргүүлэх чиглэл

- ✓ Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- ✓ Хувцас үйлдвэрлэл
- ✓ Нэхмэл

<sup>145</sup> Manufacturingcompetitiveness.pdf

- ✓ Хоол боловсруулах үйлдвэрлэл
- ✓ Мэдээллийн технологи
- ✓ Тээвэрлэлтийн тоног төхөөрөмж
- ✓ Автомашин

### 3.3.2 Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал

(2020 он тэрбум ам.доллар)

Нэхмэл	522.15
Хувцас үйлдвэрлэл	320
Мод, модон эдлэл	23.8
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх үйл ажиллагаа	129.3
Цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	176
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	14
Тавилга үйлдвэрлэл	107
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1500
Резин болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл	380

### 3.3.3 Аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого<sup>146</sup>

#### Хөгжлийн стратеги ба аж үйлдвэрийн бодлого, үндэслэл, бүтэц

1978 оноос хойших 37 жилийн хугацаанд Хятадын эдийн засгийн тогтвортой өсөлт нь аж үйлдвэрийн амжилтын түүхтэй нь шууд холбоотой. Хятад Улс бүтцийн өөрчлөлтийг эрчимтэй хийж, хөгжлийн гүн гүнзгий үйл явцыг хэрэгжүүлж ирсэн. Сүүлийн үед Хятад Улс илүү их хөрөнгө, технологи шаардсан үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг эрмэлзэж байна.

Тус улсын үйлдвэрлэгч пүүсүүдийн үйлдвэрлэдэг ихэнх бүтээгдэхүүн нь технологийн хувьд нарийн ажиллагааг шаарддаггүй байсан. Үйлдвэрлэл эрхэлдэг олон жижиг дунд үйлдвэр эрхлэгчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээсээ маш бага хэмжээний ашиг олдог, бизнесийн хүрээ, үйлдвэрлэлийн тоо хэмжээгээ их хэмжээгээр нэмэгдүүлж байж л ашгаа өсгөх боломжтой байлаа.

Эдүгээ экспортын зах зээлийн тэлэлт саарч, үйлдвэрлэлийн өртөг (жишээ нь ажиллах хүч, түүхий эд, эрчим хүч, газар) огцом өсч байгаа үед үйлдвэрлэл эрхлэгчид оршин тогтноход бэрхшээлтэй тулгарч байна. Цаашилбал, их хэмжээний үйлдвэрлэл нь хүрээлэн буй орчны нөхцөл байдлыг ихээхэн эвдэхэд хүрдэг. Төр засгийн газрын зүгээс байгаль орчны талаар илүү хатуу дүрэм журмыг баталж, улмаар бохирдлыг бууруулах шаардлага, хөрөнгө зардлыг нэмэгдүүлж байна.

Сүүлийн 30 жилийн турш харьцангуй давуу талаа ашиглаж, Хятад Улс аж үйлдвэрээ санамсаргүй, богино хугацааных гэхээсээ илүү аж үйлдвэржүүлэлт, урт хугацааны бодлогын зорилтуудаар дамжуулан хөгжүүлэх зарчмуудыг гол чиглэлээ болгож ирсэн гэж хэлж болно. Бодлого нь дараах хүчин зүйлсийг харгалзаж ирсэн. Эдгээр нь зах зээлд чиглэсэн аж үйлдвэрийн хөгжил, экспортыг дэмжсэн үйлдвэрлэл, гадаадын шууд хөрөнгө оруулалт, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, инноваци, томоохон зах зээлийн бизнесийн загвар зэрэг болно.

Хятадын хөгжлийн стратеги нь зах зээлийн өргөн талбар, хүчин зүйлийн орцын хямд өртөг,

<sup>146</sup> [India's Industrial Policy \(driштиias.com\)](http://India's Industrial Policy (driштиias.com))



тухайлбал ажиллах хүч, мөн газар, цахилгаан, түүхий эдийн өртөг зэргийг давуу тал болгон ашиглахад чиглэдэг. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр Хятад Улс эдгээр давуу талуудаа чанаржуулах, сул талуудаа (хүнд суртал, чанаргүй ажиллах хүч гэх зэрэг) аль болох багасгах, ложистикийн чадавхаа сайжруулах, технологийн үнэ цэнийн сүлжээг дээшлүүлэхийг эрмэлзэж ирсэн. Хятад Улс их хэмжээний үйлдвэрлэлийг хөшүүрэг болгох, тээврийн зардлыг бууруулах, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор дэд бүтэц, ложистикт томоохон хөрөнгө оруулалт хийжээ. Гуандун дахь гадаадын шууд хөрөнгө оруулалттай кластерууд, Жэжян дахь бүтээгдэхүүний дагнасан кластерууд бүхий Хятадын нийлүүлэлтийн сүлжээний өсөлт зэрэг нь Хятадын Засгийн газар болон аж ахуйн нэгжүүд цар хүрээг өрсөлдөөний байнгын давуу тал болгон хувиргаж байгаагийн төгс жишээ юм.

### **3.3.4 Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Өнгөрсөн жилүүдэд Хятад улс үйлдвэрлэлийн сууриа нээлттэй хаалганы бодлогыг хэрэгжүүлэх замаар хөгжүүлэхийг эрмэлзэж ирсэн. Ингэхдээ гадаадын шууд хөрөнгө оруулалтыг (ГШХО) татах, технологийн импортыг өсгөх, техникийн чадавхыг сайжруулах, хөгжлийн хөшүүрэг болсон зах зээлийнхээ асар том хэмжээг үр дүнтэй ашиглах оролдлогуудыг бүтээлчээр хийж ирсэн юм.

Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-д элссэн нь Хятад улс дэлхийн үйлдвэрлэлийн өртгийн сүлжээнд оролцох боломжийг олгосон цаг үеэ олсон чухал үйл явдал байлаа. Олон үндэстэн дамнасан корпорациуд үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа Хятад руу нүүлгэн шилжүүлсэн нь тус улсын үйлдвэрлэлийн орчны таатай байдалд ихээхэн нөлөөлжээ. Үйлдвэрлэлд ингэж өөрчлөлтүүд орох нөхцөл бүрдсэний дараа орон нутгийн хэмжээний үйлдвэрлэл, зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах зорилт бүхий технологийн олон төвүүд, судалгаа шинжилгээний (R&D) байгууламжууд байгуулагдсан.

Үйлдвэрлэлийн салбараа өөрчлөх, шинэчлэх зорилгоор тус улс 2015 оноос “Хятадад үйлдвэрлэв 2025” үндэсний стратегийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь 3D инноваци, дижитал дизайн, үйлдвэрлэл, роботын автоматжуулалт гэх зэрэг инноваци, технологийн дэвшилд түшиглэсэн үйлдвэрлэлд түлхүү анхаарсан юм.

Засгийн газар нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын тогтвортой өсөлтийг хангахын тулд хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлэх, гадны компаниудтай нэгдэх, нийлэх замаар бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, зах зээлээ нэмэгдүүлэх боломжтой болж ирсэн юм.

Сүүлийн 20 жилд Хятадын "технологийн зах зээлийг хөшүүрэг болгох нь" стратеги үр дүнгээ харьцангуй сайн өгсөн гэж хэлж болно. Хятадын үйлдвэрлэгч компаниуд техник технологийн чадавхаа эрс дээшлүүлж, 200 гаруй бүтээгдэхүүний ангиллаар дэлхийн зах зээлд тэргүүлэгч болжээ. Дэлхий даяар үндэстэн дамнасан компаниуд болон нутгийн уугуул компаниудыг багтаасан нарийн зохион байгуулалт бүхий ханган нийлүүлэлтийн сүлжээ байгуулагдсан.

Зөвхөн санхүүгийн эх үүсвэр төдийгүй техникийн мэдлэг, менежментийн ур чадварыг хөгжүүлж чадах бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах чадварыг мөн ихээхэн дээшлүүлсэн. Энэ нь шууд хөрөнгө оруулалтын сайн жишээнд тооцогддог.

### **Экспорт ба гадаадын шууд хөрөнгө оруулалт**

Хятадаас гадна хөгжиж буй бусад олон орнууд экспортод чиглэсэн болон шууд хөрөнгө

оруулалтын чиг баримжаатай стратегийг баримталж ирсэн боловч энэхүү стратеги нь тухайн улсын онцлогоос шалтгаалж аж үйлдвэрийн шинэчлэлд өөр өөр нөлөө үзүүлж байна. Хөгжиж буй орнууд аж үйлдвэрийн салбараа хөгжүүлэхдээ өргөн цар хүрээтэй хувьчлал, нээлттэй зах зээлтэй холбоотой загварыг дагаж мөрдөж байхад Хятад Улс аж үйлдвэрийн салбараа экспорт болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын боломжит өсөлтөөр дамжуулан хөгжүүлэхийг зорьж байсан.

Зөвхөн импортыг либералчлах нь экспортыг огцом нэмэгдүүлэхэд хангалттай гэж үзэхгүй байв. Хятад нь эдийн засгийн системийн шинэчлэл, гадаад улс орнуудад зах зээлээ аажмаар нэмэгдүүлэх гэсэн аж үйлдвэрийн өсөлтөд зайлшгүй шаардлагатай хоёр чиглэлийг аж үйлдвэрийн хөгжлийн стратегиа болгож ирсэн юм.

### **Экспортын бүтэц, үйлдвэрлэлийн шинэчлэлд хийгдсэн чухал алхам**

Хятад Улс хоёр чухал алхам хийсэн. Нэг нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд (FIEs) нь Хятадын эдийн засгийн тэлэлт, аж үйлдвэрийн шинэчлэлд маш чухал үүрэг гүйцэтгэх боломжийг олгосонд оршиж байв.

Удаах нь Хятадын экспортын өсөлтөд чухал нөлөөтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг гадаад улс оронд үйлдвэрлэгдсэн, импортын татваргүй орцуудыг ашиглан угсрах, бүтээх замаар явуулж байсан үйл явц юм. Өөрөөр хэлбэл, Хятад улс боловсруулах худалдааг хэрэгжүүлсэн. Боловсруулах худалдаа нь түүхий болон туслах материал, эд анги, эд анги, дагалдах хэрэгсэл, сав баглаа боодлын материалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь гадаадаас импортлох, импортолсон орцуудаа дотоодын аж ахуйн нэгжүүд боловсруулж бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлээд, түүнийгээ буцааж экспортлох бизнесийн үйл ажиллагааг илэрхийлсэн ойлголт юм.

Хятад улсын үйлдвэрлэлийн томоохон амжилт нь том зах зээлтэй нь холбоотой боловч цаашдын хөгжил нь аж үйлдвэрийн чанараас ихээхэн хамаарна. Хятад Улсын аж үйлдвэрийн хөгжлийн давуу талуудад хүчирхэг, үр дүнтэй төвлөрсөн засаглал, элбэг дэлбэг, хямд боловч бүтээмжтэй ажиллах хүч, асар том, өсөн нэмэгдэж буй дотоод зах зээл, дэд бүтцийн өндөр чанар, хөдөлмөрийн нөөцийн тэвчээртэй, тууштай байдал, инноваци, хэмнэлттэй байх соёл зэрэг багтана.

Хятадын аж үйлдвэрийн хөгжилд сайтар боловсруулсан аж үйлдвэрийн бодлого, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах үр дүнтэй стратеги, экспорт нэн чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Өөрөөр хэлбэл, гадаад худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг илүү нээлттэй болгох эдийн засгийн шилжилтийг хэрэгжүүлж чадсан.

Эдгээр нь Хятадын давуу талыг үр дүнтэй ашиглах хурдасгуур болж өгсөн. Жишээлбэл, хямд ажиллах хүчийг экспортын боловсруулах болон гадаадын хөрөнгө оруулалттай, хөдөлмөрийн нөөцийн шингээмж өндөртэй үйлдвэрүүдэд, харин дотоодын томоохон зах зээлийг гадаадын хөрөнгө оруулагчдыг татахад ашигласан билээ.

Хятадын бусдаас ялгарах нэг онцлог нь зах зээлд чиглэсэн шинэчлэл байсан бөгөөд энэ нь үр дүнтэй хөгжлийн стратеги, аж үйлдвэрийн бодлогыг бий болгож, худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нээх, аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд түлхэц болсон юм.

### **Хятад 1. “MADE IN CHINA 2025” хөтөлбөр**

2001 онд Хятад улс ДХБ-д элссэн. Ингэснээр Хятад улс зах зээлээ гадаадын

өрсөлдөгчиддөө нээх ажлыг эхлүүлэв. Хийгдсэн гадаадын хөрөнгө оруулалтын ихэнх нь өнөөгийн олон арван мянган үйлдвэр аж ахуйн газруудын үүсэл, хөгжлийн шалтгаан болж хөгжсөн бөгөөд эдгээр нь бүтэц зохион байгуулалтын хувьд хамтарсан болон гадаадын хөрөнгө оруулалттай байдаг. БНХАУ-ын далайн эрэг хавьд байрладаг экспортод чиглэсэн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нь өндөр хөгжилтэй орнуудаас орчин үеийн тоног төхөөрөмж худалдаж авч, зардлын давуу талаа ашиглан үнийн хувьд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж байсан нь олон улсын үйлдвэрлэлийн салбарын аутсорсингийн бааз болоход нь нөлөөлсөн юм. “Хятадад үйлдвэрлэв” гэсэн шошготой бүтээгдэхүүнүүд нь дэлхийн зах зээлд брэнд болж алдаршиж эхэлжээ. Далайн эргийн аж ахуйн нэгжүүдийн зардлын давуу тал нь илүүдэл ажиллах хүч, ижил төсөөтэй үйлдвэрлэлийг нэгтгэсэнээс үүдэж бий болсон гэж үздэг.

Хятадын дэд бүтцийн барилга байгууламж, интернэтийн хөгжил нь үйлдвэрлэлийн салбарыг цэцэглэн хөгжихөд мөн ихээхэн хувь нэмэр оруулсан. Интернэтээр төлөөлүүлсэн мэдээллийн технологийн хөгжил нь үйлдвэрлэлийн салбарын хөдөлгөгч хүчин зүйл болж эхэлсэн. ERP, PLM, CRM, SCM зэрэг мэдээллийн системийг Хятадын аж ахуйн нэгжүүд цахим худалдааг хөнгөвчлөх зорилгоор өргөн ашигладаг. Энэ хугацаанд Хятадын аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, хэрэглээний зах зээл нь борлуулагчдад чиглэсэн зах зээлээс худалдан авагчдад чиглэсэн зах зээл болж бүрэн өөрчлөгджээ.

Үйлдвэрлэлийн зах зээлийг олон улсын түвшинд хүргэх нь нэг талаас бүтээгдэхүүний ангиллыг баяжуулдаг. Нөгөө талаас зах зээлийн өрсөлдөөнийг эрчимжүүлэх нөлөө үзүүлж байна. Хятад улс ДХБ-д элссэний дараа Хятадын үйлдвэрлэлийн салбар дэлхийн эдийн засгийн интеграцлалд богино хугацаанд хамрагдаж чадсан. Олон улсын худалдааны хэмжээ асар өндөр түвшинд хүрсэн явдал Хятад Улсын худалдааны илүүдлийг нэмэгдүүлэх нөлөөг мөн үзүүлж байгаа тул өнөөгийн нөхцөл байдлыг даван туулахад чиглэгдсэн шинэ стратеги төлөвлөгөө хэрэгтэй байгаа юм.

Улмаар Төрийн зөвлөлөөс Хятадыг үйлдвэрлэлийн аварга том гүрэнгээс дэлхийн үйлдвэрлэлийн том гүрэн болгон өөрчлөх зорилгоор 2015 оны 5-р сарын 8-нд "Хятадад үйлдвэрлэв 2025" хөтөлбөрийг гаргалаа. Ерөнхий сайд Ли Көцяны баталсан энэхүү төлөвлөгөө нь үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн тус улсын анхны үйл ажиллагааны томоохон цогц төлөвлөгөө юм.

"Хятадад үйлдвэрлэв 2025" төлөвлөгөө нь "инновацийг жолоодохуй, чанарыг хамгийн чухалд үзэхүй, ногоон хөгжил, оновчтой бүтэц, хүн рүү чиглэхүй" гэсэн үндсэн зарчмуудыг удирдлага болгож Хятадыг 2049 онд тэргүүлэх үйлдвэрлэлийн гүрэн болгон өөрчлөх "Гурван алхам" стратегийг дэвшүүлсэн юм.

Тэргүүлэх чиглэл. Үйлдвэрлэлийн гүрэн болох стратегийн зорилгын хүрээнд “Хятадад үйлдвэрлэв 2025” төлөвлөгөөнд дараах зорилтуудыг тэргүүлэх чиглэл болгон тусгасан: Эдгээр нь 1) Үйлдвэрлэлийн инновацийг сайжруулах; 2) Мэдээллийн технологи, аж үйлдвэрийг нэгтгэх; 3) Аж үйлдвэрийн баазыг бэхжүүлэх; 4) Хятадын брэндүүдийг дэмжих; 5) Ногоон үйлдвэрлэлийг хэрэгжүүлэх; 6) Чухал салбарууд дахь ололт амжилтыг таниулах зэрэг болно.

Сүүлийн жилүүдэд “Аж үйлдвэр 4.0” гэсэн үйлдвэржилтийн динамик өөрчлөлт дэлхий нийтийг хамарч байна. Хятад дахь “Industry 4.0”-ийн хүрээнд хиймэл оюун ухаан, ухаалаг санхүү, эрүүл мэндийн үйлчилгээ, ухаалаг ложистик зэрэгт гол анхаарлаа хандуулдаг. Хятад Улс Япон, Герман, Францын компаниудтай хамтран ажилласнаар өндөр хурдны галт

тэрэг үйлдвэрлэх салбараа хөгжүүлж өндөр түвшинд хүргэж чаджээ. Тус улс дэлхийн хамгийн урт, хамгийн том хурдны төмөр замын сүлжээг аль хэдийн байгуулчихсан байгаа бөгөөд гадаадын хурдны галт тэрэгний төслүүдэд тендерт оролцож дэд бүтцийн ажил гүйцэтгэж байна. Энэ төмөр зам нь Хятадын аж үйлдвэрийн хөгжил, өрсөлдөх чадварыг улам бүр нэмэгдүүлж байна.

2009 оноос хойш Хятадын Засгийн газар дэлхийн 1000 гаруй “Авьяас” хөтөлбөрийг хэрэгжүүлж, дотоодоос, ялангуяа гадаадаас олон төрлийн өвөрмөц чадваруудыг олж нээж чаджээ. Хятадын олон дэвшилтэт үйлдвэрлэгч компаниуд бусад компаниудтай төрөл бүрийн салбарт нэгдэх боломжуудыг эрэлхийлж эхэлсэн бөгөөд Хятадын засгийн газар компаниудын өөрчлөн байгуулалтыг дэмжихийн тулд янз бүрийн урамшууллын бодлого боловсруулж хэрэгжүүлсэн байна.

### **Санхүүжилт**

Хятад дахь жижиг, дунд үйлдвэрүүд (ЖДҮ) нь бизнесүүдийн 90 гаруй хувийг эзэлдэг, нийт ажилчдын 80 гаруй хувийг ажиллуулдаг, дотоодын нийт бүтээгдэхүүний 60-аас дээш хувийг бүрдүүлдэг боловч тэдний 30 хүрэхгүй хувь нь л зээлийн санхүүжилтийг дайчлах боломжтой байжээ. Төрийн өмчийн газруудад зээл олгох нь эрсдэл багатай гэж үздэг. Эсрэгээрээ хувийн бизнесүүд мэдээллийн тэгш бус байдал, барьцаа хөрөнгө, зээлийн богино түүх, өндөр эрсдэл зэргээс шалтгаалан зээл авах боломж багатай байдаг.

Сүүлийн жилүүдэд зохицуулалтын байгууллагууд арилжааны банкууд болон бусад санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудыг ЖДҮ-ийн зээлийг өргөжүүлэхийг уриалж байна. Тэд зээлийн ялгавартай бодлого, эрсдэлийн нөхөн төлбөрийн сан, засгийн газрын баталгааны сан, татварын урамшууллыг хэрэгжүүлсэн байна. Жишээлбэл, арилжааны банкуудад ЖДҮ-ийн зээлд зориулж тусгайлан бонд гаргахыг зөвшөөрдөг бөгөөд энэ нь ЖДҮ-ийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлдэг. Төв банкных нь зүгээс зээл хадгаламжийн харьцааг тооцохдоо ЖДҮ-ийн зээлийг зээлийг харгалзан үздэггүй. 2015 оны эцсээр улсын хэмжээнд 66 арилжааны банк 549 тэрбум юанийн (83 тэрбум ам.доллар) санхүүгийн бонд гаргасан байна.

Хятадад 2015 оны эцсээр 7340 зээлийн батлан даалтын компани байсан бөгөөд 2.74 их наяд юанийн баталгаатай зээлд (нийт банкны зээлийн бараг 3 хувь) зээл олголтыг хэрэгжүүлжээ. Баталгааг төрийн сектор (мужийн болон хотын захиргаа) болон хувийн хэвшлийн аль аль нь хангаж ажилладаг. 2015 онд ЖДҮХС-д олгосон зээл нь нийт баталгаатай зээлийн 84 хувьтай тэнцэж байсан. Харьцангуй сайн төлөвшсөн ЖДҮ эрхлэгчид зээлийн баталгаанаас үлэмж хэмжээгээр ашиг хүртсэн байдаг байна.

2006 онд байгуулагдсан улсын зээлийн бүртгэлийн газар болох РВОС (CCRC) -ийн зээлийн лавлагааны төв нь банк, хөдөө орон нутгийн зээлийн хоршоо, бичил зээлийн компани, даатгалын компани болон бусад банк бус санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг 3000 гаруй санхүүгийн үйлчилгээ эрхлэгчдээс мэдээлэл цуглуулдаг. Зээлийн санхүүжилтээс гадна Хятад Улс өмчийн санхүүжилтийг чухалд үзэж байгаа.

Одоогийн байдлаар Хятадад “ChiNext” “ЖДҮ-ийн зөвлөл”, “Үндэсний хөрөнгийн бирж-үнэт цаасны арилжаа (NEEQ) гэсэн ЖДҮ-ийг санхүүжүүлэхэд чиглэгдсэн гурван үндсэн хөрөнгийн зах зээл үйл ажиллагаагаа явуулж байна. ЖДҮ-ийн зөвлөл нь өндөр технологийн компаниудад тэргүүлэх ач холбогдол өгч, хөгжлийн харьцангуй төлөвшсөн, тогтвортой ашиг орлоготой ЖДҮ эрхлэгчдэд үйл ажиллагаагаа түлхүү чиглүүлдэг. Үүний эсрэгээр ChiNext нь

шинэлэг, өндөр өсөлттэй гарааны бизнес эрхлэгчдэд харьцангуй бага шаардлага тавьж, үйл ажиллагааг нь санхүүжүүлэхэд тусалдаг.

ЖДҮ-ийн хөрөнгийн гуравдахь гол зах зээл бол ЖДҮ-ийн санхүүжилтийн сонголтуудыг хангадаг Үндэсний хөрөнгийн бирж (NEEQ) юм. Энэ нь өсөлтийн хэтийн төлөв, ялангуяа мэдээллийн технологийн шинэлэг гарааны бизнес эрхлэгчдийг дэмждэг бөгөөд тухайн бизнесийн ашигт ажиллагааны үзүүлэлтэд шаардлага тавихгүй, харьцангуй зөөлөн нөхцөлүүдийг санал болгодог. Өргөдөл гаргах үйл явц нь ч хурдтай хийгддэг.

Венчур капиталын санхүүжилт болон засгийн газрын удирдамжийн (Government guidance fund) сангийн үйл ажиллагаа хурдацтай өсч байгаа. Хөрөнгийн нийлүүлэлт, эрэлт ч мөн өсөж байна. Сангийн тоо хурдацтай өсч байгаа, санхүүжилтийн хэмжээ их байгаа нь засгийн газар сангийн менежментийн чанарт хяналт тавих шаардлагыг нэмэгдүүлж байна.

Венчур капиталын хөрөнгө оруулалтын өндөр нийлүүлэлттэй орчинд зах зээлийг хэвийн ажиллуулахын тулд инновацийн талаарх засгийн газрын удирдамжийг илүү анхаарах шаардлагыг бий болгож байна. Ингэснээр өмчийн санхүүжилт дайчилсан бизнесийн үйл ажиллагаа өрсөлдөх чадвартай болно. Хувьцааны санхүүжилтийн эхний шатанд өмчийн санхүүжилтийг хийхэд менежерийн мэдлэг, ур чадвар чухал байдаг болохыг Хятадын хөрөнгө оруулалтын сангууд анхааран ажиллаж байна. Түүнээс гадна засгийн газар, хувийн санхүүгийн байгууллагууд, бизнесийн сектор, хувь хүмүүс хамтран сан үүсгэж, үүсгэсэн сангаараа дамжуулан үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэгдсэн өмчийн санхүүжилтийн менежментийн үйл ажиллагааг ч явуулж байна.

### 3.4 Их Британи

#### 3.4.1 Их Британийн ДНБ-ний өнөөгийн байдал, бүтэц, онцлог<sup>147</sup>

Дэлхийн банкны 2019 оны эцсээр гаргасан тайланд тэмдэглэснээр Их Британийн эдийн засаг нь 2,829.1 тэрбум ам.доллар, нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ 42,300 ам.доллараар хэмжигдэх дэлхийн хамгийн баян чинээлэг бөгөөд том эдийн засагтай улсын нэг юм. Их Британийн ДНБ дэлхийн ДНБ-ний 3.3 хувийг эзэлж байна. ДНБ-д эзлэх хувь хэмжээг үйлдвэрлэлийн салбарын үндсэн бүтцийн хувьд авч үзвэл ХӨАА 0.61 хувь, Аж үйлдвэр 17.41 хувь, Үйлчилгээ 71.26 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 28. ДНБ: тэрбум ам.доллар: 2020 он

Бөөний худалдаа	311.30
Мэргэжлийн болон техникийн үйл ажиллагаа	270.88
Боловсруулах үйлдвэрлэл	258.52
Мэдээлэл холбоо	204.97
Төрийн удирдлага: батлан хамгаалах үйл ажиллагаа, нийгмийн хамгаалал	197.65
Барилга	160.10
Тээвэр, агуулахын үйлчилгээ	130.41
Орон сууц, хоолны үйлчилгээ	81.63
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	71.31
Эрүүл мэнд	58.15
Цахилгаан	41.18
Боловсрол	38.88
Урлаг	38.55
Усан хангамж	32.19

<sup>147</sup> <https://www.nordeatrade.com/it/explore-new-market/italy/economical-context>




Уул уурхай	30.65
Бусад үйлчилгээ	29.72
Хөдөө аж ахуй	3.90

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

### Аж үйлдвэрийн салбарын тойм

Уул уурхай	1.6%
Боловсруулах үйлдвэрлэл	13.2%
Цахилгаан, усан хангамж	3.7%



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

### Тэргүүлэх чиглэл

- Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэл
- ✓ Ган
  - ✓ Тээврийн тоног төхөөрөмж
  - ✓ Газрын тос
  - ✓ Байгалийн хий
  - ✓ Мэдээллийн технологи

Хөнгөн үйлдвэрийн тэргүүлэх чиглэл

- ✓ Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- ✓ Резин болон хуванцар бүтээгдэхүүн
- ✓ Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл

Эдийн засгийн хувьд аж үйлдвэрийн дараах эдийн засагтай (post industrial economy). Эдийн засгийн бүтэц нь үйлчилгээнд тулгуурласан бөгөөд нийт эдийн засгийн 79%-ийг бүрдүүлдэг.

2019 оны байдлаар аж үйлдвэрийн салбар эдийн засгийн 13%, үүнээс боловсруулах салбар 9.7%-ийг бүрдүүлсэн байна.<sup>148</sup> Хэдийгээр боловсруулах салбарын эдийн засагт эзлэх хувь хэмжээ нь бага боловч Их Британи аж үйлдвэрийн хэмжээгээрээ дэлхийд тэргүүлэх орнуудын тоонд багтдаг.

Хөгжиж буй орнуудад ажиллах хүч хямд, үйлдвэрлэлийн өртөг бага байгаатай холбоотой бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжингүй орнуудаас хөгжиж буй орон луу шилжих үйл явц сүүлийн хэдэн арван жил дэлхийн эдийн засгийн даяаршлын нөлөөгөөр эрчимтэй явагдаж байна. Капитал бага, ажиллах хүч их шаарддаг үйлдвэрлэл, ялангуяа хөнгөн үйлдвэрлэл хөгжиж буй орнуудад, харин капитал хөрөнгө оруулалт их шаардагдах болон өндөр технологийн үйлдвэрлэл хөгжингүй орнуудад төвлөрч улс орнуудын аж үйлдвэр төрөлжих шинж байдалтай болж байна.

Их Британийн хувьд ч аж үйлдвэрийн салбар, түүн дотроо хөнгөн үйлдвэрлэлийн салбар нь хөгжиж буй орнуудад бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг аутсорсинг (outsourcing) хийж бүтээмжээ нэмэгдүүлэн, өртөг бууруулах замаар өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж байна. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үе шатны судалгаа, шинжилгээ, дизайн, маркетингийн үйл ажиллагаа болон шинэ бүтээгдэхүүн бий болгох зэрэг өндөр технологи, мэдлэг, нарийн ур чадвар шаардсан өндөр бүтээмжтэй хэсгийг Их Британид гүйцэтгэж, харин маржин багатай үйлдвэрлэлийн үе шатыг аутсорсинг хийж байна. Ингэснээр бүтээмж өсөн, өртөг буурч өрсөлдөх чадвараа өсгөөд зогсохгүй, хөгжиж буй орнуудын зах зээлд

<sup>148</sup> <https://commonslibrary.parliament.uk/topic/economy-business/economy-economy/economic-situation/>



шууд гарах, түүхий эд ойр газар үйлдвэрлэлээ өргөжүүлэх зэрэг боломж нээгдэж байна.

### 3.4.2 Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал

/Сая паунд/

Хөнгөн үйлдвэрлэл		2015	2016	2017	2018	2019
1	Нэхмэлийн үйлдвэрлэл /Manufacture of textiles/	4 193	4 301	4 083	4 281	4 211
2	Хувцас үйлдвэрлэл /Manufacture of wearing apparel/	1 665	1 620	1 513	1 522	1 610
3	Арьсан эдлэл /Manufacture of leather and related products/	690	683	741	755	725
4	Мод, модон эдлэл (тавилгаас бусад) /Manufacture of wood and of products of wood and cork, except furniture; manufacture of articles of straw and plaiting materials/	6 534	6 453	6 924	7 343	7 286
5	Цаас, цаасан бүтээгдэхүүн /Manufacture of paper and paper products/	10 105	9 866	10 240	10 773	10 612
6	Нийтлэх, хэвлэх үйлчилгээ /Printing and reproduction of recorded media/	7 910	7 821	8 123	8 232	7 580
7	Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл /Manufacture of chemicals and chemical products/	20 453	21 703	24 082	24 968	24 564
8	Резин болон хуванцар бүтээгдэхүүн /Manufacture of rubber and plastic products/	19 226	19 541	20 244	20 466	20 035
9	Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл /Manufacture of electrical equipment/	10 288	10 005	10 629	10 927	11 529
10	Тавилга /Manufacture of furniture/	6 709	7 359	6 996	7 178	7 182
<b>НИЙТ</b>		<b>87 773</b>	<b>89 352</b>	<b>93 575</b>	<b>96 445</b>	<b>95 334</b>

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

### Хүнс, хөнгөн үйлдвэрлэл

Их Британийн хүнс, хөнгөн үйлдвэрлэлийг дараах 3 салбар тэргүүлдэг. Үүнд:

1. Хүнс, ундаа, тамхины үйлдвэрлэл.<sup>149</sup> Энэ нь Их Британийн боловсруулах үйлдвэрлэлийн хамгийн том хувь хэмжээ буюу 16 орчим хувийг бүрдүүлдэг. Жилд дунджаар 110 илүү тэрбум паундын бүтээгдэхүүн үйлдвэрлэж 21.6 тэрбум паундын нэмүү өртгийг бий болгон, 12.8 тэрбум паундын бүтээгдэхүүн экспортолдог. Нийт 6360 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдгаас 96% нь жижиг дунд үйлдвэрлэл байна. Хүнс, ундаа, тамхины үйлдвэрлэлд 400 мянга илүү шууд ажлын байр бий болгодог. 2022 онд нэмж 110,0 мянган ажлын байрыг шинээр бий болгох хүлээлттэй байна. Салбарын бүтээмж сүүлийн 5 жилд дунджаар 11%-иар өссөн.
2. Хувцас, арьс, шир, даавуун бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь Европт Итали, Германы дараа гуравт ордог салбар бөгөөд жилд дунджаар 11.5 тэрбум паундын нэмүү өртөг бий болгож, 8.2 тэрбум паундын бүтээгдэхүүн экспортлодог. Нийт 79,0 мянга илүү аж ахуйн нэгжид 340,0 мянган хүн ажилладаг. Нэг ажилтанд ноогдох нэмүү өртөг нь 34,220 паунд байна.

<sup>149</sup> <https://www.themanufacturer.com/uk-manufacturing-statistics/>

3. Мод болон цаасан эдлэл, хэвлэх үйлдвэрлэл. Энэ нь нийт боловсруулах үйлдвэрлэлийн 12%-ийг эзэлдэг бөгөөд нийт боловсруулах салбарын ажиллах хүчний 10%-ийг бүрдүүлдэг.

Мод болон модон эдлэлийн үйлдвэрлэл нь орон сууц, барилгын салбарын өсөлттэй холбогдон өргөжиж байгаа бөгөөд 2015-2020 оны хооронд жилд дунджаар 5.1% өсөлттэй байсан.

Харин эсрэгээрээ цахим технологийн хөгжилтэй холбоотой цаас болон хэвлэх үйлдвэрлэлийн хэмжээ мөн хугацаанд жилд дунджаар 2.8% буурсан байна.

Их Британийн хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн салбар нь инновац, шинэ технологийг нэвтрүүлж өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлд илүү их анхаарч байна. Ялангуяа хүнс, ундааны үйлдвэрлэлийн салбарт энэ чиглэлээр Европтоо тэргүүлдэг. Энэ салбарын нийт аж ахуйн нэгжийн 32% орчим нь шинэ бүтээгдэхүүнд, 18% орчим нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа инноваци нэвтрүүлэх, 32% орчим нь олон талт инновацийг хөгжүүлэх чиглэлээр ажилладаг.

Хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт дотоод болон уламжлалт зах зээлээс гадна хурдацтай өсч буй хөгжиж буй орнуудын зах зээл чухал байр суурь эзлэх болсон.

Нийгэм, эдийн засаг, технологийн хөгжилтэй уялдан хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж илүү эрүүл орчин, эрүүл бүтээгдэхүүн хэрэглэх хандлага давамгайлах болсон. Үүнтэй уялдан Их Британийн хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн салбар нь хүмүүсийн шинэ амьдралын хэв маягт нийцсэн эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, технологи нэвтрүүлэхэд ихээхэн анхаарч судалгаа, шинжилгээ, хөрөнгө оруулалт хийж байна.

Хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн салбар нь бусад аж үйлдвэрийн салбаруудын нэгэн адил дараах чиглэлд идэвхтэй хөгжиж байна.

- Байгаль орчинд ээлтэй технологи
- Шинэлэг, илүү нарийн материал
- Нано материал болон нано технологи
- Биотехнологи
- Цахим технологи

### 3.4.3 Аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого<sup>150</sup>

Хөгжингүй буюу аж үйлдвэржилтийн дараах эдийн засагтай орнууд (post industrial economy) тухайн нэг салбар гэхээсээ илүү нийт аж үйлдвэр, эдийн засгийн салбарт нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлдэг.

Их Британийн Засгийн газраас 2017 онд гаргасан “Аж үйлдвэрийн стратеги” нь хүнс, хөнгөн аж үйлдвэрийн салбарт ч хэрэгжих бөгөөд энэхүү стратегийг 3 чиглэлд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

1. Стратегийн эхний чиглэл нь нийт аж үйлдвэрийн салбарт хэрэгжих “Таван суурь” (Five Foundations) бодлого. Five Foundations буюу Таван суурь бодлого нь эдийн засгийн бүх салбарт нөлөөлөх бодлого бөгөөд 5 үндсэн хэсэгтэй.

- **Ideas буюу шинэ сэтгэлгээ:** Дэлхийд хамгийн шинэлэг эдийн засагтай болох.

Аж үйлдвэрийн салбарт инновац, шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр дэмжлэг

<sup>150</sup><https://www.gov.uk/government/publications/industrial-strategy-the-foundations/industrial-strategy-the-5-foundations>

үзүүлэх бөгөөд энэ хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- 2027 онд Судалгаа, шинжилгээнд (Research&Development) зарцуулах хөрөнгө оруулалтыг ДНБ-ний 2.4% хүргэх.
  - Судалгаа, шинжилгээнд зарцуулах зардалд ноогдох татварын хөнгөлөлтийг 12% болгож нэмэгдүүлэх /2018 оноос нэмэгдүүлсэн/.
  - Аж үйлдвэрийн стратегийн сорилтын санд 4 жилийн хугацаанд 725 сая паунд зарцуулах. Энэ сан нь “Их сорилт”-ын бодлогын хүрээнд зарцуулагдана.
  - Их Британийн Судалгаа, Шинжилгээний зөвлөл нь Судалгаа, шинжилгээний чиглэлийн олон улсын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлд ажиллана.
- **People буюу Хүн:** Хүн бүр сайн ажилтай, илүү их орлого олох боломжийг бүрдүүлэх. Ажиллах хүч, боловсон хүчний хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.
    - “Ур чадвар” төлөвлөгөөнд тусгагдсан Шинэ техник, технологийн боловсролын систем бий болгох. Үүнд “Т” (техникийн ур чадвар) зэргийн болон ажлын байрны сургалтууд орно.
    - Математик, цахим болон техникийн боловсролд 400 сая паунд зарцуулах.
    - Үндэсний Мэргэжил дээшлүүлэх сургалтын схемийг Парламентын бүрэн эрхийн хугацаа дуусахад бий болгож барилгын болон цахим технологийн чиглэлд мэргэжил дээшлүүлэх сургалтад 64 сая паунд зарцуулах.
    - Үндэсний цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх.
  - **Infrastructure буюу Дэд бүтэц:** Дэд бүтцийн томоохон шинэчлэл хийх. Орчин үеийн болон ирээдүйн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд бүтцийг бий болгоход чиглэсэн.
    - Үндэсний Бүтээмжийн Хөрөнгө оруулалтын сангийн хэмжээг 2022-2023 онд 31 тэрбум паунд хүртэл нэмэгдүүлж, Тээвэр, орон сууц, цахим дэд бүтцийг хөгжүүлэх.
    - Цахилгаан тээврийн хэрэгсэлд зориулсан дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг 100 сая паундаар нэмэгдүүлэх.
    - Орон нутаг дахь интернэт хүрэлцээ болон 5G-д зориулсан цахим дэд бүтцийн хөрөнгө оруулалтын асуудал.
  - **Business environment буюу Бизнесийн орчин:** Бизнес эхлүүлэх, хөгжүүлэхэд хамгийн тохиромжтой газар болох. Бүтээлч, өрсөлдөх чадвартай бизнес шинээр бий болж, хөгжих боломжоор хангасан бизнесийн орчин бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.
    - “Салбарын хэлцэл”-ийн бодлого нь энэ хүрээнд хэрэгжих арга хэмжээний гол цөм байна. Энэ нь тухайн салбарт тулгарч буй онцлог асуудлыг шийдвэрлэхэд чиглэнэ.
    - British Business Bank-ны хүрээнд “Инкубатор сан” үүсгэн ирээдүйтэй шинэ салбарт хувийн сектороос 7.5 тэрбум паундын хөрөнгө оруулалтыг татах
    - Жижиг дунд үйлдвэрүүдийн бүтээмжийг нэмэгдүүлэх.
  - **Place буюу Бүс нутаг:** Их Британи даяар цэцэглэн хөгжиж буй нийгэм байгуулах. Бүс нутагт эдийн засгийн өсөлтийг авчрах бизнесийг бий болгон, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

- Орон нутгийн Аж Үйлдвэрийн стратегиар дамжуулж улс даяар эдийн засгийн өсөлтийг бий болгож, “эрчимтэй хөгжлийн кластер”-уудыг тухайн бүс нутагт бий болгож хөгжүүлэх.
- Хотуудыг шинэчлэх сангаар (Transforming Cities Fund) дамжуулж хот хоорондын тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх.
- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг эхлүүлж сургалтын түвшин доогуур бүс нутгийг өндөр ур чадвартай багшаар хангах.

2. Стратегийн 2 дахь чиглэл нь салбарт чиглэсэн аж үйлдвэрийн бодлого буюу “Салбарын хэлцэл”-ийн бодлого (Sector Deals). Британий эдийн засагт чухал ач холбогдолтой эсвэл, стратегийн салбаруудад төр, хувийн хэвшлийн хороонд түншлэл буюу “Салбарын хэлцэл” байгуулж салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. Энэ бодлогыг 3 аргаар хэрэгжүүлнэ.

- Хувийн хэвшил, төр, судлаачдыг хамруулсан Салбарын зөвлөлийг байгуулах.
- Өрсөлдөөний зарчмаар салбарын Судалгаа, шинжилгээнд зориулж санхүүжилт олгох.
- Салбарын ажилчдад шаардагдах мэргэжлийн ур чадварыг олгох, хөгжүүлэх чиглэлээр бодлого хэрэгжүүлэх.

2019 байдлаар 11 салбарт зориулсан “Салбарын хэлцэл” байгуулжээ. Эдгээрээс хүнс, хөнгөн үйлдвэрт хамааралтай “Салбарын хэлцэл”-ийн бодлого болох Креатив /creative/ аж үйлдвэрийн секторын хэлцэлд дараах арга хэмжээг тусгасан байна.

- Бизнесийн соёлыг хөгжүүлэх санд 20 сая паундын санхүүжилт олгож тухайн креатив буюу бүтээлч бизнест хөрөнгө оруулалт татах.
- 58 сая паундын санхүүжилт хийж онцгой технологийг нэвтрүүлэх, өндөр технологийн салбарт Их Британийн эзлэх хувь хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх. Мөн “Урлаг, хүн амын судалгааны зөвлөл”-өөр дамжуулан их сургууль, креатив бизнесийн 8 түншлэлийг бий болгож 64 сая паундын санхүүжилт олгох.
- Эрчимтэй хөгжиж буй бизнесийн хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд креатив бизнест 4 сая хүртэл паундын санхүүжилт олгох.
- Креатив бизнесийн санаачилгаар 2 жилийн хугацаанд 2000 сургууль, 600 мянган суралцагчдыг креатив ажлын байрны хөтөлбөрийг боловсруулан, ажлын байрны дадлага хийх стандартыг тогтоож 2 сая хүртэлх паундын төслийн санхүүжилт олгох.

3. Стратегийн 3 дахь чиглэл нь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн аж үйлдвэрийн бодлого буюу “Их сорилт” (Grand Challenge). Энэ нь дэлхий нийтэд тулгарч буй асуудлуудыг аж үйлдвэрийн салбар шийдсэнээр Их Британийн эдийн засгийг улам хүчирхэгжүүлж, амьдралын түвшинг сайжруулах бодлого юм. Дараах 4 зорилтыг “Их сорилт”-ын хүрээнд шийдвэрлэнэ.

- Хиймэл оюун ухаан ба мэдээлэл, өгөгдлийн боловсруулалт
- Насжилт нэмэгдэж буй нийгэм
- Байгаль орчинд ээлтэй өсөлт- Орон сууцны эрч хүчний хэрэглээг 50% бууруулах.
- Ирээдүйн тээврийн хэрэгсэл- Нүүрсхүчлийн хий ялгаруулдаггүй тээврийн хэрэгслийг зохион бүтээх, загварыг гаргах. 2040 онд нүүрс хүчлийн хий ялгаруулалтыг “0” болгох.

Их Британи дэлхийн худалдааны байгууллагад 1995 оны 1-р сарын 1-нд элссэн. 2020 оны

1-р сарын 31 хүртэл Европын холбооны гишүүн улс байсан /одоо гишүүнээс гарсан/. 2017 онд Британий Засгийн газраас гаргасан “Аж үйлдвэрийн стратеги” нь бүх салбарт хамааралтай. Түүнд ‘Five Foundations’ буюу Таван суурь зарчмыг тодорхойлсон

### **Хөгжлийн стратеги ба аж үйлдвэрийн бодлого, үндэслэл, бүтэц**

Их Британийн Аж үйлдвэрийн стратегийн зорилго нь ажлын байр, ур чадвар, аж үйлдвэр, дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх замаар орон даяар иргэдийн орлого олох чадварыг нэмэгдүүлэх бизнесийг дэмжих замаар бүтээмжийг нэмэгдүүлэх явдал байв. Их Британи Улс аж үйлдвэрийн стратегийг засгийн газар аж үйлдвэрийн салбартай түншлэн ажиллаж, ажлын байр, эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэгдсэн урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэж тодорхойлсон бөгөөд аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлогын хүрээнд дараах 5 зорилтыг чухалд үзсэн байдаг. Эдгээр нь:

*Салбарын түншлэл:* Дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, инновацийг дэмжих, экспортын боломжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бүхий л салбарт дэмжлэг үзүүлэх

*Технологи:* Их Британи нь технологийн хөгжлөөрөө дэлхийд манлайлах судалгааны чадварыг хөгжүүлэх, технологийн дэвшлийг арилжааны эргэлтэд оруулах

*Чадвар:* Ажил олгогч болон ажиллагсад шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэхийн тулд энэ чиглэлээр төрөөс гаргаж буй санхүүжилтийг бизнес эрхлэгчдэд түлхүү хүргэх, ямар ур чадвар хэрэгцээтэй байгааг тодорхойлох чиглэлээр хамтран ажиллах

*Санхүүгийн хүртээмж:* Хөдөлмөр, шинэлэг тоног төхөөрөмжид хөрөнгө оруулж, үйлдвэрлэлийн үнэ цэнийг өсгөхөд шаардлагатай санхүүжилтийг олж авахад нь бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх

*Худалдан авах ажиллагаа:* Их Британийн ханган нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх, улсын секторын худалдан авалтын энгийн, ил тод системийг бий болгох зэрэг болно.


Ингээд аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх бодлогын хүрээнд дараах хүчин зүйлсийг харгалзаж үзжээ. Эдгээрийг жагсаавал дараах байдалтай байна.

- ✓ Салбарын бодлогын үр нөлөө
- ✓ Улсын өмч хувьчлал
- ✓ Хөрөнгө оруулалтын татаас
- ✓ Төрийн салбарын худалдан авалт
- ✓ Гадаадын шууд хөрөнгө оруулалт
- ✓ Салбарын бус микро эдийн засгийн бодлогод томоохон нөлөө бүхий бодлогын үр нөлөө
- ✓ Шинжлэх ухаан, технологийн бодлого
- ✓ Бүс нутгийн бодлого ба бөөгнөрөл
- ✓ Өрсөлдөөний бодлого
- ✓ Эрэлтийн менежмент
- ✓ Олон улсын худалдаа
- ✓ Валютын ханшийн дэглэм

### **3.4.4 Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

#### **Мэргэжлийн ур чадвар**

Ур чадвар нь бизнесийн үйл ажиллагаа явуулахад бүх бизнес эрхлэгчдэд зайлшгүй



шаардлагатай байдаг. Ур чадварыг хөгжүүлэхдээ түншлэлд тулгуурласан бодлогыг хэрэгжүүлжээ.

Засгийн газар, анхан шатны боловсролд хөрөнгө оруулах, өөртөө хөрөнгө оруулж чадахгүй насанд хүрэгчдийг дэмжих, сургалтад хамрагдахад нь аж ахуйн нэгж, иргэдийг туслах, залуу боловсон хүчнүүдэд ажлын туршлага олгох, мэргэжлийн бүх боловсрол нь нарийн төвөгтэй стандартыг хангаж, байнга өөрчлөгдөж буй хэрэгцээтэй зэрэгцэн хөгжих ёстой болохыг мэдэрч байгууллагын чадавхад хөрөнгө оруулах зэрэг чиглэлүүдээр ур чадварыг хөгжүүлэх бодлогыг тодорхойлсон байна. Түүнчлэн дагалдан суралцах нь мэргэжлийн боловсролын хөгжлийн тулгын чулуу бөгөөд төр, аж ахуйн нэгжүүд дагалдан суралцах орчин, чадварыг чанарын өндөр түвшинд жигд хангаж, хэрэгцээтэй санхүүжилтийг шударга, үр дүнтэй хуваарилах тал дээр бизнесүүдтэй хамтран ажиллах нь чухал гэж үзжээ.

Ингээд Их Британийн Засгийн газар хөдөлмөрийн нөөцийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхтэй холбоотой дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

#### STEM ур чадварыг дээшлүүлэх

Шинжлэх ухаан, технологи, инженер ба математикийн (STEM) ур чадвар нь эдийн засгийн олон салбарт өсөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг болохын ач холбогдлыг дөвийлгөж инженер мэргэжилтнүүдийн ажил олгогч, сургагчдыг хоорондоо болон засгийн газартай нэгдэж ажиллахыг уриалан тодорхой ажлуудыг хийсэн.

#### Үндсэн түвшний сургалт

Сургалтын үнэлгээ хангалтгүйн улмаас сургуулиас гарсан залуу хүмүүсийн хэрэгцээг тасралтгүй хангах шаардлага гарч ирдэг. Их Британид хэрэгжиж байгаа үндсэн түвшний сургалтаар анхан шатны англи хэл, математикийн мэдлэгийг олгодог байна. Бизнес эрхлэгчид болон засгийн газрын өмнө тулгарч буй гол бэрхшээл нь хамтын амжилтыг бий болгоход хүмүүсийнхээ чадварыг ашиглах, хөгжүүлэх явдал юм. Энэ нь ажил олгогч, засгийн газар, хувь хүмүүсээс урт хугацааны, нэгдсэн хүчин чармайлтыг шаардаж байдаг бөгөөд наад захын мэдлэгтэй байхаас дараагийн шатны сургалтын чанар шалтгаалдаг тул үндсэн түвшний сургалтад ач холбогдол өгсөн байна.

#### Ажил олгогчоор удирдуулсан санхүүжилт

Сургалтын саналын чанар, үнэ цэнийг ажил олгогчид засгийн газраас илүү сайн мэдэрдэг тул ажил олгогчдын санал, хүсэлтийг харгалзан хөдөлмөрийн нөөцийг бэлтгэхтэй холбоотой үйл ажиллагаа, шаардагдах санхүүжилтийг төлөвлөдөг байна.

#### Шинэ сорилтуудыг шийдвэрлэх түншлэл

Засгийн газар болон ажил олгогчид аж үйлдвэрийн гол салбарт хамаарах өндөр технологийг эзэмших ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн төслүүдийн санхүүжилтийг хамтын оролцоонд тулгуурлан хийж байна.

#### Үндэсний коллежуудыг хөгжүүлэх

Техникийн гол салбаруудад мэргэшсэн ур чадварыг эзэмшүүлэх үйл ажиллагаа явуулдаг үндэсний коллежийн шинэ үеийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлж байна.

#### **Санхүүжилт**



Засгийн газар нь Их Британийг бизнес эхлүүлэх, санхүүжүүлэх, хөгжүүлэх хамгийн тохиромжтой газруудын нэг болгохыг зорьж байна. Одоогийн байдлаар банкууд ЖДҮ-т жил бүр 100 тэрбум фунт стерлинг олгодог боловч олон жижиг пүүсүүд санхүүжилттэй холбоотой томоохон асуудлуудтай тулгарсаар байна. Эдгээр нь:

- Өрсөлдөөн багатай, төвлөрөл өндөртэй банкны зээлийн зах зээл;
- Хөрөнгө оруулагчид аль эсвэл зээлдүүлэгчид жижиг бизнесүүдийн зээлийн чадварыг үнэлэх ёстой байдаг тул хүссэнээс нь багаар санхүүжилт олгох үйл явц;
- Пүүсүүд санхүүжилтийн өөр хувилбаруудын талаарх ойлголт, мэдлэггүй байдал зэрэг болно.

Их Британийн Засгийн газар бизнесийн сонголтыг нэмэгдүүлж, үйлчилгээгээ сайжруулах чиглэлээр банкуудыг шахаж, харилцагчдын зардлыг бууруулах, олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг, өрсөлдөх чадвартай банкны салбарыг хөгжлийг бий болгохын төлөө тууштай ажиллаж байна.

### **Британийн бизнесийн банк**

Их Британийн Бизнесийн банк нь ЖДҮ эрхлэгчдийг цэцэглэн хөгжих боломжийг олгох зорилгоор төрөөс дэмжлэг бүхий эдийн засгийн хөгжлийн банкны хэлбэрээр ажиллаж байна. Их Британийн санхүүжилтийн хөтөлбөрүүд нь зөвхөн банкны зээлжилтэд анхаарлаа төвлөрүүлэхээс гадна гарааны санхүүжилт, венчур капитал болон банк бус зээл гэх мэт санхүүгийн өөр хэлбэрүүдэд ач холбогдол өгдөг.

Банкны хөтөлбөрүүд нь хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт хийх боломжтой олон тооны бизнес эрхлэгчдийг дэмжиж байна. Тухайлбал, 2013 онд 660 сая фунт стерлингийн зээл, хөрөнгө оруулалтын дэмжлэгийг үзүүлж, үүний талаас илүү хувийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч өөр компаниудаар дамжуулан хэрэгжүүлжээ. Нийт 500 сая фунт стерлингийн багтаамжтай капиталын санг байгуулсан байна. Эдгээр нь хувийн болон улсын мөнгийг нэгтгэж, өндөр өсөлттэй бизнесүүдэд өмчийн санхүүжилтийг бий болгоход чиглэгдсэн арилжааны чиглэлээр төвлөрсөн сангууд юм.

Засгийн газрын зүгээс аж үйлдвэрийн хөгжилд санхүүгийн бие даасан дэмжлэгийн үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор санхүүгийн үйлчилгээний шинээр гарч ирж буй загваруудыг дэмжиж, санхүүгийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай олон янзын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байгаагийн зэрэгцээ амьдрах чадвартай, гарааны аль эсвэл өсөлтөд чиглэсэн бизнес эрхлэхэд зориулж олон тэрбум фунт стерлингийн санхүүжилтийг олгосон.

### **Өрсөлдөөнийг сайжруулах нь**

2011 онд Банкны бие даасан комиссоос дөрвөн том банк жижиг бизнесийн банкны үйлчилгээний 85%-ийг хангадаг болохыг тогтоожээ. Банкны салбар дахь өрсөлдөөний дутагдалтай байгаа энэ байдал нь бизнес эрхлэгчид заримдаа таагүй нөхцөлийг хүлээн зөвшөөрөх аль эсвэл санхүүгийн эх үүсвэрийг огт авахгүй байхаас өөр аргагүй байдалд хүргэж байсан юм.

Жижиг бизнес эрхлэгчдийн дунд санхүүжилтийн өөр хувилбар, зохицуулалтын хязгаарлалтын талаар мэдлэг дутмаг байгаа нь бусад үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд саад болж байна. Дээр дурдсан Их Британийн Бизнес Банкны хөтөлбөрүүдтэй зэрэгцэн санхүүжилтийг нэмэгдүүлэхтэй холбоотой тодорхой арга хэмжээг

авч байна. Тухайлбал, хөрөнгө оруулагчдад олон нийтийн санхүүжилтийн платформуудын схемийг ашиглах боломжийг олгож, 1100 гаруй жижиг компанид хөрөнгө босгоход нь тусалсан. Шинэ банкуудад эрх олгох үйл явцыг боловсронгуй болгож, хөрвөх чадварын шаардлагыг өөрчилж, зах зээлд гарч, бизнес эрхлэх санхүүжилтийн боломжуудыг нэмэгдүүлэхийн сацуу өрсөлдөгч банкууд болон үйлчилгээ үзүүлэгч бусад компаниудаар дамжуулан авах боломжтой үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Санхүүжилтийн шинэлэг сонголтууд нь илүү эрсдэлтэй хэдий ч хөрөнгө оруулагчдын сонирхлыг илүүтэй татаж байна.

### **Уян хатан чанарыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх**

Бизнесүүдээ урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхийн тулд Их Британи тогтвортой, хариуцлагатай банкны салбартай байх нь чухал юм. Их Британид өмнө нь олон нийтийн санхүүгийн үйлчилгээнд итгэх итгэлийг доройтуулсан үйл явц гарч байсан. Банкны салбарыг илүү тэсвэртэй, хариуцлагатай болгох чиглэлээр банкны салбартай хамтран ажиллаж байна.

### **Инноваци болон технологийг ашиглах нь**

Их Британийн эдийн засгийн өсөлт, хөгжил цэцэглэлтийн гол хөдөлгөгч хүчин зүйл байсаар ирсэн бөгөөд цаашид ч эдийн засгийн өсөлтийн шалтгааны ихэнх хэсгийн тайлбарласаар байх болно. Инноваци болон технологи нь эрүүл мэнд, халамжийг сайжруулах, байгальд ээлтэй, тогтвортой эрчим хүчний үйлдвэрлэлийг хангах, хүнсний аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх, хүн ам зүйн өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх зэрэг нийгэмд тулгарч буй гол бэрхшээлүүдийг даван туулахад бидэнд тусалдаг.

Мэдлэг, хөгжил дэвшил, шинэ технологийг ашиглах хил хязгаарыг тэлэх нь аж үйлдвэрийн стратегийн гол үүрэг юм. Catapult нь бизнес, эрдэмтэн, инженерүүд сүүлийн үеийн судалгаа, шинжилгээний ажилд зэрэгцэн ажиллаж, өндөр боломжит санаануудыг шинэ бүтээгдэхүүн болгон өөрчлөх физик төв юм. Энэхүү төв нь шинэ технологийг ашиглахтай холбоотой эрсдэлийг бууруулж, эргэлзээ төрүүлэхүйц байдлыг багасгахдаа лабораториос илүү өргөн цар хүрээг хамарсан шинэ программуудыг танилцуулж, үйлдвэрлэлийн цар хүрээг өргөжүүлж болохыг харуулах, технологийг сурталчлах ажлыг эрчимжүүлэх, шинэ технологи боловсруулж, турших шинэ судалгаа, шинжилгээний байгууламжаар хангаж, тэргүүлэх зэргийн судалгаа хийх боломжийг олгож байна.

Жишээлбэл, судалгааны бааз, аж үйлдвэрийн хүчийг нэгтгэх зорилгоор их дээд сургуулиуд, инновацийн төвүүд, шинжлэх ухааны паркууд, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, тэдгээрийн эргэн тойронд байгаа робот, автономит системийн шилдэг төвүүдэд судалгаа хийхэд шаардлагатай шинэ байгууламж, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлж байна.

Технологийг хөгжүүлэх манлайллын бүлгүүдтэй зохицуулалтын асуудлуудыг шийдвэрлэж, төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, мэргэжлийн ур чадварын хэрэгцээ гэх зэрэг хөгжлийн томоохон хөшүүргүүдийг ашиглах чиглэлээр хамтран ажиллаж технологи болон аж үйлдвэр хоорондын холболтыг бэхжүүлж байна.

### 3.5 Энэтхэг Улс

#### 3.5.1 ДНБ-ний өнөөгийн байдал, бүтэц, онцлог<sup>151</sup>

Энэтхэг Улс нь 2020 оны байдлаар Дэлхийн хэмжээнд нийт ДНБ-ний 6.67%-ийг, Азийн орнуудын ДНБ-ний 16%-ийг тус тус эзэлдэг байна. Энэтхэгийн эдийн засаг 2020 онд 8.681 тэрбум ам. долларт хүрчээ.<sup>152</sup> 1 хүнд ногдох ДНБ 2,227 ам доллар. Статистик, Хөтөлбөр Хэрэгжилтийн Яам (Ministry of Statistics and Programme Implementtion)-ны мэдээлснээр (2021 оны 1 дүгээр сарын 4-ний байдлаар)<sup>153</sup>

ДНБ-ний салбараар:

- ✓ Хөдөө аж ахуй 17.76%
- ✓ Аж үйлдвэр 24.48%
- ✓ Үйлчилгээ 54.77% эзэлж байна.

Зураг 38. ДНБ-ний бүтэц



Эх сурвалж: <https://statisticstimes.com/economy/country/india-gdp-sectorwise.php>

- Хөдөө аж ахуйн салбартаа ойн аж ахуй, мод бэлтгэл, загас агнуур, загасны аж ахуй, газар тариалан, мал аж ахуй болон холбогдох бусад салбаруудыг хамруулжээ.
- Аж үйлдвэрийн салбарт нь уул уурхай олборлох, үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүн, нэхмэл хувцас, арьсан бүтээгдэхүүн, металл, машин тоног төхөөрөмж, цахилгаан, хий, усан хангамж, ба бусад үйлчилгээ, барилга зэрэг салбаруудыг багтдаг.
- Үйлчилгээний салбарт худалдаа, зочид буудал, зоогийн газар, тээвэр холбоо, үйлчилгээ, төмөр зам, авто тээвэр, усан болон агаарын тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, банк, даатгал, үл хөдлөх, төрийн захиргаа, батлан хамгаалах болон бусад холбогдох салбаруудыг хамруулсан байна.

Хүснэгт 29. ДНБ үйлдвэрлэлийн салбаруудаар

	Салбар	2019-2020 оны Нэмэгдсэн өртгийн хэмжээ (Gross Value Added) рупи-гээр			
		Тогтмол үнэ	Хувь (%)	Одоогийн үнэ	Хувь (%)
1.	ХАА салбар	1,948,110	14.65%	3,257,443	17.76%
1.1	ХАА, ойн аж ахуй, загас агнуур	1,948,110	14.65%	3,257,443	17.76%
2.	Аж үйлдвэрийн салбар	4,015,068	30.19%	5,040,100	27.48%
2.1	Уул уурхай олборлох	355,680	2.67%	393,102	2.14%
2.2	Боловсруулах үйлдвэрлэл	2,317,280	17.42%	2,775,587	15.13%

<sup>151</sup> <https://www.nordeatrade.com/fi/explore-new-market/italy/economical-context>

<sup>152</sup> <https://statisticstimes.com/economy/country/india-gdp.php>


<sup>153</sup> <https://statisticstimes.com/economy/country/india-gdp-sectorwise.php>

2.3	Цахилгаан,хий, усан хангамж, бусад хэрэглээний үйлчилгээ	308,832	2.32%	486,516	2.65%
2.4	Барилга	1,033,276	7.77%	1,384,895	7.55%
3.	Үйлчилгээний салбар	7,337,941	55.17%	10,045,694	54.77%
3.1	Худалдаа, зочид буудал, тээвэр, харилцаа, холбоо, үйлчилгээ	2,577,945	19.38%	3,316,653	18.08%
3.2	Санхүү, үл хөдлөх хөрөнгө, проф үйлчилгээ	2,915,680	21.92%	3,842,524	20.95%
3.3	Төрийн захиргаа, батлан хамгаалах, бусад үйлчилгээ	1,844,316	13.87%	2,886,517	15.74%
	<b>Нийт дүн</b>	<b>13,301,120</b>	<b>100%</b>	<b>18,343,237</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь:

- ✓ Төрийн удирдлага, батлан хамгаалах, бусад үйлчилгээ- 15.74%
- ✓ Санхүү, үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ-20.95%
- ✓ Худалдаа, зочид буудал, тээвэр, харилцаа, холбоо, үйлчилгээ-18.08%



Эх сурвалж: <https://statisticstimes.com/economy/country/india-gdp-sectorwise.php>


Энэтхэгийн энэ салбаруудыг 2019-2020 оны нэмэгдсэн өртгийн хэмжээгээр үзүүлбэл: (2020 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар \$1 USD = ₹71.321рупи)

### Аж үйлдвэрийн салбарын тойм

ДНБ-д эзлэх хувь:

- ✓ Уул уурхай олборлох 2.14%
- ✓ Боловсруулах үйлдвэр 15.13%
- ✓ Цахилгаан, хий, усан хангамж, бусад хэрэглээ 2.65%

Зураг 39. Аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: <https://statisticstimes.com/economy/country/india-gdp-sectorwise.php>

## Тэргүүлэх чиглэл

Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэл

- ✓ Нэхмэл
- ✓ Химийн бодис
- ✓ Хоол боловсруулах
- ✓ Хөдөө аж ахуйн бизнес
- ✓ Гар урлал
- ✓ Газрын тос
- ✓ Нефть
- ✓ Үнэт чулуу, үнэт эдлэл
- ✓ Савхин
- ✓ Төмрийн хүдэр
- ✓ Ган
- ✓ Хөнгөн цагаан
- ✓ Цемент
- ✓ Уул уурхай
- ✓ Мэдээллийн технологи
- ✓ Цахилгаан
- ✓ Эмийн үйлдвэрлэл

Хөнгөн үйлдвэрийн тэргүүлэх чиглэл

- ✓ Хими, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- ✓ Эмийн бүтээгдэхүүн, эмнэлгийн бүтээгдэхүүн
- ✓ Нэхмэлийн үйлдвэрлэл

### 3.5.2 Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал

Хөнгөн үйлдвэрлэлийн нэрс	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
Хими, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8,108,310	11,898,751	11,970,904	12,405,946	13,973,575
Эмийн бүтээгдэхүүн, эмнэлгийн бүтээгдэхүүн	7,211,578	8,268,793	8,756,082	9,129,166	10,619,492
Нэхмэлийн үйлдвэрлэл	4,497,222	4,811,398	5,237,865	5,594,451	6,141,267
Рензин ба хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3,746,777	4,127,996	4,568,081	4,326,804	5,101,566
Цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл	3,500,748	4,321,733	4,578,531	4,743,665	4,990,801
Хувцасны үйлдвэрлэл	2,214,838	2,862,569	2,876,159	3,238,377	3,561,893
Цаас,цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1,090,733	1,243,335	1,261,676	1,728,626	2,133,571
Арьсан эдлэл, түүнтэй холбоотой үйлдвэрлэл	646,519	952,886	1,021,001	1,091,491	1,255,702
Принтер, хэвлэлийн эх бэлтгэх, цэвэрлэх	264,761	1,050,376	961,382	1,050,897	1,154,413
Тавилга үйлдвэрлэл	290,290	298,760	273,003	356,103	431,140
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	306,971	357,749	397,347	368,650	425,083
Хэвлэх үйл ажиллагаа	264,761	257,825	223,995	232,969	194,352
<b>Нийт дүн</b>	<b>32,143,508</b>	<b>40,452,171</b>	<b>42,126,026</b>	<b>44,267,145</b>	<b>49,982,855</b>

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

### 3.5.3 Аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого

Энэтхэгийн аж үйлдвэрийн бодлогод Засгийн газрын бодлого, шийдвэр, дүрэм журам, тарифын болон хөдөлмөрийн бодлого, гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих зэрэг үйл ажиллагаануудыг хамруулжээ.

Аж үйлдвэрийн бодлогын үндсэн зорилтууд нь:

- ✓ Хөдөлмөрийн бүтээмжийг тогтвортой өсөлтөөр хангах;
- ✓ Ажил эрхлэлтийг дэмжих;

- ✓ Ажиллах хүчийг нэмэгдүүлэх;
- ✓ Олон улсад өрсөлдөх чадварыг тогтворжуулах;
- ✓ Дэлхийн хэмжээнд Энэтхэг Улс томоохон түншлэгч болох.

Энэтхэг улс нь тусгаар тогтносон үеэс хойш 1948, 1956, 1977, 1980, 1990, 1991 онуудад аж үйлдвэрийн бодлогод шинэчлэлүүдийг хийсэн байна. Эдгээр онуудад аж үйлдвэрийн бодлогын гол асуудлуудыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. 1948 онд “Холимог эдийн засгийн загвар” (Mixed Economic Model)-тай болохыг тодорхойлсон. Энэ салбаруудыг дөрвөн хүрээнд авч үзжээ.

- ✓ Стратегийн аж үйлдвэрүүд (зэр зэвсэг болон тэсрэх сум, атомын энерги, төмөр зам);
- ✓ Гол аж үйлдвэрүүд (нүүрс, төмөр, гангийн үйлдвэр, онгоц болон хөлөг онгоцны үйлдвэрлэл, утас, телеграф, утасгүй төхөөрөмж, ашигт малтмалын тос);
- ✓ Чухал салбарууд (хүнд химийн бодис, элсэн чихэр, даавуу, нэхмэл, ноосны үйлдвэр, цемент, цаас, багаж хэрэгсэл, бордоо, резин, далайн тээвэр, мотор, трактор, цахилгаан хэрэгсэл);
- ✓ Бусад салбарууд (дээр дурдсан ангилалд багтаагүй бусад бүх салбар)

1948 онд “Аж үйлдвэрийн хөгжил, зохицуулалтын тухай хууль” (Industries Development and Regulation Act)-ийг боловсруулж 1956 онд баталсан байна.

2. Засгийн газар анхны аж үйлдвэрийн бодлогоо 1956 онд шинэчлэн боловсруулжээ. Үүнийг Энэтхэгийн Эдийн Засгийн Үндсэн Хууль (“Economic Constitution of India”) гэж нэрлэсэн. Энэ бодлогыг дараах байдлаар 3 хуваажээ. Үүнд:

- ✓ А хэсэг нь: Энэ хэсэгт заасан зэр зэвсэг болон тэсрэх сум, атомын энерги, төмөр зам, агаарын тээвэр гэсэн 4 салбарт Засгийн газар монополь эрхтэй. Үлдсэн 13 салбарын бодлогыг мужийн Засгийн газар боловсруулсан.
- ✓ Б хэсэг төрийн болон хувиараа бизнес эрхлэгчдийн аль алинд нээлттэй.
- ✓ С хэсэгт дээрх 2 ангилалд багтаагүй бүх салбаруудыг хамруулжээ. 1956 онд хувийн хэвшлийг дэмжих хүрээг багасгаж, шинэ үйлдвэр нээх, үйлдвэрлэлээ өргөжүүлэхийн тулд Засгийн газраас тусгай зөвшөөрөл (лиценз) олгодог болсон байна.

3. 1977 оны Засгийн газрын аж үйлдвэрийн бодлогын гол зорилго нь жижиг хотуудад өргөнөөр тархсан жижиг үйлдвэрүүдийг дэмжих явдал байв. Жижиг үйлдвэрийн салбарыг зуслан, өрхийн, бичил гэж гурван бүлэгт хуваасан байна. Томоохон хэмжээний аж үйлдвэрийн салбарт; үндсэн аж үйлдвэрүүд, хүнд аж үйлдвэрүүд, өндөр технологийн аж үйлдвэрүүд, бусад жагсаалтад багтаагүй жижиг үйлдвэрүүдийг хамруулжээ.

4. 1980 оны аж үйлдвэрийн бодлого нь холбооны эдийн засгийн үзэл баримтлалыг дэмжих, төрийн салбарын үр ашгийг дээшлүүлэх, аж үйлдвэрлэлийн чиг хандлагыг өөрчлөх явдал байв. Монополь ба Худалдааны хязгаарлалтын үйл ажиллагааны тухай хууль (Monopolies and Restrictive Trade Practices Act), Валют зохицуулалтын тухай хууль (Foreign Exchange Regulation Act)-иудыг баталсан байна.

5. 1991 оны аж үйлдвэрийн шинэ бодлогын онцлог шинжүүд:

- ✓ Төрийн салбарт зэр зэвсэг болон тэсрэх сум, атомын энерги, ашигт малтмалын тос, төмөр зам, уул уурхай гэсэн үндсэн 5 салбар тэргүүлэх байр суурийг эзэлдэг байна. (Одоогийн байдлаар атомын энерги болон төмөр замын салбар нь Төрийн салбарт хамрагдсан хэвээр байна)



- ✓ Аж үйлдвэрийн жагсаалтаас гадна бүх төслүүдэд аж үйлдвэрийн тусгай зөвшөөрөл лицензийг цуцалсан.(Одоогийн байдлаар сансар, электроник болон батлан хамгаалах; аюултай химийн бодисууд; үйлдвэрийн тэсрэх бодис; тамхи болон навчин тамхины үйлдвэрлэл зэрэгт аж үйлдвэрийн лиценз шаардлагатай)
- ✓ Төрийн байгууллага хөрөнгө оруулалтаа багасгах: Төрийн байгууллагын үр ашиг болон өрсөлдөх чадварыг ихэсгэсэн ч Засгийн газар санхүүжилтээ бууруулсан.
- ✓ Гадаадын хөрөнгө оруулалтыг либералчлах: Тэргүүлэх чиглэлийн 47 аж үйлдвэрийн салбарт Гадаадын шууд хөрөнгө оруулалт (Foreign Direct Investment)-ын 51%-ийг хүлээн зөвшөөрсөн байна. Экспорт худалдааны хувьд Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг 74%-ийг хүлээн зөвшөөрчээ. (Өнөөгийн байдлаар Засгийн газар эдийн засагт Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрдөг олон салбар байдаг)
- ✓ Гадаад технологийн гэрээ: Технологитой холбоотой гэрээний автомат зөвшөөрөл.
- ✓ Монополь ба Худалдаа Хязгаарлах Практикийн тухай хууль (1980)-д нэмэлт өөрчлөлт оруулж, хөрөнгө давамгайлсан компаниудын хязгаарлалтыг хассан байна. 2002 онд Монополь ба Худалдаа Хязгаарлах Практикийн тухай хуулийг Өрсөлдөөний тухай хууль (Competition Act) -иар сольсон байна.

#### Аж үйлдвэрийн шинэ бодлогын үр дүн

- ✓ 1991 оны аж үйлдвэрийн бодлого нь тусгай зөвшөөрлийн лиценз (Licence Raj)-ийг аж үйлдвэрийн өсөлт, хүнд суртлыг арилгах замаар эдийн засгийг либералчлах бодлогыг хэрэгжүүлсэн.
- ✓ Төрийн байгууллагын хязгаарлагдмал үүрэг нь Засгийн газрын ачааллыг бууруулсан.
- ✓ Энэ бодлого нь гадаад орны компаниудыг Энэтхэгт нэвтрүүлж, хөрөнгийн хязгаарлалтыг арилгаж, либералчлах тусгай зөвшөөрөл олгох боломжийг бүрдүүлсэн. Өрсөлдөөнийг нэмэгдүүлж, цахилгаан барааны үнэ гэх мэт олон барааны үнийг бууруулахад хүргэсэн. Энэ нь хувийн хэвшлийн бүх салбарт дотоод болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих боломжийг бүрдүүлсэн.
- ✓ Мөн экспортыг нэмэгдүүлэх бодлого баримталсан.

#### Аж үйлдвэрийн ахиц, дэвшил

- ✓ Аж үйлдвэрийн бодлого нь 1956 оноос хойш Социалист нийгмээс 1991 онд Капиталист нийгэм рүү шилжсэн байна.
- ✓ Энэтхэгт гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, зохицуулалт хийхэд либералчлагдсан аж үйлдвэрийн бодлогын дэглэмийг ашигласан.
- ✓ 2018 онд Дэлхийн банкны бизнесийн тайланд Энэтхэг Улс 77 дугаар байранд жагсжээ. Төлбөрийн чадваргүй байдалтай холбоотой шинэчлэл нь Дампуурал болон төлбөрийн чадваргүй байдлын тухай хууль (Bankruptcy and Insolvency Act, 2017), Бараа, ажил, үйлчилгээний татвар (Goods and Services Taxes) бөгөөд аж үйлдвэрийн салбарт урт хугацааны турш үр дүнгээ өгнө гэж үзэж байна.
- ✓ “Make in India” болон “Start up India” зэрэг хөтөлбөр нь бизнесийн экосистемийг сайжруулсан байна.
- ✓ Цахилгаан эрчим хүчний дутагдал, өндөр үнэ, зээлийн хязгаарлалт, хөдөлмөрийн зохицуулалт, улс төрийн оролцоо, дүрэм журмын өөрчлөлт зэрэг нь аж үйлдвэрийн өсөлтөд тулгамдсан асуудал хэвээр байна.

- ✓ Энэтхэг Улсын Засгийн газар 2018 оны 12 дугаар сард бүх бизнес эрхлэгчдэд чиглэсэн “Аж үйлдвэрийг хөгжүүлэх шинэ бодлого”-ыг нэвтрүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.<sup>154</sup>

Хэрэгжиж буй гол хөтөлбөрүүд:

- ✓ НҮБ-ын хөгжлийн байгууллагатай хамтран “Тогтвортой аж үйлдвэрийн хөгжлийн 2018-2022 оны хөтөлбөр” (ISID);
- ✓ Арьсан гутлын үйлдвэр болон түүнтэй холбогдох дагалдах хэрэгслийг хөгжүүлэх хөтөлбөр;
- ✓ Бүх мужийн Засгийн газартай хамтран дижитал хөтөлбөр;
- ✓ Засгийн газар нь аж үйлдвэрлэлийн салбарт “Үндэсний Үйлдвэрлэлийн Бодлого” (National Manufacturing Policy) хөтөлбөр;
- ✓ Make in India” болон Start up India хөтөлбөр;
- ✓ Ноосон үйлдвэрлэлийг хөгжүүлэх нэгдсэн хөтөлбөр 2017-2018, 2019-2020 болно.

Энэтхэгийн аж үйлдвэрийн гол салбарт:

- ✓ Уул уурхай олборлох;
- ✓ Боловсруулах үйлдвэрлэл;
- ✓ Хүнсний бүтээгдэхүүн, ундаа, тамхи;
- ✓ Нэхмэл, хувцас, бусад бүтээгдэхүүн;
- ✓ Металл бүтээгдэхүүн;
- ✓ Машин тоног төхөөрөмж;
- ✓ Бусад үйлдвэрлэлийн бараа;
- ✓ Цахилгаан, хий, усан хангамж, бусад үйлчилгээ;
- ✓ Барилга зэргийг багтжээ.

#### Боловсруулах үйлдвэрлэл<sup>155</sup>

Энэтхэгийн өсөлттэй өндөртэй салбаруудын нэг нь боловсруулах үйлдвэрлэл юм. Энэтхэгийн Засгийн газар “Make in India” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2022 он гэхэд энэ салбарт 100 сая ажлын байр шинээр бий болгохыг зорьж байна.

Энэтхэгийн боловсруулах үйлдвэрлэлийн салбарт Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) 2000 он 3-4 дүгээр сард 89.40 тэрбум ам. долларт хүрчээ. 2020 оны 5 дугаар сард Энэтхэгийн Засгийн газар Батлан хамгаалах салбарын шууд хөрөнгө оруулалтыг 49%-иас 74% болон өссөн байна. Энэ нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалтыг татах таатай боломжийг бүрдүүлжээ.

Энэ салбарыг 2025 он гэхэд 1 их наяд ам. долларт хүрэх боломжтой гэж үзэж байна. Бараа, үйлчилгээний татвар (GST)-ийг хэрэгжүүлснээр Энэтхэгийг ДНБ нь 2.5 их наяд ам. доллар болох ба нийт 1.32 тэрбум хүн амтай болно гэж төсөөлж байна.

Энэтхэгийн үүрэн холбоо ба электроникийн холбоо (ICEA) нь Энэтхэг Улс 2025 он гэхэд зөөврийн компьютер, таблет үйлдвэрлэх хүчин чадлаа 100 тэрбум ам.долларт хүргэх боломжтой гэж таамаглаж байна. Боловсруулах үйлдвэрлэлд гар утас, дээд зэрэглэлийн автомашины брэндийг шинээр байгуулахаар зорьж байна. Аж үйлдвэрийн салбарт ухаалаг хотыг хөгжүүлэхэд Засгийн газар улс үндэстний цогц хөгжлийг хангахыг зорьж байна.

<sup>154</sup> <https://www.drishtiiias.com/to-the-points/paper3/india-s-industrial-policy>

<sup>155</sup> <https://www.ibef.org/industry/manufacturing-sector-india.aspx>

### Нэхмэл хувцас, оёдлын үйлдвэр<sup>156</sup>

Энэтхэгийн нэхмэл хувцас, оёдлын үйлдвэр нь ДНБ-ний 2.3%, аж үйлдвэрийн 13%, экспортын 12%-ийг тус тус эзэлдэг байна.

Нэхмэлийн үйлдвэр нь хөдөө аж ахуй (хөвөн түүхий эд) болон эртний соёл, уламжлал (гар нэхмэл)-тай байдаг тул бусад үйлдвэрүүдээс өвөрмөц ялгаатай. Энэтхэгийн нэхмэлийн үйлдвэр нь дэлхийн зах зээлд тохирсон олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.

Батлан хамгаалах судалгаа, хөгжлийн байгууллага (Defence Research and Development Organisation) нь Энэтхэгийн нэхмэлийн үйлдвэрт гадаадаас импортоор оруулж ирэх, нэхмэлийн утас үйлдвэрлэх, цэргийн дүрэмт хувцас зэргийг арилгаж, өөрснөө үйлдвэрлэх боломжийг бүрдүүлжээ. Мөн гараар нэхсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортод дэмжлэг үзүүлэх ажлыг эхлүүлсэн.

2020 онд Нэхмэлийн яамнаас (Ministry of Textiles) нэхмэлийн шинэ бодлогыг боловсруулсан. Гадаад худалдааны ерөнхий газар (The Directorate General of Foreign Trade) нь нэхмэлийн үйлдвэрийн дэд салбар болох хувцас, бусад гар хийцийн бүтээгдэхүүний хувьд Энэтхэгээс бараа экспортлох схем (Merchandise Exports from India Scheme)-ийн дагуу шимтгэлийг 2%-иас 4%-ийн болгон шинэчилжээ.

#### **Хөгжлийн стратеги ба аж үйлдвэрийн бодлого, үндэслэл, бүтэц**

Энэтхэг Улс аж үйлдвэрийн хөгжлийн бодлогоо тодорхойлохдоо дараах хүчин зүйлсийг харгалзан үзсэн байдаг. Эдгээр нь 1. Хөрөнгө оруулалт 2. Хөдөлмөр 3. Ур чадвар 4. Аж ахуйн нэгжүүд (ялангуяа жижиг үйлдвэрүүд) болон кластерууд 5. Худалдаа 6. Технологи 7. Өрсөлдөөн ба зохицуулалт зэрэг болно. Энэтхэгийн хэрэгжүүлж буй аж үйлдвэрийн бодлогын хүрээнд ЖДҮ чухал байр суурь эзэлдэг. Учир нь ЖДҮ-ийн салбар нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 45%, нийт экспортын 40%-ийг бүрдүүлдэг, 60 гаруй сая ажиллагсадтай, жил бүр 1.3 сая ажлын байр бий болгож, дотоодын болон олон улсын зах зээлд 8000 гаруй төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг. Энэтхэгт ойролцоогоор 30 сая ЖДҮ үйл ажиллагаа явуулдаг, салбарын үйлдвэрлэл нь жилд дунджаар 8%-иар өсч байна.

#### **3.5.4 Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Үндэсний үйлдвэрлэлийн бодлого: Энэхүү бодлогын хүрээнд дараах арга зорилтуудыг дэвшүүлсэн байна.

- ✓ Сургалт, хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэх: Сая сая бага боловсрол эзэмшсэн хүмүүсийг үйлдвэрлэлийн сургалтын байгууллагуудаар дамжуулан сургаж, орон нутгийн хэмжээнд хэлний сургалтуудыг орон даяар явуулах болно. Мэргэжлийн сургалт, ур чадварыг дээшлүүлэх нь үйлдвэрлэл дахь хүний нөөцийн оролцоог дээшлүүлж, ажилчдын бүтээмжийг дээшлүүлнэ.
- ✓ Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх: Ур чадвар, үйлдвэрлэлийн түвшинг дээшлүүлж, хүмүүс инновацийг боловсруулж, дадлагажуулах, дагалдан суралцах загварыг гаргах нь компаниудыг илүү нягтралтай ажиллах хүчээр ажиллуулах, зардал багатай ажиллах боломжийг сайжруулах боломжийг олгоно.
- ✓ Өргөн цар хүрээний дэд бүтцийн сайжруулалт: Дэлхийн жишигт нийцсэн боомт, ачаа тээвэрлэлт, хурдны зам, төмөр замын коридорыг хөгжүүлэх нь түүхий эд худалдан

<sup>156</sup> <https://www.ibef.org/industry/textiles.aspx>

- авах, нэвтрүүлэх сувгийг сайжруулах, зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлнэ. Энэ нь компаниудад уян хатан байх, зах зээлийн динамик нөхцөл байдалд хурдан хариу үйлдэл үзүүлэх, үйлдвэрлэл, зах зээлээ өргөжүүлэх, үр ашигтай нийлүүлэлтийн сүлжээг бий болгох, ачаа тээврийн зардлыг бууруулах боломжийг олгож, өрсөлдөх чадварыг нь сайжруулахад тусална.
- ✓ Компаниудын бөөгнөрөл, төвлөрөл: Үндэсний хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бүс (National investment and manufacturing zone)-ээр дамжуулан салбар дотроо үйл ажиллагаагаа явуулбал жижиг, дунд, том ханган нийлүүлэгчид, үйлдвэрлэгчид орон зайн хувьд хоорондоо ойрхон ажиллах боломжийг олгож, ханган нийлүүлэлтийн асуудлыг нэгдсэн зохион байгуулалттай, хурдтай шийдэх боломжийг бүрдүүлнэ. Энэ нь эдийн засагт давуу талыг олгож, хүргэх хугацаа болон ачааны зардлыг бууруулах нөлөөг үзүүлнэ.
  - ✓ Технологи олж авах, хөгжүүлэх: Татварын хөнгөлөлт, татаас зэрэг урамшуулал нь ЖДҮ эрхлэгчид болон томоохон аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай технологийн хүртээмжийг өсгөх боломжийг олгоно. Татаас нь технологийн хөгжлийг дэмжиж, хөрөнгө оруулалтыг илүү сонирхол татахуйц болгож, судалгаа шинжилгээний чанарыг сайжруулах, оюуны өмчийн эрхийг бий болгоход түлхэц болно.
  - ✓ Зохицуулалтын шинэчлэл: Түргэн шуурхай, үр дүнтэй зохицуулалт нь бодлогуудын нийцлийн чанарын шалгуур болдог. Энэ нь нэг цэгийн цахим үйлчилгээг хурдан хүргэж, аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үндсэн үйл ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлэх, үйл ажиллагааг нь цаг алдалгүйгээр өргөжүүлэх таатай уур амьсгалыг бүрдүүлэх болно.
  - ✓ Гадаадын хөрөнгө оруулалт: Засгийн газар гадаадын шууд хөрөнгө оруулалтыг (ГШХО) татахын тулд гадаадын шууд хөрөнгө оруулалтын зохицуулалтыг ойлгомжтой болгож хөнгөвчлөх, салбарын шинэчлэлд шуурхай дүгнэлт хийж, хөрөнгө оруулалтын эерэг орчныг бүрдүүлэхийг зорьж байна. Гадаадын хөрөнгө оруулагчид дотоодын үйлдвэрлэгчидтэй түншлэлийн замаар (хөрөнгө оруулалт хийх, технологийг хуваалцаж ) аль эсвэл ногоон үйлдвэрлэлийг эрхлэх, ажлын байр бий болгох, орон нутгийн бизнес эрхлэгчид, ханган нийлүүлэгчид, ложистикийн үйлчилгээ эрхлэгчид, дэд бүтэц хөгжүүлэгчидтэй хамтран ажиллаж томоохон хөрөнгө оруулалт хийх зорилгоор орж ирдэг.
  - ✓ Худалдааны бодлого: Засгийн газар худалдааны бодлогоо шинэчилж, олон улсын зах зээлийг нээхээр төлөвлөж байна. Энэ нь зах зээлийг тэлэх, эрэлтийн хэлбэлзлийг бууруулах, үйлдвэрийн ашиглалт, капиталын хүчин чадлыг нэмэгдүүлэх болно.
  - ✓ Хөдөө аж ахуйн банк: Засгийн газраас хөдөө аж ахуйн банкны төрөлжсөн үйл ажиллагааг дэмжсэнээр газрын ашиглалтыг нэмэгдүүлэх, бүтээмжийг нь дээшлүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дотооддоо үйлдвэрлэлийг богино хугацаанд байгуулах, хөрөнгө оруулалтыг татах боломжийг олгох юм.
  - ✓ Үндэсний хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бүсийн хүрээнд гарах механизмууд нь ажлын байрны бодлого, хөрөнгө хуваарилалтын төлөвлөгөө, татварын чөлөөлөлтийг (тодорхой нөхцөлд) тодорхойлох замаар засгийн газар бүс нутгийн хөдөлмөрийн харилцаа, энэхүү харилцааны хяналтын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.

- ✓ Инноваци болон оюуны өмчийн эрх (IPR): Засгийн газрын инноваци, оюуны өмчийн эрхийн бүртгэлийг дэмжин сурталчлах нь үйлдвэрлэгчдийн хувьд дэлхийн тавцанд өрсөлдөхөд стратегийн чухал, урт хугацааны давуу талыг бий болгоно.
- ✓ Түншлэлээр дамжуулан аж үйлдвэрийн өсөлтийг дэмжих: Бодлого нь түншлэлээр дамжуулан өсөлтийг дэмжинэ. Энэ нь компаниудын уялдаа холбоог нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, технологийг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, бизнесүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжийг олгохын зэрэгцээ харьцангуй үнэ цэнэ өндөртэй бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх эерэг таатай орчныг бүрдүүлнэ.

## Санхүүжилт

Энэтхэгийн төв банк нь ЖДҮ-ийн салбарт зээлийн удирдлагын талаар шаардлагатай зааврыг банкуудад өгөх нь зайлшгүй чухал гэж үзсэн. Засгийн газар зээл авч чадахгүй байгаа ЖДҮ эрхлэгчдэд санхүүжилтийн таатай орчин бүрдүүлэхийг хичээх ёстой. ЖДҮ-ийн салбарын зээл олгоход тэргүүлэх ач холбогдол өгдөг төвлөрсөн банкууд, ББСБ-уудыг байгуулснаар хэрэгжилтийг хангаж болно. ЖДҮ-ийн эрсдэл өндөртэй санхүүжилтийн схем байж болох ч өгөөжийн хэмжээг тогтвортой болгох боломжтой. Түүнээс гадна зээлийн төлбөрийг хойшлуулах нь ЖДҮ-ийн хөгжилд, ялангуяа байгуулагдаад удаагүй байгаа бизнесүүдэд чухал байдаг.

Төлбөрөө төлж чадахгүй байгаа ихэнх үйлчлүүлэгчид нь томоохон аж ахуйн нэгжүүд байдаг бөгөөд ЖДҮ эрхлэгчид бизнесээ алдах вий гэж болгоомжилсондоо зээлийн төлөлтийн талаар мэдээлэх сонирхолгүй байдаг. Төлбөрийн асуудлыг шийдвэрлэхийн тулд Засгийн газар дэлгэрэнгүй мэдээллийг өгдөг автоматжуулсан портал байгуулж болно. Төлбөрийг төлөөгүй тохиолдолд Засгийн газар төлбөрөө төлж чадахгүй байгаа байгууллагууд уруу автомат санамж илгээж болно.

Төсөв нь засгийн газар санхүү, эдийн засгийн шинэ зорилт дэвшүүлэх, бодлогын чиглэл өгөх, санхүүгийн эх үүсвэрийг хуваарилах боломж гэж тооцогддог. Сангийн сайд нийгэм, эдийн засгийн өсөлтийн нийтлэг зорилтыг хангахын тулд шинэ бодлого, схем, төслүүдээ зарлаж, эдийн засгийн төрөл бүрийн салбарыг хөгжүүлэхэд санхүүгийн нөөцийн хуваарилалтыг төслийг боловсруулдаг. Жижиг дунд бизнес эрхэлсэн яам эдийн засагт чухал ач холбогдолтойг харгалзан үзэж, эдийн засгийн уналттай нөхцөлд бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлүүдийг судлан үзэж, шийдвэр гаргах нь чухал юм.

Үндэсний үйлдвэрлэлийн бодлогын хүрээнд дэд хөтөлбөр хэрэгжиж байгаагийн нэг нь “Санхүүгийн дэмжлэг-Ерөнхий сайдын хөдөлмөр эрхлэлтийг бий болгох хөтөлбөр” юм. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

- Зээлийн хөрөнгөөр технологийн шинэчлэл хийсэн бизнест татаас өгсөн.
- Бичил, жижиг үйлдвэрүүдэд зориулсан зээлийн баталгааны итгэлцлийн сан байгуулсан.
- Банкинд олгосон зээлийн дүнгийн багагүй хувьтай тэнцэх хэсэгт Итгэлцлийн сан (Trust Fund) баталгаа гаргадаг. Баталгаа гаргах үйл явцыг хэрэгжүүлсэн.
- ЖДҮ-ийн 2%-ийн хүүтэй зээл олгосон.
- Бага хүүтэй зээлийг олгохын хажуугаар бараа үйлчилгээний татварын платформыг нэвтрүүлсэн. Энэ нь эдийн засгийг бүртгэлжүүлэх, бодлогын үр ашигтай байдлыг хангахад тусалсан.

- Түүнчлэн subordinated debt буюу доогуур зэрэглэлийн өрийн санхүүжилтээр бизнесүүдийг хангасан. Энэ нь өр төлбөрүүдийн хамгийн сүүлд төлөгддөг онцлогтой барьцаагүй өрийн эх үүсвэр бөгөөд зээлдүүлэгч нь тухайн бизнес төлбөрөө төлөх боломжгүй тохиолдолд доогуур зэрэглэлийн энэхүү өрийг хувьцаа болгож хөрвүүлэх боломжийг олгосноороо зээлдэгчийн төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулах нөлөөг үзүүлэх сайн талтай юм. Өөрийн хөрөнгийг хэмжээ нь нэмэгдсэн бизнесийн өр, эздийн өмчийн харьцаа өсөж, өрийн эх үүсвэрийг дахин дайчлах боломжоо нэмэгдүүлнэ.
- Засгийн газраас бизнесүүдэд хүүний татаас өгсөн. Энэ нь бага хүүтэй зээлээр хөрөнгөө санхүүжүүлэх боломжийг олгосон.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <https://www.nordeatrade.com/fi/explore-new-market/italy/economical-context>
- [http://www.isigrowth.eu/wp-content/uploads/2016/01/working\\_paper\\_2016\\_2.pdf](http://www.isigrowth.eu/wp-content/uploads/2016/01/working_paper_2016_2.pdf)
- <https://ec.europa.eu/growth/tools-databases/regional-innovation-monitor/organisation/centro-i/ministry-economic-development-italy>
- <https://www.urbanwins.eu/industrial-symbiosis-platform-in-italy/>
- <http://www.industrialsymbiosis.it>
- [http://www.eurasiancommission.org/ru/act/prom\\_i\\_agroprom/dep\\_prom/SiteAssets/Материалы%20в%20разделе%20Аналитика/Отраслевые%20обзоры/Аналитическая%20записка%20по%20гос%20поддержке%20ЕС%20легкая%20промышленность.pdf](http://www.eurasiancommission.org/ru/act/prom_i_agroprom/dep_prom/SiteAssets/Материалы%20в%20разделе%20Аналитика/Отраслевые%20обзоры/Аналитическая%20записка%20по%20гос%20поддержке%20ЕС%20легкая%20промышленность.pdf)
- <https://www.sace.it/en>
- <https://www.themanufacturer.com/uk-manufacturing-statistics/>
- [ibisworld.com](http://ibisworld.com)
- [https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment\\_data/file/31785/10-1333-manufacturing-in-the-UK-an-economic-analysis-of-the-sector.pdf](https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/31785/10-1333-manufacturing-in-the-UK-an-economic-analysis-of-the-sector.pdf)
- [https://www.cgisf.gov.in/docs/1597953122New Industrial Policy.pdf](https://www.cgisf.gov.in/docs/1597953122New%20Industrial%20Policy.pdf)
- <https://www.prnewswire.com/news-releases/setting-up-nemanufacturing-facilities-in-india-2020-competitive-benchmarking-of-leading-states-301078802.html>
- [https://twitter.com/IndLandBank\\_Gol/status/1387714265365159937/photo/1](https://twitter.com/IndLandBank_Gol/status/1387714265365159937/photo/1)
- <https://statisticstimes.com/economy/country/india-gdp.php>
- <https://statisticstimes.com/economy/country/india-gdp-sectorwise.php>
- [India's Industrial Policy \(drishtiias.com\)](http://India's%20Industrial%20Policy%20(drishtiias.com))
- <https://www.drishtiias.com/to-the-points/paper3/india-s-industrial-policy>
- <https://www.ibef.org/industry/manufacturing-sector-india.aspx>
- [World\\_manufacturing\\_production\\_2020\\_Q1.pdf](#)
- [High\\_Value\\_Manufacturing\\_Strategy\\_2012-15.pdf](#)
- [Manufacturing%20White%20Paper%20May%202018\\_UK.pdf](#)
- [Microsoft PowerPoint - \\_EDIIN\\_NUUTs\\_\(201005135341\) \(mofa.gov.mn\)](#)
- [Manufacturing-in-the-UK-an-economic-analysis-of-the-sector.pdf](#)
- [UK%20government-policy-since-1945.pdf](#)
- [Ноос ноолууран бүтээгдэхүүн - ХХААХҮЯам \(mofa.gov.mn\)](#)
- [India/A\\_NEW\\_INDUSTRIAL\\_POLICY\\_FOR\\_INDIA.pdf](#)
- [India/IMP.pdf](#)
- [Factors%20on%20american%20industry%20industrialization.pdf](#)
- [usda-strategic-plan-2018-2022.pdf](#)
- [IndustrialpolicyintheUnitedStates.pdf](#)
- [Case\\_Study\\_4%20\(1\).pdf](#)
- [Innovative-China-New-Drivers-of-Growth.pdf](#)
- [2015-006.pd](#)
- [2015-Manufacturingcompetitiveness.pdf](#)
- [Feng2018\\_Article\\_CurrentProblemsInChinaSManufac.pdf](#)
- [IF10964\\_industrial%20priorities.pdf](#)
- [Naughton2021\\_Industrial\\_Policy\\_in\\_China\\_CECHIMEX.pdf](#)
- [The\\_Concept\\_of\\_Chinas\\_Light\\_Industry\\_Development\\_%20\(1\).pdf](#)



- 2016huulitogtoomj.pdf
- 2016uildeverjilt.pdf
- GDP\_GNI.pdf
- c60255ec3c075e622575fa120a2ba866769fc%20(1).pdf
- 2017moriinhotolbor.pdf
- 2019%20gender.pdf
- 2020tog203h2.pdf
- 20181moriinhot.pdf
- 12283339\_02.pdf
- economic\_impact.pdf
- Factors%20on%20developing%20country%20industrialization.pdf
- factors%20on%20industrialization.pdf
- Mongol%20uls/Financial\_account2018,%20MGL.pdf
- GDP%20class,%20Canada.PDF
- GDP\_2019Q4.pdf
- GDP\_2020Q4\_en.pdf
- HHAA.pdf
- hongon\_2016-2020.pdf
- hongon20191.pdf
- Industry\_2018.pdf
- IOT\_Analysis\_2010\_2015.pdf
- ISIC 4.0 last.pdf
- MCC\_Mongolia\_CA\_Mongolian, салбарын ангилал.pdf
- moriinhotolbor2020.pdf
- NA\_2019.pdf
- Naughton2021\_Industrial\_Policy\_in\_China\_CECHIMEX.pdf
- plan2019(1).pdf
- salbar2017.pdf
- Sector\_acc\_2010-2019.pdf
- Sectoral analysis.pdf
- seriesm\_4rev4e (1).pdf
- sta\_report\_on\_quarterly\_production\_2013q3-1.pdf
- stat2016.pdf
- Thailand.pdf
- Бодлогын хэрэгжилийг үнэлсэн тайлан, 2018\_USA.pdf
- Яамны бодлого.pdf
- 2016hevlel.pdf
- 2016huulitogtoomj.pdf
- 2016uildeverjilt.pdf
- Industrial\_Revolution\_in\_the\_United\_States



## БҮЛЭГ II

---

### НИЙГЭМ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ХҮЧИРХИЙЛЭЛ БА ХҮҮХЭД ХАМГААЛАЛ: ОЛОН  
УЛСЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

(Харьцуулсан судалгаа)

*Д.Аюуш, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа*

**АГУУЛГА**

ТОВЧИЛСАН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

**1. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭЛБЭР, ЭРХ ЗҮЙН  
ОРЧИН.**

Цахим орчин дахь хүчирхийллийн хэлбэр

Хууль эрх зүйн орчин

**2.ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

**3.ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ**

Кибер гэмт хэргийн тухай конвенц

“Цахим орчин дахь хүүхдийн хамгаалалт 2020” бодлого боловсруулагчдад өгөх удирдамж

Цахим орчин дахь Хүний эрхийн түгээмэл тунхаглал

“Ковид-19” цар тахал ба цахим орчин дахь хүүхдийн хүчирхийлэл

**4.БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

Герман улс

Япон улс

АНУ

ИБУИНХУ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ХХЗХ	Харилцаа, холбооны зохицуулах хороо
ЗГ	Засгийн газар
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОУЦХБ	Олон улсын цахилгаан холбооны байгууллага
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ОУХХЭ	Олон улсын харилцаа холбооны эвсэл
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

## УДИРТГАЛ

Энэхүү судалгаанд цахим орчин дахь хүчирхийллийн хэлбэр, хүүхэд хамгааллын эрх зүйн орчин, олон улсын зөвлөмж, бусад орнуудын сайн туршлагуудыг харьцуулан судлав.

Судалгааны **нэгдүгээр бүлэгт** цахим орчин дахь хүчирхийллийн хэлбэр, Монгол Улсын хууль, эрх зүйн орчны талаар, **хоёрдугаар бүлэгт** цахим орчин дахь хүүхдийн хүчирхийллийн нөхцөл байдлыг судлан гаргав. Судалгаанд ГБХЗХГ-аас хийсэн “Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал” судалгаа (2018), ХХЗХ-оос хийсэн “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал” судалгаа (2021)-ийг ашигласан болно. **Гуравдугаар бүлэгт** цахим орчин дахь гэмт хэрэг, олон нийтийн сүлжээн дэх хүчирхийллийн талаарх олон улсын баримт бичгийн талаар судлав. Тухайлбал, кибер гэмт хэргийн тухай конвенц, НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF), ОУЦХБ (ITU)-аас гаргасан “Цахим орчинд хүүхдийг хамгаалах тухай бодлого боловсруулагчдад хандах удирдамж”, “Цахим орчин дахь Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Ковид-19” цар тахал ба цахим орчин дахь хүүхдийн хүчирхийллийн талаарх мэдээллийг энэ хэсэгт тоймлон оруулав. **Дөрөвдүгээр бүлэгт** нийгмийн сүлжээн дэх хүчирхийллийн эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах тусгайлсан хуультай Герман мөн энэ талаар өндөр түвшинд зохицуулсан ИБУИНХУ (Англи), АНУ, Япон зэрэг орнуудыг сонгон, хууль тогтоомжуудыг харьцуулан судалсан болно.

**Түлхүүр үг:** Цахим орчин дахь хүчирхийлэл, цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал, цахим орчин дахь хүний эрх, НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF), ОУЦХБ (ITU)-ийн зөвлөмж, “Ковид19” цар тахал ба цахим орчин

**Keywords:** Cyberbullying, child safety in cyberspace, human rights in cyberspace, UNICEF’s guidelines, ITU’s guidelines, COVID-19 and cyberspace

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

**Цахим орчин дахь хүчирхийллийн хэлбэр, эрх зүйн орчны талаар:** Цахим хүчирхийлэл (cyberbullying) гэдэг<sup>157</sup> нь хэн нэгэн этгээд цахим технологийг ашиглан бусад хүнийг дарамтлах, заналхийлэх, ичээх, эсвэл түрэмгийлэх явдал юм. Энэ нь гар утас, компьютер, таблет, тоглоомын систем гэх мэт төхөөрөмж ашиглан үйлдэгддэг. Цахим хүчирхийлэл нь хүний эрхийг зөрчиж байгаа бөгөөд зарим тохиолдолд хууль зөрчсөн үйлдэл болж байна.

Хууль эрх зүйн хувьд Монгол Улс хүүхдийн бүх төрлийн хүчирхийллийн асуудлаар Үндсэн хууль болон хүний эрх, хүүхэд хамгаалалтай холбоотой олон улсын баримт бичгүүдэд нэгдэн орсны дээр Эрүүгийн, Зөрчлийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Садар самуунтай тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Зар сурталчилгааны тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад тус тус тусгаж өгчээ.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлийн 3.4-т “Хүний аюулгүй байдал”<sup>158</sup>-ыг тодорхойлж, ... “Хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдийг хүн худалдах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгож энэ чиглэлд бэхжүүлнэ.” гэж ... 3.6-т Мэдээллийн аюулгүй байдлыг

<sup>157</sup> <https://kidshealth.org/en/parents/cyberbullying.html>

<sup>158</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол <https://www.legalinfo.mn/annex/details/8070?lawid=6163>



хангах үндсийг “Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж зааж өгсөн нь цахим орчин дахь хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах байдал давхар заагдсан гэж үзэхээр байна.

2018 онд ЗГ-ын тогтоолоор “Сургалтын орчинд авах арга хэмжээ” батлагдаж, үүнд: “Сургууль, цэцэрлэгийн орчинд хичээл, сургалтын үеэр сурагч, хүүхдүүдэд ухаалаг гар утас, түүнтэй адилтгах төхөөрөмж ашиглахыг 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хязгаарлаж”, ... “хүүхэд залуучуудын дунд ухаалаг утас болон цахим сүлжээний ёс зүйтэй хэрэглээг хэвшүүлэх хүрээнд хүүхэд, залуучуудад ээлтэй бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, цахим хүчирхийлэл, халдлагаас урьдчилан сэргийлэх” арга хэмжээ авахаар заажээ.

2020 онд ХХМТГ<sup>159</sup>-аас “Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл” батлагдаж, цахим орчинд хүүхдийг эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөхүйц мэдээ мэдээлэл, агуулга, харилцаанаас шалтгаалсан эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгыг тусгасан байна.

Манай улсад цахим орчин дахь хүчирхийлэл, нийгмийн сүлжээний талаар тусгайлсан хууль байхгүй бөгөөд эрүүгийн хууль дахь зүйл, заалт нь хүчирхийллийг ямар хэлбэрээр гэдгийг ялгаж бүртгэдэггүй, мөн цахимаар үйлдэж буй гэмт хэрэгт цахим хүчирхийллийн гэмт хэргийг тусад нь ялгаж бүртгэдэггүй байгаа нь энэ талын мэдээлэл боловсруулалт хийхэд хүндрэл учруулж байна.

**Цахим орчин дахь хүүхдийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар:** Цахим орчин дахь хүүхдийн хүчирхийллийн талаарх тоо баримтыг ...

- 1) цагдаад бүртгэгдсэн гэмт хэрэг зөрчлийн мэдээ;<sup>160</sup>
- 2) шүүхээр шийдвэрлэгдсэн шүүн таслах ажлын мэдээ;<sup>161</sup>
- 3) гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын харьяа 108 төв (утас) болон түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн статистик тоон мэдээ

зэргээс шүүж үзэхэд цахим хүчирхийлэл нь цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг<sup>162</sup>-т хамаарч хүүхдийн хүчирхийллийн гэмт хэргийг ялгаж харах боломжгүй байна. Үүнийг илүү нарийвчлан эмпирик судалгаа хийж, тодруулах шаардлагатай.

Цагдаагийн ерөнхий газарт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээнээс харахад цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо жил бүр нэмэгдэж, 2019 онд 57, 2020 онд 146 болж 2.6 дахин өссөн байна. Хүүхдийн 108 утсанд 2020 онд цахим донтолт 160, цахим дарамт 166 бүртгэгдсэн бол 2021 оны 5 дугаар сарын байдлаар цахим донтолт 91, цахим дарамтын талаар 52 дуудлага ирсэн байна.

<sup>159</sup> Харилцаа холбоо, мэдээлэл, технологийн газар

<sup>160</sup> Цагдаагийн байгууллагад 2021 оны эхний 3 сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, Цагдаагийн ерөнхий газар, мэдээлэл дүн шинжилгээ шуурхай удирдлагын алба, 2021.04.05

<sup>161</sup> Монгол Улсын шүүхийн 2020 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ, Шүүхийн ерөнхий зөвлөл, 2021 он <http://www.judinstitute.mn/main/252--2020-.html>

<sup>162</sup> Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэг <https://www.legalinfo.mn/law/details/11634>

ГБХЗХГ-аас 2018 онд “Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал, ХХЗХ-оос 2021 онд “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаарх судалгаа”-г гүйцэтгэжээ. Дээрх хоёр судалгаанд өсвөр насны хүүхдийн интернэтийн хэрэглээ түүний дотор нийгмийн сүлжээ (facebook)-ний хэрэглээний онцлог, тэдний аюулгүй байдал, цахим орчны халдлагад өртөж байсан талаарх баримтыг тусгажээ. Судалгаанд өсвөр насныхан, багш, эцэг эхийн төлөөллийг тал талаас оролцуулсан нь онцлог болжээ.

***Цахим орчин дахь хүчирхийллийн талаарх олон улсын баримт бичгийн талаар:***


Кибер аюулгүй байдлын олон талт хамтын ажиллагааны эрх зүйн үндэс нь Кибер гэмт хэргийн тухай Будапештийн конвенц юм. Тус конвенцийн наймдугаар зүйлд Хүүхдийн порнографтай холбоотой гэмт хэрэг буюу хүүхдийн эрхийн талаар зохицуулж, процессын хууль, шүүх эрх мэдлийн талаар болон олон улсын хамтын ажиллагааны талаар дурджээ. Монгол Улс тус конвенцийн оролцогч болохын тулд түүний оролцогч 45 улсаас дэмжлэг авах шаардлагатай юм.

Мөн НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF), Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага (ITU) болон Цахим орчинд хүүхдийг хамгаалах санаачилгатай хамтран “Цахим орчинд хүүхдийг хамгаалах тухай бодлого боловсруулагчдад хандах удирдамж”-ийг шинэчлэн гаргасан байна.

Тус удирдамж нь хүүхдийг нийгмийн болон цахим орчинд хоёуланд нь хамгаалах үүргээ ухамсарлаж, хэрэгжүүлэх тогтолцоог бодлого боловсруулагч болон засгийн газарт санал болгосон байна. Мөн цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг устгах зорилготой “Бид Хамгаална” (WeProtect) загварыг хэрэгжүүлэхээр дэлхий улс орнуудын бодлого боловсруулагч болон засгийн газруудад зөвлөсөн байна.

Мөн судлаач Роберт Б.Геманы боловсруулсан Цахим орчин дахь Хүний эрхийн түгээмэл тунхаглал (төсөл)-ыг эрдэмтэн судлаачид талархан хүлээн авч байна.

“Ковид-19” цар тахлын улмаас дэлхий дахинд хүүхдүүдийн хичээл, сургууль тасалдсантай холбоотой нийгэм, эдийн засгийн олон асуудал үүсч байгаа бөгөөд дэлхийн цөөнгүй улсад дижитал хэлбэрээр хичээлийг үргэлжлүүлж байна. Үүнээс шалтгаалан хүүхдүүдийн интернэт хэрэглээ нэмэгдэж, цахим орчинд өнгөрөөх хугацаа уртассан талаар НҮБ-ын Хүүхдийн сангаас мэдээлэл гаргасан байна. Манай улсад ч ийм нөхцөл байдал үүссэн бөгөөд эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хүүхдийнхээ интернэт хэрэглээнд хяналт тавьж, анхаарал хандуулах зүй ёсны шаардлага бий болоод байна.



**Цахим орчин дахь хүчирхийлэл, хүүхэд хамгааллын талаарх бусад орны туршлага, эрх зүйн зохицуулалт**

№	Улс	Цахим хүчирхийллийн нөхцөл байдал	Эрх зүйн орчин	Хариуцдаг байгууллага	Авч буй арга хэмжээ
1	Герман	<p>Jungendschutz.net цахим хуудсанд бүртгэгдсэн 7513 зөрчлийн ангиллыг авч үзэхэд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- хүүхдийн бэлгийн мөлжлөг-41%</li> <li>- улс төрийн хэт туйлшралтай холбоотой цахим гэмт хэрэг,</li> <li>- хүүхэд залууст хор хөнөөлтэй мэдээлэл зэрэг нь бусад хувийг эзэлж байна.</li> </ul> <p>Эдгээр цахим гэмт хэргийн 86% нь гадаадын серверээс ирсэн бөгөөд тал орчим хувь нь платформ дээр илэрчээ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Залуучуудыг хамгаалах тухай хууль (JuSchG)</li> </ul> <p><i>Эх сурвалж:</i>  <a href="https://germanlawarchive.iuscompr.org/?p=724">https://germanlawarchive.iuscompr.org/?p=724</a></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн сүлжээн дэх хүүхэд, залуучуудын хамгааллын тухай муж хоорондын гэрээ (JMStV)</li> </ul> <p><i>Эх сурвалж:</i> <a href="https://www.kjm-online.de/en/">https://www.kjm-online.de/en/</a></p> <ul style="list-style-type: none"> <li>- Германы Эрүүгийн хууль</li> </ul> <p><i>Эх сурвалж:</i> Criminal Code (Strafgesetzbuch, StGB)  <a href="https://germanlawarchive.iuscompr.org/?p=752">https://germanlawarchive.iuscompr.org/?p=752</a></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн сүлжээн дэх хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль</li> </ul> <p><i>Эх сурвалж:</i>  <a href="http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/14077.pdf">http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/14077.pdf</a></p>	<p>Цахим болон нийгмийн сүлжээн дэх хүчирхийллийн гэмт хэрэг, халдлагаас хүүхэд, залуу үеийг хамгаалах үйл ажиллагааг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Холбооны гэр бүлийн яам</li> <li>- Яамны харьяа Хүүхэд, залуучуудын хортой мэдээллийн хяналтын холбооны зөвлөл (BPJM),</li> <li>- Цахим орчин дахь хүүхэд, залуучуудыг хамгаалах комисс (KJM) зэрэг байгууллагууд хариуцан ажилладаг.</li> <li>- Цагдаагийн байгууллага, төрийн болон хувийн, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажилладаг байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цахим үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг хянах, мэдээллийг индексжүүлэх, гомдол хүлээн авах, шийдвэрлэх, хүүхдийн цахим хүчирхийллийн эсрэг хөтөлбөр, үйл ажиллагаа хэрэгжүүлэх зэргээр хяналт тавьдаг.</li> <li>- Мэдээллийг ангилан хортой мэдээллийг устгах хяналтын төв ажиллуулдаг. Үүнд хуулиар гадаад, дотоодын үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд бүгд хамрагдана.</li> <li>- Хувь хүмүүс, эцэг эхчүүдэд цахим хүүхдийн хүчирхийллээс хамгаалах мэдлэг олгох, шүүлтүүр бүхий технологи нэвтрүүлэх зэргийг хуулиар шаарддаг.</li> </ul>
2	Япон	<p>2020 онд 18-аас доош насны 1819 хүүхэд цахим гэмт хэргийн хохирогч болсон. Хохирогчдын бараг 90 хувь нь бага, ахлах сургуулийн сурагчид байсан. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>- хүүхдийг хамгаалах хууль, журмыг зөрчсөн 738,</li> <li>- хүүхдийн садар самуун 597, хүүхдийн биеэ үнэлэх явдал 311 байгаа бол</li> <li>- хүнд гэмт хэргийн хувьд хүүхэд хулгайлах гэмт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цахим мөрдлөгийн эсрэг хууль</li> </ul> <p><i>Эх сурвалж:</i>  <a href="https://www8.cao.go.jp/youth/kankyou/index.html">https://www8.cao.go.jp/youth/kankyou/index.html</a></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүгийн хууль</li> </ul> <p><i>Эх сурвалж:</i>  <a href="http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&amp;v m=2&amp;id=1960">http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&amp;v m=2&amp;id=1960</a></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн биеэ үнэлэх, хүүхдийн порно үйлдэлд хариуцлага ногдуулах болон</li> </ul>	<p>Цахим орчин дахь хүүхэд, залуучуудыг хамгаалах асуудлыг</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дотоод хэргийн яам, Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан технологийн яам,</li> <li>- холбогдох агентлагууд тус тус хариуцдаг.</li> <li>- Үндэсний цагдаагийн газар бусад төрийн болон хувийн байгууллагууд хамтран ажилладаг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цахим үйлчилгээ үзүүлэгчид нь хүүхэд, залуучуудад интернэтийн аюулгүй хэрэглээний талаар мэдлэг олгох, сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулдаг.</li> <li>- Цахим төхөөрөмж үйлдвэрлэгч болон хэрэглэгчдэд цахим хортой мэдээллээс хамгаалах шүүлтүүр бүхий технологийг нэвтрүүлэхийг үүрэг болгосон.</li> <li>- Цахим хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдлэг</li> </ul>

		хэрэг өссөн үзүүлэлттэй гарчээ.	хүүхдийг хамгаалах тухай хууль <i>Эх сурвалж:</i> <a href="http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&amp;id=2895&amp;re=02&amp;vm=02">http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&amp;id=2895&amp;re=02&amp;vm=02</a>		олгох хөтөлбөр, гарын авлага боловсруулан түгээх, сургалт зохион байгуулах арга хэмжээ авдаг.
3	АНУ	<p>2020 онд Интернэт гэмт хэргийн талаар гомдол хүлээн авах төвд дараах төрлийн гэмт хэргүүд бүртгэгдсэн байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хуурамч цахим шуудан ашиглан аюулгүй байдлын мэдээлэл, хувийн мэдээлэл авах (phishing)</li> <li>- Захиалгын төлбөр болон хүргэлт хийгдэхгүй байх</li> <li>- Сүрдүүлж мөнгө авах</li> <li>- Хувийн мэдээлэл хулгайлж авах</li> <li>- Хуурамч нэр, хаяг ашиглан хүнтэй харицах</li> <li>- Хуурамч баримт материал ашиглан бусдыг хууран мэхлэх</li> <li>- Бусдын итгэлийг хүлээснээр залилах, мэхлэх</li> <li>- Айлган сүрдүүлэх, заналхийлэх</li> <li>- Хуурамч цахим шуудангийн хаягнаас бусадтай харилцах</li> <li>- Бусдын төлбөрийн карт ашиглан төлбөр төлөх.</li> </ul> <p>Алга болсон болон бэлгийн мөлжлөгийн золиос болсон хүүхдүүдийг эрэн хайх,</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Цахим ертөнцөд хүүхдийн нууцыг хамгаалах тухай хууль <i>Эх сурвалж:</i> <a href="https://www.ftc.gov/news-events/media-resources/protecting-consumer-privacy-security/kids-privacy-copra">https://www.ftc.gov/news-events/media-resources/protecting-consumer-privacy-security/kids-privacy-copra</a></li> <li>- <a href="https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-91">https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-91</a></li> <li>- Интернэт орчинд хүүхдийг хамгаалах тухай хууль <i>Эх сурвалж:</i> <a href="https://www.fcc.gov/consumers/guides/childrens-internet-protection-act">https://www.fcc.gov/consumers/guides/childrens-internet-protection-act</a></li> <li>- Домэйн нэр үнэн зөв байх тухай хууль <i>Эх сурвалж:</i> <a href="https://www.congress.gov/bill/108th-congress/senate-bill/800/text">https://www.congress.gov/bill/108th-congress/senate-bill/800/text</a></li> <li>- Хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын тухай хууль <i>Эх сурвалж:</i> <a href="https://www.law.cornell.edu/uscode/text/34/subtitle-II/chapter-209">https://www.law.cornell.edu/uscode/text/34/subtitle-II/chapter-209</a></li> <li>- 21-р зуунд хүүхдийг хамгаалах тухай хууль <i>Эх сурвалж:</i></li> </ul>	Цахим гэмт хэргээс хүүхэд залуусыг урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх асуудлыг: - АНУ-ын Хууль зүйн яам, Боловсролын яам - Яамдын харьяа агентлагууд, олон нийтийн болон сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд хариуцан, хамтран ажилладаг байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Холбооны Худалдааны Комисс нь Хүүхдийн аюулгүй интернэт хэрэглээг дэмжих хөтөлбөр боловсруулан улс орон даяар хэрэгжүүлдэг.</li> <li>- Цахимаар үйлчилгээ эрхлэгчид нь хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, садар самуун үйлдэлд ашигласан материалын талаар хууль сахиулагч байгууллагад нэн даруй мэдэгдэж ажилладаг.</li> <li>- Хууль зүйн яамны Хүүхдийг садар самуун, бэлгийн мөлжлөгөөс хамгаалах албаны Дэвшилтэт технологи ашиглан мөрдөн шалгах нэгж нь 2006 оноос орон даяар Аюулгүй хүүхэд нас хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.</li> <li>- Сургууль, номын сангууд нь компьютертаа зохисгүй материалыг шүүх программыг суулгах шаардлагатай зэрэг олон тооны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг.</li> </ul>

		<p>хамгаалах төвийн Цахим гэмт хэргийн мэдээллийн сүлжээ (CyberTipline) нь 2020 оны байдлаар цахимаар үйлчилгээ эрхлэгчдээс хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, садар самуун үйлдэлд ашигласан материалын талаарх 21.7 сая мэдээлэл хүлээн авсан байна.<sup>163</sup></p>	<p><a href="https://www.ftc.gov/enforcement/statutes/protecting-children-21st-century-act">https://www.ftc.gov/enforcement/statutes/protecting-children-21st-century-act</a>  <a href="https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-91A">https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-91A</a></p> <ul style="list-style-type: none"> <li>- Цахим гэмт хэргийн мэдээллийн шинэчлэлийн тухай хууль</li> </ul> <p><i>Эх сурвалж:</i>  <a href="https://uscode.house.gov/view.xhtml?req=granuleid:USC-prelim-title18-section2258A&amp;num=0&amp;edition=prelim">https://uscode.house.gov/view.xhtml?req=granuleid:USC-prelim-title18-section2258A&amp;num=0&amp;edition=prelim</a></p>		
4	ИБУИН ХУ	<p>Цахимаар хамгийн их үйлдэгдэж буй гэмт хэргийн төрлүүдэд дараах хэргүүд ордог байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн сүлжээ болон цахим шуудангийн нууц үг ашиглан хакердах</li> <li>- Хуурамч цахим шуудан ашиглан аюулгүй байдлын мэдээлэл, хувийн мэдээлэл авах (phishing)</li> <li>- Хортой програм хангамж-гэмт хэрэгтнүүд файлуудыг хулгайлж компьютерийн систем болон сүлжээнд халдах (malicious software)</li> <li>- Мөнгө хулгайлах зорилгоор цахим хуудас руу халдах ингэхдээ тухайн цахим хуудасны</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Компьютерийн зүй бус хэрэглээний тухай хууль</li> </ul> <p><i>Эх сурвалж:</i>  <a href="https://www.legislation.gov.uk/ukpga/1990/18/contents">https://www.legislation.gov.uk/ukpga/1990/18/contents</a></p> <ul style="list-style-type: none"> <li>- Айлган сүрдүүлэхээс хамгаалах тухай хууль</li> </ul> <p><i>Эх сурвалж:</i>  <a href="https://www.legislation.gov.uk/ukpga/1997/40/contents">https://www.legislation.gov.uk/ukpga/1997/40/contents</a></p> <ul style="list-style-type: none"> <li>- Гэмт хэрэгтэнд хариуцлага тооцох ба нийтийн хэв журмыг сахиулах тухай хууль</li> </ul> <p><i>Эх сурвалж:</i>  <a href="https://www.legislation.gov.uk/ukpga/1994/33/contents">https://www.legislation.gov.uk/ukpga/1994/33/contents</a></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тэгш эрхийн тухай хууль</li> </ul> <p><i>Эх сурвалж:</i>  <a href="https://www.gov.uk/bullying-at-school">https://www.gov.uk/bullying-at-school</a></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хор нөлөөтэй харилцаа</li> </ul>	<p>Цахим гэмт хэргээс хүүхэд залуусыг урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх асуудлыг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хууль зүйн яам, Боловсролын яам</li> <li>- Яамдын харьяа агентлагууд, тухайлбал, Хууль зүйн яамны харьяа Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх Агентлаг</li> <li>- Цагдаагийн газар, бүсийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх нэгжүүд, олон улсын хууль сахиулах байгууллагууд, сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийн болон сайн дурын байгууллагууд хариуцан, хамтран</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх агентлаг нь цахим орчинд гэмт хэрэг үйлдэгч өсвөр насныхан болон залуучуудыг цахим хэрэгтэн болохоос сэргийлж Цахим сонголт (CyberChoices) аянг зохион байгуулдаг.</li> <li>- Сургуулийн удирдлагууд сургууль, сургалтын байгууллагын эргэн тойронд суралцагч хүүхдүүд болон багш сурган хүмүүжүүлэгчдэд эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж ажилладаг.</li> <li>- Их Британийн Хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах зөвлөл (UK Council for Child Internet Safety) нь хүүхэд, залуусын цахим орчны аюулгүй байдлыг хангах олон төрдлийн үйл ажиллагаагаа явуулдаг.</li> </ul>

<sup>163</sup> <https://www.missingkids.org/footer/media/keyfacts>  
<https://www.missingkids.org/content/dam/missingkids/gethelp/2019-reports-by-esp.pdf>

	<p>сүлжээ болон серверийг хэт их ачааллах замаар үйлдэх (Distributed denial of service).</p>	<p>холбооны тухай хууль  Эх сурвалж:  <a href="https://www.legislation.gov.uk/ukpga/1988/27">https://www.legislation.gov.uk/ukpga/1988/27</a>  - Харилцаа холбооны тухай хууль  Эх сурвалж:  <a href="https://www.legislation.gov.uk/ukpga/2003/21/contents">https://www.legislation.gov.uk/ukpga/2003/21/contents</a>  - Боловсрол болон хяналт шалгалтын тухай хууль  Эх сурвалж  <a href="https://www.legislation.gov.uk/ukpga/2006/40/contents">https://www.legislation.gov.uk/ukpga/2006/40/contents</a>  - Дижитал Эдийн засгийн тухай хууль  Эх сурвалж:  <a href="https://www.legislation.gov.uk/ukpga/2017/30/section/103/enacted">https://www.legislation.gov.uk/ukpga/2017/30/section/103/enacted</a></p>	<p>ажилладаг.</p>	
--	--	--	-------------------	--



## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### 1. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭЛБЭР, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Цахим хүчирхийлэл (cyberbullying) гэдэг<sup>164</sup> нь хэн нэгэн цахим технологийг ашиглан бусад хүнийг дарамтлах, заналхийлэх, ичээх, эсвэл түрэмгийлэх явдал юм. Энэ нь гар утас, компьютер, таблет, тоглоомын систем гэх мэт төхөөрөмж ашиглан үйлдэгддэг. Цахим хүчирхийлэл нь хүний эрхийг зөрчиж байгаа бөгөөд зарим тохиолдолд хуулийг ноцтой зөрчсөн үйлдэл болж байна. Сүүлийн үед цахим хүчирхийлэл нь өсвөр насныхан дунд улам их газар авч байгаа хэдий ч насанд хүрсэн хүн өртөх явдал цөөнгүй байна.<sup>165</sup>

#### Цахим орчин дахь хүчирхийллийн хэлбэр

Цахим хүчирхийллийн хэлбэрийг Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооноос дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:<sup>166</sup>

1. Хэн нэгэн рүү эелдэг бус доромжилсон эсвэл сүрдүүлсэн и-мэйл, чат, текст, мессеж илгээх;
2. Хэн нэгний цахим хаяг, бүртгэлд зөвшөөрөлгүй халдах, ашиглах ;
3. Бусдын хувийн зураг, мэдээллийг хуулбарлан байршуулж, эвлүүлэг хийх, бичлэг хийх замаар бусдыг гүтгэх доромжлох;
4. Онлайн тоглоом тоглохдоо хэн нэгэнтэй бүдүүлэг, эелдэг бус харьцах;
5. Бусдын хувийн тааламжгүй зургийг цахим орчинд байршуулах, бусдад илгээх, хуваалцах;
6. Хэн нэгнийг элэглэн дуурайсан, хуурч мэхэлсэн нийгмийн сүлжээний хуурамч хаяг үүсгэх, ашиглах;
7. Хэн нэгнийг анги сургууль, олон нийтийн нийгмийн сүлжээний групп, онлайн харилцаанд ямар нэг шалтгаангүйгээр оролцуулахгүй байх, блок хийх... зэрэг байна.

Цахим хүчирхийллийн золиос нь насанд хүрээгүй хүн буюу хүүхдүүд болох нь элбэг бөгөөд Монгол Улсын нийт хүн амын 37.6 хувийг 0-18 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Мөн манай улсын нийт хүн амын 80.6 хувь нь интернэт хэрэгч<sup>167</sup>, түүний дотор ухаалаг утастай хүүхдүүдийн 95 хувь нь интернэт хэрэглэдэг, мөн тэдний 92 хувь нь фэйсбүүк хаягтай байгаа<sup>168</sup> нь цахим орчин болон нийгмийн сүлжээнд агуулгын эрсдэл, харилцааны эрсдэл, үйлдлийн эрсдэл гарч болохоор байна.

#### Хууль эрх зүйн орчин

##### **Монгол Улсын Үндсэн хууль:**

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11-т "...хүүхдийн ашиг сонирхолыг төр хамгаална"<sup>169</sup> гэж заасан. Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасан.

<sup>164</sup> <https://kidshealth.org/en/parents/cyberbullying.html>

<sup>165</sup> <https://www.verywellfamily.com/types-of-cyberbullying-460549>

<sup>166</sup> Цахим орчин хүүхэд хамгаалал сэдэвт хэвлэмэл фостерын сан, Харилцаа холбооны зохицуулах хороо [http://ekids.mn/Home/newsdetail?dataID=22012&fbclid=IwAR2YroLWF0HURKca5LdAYWTQH5Fr5kGOy5JwOxQICEOer\\_x\\_7CNkqt\\_QixY](http://ekids.mn/Home/newsdetail?dataID=22012&fbclid=IwAR2YroLWF0HURKca5LdAYWTQH5Fr5kGOy5JwOxQICEOer_x_7CNkqt_QixY)

<sup>167</sup> Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар <https://dashboard.cita.gov.mn/>

<sup>168</sup> "Өсвөр үе ба цахим хэрэглээ" судалгаа, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, 2018 он <https://bit.ly/2RIBGNE>

<sup>169</sup> Монгол Улсын Үндсэн хууль, 1992.01.13 <https://www.legalinfo.mn/law/details/367>

## **Хүүхдийн хүчирхийллийн талаарх Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын баримт бичиг:**

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал;<sup>170</sup>
- Хүүхдийн эрхийн тухай конвенц;<sup>171</sup>
- Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц;<sup>172</sup>
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц<sup>173</sup>;
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт<sup>174</sup> ... зэрэг баримт бичгүүдэд хүүхдийн аливаа төрлийн (цахим) хүчирхийллээс сэргийлэх, эрхийг нь хамгаалах талаар авч үзсэн байна.

## **Монгол Улсын хуулиуд:**

- Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн 16.8-д: “Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах”<sup>175</sup> Мөн хуулийн 16.9-д: “Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах” энэхүү гэмт хэргийг цахим сүлжээ ашиглаж хийсэн бол хүндрүүлэх нөхцөл болгохоор хуульчилсан
- Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйл “Хүүхдийн эрхийг зөрчих”<sup>176</sup> асуудлыг зохицуулсан байна. Тухайлбал, 6.20 дугаар зүйлийн 3.1-д: “Хүүхдийг өөрийнх нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр мэдээлэл сурталчилгаанд ашиглах”-ыг хориглосон. Уг зөрчлийн хүүхдийн эрхийн улсын байцаагч шалгаж шийдвэрлэнэ.
- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйл “Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал”<sup>177</sup> асуудлыг зохицуулсан. Энэ нь эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаалахаар заасан.
- Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлд “Хүүхдийн хамгаалуулах эрх”<sup>178</sup>-ийн талаар дурдаж, 7.1-т “Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй.” гэж заасан.

<sup>170</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946.12.10 <https://www.legalinfo.mn/law/details/1271>

<sup>171</sup> 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон. <https://www.legalinfo.mn/law/details/1276>

<sup>172</sup> 1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталж, 1995 оны 5 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон. <https://www.legalinfo.mn/law/details/1273>

<sup>173</sup> 1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталж, 2000 оны 11 дүгээр сарын 19-нд хүчин төгөлдөр болсон. <https://www.legalinfo.mn/annex/details/6?lawid=307>

<sup>174</sup> 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-нд хүчин төгөлдөр болсон. <https://www.legalinfo.mn/law/details/1257>

<sup>175</sup> Эрүүгийн хууль, 2015.12.03 <https://www.legalinfo.mn/law/details/11634>

<sup>176</sup> Зөрчлийн тухай хууль, 2017.05.11 <https://www.legalinfo.mn/law/details/12695>

<sup>177</sup> Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016.02.05 <https://www.legalinfo.mn/law/details/11710>

<sup>178</sup> Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016.02.05 <https://www.legalinfo.mn/law/details/11709>

- Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд “Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журам”<sup>179</sup> ыг тодорхойлж, 7.2.3-т “18 насанд хүрээгүй хүнээр худалдуулах, 18 насанд хүрээгүй хүнд худалдах”-ыг хоригложээ.
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд “Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх”<sup>180</sup>-ийг тодорхойлж 5.11-т “Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүн худалдаалахад өртөх эрсдэлтэй хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж, сургалт, судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийн улсын хэмжээнд цаашид авах арга хэмжээний санал боловсруулна.” гэж тусгасан.
- Зар сурталчилгааны тухай хуулийн 16 дугаар зүйлд “Зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд хүүхдийг эрхийг хамгаалах”<sup>181</sup> зүйлийг оруулж 8 заалтаар хориглож хүүхдийн эрх зөрчигдөхөөс хамгаалсан байна.
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28, 31 дүгээр зүйлүүдэд<sup>182</sup> гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар нутгийн захиргааны байгууллага болон иргэний эрх, үүрэгт хүүхдийн эрхийг хамгаалах заалтууд тус тус орсон байна.

### **УИХ-ын тогтоол:**

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлийн 3.4-т “Хүний аюулгүй байдал”<sup>183</sup>-ийг тодорхойлж, ... “Хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдийг хүн худалдах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгож энэ чиглэлд бэхжүүлнэ.” гэж заажээ. Мөн 3.6-т Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндсийг “Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж зааж өгсөн нь цахим орчин дахь хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах байдал давхар заагдсан гэж үзэхээр байна.

### **ЗГ-ын тогтоол:**

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 276 дугаар тогтоолоор хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллага, алба, нэгжид “Сургалтын орчинд авах арга хэмжээ”<sup>184</sup> батлагдаж, үүнд: “Сургууль, цэцэрлэгийн орчинд хичээл, сургалтын үеэр сурагч, хүүхдүүдэд ухаалаг гар утас, түүнтэй адилтгах төхөөрөмж ашиглахыг 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хязгаарлаж”, ... “хүүхэд залуучуудын дунд ухаалаг утас болон цахим сүлжээний ёс зүйтэй хэрэглээг хэвшүүлэх хүрээнд хүүхэд, залуучуудад ээлтэй бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, цахим хүчирхийлэл, халдлагаас урьдчилан сэргийлэх” арга хэмжээг тус тус авсан.

<sup>179</sup> Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, 1998.01.22 <https://www.legalinfo.mn/law/details/445>

<sup>180</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012.01.19 <https://www.legalinfo.mn/law/details/554?lawid=554>

<sup>181</sup> Зар сурталчилгааны тухай хууль 2002.05.30 <https://www.legalinfo.mn/law/details/259>

<sup>182</sup> Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019.06.06 <https://www.legalinfo.mn/law/details/14700>

<sup>183</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол <https://www.legalinfo.mn/annex/details/8070?lawid=6163>

<sup>184</sup> МУ-ын ЗГ-ын тогтоол, Сургалтын орчинд авах арга хэмжээний тухай, 2018.09.05 <https://www.legalinfo.mn/law/details/13638>

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/68 дугаар тушаалаар батлагдсан “Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл”<sup>185</sup>-д цахим орчинд хүүхдийг эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөхүйц мэдээ мэдээлэл, агуулга, харилцаанаас шалтгаалсан эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилготой. Мөн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлийг багтаасан байна.

## 2. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Цахим орчин дахь хүүхдийн хүчирхийллийн талаарх тоо баримтыг...

1. цагдаад бүртгэгдсэн гэмт хэрэг зөрчлийн мэдээ;<sup>186</sup>
2. шүүхээр шийдвэрлэгдсэн шүүн таслах ажлын мэдээ;<sup>187</sup>
3. гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын харьяа 108 төв (утас) болон түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн статистик тоон мэдээ...

зэргээс шүүж үзэхэд цахим хүчирхийлэл нь цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт<sup>188</sup> хамаарч байгаа бөгөөд хэрэг бүртгэлд хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээллийг ялгаж бүртгэдэггүй учир хүүхдийн хүчирхийллийн гэмт хэргийг ялгаж харах боломжгүй байна. Үүнийг илүү нарийвчлан эмпирик судалгаа хийж, тодруулах шаардлагатай.

Цагдаагийн ерөнхий газарт бүртгэгдсэн цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо жил бүр нэмэгдэж, 2019 онд 57, 2020 онд 146 болж 2.6 дахин өссөн байна. Мөн хүүхдийн 108 утсанд 2020 онд цахим донтолт 160, цахим дарамт 166 бүртгэгдсэн бол 2021 оны 5 дугаар сарын байдлаар цахим донтолт 91, цахим дарамтын талаар 52 дуудлага ирсэн байна.

### “Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал” социологийн судалгаа

Уг судалгааг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2018 онд гүйцэтгэсэн бөгөөд 21 аймаг болон Нийслэлийн 9 дүүргээс нийт 30 сургуулийг сонгон хамруулсан. Түүвэрлэлтийн нэгжийг сургуулиар сонгон авсан бөгөөд нэгж сургуулиас 11-17 насны сурагчдын тоог хамгийн багадаа 70 байхаар тооцоолон, сурагчдын нэрсийн жагсаалтаас тохиромжит түүврийн аргаар сонгон асуулга судалгаанд хамруулсан. Судалгаанд 11-17 насны 2240 хүүхэд, 378 эцэг эх болон ЕБС-ийн 402 багш, нийгмийн ажилтан нийт 3019 хүнийг хамруулсан байна. Судалгааны голлох үр дүнг танилцуулбал:<sup>189</sup>

#### Сурагчдаас авсан судалгааны үр дүн

- Судалгаагаар өсвөр насны хүүхдүүдийн интернэтийн хэрэглээ маш өндөр байгаа харагдлаа. Тэдний нас ахих тусам цахим хэрэглээний түвшин нэмэгдэж байв.

<sup>185</sup> ХХМТГ-ын даргын тушаал, Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл, 2020.05.15 <https://bit.ly/3ocbKQM>

<sup>186</sup> Цагдаагийн байгууллагад 2021 оны эхний 3 сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, Цагдаагийн ерөнхий газар, мэдээлэл дүн шинжилгээ шуурхай удирдлагын алба, 2021.04.05

<sup>187</sup> Монгол Улсын шүүхийн 2020 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ, Шүүхийн ерөнхий зөвлөл, 2021 он <http://www.judoinstitute.mn/main/252--2020-.html>

<sup>188</sup> Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэг <https://www.legalinfo.mn/law/details/11634>

<sup>189</sup> Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгаа, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, 2018 он <https://bit.ly/3hpHpgk>

- Сурагчдын дийлэнх буюу 85 орчим хувь нь ухаалаг утас хэрэглэдэг, тэдний 92 хувь нь нүүр номын хаягтай байв. Эндээс үзэхэд ухаалаг утас авах нь тийм ч хүндрэлтэй асуудал биш гэдэг нь харагдаж байна.
- 70 гаруй хувь нь өдөрт 1-2 цагийг цахим орчинд өнгөрүүлдэг ба тэдэнд ихэнх тохиолдолд аливаа асуудал тулгарахад хамгийн дотны туслагч нь найз нөхөд, үе тэнгийнхэн байдаг байна.
- Гурван хүүхэд тутмын нэг нь цахим орчны хувийн нууц мэдээллээ хадгалах тохиргоог огт мэддэггүй бөгөөд эцэг, эхчүүдийн энэ талын мэдлэг нь хүүхдээсээ муу байв.
- Хоёр хүүхэд тутмын нэг нь садар самууныг сурталчилсан мэдээлэлтэй тогтмол тааралддаг, таван хүүхэд тутмын дөрөв нь цахимаар зүй бус утгатай зурвас авдаг ба эцэг эхчүүдийн ийм төрлийн сөрөг мэдээллийг шүүх програм хангамжийг ашиглах чадвар 95 хувьд нь огт байхгүй байна.
- Интернэтийн байгууллага хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа насанд хүрээгүй хүн байгаа эсэхийг 84 гаруй хувь нь асуугаагүй байна. Интернэтийн компаниуд бага насны хүүхэдтэй айлд сөрөг мэдээллийг шүүгч програмыг заавал суулгуулах шаардлагатайг мэдээлэх үүргээ биелүүлэхгүй, нийгмийн хариуцлагаа ухамсарлахгүй байна.
- Гурван хүүхэд тутмын нэгнийх нь гар утасны дугаар өөр хүний нэр дээр бүртгэлтэй байна. Гар утасны дугаарыг хүүхдийн нэр дээр бүрэн бүртгэлжүүлснээр хориглосон буюу сөрөг нөлөө бүхий мэдээлэл хүлээн авахаас урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой гэж үзэж байна.

#### **Багш нараас авсан судалгааны үр дүн**

- Хоёр сурагч тутмын нэг нь багшаасаа цахим орчны зохисгүй хэрэглээний талаарх зөвлөгөөг байнга болон заримдаа авдаг хэдий ч ЕБС-ийн гурван багш тутмын нэг нь сурагчдад энэ талын зөвлөгөө өгөхөд бэлэн биш гэж өөрийгөө дүгнэсэн байв.
- Багш нар цахим орчны шүүлтүүрийн програм хангамжийг 97 хувь нь огт ашигладаггүй байна.
- ЕБС-д өсвөр насны хүүхдүүдэд цахим орчны аливаа эрсдэлийг таниулах, урьдчилан сэргийлэх талаар хичээл явуулах арга зүйн болон сургалтын материал дийлэнхэд нь байхгүй байна. Иймээс цаашид сурагчдад цахим орчны зөв хэрэглээ, аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох багш бэлтгэх шаардлагатай гэж 80 орчим хувь нь үзсэн байна.

#### **Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаарх судалгаа<sup>190</sup>**

Уг судалгааг Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2021 онд хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгааны тайланг хавсралт хэсэг бүтнээр оруулав.

### **3.ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ**

#### **Кибер гэмт хэргийн тухай конвенц**

Нийгмийн сүлжээ (social network) нь өөрөө цахим буюу кибер орчинд үйлдэгддэг байна. Ийм нөхцөлд кибер аюулгүй байдлыг хангах асуудлаарх олон талт хамтын ажиллагаанд

<sup>190</sup> Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаарх судалгаа, Харилцаа холбооны зохицуулах хороо, 2021 он <https://www.crc.gov.mn/w/389>



Монгол Улс идэвхтэй оролцох шаардлагатай болж байна. Кибер аюулгүй байдлын олон талт хамтын ажиллагааны эрх зүйн үндэс нь Кибер гэмт хэргийн тухай Будапештийн конвенц<sup>191</sup> юм.

Тус конвенцийн наймдугаар зүйлд Хүүхдийн порнографтай холбоотой гэмт хэрэг буюу хүүхдийн эрхийн талаар зохицуулж, процессын хууль, шүүх эрх мэдлийн талаар болон олон улсын хамтын ажиллагааны талаар дурджээ.

Монгол Улс Кибер гэмт хэргийн тухай конвенцийн оролцогч болохын тулд түүний оролцогч 45 улсаас дэмжлэг авах шаардлагатай юм. Монгол Улс Ази, номхон далайн бүсийн орнуудын “Кибер аюулгүй байдлын 5 дугаар форум”-ын 2014 оны 5 дугаар сард, “Онлайн эрх чөлөө” эвслийн сайд нарын 5 дугаар бага хурлыг 2015 оны 5 дугаар сард тус тус Улаанбаатар хотноо зохион байгуулсан нь Монгол Улс олон улсын өмнө кибер гэмт хэрэгтэй тэмцэх, кибер аюулгүй байдлыг хангах бодит хүсэл эрмэлзэл байгааг илтгэх төдийгүй Кибер гэмт хэргийн тухай конвенцод нэгдэн орох шаардлагад эерэг үзүүлэлт болж байна.<sup>192</sup>

Харин Монгол Улсын хоёр хөрш болон ОХУ болон БНХАУ нь дээрх конвенцийн оролцогч хараахан болоогүй байна.

### **“Цахим орчин дахь хүүхдийн хамгаалалт 2020” бодлого боловсруулагчдад өгөх удирдамж**

Улс орнууд “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (SDG)-д тусгагдсан зорилтуудын дагуу хүүхдийн төлөө хийх ажил, зорилтуудаа шинэчлэн баталж байна. Тухайлбал, зорилт 16.2-т 2030 он гэхэд хүүхдийн эсрэг аливаа төрлийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, эрүүдэн шүүх явдлыг таслан зогсоохыг тусгасан байна.<sup>193</sup>

Үүнтэй холбоотойгоор НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF), Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага (ITU) болон Цахим орчинд хүүхдийг хамгаалах санаачилгатай хамтран “Цахим орчинд хүүхдийг хамгаалах тухай бодлого боловсруулагчдад хандах удирдамж”<sup>194</sup>-ийг шинэчлэн гаргасан байна.

Удирдамж нь хүүхдийг нийгмийн болон цахим орчинд хоёуланд нь хамгаалах үүргээ ухамсарлаж, хэрэгжүүлэх тогтолцоог бодлого боловсруулагч болон засгийн газарт санал болгосон байна. Мөн цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг устгах зорилготой “Бид Хамгаална” (WeProtect) загварыг хэрэгжүүлэхээр дэлхий улс орнуудын бодлого боловсруулагч болон засгийн газруудад зөвлөсөн байна.

Монгол Улсын хувьд удирдамжид заасан (WeProtect) загварыг хэрэгжүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхараар ахлуулсан Цахим орчин дахь

<sup>191</sup>Кибер гэмт хэргийн тухай конвенц, 2001.11.23 <https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/rms/0900001680081561>

<sup>192</sup> Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь, Л.Галбаатар, 2015 он, 36-р хуудас

<sup>193</sup> Цахим орчин дахь хүүхдийн хамгаалалт 2020” бодлого боловсруулагчдад өгөх удирдамж, Guidelines for policy-makers on Child Online Protection 2020, [https://www.itu.int/en/ITU-D/Cybersecurity/Documents/COP/Guidelines/2020-translations/S-GEN-COP.POL\\_MAKERS-2020-PDF-E.pdf](https://www.itu.int/en/ITU-D/Cybersecurity/Documents/COP/Guidelines/2020-translations/S-GEN-COP.POL_MAKERS-2020-PDF-E.pdf)

<sup>194</sup> Цахим орчин дахь хүүхдийн хамгаалалт 2020” бодлого боловсруулагчдад өгөх удирдамж, Guidelines for policy-makers on Child Online Protection 2020, [https://www.itu.int/en/ITU-D/Cybersecurity/Documents/COP/Guidelines/2020-translations/S-GEN-COP.POL\\_MAKERS-2020-PDF-E.pdf](https://www.itu.int/en/ITU-D/Cybersecurity/Documents/COP/Guidelines/2020-translations/S-GEN-COP.POL_MAKERS-2020-PDF-E.pdf)



хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх салбар дундын ажлын хэсэг<sup>195</sup> гарган ажиллаж байна.

### **Цахим орчин дахь Хүний эрхийн түгээмэл тунхаглал**

Урьд дурдсанаар 1948 онд НҮБ-ын Ерөнхий ассамблей Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан. Тэгвэл өнөөдөр хүний эрхийг дэлхийн улс орнуудын хил хязгаарыг үгүй болгон, улам бүр даяаршуулж байгаа цахим ертөнцөд зохицуулах, тунхаглах шаардлага урган гарч байна. Дэлхийн улс орнууд энэ асуудалд хамтдаа анхаарал хандуулж, бодлогын баримт бичгүүдийг боловсруулж байна. Энэхүү тунхаглалын цахим орчин дахь хувилбар(төсөл)<sup>196</sup>-ыг Роберт Б.Геман хэмээх судлаач боловсруулжээ.

1. Хүн бүр хүний өөрийн санаа бодол, илэрхийллийг шууд ба шууд бусаар илэрхийлэх, түгээх, бусадтай хуваалцах зохих ёсны, тэгш боломжоор хангагдсан байна.
2. Хүн бүр энэхүү тунхаглалд заасан бүх эрх, эрх чөлөөг үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, хэл соёл, шашин шүтлэг, үзэл бодол, нийгмийн гарал үүсэл, хөрөнгө чинээ, нийгмийн байдал зэрэг дурын ялгаваргүйгээр тэгш эдэлнэ.
3. Хүн бүр өөрийн хувийн цахим орон зай, нэртэй байж нэр, онлайн хэлцлээ нууцлан хамгаалах эрхтэй.
4. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, вэб сайтаас хүний хувийн мэдээллийг албадан гаргаж өгөхийг шаардаж болохгүй. Шаардлагатай үед зохих зөвшөөрлийн үндсэн дээр мэдээллийг гаргаж өгч болно.
5. Хэн ч урьдчилсан зөвшөөрөл авалгүйгээр сайн дураар нийтэд хандсан их хэмжээний цахим шуудан, сервер компьютерт ачаалал үүсгэх хавсралт файл, хөнөөлт программ хангамжуудыг илгээх эрхгүй.
6. Хүн бүр интернэтээс мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Гагцхүү энэхүү эрхээ эдлэхдээ тухайн харилцаанд тогтоосон зан үйлийн хэм хэмжээг даган мөрдөнө.
7. Цахим ба бодит орон зайд цөөнхийн болон хэрэглэгчийг тусгайлан хамгаална. Газарзүйн харьяаллын гэрээ ёсоор ял оногдуулах тохиолдолд оршин байгаа газрын эрх зүйн тогтолцооноос үл хамааран хувь хүний суурь эрхийг хүндэтгэнэ.
8. Хүн бүр өөрийнх нь эрх, эрх чөлөө зөрчигдөх, хувийн мэдээллээ хортойгоор ашиглуулахын эсрэг хууль зүйн хамгаалалтад байх эрхтэй.
9. Агуулга, онлайн харилцаатай холбогдуулан хэнийг ч дур зоргоор хянаж, шалгахыг хориглоно.
10. Хүн бүр эрх, үүргээ тодорхойлуулах, түүний эсрэг ял тулгасан тохиолдолд ялын үндэслэлийг тогтоолгохоор хараат бус, шударга шүүхээр хууль ёсны, нээлттэй дэгээр шүүлгэх бүрэн эрхтэй.
11. Хүн бүр төрийн байгууллага, интернэтийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан хуулиар тусгайлан нууцалснаас бусад мэдээлэлд хандах эрхтэй.
12. Хүн бүр өөрийн харилцаа холбоо, хэлцлээ хамгаалах технологийг сонгох эрхтэй ба энэ эрхийг хэрэгжүүлэхэд нь технологид харшлахыг хориглоно.
13. Хүн бүр өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрх нь итгэл үнэмшил, сүсэг бишрэлээ төрөл бүрийн зан үйлээр илэрхийлэх эрхийг мөн

<sup>195</sup> Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах салбар дундын ажлын хэсэг хуралдаж байна. <https://mlsp.gov.mn/content/detail/805>

<sup>196</sup> Цахим орчин дахь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, <http://www.be-in.com/10/rightsdec.html>

- агуулна. Хэний ч үзэл бодлоо илэрхийлсэн зан үйлийн хэлбэрт нь ял, зэмлэл хүлээлгэхийг хориглоно.
14. Хүн бүр интернэтийн үйлчилгээ үзүүлэгчийг чөлөөтэй сонгох, түүнийгээ солих эрхтэй. Мөн үйлчилгээний төлбөртэй холбоотойгоор байрлал үл харгалзан “үнэгүй”, “нийтийн” үйлчилгээг сонгох эрхтэй.
  15. Хэний ч хандалтын эрх буюу цахим шуудангийн бүртгэлийг үйлчилгээний гэнэтийн өөрчлөлт зэрэг зохисгүй шалтгаан, дур зоргоор хаах, устгахыг хориглоно.
  16. Хүн бүр өөртэйгөө онлайнаар холбогдох этгээдээ чөлөөтэй сонгох эрхтэй. Хэнийг ч тодорхой бүлэгт хамруулах, вэб сайтад зочлуулахаар албадахыг хориглоно.
  17. Хэн бүхний хувийн мэдээлэл, онлайн үйл ажиллагаа нь хувийн өмч бөгөөд түүнийг тухайн этгээ өөрөө хянана. Хүн бүр энэхүү өмчөө үнэлэх, ил тод болгох, бусадтай солилцох эсэхээ өөрөө шийдэх эрхтэй.
  18. Хүн бүр ашиг сонирхол, үнэт зүйл, чиг үүргийг бүлгийг үүсгэх эрхтэй.
  19. Хүн бүр шинэ технологийг эзэмших эрхтэй. Төрийн байгууллагаас бүх нийтэд хэрэглээний програм хангамжууд ба онлайн харилцааны сургалтуудыг явуулах үүрэгтэй. Амьдралын хүнд нөхцөлд байгаа хүмүүс, өндөр настангууд болон хэрэгцээт хүмүүст зориулсан сургалт тусгай хөтөлбөрүүдийг авч үзнэ. Сургалт нь хувь хүнд чиглэсэн, тэдний өөрийгөө хүндлэх хүндлэлийг бэхжүүлж, бие даасан байдлыг дэмжихэд чиглэнэ.
  20. Эцэг, эхчүүд өөрийн үзэл бодлоор үр хүүхдийнхээ онлайн харилцааг удирдан чиглүүлэх эрх, үүрэгтэй. Энэ асуудлаар ямар ч байгууллага эцэг эхийн сонголтыг үгүйсгэх эрхгүй.
  21. Хүн бүр зохиогчийн эрхээр хамгаалагдах утга зохиол, урлагийн болон шинжлэх ухааны бүтээлээ бусадтай онлайнаар хуваалцах эрхтэй.
  22. Хүн бүр энэхүү тунхаглалд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн хувьдаа ашиг, орлоготой болох эрхтэй.
  23. Хүн бүр өөрийн зан үйл, илэрхийллээ хариуцах, өөрийн байр суурьтай байх эрхтэй.
  24. Энэхүү тунхаглалын зарчмуудыг аль нэг улс орон, бүлэглэл, бие хүний зүгээс энд тунхагласан эрх, эрх чөлөөг үгүйсгэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх, агуулгыг мушгин өөрчлөх, өөрчлөн хэрэглэхийг хориглоно.

#### **“Ковид-19” цар тахал ба цахим орчин дахь хүүхдийн хүчирхийлэл<sup>197</sup>**

“Ковид-19” өвчний улмаас дэлхий дахинд үүсээд буй нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн нийт оюутан, сурагчдын 99 хувь буюу 1.7 тэрбум хүүхдийн танхимын хичээл тасалдаад байна.<sup>198</sup> Хүүхдүүдийн хичээл, сургууль тасалдсантай холбоотой нийгэм, эдийн засгийн олон асуудал үүсч байгаа бөгөөд дэлхийн цөөнгүй улсад дижитал хэлбэрээр хичээлийг үргэлжлүүлж байна. Үүнээс шалтгаалан хүүхдүүдийн интернэт хэрэглээ нэмэгдэж, цахим орчинд өнгөрөөх хугацаа уртассан. Манай улсад ч ийм нөхцөл байдал үүссэн бөгөөд эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хүүхдийнхээ интернэт хэрэглээнд хяналт тавихад анхаарал хандуулах зүй ёсны шаардлага бий болоод байна.

<sup>197</sup> Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал, Монгол Улсын Тагнуулын ерөнхий газар, <https://gia.gov.mn/12/item/709>

<sup>198</sup> НҮБ-ын Хүүхдийн сангийн мэдээллийн төв, “Ковид-19 ба Хүүхдүүд” [https://data.unicef.org/covid-19-and-children/?utm\\_source=UNICEF%20Data&utm\\_medium=homepage&utm\\_campaign=COVID19-hub-unicef-data-hero-image](https://data.unicef.org/covid-19-and-children/?utm_source=UNICEF%20Data&utm_medium=homepage&utm_campaign=COVID19-hub-unicef-data-hero-image)


Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO)-ын судалгаагаар жил бүр 200 сая хүүхэд бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн золиос болдог байна. Үүний тодорхой хувь нь цахим орчинд үйлдэгдэж, жилээс жилд хувь хэмжээ нь нэмэгдэж байгаа бөгөөд интернэт орчин нь мөлжлөг, хүчирхийллийн талбар болж байна. Тийм учраас цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг бүхий л түвшинд авч үзэх шаардлагатай.

Цахим орчныг хүүхдэд аюулгүй болгох нь хүний үндсэн эрхтэй холбоотойгоос гадна шинэ үед цахим “хувьсал” хийх боломжийг олгоно. Аливаа улс, тэр дундаа хурдацтай хөгжиж буй улс орон цахим хувьсал хийснээр эдийн засгийн хөгжил эрчимтэй нэмэгддэг байна. Олон улсын харилцаа холбооны эвлэл (ОУХХЭ) /International Communication Union/-ийн хийсэн судалгаагаар тухайн улсын цахим орчны хэрэглээ 10 хувиар нэмэгдэхэд нэг хүнд ногдох ДНБ 1.3 хувиар өсдөг байна. Энэхүү өсөлт нийт хүн ам, тэр дундаа хүүхдүүд цахим технологийн олгож буй харилцаа холбооны хязгааргүй боломжийг хүртэх болсон үед илрэх бөгөөд ингэхийн тулд цахим орчин нь өөрөө аюулгүй байх ёстой гэж үзэж байна.

ОУХХЭ, ЮНЕСКО-ийн хийсэн судалгаанаас үзэхэд дэлхийн нийт хүн амын 50 гаруй хувь, үүний дотроо хүүхдүүдийн 30 гаруй хувь нь өдөр тутам интернэт ашигладаг аж. Тэдний үзсэнээр 2025 он гэхэд:

- Дэлхийн нийт хүн амын 70-аас багагүй хувь нь өдөр тутам интернэт ашиглаж,
- Нийт хүүхдийн 60 хувь нь дижитал хэрэглээний үндсэн мэдэгдэхүүн, чадвартай болж,
- Дэлхийн нийт хүн амын 40 хувь нь цахим санхүүгийн үйлчилгээ ашигладаг болох гэнэ.

*Зураг 1. Хүн амд 19 наснаас доош настай хүүхдийн эзлэх хувь*



Интернэт хэрэглэгчдийн хувьд хүүхдүүдийн хэрэглээ хамгийн хурдацтай нэмэгдэж байгаа бөгөөд ойрын жилүүдэд хөгжил буурай оронд ч хөдөлгөөнт интернэт тавигдаж, хэрэглээ улам нэмэгдэх нь гарцаагүй болж байна.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгод 2030 он гэхэд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй бүх төрлийн хүчирхийлэл, бие, эрхтний наймаа, бэлгийн мөлжлөг зэргийг үгүй хийх зорилго


тавьсан. Гэвч цахим орчинд хүүхэд бэлгийн мөлжлөгт өртөх болон бусад олон төрлийн дарамт, шахалттай тэмцэх ажилд тулгарч буй асуудлуудаас онцлох дараах асуудлууд байна.

- Зарим улс оронд цахим орчинд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн эсрэг хууль, журам байдаггүй, хууль, журмууд хоорондын уялдаа холбоо сул, үл нийцдэг.
- Цахим үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад өөрсдийнх нь платформ дээр үйлдэгдсэн хүүхдийн мөлжлөгийн талаарх материалыг хадгалах талаар зохицуулалт байхгүй.
- Улс орнуудад энэ төрлийн гэмт хэргийн талаарх нэгдсэн стандарт, тайлбар байдаггүйн улмаас аливаа асуудлын цар хүрээг тодорхойлох, хамтран ажиллахад саад учруулдаг.
- Ихэнх улсуудад цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг хангахад хамтын ажиллагаа шаардлагатай салбаруудыг холбосон дэд бүтэц, чадамж байдаггүй.
- Олон улсыг хамарсан судалгаа, мэдээлэл хомс байдал.
- Хүүхдүүдийн цахим орчинд цаг өнгөрөөдөг орчин (Сошиал медиа, мессеж програмууд, live-stream апп-ууд, хоорондоо холбогддог тоглоомууд)-ын хараа хяналтгүй байдал.
- Интернет урсгалыг хянахад төвөгтэй бөгөөд технологи хөгжихийн хэрээр өндөр нягтаршил бүхий зураг авах, бичлэг хийх, live-stream хийх боломж бүхий камертай хямд гар утас гарч байгаа нь хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй тэмцэх ажлыг улам хэцүү болгодог.
- Дижитал төхөөрөмжүүдэд тэднээр дамжуулан хүүхдийг дарамтлах, мөлжлөг үйлдэх боломжийг хаах технологийн боломж бага, эсвэл огт байдаггүй.
- Зарим оронд соёл болон нийгэм, цахим орчны нөхцөл байдал, бусад хүчин зүйлээс шалтгаалж мөлжлөг үйлдэгчид баригдахгүйгээр гэмт хэрэг үйлдэх боломжтой байдаг.
- Цахим орчны талаарх мэдлэг буюу насны ялгаа. Эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгч, бодлого боловсруулагчид ихэвчлэн технологийн мэдлэг муугийн улмаас хүүхдүүдийн цахим орчин дахь амьдралыг ойлгох, тэднийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх мэдэгдэхүүнгүй байдаг.
- Ерөнхийдөө уг асуудлыг хүндрүүлэн авч үздэггүй, мэддэггүйн улмаас цахим орчин дахь хүүхэд хамгааллын арга зүйг хэрэгжүүлдэггүй.

### **Асуудлын цар хүрээ**

- Зөвхөн нэг жилийн хугацаанд “Internet Watch Foundation” байгууллага хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй холбоотой материал тавьж буй 105,000 вебсайт олж илрүүлдэг байна.
- 2018 онд гэхэд л хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй холбоотой 223,999 зураг, бичлэг илрүүлж байсан.
- 2018 онд хийгдсэн судалгаагаар хүүхдэд зориулсан гар утасны аппликейшнуудын 19 хувь нь хүүхдийн мэдээллийг цуглуулж байсан.
- Ахлах, дунд сургуулийн сурагчдын 30-аас илүү хувь нь цахим дарамтад өртсөн, өртөх хандлагатай байдаг байна.

Зураг 2. Хязгаарлалт хийгдсэн орнууд (хязгаарлалт сул, дунд, өндөр)




Мэдээллээс харахад олон тооны цахим платформ, үйлчилгээ хүүхдийг янз бүрийн аюулаас хамгаалах чиглэлд хангалттай анхаарч, тохирох арга хэмжээг авдаггүй. Үүний уршгаар маш олон хүүхэд хохирсоор байна. Харин эдийн засаг, нийгмийн дэд бүтцээ цахимжуулсан орнуудын туршлагаас харахад цахим орчинг хүүхдэд аюулгүй болгохын тулд дараах алхмуудыг хэрэгжүүлсэн байна.

- Цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлийн төвлөрсөн удирдлага бий болгох, холбогдох хууль, журмыг батлах.
- Хүүхдэд зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ нь аюулгүй байдлыг хангасан байхад анхаарах.
- Урьдчилан сэргийлэх, илрүүлэх, зогсоох нэгдсэн систем бий болгох.
- Үндэсний болон бүс нутгийн хэмжээнд Засгийн газар, хувийн салбар, олон нийтийн болон судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах.
- Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдыг уг асуудлаар сургах, шаардлагатай үед хэнд хандахыг нь тодорхой болгох.

Зураг 3. Хүүхдүүдийн цахим орчны хэрэглээ, нөхцөл байдал

UIA.MN  
СУДАЛГААНЫ САН




Source: GSMA Global connectivity Index 2018, GSMA Intelligence Unit  
<https://www.mobileconnectivityindex.com/#year=2018>

ОУХХЭ-ийн судалгаагаар хөгжил буурай орнуудад ч нийт залуу үеийн 35 хувь нь интернэт хэрэглэдэг байна. Дээр дурдсанчлан интернэтэд холбогдох боломжтой технологийн үнэ буурах тусам эдгээр улсад залуу үе, хүүхдүүд тэдгээрийг ашиглах боломж нэмэгдэж байгаа.

UIH.MN  
 СУДАЛГААНЫ САН





Дээрх графикт хөгжиж буй болон хөгжингүй 34 улсыг сонгон, эцэг эхчүүдээс “Таны 5-17 насны хүүхэд сүүлийн гурван сард гар утас ашиглан интернэтэд холбогдсон уу” гэх асуултыг асууж, үр дүнг нь гаргасан байна. Уг графикаас дэлхийн улс орнууд дахь хүүхдүүдийн гар утасны хэрэглээ, интернэт хэрэглээ, эцэг эхчүүдийн хяналтыг харж болохоор байна.

ДЭМБ-ын мэдээллээр өмнө дурдсанчлан жил бүр 200 сая хүүхэд бэлгийн мөлжлөгийн хохирогч болдог. INTERPOL-ийн санд 19400 гаруй хохирогчийн 1.5 сая зураг, бичлэг хадгалагддаг бол АНУ-ын алга болсон, мөлжлөгт өртсөн хүүхдийн тухай мэдээллийн санд 25 сая гаруй хохирогч хүүхдийн мэдээлэл хадгалагддаг байна. Гэвч бодит тоо үүнээс харьцангуй их бөгөөд илрэхгүй, хохирогч нь өөрөө ч мэдээгүй байх тохиолдол олон байна.

#### 4.БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

##### ГЕРМАН УЛС

Герман улс цахим гэмт хэрэг ба онлайн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь чухал гэж үздэг. Сүүлийн үед интернэт сүлжээ болон түүнд холбогдсон төхөөрөмжүүд нь уламжлалт гэмт хэргүүдийг үйлдэх гол хэрэгсэл болж байна.

##### **Цахим орчин дахь гэмт хэрэг, хүчирхийллийн нөхцөл байдал**<sup>199</sup>

Харин Германы Хүүхэд залуучуудыг цахим орчин дахь хүчирхийллээс хамгаалах үйл ажиллагаа, хяналтыг явуулдаг Jungenschutz.net цахим хуудсанд бүртгэгдсэн 7513 зөрчлийн ангиллыг авч үзэхэд хүүхдийн садар самуун 41% -ийг эзэлж байгаа бол улс төрийн хэт туйлшралтай холбоотой цахим гэмт хэрэг, порнографтай холбоотой, хүүхэд залууст хор хөнөөлтэй мэдээлэл зэрэг нь бусад хувийг эзэлж байна.

Эдгээр цахимаар үйлдэгдсэн гэмт хэргийн 86% нь гадаадын серверээс ирсэн бөгөөд агуулгын тал орчим хувь нь платформ дээр илэрчээ. Ялангуяа Facebook (14%), YouTube (10%), Twitter (6%), Instagram (5%), Tumblr (4%) нар ихээхэн хувийг эзэлж байжээ.

Хор хөнөөлтэй мэдээллийг устгах амжилтын хувь нь дотоодын сервер дээр 100%, гадаадын серверүүдийн хувьд 92% байна. Хугацааны хувьд Германд дунджаар 4,8 хоногийн хугацаанд устгадаг бол гадаадын серверүүд 7,8 хоногт устгадаг байна.

Цахим хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор засгийн газрууд иргэний нийгэм, хувийн секторууд ба олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хэлбэрээр маш өргөн цар хүрээтэй санал санаачлагуудыг гарган, дэмжих бодлогыг баримтлан ажилладаг. Энэ хүрээнд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэнд хяналт тавих, бодлого хөтөлбөр боловсруулах, хүүхэд залууст мэдлэг олгох, цахим орчныг ашиглах боловсролыг дээшлүүлэх, мэдээ мэдээллээр хангах, цахим гэмт хэрэг, хүчирхийллээс хамгаалах арга хэрэгслийг нэвтрүүлэх зэрэг өргөн хүрээний цогц арга хэмжээг авч ирсэн байна. Тухайлбал,

- ✓ **Райнландын 10 зүйлт хөтөлбөр** (Rhineland's 10 Point Program)- Интернэтийн зохистой хэрэглээний талаарх мэдлэгийг дээшлүүлж, суурь мэдлэгтэй болгох замаар хүүхэд, залуучуудыг аюултай цахим агуулгаас хамгаалах зорилготойгоор боловсруулж 2007 оноос хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөр нь Европын Холбооноос санхүүжүүлдэг Киксейф (Kicksafe) зэрэг хөтөлбөрүүдтэй хамтран ажилладаг.
- ✓ **Киксейф хөтөлбөр** (Kicksafe)- Мөн хүүхэд, залуучуудын интернэт болон цахим хүчирхийллийн талаарх ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх зорилготойгоор 2009 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөр нь хүүхэд, залуучуудыг өөрийн “хүүхэд залуучуудын” цахим хуудсуудаараа дамжуулан нэгтгэж, шинээр тулгамдаж буй асуудлуудыг хөндөн танилцуулдаг. Энэ хөтөлбөрийн хүрээнд жил бүрийн 2

<sup>199</sup> [https://www.jungenschutz.net/fileadmin/download/pdf/Report\\_2019\\_Children\\_on\\_the\\_Internet.pdf](https://www.jungenschutz.net/fileadmin/download/pdf/Report_2019_Children_on_the_Internet.pdf)

дугаар сарын 5-ны өдрийг Европын “Илүү аюулгүй интернэтийн өдөр” болгон тэмдэглэдэг ба засгийн газрын болон хувийн хэвшлийн олон байгууллагуудтай хамтран ажиллаж, интернэт орчны аюулгүй байдал ба цахим хүчирхийллийн талаарх мэдээллүүдээр хангадаг. Европын Холбооны хэмжээнд улс орон тус бүрийн онцлог асуудлыг хөндөн үзэх үүднээс тусгайлсан цахим сүлжээнүүдийг бий болгон ажиллуулдаг байна.

- ✓ **Freiwillige Selbstkontrolle Multimedia-Diensteanbieter (FSM)** буюу Сайн дурын өөрийгөө зохицуулах мультимедиа үйлчилгээ үзүүлэгчдийн ассоциаци нь хүүхэд залуучуудыг аюултай цахим агуулгаас хамгаалах зорилгоор 1997 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд хууль бус болон аюултай цахим агуулгын талаарх мэдээг шинжлэн үздэг Хотлайн (Hotline)-ыг ажиллуулдаг. FSM нь 1999 онд **INHOPE** нэртэй интернэтийн хотлайн ажиллуулагчдын Олон улсын ассоциацийг бусадтай хамтран үүсгэн байгуулсан ба энд ихэвчлэн Европт байрлах 20 гаруй интернэтийн хотлайн нэгдэн орсон байна. INHOPE нь интернэтийн аюулгүй байдлыг ханган ажилладаг хотлайнуудын ажиллах орчныг нөхцөлдүүлж, хамтран ажилладаг.
- ✓ **Интернэт ба Дижитал Нийгмийн лавлах**- Дижитал ур чадвар, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөгөө өгч, гарын авлагаар ханган ажилладаг. Энд бас муж улсын түвшинд үйл ажиллагаа явуулдаг “**Medienpass NRW**” **хөтөлбөр (хэвлэл мэдээллийн сувгийн паспорт)** зэргийг дурдаж болно.

Мөн хүүхэд сэтгэлийн дарамтанд орох үедээ залгаж тусламж авах боломжтой “Хүүхэд, залуучуудад туслах шугам (“Nummer gegen Kummer”) буюу Телефон зөвлөгөө, үйлчилгээний төвийн 116 111 утасны дугаарыг ажиллуулдаг. Энд өдөрт дунджаар хоёр дуудлага тутмын нэг нь цахим хүчирхийлэлтэй холбоотой байдаг байна. 2013 онд гэхэд Германы телефон зөвлөгөө, үйлчилгээний төвд 495 цахим хүчирхийллийн тохиолдол бүртгэгдсэн байна.

### ***Цахим орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал*<sup>200</sup>**

Цахим болон нийгмийн сүлжээн дэх хүчирхийллийн аливаа гэмт хэрэг, халдлагаас хүүхэд, залуу үеийг хамгаалах үйл ажиллагааг **Холбооны гэр бүлийн яам** хариуцахаас гадна тус яамны харьяа **Хүүхэд, залуучуудад хортой мэдээллийн хяналтын холбооны зөвлөл (BPKM)**, Цахим орчин дахь хүүхэд, залуучуудыг хамгаалах комисс (KJM) зэрэг байгууллагууд хариуцан ажилладаг. Эдгээр төрийн захиргааны байгууллагууд нь Хүүхэд, залуучуудыг хамгаалах хууль, Нийгмийн сүлжээн дэх хүүхэд, залуучуудын хамгааллын тухай муж хоорондын гэрээ зэрэг эрх зүйн орчны хүрээнд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг хянах, мэдээллийг индексжүүлэх, гомдол хүлээн авах, шийдвэрлэх, хүүхдийн цахим хүчирхийллийн эсрэг хөтөлбөр, үйл ажиллагаа хэрэгжүүлэх зэргээр хяналт тавьдаг. Мөн эдгээр нь Холбооны хууль зүйн яам, Германы цагдаагийн байгууллага, төрийн болон хувийн, олон нийтийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг байна.

Герман улсын Засгийн газраас 2003 оноос цахим хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэнд шийтгэл ногдуулах, хохирогч нарт туслах зэрэг ажлыг хийх талаар ихээхэн анхаарч эхэлсэн.

Тухайн жилд хүүхэд, залуучуудыг хортой бөгөөд аюултай агуулгаас илүү сайн хамгаалах үүднээс Хүүхэд, залуучуудыг хамгаалах хуулийг Холбооны Засгийн газар болон Ландераас (the Federal State and the Länder) сайжруулан шинэчилжээ. Энэхүү хуулийн

<sup>200</sup> <https://www.jugendschutz.net/en/index.html>

шинэ зүйл заалтууд ба төрийн институцийн үйл ажиллагаа нь залуучуудыг интернэтийн сөрөг нөлөөнөөс аль болох сайн хамгаалж, тэдний насны онцлогт тохируулан нийгмийн болон хувь хүний хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн байна.

Хамгийн чухал зохицуулалтууд дараах хоёр хуульд тусгагдсан байдаг: Холбооны улсын түвшинд **“Залуучуудыг хамгаалах тухай хууль”** (JuSchG)<sup>201</sup> нь CD зэрэг биет мэдээллийг нийтэд түгээх асуудлыг зохицуулж, чухам алийг хүүхэд, залуучуудад хортой мэдээллийн жагсаалтад оруулахыг тодорхойлно. Мужийн түвшинд (Länder level) **“Нийгмийн сүлжээн дэх хүүхэд, залуучуудын хамгааллын тухай муж хоорондын гэрээ”**<sup>202</sup> (JMStV) нь интернэт болон өргөн нэвтрүүлэгт хэрэглэгддэг цорын ганц хууль эрх зүйн үндэс юм.

“Нийгмийн сүлжээн дэх хүүхэд, залуучуудын хамгааллын тухай муж хоорондын гэрээ” (JMStV)–ний 4-6 дугаар зүйл нь ямар төрлийн агуулгуудыг интернэтэд түгээхгүй, эсхүл тодорхой хязгаартайгаар түгээхийг тодорхойлсон байдаг. Агуулгын гурван түвшин бий: ноцтой хууль бус, аюултай эсхүл хортой гэх мэт. Үүнээс гадна хүүхэд, залуучуудад чиглэсэн онлайн зар сурталчилгааны зарим хязгаарлалтууд байдаг.

“Нийгмийн сүлжээн дэх хүүхэд, залуучуудын хамгааллын тухай муж хоорондын гэрээ” (JMStV) нь “jugendschutz.net” цахим хуудас болон “Цахим орчинд хүүхэд, залуучуудыг хамгаалах комиссын (KJM) үйл ажиллагааны зорилтуудыг томъёолж, техникийн арга хэмжээтэй холбоотой зүйл заалтуудыг ч бас багтаасан байдаг.

**“Цахим орчин дахь хүүхэд, залуучуудыг хамгаалах комисс”** (KJM) бол өргөн нэвтрүүлэг ба интернэтийг байнга хянах төв захиргаа ба агуулга нийтлэн түгээгч нарыг залуучуудыг хамгаалах хууль эрх зүйд нийцүүлэн ажиллах явдлыг баталгаажуулдаг төрийн хэвлэл мэдээллийн зохицуулагч байгууллага юм. KJM нь хууль журам зөрчигдсөн эсэхийг тодорхойлж, удирдан чиглүүлэх арга хэмжээний шийдвэрийг гаргана.

KJM нь тухайн нэг агуулгыг хориглох эсхүл торгууль ногдуулах гэхчлэн зөрчлийн хүнд хөнгөний хэмжээнээс хамааран харилцан адилгүй янз бүрийн хуулийн хариуцлагыг ногдуулна. Үүнд тухайн нийтлэл, агуулга түгээгчийн харьяа мужийн хэвлэл мэдээллийн захиргаа нь зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг харицлагыг хүлээнэ.

**jugendschutz.net**<sup>203</sup> цахим хуудас нь байгууллагын хувьд KJM-тэй холбоотой бөгөөд KJM ба мужийн залуучуудын дээд захиргаадыг зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд нь дэмжин тусалдаг бөгөөд интернэт агуулгыг хянаж, Залуучуудыг хамгаалах хууль зөрчсөн үйлдлийг тогтоон таниж, KJM-д дараагийн арга хэмжээг авахуулахаар уламжилна.

KJM-ийн зэрэгцээгээр **“Хүүхэд, залуучуудад хортой мэдээллийн хяналтын холбооны зөвлөл”** - the Federal Review Board for Media Harmful to Minors (BpJM) нь онлайн агуулгыг залуучуудад аюултай эсэхийг шийдэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. BpJM нь бусад захиргааны байгууллагуудын албан хүсэлтээр үйл ажиллагаагаа явуулах ба “индекс жагсаалтад” URLs-уудыг оруулна. Үүнээс гадна BpJM интернэт орчинд хүүхэд,

<sup>201</sup> <https://germanlawarchive.iuscomp.org/?p=724>

<sup>202</sup> [https://www.kjmonline.de/fileadmin/user\\_upload/Rechtsgrundlagen/Gesetze\\_Staatsvertraege/Interstate\\_Treaty\\_on\\_the\\_Protection\\_of\\_Minors\\_in\\_the\\_Media\\_JMStV\\_in\\_English\\_19th\\_Interstate\\_Broadcasting\\_Treaty.pdf](https://www.kjmonline.de/fileadmin/user_upload/Rechtsgrundlagen/Gesetze_Staatsvertraege/Interstate_Treaty_on_the_Protection_of_Minors_in_the_Media_JMStV_in_English_19th_Interstate_Broadcasting_Treaty.pdf)

<sup>203</sup> <https://www.jugendschutz.net/en/index.html>

залуусыг найдвартай хамгаалахад учирч болзошгүй гэмт үйлдлүүдэд хариу арга хэмжээ авах албан ёсны эрх үүрэгтэй зөвлөл юм.

Гэрээнд зааснаар ноцтой хууль бус агуулга буюу хүүхдийг бэлгийн замаар хүчирхийлж буй, үзэн ядалтыг дэвэргэсэн, хүчирхийллийг хөөрөгдсөн дүр дүрслэлийг интернэтэд хүртээмжтэй нийтэлж болохгүй. Ихэнх тохиолдолд ийм агуулгыг нийтлэн түгээх нь Эрүүгийн хэрэгт тооцогдоно. Энэ төрлийн гэмт хэргийг Холбооны хууль зүйн яамны харьяа Эрүүгийн цагдаагийн газарт мэдэгдэнэ.

Хүүхэд, залуучуудад аюултай агуулга гэдэгт жишээлэхэд насанд хүрэгчдийн порно эсхүл “Хүүхэд, залуучуудад хор хөнөөлтэй мэдээлэл” гэх жагсаалтад (индекс жагсаалт) орсон агуулгуудыг тооцох ба эдгээрийг зөвхөн насанд хүрэгчдэд л үзүүлж болно. Энэ агуулгад хүүхэд, залуучууд нэвтрэх явдлыг хаах үүднээс цахим сүлжээгээр хангагч нар шаардлага хангахуйц түвшний “нас тогтоох системийг” (age verification system)-ийг нэвтрүүлэн ашиглах ёстой.

Мөн маш их бухимдал, айдсыг төрүүлэхүйц хортой агуулгад нэвтрэх хязгаарлалтыг үзэхэд мөн тодорхой хязгаарлалтыг хийх шаардлагыг цахим сүлжээ эрхлэгчдэд тавина. Үүний тулд КJM-ээс хүлээн зөвшөөрсөн нэвтрэх техникийн хамгаалалтын арга хэмжээнүүдийг (technical protection measures) авч хэрэгжүүлнэ. Мөн ТВ-гээр хязгаарлалт тогтоосон зэрэглэлийнх нь дагуу цацаж болно (жишээлэхэд, 16-д зэрэглэгдсэн агуулгыг 22 цагаас хойш үзүүлэх гэх мэт).

Зар сурталчилгаатай холбоотой тусгай журмууд бий: зар суртчилгаа түгээгчид хүүхэд багачуудын гэнэн, туршлагагүй байдлыг ашиглан ямар нэг бүтээгдэхүүн, эсхүл үйлчилгээг худалдан авахыг шууд хандан сурталчилж болохгүй.

### ***Цахим орчин дахь гэмт хэрэг, хүчирхийллийн эрх зүйн орчин***

Ихэнх улс орнуудад интернэтийн орчинд бэлгийн дарамт үзүүлэх, хүүхэд хүчирхийлэх зэргийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох, цахим дарамт, гутаан доромжлох зэрэг цахим хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох хууль, эрх зүйн үндэслэлийг бий болгож эхэлсэн бөгөөд зарим хуульд үйлчилгээ үзүүлэгч этгээдүүдэд нь хариуцлага тооцохоор зохицуулсан байдаг. Энэ ч үүднээс тус улсын хууль эрх зүйд заасан энэ төрлийн гэмт хэргүүд нь Будапештийн конвенцтой тэр бүр шууд холбогддоггүй учраас Германд тэрхүү конвенцийн бодит чадамжийг цахим гэмт хэргийг явцуу хүрээгээр авч үздэг гэж дүгнэжээ. Цахим дарамт ба онлайн хүчирхийлэл нь дан ганц Эрүүгийн хуулиар шийдэгдэх асуудал биш тул зарим тодорхой урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, нийгмийг соён гэгээрүүлж энэ талын мэдлэг, ухамсарыг дээшлүүлэх зэрэг ажлыг хийх шаардлагатай байдаг байна.

Герман улсад цахим орчин дахь гэмт хэрэг, хүчирхийллийн асуудлыг Эрүүгийн хууль (Strafgesetzbuch) болон Нийгмийн сүлжээн дэх хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль, Теле мэдээллийн тухай хууль (Telemedia act)-иудаар нийтлэг зохицуулахаас гадна цахим сүлжээн дэх хүүхэд хамгааллын асуудлыг өмнө дурдсанчлан холбогдох хуулиудаар зохицуулж байна. Эдгээр хуулиуд нь хоорондоо нягт уялдаа холбоотой бөгөөд хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээн дэх хүчирхийллийн агуулга ба цахим хүчирхийллийн үйлдлийг зохицуулах эрх зүйн цогц баримт бичиг юм.



## Германы Эрүүгийн хууль<sup>204</sup>

Герман улс бусад орнуудын нэгэн адилаар цахим орчин дахь гэмт хэрэг, хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэхэд Эрүүгийн хуулийн заалтуудыг хэрэглэж байна. Тухайлбал, Хууль бус суртал ухуулгын материал тараах буюу Үндсэн хуульд харшилсан байгууллагын тэмдэглэгээг ашиглах, төрийн эсрэг онц хүнд гэмт хэрэг үйлдэхийг дэмжих, хууран мэхлэх гэмт хэрэг үйлдэхийг завдах, олон нийтийг гэмт хэрэгт уриалах, мөн үзэн ядахыг өөгшүүлэх болон бусад гэмт үйлдлийн тохиолдлуудад дараах Эрүүгийн хуулийн зүйл заалтуудыг хэрэглэн шийдвэрлэнэ. Үүнд: Германы эрүүгийн хуулийн 238 дугаар хэсэг (бусдыг хууль бусаар мөшгих), 240 дүгээр хэсэг (бусдыг заналхийлэх, хүч хэрэглэх хэлбэрээр үйл үйлдүүлэх, зовоох эсхүл эс үйлдүүлэх), 241 дүгээр хэсэг (гэмт хэрэг үйлдэхээр сүрдүүлэх), 176 дугаар зүйл (хүүхдийг хүчирхийлэх), 185 дугаар хэсэг (гутаан доромжлох), 186 дугаар хэсэг (гүтгэх), 187 дугаар хэсэг (санаатайгаар гүтгэх), 201 дүгээр хэсэг (үг ярианы хувийн нууцыг алдагдуулан зөрчих), мөн Германы Эрүүгийн хуулийн (Strafgesetzbuch) 201a хэсэг (хувийн нууцыг зураг авч зөрчих) ба Үзүүлэх урлагийн бүтээл, фото зургийн зохиогчийн эрхтэй холбоотой хуулийн (Kunsturhebergesetz) 33 дугаар хэсэг зэрэг багтана. Эрүүгийн хуулийн 238 дугаар хэсэгт (хууль бусаар мөшгих) теле харилцааны арга зам (1-р догол мөрийн 2 дугаарт) эсхүл хэн нэгний хувийн мэдээллийг ашиглах (1-р догол мөрний 3 дугаарт) зэргийг маш тодорхой заасан байдаг. Хүүхдийн хүчирхийллийг заасан 176 дугаар хэсэгт ч мөн адил теле харилцааны арга хэлбэрийг тодорхой хамруулан заасан (4-р догол мөрний 3 ба 4 дүгээрт).

## Нийгмийн сүлжээн дэх хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль<sup>205</sup>

2017 оны 6 дугаар сараас хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн “Нийгмийн сүлжээн дэх хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль” нь Эрүүгийн хуулийн хүчин төгөлдөр үйлчилж буй заалтуудыг нийгмийн сүлжээний онцгой орчинд хэрэгжүүлэх, нийгмийн сүлжээ эрхлэгчдэд гомдол хүлээн авч барагдуулах үр өгөөжтэй, ил тод менежментийг нэвтрүүлэх үүргийг хүлээлгэх, нийгмийн сүлжээ эрхлэгчид, төрийн захиргааны байгууллагуудын мэдэгдэл, шүүхийн зарлан дуудах, шүүхийн шийдвэр хүлээн авах, тэдгээртэй харилцах түншийг нэр заан томилох зэргийг зохицуулна. Хууль нь дараах агуулга, бүтэцтэй байна.

§ 1 *Хамрах хүрээ*

§ 2 *Тайлагнах үүрэг*

§ 3 *Хуульд үл нийцэх агуулгын талаар гарсан гомдлыг хүлээн авч барагдуулах журам*

§ 4 *Мөнгөн торгууль ногдуулах тухай журам*

§ 5 *Шуудан хүлээн авах эрх бүхий дотоодын этгээд томилох*

§ 6 *Шилжилтийн үеийн журам*

Нийгмийн сүлжээнд хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль нь Германд нийгмийн сүлжээ эрхлэгчдэд зориулсан хууль бөгөөд 2 саяаас илүү бүртгэлтэй хэрэглэгч бүхий нийгмийн цахим сүлжээ бүрийг санал гомдлыг үр дүнтэй барагдуулах менежменттэй

---

<sup>204</sup> **Criminal Code (Strafgesetzbuch, StGB)** <https://germanlawarchive.iuscomp.org/?p=752>

<sup>205</sup> Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зааг хязгаар. Фрейдрих Эбертийн сан. 2018 он. <http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/14077.pdf>



байхыг шаарддаг ба тодорхой цаг, хүрээнд Германы Эрүүгийн хуулийн тодорхой зүйл заалтуудыг зөрчсөн хууль бус агуулгыг мэдэгдсэн даруйд нь устгах эсхүл хаах үүргийг хүлээнэ. Харин хувиараа нийгмийн сүлжээ хэрэглэгчдэд үйлчлэхгүй.

Хуулиар нийгмийн сүлжээ эрхлэгчдэд шийдвэр гаргах тодорхой хугацааны хязгаарыг зааж өгсөн. Мөн нийгмийн сүлжээ эрхлэгчдээс хэрэглэгчдийн гомдлыг хүлээн авч барагдуулах хандалтын аливаа саадгүй, ойлгомжтой, ил тод аргачлалыг нэвтрүүлэхийг шаарддаг учраас үйлчилгээ эрхлэгчид тэдний платформ дээр Германы эрүүгийн хууль зөрчсөн байж болзошгүй агуулгын талаар мэдээлэл өгөхөд ашиглах ойлгомжтой, хялбар боломжийг хэрэглэгчдэд олгох ёстой. Нийгмийн сүлжээ эрхлэгчид эдгээр мэдээллийг хүлээн авмагц нэн даруй хуулиар тогтоосон хугацаанд багтаан боловсруулж гаргасан шийдвэрээ танилцуулах ёстой.

Хэрвээ нийгмийн сүлжээ эрхлэгчид хуулиар ногдуулсан үүрэг болох гомдол хүлээн авч барагдуулах менежментийг нэвтрүүлээгүй, хугацаа хэтрүүлсэн, эсвэл Германы эрүүгийн хуулийн зохих заалтуудын дагуу агуулгыг устгах, хаах үүргээ үл тоомсорлосон бол 5 сая хүртэлх еврогийн мөнгөн торгууль төлөх, онц ноцтой тохиолдолд 50 сая хүртэлх еврогийн торгууль төлөх юм.

Нийгмийн сүлжээ эрхлэгчид хууль зүй, төрийн захиргааны байгууллагууд болон иргэдийн зүгээс агуулгын болон бусад асуудлаар хандаж байх байнгын түншийг нэр заан томилох үүргийг хүлээнэ. Тухайн түншид хандсан асуултад 48 цагийн дотор хариу өгөх ба хугацаа хэтрүүлсэн тохиолдолд мөнгөн торгууль ногдуулна.

Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, мөнгөн торгууль ногдуулах, нийгмийн сүлжээ эрхлэгчдийн талаар иргэдийн гаргасан гомдлыг Холбооны Хууль Зүй, Хэрэглэгчдийн эрхийг Хамгаалах Яамны харьяа Холбооны хууль зүйн газар хариуцна.

Энэхүү хууль батлагдсантай холбоотойгоор Теле мэдээллийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулж (интернэтийг зохицуулах суурь хууль) онц ноцтой тохиолдолд нийгмийн сүлжээ эрхлэгчдэд хууль зөрчсөн агуулгын зохиогчийн мэдээллийг ил болгох үүргийг ногдуулах эрхийг шүүхэд олгосон. Тухайлбал, доромжлуулсан иргэн зохиогчийг иргэний шүүхэд өгч болно. Ингэснээр доромжлолд өртсөн хүн нийгмийн сүлжээнд тухайн иргэнийг доромжилсон, гүтгэсэн агуулга нийтлүүлснийх нь төлөө зохиогчоос хохирлын мөнгө төлүүлэх боломж бүрдсэн байна.

Мөн Нийгмийн сүлжээнд хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль ёсоор нийгмийн сүлжээ эрхлэгч компаниуд хагас жил тутамд тайлан гаргах ёстой байдаг байна.

Тус хуулийн үндсэн ач холбогдол нь зөвхөн иргэд болон байгууллагууд, төрийн захиргааны байгууллагуудын зүгээс мэдээлэл ирсэн тохиолдолд уг мэдээллийг үндэслэн тухайн агуулгын мөн чанар, түүнтэй холбоотойгоор тухайн агуулгыг устгах, хаах тухай шийдвэрийг эхлээд нийгмийн сүлжээ эрхлэгчид гаргадагт оршино. Тийм учраас энэ хууль нь нийгмийн цахим сүлжээнд эрүүл зөв орчныг бүрэлдүүлэх, цахим дарамт шахалт болон онлайн хүчирхийллийг зогсооход чухал хувь нэмэртэй байгаа ажээ. (энэ хууль батлагдсанаар Фэйсбүүк компани гэхэд л Герман улсад өөрийн гэсэн 2 контент устгалын төвийг байгуулаад байгаа ба тэр нь 1200 ажилтантайгаар хяналт шалгалтын үйл ажиллагааг 24 цагаар явуулж байна. Хэрэв тус контент устгалын төв Герман улсад нутаг дэвсгэр дээрх Фэйсбүүкийн хэрэглээ, контентод байнгын хараа хяналт тавих ба ямар нэгэн зөрчилтэй контент илэрвэл түүнийг нь 24 цагийн дотор устгах үүрэгтэй.)

Энэ мэтчилэн дээрх хуулийн олон салбар хүрээ нь цахим дарамт шахалт ба цахим хүчирхийллээс урьдчилан сэргийлэхтэй холбогдож байдаг. Эрүүгийн хууль болон эдгээр хуулиас гадна Иргэний хууль (нөхөн төлбөр, арилгах ба хориглох), Хөдөлмөрийн хууль (сануулах хуудас), Цагдаагийн хууль ба Үйлчилгээ үзүүлэгчдийн журам зэргийг багтаасан захиргааны хууль зэрэгт холбогдох зүйл заалтууд бий. Тухайлбал, Иргэний хуулийн хүчирхийлэл ба мөшгих үйлдлээс урьдчилан сэргийлэх заалтууд (Gewaltsschutzgesetz) нь шүүхэд цаашдын урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үндэслэл болдог байна.

## **ЯПОН УЛС**

2021 оны 1-р сарын байдлаар Япон улс 117 сая орчим идэвхтэй интернэт хэрэглэгчтэй болж Ази, Номхон далайн бүсийн дөрөвдүгээрт жагсжээ. Эдийн засаг төдийгүй хүмүүсийн өдөр тутмын амьдрал дижитал үйл ажиллагааны ач холбогдол нэмэгдэж байгаатай холбогдуулан Японы кибер аюулгүй байдал нь дотоодын чухал асуудал болжээ.

### ***Цахим орчин дахь хүчирхийллийн нөхцөл байдал*<sup>206</sup>**

Япон улсад интернэтийн гэмт хэргийн хэлбэр өргөн хүрээг хамарч байна. Тухайлбал, 2019 онд онлайн банкны луйврын улмаас 2.5 тэрбум гаруй иений хохирол учирсан байна. 2020 онд телевизийн реалити цуврал нэвтрүүлэгт оролцсон эмэгтэй мэргэжлийн бөх Хана Кимура амиа хорлосонтой холбоотойгоор кибер дээрэлхэх явдал улс оронд томоохон асуудал болжээ. Тухайн жилийн туршид цагдаа нар коронавирустай (COVID-19) холбоотой кибер гэмт хэрэгт сэжиглэгдсэн хэдэн зуун хэргийг бүртгэжээ. Бусад зөрчилд хүүхдийн биеэ үнэлэх, садар самуунд уруу татсан, хууль бусаар компьютерт нэвтрэх, хууль бус бизнесийн үйл ажиллагаа, хор хөнөөлтэй мэдээлэл зэрэг гэмт хэргүүд орж байна.

2021 оны 3-р сарын байдлаар Үндэсний цагдаагийн газраас явуулсан судалгаагаар 18-аас доош насны 1819 хүүхэд 2020 онд нийгмийн сүлжээтэй холбоотой гэмт хэргийн хохирогч болсон болохыг тогтоожээ. Хохирогчдын бараг 90 хувь нь бага, ахлах сургуулийн сурагчид байсан бөгөөд үүний 35,3 хувийг твиттер ашиглагч эзэлж байна. Хэдийгээр 2019 оны мөн үетэй (2082) харьцуулахад 12,6%-аар буурсан боловч 2013 оноос хойш сүүлийн 5 жилд 4.6 хувиар өссөн үзүүлэлттэй байжээ. Гэмт хэргийн төрлийг ангиллаар нь авч үзвэл, хүүхдийг хамгаалах хууль, журмыг зөрчсөн 738, хүүхдийн садар самуун 597, хүүхдийн биеэ үнэлэх явдал 311 байгаа бол хүнд гэмт хэргийн хувьд хулгайлах гэмт хэрэг өссөн үзүүлэлттэй гарчээ. Хохирогчдын нэвтрэх хэрэгслийн хувьд ухаалаг гар утас нийт интернэт хэрэглэгчдийн 90 орчим хувийг эзэлж байсан бол ашигладаг сүлжээний хувьд Твиттер дээр 642, Инстаграм дээр 221, Химабе дээр 160, Тик ток дээр 76, Коё Томо дээр 63 байсан байна.<sup>207</sup>

Энэ мэтчилэн сүүлийн жилүүдэд смарт утас гэх мэт интернэтэд холбогдсон төхөөрөмжүүдийн хэрэглээ хурдацтай хөгжиж, хүүхэд залуучууд нийгмийн сүлжээг ашиглах нь ихсэхийн хэрээр гэмт хэргийн хохирол нэмэгдэж байна.

### ***Цахим орчин дахь хүчирхийлэл ба хүүхэд хамгаалал*<sup>208</sup>**

Японы Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь хүүхэд, залуучуудын хөгжил, дэмжлэгийн

<sup>206</sup> <https://www8.cao.go.jp/youth/kankyou/index.html>

<sup>207</sup> <https://resemom.jp/article/2021/03/15/60976.html>

<sup>208</sup> [https://www8.cao.go.jp/youth/kankyou/internet\\_torikumi/index.html](https://www8.cao.go.jp/youth/kankyou/internet_torikumi/index.html)

талаар төлөвлөлт, иж бүрэн зохицуулалт хийх үүрэг бүхий төрийн байгууллагын хувьд үндсэн цогц бодлогыг бий болгосон бөгөөд энэхүү бодлогыг үндэслэн холбогдох яам, агентлагууд орон нутгийн засгийн газар болон бусад холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

Үүнээс гадна интернэт орчинд үйл ажиллагаа явуулдаг GREE, CyberAgent, DeNA, Facebook Japan, Mixi, LINE, Twitter Japan зэрэг операторууд нэгдэн “Өсвөр үеийнхний интернэт ашиглалтын орчныг сайжруулах зөвлөл”-ийг олон нийтийн сайтуудаас үүдэлтэй хүүхдийг гэмтээх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтыг сурталчлах зорилгоор 2017 онд байгуулсан. Зөвлөл нь хүүхдийн аюулгүй интернэт орчныг бүрдүүлэхээр мэдээлэл солилцох, судалгаа, боловсрол, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Мөн Ignis, Cocone, Nanameue, Moi, Yudo, ITI, C studio, Social Town, Maleo зэрэг компаниуд оролцох болсон. Тус зөвлөл нь Үндэсний цагдаагийн газартай хамтран ажилладаг байна.

Цахим орчин дахь хүүхэд, залуучуудыг хамгаалах асуудлыг “Насанд хүрээгүй хүмүүсийн интернэтийн аюулгүй орчныг бүрдүүлэх тухай хууль”, Насанд хүрээгүй хүмүүсийн аюулгүй интернэт хэрэглээг бий болгох үндсэн төлөвлөгөөг үндэслэн Дотоод хэргийн яам, Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан технологийн яам, холбогдох агентлагууд, Үндэсний цагдаагийн газар бусад төрийн болон хувийн байгууллагууд хамаарах бөгөөд тэдгээр нь хамтран хүүхэд, залуучуудад интернэтийн аюулгүй хэрэглээний талаар сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулдаг.

### ***Насанд хүрээгүй хүмүүсийн интернэтийн аюулгүй орчныг бүрдүүлэх тухай хууль***

Тус хуулийг 2008 онд баталсан бөгөөд энэхүү хуулиар насанд хүрээгүй хүмүүст интернэтийг зохистой ашиглах чадварыг эзэмшүүлэх, шүүлтүүрийн тархалтыг дэмжих замаар насанд хүрээгүй хүмүүсийн хортой агуулга бүхий мэдээллийг үзэх боломжийг багасгах, иргэдэд интернэтийн зохистой хэрэглээг зохицуулах үүргийг ногдуулж, түүнийг төр засгаас дэмжих бодлогыг баримталсан. Мөн холбогдох засаг захиргаа, интернэттэй холбоотой бизнес эрхлэгчид, эцэг эхчүүд, асран хамгаалагчдад хүүхдийг хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалах арга хэмжээ авах (интернэтийн зохистой хэрэглээний талаар сурталчлах, боловсрол олгох, хүүхдийн хэрэглэж буй цахим төхөөрөмжид шүүлтүүр хэрэглэж буй эсэхэд хяналт тавих гм) үүрэг хариуцлагыг ногдуулах болсон байна.

Насанд хүрээгүй хүүхдийн асран хамгаалагч хортой мэдээллийг шүүгч үйлчилгээг ашиглахгүй гэсэн хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд цахим төхөөрөмж үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдээс шүүгч программыг ашиглахад хялбар байдлаар суурилуулж тухайн бүтээгдэхүүнийг борлуулах, үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд заавал биелүүлэхийг шаардах эрхтэй.

Хуульд зааснаар цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг “Цахим орчинд насанд хүрээгүй хүмүүст аюулгүй мэдээллийн орчныг бүрдүүлэх хороо” хариуцахаар заасан байна.

Энэхүү хуулийн гол зорилго нь хүүхдэд сөргөөр нөлөөлөх мэдээллээс урьдчилан сэргийлэх, шүүгч программ хангамжийг өргөн нэвтрүүлэх боломжийг бий болгох, ингэснээр хүүхдүүдийг цахим гэмт хэргийн золиос болохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

### ***Цахим орчин дахь гэмт хэрэг, хүчирхийлэл ба хууль эрх зүйн орчин***

Японд цахим гэмт хэрэг, хүчирхийлэлтэй холбоотой хэргийг Цахим мөрдлөгийн эсрэг хууль болон Эрүүгийн хуулийн зарим зүйл заалтаар шийдвэрлэж байна. Харин хүүхдийн цахим хүчирхийлэл, садар самуунтай холбоотой гэмт үйлдлийг Хүүхдийн биеэ үнэлэх, хүүхдийн порно үйлдэлд хариуцлага ногдуулах болон хүүхдийг хамгаалах тухай хуулиар мөн зохицуулж байна.

### Цахим мөрдлөгийн тухай хууль

Энэ хуулийн зорилго нь хувь хүний бие болон эрх чөлөө, нэр хүндэд хор хүргэхээс урьчилан сэргийлж, улмаар мөрдөн мөшгөсөн хэрэгт ногдуулах шийтгэл, хохирогчид үзүүлэх тусламжийн арга хэмжээг тодорхойлсон заалтууд гэх зэргийн багтаасан шаардлагатай хоригуудыг тогтоох замаар иргэдийн амь насны аюулгүй, амар тайван байдлыг хангахад хувь нэмрээ оруулахад оршино.

#### Зүйл 2. (Тодорхойлолт)

1. Энэ хуульд хэрэглэсэн “Following, etc - дараах байдлаар” гэсэн нэр томъёог дор жагсаан дурдсан асуудлуудын аль нэгийг хувь хүн, түүний хань ижил, ах дүү эсхүл хамтран амьдарч буй хүмүүс, эсхүл түүнтэй нийгмийн амьдралд идэвхтэй бөгөөд ойр дотно харилцаатай хэн нэгний эсрэг өөрийн хүсэл зэргийг хангах зорилгоор үйлдсэн, хэн нэгэнд хандсан эсхүл дээр дурдсан хүсэл нь харилцан бус, өшөө авах үүднээс үйлдсэн гэх утгаар ойлгоно.

(5) Дуудлага хийгээд ярихгүй байх, эсхүл татгалзсаар байтал дуудлага хийх, зурвас бичвэрийг факс машинаар, эсхүл захидал бичвэр дамжуулагч ямар нэг үйлчилгээ ашиглан байнга илгээх.

2. (5)-д заасан “Аливаа захидал зурвас илгээх үйлчилгээгээр зурвас бичвэр илгээх” гэдэгт доор дурдсан үйлдлүүд багтана.

А. Хохирогчийг тухайн илгээлт дамжуулалтын хүлээн авагч гэдгийг тогтоосны дараагаар мэдээлэл дамжуулах теле харилцаагаар дамжуулан зурвас бичвэрүүдийг илгээх;

Б. “А”-д заасны дээр бас теле харилцаа ашиглагч тухайлсан нэг хүний оруулсан мэдээллийг гуравдагч этгээдэд үзүүлэх, тухайлсан хүнд мэдээлэл дамжуулах зориулалттай функцыг гуравдагч этгээдээр ашиглуулах.

3. Энэ хуулийн “Мөшгих” гэдэг нэр томъёог дараах утгаар ойлгоно.

Бусдад өөрийн амь нас, амар тайван байдлын талаар эсхүл нэр хүндийг унагаах, үйл ажиллагааны эрх чөлөөг нь ноцтой хохирооно гэх зовнил эсхүл айдас төрүүлэхүйц үйл үйлдлүүдэд хамаарна.)

### Хүүхдийн биеэ үнэлэх, хүүхдийн порно үйлдэлд хариуцлага ногдуулах болон хүүхдийг хамгаалах тухай хууль

Энэхүү хуулиар хүүхдийн эрхийг илтэд зөрчсөн садар самууныг сурталчилсан болон хүүхдийг садар самуун, биеэ үнэлэх, эрүүгийн хариуцлага ногдуулах, хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн зорилготой. Энэхүү хуулиар интернэтээр насанд хүрээгүй хүмүүсийн порно бичлэг тараасан, бичлэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан байна.

#### 7(6) дугаар зүйлтэй холбогдох хууль журам, шийтгэлийн тухай

насанд хүрээгүй хүмүүс буюу 18 нас хүрээгүй хүмүүс биеэ үнэлсэн бол 5-аас дээшгүй

жил хорих ял оноох, эсхүл 5 саяаас ихгүй иенээр торгох ял ногдуулна. Харин хүүхдийн порно бичлэгийг тараасан этгээдэд мөн адил ял ногдуулахаар заажээ.

### Эрүүгийн хууль

222 (1) дугаар зүйл. Сүрдүүлэх:

Бусдын амь нас, эрх чөлөө, нэр хүнд, эд хөрөнгөд заналхийлж сүрдүүлсэн этгээдийг 2-оос ихгүй жилээр хорих эсхүл 300,000-аас ихгүй иенээр торгоно.

223 (1) дүгээр зүйл. Шахалт:

Бусдын амь нас, эрх чөлөө, нэр хүнд, эд хөрөнгийг доромжлол хэрцгийлэл хэрэглэж ямар ч үүрэг хүлээгээгүй өрөөл бусдаар үйл үйлдүүлэх, эсхүл бусдыг өөрийн зүй ёсны эрхээ эдлэхэд нь саад болох зэргээр заналхийлж сүрдүүлсэн этгээдийг 3 илүүгүй жилээр хорьж шийтгэнэ.

230 (1) дүгээр зүйл. Гүтгэлэг:

Олон нийтийн өмнө баримт дэлгэн мэдүүлж бусдыг гүтгэсэн этгээдийг, тухайн баримт үнэн, худлаас үл шалтгаалан, 3-аас илүүгүй жилээр хорих эсхүл ажил алба эрхлүүлэхгүй байх эсхүл 500,000-аас ихгүй иенээр торгоно.

231 дүгээр зүйл. Гутаан доромжлох:

Бусдыг олны өмнө гутаан доромжилсон этгээдийг хэдий тэр нь ямарваа баримт нотолгоо болохгүй байсан ч хөдөлмөрлөх эрхийг хасаж, жижиг гэмт хэргийн нөхцөлөөр хорих эсхүл бага хэмжээний торгууль ногдуулна.

233 дугаар зүйл. Бизнес т саад учруулах:

Буруу худал цуурхал тараах эсхүл залилан мэхлэх арга замаар бусдын бизнесийн нэр хүндийг сэвтүүлэх эсхүл саад учруулсан бол 3-аас илүүгүй жилээр хорих эсхүл 500,000-аас ихгүй иенээр торгох шийтгэл ногдуулна.

234 дүгээр зүйл. Бизнес т хүчээр саад учруулах:

Бусдын бизнес т хүчээр саад учруулсан этгээдийг өмнөх зүйлд заасны адилаар шийтгэнэ.

175(1) дүгээр зүйл. Электромагнет бичлэг агуулсан бүдүүлэг ичгүүргүй агуулгатай бичлэг үзүүлэх:

Олон нийтэд ичгүүргүй бүдүүлэг баримт, зурмал зураг, электромагнет бичлэг бүхий эсхүл бусад агуулга бүхий мэдээлэл бичлэгээр хангасан эсхүл үзүүлсэн этгээдийг 2-оос илүүгүй жилээр хорих, эсхүл 2,500,000-аас ихгүй иенээр эсхүл бага хэмжээгээр торгох, эсхүл хорих ба торгох хоёуланг нь ногдуулан шийтгэнэ. Бүдүүлэг электромагнетик бичлэг эсхүл теле харилцаагаар дамжуулсан өөр бусад бичлэг түгээсэн этгээдийг мөн энэ адил шийтгэнэ.

Зүйл 3(1)-ийн заалтаар учрах хохирлоос урьдчилан сэргийлэх тухай

Танихгүй хүмүүст эсхүл хэд хэдэн хүмүүст хувийн секс дүрс бүхий бичлэгийг теле харилцааны шугамаар дамжуулж, улмаар гуравдагч этгээд тухайн дүрс бичлэг дэх хүнийг оноон танисан тохиолдолд тухайн бичлэг дамжуулсан этгээдийг 3-аас илүүгүй жилээр хорих эсхүл 500,000-аас ихгүй иенээр торгож шийтгэнэ.



## АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-д цахим гэмт хэрэг нь ард иргэдийн аюулгүй байдал, амь нас, улс орны болон эдийн засгийн аюулгүй байдалд заналхийлж байна. Цахим гэмт хэрэг, түүнд тавих хяналт, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алхмууд, цахим орчныг зохицуулах эрх зүйн зохицуулалтууд нь гэмт хэргийн гаралт, төрлөөс хамааран улам нарийсч, боловсронгуй болсоор байна. Тус улсад цахим гэмт хэргийг Хууль зүйн яам (Department of Justice)-ны харьяа агентлаг Холбооны Мөрдөх Товчоо (Federal Bureau of Investigation) хамаарах бөгөөд хууль хэрэгжүүлэгч засгийн газрын бусад агентлагууд болон олон нийтийн байгууллагуудтай хамтран ажилладаг байна.

Холбооны Мөрдөх Товчоо нь цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хүрээнд шинээр бүтээгдсэн орчин үеийн дэвшилтэт техник болон аналитик хэрэгслүүдийг ашигладаг ч өдрөөс өдөрт шинэчлэгдэж буй цахим ертөнцөд шинэ төрлийн кибер аюултай нүүр тулсаар байна.

- Холбооны Мөрдөх Товчоо нь өөрийн 56 салбартаа тусгайлан бэлтгэсэн цахим гэмт хэрэгтэй тэмцэх тасгийг ажиллуулдаг байна. Тухайн тасаг нь үүргээ гүйцэтгэхдээ бусад агентлагийн алба, тасгуудтай хамтран ажиллана.
- Томоохон гэмт хэргийг илрүүлэн, яаралтай хариу арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд хэдхэн цагийн дотор улс орон даяар Кибер ажиллагааны шуурхай багийг бүрдүүлэн ажиллуулна.
- Дэлхийн улс орнууд дахь АНУ-ын Элчин сайдын яамдад тухайн улсын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах кибер гэмт хэрэгтэй тэмцэх төлөөлөгчийг томилон ажиллуулдаг.
- Интернет гэмт хэргийн талаар гомдол хүлээн авах төв (Internet Crime Complaint Center) нь олон нийтээс интернет гэмт хэргийн талаарх гомдлыг хүлээн авдаг. Гомдлыг хүлээн авснаар тус төвийн Иргэдийн хөрөнгийг буцаан авах, эргэн төлүүлэх баг нь кибер гэмт хэргийн хохирогчдод хэдэн зуун мянган долларыг эргүүлэн авахад тусалдаг байна.
- 7 хоногийн 24 цагаар тасралтгүй ажилладаг Кибер Хяналт (CyWatch)-ын төв нь улс орон даяар үйл ажиллагаа явуулж буй бусад салбаруудтай холбогдон, гарсан гэмт хэргийн талаар мэдээлэл өгөн, хяналт тавьж ажилладаг.

Холбооны Мөрдөх Товчоо нь кибер гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд АНУ-ын засгийн газрын туршлагатай мэргэжилтэн, шинжээчдээс бүрдсэн Үндэсний Батлан хамгаалах цахим холбоо (National Defence Cyber Alliance) болон хууль хэрэгжүүлэгчид, хувийн хэвшлийн төлөөллүүд, эрдэм шинжилгээний байгууллагуудаас бүрдсэн Үндэсний Кибер гэмт хэргийг илрүүлэх Сургалтын Холбоо (National Cyber Forensics and Training Alliance)-той хамтран ажилладаг байна.

АНУ-ын засгийн газрын бусад агентлагууд болох тагнуул болон хууль хэрэгжүүлэгч 30 орчим агентлагаас бүрдсэн Үндэсний Кибер эрэн сурвалжлах хамтарсан баг (National Cyber Investigative Joint Task Force) 2008 онд байгуулагдан, үйл ажиллагаа явуулж буй бөгөөд Холбооны Мөрдөх Товчоо тэргүүлдэг байна.

2020 оны байдлаар Интернет гэмт хэргийн талаар гомдол хүлээн авах төвд бүртгэгдсэн цахим гэмт хэргийн төрөлд Хувь хүний кредит картны дугаар, картны нууц дугаарыг мэхлэн авах (phishing) болон үүнтэй ижил төрлийн залилангийн хэргүүд хамгийн их



бүртгэгдсэн байна.<sup>209</sup>

АНУ-д цахим гэмт хэргийн төрөл болох цахим хүчирхийлэл (cyber violence), ихэвчлэн энэ төрлийн гэмт хэргийн золиос болдог хүүхэд хамгааллын асуудал анхаарлын төвд байсаар байна. Цахим хүчирхийллийн төрлүүдэд:

- Цахимаар дээрэлхэх, доромжлох, айлган сүрдүүлэх, мөшгих,;
- Цахим орчинд хүүхдэд хор хөнөөлтэй контент, материалыг хараа хяналтгүй тавих;
- Хүүхдийг цахимаар урхихдах, хуурч аргандаа оруулан гэмт хэргийн золиос болгох;
- Хүүхдийг арилжааны зорилгоор бэлгийн мөлжлөгт ашиглах зэрэг хэргүүд орно.

### **Цахимаар дээрэлхэх, доромжлох, айлган сүрдүүлэх (Cyberbullying and Cyber harassment)<sup>210</sup>**

Сургуулийн насны хүүхдүүдийн дунд нэгнийгээ дээрэлхэх, доромжлох үйлдэл (bullying) байсаар ирсэн бөгөөд байнга давтагдаж байдаг. Энэ нь цахим орчинд мөн (cyberbullying) үйлдэгдэж байна. Ихэвчлэн сургуулийн орчинд (их, дээд сургууль мөн орно) үйлдэгдэж буй энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг сургууль бүр зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэгтэй. Эдгээр үйлдлүүдийг бүгдийг гэмт хэрэгт тооцохгүй хэдий ч арьс өнгө, гарал үүсэл, нас хүйс, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл зэргээр нь ялгаварлан гадуурхаж, айлган сүрдүүлсэн (cyber harassment) тохиолдолд холбооны иргэний эрхийн тухай хуулиар зохицуулдаг байна.

Сурагч, оюутнууд энэ төрлийн хэргийн золиос болсон тохиолдолд нэн тэргүүнд сургуульдаа мэдэгдэх үүрэгтэй бөгөөд сургууль нь энэ хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх, тодорхой шат дараатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, үүссэн нөхцөл байдлыг засч залруулах үүрэгтэй байна. Хэрэв энэхүү зүй бус үйлдэл давтагдсаар байвал АНУ-ын Боловсролын яамны Иргэний эрхийг хамгаалах алба болон АНУ-ын Хууль зүйн яамны Иргэний эрхийг хамгаалах хэлтэст тус тус хандан, дараагийн шатны арга хэмжээг авч, асуудлыг шийдвэрлэх боломжтой байна.

### **Цахимаар мөшгих (Cyber stalking)**

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь ихэвчлэн хүүхэд, эмэгтэйчүүд байдаг байна. Нэгдсэн Улсын Код, Сэдэв 18 - Гэмт хэрэг болон Гэмт хэргийн үйл явц, Бүлэг 110А, Хэсэг 2261А-аар Мөшгих болон Цахимаар мөшгих гэмт хэргийг зохицуулсан байна.<sup>211</sup>

#### **2261А Мөшгих**

Хэн боловч,

(2) шуудан, олон талт компьютерийн үйлчилгээ, цахим харилцаа холбооны үйлчилгээ, муж хоорондын худалдааны цахим холбооны систем, муж хоорондын болон гадаад худалдааны бусад тоног төхөөрөмж ашиглан хэн нэгнийг алах, гэмтээх, бэртээх, айлган сүрдүүлэх, заналхийлэх зорилгоор эсхүл алах, гэмтээх, бэртээх, айлган сүрдүүлэх, заналхийлэх зорилгоор байнгын хараа хяналтандаа оруулсан бол-

(А) тухайн хүнийг айлган үхэлд хүргэсэн, ноцтойгоор гэмтээсэн, тухайн хүний тэжээвэр амьтныг алсан;

(Б) тухайн хүнийг сэтгэл санааны гүн хямрал, дарамтанд оруулсан, оруулахыг

<sup>209</sup> <https://www.statista.com/statistics/184083/commonly-reported-types-of-cyber-crime/>

<sup>210</sup> <https://www.stopbullying.gov/resources/laws/federal>

<sup>211</sup> <https://www.law.cornell.edu/uscode/text/18/2261A#>

завдсан, сэтгэл санааны гүн хямралд оруулах нь тодорхой байсан тохиолдолд, 2261 (б) болон 2261 Б-д заасан шийтгэлийг онооно.

### **2261 (б) Шийтгэл**

Хэрэв гэмт этгээд энэ гарчгийн 2261А хэсгийг зөрчсөн бол хоригдох ялаар шийтгүүлнэ-

- (1) Хохирогч нас барсан тохиолдолд насаар нь болон тодорхой хугацаагаар;
- (2) Хохирогч тахир дутуу болсон эсхүл үхэлд хүрэх хүртэл гэмтэл авсан тохиолдолд 20 жилээс ихгүй хугацаагаар;
- (3) Гэмт хэргийн үеэр хэрэгтэн аюултай зэвсэг хэрэглэсэн, хохирогчийн биед ноцтой гэмтэл учруулсан тохиолдолд 10 жилээс ихгүй хугацаагаар;
- (5) бусад тохиолдолд 5 жилээс ихгүй хугацаагаар хорих болон торгох шийтгэл онооно.
- (6) Мөшгих гэмт хэрэг үйлдэн, түр болон байнгын хугацаагаар иргэний болон эрүүгийн таслан сэргийлэх, холбоо барихыг хорих зэрэг хүлээлгэсэн хариуцлагыг зөрчсөн тохиолдолд 1 жилээс ихгүй хугацаагаар хорих шийтгэл онооно.

АНУ-д цахим хүчирхийллийн хэлбэр болох хүүхдэд хор хөнөөлтэй материал үзүүлэх, хүүхдийг садар самуунд уруу татах, хулгайлах, бэлгийн мөлжлөгийн золиос болгох зэрэг гэмт хэргүүдээс сэргийлэх зорилгоор **Цахим ертөнцөд хүүхдийн нууцыг хамгаалах тухай хууль** (Children's Online Privacy Protection Act 1998), **Интернэт орчинд хүүхдийг хамгаалах тухай хууль** (Children's Internet Protection Act 2000), **Домэйн нэр үнэн зөв байх тухай хууль** (Truth in Domain Names Act 2003), **Хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын тухай хууль** (Child Protection and Safety Act 2006), **21-р зуунд хүүхдийг хамгаалах тухай хууль** (Protecting Children in the 21<sup>st</sup> Century Act 2007), **Цахим гэмт хэргийн мэдээллийн шинэчлэлийн тухай хууль** (CyberTipline Modernization Act 2018) болон холбогдох бусад хууль тогтоомжоор цахим ертөнц дэх хүүхдийн эрхийг хамгаалдаг байна.

**Цахим ертөнцөд хүүхдийн нууцыг хамгаалах тухай хууль**-Нэгдсэн Улсын Код, Сэдэв 15, Бүлэг 91<sup>212</sup>

Тус хуулиар 13-аас доош насны хүүхэд цахим хуудсанд хандаж байгаа тохиолдолд эцэг, эхийнх нь зөвшөөрөлгүйгээр хувийн мэдээллийг нь авахгүй байх талаар хуульчилсан байна. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий Холбооны Худалдааны Комисс нь тус хуулийг хэрэгжүүлэх журмыг баталсан бөгөөд 2012 онд шинэчлэн баталж, хууль зөрчсөн компаниудад зохих арга хэмжээг ногдуулсаар ирсэн байна.

**Интернэт орчинд хүүхдийг хамгаалах тухай хууль**-Нэгдсэн Улсын Код, Сэдэв 47-254<sup>213</sup>

Тус хуулиар хүүхдийг интернэтээр зохисгүй, садар самуун материал харах, үзэхээс сэргийлсэн зохицуулалтыг хийсэн байна. Сургууль, номын сангууд нь компьютертаа зохисгүй материалыг шүүх программыг суулгах шаардлагатай бөгөөд Интернэтийн аюулгүй байдлын бодлогыг баримтлан хэрэгжүүлдэгээ баталгаажуулаагүй тохиолдолд E-rate хөтөлбөрөөс олгодог интернэтийн хөнгөлөлтийг эдлэх боломжгүй болох юм. Холбооны Харилцаа холбооны Хороо нь (Federal Communication Commission) тус

<sup>212</sup> <https://www.ftc.gov/news-events/media-resources/protecting-consumer-privacy-security/kids-privacy-coppa>  
<https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-91>

<sup>213</sup> <https://www.fcc.gov/consumers/guides/childrens-internet-protection-act>

хуулийг хэрэгжүүлэх журмыг 2001 оны эхээр батлан, 2011 онд шинэчлэн баталсан байна.

**Домэйн нэр үнэн зөв байх тухай хууль**-Нэгдсэн Улсын Код, Сэдэв 34, Бүлэг 209<sup>214</sup>

Тус хуулиар хүмүүст болон насанд хүрээгүй хүүхдэд интернэтээр зохисгүй материал үзүүлэх, садар самуунд уруу татах зорилгоор хуурамч домэйн нэр ашиглахыг хориглосон байна.

Хэрэв санаатайгаар хуурамч домэйн нэр ашиглан, хүнийг төөрөгдүүлэн садар самуунд уруу татсан тохиолдолд мөнгөн торгууль ногдуулах буюу 2 жилээс ихгүй хугацаагаар хорих эсхүл мөнгөн торгууль ногдуулах болон хорих шийтгэл давхар ногдуулна.

Хэрэв санаатайгаар хуурамч домэйн нэр ашиглан, хүүхдийг төөрөгдүүлэн садар самуунд уруу татсан тохиолдолд мөнгөн торгууль ногдуулах буюу 10 жилээс ихгүй хугацаагаар хорих эсхүл мөнгөн торгууль ногдуулах болон хорих шийтгэл давхар ногдуулна гэж заажээ.

**Хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын тухай хууль**-Нэгдсэн Улсын Код, Сэдэв 18, Бүлэг 110<sup>215</sup>

Энэ хуулийг хүчирхийллийн золиос болсон Адам Валш хүүгийн нэрээр нэрлэсэн байна. Энэ хуулиар цахим хуудас хайх явцад санаатайгаар хүнийг төөрөгдүүлсэн нэр хаяг, зураг тавьж хүмүүс, насанд хүрээгүй хүүхдийг садар самуунд уруу татах, хүүхдэд зохисгүй, хортой контент үзүүлэхийг хориглосон байна.

Түүнчлэн энэ хуулиар улс орон даяар хүчингийн хэрэгт холбогдож байсан гэмт этгээдүүдийг бүртгэлжүүлэхийг үүрэг болгосон байна. Гэмт этгээдүүдийг гэмт хэргийн шинжээс хамааран 3 ангилалд (Tier 1, 2, 3) ангилах бөгөөд 2-хүнд, 3-онц хүнд хэрэг үйлдсэн этгээдүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулахыг муж, орон нутгийн хууль сахиулагчдад үүрэг болгосон байна.

1-р ангиллын гэмт хэрэгтнүүд 15 жилийн турш, жил бүр оршин суугаа газрынхаа цагдаагийн газарт бүртгүүлнэ.

2-р ангиллын гэмт хэрэгтнүүд 25 жилийн турш, 6 сар тутам оршин суугаа газрынхаа цагдаагийн газарт бүртгүүлнэ.

3-р ангиллын гэмт хэрэгтнүүд насан туршдаа, 3 сар тутам оршин суугаа газрынхаа цагдаагийн газарт бүртгүүлнэ.

Бүртгэл хийлгээгүй тохиолдолд хууль зөрчсөнд тооцон, хариуцлага хүлээлгэнэ.

**21-р зуунд хүүхдийг хамгаалах тухай хууль**-Нэгдсэн Улсын Код, Сэдэв 15, Бүлэг 91A<sup>216</sup>

Энэ хуулиар хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий Холбооны Худалдааны Комисст Хүүхдийн аюулгүй интернэт хэрэглээг дэмжих хөтөлбөр боловсруулан улс орон даяар хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байна. Тус хөтөлбөр нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хэрэглэж буй интернэтийн аюулгүй байдлыг хангах арга хэрэгслүүдээс шилдэг туршлагыг шалгаруулан, урамшуулах, олон нийтэд түгээх, танилцуулах, ялангуяа интернэтийн аюулгүй болон зохистой хэрэглээ, цахим орчинд

<sup>214</sup> <https://www.law.cornell.edu/uscode/text/34/subtitle-II/chapter-209>

<sup>215</sup> <https://www.congress.gov/bill/108th-congress/senate-bill/800/text>

<sup>216</sup> <https://www.ftc.gov/enforcement/statutes/protecting-children-21st-century-act>  
<https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-91A>

олон нийтийн сүлжээгээр үл таних хүнтэй хэрхэн харилцах, цахимаар доромжлох, дээрэлхэх үйлдлээс хэрхэн сэргийлэх, хариу өгөх талаар хүүхэд, өсвөр насныханд сургах, таниулах сургалтын хөтөлбөрүүдийг багтаасан байх шаардлагатай байна. Холбооны Худалдааны Комисс нь жил бүр Конгресст хуулиар хүлээсэн энэхүү үүргийнхээ хэрэгжилтийн тайланг танилцуулах шаардлагатай байна.

**Цахим гэмт хэргийн мэдээллийн шинэчлэлийн тухай хууль**-Нэгдсэн Улсын Код, Сэдэв 18, Бүлэг 110-2258A<sup>217</sup>

АНУ-д үйл ажиллагаа явуулж байгаа цахимаар үйлчилгээ эрхлэгчид нь хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, садар самуун үйлдэлд ашигласан материалын талаар мэдсэн тохиолдолд хууль сахиулагч байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй байна.

АНУ-ын Хууль зүйн яамны **Хүүхдийг садар самуун, бэлгийн мөлжлөгөөс хамгаалах алба** (Child Exploitation and Obscenity Section) нь 1987 онд байгуулагдсан бөгөөд садар самууныг сурталчлахаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргээс хүүхдийг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй бөгөөд 2002 онд **Дэвшилтэт технологи ашиглан мөрдөн шалгах нэгж** (High Technology Investigative Unit)-ийг дотооддоо байгуулан, орон даяар үйл ажиллагаа явуулдаг 94 салбар нэгжээр дамжуулан, цахимаар үйлдэгдэх энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлж, илрүүлж ажиллах болсон байна. Тус алба нь 2006 оноос Аюулгүй хүүхэд нас хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлжээ.<sup>218</sup>

Тус алба нь хүүхэд хамгаалах дээрх болон хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох үйл ажиллагаанд холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилладаг байна.<sup>219</sup>

## ИБУИНХУ

ИБУИНХУ-д 2020 онд 46,6 сая хүн өдөр бүр интернэт ашигладаг. Их Британид нийт өрхийн дийлэнх хувь нь онлайнаар холбогдох боломжтой байгаа бол 2019 оны байдлаар нийт өрхийн 7 хувь нь интернэтэд холбогдоогүй байна гэж ONS мэдээлсэн. Евростат энэ үзүүлэлтийг илүү өндөр буюу интернэт холболттой өрхүүдийн 96 хувь, ЕХ-ны дунджаас 90 хувиас дээгүүр байна гэж тооцоолжээ.<sup>220</sup>

ИБУИНХУ-д Үндэсний Гэмт хэрэгтэй тэмцэх Агентлаг (National Crime Agency)<sup>221</sup> нь үндэсний хэмжээнд цахим болон бусад төрлийн гэмт хэрэгтэй тэмцдэг байна. Тус улсад цахим гэмт хэрэг нь цар хүрээний хувьд өргөсөж, илүү нарийн, ярвигтай болсоор байна. Хувь хүмүүсийг эрүүл мэнд болон эдийн засгийн хувьд хохироох, аюул, эрсдэлд оруулахаас авахуулаад зайлшгүй шаардлагатай төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг тасалдуулах, доголдуулах, цаашлаад үндэсний аюулгүй байдалд заналхийлэх хэмжээний хэргүүд цахимаар үйлдэгдэж, тооцож баршгүй хохирол учруулдаг байна.

Хувь хүн болон байгууллагууд нь аюулгүй байдлаа хангаагүйн улмаас цахим гэмт хэрэг үйлдэгсдийн өгөөш болсоор байна. Гэмт хэрэгтнүүд нууц үг, баримт мэдээлэл зэргийг хулгайлж гэмт хэрэгтээ ашиглахаас гадна данснаас шууд мөнгө хулгайлах зэргийг цахимаар үйлдэж байна. Цахимаар хамгийн их үйлдэгдэж буй гэмт хэргийн төрлүүдэд:

<sup>217</sup> <https://uscode.house.gov/view.xhtml?req=granuleid:USC-prelim-title18-section2258A&num=0&edition=prelim>

<sup>218</sup> <https://www.justice.gov/criminal-ceos>

<sup>219</sup> <https://www.justice.gov/criminal-ceos/citizens-guide-us-federal-child-exploitation-and-obscenity-laws>

<sup>220</sup> <https://www.statista.com/statistics/275786/daily-internet-users-in-great-britain/>

<sup>221</sup> <https://www.nationalcrimeagency.gov.uk/what-we-do/crime-threats/cyber-crime>

- Нийгмийн сүлжээ болон цахим шуудангийн нууц үг ашиглан хакердах
- Хуурамч цахим шуудан ашиглан аюулгүй байдлын мэдээлэл, хувийн мэдээлэл авах (phishing)
- Хортой програм хангамж-гэмт хэрэгтнүүд файлуудыг хулгайлж компьютерийн систем болон сүлжээнд халдах (malicious software)
- Мөнгө хулгайлах зорилгоор цахим хуудас руу халдах ингэхдээ тухайн цахим хуудасны сүлжээ болон серверийг хэт их ачааллах замаар үйлдэх (Distributed denial of service) зэрэг ордог байна.

Цахим гэмт хэрэг нь дэлхий нийтийг хамарсан аюул болоод байгаа учир олон улсын байгууллагууд, улс орнууд хоорондын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай байна. Тус улсын Үндэсний Гэмт хэрэгтэй тэмцэх Агентлаг нь Их Британи улсын цагдаагийн газар, бүсийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх нэгжүүд, олон улсын хууль сахиулах байгууллагууд, тухайлбал Европол, Холбооны Мөрдөх Товчоо, АНУ-ын Тагнуулын Алба зэрэгтэй мэдээ мэдээллээ хуваалцан хамтарч ажиллахын зэрэгцээ хувийн хэвшлийнхэнтэй техникийн туршлагаа хуваалцан, үр дүнтэйгээр хамтран ажилладаг байна.

Түүнчлэн иргэд, олон нийт, бизнес эрхлэгчдийг цахим халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч ажилладаг. Үүнд, Үндэсний Цахим Аюулгүй байдлын Төв (National Cyber Security Center)<sup>222</sup>, тус төвийн харьяа зөвлөгөө өгөх төв, Аюулгүй интернэт хэрэглээний талаар мэргэжилтний зөвлөгөө өгөх төв (Get Safe Online Free expert advice)<sup>223</sup> зэрэг олон байгууллагууд багтана.

Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх агентлаг нь цахим орчинд гэмт хэрэг үйлдэгч өсвөр насныхан болон залуучуудыг цахим хэрэгтэн болохоос сэргийлж, тэдгээрийн цахим орчинд ажиллах ур чадварыг зөвөөр ашиглах, хаана ажиллах боломжтой талаар зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор тэдэнтэй болон эцэг эхтэй нь уулзаж ярилцах, гэмт хэргээс холдуулах шат дараатай арга хэмжээг авах Цахим сонголт (CyberChoices) аянг зохион байгуулдаг байна.

Их Британи улсад цахим гэмт хэргийн төрөл болох цахим хүчирхийллийг иргэний болон эрүүгийн хуулиудаар зохицуулдаг. Цахим хүчирхийллээс хүүхдийг хамгаалах, уг гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдэж буй насанд хүрээгүй хүүхдийг ялангуяа дахин хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэрэгт нэн тэргүүнд анхаарч ажилладаг байна.

### **Цахимаар дээрэлхэх, доромжлох, айлган сүрдүүлэх (Cyberbullying and Cyber harassment)**

Дээрэлхэх, доромжлох (bullying), үүнийг мөн цахимаар үйлдэхэд (cyberbullying) **Компьютерийн зүй бус хэрэглээний тухай хууль** (Computer Misuse Act 1990)<sup>224</sup>, **Айлган сүрдүүлэхээс хамгаалах тухай хууль** (Protection from Harassment Act 1997)<sup>225</sup>, **Гэмт хэрэгтэнд хариуцлага тооцох ба нийтийн хэв журмыг сахиулах тухай хууль** (Criminal Justice and Public Order Act 1994)<sup>226</sup>, **Тэгш эрхийн тухай хууль** (Equality Act

<sup>222</sup> <https://www.ncsc.gov.uk/>

<sup>223</sup> <https://www.getsafeonline.org/>

<sup>224</sup> <https://www.legislation.gov.uk/ukpga/1990/18/contents>

<sup>225</sup> <https://www.legislation.gov.uk/ukpga/1997/40/contents>

<sup>226</sup> <https://www.legislation.gov.uk/ukpga/1994/33/contents>



2010)<sup>227</sup>, **Хор нөлөөтэй харилцаа холбооны тухай хууль** (Malicious Communications Act 1988)<sup>228</sup>, **Харилцаа холбооны тухай хууль** (Communications Act 2003)<sup>229</sup>, **Боловсрол болон хяналт шалгалтын тухай хууль** (Education and Inspections Act 2006)<sup>230</sup>–аар тус тус зохицуулдаг байна.

Тухайн хүний нийгмийн сүлжээ болон цахим шуудангийн хаягны нууц үгийг хулгайлан дээрэлхэх, доромжлох гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд **Компьютерийн зүй бус хэрэглээний тухай** хуулиар шийдвэрлэнэ.

Аливаа холбоо, харилцааны хэрэгсэл ашиглан хүнийг айлган сүрдүүлж, айдас түгшүүрт автуулах, сэтгэл санааны гутралд оруулах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд **Хор нөлөөтэй харилцаа холбооны тухай** хуулиар шийдвэрлэдэг байна.

Мөн бүдүүлгээр доромжилсон, зохисгүй, садар самуун болон сүрдүүлсэн, заналхийлсэн цахим зурвас илгээх нь **Харилцаа холбооны тухай** хуулийн 127-р хэсэгт заасны дагуу гэмт хэрэгт тооцогдоно.

**Боловсрол болон хяналт шалгалтын тухай** хуулиар сургуулийн удирдлагад сургууль, сургалтын байгууллагын эргэн тойронд суралцагч хүүхдүүд болон багш сурган хүмүүжүүлэгчдэд эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж ажиллахыг үүрэг болгосон байна. Түүнчлэн энэ хуулиар бусад сурагчдыг дээрэлхэх, доромжлох, айлган сүрдүүлэх үйлдэл байнга үзүүлж буй сурагчдыг хүмүүжүүлэх, сахилга бат сахиулах тодорхой эрхийг (тухайлбал, үүрэн телефоны утсыг хураан авах зэрэг) багш, сурган хүмүүжүүлэгчдэд олгосон бөгөөд хүчирхийлэл үйлдэгч хүүхдүүд болон тэдгээрийн эцэг, эхчүүдэд хүчирхийлэл нь тэвчиж болшгүй гэмт үйлдэл болохыг ойлгуулж, үүнийг таслан зогсоохын тулд удаа дараа хүчирхийлэл үйлдэгч хүүхдийн эцэг эхийг шүүхийн шийдвэрээр хүүхдээ хүмүүжүүлэх албадан сургалтанд хамруулах, цаашлаад 1000 хүртэлх фунт стерлингийн торгууль ногдуулах хүртэл арга хэмжээ авахаар хуульчилсан байна.

Мөшгих (stalking) болон цахимаар мөшгих (cyberstalking) хэргийг **Айлган сүрдүүлэхээс хамгаалах тухай** хуулийн 2А хэсгээр зохицуулна. Энэ хуулиар мөшгих гэмт хэргийн хохирогчийг хамгаалахаар заасан хэдий ч цахим халдлагын хохирогчийг давхар хамгаалдаг байна.

Тус хуулиар мөшгинө гэдэгт хэн нэгнээс салахгүй, байнгын хойноос нь даган, айдаст автуулах үйлдлийг хэлнэ гэжээ. Тодорхой хохирогчтой байнга, тогтмол холбоо барих, холбоо барих оролдлогууд тасралтгүй хийх үйлдлийг мөшгих гэнэ. Мөшгих болон цахимаар мөшгих гэмт хэрэг нь хохирогчийг байнга айлган сүрдүүлж, сэтгэл санаа болон бие махбодын хохирол учруулдаг тул хохирлын хэмжээ болон гэмт үйлдлээс хамааран 6 сараас 5 жил хүртэл хугацаанд хорих ялаар шийтгэхээр хуульчилсан байна.

**Дижитал Эдийн засгийн тухай хууль** (Digital Economy Act 2017)-ийн 103-р хэсэгт зааснаар засгийн газар нь нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчдэд зориулж, нийгмийн сүлжээгээр зүй бус, гэмт хэргийн шинжтэй дээрэлхсэн, доромжилсон, айлган сүрдүүлсэн утга агуулга бүхий материалыг нийтлэх, түгээхийг хориглох, холбогдох байгууллагад мэдэгдэх тухай гарын авлага боловсруулан, хэрэгжүүлж ажиллахыг хуульчилсан байна.

<sup>227</sup> <https://www.gov.uk/bullying-at-school>

<sup>228</sup> <https://www.legislation.gov.uk/ukpga/1988/27>

<sup>229</sup> <https://www.legislation.gov.uk/ukpga/2003/21/contents>

<sup>230</sup> <https://www.legislation.gov.uk/ukpga/2006/40/contents>



Хүүхдийг цахимаар садар самуунд уруу татах, хулгайлах, хүчирхийлэх, бэлгийн мөлжлөгийн золиос болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагууд нэгдэн үйл ажиллагаагаа явуулдаг байна. Засгийн газар, хууль сахиулагчид, эрдэм шинжилгээний байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, болон эцэг эхчүүдийн төлөөллөөс бүрдсэн Их Британийн Хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах зөвлөл (UK Council for Child Internet Safety) нь хүүхэд, залуусын цахим орчны аюулгүй байдлыг хангахын төлөө үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Үндэсний Гэмт хэрэгтэй тэмцэх Агентлагийн харьяа Хүүхдийн мөлжлөг ба Онлайн хамгааллын төв (Child Exploitation and Online Protection Center) нь хүүхэд багачуудыг гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлж, эцэг эхчүүд, багш сурган хүмүүжүүлэгчид болон хүүхдүүдэд зориулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох төрөл бүрийн зөвлөгөө мэдээллийг багтаасан ThinkUKnow<sup>231</sup> цахим хуудсыг ажиллуулдаг.

Хүүхдэд харгис хэрцгий хандахаас урьдчилан сэргийлэх Үндэсний Нийгэмлэг (National Society for the Prevention of Cruelty to Children) нь хүүхдийн хүчирхийллийг таслан зогсоохын төлөө тэмцэгч, сайн дурын тэргүүлэгч байгууллага юм. Тус байгууллага нь хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд туслах, аюулд өртөж болзошгүй хүүхдүүдийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Тус байгууллага нь 1883 онд үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ.

**Хүүхэд хамгааллын тухай хууль** (Protection of Children Act 1978), **Бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль** (Sexual Offences Act 2003) болон холбогдох бусад хуулиар хүүхдийг бэлгийн мөлжлөгийн золиос болохоос урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэгтэнд хариуцлага ногдуулах зэрэг харилцааг зохицуулдаг байна. Эдгээр хуулиудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд засгийн газрын харьяа Боловсролын газар (Department for Education) нь “Хүүхдийн аюулгүй сурах орчныг бүрдүүлэх” удирдамжийг боловсруулан, сургалтын байгууллага болон эцэг эхчүүдэд мөрдүүлэн ажиллаж байна.



---

<sup>231</sup> <https://www.thinkuknow.co.uk/>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Хууль, тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль
- Эрүүгийн хууль
- Зөрчлийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Садар самуунтай тэмцэх тухай хууль
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
- Зар сурталчилгааны тухай хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)
- ЗГ-ын 2018 оны 276 дугаар тогтоол
- ХХМТГ-ын даргын 2020 оны А/68 дугаар тушаал

### Олон улсын баримт бичиг

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Хүүхдийн эрхийн тухай конвенц
- Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

### Ном

- Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь, Л.Галбаатар, 2015 он
- Монгол Улсын шүүхийн тайлан, Шүүхийн 2020 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ, 2021 он

### Бусад материал

- Монгол Улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ 2020, Хүүхдийг Ивээх Сан, 2021 он
- Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэл, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, 2020 он
- Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сургалт, судалгаа мэдээллийн төв. 2018 он.
- Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаарх судалгааны тайлан, Харилцаа холбооны зохицуулах хороо. 2021 он
- Цагдаагийн байгууллагад 2021 оны эхний 3 сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

### Цахим хуудас

- Цахим орчин дахь хүүхдийн хамгаалалт 2020” бодлого боловсруулагчдад өгөх удирдамж, Guidelines for policy-makers on Child Online Protection 2020,

[https://www.itu.int/en/ITU-D/Cybersecurity/Documents/COP/Guidelines/2020-translations/S-GEN-COP.POL\\_MAKERS-2020-PDF-E.pdf](https://www.itu.int/en/ITU-D/Cybersecurity/Documents/COP/Guidelines/2020-translations/S-GEN-COP.POL_MAKERS-2020-PDF-E.pdf)

- Цахим орчин хүүхэд хамгаалал сэдэвт хэвлэмэл фостерын сан, Харилцаа холбооны зохицуулах хороо  
[http://ekids.mn/Home/newsdetail?dataID=22012&fbclid=IwAR2YroLWF0HURKca5LdAYWTQH5Fr5kGOy5JwOxQICEOer\\_x\\_7CNkqt\\_QixY](http://ekids.mn/Home/newsdetail?dataID=22012&fbclid=IwAR2YroLWF0HURKca5LdAYWTQH5Fr5kGOy5JwOxQICEOer_x_7CNkqt_QixY)
- <https://www.verywellfamily.com/types-of-cyberbullying-460549>
- <https://kidshealth.org/en/parents/cyberbullying.html>
- <https://www.gov.uk/bullying-at-school>
- Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар <https://dashboard.cita.gov.mn/>
- Цахим гэмт хэргийн талаарх онцлох баримтууд, Тагнуулын ерөнхий газар. <https://gia.gov.mn/49/item/643>
- Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах салбар дундын ажлын хэсэг хуралдаж байна. <https://mlsp.gov.mn/content/detail/805>
- Цахим орчин дахь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, <http://www.be-in.com/10/rightsdec.html>
- Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал, Монгол Улсын Тагнуулын ерөнхий газар, <https://gia.gov.mn/12/item/709>
- НҮБ-ын Хүүхдийн сангийн мэдээллийн төв, “Ковид-19 ба Хүүхдүүд” [https://data.unicef.org/covid-19-and-children/?utm\\_source=UNICEF%20Data&utm\\_medium=homepage&utm\\_campaign=COVID19-hub-unicef-data-hero-image](https://data.unicef.org/covid-19-and-children/?utm_source=UNICEF%20Data&utm_medium=homepage&utm_campaign=COVID19-hub-unicef-data-hero-image)

#### Герман

- <https://www.asianlaws.org/docs2019/reports/Mapping%20study%20on%20cyberviolence.pdf>
- [https://www.jugendschutz.net/fileadmin/download/pdf/Report\\_2019\\_Children\\_on\\_the\\_Internet.pdf](https://www.jugendschutz.net/fileadmin/download/pdf/Report_2019_Children_on_the_Internet.pdf)
- <https://www.jugendschutz.net/en/index.html>
- <https://germanlawarchive.iuscomp.org/?p=724>
- Interstate Treaty on the Protection of Minors in the Media [https://www.kjm-online.de/JMStV\\_in\\_English\\_\\_19th\\_Interstate\\_Broadcasting\\_Treaty.pdf](https://www.kjm-online.de/JMStV_in_English__19th_Interstate_Broadcasting_Treaty.pdf)
- Criminal Code (Strafgesetzbuch, StGB) <https://germanlawarchive.iuscomp.org/?p=752>
- НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ <http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/14077.pdf>

#### Япон

- Links to domestic policies, strategies or responses to cyberviolence.
- [http://www.npa.go.jp/safetylife/syonen/no\\_cp/measures/index\\_e.html](http://www.npa.go.jp/safetylife/syonen/no_cp/measures/index_e.html)
- The Protection of Human Rights (see pp.25-26)
- <http://www.moj.go.jp/content/001247391.pdf>
- [https://www8.cao.go.jp/youth/youth-harm/law/pdf/for\\_english.pdf](https://www8.cao.go.jp/youth/youth-harm/law/pdf/for_english.pdf)
- <https://prtimes.jp/main/html/rd/p/000002198.000001594.html>

#### АНУ

- <https://www.statista.com/statistics/184083/commonly-reported-types-of-cyber-crime/>
- <https://www.stopbullying.gov/resources/laws/federal>

- <https://www.law.cornell.edu/uscode/text/18/2261A#>
- <https://www.ftc.gov/news-events/media-resources/protecting-consumer-privacy-security/kids-privacy-coppa>
- <https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-91>
- <https://www.fcc.gov/consumers/guides/childrens-internet-protection-act>
- <https://www.law.cornell.edu/uscode/text/34/subtitle-II/chapter-209>
- <https://www.congress.gov/bill/108th-congress/senate-bill/800/text>
- <https://www.ftc.gov/enforcement/statutes/protecting-children-21st-century-act>
- <https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-91A>
- <https://uscode.house.gov/view.xhtml?req=granuleid:USC-prelim-title18-section2258A&num=0&edition=prelim>
- <https://www.justice.gov/criminal-ceos>

#### ИБУИНХУ (Англи)

- <https://www.justice.gov/criminal-ceos/citizens-guide-us-federal-child-exploitation-and-obscenity-laws>
- <https://www.statista.com/statistics/275786/daily-internet-users-in-great-britain/>
- <https://www.nationalcrimeagency.gov.uk/what-we-do/crime-threats/cyber-crime>
- <https://www.ncsc.gov.uk/>
- <https://www.getsafeonline.org/>
- <https://www.legislation.gov.uk/ukpga/1990/18/contents>
- <https://www.legislation.gov.uk/ukpga/1997/40/contents>
- <https://www.legislation.gov.uk/ukpga/1994/33/contents>
- <https://www.gov.uk/bullying-at-school>
- <https://www.legislation.gov.uk/ukpga/1988/27>
- <https://www.legislation.gov.uk/ukpga/2003/21/contents>
- <https://www.legislation.gov.uk/ukpga/2006/40/contents>
- <https://www.thinkuknow.co.uk/>



**АМЬД БА АМЬГҮЙ ДОНОР, НАСНЫ БАЙДАЛ, ТҮҮНИЙ АР ГЭРТ ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ  
ДЭМЖЛЭГИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨМЖ БА  
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

(Харьцуулсан судалгаа)

*Д.Амаржаргал (Ph.D), Б.Батцэцэг,  
О.Нарантуяа*

**АГУУЛГА**

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АМЬД БА АМЬГҮЙ ДОНОР, ТҮҮНИЙ АР ГЭРИЙНХЭНД ҮЗҮҮЛЭХ  
ДЭМЖЛЭГ БОЛОН НАСНЫ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОДЛОГО, ЗӨВЛӨМЖ

Амьд ба амьгүй донор ба түүний ар гэрийнхэнд үзүүлэх дэмжлэг, урамшууллын  
талаар

ДЭМБ-ын Хүний эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах талаар баримтлах зарчим

Европын Зөвлөлөөс гаргасан Амьд ба амьгүй донорын бие ба эрхтэнтэй  
холбоотой санхүүгийн ашиг сонирхлыг хориглох зарчмыг хэрэгжүүлэх гарын  
авлага

Дэлхий дахинд элэгний амьд донорт олгох санхүүгийн дэмжлэг

Олон улсад амьд донорын насны байдал

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ДОНОРЫН НАС БА ДЭМЖЛЭГТЭЙ ХОЛБООТОЙ БУСАД  
ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Америкийн Нэгдсэн Улс

Сингапур улс

Литва улс

Хорват улс

Бүгд Найрамдах Молдова улс

БНСУ

Турк улс

Финланд улс

Энэтхэг улс

Япон улс

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгааг захиалагчийн хүсэлтийн дагуу хөгжингүй болон хөгжиж буй орнуудаас АНУ, Сингапур, Латви, Хорват, Молдав, Солонгос, Турк, Энэтхэг, Япон зэрэг орнуудыг хамруулж, амьд ба амьгүй донор, түүний ар гэрийнхэнд үзүүлэх санхүүгийн болон нийгмийн дэмжлэг, насны байдлын талаарх асуудлыг хэрхэн зохицуулсныг холбогдох хууль, эрх зүйн орчны хүрээнд судалсан болно.

Судалгааны явцад эдгээр орнуудын эс, эд, эрхтний донорт холбогдох хууль, тогтоомжуудыг судалсанаас гадна Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-ын Хүний эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах талаар баримтлах зарчим, Европын Зөвлөлөөс гаргасан Амьд ба амьгүй донорын бие ба эрхтэнтэй холбоотой санхүүгийн ашиг сонирхлыг хориглох зарчмыг хэрэгжүүлэх гарын авлага, амьд ба амьгүй донор, түүний ар гэрийнхэнд үзүүлэх дэмжлэг болон насны байдлын талаар судалсан олон улсын судалгааны ажлуудын дүгнэлтээс түүвэрлэн орууллаа.

**Түлхүүр үг:** ДЭМБ-ын зөвлөмж, амьд донорын насны байдал, амьгүй донорын ар гэрийнхэнд үзүүлэх дэмжлэг, олон улсын зөвлөмж

**Keywords:** WHO guideline, living donor, deceased donor, financial incentives for donor, international recommendation

**Судалгааны үр дүнгийн тойм:** Судалгааны тайлан нь хоёр хэсгээс бүрдэх бөгөөд Нэгдүгээр хэсэгт, амьд ба амьгүй донороос эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах насны байдал болон өөрт нь эсвэл ар гэрийнхэнд нь үзүүлэх дэмжлэгийн талаарх олон улсын туршлага, олон улсад баримталж буй бодлогын талаар судалсан болно. Хоёрдугаар хэсэгт, хөгжингүй болон манай улстай хөгжлийн түвшин ойролцоо орнуудын донор болон эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчны хүрээнд насны байдал, донорт болон ар гэрийнхэнд үзүүлэх дэмжлэгийн талаарх асуудлуудыг судаллаа.

ДЭМБ-аас улс орон бүр өөрийн хүн амын эс, эд, эрхтний донор болон шилжүүлэн суулгах хэрэгцээг хангах үндэсний түвшний үүрэг хариуцлагатай байхыг засгийн газруудад уриалсан ба энэ хүрээнд донор ба эд эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг дэлхий дахины ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн хэрэгжүүлэх, ялангуяа “ДЭМБ-ын Хүний эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах талаар баримтлах зарчим”-ыг мөрдөхийг зөвлөжээ.

Энэ зарчимд донорын насны байдлын тухай заахдаа: тухайн улсын хуульд тодорхой заагаагүй бол шилжүүлэн суулгах зорилгоор насанд хүрээгүй хүний биеэс эс, эд, эрхтэн авах ёсгүй бөгөөд тэднийг хамгаалах тал дээр зохих арга хэмжээг авах ёстой гэж

заажээ. Улмаар хүүхэд эс, эд, эрхтэн хандивлах тохиолдолд түүний зөвшөөрлийг удаа дараа авах ёстой гэсэн байна.

Харин донорт болон түүний ар гэрийнхэнд үзүүлэх санхүүгийн ба бусад дэмжлэгийн талаар заахдаа: хүний эс, эд, эд эрхтнийг аливаа мөнгөн төлбөр, бусад шагналгүйгээр хандивлах ёстой гэдэг зарчмыг онцолсон байх ба хэрэв амьд ба амьгүй донорын хамаатан садан албан шахалтанд орсон, төлбөр төлөх хэлбэр болгосон, бусдад ашиглагдсаны улмаас эс, эд эрхтний хандив өгч байгаа бол бол эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүд шилжүүлэн суулгах мэс заслыг хийх ёсгүй бөгөөд эрүүл мэндийн даатгагч болон бусад төлбөр төлөгч талууд энэ үйлдэлд оролцох ёсгүй гэж



анхааруулжээ. Гэвч эдгээр заалт нь донорын гаргасан зардлыг нөхөх, шилжүүлэн суулгасны дараах нөхөн сэргээх, боловсруулах, хадгалах, нийлүүлэх зардлыг төлөхөд хамаарахгүй гэсэн байна.

Европын Зөвлөлөөс гаргасан “Амьд ба амьгүй донорын бие ба эрхтэнтэй холбоотой санхүүгийн ашиг сонирхлыг хориглох зарчмыг хэрэгжүүлэх” гарын авлагад санхүүгийн ашиг сонирхол гэдэгт амьд ба амьгүй донорын гэр бүл эсвэл өөр гуравдагч этгээдэд шууд ба шууд бус хэлбэрээр төлөх төлбөр, урамшууллыг ойлгоно гэж заасан. Учир нь энэ нь нийгмийн хамгийн эмзэг давхаргын хүмүүсийг эс, эд, эрхтний мөлжлөгт өртөх эрсдэлийг дагуулдаг. Гэхдээ санхүүгийн ашиг олохыг хориглох зарчим нь дараах зүйлст саад болох ёсгүй гэжээ. Үүнд:

- ✓ амьд донорын орлогоо алдсаны нөхөн олговор, эрхтэн, эд, эсийг авах, эсвэл холбогдох эмнэлгийн үзлэгээс үүссэн бусад үндэслэл бүхий зардал;
- ✓ эрхтэн, эд, эсийг авсаны үр дүнд гэмтэл гарсан тохиолдолд олгох нөхөн төлбөр.

Мөн санхүүгийн ашиг олохыг хориглох нь хандивтай холбогдон гарсан эмнэлгийн болон холбогдох техникийн үйлчилгээний төлбөрийг төлөхөд саад болохгүй гэсэн байна.

Амьгүй донор ба түүний ар гэрийнхэнд өгөх санхүүгийн болон бусад дэмжлэг хэдийгээр олон улсын зөвлөмжийн дагуу дэмжигддэггүй боловч амьд донорын хувьд санхүүгийн болон бусад дэмжлэг улс орнуудад харьцангуй өөр, олон янзын зохицуулалттай байна. аар зохиц ДЭМБ-ын эрхтэн шилжүүлэн суулгах ажиглалтын төвд бүртгэгдсэн санд жилд 10 буюу түүнээс дээш тоогоор амьд донороос элэг шилжүүлэн суулгалт хийдэг нийт 37 орныг хамруулан судлахад 26 оронд амьд донорын санхүүгийн ачааллыг хөнгөвчлөхөд тодорхой хэмжээний туслалцаа үзүүлдэг байна. Үүнд тухайлбал, эрүүл мэндийн даатгалд хамруулах, ажилгүй байсан үеийн цалин хөлсний нөхөн олговор, ажлын байрыг хамгаалах, элэг хандивласны дараах эрүүл мэндийн хүндрэлийн эмчилгээ үйлчилгээ, хүүхэд асрах үйлчилгээ, байр, хоол, аяллын зардлыг нөхөх олгох зэрэг дэмжлэгүүд багтаж байна. Эдгээрээс ээс 14 улсад ажилгүй байх үед нь цалин хөлс, эсвэл цалинтай чөлөө олгодог байна. Тухайлбал, Белгид цалингийн 60%-тай тэнцэх тэтгэмжийг тодорхой хугацааны туршид олгодог. Зарим оронд музей, үзвэрийн газруудад үнэ төлбөргүй нэвтрэх, автомашины зогсоол ашиглах, агаарын тээврээр зорчиход хөнгөлөлт үзүүлэх, байрны зээл болон эмнэлгийн төлбөрөөс чөлөөлөх зэрэг урамшууллын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг байна. Судалгаанд авагдсан орнуудын амьд донорын насны байдал, амьд ба амьгүй донор, түүний ар гэрийнхэнд нь үзүүлэх санхүүгийн болон бусад дэмжлэгийн талаарх эрх зүйн орчныг харьцуулан судлахад дараах байдалтай байна.

СУДАЛГААНЫ САН

	Хууль	Донорын насны байдал	Санхүүгийн ба бусад дэмжлэг
АНУ	Үндэсний эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль (The national Organ Transplant act)	Амьд донорын насны доод болон дээд хязгаарыг 18-60 нас гэж тогтоосон байх ба сайн дурын үндсэн дээр зөвшөөрөл олгоно.	Унаа, байр, хоол болон холбогдох бусад зардал, ажиллаагүй үеийн цалин хөлс олгох, донорын хүүхэд болон ахмад настныг асрах зардал, мэс заслын төлбөр, дараагийн үзлэгүүдийн төлбөр болон татварын хөнгөлөлт үзүүлэх, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах зэрэг зохицуулалттай.
Сингапур Улс	“Хүний эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль” (Human organ transplant Act) болон Эрүүл мэндийн эмчилгээ, боловсрол, судалгааны тухай хууль (Medical Therapy, Education and Research Act)	21 насанд хүрсэн, эрх зүйн чадамжтайэтгээд донор болох хүсэлтээ бичгээр сайн дурын үндсэн дээр гаргах ба түүнд бие даасан Зөвшөөрөл олгох комиссоос зөвшөөрсөн тохиолдолд эд, эс, эрхтнийг авахыг зөвшөөрнө.	Хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулиар эд, эрхтэн хандивлах нь бусдын амь насыг аврах буяны үйлс гэж тодорхойлсон тул амьгүй донорын гэр бүлийн гишүүдэд нөхөн олговор олгох, мөн ар гэрийнхэн нь ямар нэгэн хариу төлбөр шаардахыг хуулиар хоригложээ
Латви улс	Донорын үйл ажиллагаа болон хүний эд, эс, эрхтнийг шилжүүлэн суулгах тухай” хууль (Law On Donation And Transplantation Of Human Tissues, Cells And Organs)	Насанд хүрээгүй амьд донороос нөхөн төлжих боломжтой эд, эсийг шилжүүлэн суулгаж болно.	Донорын үйл ажиллагаа болон хүний эд, эс, эрхтнийг шилжүүлэн суулгах тухай хуулийн 13 дугаар зүйлд нас барсан эсвэл амьд хүний эд, эс, эрхтэн нь арилжааны зорилготой байж болохгүй. Санхүүгийн ашиг олох эсвэл үр дүн санал болгох зорилгоор эд, эс, эрхтний хэрэгцээ, бэлэн байдлын талаар сурталчлахыг хориглоно.
Хорват улс	Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль ( Organ Transplant Law)	Амьд донороос эрхтэн шилжүүлэн суулгах тохиолдолд донор бичгээр зөвшөөрөл өгсөн байх бөгөөд насанд хүрээгүй болон эрх зүйн чадамжгүй хүн бол түүний хууль ёсны төлөөлөгч буюу асран хамгаалагчаас зөвшөөрөл авч, эрхтэн шилжүүлэн суулгах шийдвэрийг эмнэлгийн байгууллагын ёс зүйн хороо шийдвэрлэнэ.	Хорватын иргэд эсвэл байнгын оршин суугч нь эрхтнээ үнэгүй хандивлана.
Бүгд Найрамдах Молдова Улс	“Хүний эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль” (On The Transplant of Human Organs, Tissues and Cells)	18 насанд хүрсэн, эрх зүйн чадамжтай хүн донор болох хүсэлтээ сайн дурын үндсэн дээр бичгээр гаргаж, түүнийг нь бие даасан Зөвшөөрөл олгох комиссоос зөвшөөрсөн тохиолдолд эд, эс, эрхтнийг авахыг зөвшөөрнө.	Тус улсын хувьд нөхөн олговор олгох талаар хуулийн зохицуулалт байхгүй байна.

Солонгос улс	Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль ( Organ Transplant Law)	Амьд донороос эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах тохиолдолд тухайн хүнээс заавал зөвшөөрөл авах бөгөөд 16-аас дээш насны насанд хүрээгүй донор, 16-аас доош насны хүүхдийн цус болон ясны чөмөгний донор болох тохиолдолд хүүхдийн болон түүний эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна.	Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулийн 32 дугаар зүйлд эрхтний донор болсон хүмүүст оршуулгын болон эмчилгээний зардал, эрхтний донорын үзлэг хийлгэх, донор болох зэргээр эмнэлэгт хэвтэх хугацаанд цалинтай чөлөө олгох, донорын гэр бүлийхэнд зориулсан дурсгалын болон хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах, холбогдох бусад байгууллагатай харилцахад дэмжлэг үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн үнэгүй зөвлөгөө өгөх гэх мэт.
Турк улс	“Эд, эрхтэн авах, хадгалах, шилжүүлэн суулгах тухай хууль” (Organ Transplantation Law)	Амьд донорын нас 18 хүрсэн байхаар хуульчилсан бөгөөд хамгийн багадаа хоёр гэрчийг байлцуулж, бусдын дарамт шахалтаас ангид зөвхөн өөрийн хүсэл зоригоор урьдчилан бичгээр үйлдэж, гарын үсэг зурсан тэмдэглэл үйлдэх, эсхүл хамгийн багадаа хоёр гэрчийг байлцуулж амаар илэрхийлэн зөвшөөрөл өгч гарын үсэг зурсан тэмдэглэлийг холбогдох эмч нь баталгаажуулсан байх шаардлагатай.	Эд, эрхтэн авах, хадгалах, шилжүүлэн суулгах тухай хуулийн 1 дүгээр бүлэгт Нийтлэг үндэслэлийг хуульчлахдаа “Төлбөртэйгөөр, эсхүл ямар нэгэн ашиг сонирхлыг хангах зорилгоор эд, эрхтнийг авах, худалдан борлуулахыг хориглоно;” гэж заасан бөгөөд энэхүү зохицуулалт амьд донорын хувьд ч, амьгүй донорын хувьд ч нэгэн адил үйлчилж байна.
Финланд	Хүний эд, эс, эрхтнийг анагаахын зорилгоор ашиглах тухай хууль (No. 101/2001 Act on the Medical Use of Human Organs, Tissues and Cells),	Донор нь насанд хүрээгүй буюу 18 насанд хүрээгүй тохиолдолд эд, эс, эрхтнийг шилжүүлэн авахаас өмнө түүний хууль ёсны төлөөлөгчийн бичгээр гаргасан зөвшөөрлийг авах ёстой.	Хүний эд, эс, эрхтнийг анагаахын зорилгоор ашиглах тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар эд, эс, эрхтний донор болон хүлээн авсан этгээд нь хандив, төлбөр авахгүй. Эрүүл мэндийн даатгалын тухай (Health insurance act <sup>232</sup> ) хуульд зааснаар эд, эс, эрхтнийг шилжүүлэн суулгасны улмаас орлогын алдагдал хүлээсэн, эрхтэн шилжүүлэн суулгах хэрэгцээ шаардлагын улмаас хяналт, шинжилгээ өгөх тохиолдолд донор нь өдрөөр тооцож тэтгэмж авах эрхтэй.
Энэтхэг Улс	“Хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль” (The transplantation of human organs act) “	Хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулийн 2 дугаар бүлэгт “амьд донор” гэж 18 нас хүрсэн, өөрийн сайн дураар эд, эс, эрхтнээ хандивлахыг зөвшөөрсөн хүнийг хэлнэ гэж заасан	Засгийн газраас донорын үйл явцыг дэмжих зорилгоор амьгүй донорын ар гэрт эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажиллагааг эрхлэн явуулсан эмнэлгээр насан туршдаа оношлуулах, эмчлүүлэх урамшуулал олгож байхаар төлөвлөж байна. Үүнээс гадна,

<sup>232</sup> [https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2004/en20041224\\_20110911.pdf](https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2004/en20041224_20110911.pdf)

			ирээдүйд амьгүй донорын ар гэрийн амьдралын баталгааг дэмжих зорилгоор хүлээн авагчаас 2 жилийн дотор нэг удаа тусламж авахыг зөвшөөрөх, мөн төрөөс 3 жилд нэг удаа даатгалд хамруулах боломжтой болгох юм.
Япон Улс	“Эрхтэн шилжүүлэх тухай хууль” (Organ Transplant Law)	15 насанд хүрсэн иргэн сайн дурын үндсэн дээр өөрийн гэр бүлийн гишүүнд эрхтэн хандивлахыг зөвшөөрснөө бичгээр мэдэгдэж донор болно.	Эд эрхтэн хандивлах нь хариу төлбөргүй бөгөөд сайн үйлсийн шинжтэй байдаг тул амьгүй донорын гэр бүлийн гишүүд, ар гэрт нь ямар нэгэн нөхөн олговор олгодоггүй байна. Харин эд эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой эмнэлгийн болон бусад шаардлагатай зардлыг хүлээн авагч тал бүрэн хариуцдаг.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АМЬД БА АМЬГҮЙ ДОНОР, ТҮҮНИЙ АР ГЭРИЙНХЭНД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ БОЛОН НАСНЫ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОДЛОГО, ЗӨВЛӨМЖ

#### **Амьд ба амьгүй донор ба түүний ар гэрийнхэнд үзүүлэх дэмжлэг, урамшууллын талаар**

Амьгүй донорт үзүүлэх дэмжлэгийг санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг гэж хуваан авч үзнэ. Санхүүгийн урамшуулал нь эс, эд, эрхтнээ хандивлах зөвшөөрлийг нь авах зорилгоор үнэ бүхий зүйл өгөхийг хэлнэ. Жишээлбэл, эрхтний үнийг чөлөөт зах зээлийн зарчмаар тогтоох буюу эрх бүхий зохицуулах байгууллагаас тогтоосон үнийн дагуу төлбөр хийж болно. Зарим тохиолдолд татварын хөнгөлөлт авахын тулд буяны хандив өгдөгтэй адилаар эд эрхтний хандив өгөх тохиолдол ч байдаг. Ийм урамшуулалд бэлэн мөнгө, оршуулгын зардал эсвэл буяны хандив зэрэгт зориулагдсан тодорхой зорилго бүхий мөнгөн төлбөр; эрүүл мэндийн даатгал зэрэг үнэ бүхий үйлчилгээ орно. Санхүүгийн урамшуулал нь донорт нас барахаас өмнө эсвэл нас барсных нь дараа түүний эзэмшилд шилжих хэлбэрээр явагдана. Хэрэв донорын гэр бүл хандив өгөх шийдвэр гаргасан тохиолдолд урамшуулал нь гэр бүлд нь очдог.<sup>233</sup>

Амьгүй донорт олгох санхүүгийн бус урамшуулалд нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх хэлбэр буюу олон нийтийн талархал, одон, түрүүлж эрхтэн шилжүүлэн суулгах эрх олгох гэх мэт хэлбэрээр явагддаг. Энэ нь эрхтний донор болохоор бүртгүүлсэн хүмүүс түрүүлж эрхтэн шилжүүлэн суулгах эрх олгох буюу эсвэл гэр бүлийнхэн нь тийм эрхээр хангагдахыг хэлнэ.

#### **Нөхөн төлбөр нь эрхтний хангамжийг бодитойгоор нэмэгдүүлэх үү?**

Амьгүй донорт санхүүгийн урамшуулал олгож эс, эд, эрхтний хангамжийг нэмэгдүүлэхийг дэмжигчид амьгүй донорын ар гэрийнхэнд тодорхой хэмжээний төлбөр төлөх нь тэдний зөвшөөрөл өгөх магадлалыг эрс нэмэгдүүлнэ гэж үздэг. Учир нь практик дээр нас барсан хүний цогцсоос гэр бүлийнхэнд нь ямар нэгэн ашиг гарахгүй гэж үздэг байна.

Гэтэл санхүүгийн дэмжлэг ба эрхтэн хандивлах хүсэл эрмэлзлийн хоорондох хамаарал нь зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдах, худалдан авах хэв загварт тэр бүр нийцдэггүй. Өдгөө олон хүмүүс нас барсныхаа дараа донор болох хүсэлт гаргах нь нэмэгдсээр байгаа бөгөөд нас барагсдын гэр бүлийн талаас илүү хувь нь ямар нэгэн нөхөн төлбөр авалгүйгээр донор болгохыг зөвшөөрч байна. Гэвч санхүүгийн дэмжлэгийг нэвтрүүлснээр гэр бүлийнхнийх нь сайн санааны үүднээс хандивлаж буй сэдлийг өөрчилж, эсрэгээрээ нас барагсдын эрхтнийг үнэлж чадахгүй байх нөхцөл үүсгэж, гэр бүлийнхэн нь зөвшөөрөл өгөхөөс татгалзах байдалд хүргэж ч болзошгүй юм. Туршилт судалгаагаар амьгүй донорын эд эрхтнийг хандивлахад урамшуулал олгох тогтолцоог нэвтрүүлэхэд, ар гэрийнхэн нь ухаан орохгүй байгаа гэр бүлийн гишүүнийхээ амьдрал дэмжигч аппаратын хэрэглээг уртасгаж байсан нь тогтоогдсон байна.

ДЭМБ-аас улс орон бүр өөрийн орны хүн амын эд, эрхтний донор болон шилжүүлэн суулгах хэрэгцээг хангах үндэсний түвшний үүрэг хариуцлага хүлээхийг байхыг засгийн

<sup>233</sup> Liverman, C. T., & Childress, J. F. (Eds.). (2006). Organ donation: Opportunities for action. National Academies Press.

газруудад уриалсан. Үүнийг үндэсний өөрийгөө хангах чадвар<sup>234</sup> гэдэг ойлголтоор илэрхийлж байна. Үндэсний өөрийгөө хангах чадварыг бүрдүүлэхийн тулд дараах цогц арга хэмжээг үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Хууль тогтоомжийн хүрээнд хяналт зохицуулалтын бодлогыг тусгах;
- Амьгүй донорын хөтөлбөрийг эрүүл мэндийн тогтолцоонд суулгах;
- Амьд донорын аюулгүй байдлыг хангах ёс зүйг мөрдөх;
- Донор ба эд эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг дэлхий дахины ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн хэрэгжүүлэх, ялангуяа “ДЭМБ-ын Хүний эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах талаар баримтлах зарчим”-ыг мөрдөх нь зүйтэй.<sup>235</sup>

ДЭМБ-ын Хүний эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах талаар баримтлах зарчим<sup>236</sup>

1. Нас барсан хүний биеэс эс, эд, эрхтэн авч дараах тохиолдолд шилжүүлэн суулгаж болно.

(а) хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан

(б) нас барсан хүн үүнийг эсэргүүцсэн гэж үзэх үндэслэлгүй

2. Донор нас барсан болохыг тогтоож буй эмч донорын биеэс эс, эд, эрхтэн авах үйл ажиллагаанд оролцож болохгүй. Мөн уг эс, эд, эрхтнийг хүлээн авахаар төлөвлөж буй өвчтөнийг асран хамгаалах үйл ажиллагаанд оролцох ёсгүй.

3. Амьгүй донороос авсан эс, эд, эрхтнийг эмчилгээний зорилгоор ашиглахдаа хамгийн дээд түвшинд хүртэл хөгжүүлэх ёстой. Харин амьд донорын хандивыг дотоодын журамд заасны дагуу зохицуулна. Ерөнхийдөө амьд донор нь хүлээн авагчтай удам зүй, хууль эрх зүй, сэтгэл зүйн хувьд холбоотой байх ёстой.

Амьд донор сайтар мэдээлэл авсны үндсэн дээр эдийн тохироо бүрдсэн байх шалгуурыг хангасан тохиолдолд сайн дурын зөвшөөрлийг өгөх ба тэдний аюулгүй байдлыг мэргэжлийн үүднээс хангах ёстой. Донорт учирч болзошгүй эрсдэл, үр дагаврыг бүрэн, ойлгомжтой байдлаар мэдээлэх ёстой. Донор нь аливаа хууль бус нөлөө, албадлагаас ангид хууль эрх зүйн хувьд бүрэн чадамжтай байх ба авсан мэдээллээ үнэлж, цэгнэсний үндсэн дээр өөрийн хүслээр шийдвэрээ гаргах ёстой.

4. Тухайн улсын хуулийн дагуу зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд шилжүүлэн суулгах зорилгоор насанд хүрээгүй хүний биеэс эс, эд, эрхтэн авах ёсгүй. Энэ талаар насанд хүрээгүй хүүхдийг хамгаалах тодорхой арга хэмжээ авах ёстой бөгөөд хэрэв хандивлах тохиолдолд хүүхдийн зөвшөөрлийг удаа дараа авах ёстой. Насанд хүрээгүй хүнд хамааралтай эдгээр зүйл нь эрх зүйн чадамжгүй хүнд ч бас хамаарна.

5. Эс, эд, эд эрхтнийг аливаа мөнгөн төлбөр, бусад шагналгүйгээр хандивлах ёстой. Шилжүүлэн суулгах зорилгоор эс, эд, эрхтэнг худалдаж авах, худалдаж авахыг санал болгох, эсвэл амьгүй донорын хамаатан садан эс, эд, эрхтнийг нь зарахыг хориглох хэрэгтэй. Энэ заалт нь донорын гаргасан зардлыг нөхөх, шилжүүлэн суулгасны дараах нөхөн сэргээх, боловсруулах, хадгалах, нийлүүлэх зардлыг төлөхөд хамаарахгүй.

<sup>234</sup> National self-sufficiency

<sup>235</sup> Delmonico, F. L., Domínguez-Gil, B., Matesanz, R., & Noel, L. (2011). A call for government accountability to achieve national self-sufficiency in organ donation and transplantation. *The Lancet*, 378(9800), 1414-1418.

<sup>236</sup> World Health Organization. (2010). WHO guiding principles on human cell, tissue and organ transplantation. *Transplant Journal of Australasia*, 19(2), 26-30.



6. Хүний эс, эд, эрхтний сайн санааны хандивыг сурталчлах, олон нийтийн уриалга хийх, сурталчлах ажлыг дотоодын журмын дагуу хийж болно.

Аливаа нас барсан хүн өөрөө болон хамаатан садан нь эс, эд, эрхтнийг төлбөртэйгээр санал болгох, эсвэл худалдан авах зорилгоор хэрэгцээ ба бэлэн байдлыг сурталчлахыг хориглох хэрэгтэй. Ийм худалдаа наймааг зуучлахыг хориглох хэрэгтэй.

7. Хэрэв холбогдох эс, эд, эрхтнийг хандивлагч донор эсвэл амьгүй донорын хамаатан садан албан шахалтанд орсон, төлбөр төлөх хэлбэр болгосон, ашиглагдсаны улмаас өгч байгаа бол эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүд шилжүүлэн суулгах мэс заслыг хийх ёсгүй бөгөөд эрүүл мэндийн даатгагч болон бусад төлбөр төлөгч талууд энэ үйлдэлд оролцох ёсгүй.

8. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах процедурт оролцдог бүх эрүүл мэндийн байгууллагууд, мэргэжилтнүүд үзүүлсэн үйлчилгээний төлбөрөөс хэтэрсэн төлбөрийг авахыг хориглох ёстой.

9. Эрхтэн, эс, эд эсийг хуваарилахдаа санхүүгийн болон бусад зүйлээр бус эмнэлзүйн шалгуур, ёс зүйн хэм хэмжээг баримтлах хэрэгтэй. Зохих хороодын тодорхойлсон эс, эд, эрхтэн хуваарилалтын дүрэм нь тэгш, үндэслэл бүхий, ил тод байх ёстой.

10. Өндөр чанартай, аюулгүй, үр дүнтэй процедур нь донор болон хүлээн авагчийн аль алинд зайлшгүй шаардлагатай байдаг. Тиймээс эс, эд, эрхтэн хандивласан, шилжүүлэн суулгасны дараах урт хугацааны үр дүнг амьд донор болон хүлээн авагчийг хянаж, үнэлснээр, ашигтай тал болон хор хөнөөлийг нь баримтжуулна.

Шилжүүлэн суулгаж буй хүний эс, эд, эрхтнүүд нь онцгой шинж чанартай эрүүл мэндийн бүтээгдэхүүн тул аюулгүй байдал, үр нөлөө, чанарын түвшинг тогтмол шалгаж, сайжруулж байх ёстой. Энэ нь дотооддоо болон гадаадад хэрэглэгдэх хүнээс гаралтай бүтээгдэхүүний сөрөг үр дагавар, гаж нөлөөг мэдээлэх, хянах, сэрэмжлэх зэрэг чанарын тогтолцоог хэрэгжүүлэхийг шаарддаг.

11. Хандив, шилжүүлэн суулгах үйл ажиллагааны зохион байгуулалт, гүйцэтгэл, түүнчлэн эмнэлзүйн үр дүн нь ил тод, хяналт шинжилгээ хийхэд нээлттэй байх ёстой бөгөөд донор ба хүлээн авагчийн хувийн нууцлыг чанд хамгаалж байх ёстой.

Европын Зөвлөлөөс гаргасан Амьд ба амьгүй донорын бие ба эрхтэнтэй холбоотой санхүүгийн ашиг сонирхлыг хориглох зарчмыг хэрэгжүүлэх гарын авлага<sup>237</sup>

Энэхүү баримт бичиг нь Биологи, анагаах ухааны хэрэглээнд хүний эрх ба нэр хүндийг хамгаалах: Хүний эрх ба био анагаахын тухай конвенцид (ETS № 164; Овьедогийн конвенц) заасны дагуу амьд ба амьгүй донорын бие ба биеийн хэсэгтэй холбоотойгоор санхүүгийн ашиг олохыг хориглох зарчмыг хэрэгжүүлэх зөвлөмжийг өгдөг.

Донортой холбоотой санхүүгийн ашиг олохыг хориглох зарчим нь дараах зүйлийг баталгаажуулах зорилготой юм.

- ▶ амьд донор ба хүлээн авагчийн нэр хүнд, хүний эрхийг хүндэтгэх;
- ▶ амьгүй донорын бие махбодийн салшгүй байдлыг хангах;

<sup>237</sup> Guide for the implementation of the principle of prohibition of financial gain with respect to the human body and its parts from living or deceased donors <https://rm.coe.int/guide-financial-gain/16807bfc9a>

- ▶ сайн санааны хандивыг сурталчлах;
- ▶ хандивлагдсан биеийн хэсгүүдийн аюулгүй, чанартай байдлыг баталгаажуулсанаар хүмүүсийн итгэж болох хандивын тогтолцоог хадгалахад хувь нэмэр оруулна. Хүний бие ба түүний хэсэгтэй холбоотой санхүүгийн ашиг сонирхолд амьд ба амьгүй донорын гэр бүл эсвэл өөр гуравдагч этгээдэд шууд ба шууд бус хэлбэрээр төлөх төлбөр, урамшууллыг оруулж ойлгоно. Учир нь нийгмийн хамгийн эмзэг давхаргын хүмүүсийг мөлжлөгт өртөх эрсдэлийг дагуулдаг.

Санхүүгийн ашиг олохыг хориглох нь дараах зүйлд саад болох ёсгүй.

- ▶ амьд донорын орлогоо алдсаны нөхөн олговор, эрхтэн, эд, эсийг авах, эсвэл холбогдох эмнэлгийн үзлэгээс үүссэн бусад үндэслэл бүхий зардал;
- ▶ эрхтэн, эд, эсийг авсны үр дүнд гэмтэл гарсан тохиолдолд олгох нөхөн төлбөр.

Тиймээс донор нь санхүүгийн хувьд төвийг сахисан байх ёстой.

Санхүүгийн ашиг олохыг хориглох нь хандивтай холбогдон гарсан эмнэлгийн болон холбогдох техникийн үйлчилгээний төлбөрийг төлөхөд саад болохгүй.

Энэхүү зарчим нь хандивын зорилгоос үл хамааран хүний бие махбодь эсвэл түүний хэсгийг хандивлахад хамаарна.

### **Дэлхий дахинд элэгний амьд донорт олгох санхүүгийн дэмжлэг**

ДЭМБ-ын эрхтэн шилжүүлэн суулгах ажиглалтын төвд бүртгэгдсэн санд жилд 10 буюу түүнээс их тоогоор амьд донороос элэг шилжүүлэн суулгалт хийдэг нийт 37 орныг хамруулан судлахад 26 оронд амьд донорын санхүүгийн ачааллыг хөнгөвчлөх тодорхой хэмжээний туслалцаа үзүүлдэг байна. Үүнд эрүүл мэндийн даатгалд хамруулах, ажилгүй байсан үеийн цалин хөлсний нөхөн олговор, хөдөлмөр эрхлэлтийг хамгаалах, элэг хандивласны дараах эрүүл мэндийн хүндрэлийн эмчилгээ үйлчилгээ, хүүхэд асрах үйлчилгээ, байр, хоол, аяллын зардлын нөхөх олговрууд багтаж байна. Үүнээс 14 улсад ажилгүйдлийн цалин хөлс эсвэл цалинтай чөлөө олгодог байна. Тухайлбал, Белгид цалингийн 60%-тай тэнцэх тэтгэмжийг тодорхой хугацаанд олгодог. Зарим оронд музей, үзвэрийн газруудад үнэ төлбөргүй нэвтрэх, автомашины зогсоол, агаарын тээврээр зорчиход хөнгөлөлт үзүүлэх, байрны зээл болон эмнэлгийн төлбөрөөс чөлөөлөх зэрэг урамшууллын өвөрмөц хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна.<sup>238</sup>

Азийн улс орнуудад энэ талын нөхөн төлбөр олгох механизм байхгүй, эсвэл муу хөгжсөн байна. Элэг шилжүүлэн суулгалт өндөртэй Египет улсад өнөөг хүртэл эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой хуулийн зохицуулалт байхгүй боловч донор олох үнэлгээний судалгааг элэг хүлээн авагч өөрөө төлдөг байна. Сингапур улсад мөн нөхөн төлбөр олгох албан ёсны хөтөлбөр байдаггүй бөгөөд донор хүлээн авагчаас тодорхой санхүүгийн дэмжлэг авч болдог байна. Харин Пакистан, Энэтхэг, Өмнөд Солонгост донорт гаргах зардлыг дэмждэггүй эсвэл энэ талын тогтолцоо хөгжөөгүй байна. Энэтхэг, Иран, Израиль болон АНУ-д элэгний хандивын дараах хяналтын хугацааг 12 сараас 5 жил гэж зааж өгсөн байна.

Элэг хандивласны улмаас гарсан эмнэлгийн бус зардлыг 14 оронд тодорхой хэмжээнд

<sup>238</sup> Emamaullee, J., Tenorio, L., Khan, S., Butler, C., Kim, S., Tucker-Seeley, R., ... & Genyk, Y. (2020). Living donor financial assistance programs in liver transplantation: The global perspective. *Clinical Transplantation*, 34(11), e14073.

нөхөн төлбөр олгодог. Герман, Турк, Хятад, Чили, Сингапурт нөхөн төлбөр олгох албан ёсны хөтөлбөр байдаггүй ч донор нөхөн төлбөрөө шилжүүлэн суулгах төвүүд, донор эсвэл хүлээн авагчийн эрүүл мэндийн даатгал, эсвэл хүлээн авагчаас шууд гаргуулж авдаг. Герман ба Туркэд нийтийн эрүүл мэндийн даатгалаар санхүүжилт олгодог. Сингапур ба Хятад улс хувийн эрүүл мэндийн сангаас нөхөн төлбөрийг төлдөг бөгөөд Чилид нийтийн ба хувийн сангийн аль алиныг нь ашигладаг.

Хойд Америкт нөхөн төлбөр олгох хөтөлбөрүүд сайн хөгжсөн байдаг ба Канадад муж бүрт өөрөөр зохицуулдаг бол АНУ-д Амьд донорыг дэмжих үндэсний төвөөс орлогод суурилан 6000 хүртэлх долларыг хоол хүнс, байр, унааны урьдчилгаа төлбөрт олгодог. Үүнтэй адил Азид Израиль ба Саудын Арабт засгийн газраас нь нөхөн төлбөрийн санхүүжилтийн багцыг гаргадаг.

### **Олон улсад амьд донорын насны байдал**

Амьд донор болох хүсэлтэй өсвөр насныхан болон залуу хүмүүст тийм зөвшөөрөл олгох нь олон талын бэрхшээл дагуулдаг. ДЭМБ-аас өсвөр насыг 10-19 насны хүүхэд гэж тодорхойлдог ба хүний шийдвэр гаргах чадвартай холбоотой тархины хэсгүүдийн хөгжил 20 насны дунд үе хүртэл хөгжсөөр байдаг. Тиймээс зарим залуу хүний хувьд донор болсны улмаас өөрт үүсэх мэс заслын нөлөө, эрсдэлийг үнэлэх чадвар суухаасаа өмнө хууль эрх зүйн боломжтой болчих магадлалтай юм. Түүнээс гадна ихэнх залуу донор санхүүгийн болон сэтгэлзүйн хувьд эцэг, эх эсвэл хэн нэгнээс хамааралтай байдаг тул өргөж буй хандив нь сайн дурын шинжтэй эсэхийг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг.<sup>239</sup>

Амьд донорын насны байдлын хувьд улс бүр өөр өөр зохицуулалттай байна. Канадын муж бүр өөрийн гэсэн хуультай тул 16-19 настай хүүхэд хууль ёсоор донор болохыг зөвшөөрдөг.

<b>Канадын мужуудын нэр</b>	<b>Донор болоход зөвшөөрөгдөх нас</b>
Онтарио, Принц Эдвардын арал	16 нас
Алберта, Манитоба, Саскачеван, Квебек	18 нас
Бритиш Колумб, Нью Брансвик, Ньюфондлад ба Лабрадор, Нортвест Территори, Нова Скотиа, Нунавут, Юкон	19 нас

Харин амьгүй донорын хувьд хууль ёсны төлөөлөгч нь дээрх насанд хүрээгүй байсан ч зөвшөөрөл олгож болно. Канадын зарим мужуудад онцгой заалтууд үйлчилдэг. Жишээлбэл, Альберта мужид 18-аас доош насны хүүхдүүд донор болоход эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлөөс гадна бие даасан үнэлгээний хороо донор болох гэж буй хүүхэд ямар нэг хүч, ятгалганд автаагүй бөгөөд эрсдэл багатай гэж үнэлсэн тохиолдолд зөвшөөрнө. Манитоба мужид 16-18 насны хүүхдийг өөрөө донор болох зөвшөөрөл өгөх чадвартай гэсэн сэтгэцийн эмчийн дүгнэлтээс гадна хууль ёсны асран хамгаалагчийн зөвшөөрөл ба хүлээн авагч нь зөвхөн цөм гэр бүлийн гишүүн байвал зөвшөөрдөг. Альберта, Манитоба мужийн аль алинд 16-аас доош насны хүүхдүүдэд зөвхөн нөхөн төлжих чадвартай эдээ хандивлахыг зөвшөөрдөг.

Англи, Уэльс, Умард Ирландад амьд донорын насны доод хязгаар байдаггүй. Шотландад

<sup>239</sup> Campbell, M., Wright, L., Greenberg, R. A., & Grant, D. (2013). How young is too young to be a living donor?. American Journal of Transplantation, 13(7), 1643-1649.

зөвхөн 16-аас дээш насны хүн амьд донор болохыг хууль ёсоор зөвшөөрдөг. Европын олон оронд насанд хүрээгүй хүнийг донор болохыг хуулиар хориглодог ба зарим газарт зөвшөөрсөн ч өсвөр насны хүүхэд донор болох нь ховор байдаг. 2006 онд хэвлэгдсэн судалгаагаар Франц ба Герман улсад насанд хүрээгүй хүн амьд донор болсон тохиолдол бүртгэгдээгүй байна. Мөн Их Британид 1986-2005 оны хооронд насанд хүрээгүй хүн амьд донор болсон тохиолдол гурван удаа л бүртгэгдсэн байна.

Амьд донор болохыг зөвшөөрсөн нас АНУ-н ихэнх мужид 18 нас байдаг ба зарим тохиолдолд онцгой заалт үйлчилдэг. Калифорни мужид 15 настай донорууд эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлөөр хандив өгч болно. 1987-2000 оны хооронд АНУ-д 18-аас доош насны 60 хүн бөөрөө хандивласан байна. Хамгийн залуу донор нь 10 настай хүүхэд байсан бөгөөд ихэр эгчдээ бөөрөө шилжүүлэн суулгах зөвшөөрөл өгсөн байна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ДОНОРЫН НАС БА ДЭМЖЛЭГТЭЙ ХОЛБООТОЙ БУСАД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-д 1984 онд Үндэсний эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль (The national Organ Transplant act) батлагдсанаар эрхтэн худалдан авах, шилжүүлэн суулгах сүлжээг бий болгох, эрхтэн шилжүүлэн суулгах байгууллага байгуулах, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх зэрэг эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой харилцааг зохицуулсан. Өнөөгийн байдлаар эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой харилцааг Үндэсний эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль, Эрхтэн хандивлах, нөхөн сэргээх үйл ажиллагааг сайжруулах тухай хууль (The Organ Donation and Recovery Improvement Act), Амьдралын бэлэг конгрессийн медалын хууль (the Gift of Life Congressional Medal Act), Амьдралын бэлэг татварын хөнгөлөлтийн хууль (The Gift of Life Tax Credit Act), Эрхтний донорыг сайжруулах тухай хууль (The Organ Donation Improvement Act), Амьд эрхтний донорын ажлын байрны аюулгүй байдлын тухай хууль (The Living Organ Donor Job Security Act), Эрхтний хандивыг сэргээх, сайжруулах тухай хууль (The Organ Donation Recovery and Improvement Act) зэрэг хууль тогтоомжоор зохицуулж байна.

#### Амьд донорын насны байдал:

Амьд донорын насны доод болон дээд хязгаарыг 18-60 нас гэж тогтоосон бөгөөд сайн дурын үндсэн дээр донор болж болно.

#### Донор ба түүний ар гэрт олгох нөхөн олговор:

Амьд донорын нөхөн олговрын хөтөлбөрийг “Амьд донорыг дэмжих үндэсний төв” хэрэгжүүлдэг бөгөөд дараах төрлийн дэмжлэгийг үзүүлдэг<sup>240</sup>. Тухайлбал, унаа, байр, хоол болон холбогдох бусад зардал, алдагдсан цалин хөлс, донорын хүүхэд болон ахмад настныг асрах зардал, мэс заслын төлбөр болон дараагийн үзлэгийн төлбөрүүдийг төвөөр дамжуулан олгодог.

Мөн бусад хууль тогтоомжид зааснаар дараах дэмжлэгийг үзүүлдэг.

- Хуульд заасны дагуу донор эсвэл түүний гэр бүлд дурсгалын медаль өгөх
- Татварын хөнгөлөлтийн хуулийн дагуу 17 муж<sup>241</sup> улсад эрхтний болон чөмөгний донорт татварын дэмжлэг (Луизанна муж орлогын албан татвараас 10.000 долларын татварын хөнгөлөлт) үзүүлж байна.

<sup>240</sup> <https://www.organdonor.gov/about/process/living-donation.html>

<sup>241</sup> Arkansas, Georgia, Idaho, Iowa, Louisiana, Maryland, Massachusetts, Minnesota, Mississippi, New Mexico, New York, North Dakota, Ohio, Oklahoma, South Carolina, Utah, Virginia, and Wisconsin  
<https://www.americantransplantfoundation.org/2012/11/15/tax-incentives-and-organ-donation/>

## СИНГАПУР УЛС

Сингапур Улсад 1970 онд анх удаа амьгүй донороос бөөр авч шилжүүлэн суулгах мэс заслыг хийсэн бол 1990 онд анх удаа зүрх болон элэг шилжүүлэн суулгах мэс засал хийгдсэн байна. Орчин үед тус улсад бөөр, элэг, зүрх, уушги, арьс, яс болон нүдний эвэрлэгийг шилжүүлэн суулгах мэс заслууд амжилттай хийгдэж байна. Одоо Сингапурт эрхтэн шилжүүлэн суулгах харилцааг “Хүний эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль” (Human organ transplant Act)<sup>242</sup> болон Эрүүл мэндийн эмчилгээ, боловсрол, судалгааны тухай хууль (Medical Therapy, Education and Research Act)<sup>243</sup>-р тус тус зохицуулж байна.

### Амьд донорын насны байдал:

Хүний эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулийн 5 дугаар бүлэгт амьд донороос эд, эс, эрхтэн авахтай холбоотой харилцаа болон зөвшөөрөл олгох бие даасан комиссын бүрэн эрхийг тогтоож өгсөн байна. Амьд донороос эд, эс, эрхтэн авахыг гагцхүү эдийн тохироо бүрдсэн амьгүй донорын эд, эс, эрхтэн байхгүй тохиолдолд зөвшөөрнө. Ингэхдээ 21 насанд хүрсэн, эрх зүйн чадамж бүхий этгээд нь донор болох хүсэлтээ бичгээр сайн дурын үндсэн дээр гаргаж, түүнийг бие даасан Зөвшөөрөл олгох комиссоос зөвшөөрсөн тохиолдолд эд, эс, эрхтнийг авахыг зөвшөөрнө.

Амьд донорт эрхтэн хандивлах явцад үүссэн зардлыг олгох, эрүүл мэндийг даатгалыг нөхөн төлж болно.

### Донор ба түүний ар гэрт олгох нөхөн олговор:

Хүний эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуульд зааснаар 21 нас хүрмэгц иргэн бүрд донор болохоос татгалзах тухай анкет бүхий танилцуулгыг хүргүүлдэг ба донор болохоос татгалзах бол холбогдох баримт бичгийг бөглөж буцаан хүргүүлэх үүрэгтэй. Ийнхүү татгалзсан байдлаа хүргүүлээгүй тохиолдолд тухайн хүнийг нас барсаныхаа дараа донор болохыг зөвшөөрсөнд тооцдог. Үүнийг Opt out тогтолцоо гэдэг.

Хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулийн 2 дугаар бүлэгт нас барсны дараа эд, эрхтнийг авахтай холбоотой харилцааг амьгүй донор болохыг тархины үхлийн эмнэлзүйн нарийн шалгуурыг баримтлан хоёр өөр эмч болон хяналтын ажилтны зөвшөөрлийг авах ба хяналтын ажилтныг тусгайлан хуулиар томилно гэж заасан байна. Хяналтын ажилтан нь эмнэлэгт нас барсан этгээдээс эд, эрхтэн авах зөвшөөрлийг гаргах ба дараах этгээдээс эд, эрхтнийг авахыг хориглоно. Үүнд:

- Амьд байхдаа, 21 нас хүрэх үедээ донор болохоос татгалзсан этгээд;
- Сингапурын иргэн бус, эсхүл байнгын оршин суугч бус этгээд;
- Асран хамгаалагч нь зөвшөөрөл олгоогүй бөгөөд 21 нас хүрээгүй этгээд;
- Асран хамгаалагч, эсхүл эцэг эх нь зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд сэтгэцийн өвчтэй этгээд.

Сингапур Улсын иргэд, байнгын оршин суугчдын 74.2 хувийг хятад үндэстэн эзэлдэг бөгөөд Хятадын уламжлалт соёл, Күнзийн сургаалтай холбоотойгоор гэр бүлийн гишүүд ойр дотнын хүнээ нас барсны дараа эд, эрхтнийг нь хандивлах зөвшөөрөл

<sup>242</sup> <https://sso.agc.gov.sg/Act/HOTA1987>

<sup>243</sup> <https://sso.agc.gov.sg/Act/MTERA1972>



гаргах нь ховор байдаг. Иймд тус улсын Хүний эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулиар эд, эрхтэн хандивлах нь бусдын амь насыг аврах буяны үйлс гэж тодорхойлсон тул амьгүй донорын гэр бүлийн гишүүдэд нөхөн олговор олгох, мөн ар гэрийнхэн нь ямар нэгэн хариу төлбөр шаардахыг хуулиар хоригложээ.

## ЛИТВА УЛС

Литва Улсад донор болон эд, эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой харилцааг 1999 онд батлагдсан “Донорын үйл ажиллагаа болон хүний эд, эс, эрхтнээ шилжүүлэн суулгах тухай” хууль (Law On Donation And Transplantation Of Human Tissues, Cells And Organs)-иар зохицуулж байна.

Эрүүл мэндийн сайдын баталсан журмын дагуу өөрийн эд, эс, эрхтнээ шилжүүлэн суулгахаар хандивлахыг зөвшөөрч, хүсэлт гаргасан эрх зүйн чадамжтай этгээд донор болж болно. Мөн эрх зүйн чадамж бүхий этгээд бүр дээрх журамд заасны дагуу нас барсныхаа дараа донор болох буюу амьгүй донор болохоос татгалзах эрхтэй. Амьгүй донороос эд, эс, эрхтэн авахдаа нас барагч амьд байхдаа донор болохоос татгалзаагүй бол гэр бүлийн гишүүний зөвшөөрлийг авна.

Гэр бүлийн гишүүний зөвшөөрлийг авах эрэмбийг дараах байдлаар тогтоосон байна.<sup>244</sup>

- Эхнэр, нөхөр
- Насанд хүрсэн хүүхэд (үрчилж авсан хүүхэд)
- Эцэг, эх (үрчлэгч эцэг, эх)
- Ах, эгч, дүү

Дээр дурдсан гишүүдийн аль нэг нь татгалзсан тохиолдолд нас барагчийн эд, эс, эрхтнийг авахыг хориглоно.

Эрүүл мэндийн яамны харьяа Үндэсний шилжүүлэн суулгах хороо (The National Transplant Bureau) нь энэ хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу нь хүний эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах талаарх төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж, тус бодлогын хэрэгжилт, боловсруулалтад хяналт тавина.

### Амьд донорын насны байдал:

Донорын үйл ажиллагаа болон хүний эд, эс, эрхтнээ шилжүүлэн суулгах тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар зөвхөн эмчилгээнд зориулж нөхөн сэргэх чадваргүй эд, эс, эрхтнийг донорын зөвшөөрснөөр шилжүүлэн суулгаж болно.

Насанд хүрээгүй амьд донороос нөхөн төлжиж буй эд, эсийг шилжүүлэн суулгаж болно. Насанд хүрээгүй хүн дараах тохиолдолд донор болох боломжтой.

- 18 нас хүрэхээс өмнө түүний эцэг, эх эсвэл асран хамгаалагч нөхөн төлжиж буй эд, эсийг хандивлах, шилжүүлэн суулгах зөвшөөрөлд гарын үсэг зурна;
- 14-өөс дээш насны насанд хүрээгүй хүн өөрийн нөхөн төлжиж буй эд, эсийг шилжүүлэн суулгах зөвшөөрөлд гарын үсэг зурсан;

<sup>244</sup> “Донор болон эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаарх гадаадын зарим орны туршлага, бодлого, эрх зүйн орчин” харьцуулсан судалгаа СТ-17/212, УИХТГ-ын МХШҮХ-ийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, 2017 он

- хандивлагчийн ойрын хамаатан садныг эмчлэх зорилгоор эд, эсийг шилжүүлэн суулгана.

Донор ба түүний ар гэрт олгох нөхөн олговор:

Донорын үйл ажиллагаа болон хүний эд, эс, эрхтнийг шилжүүлэн суулгах хуулийн 13 дугаар зүйлд нас барсан эсвэл амьд хүний эд, эс, эрхтэн нь арилжааны зорилготой байж болохгүй. Санхүүгийн ашиг олох эсвэл үр дүн санал болгох зорилгоор эд, эс, эрхтний хэрэгцээ, бэлэн байдлын талаар сурталчлахыг хориглоно гэж заасан.

## **ХОРВАТ УЛС**

Хорват улс нь эрхтэн шилжүүлэн суулгаж байгаа туршлагаараа дэлхийд дээгүүрт ордог бөгөөд амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгадаг. Амьд донороос зөвхөн эмчилгээний журмаар эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгахыг зөвшөөрдөг.

Тус улсад эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой харилцааг Эрүүл мэндийн тухай хууль (Organ Transplant Law)<sup>245</sup>, Өвчтөний эрхийн тухай хууль, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулиар зохицуулдаг бөгөөд тус улсын иргэд эрхтний донорын карт ашигладаг.

Амьд донорын насны байдал:

Хорват улсын иргэн амьддаа эрхтэн хандивлахыг эсэргүүцсэн тухайгаа илэрхийлээгүй бол эрхтний донор гэж тооцогддог. Нас барсны дараа эрхтэн шилжүүлэн суулгахад ар гэрийнхэнээс нь зөвшөөрөл шаарддаггүй боловч гэр бүлийнхний саналыг хүндэтгэн үздэг.

Амьд донороос эрхтэн шилжүүлэн суулгах тохиолдолд донор бичгээр зөвшөөрөл өгсөн байх бөгөөд насанд хүрээгүй болон эрх зүйн чадамжгүй хүн бол түүний хууль ёсны төлөөлөгч буюу асран хамгаалагчаас зөвшөөрөл авах бөгөөд эрхтэн шилжүүлэн суулгах шийдвэрийг эмнэлгийн байгууллагын ёс зүйн хороо (ethics committee of the health institution) шийдвэрлэнэ.

Донор ба түүний ар гэрт олгох нөхөн олговор:

Хорватын иргэд эсвэл байнгын оршин суугч нь эрхтнээ үнэгүй хандивлана. Харин гадаадын иргэд эрхтнээ эхнэр, нөхөр, хамтрагч эсвэл гэр бүлийн шууд хамааралтай гишүүнд бичгээр гаргасан зөвшөөрлийн үндсэн дээр хандивлах боломжтой байдаг.

Амьд донороос эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгасан бол донорт эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үнэ төлбөргүй авдаг. Энэ даатгалын үйлчилгээ нь ердийн болон нэмэлт үйлчилгээг үзүүлдэг.<sup>246</sup>

## **БҮГД НАЙРАМДАХ МОЛДОВА УЛС**

Бүгд Найрамдах Молдова Улсад анх 1960-аад оны үед донороос ясны чөмөг шилжүүлэн суулгах ажилбар хийгдсэнээр эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажиллагааны эх суурь тавигдсан гэж үздэг. 1982-1999 оны хооронд бөөр шилжүүлэн

<sup>245</sup> <http://www.mvep.hr/files/file/dokumenti/prevodenje/zakoni/26-Zakon-o-zdravstvenoj-za%C5%A1titi-NN-150-08,-71-10,-139-10...70-16-pro%C4%8Di%C5%A1%C4%87eni-tekst-ENG.pdf>

<sup>246</sup> <https://www.expaticroatia.com/dopunsko-health-insurance-supplement/>

суулгах ажиллагаа хийгдэж байсан ч эрх зүйн орчин хангалтгүй байсны улмаас донор болон шилжүүлэн суулгах үйл ажиллагаа түр зогсжээ. 2008 онд “Хүний эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль” (On The Transplant of Human Organs, Tissues and Cells)<sup>247</sup> батлагдсанаар эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаа сэргэж, 2011 оноос амьд донороос бөөр, 2013 онд амьд донороос элэг, харин 2014 оноос амьгүй донороос эд, эрхтэн авах мэс заслууд тус тус хийгдэж байна.<sup>248</sup>

#### Амьд донорын насны байдал:

Хүний эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулийн 5 дугаар бүлэгт амьд донороос эд, эс, эрхтэн авахыг гагцхүү эдийн тохироо бүрдсэн бөгөөд амьгүй донорын эд, эс, эрхтэн байхгүй тохиолдолд зөвшөөрнө. 18 насанд хүрсэн, эрх зүйн чадамжтай хүн донор болох хүсэлтээ сайн дурын үндсэн дээр бичгээр гаргаж, түүнийг нь бие даасан Зөвшөөрөл олгох комиссоос зөвшөөрсөн тохиолдолд эд, эс, эрхтнийг авахыг зөвшөөрнө гэж заажээ.

#### Донор ба түүний ар гэрт олгох нөхөн олговор:

Хүний эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулийн 4 дүгээр бүлэгт нас барагчийн цогцсоос эд, эс, эрхтэн авахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Гагцхүү Эрүүл мэндийн яамнаас баталсан журмын дагуу нас барсныг тогтоосны үндсэн дээр цогцсоос эд, эс, эрхтнийг авч болох юм. Ингэхдээ тархины үхлээс гадна зүрх судасны үйл ажиллагаа болон амьсгал бүрэн зогссоныг тогтоосон байх учиртай. Нас барсныг тогтоож буй эмч нар нь эд, эс, эрхтэн авах, шилжүүлэн суулгах ажиллагаанд оролцох эмч, эсхүл хүлээн авагч өвчтөнийг эмчилж буй эмч байж болохгүй.

Амьгүй донорын хувьд гагцхүү амьддаа зөвшөөрөл өгсөн бол донор болох бөгөөд хэрэв амьддаа донор болохоос татгалзсан шийдвэрээ бичгээр гаргасан, эсхүл хуульд заасан журмын дагуу мэдэгдсэн тохиолдолд түүний эд, эс, эрхтнийг авахыг хориглоно.

Донор болох эсэхтэй холбоотой шийдвэр байхгүй тохиолдолд нас барагчийн эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд, эхнэр, нөхөр, эсхүл хууль ёсны төлөөлөгч нь эд, эс, эрхтнийг хандивлахыг татгалзсан шийдвэрээ бичгээр гаргаагүй тохиолдолд зөвшөөрнө. Мөн дээрх этгээдүүд байхгүй, эсхүл дээрх этгээдүүдийн мэдээлэл олдоогүй тохиолдолд тухайн этгээдийн эд, эс, эрхтнийг авахыг зөвшөөрнө. Тус улсын хувьд нөхөн олговор олгох талаар хуулийн зохицуулалт одоогоор байхгүй байна.

## **СОЛОНГОС УЛС**

Солонгос улс 2000 онд Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль батлагдсанаар эрхтэн шилжүүлэн суулгах үйлчилгээний эрх зүйн орчин бүрдсэн. Одоогийн байдлаар эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой харилцаанд дараах хууль тогтоомж үйлчилж байна. Тухайлбал, Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль,

<sup>247</sup>[https://www.researchgate.net/publication/272944739\\_Evaluation\\_Of\\_The\\_Transplant\\_System\\_in\\_the\\_Republic\\_of\\_Moldova](https://www.researchgate.net/publication/272944739_Evaluation_Of_The_Transplant_System_in_the_Republic_of_Moldova)

<sup>248</sup> Донор болон эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаарх гадаадын зарим орны туршлага, бодлого, эрх зүйн орчин” харьцуулсан судалгаа СТ-17/212, УИХТГ-ын МХШҮХ-ийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, 2017 он

Эмчилгээний тухай хууль, Хүний эд эсийн аюулгүй байдал, менежментийн тухай хууль, Дархлал олдмол хомсдолоос урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулийн хэрэгжилтийг хангах журам, Улсын эрхтэн, эд эс, цусны менежментийн газраас эрхтний донорыг дэмжих журам зэрэг хууль тогтоомжоор зохицуулж байна.

Солонгосын эрхтэн донорын агентлаг нь 2009 онд байгуулагдсан бөгөөд эрхтэн, эд, эсийн донортой холбоотой харилцааг хариуцан зохион байгуулдаг. 2007 оноос сайн дурын эрхтний донорын жолооны үнэмлэх дээр тэмдэглэгээ хийдэг болсон.

2019 оны байдлаар эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал 2500-г хийснээр гэр бүлийн зөвшөөрлөөр 1600, тархины үхлийн улмаас 450 хүн донор болсон байна.

Тус улсад донор болох хүсэлтэй хүн эрхтэн хандивлах карт авдаг бөгөөд 2019 оны байдлаар донор болох хүсэлт гаргасан 128,811 хүн бүртгэлтэй байна.

Амьд донорын насны байдал:

Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулийн 2 дугаар зүйлд зааснаар хүний эд, эрхтэн хандивлах зорилго нь сайн дурын байна гэж заасан. Мөн хуулийн 11 дүгээр зүйлд амьд донороос эд, эс, эрхтэн авахдаа дараах этгээдээс авахыг хориглосон. Үүнд:

- 16 насанд хүрээгүй хүн;
- жирэмсэн болон төрсөнөөс хойш 3 сар өнгөрөөгүй хүн;
- сэтгэцийн өвчтэй, оюуны бэрхшээлтэй хүмүүс;
- мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодист донтсон хүмүүс.

Амьд донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах тохиолдолд тухайн хүнээс заавал зөвшөөрөл авах бөгөөд 16-аас дээш насны насанд хүрээгүй донор, 16-аас доош насны хүүхдийн цус болон ясны чөмөгний донор болох тохиолдолд хүүхдийн болон түүний эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна.

**Донорын насны байдал<sup>249</sup>**

	0-9	10-19	20-29	30-39	40-49	50-59	60-69	70-79	80-89	Нийт	Дундаж нас
2019	10	17	44	58	108	107	79	22	5	450	47.0
2018	6	14	31	60	88	140	80	27	3	449	49.0
2017	15	18	41	56	116	146	88	31	4	515	48.2
2016	23	18	46	61	137	173	89	24	2	573	46.9
2015	16	22	43	65	125	134	75	20	1	501	46.0

Донор ба түүний ар гэрт олгох нөхөн олговор:

Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулийн 32 дугаар зүйлд эрхтний донор болсон хүмүүст үзүүлэх дэмжлэгийг дараах байдлаар зохицуулсан байна.

1. Оршуулгын зардал болон эмчилгээний зардал
2. Ажилтан нь эрхтний донорийн үзлэг хийлгэх, донор болох зэргээр эмнэлэгт хэвтэх хугацаанд цалинтай чөлөө олгох
3. Донорын гэр бүлийхэнд зориулсан дурсгалын болон хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах

<sup>249</sup> KODA annual report 2019 <https://www.koda1458.kr/newM/newPr/annual.do>

4. Холбогдох бусад байгууллагатай харилцахад дэмжлэг үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн үнэгүй зөвлөгөө өгөх гэх мэт.

### Оршуулгын болон эмчилгээний зардлын хэмжээ

	Зардлын төрөл	Хэмжээ
Тархины үхжилттэй донор	Оршуулгын зардал	3.6 сая вон
	Эмчилгээний зардал	1.8 сая вон
	Оршуулгын үйлчилгээний дээд хязгаар	5.4 сая вон
	Нийтийн байгууллагад хандивлах	5.4 сая вон
Эд, эсийн донор	Оршуулгын зардал	3.6 сая вон
	Эмчилгээний зардал	1.8 сая вон
	Оршуулгын үйлчилгээний дээд хязгаар	5.4 сая вон
	Нийтийн байгууллагад хандивлах	5.4 сая вон
Амьд донор /эмчилгээний зардлыг батлагдсан дээд хязгаарт багтаан олгоно/ Донор болж чадаагүй бол	Элэгний донор	700.000 вон
	Бөөр, нойр булчирхай, нарийн гэдэс гэх мэт	600.000 вон
Донор болж чадаагүй бол	Оршуулгын зардал	3.6 сая вон

Донорын гэр бүлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулдаг. Үүнд:

Гэр бүлийг дэмжих хөтөлбөр нь донор болох үеийн болон донор болсны дараах гэсэн 2 төрөлд ангилах бөгөөд дараах хөтөлбөр, үйл ажиллагааг Солонгосын эрхтэн донорын агентлаг зохион байгуулдаг.

- Мэргэжлийн нийгмийн ажилтнуудаас бүрдсэн “Гэр бүлийн менежментийн баг” нь хандивлагчийн ар гэрийхэнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;
- Хандивлагчдын гэр бүлийн уулзалт, цуглаан зохион байгуулах;
- Хандивлагчдын дурсгалыг хүндэтгэх арга хэмжээ;
- Гэр бүлийн зөвлөгөө өгөх. Хандивлагчийн оршуулга болон түүний дараах захиргааны зарим асуудлыг шийдвэрлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэг үйлчилгээг нийгмийн ажилтан гэрт нь очиж болон утсаар холбогдон дэмжлэг үзүүлдэг;
- Хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх. Нас барсан тухай мэдээлэл, өв залгамжлалтай холбоотой захиргааны журмаар шийдвэрлэх асуудалд бэрхшээл тулгарвал дэмжлэг үзүүлнэ;
- Оршуулгын үйлчилгээг дэмжих хөтөлбөр;
- Ном, гарын авлага, мэдээллээр хангах, хандивлагчдын талаарх ном гаргах.

Тэнгэрт байгаа хандивлагчдад захидал илгээх “Тэнгэрийн улс” захидлын цахим хуудсыг ажиллуулдаг.

### ТУРК УЛС

Турк Улсад анх 1969 онд Анкара болон Истанбул хотод зүрх шилжүүлэн суулгах мэс засал хийгдсэнээр эрхтэн шилжүүлэх ажиллагааны эх суурь тавигдсан байна. 1975 онд анх эхээс хүүд нь бөөр шилжүүлэн суулгах мэс засал, 1978 онд амьгүй донороос бөөр шилжүүлэх ажиллагааг хийсэн байна. 1979 онд “Эд, эрхтэн авах, хадгалах, шилжүүлэн суулгах тухай хууль” (Organ Transplantation Law)<sup>250</sup>–ийг

<sup>250</sup> <http://www.lawsturkey.com/law/2238-organ-transplantation-law>

баталсан. 2001 онд Эрүүл мэндийн яамны харьяанд эд, эрхтэн худалдан авах, шилжүүлэн суулгах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Үндэсний зохицуулалтын төвийг байгуулсан. Энэ байгууллагын гол зорилго нь нас барсан хүнээс эд, эрхтний хандив авахыг өргөжүүлэх, нас барсан донороос шилжүүлэн суулгах эрхтний тоог нэмэгдүүлэхэд оршино.

Хандивласан эд, эрхтнийг шилжүүлэн суулгах ажиллагаа нь Эрүүл мэндийн яамны хяналтан дор явагддаг. Үндэсний зохицуулалтын төвөөс “Үндэсний зохицуулалтын систем”-ийг бий болгосноор эрхтэн шилжүүлэн суулгах талаар хүсэлт гаргасан иргэдийг нэгдсэн дараалалд оруулсан бөгөөд хандивлагчид эрхтнээ дараах байгууллагуудаар дамжуулан хандивлаж болно. Үүнд:<sup>251</sup>

1. Эрүүл мэндийн төвүүд;
2. Эмнэлгүүд;
3. Цагдаагийн байгууллагууд;
4. Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд;
5. Эрхтэн шилжүүлэн суулгах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд зэрэг болно.

Амьд донорын насны байдал:

Эд, эрхтэн авах, хадгалах, шилжүүлэн суулгах тухай хуулийн 2 дугаар бүлэгт амьд донороос эд, эрхтэн авах харилцааг зохицуулсан бөгөөд уг бүлэгт 18 насанд хүрээгүй, мөн сэтгэцийн хувьд эрүүл бус хүнээс эд, эрхтэн авахыг хориглоно гэж заасан байна.

Амьд донор нь насны хувьд 18 хүрсэн байхаар хуульчилсан бөгөөд уг хүнээс эд, эрхтэн авахын тулд хамгийн багадаа хоёр гэрчийг байлцуулж, бусдын дарамт шахалтаас ангид зөвхөн өөрийн хүсэл зоригоор урьдчилан бичгээр үйлдэж, гарын үсэг зурсан тэмдэглэл үйлдэх, эсхүл хамгийн багадаа хоёр гэрчийг байлцуулж амаар илэрхийлэн зөвшөөрөл өгч гарын үсэг зурсан тэмдэглэлийг холбогдох эмч нь баталгаажуулсан байх шаардлагатай.

Донор ба түүний ар гэрт олгох нөхөн олговор:

Эд, эрхтэн авах, хадгалах, шилжүүлэн суулгах тухай хуулийн 3 дугаар бүлэгт амьгүй донороос эд, эрхтэн авах тухай харилцааг зохицуулсан ба аливаа хүн амьддаа бүх бие, эсхүл зарим эд, эрхтнээ эмчилгээ, оношилгоо, шинжлэх ухааны зориулалтаар ашиглахыг зөвшөөрч албан ёсны гэрээслэл үйлдээгүй, эсхүл энэ талаарх хүсэл зоригоо хоёр гэрчийг байлцуулан амаар илэрхийлээгүй тохиолдолд түүнийг нас барах үед байлцсан түүний эхнэр, нөхөр, насанд хүрсэн хүүхдүүд, эцэг, эх, эсхүл ах, эгч, дүү нарын аль нэг нь; хэрэв ийм хүн байхгүй бол аль нэг ойр дотнынх нь хүний зөвшөөрснөөр тухайн нас барсан хүний эд, эрхтнийг авч болно.

Аливаа хүн амьддаа өөрийг нь нас барсны дараа эд, эрхтнийг нь авахаас татгалзсан бол түүний эд, эрхтнийг авахыг хориглоно. Осол, эсхүл өөр бусад золгүй байдлаар амиа алдсан хүний дэргэд дээр дурдсан ойр дотнын хүн байхгүй тохиолдолд түүний клиник үхлийг эрх бүхий эмч мэргэжилтний баг гэрчилснээр нэн

---

<sup>251</sup> Донор болон эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаарх гадаадын зарим орны туршлага, бодлого, эрх зүйн орчин” харьцуулсан судалгаа СТ-17/212, УИХТГ-ын МХШҮХ-ийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, 2017 он



яаралтай эрүүл мэндийн тусламж үзүүлэх шаардлагатай тохиолдолд ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр гэмтээгүй эд, эрхтнийг нь авч болохоор заасан байна.

Эд, эрхтэн авах, хадгалах, шилжүүлэн суулгах тухай хуулийн 1 дүгээр бүлэгт Нийтлэг үндэслэлийг хуульчлахдаа “Төлбөртэйгөөр, эсхүл ямар нэгэн ашиг сонирхлыг хангах зорилгоор эд, эрхтнийг авах, худалдан борлуулахыг хориглоно;” гэж заасан бөгөөд энэхүү зохицуулалт амьд донорын хувьд ч, амьгүй донорын хувьд ч нэгэн адил үйлчилж байна. Иймд амьгүй донорын ар гэрт олгох нөхөн олговор гэж байдаггүй ажээ.

## **ФИНЛАНД УЛС**

Эрхтэн шилжүүлэн суулгах ажилбарыг хийж буй дэлхийн улс орнуудын жишигтэй харьцуулахад Финланд улсад хийгдсэн ажилбарын үр дүн нь дээгүүрт ордог бөгөөд тус улсад донор болох хүсэлтэй хүн эрхтэн хандивлах карт ашигладаг.

Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засалтой холбоотой харилцааг 2001 онд батлагдсан Хүний эд, эс, эрхтнийг анагаахын зорилгоор ашиглах тухай хууль (No. 101/2001 Act on the Medical Use of Human Organs, Tissues and Cells), Эрүүл мэндийн тухай, Эмнэлэгийн нарийн мэргэжлийн тусламжийн тухай, Өвчтөний статус болон эрхийн тухай, Эрүүл мэндийн мэргэжилтэний тухай хуулиар тус тус зохицуулдаг<sup>252</sup>.

### Амьд донорын насны байдал:

Хүний эд, эс, эрхтнийг анагаахын зорилгоор ашиглах тухай хуулийн 3 дугаар бүлэгт зааснаар Донор нь эд, эс, эрхтнийг нь авахыг зөвшөөрсөн тухай бичгээр албан ёсны зөвшөөрөл өгсөн байх шаардлагатай ба эд, эс, эрхтнийг авахаас өмнө хэдийд ч ямар нэгэн шалтгаан заалтгүйгээр зөвшөөрлөө эргүүлэн авч болно. Хэрэв донор нь насанд хүрээгүй, эсхүл насанд хүрсэн боловч өвчний улмаас эмчилгээний талаар шийдвэр гаргах чадваргүй, сэтгэцийн эмгэгтэй болон хөдөлмөрийн чадвараа алдсан зэрэг тохиолдолд эд, эс, эрхтнийг шилжүүлэн авахаас өмнө түүний хууль ёсны төлөөлөгчийн бичгээр гаргасан зөвшөөрлийг авах ёстой. Тус улс 18 нас хүрсэн хүнийг насанд хүрсэн гэж үздэг.

Насанд хүрээгүй болон эрх зүйн чадамжгүй хүмүүс зөвхөн нөхөн төлжих эд, эрхтнээ бүхэлд нь буюу нэг хэсгийг нь төрсөн ах, дүүгийнх нь амь насанд аюултай өвчин, эмгэг тохиолдсон, мөн түүнчлэн амьгүй, эсхүл хуульд заасан нөхцөл шаардлагад нийцсэн донороос тухайн өвчтөнд тохирох эд, эрхтнийг авах боломжгүй тохиолдлуудад хандивлаж болно. Хэрэв донор нь насанд хүрээгүй боловч эмчилгээний талаар шийдвэр гаргаж чадахаар насанд хүрсэн тохиолдолд өөрийн ойрын хамаатан садан болон ойр дотны хүндээ эд, эрхтнээ шилжүүлэх талаар шийдвэр гаргаж болно. Амьгүй донор болон хуульд заасан нөхцөл шаардлагад нийцсэн донороос тохирох эс авах боломжгүй тохиолдолд насанд хүрээгүй боловч эмчилгээний талаар шийдвэр гаргаж чадах насанд хүрсэн хүн эс хандивлах тухай шийдвэр гаргаж болно.<sup>253</sup>

<sup>252</sup> “Донор болон эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаарх гадаадын зарим орны туршлага, бодлого, эрх зүйн орчин” харьцуулсан судалгаа СТ-17/212, УИХТГ-ын МХШҮХ-ийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, 2017 он

<sup>253</sup> “Донор болон эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаарх гадаадын зарим орны туршлага, бодлого, эрх зүйн орчин” харьцуулсан судалгаа СТ-17/212, УИХТГ-ын МХШҮХ-ийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, 2017 он

Донор ба түүний ар гэрт олгох нөхөн олговор:

Хүний эд, эс, эрхтнийг анагаахын зорилгоор ашиглах тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар эд, эс, эрхтний донор болон шилжүүлэн авсан этгээд нь хандив, төлбөр авахгүй. Санхүүгийн ашиг олох эсвэл харьцуулсан үр дүн санал болгох зорилгоор эд, эс, эрхтний хэрэгцээ, бэлэн байдлын талаар сурталчлахыг хориглоно гэж заасан.

Эрүүл мэндийн даатгалын тухай (Health insurance act<sup>254</sup>) хуульд зааснаар эд, эс, эрхтнийг шилжүүлэн суулгасны улмаас орлогын алдагдал хүлээсэн, эрхтэн шилжүүлэн суулгах хэрэгцээ шаардлагын улмаас хяналт, шинжилгээ өгөх тохиолдолд донор нь өдрөөр тооцож тэтгэмж авах эрхтэй. Хэрэв донорт ажил олгогч цалинтай чөлөө олгосон бол өдрийн тэтгэмж олгохгүй. Өдрийн тэтгэмжийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгоно.

## **ЭНЭТХЭГ УЛС**

Энэтхэг Улсад анх 1970 онд бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг хийсэн бөгөөд 1994 онд “Хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль” (The transplantation of human organs act)<sup>255</sup>-ийг баталсан байна. Ерөнхийдөө, энэ хуулиар зөвхөн нас барсан хэлбэрт байгаа тархины үхлийн хувьд хүлээн зөвшөөрсөн бөгөөд эд, эрхтэн худалдан борлуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой. Энэ хуулиар тархины үхлийг донор болгохыг хүлээн зөвшөөрснөөр бөөр шилжүүлэн суулгах төдийгүй элэг, зүрх, уушги болон түрүү булчирхайг шилжүүлэн суулгах боломжтой болсон юм.

Амьд донорын насны байдал:

Хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулийн 2 дугаар бүлэгт “амьд донор” гэж 18 нас хүрсэн, өөрийн сайн дураар эд, эс, эрхтнээ хандивлахыг зөвшөөрсөн хүнийг хэлнэ гэж заасан байна. Амьд донорууд нь дараах 3 төрлийн хүмүүст эд эрхтнээ хандивлаж болно. Үүнд:

- Ойр дотнын хүмүүс: Зөвхөн цусан төрлийн хүмүүс болон эхнэр нөхөр хамаарна. Цусан төрлийн хүмүүс нь эцэг эх, үр хүүхдүүд, ах эгч, өвөө, эмээ, ач зээ гэх мэт. Гэхдээ тэд хүлээн авагчтай ямар харилцаатай болохоо албан ёсны баримт бичиг, эсхүл эмнэлгийн генетикийн шинжилгээгээр нотлох ёстой.
- Ойр дотнын бус хүмүүс: Хандивлагч нь хүлээн авагчтай гэр бүл, садан төрлийн хамаарал бүхий харилцаагүй боловч өөрт нь хандсан сэтгэлийн үүднээс хандив өгөхийг хүсэж буй хүмүүс юм. Энэ тохиолдолд Зөвшөөрлийн хорооны ярилцлагад оролцож, зөвшөөрөл авах шаардлагатай.
- SWAP хандивлагчид: Энэ нь ойр дотнын хандивлагч хүлээн авагч хоёрын хооронд эдийн нийцэлгүй байх үед хамаардаг юм. Жишээ нь, эхний хосын хандивлагч нь хоёр дахь хосын хүлээн авагчтай тохирч, харин хоёр дахь хосын хандивлагч нь эхний хосын хүлээн авагчтай тохирч байвал хандивлагч нарыг сольж болно. Гэхдээ хандивлагч хүлээн авагч нар ойр дотнын хүмүүс байвал SWAP-ыг зөвшөөрдөг.

<sup>254</sup> [https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2004/en20041224\\_20110911.pdf](https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2004/en20041224_20110911.pdf)

<sup>255</sup> <https://main.mohfw.gov.in/sites/default/files/Act%201994.pdf>

Донор ба түүний ар гэрт олгох нөхөн олговор:

Нас, хүйс, арьс өнгө үл хамааран хэн ч нас барсныхаа дараа эд, эс, эрхтний донор болж болно. Хэрэв нас барсан хандивлагч нь 18 нас хүрээгүй бол эцэг эхийн аль нэгний зөвшөөрөл, эсхүл ойрын хамаатан саднаас зөвшөөрөл авах шаардлагатай.

Энэтхэг Улсын Засгийн газраас донорын үйл явцыг дэмжих зорилгоор амьгүй донорын ар гэрт эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажиллагааг эрхлэн явуулсан эмнэлгээр насан туршдаа оношлуулах, эмчлүүлэх урамшуулал олгож байхаар төлөвлөж байна. Үүнээс гадна, ирээдүйд амьгүй донорын ар гэрийнхэн нь амьдралын баталгааг дэмжих зорилгоор хүлээн авагчаас 2 жилийн дотор нэг удаа тусламж авахыг зөвшөөрөх, мөн төрөөс 3 жилд нэг удаа даатгалд хамруулах боломжтой болгох юм.

## **ЯПОН УЛС**

Япон Улсад 1956 онд анхны эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг бөөрний цочмог дутагдалтай өвчтөнд бөөр түр шилжүүлэн суулгаж эхэлсэн түүхтэй. Анх 1994 онд “Эрхтэн шилжүүлэх тухай хууль” баталсан боловч уг хуулиар амьд донор эрхтэн шилжүүлэхийг зөвшөөрөөгүй байсан юм. Энэ нь хууль зүйн болон ёс зүйн суурь зарчмууд болон шашин, зан заншилтай шууд холбоотой байжээ. Улмаар дэлхий дахинд амьд донорын асуудал ихээр яригдах болж, Япон Улсын парламент (THE DIET) 2010 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр “Эрхтэн шилжүүлэх тухай хуулийн” шинэчилсэн найруулгыг (Organ Transplant Law)<sup>256</sup> баталснаар гэр бүлийн гишүүндээ эрхтэн хандивлах эрх зүйн үндэс бий болжээ.

Амьд донорын насны байдал:

Энэ хуулийн өөрчлөлтөөр эрхтэн хандивлах нь зөвхөн гэр бүлийн хүрээнд зөвшөөрөгдсөн бөгөөд дараах гурван шаардлагыг заавал хангасан байх учиртай. Үүнд:

1. 15 насанд хүрсэн иргэн сайн дурын үндсэн дээр өөрийн гэр бүлийн гишүүнд эрхтэн хандивлахыг зөвшөөрснөө бичгээр мэдэгдсэн байх;
2. Эрхтэн хандивлагч нь гэр бүлийн гишүүн (эхнэр нөхөр, хүүхэд, эцэг эх)-тэй ямар харилцаатай болох нь албан ёсны лавлагаа, эсхүл эргэлзээгүй баримт бичгээр хөдөлбөргүй нотлогдсон байх;
3. Эрүүл мэндийн шаардлага (нийцтэй байдлын шалгуур) хангагдсан байна гэж хуульчилсан байна.

Японд эд, эрхтнээ сайн дурын үндсэн дээр хандивладаг учир ямар нэгэн нөхөн олговор, урамшуулал олгодоггүй харин Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын талархлын бичиг гардуулдаг байна.

Донор ба түүний ар гэрт олгох нөхөн олговор:

Японы шинто шашинд эд, эрхтэн шилжүүлэн суулгахыг хориглодог учраас амьгүй донорын эд эрхтнийг авах, шилжүүлэн суулгах явдал туйлын ховор байдаг аж.

2010 оны Эрхтэн шилжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар тархины үхлийн дараа, эсхүл зүрх зогссоны дараа эрхтнийг нь хандивлах эрх зүйн орчин анх

---

<sup>256</sup> <https://www.jotnw.or.jp/en/00/>

удаа бүрдсэн байна. Эд, эрхтнээ хандивлахаар төлөвлөж байгаа хэн нэгэн амьд сэрүүн байхдаа эд, эрхтнээ бусдад хандивлах зорилгоо бичгээр илэрхийлсэн тохиолдолд, эсхүл нас барсан хүний гэр бүлийн гишүүдийн зөвшөөрснөөр эд эрхтнийг шилжүүлэн суулгах боломжтой болжээ.

Гэхдээ эд, эрхтэн хандивлах нь хариу төлбөргүй бөгөөд сайн үйлсийн шинжтэй байдаг тул амьгүй донорын гэр бүлийн гишүүд, ар гэрт нь ямар нэгэн нөхөн олговор олгодоггүй байна. Харин эд эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой эмнэлгийн болон бусад шаардлагатай зардлыг хүлээн авагч тал бүрэн хариуцдаг.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Liverman, C. T., & Childress, J. F. (Eds.). (2006). Organ donation: Opportunities for action. National Academies Press.
- Delmonico, F. L., Domínguez-Gil, B., Matesanz, R., & Noel, L. (2011). A call for government accountability to achieve national self-sufficiency in organ donation and transplantation. *The Lancet*, 378(9800), 1414-1418.
- World Health Organization. (2010). WHO guiding principles on human cell, tissue and organ transplantation. *Transplant Journal of Australasia*, 19(2), 26-30.
- Guide for the implementation of the principle of prohibition of financial gain with respect to the human body and its parts from living or deceased donors <https://rm.coe.int/guide-financial-gain/16807bfc9a>
- Emamaullee, J., Tenorio, L., Khan, S., Butler, C., Kim, S., Tucker-Seeley, R., ... & Genyk, Y. (2020). Living donor financial assistance programs in liver transplantation: The global perspective. *Clinical Transplantation*, 34(11), e14073.
- Campbell, M., Wright, L., Greenberg, R. A., & Grant, D. (2013). How young is too young to be a living donor?. *American Journal of Transplantation*, 13(7), 1643-1649.

### БНСУ

- Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль <https://www.law.go.kr/>
- Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулийн хэрэгжилтийг хангах журам <https://law.go.kr/LSW/lsInfoP.do?lsiSeq=206268#0000>
- Улсын эрхтэн, эд эс, цусны менежментийн газраас эрхтний донорыг дэмжих журам <https://www.law.go.kr>
- Солонгосын эрхтний донорын агентлаг <https://www.koda1458.kr/newKoda/vision.do>
- Донорт үзүүлэх дэмжлэгийн талаарх мэдээлэл <https://easylaw.go.kr/CSP/CnpClsMain.laf?popMenu=ov&csMSeq=263&ccfNo=2&cciNo=2&cnpClsNo=4>
- [http://www.bktimes.net/data/board\\_notice/1563187553-41.pdf](http://www.bktimes.net/data/board_notice/1563187553-41.pdf)

### Финланд улс

- Хүний эд, эс, эрхтнийг анагаахын зорилгоор ашиглах тухай хууль <https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2001/en20010101>
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- [https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2004/en20041224\\_20110911.pdf](https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2004/en20041224_20110911.pdf)

### Литва

- Донорын үйл ажиллагаа болон хүний эд, эс, эрхтнээ шилжүүлэн суулгах тухай” хууль (Law On Donation And Transplantation Of Human Tissues, Cells And Organs)
- <https://e-seimas.lrs.lt/portal/legalAct/lt/TAD/19d1d990225011e6aced8d454428fb7?jfwid=191fum8213>

### Хорват

- <http://www.mvep.hr/files/file/dokumenti/prevodenje/zakoni/26-Zakon-o-zdravstvenoj-za%C5%A1titi-NN-150-08,-71-10,-139-10...70-16-pro%C4%8Di%C5%A1%C4%87eni-tekst-ENG.pdf>
- <https://www.expatinroatia.com/how-to-be-an-organ-donor-in-croatia/>

### АНУ

- Үндэсний эрхтэн шилжүүлэх тухай хууль (National Organ Transplant act) <https://www.govinfo.gov/content/pkg/STATUTE-98/pdf/STATUTE-98-Pg2339.pdf>
- <https://www.organdonor.gov/about/process/living-donation.html>

- <https://www.expaticroatia.com/dopunsko-health-insurance-supplement/>

#### Сингапур

- <https://sso.agc.gov.sg/Act/HOTA1987>
- <https://sso.agc.gov.sg/Act/MTERA1972>

#### Литва улс

- “Донор болон эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаарх гадаадын зарим орны туршлага, бодлого, эрх зүйн орчин” харьцуулсан судалгаа СТ-17/212, УИХТГ-ын МХШҮХ-ийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, 2017 он

#### Бүгд Найрамдах Молдова Улс

- [https://www.researchgate.net/publication/272944739\\_Evulation\\_Of\\_The\\_Transplant\\_System\\_in\\_the\\_Republic\\_of\\_Moldova](https://www.researchgate.net/publication/272944739_Evulation_Of_The_Transplant_System_in_the_Republic_of_Moldova)
- Донор болон эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаарх гадаадын зарим орны туршлага, бодлого, эрх зүйн орчин” харьцуулсан судалгаа СТ-17/212, УИХТГ-ын МХШҮХ-ийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, 2017 он

#### Турк

- <http://www.lawsturkey.com/law/2238-organ-transplantation-law>
- Донор болон эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаарх гадаадын зарим орны туршлага, бодлого, эрх зүйн орчин” харьцуулсан судалгаа СТ-17/212, УИХТГ-ын МХШҮХ-ийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, 2017 он

#### Япон

<https://www.jotnw.or.jp/en/00/>



## КОВИД-19 БА НҮБ-ЫН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ: ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ

*Д.Амаржаргал (Ph.D), Т.Батцэцэг,  
Д.Жигваагүнсэл О.Нарантуяа, Р.Оргилмаа,*

### АГУУЛГА

#### УДИРТГАЛ

1-Р ХЭСЭГ: КОВИД-19 БА НҮБ-ЫН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ НҮБ-ЫН СУДАЛГАА БОЛОН ОЛОН УЛСЫН ШИНЖЭЭЧДИЙН ДҮГНЭЛТ, СУДАЛГААНЫ ТАЙЛАН:

- НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс явуулсан ковид-19 тогтвортой хөгжлийн зорилтод үзүүлэх нөлөөллийн талаарх судалгаа
  - “Цар тахлыг өнөөдөр даван туулж, сайн сайхан маргаашийг цогцлоох нь: Парламентуудын үүрэг” хэмээх 142 дугаар чуулганы үндсэн сэдвийн дор ОУПХ-ны НҮБ-ын асуудлаарх байнгын хороотой хамтарсан хуралдаанд хөндөж болох асуудлууд
- КОВИД-19-т хариу үзүүлэхэд НҮБ-ын гүйцэтгэх үүрэг (*Улка Халачи Улусоё-Абэрдэн их сургуулийн хүндэт лектор, Анкарагийн их сургуулийн Хуулийн сургуулийн доктор, профессор-нийтлэл*)
- КОВИД-19 цар тахлын шалгалт ба НҮБ-ын Аюулгүй Байдлын зөвлөл (*Бруно Шарбонно-Канадын Сент-Жаны Хатан хааны Цэргийн коллеж, Хүмүүнлэгийн болон Нийгмийн ухааны тэнхим- Судалгааны тайлан*)
- Дэлхийн удирдагчдын уулзалтаар томоохон улс гүрнүүдийн дунд тэгш бус байдал өсөн нэмэгдэхийн хэрээр хурцадмал байдал даамжирч, улмаар НҮБ-ын шинэчлэлийн талаар тохиролцоонд хүрэхэд улам бүр хүндрэлтэй болж байгааг онцолж байна.

2-Р ХЭСЭГ: НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2030 ХӨТӨЛБӨР БА МОНГОЛ УЛСЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилт 2030 хөтөлбөр, түүний хүрээнд УИХ, болон Засгийн газраас хийгдсэн ажлууд

#### ХАВСРАЛТ:

- “Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд Парламентын хүлээх үүрэг”
- Парламентын гарын авлагын товч танилцуулга

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Энэхүү лавлагаа, мэдээлэлд захиалагчийн хүсэлтийн дагуу Ковид-19-ын эсрэг НҮБ-ын гүйцэтгэсэн үүрэг, үйл ажиллагаа болон түүний талаар бусад орны эрдэмтэн, судлаачдын дүгнэлт, шүүмж, судалгааны тайланг тоймлон оруулсан ба НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 2030 хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын баримталж буй бодлого, үйл ажиллагааны тоймыг товч мэдээлэл хэлбэрээр тус тус оруулсан болно.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөө хүн төрөлхтний эрүүл мэнд, амь нас, амьдралын хэв маягт ихээхэн өөрчлөлт хувьслыг авчрахын хэрээр түүний эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээнд бодлогын болоод арга зүйн шинэчлэлийг шаардаж байгааг дээрх судалгааны тайлан болон нийтлэл, шүүмжүүдэд нийтлэг дурджээ. Бид цар тахлын энэ хүнд үед аль болох хурдтай, нэгдмэл шийдвэр гаргаж хүн төрөлхтөн, улс орнуудад тэгш хүртээмжтэй түгээх нь чухал болохыг судлаачид чухалчилсан байна. Үүнийг өнөөгийн цаг үед НҮБ, түүний Аюулгүй байдлын зөвлөл гүйцэтгэх шаардлагатай бөгөөд энэхүү үүргээ хангалттай гүйцэтгэж чадахгүй байгаа, түүний бүтэц, үүрэг, үйл ажиллагаанд шинэчлэл хийх шаардлагатай зэрэг асуудлуудыг хөндсөн байна.

2015 онд НҮБ-ын Ерөнхий асамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн. Манай улс НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн улс орны нөхцөл байдал, онцлогт тохируулан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ийг 2016 оны 2-р сард УИХ-ын 19-р тогтоолоор баталсан. Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-ын 17 зорилго, 169 зорилт нь манай улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ын 4 бүлэг, 44 зорилттой уялдах бөгөөд НҮБ-ын ТХЗ-ын шалгуур 241 үзүүлэлтээс МУ-д хамааралгүй 13 үзүүлэлтийг хасч, үлдсэн 228 үзүүлэлтийг 335 үзүүлэлт болгон өргөтгөн тусгасан.

Ковид 19 цар тахлын нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор НҮБ-ын дээрх хөтөлбөрийн хүрээнд улс орнууд олон тулгуурт бодлого арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд манай улсын хувьд Засгийн Газрын 2020 оны 01-р сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30-р тогтоол баталсанаас хойш Монгол Улсын хэмжээнд нийтдээ коронавирусийн цар тахалтай холбоотой 1 хууль, УИХ-ын 4 тогтоол, Засгийн газрын 36 тогтоол батлагдсан байна.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**Нэгдүгээр хэсэг: Олон улсын байгууллага, судлаачдын дүгнэлт, судалгааны тайлангийн тойм**

**НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРӨӨС ЯВУУЛСАН КОВИД-19 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ СУДАЛГАА<sup>257</sup>**

Өнөөгийн цар тахлын тархалтын улмаас тогтвортой хөгжлийн зорилтод үүсээд буй нөхцөл байдал

2020 онд дэлхий дахинаа цар тахлын улмаас 94 сая хүн ядууралд автсан байна. 2030 онд энэ цар тахлын нөлөөгөөр 44 сая хүн ядууралд нэрвэгдсэн хэвээр байх болно. Энэ нь 2030 онд тоологдох магадлалтай байсан 861 сая нэн ядуу хүмүүсийн тоог улам ихэсгэж, 905 сая хүн болгоно. Ийнхүү нэмэлтээр нэн ядуусын эгнээнд шилжих 44 сая хүний тал хувь нь (22 сая) эмэгтэйчүүд, охид байх болно.

2030 он гэхэд цар тахалгүй байх үеийнхээс нэмэлтээр 7.9 сая хүн, түүнээс 1.5 сая гаруй хүүхэд хоол тэжээлийн дутагдалд орно гэж тооцоолж байна.

2030 онд КОВИД-гүй үеийг бодвол ахлах сургуулиа төгсөгчдийн түвшин 1 хувиар доогуур байх болно.

Эхийн эндэгдлийн түвшин КОВИД-гүй үед 100,000 төрөлтөд 86,3 байхаар байсан нь 2,3 пунктээр нэмэгдэж 88,69 болох болно.

Тогтвортой хөгжлийн зорилтын биелэлтийг эрчимжүүлэхгүй орхивол цар тахлын улмаас цаашид үүсэх хүндэрсэн нөхцөл байдал

КОВИД-ийн нөлөөгөөр 2030 он гэхэд нэмэлтээр 207 сая хүн ядуусын эгнээнд шилжиж, нэн ядуусын тоо 1 тэрбум давах магадлалтай байна.

Хүндэрсэн нөхцөл байдал хүний хөгжлийн бүхий л үзүүлэлтүүдэд нөлөөлөх болно. Нэн ялангуяа:

- Эмэгтэйчүүдийн ядуурлын түвшин 102 саяаар нэмэгднэ.
- Нэмж 37 сая хүн хоол тэжээлийн дутагдалд орох магадлалтай байгаагаас 4 сая нь 5-аас доош насны хүүхдүүд байх болно.
- Ерөнхий боловсролын сургууль төгсөж буй хүүхдүүдийн хувь хэмжээ 2030 он гэхэд 2 хувиар буурч, КОВИД-гүй үед байх байсан 66% -иас 64% болж буурах болно.

Тогтвортой хөгжлийн зорилтын биелэлтийг эрчимжүүлсэн ('SDG Push' хувилбар) тохиолдолд үүсэх нөхцөл байдал

'SDG Push' зорилтот арга хэмжээ авсанаар нэн ядуу хүмүүсийн тоог 2030 он гэхэд өнөөгийн чиг хандлагатай харьцуулахад 146 саяар бууруулна.

'SDG Push' хувилбарын үр өгөөж нь 2030 он гэхэд бусад үзүүлэлтүүд дээр ч гарна.

Тухайлбал:

- Ойролцоогоор 128 сая насанд хүрэгчид, 16 сая хүүхэд хоол тэжээлийн дутагдлаас гарч, ерөнхий боловсролын сургууль төгсөгчид 66-70% хувь болж өсөхөөр байна.

Нэн ядуурлыг арилгах зорилтыг бүх улс орон биелүүлж чадахгүй ч 'SDG Push' хувилбарыг хэрэгжүүлсэнээр 14 орон 2030 он гэхэд энэ зорилтыг хэрэгжүүлж чадахаар

<sup>257</sup> [https://sdgintegration.undp.org/sites/default/files/Impact\\_of\\_COVID-19\\_on\\_the\\_SDGs.pdf](https://sdgintegration.undp.org/sites/default/files/Impact_of_COVID-19_on_the_SDGs.pdf)

байна.

### 'SDG Push' хувилбар

SDG Push хувилбар нь дөрвөн үйл ажиллагааны хүрээнд хийгдэх арга хэмжээнүүдийг агуулах ба Moyer ба Bohl (2018), Moyer ба Hedden (2020) нарын бүтээлүүдэд суурилан гаргасан сценариуд юм.

### **Засаглал**

Авлигыг бууруулж, засгийн газрын үр ашгийг дээшлүүлж, олон нийтийн ардчиллыг нэмэгдүүлэх

### **Нийгмийн хамгаалал (тэгш бус байдлыг арилгах)**

Бүх түвшний боловсролын хамрагдалт ба төгсөлтийн хувийг дээшлүүлэх, мэргэжлийн чадвар муутайн улмаас бага орлоготой байгаа өрхүүдийн нийгмийн байдлыг сайжруулах, тэдний хоол тэжээлийн байдлыг нэмэгдүүлэх, цэвэр ус, ариун цэврийн байгууламж, цахилгаан эрчим хүч, орчин үеийн гал зуухны хүртээмжийг сайжруулахад нийгмийн анхаарлыг төвлөрүүлж, боловсрол ба эрүүл мэндийн зардалд засгийн газраас дэмжлэг үзүүлэх

### **Ногоон эдийн засаг (байгаль, цаг уур, эдийн засгийг тэнцвэржүүлэх)**

Махнаас илүү хүнсний ногоо, жимс түлхүү хэрэглэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, тээвэрлэлт, боловсруулалт, хэрэглээнээс гарах хог хаягдлыг багасгах, хөдөө аж ахуйн гарцыг нэмэгдүүлэхдээ ойн моджилтыг нэмэгдүүлэх, хотын агаарын бохирдлыг бууруулах, ус, эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх, нүүрстөрөгч ялгаруулсаны татвар, технологийн хурдацтай ахиц дэвшил, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх

### **Цахимжилт ба инновац (хурд, цар хүрээний хувьд)**

Дээд боловсролд, ялангуяа шинжлэх ухааны салбарт анхаарал хандуулах, эрдэм шинжилгээний ажилд зарцуулах төрийн болон нийгмийн зардлыг нэмэгдүүлэх

**“Цар тахлыг өнөөдөр даван туулж, сайн сайхан маргаашийг цогцлоох нь: Парламентуудын үүрэг” хэмээх 142 дугаар чуулганы үндсэн сэдвийн дор ОУПХ-ны НҮБ-ын асуудлаарх байнгын хороотой хамтарсан хуралдаанд хөндөж болох асуудлууд**

**Нийтийн сайн сайхны төлөөх вакцины хүртээмж**

- Сүүлийн жилүүдэд эх нялхсын эндэгдлийг бууруулж, ХДХВ, хумхаагийн улмаас нас барагсдын тоог бууруулж чадсан нь тогтвортой хөгжлийн зорилтуудаа биелүүлэхэд чухал үзүүлэлтүүд болсон. Харин Ковид-19 цар тахал дэгдсэнээр тогтвортой хөгжлийн зорилтууд бүхэлдээ хоцрогдсон билээ. Эрүүл мэнд нь хөгжлийн үндэс суурь болдог тул эрүүл мэндэд чиглэсэн зорилтын эрч хүчийг сэргээх, хурдасгахад маш их хүчин чармайлт хэрэгтэй байна. Үүнд шинэ коронавирусийн эсрэг дархлаажуулалт үндсэн үүрэгтэй. Учир нь дархлаажуулалтыг бусад нийгмийн үйлчилгээнээс нэн тэргүүнд тавьж, олон хүнд хүргэснээр анхан шатны эрүүл мэндийн тогтолцооны үндэс суурь бүрдэж, бүх нийтийн эрүүл мэндийн гол хөшүүрэг болох юм.<sup>258</sup> Ингэснээр “SDG push” (энэ талаар доорх судалгаанаас харна уу) буюу тогтвортой хөгжлийн зорилтуудыг эрчимжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.
- Дэлхий даяар цар тахлын эсрэг хурдтай, хүрэлцээтэй вакцинжуулалт хийхийн тулд нэгдсэн засаглал шаардагдаж байна. Цар тахлын эсрэг вакцинжуулалтын үр ашгийг бүх улсууд хүртэх ба үүнийг баталгаажуулахын тулд дэлхий нийтийн хамтын ажиллагаа, шаардлагатай байна. Тиймээс нэг ч орон вакциныг өөр дээрээ хуримтлуулж болохгүй. Ямар ч корпорац энэ үйл явдлаас ашиг олох ёсгүй. Мөн ямар ч байгууллага, хувь хүн энэ вакцинтай холбоотой оюуны өмчийн эрхийг эзэмших ёсгүй. "Вакцины үндсэрхэг үзэл"(vaccine nationalism) газар авсан өнөө үед нэг ч орон дангаараа амжилтанд хүрч чадахгүй. Вакцинжуулалтын үе шат бүрт хамтын ажиллагаа, зохицуулалт шаардлагатай байна. Үүнийг Олон улсын эрүүл мэндийн хуулинд (Global health law) дэлгэрэнгүй тусгаж, цаашдын гарч болзошгүй эрсдэлээс сэргийлэх нь зүйтэй<sup>259</sup>
- Зарим коронавирусийн эсрэг вакцинд ДЭМБ-ын зөвшөөрөл өгөх явц удаашралтай<sup>260</sup> байгаагаас олон нийт энэ вакциныг хийлгэхгүй байхаар сонгох, вакцинд итгэх итгэл нь буурч байна. Вакциныг сонголттойгоор бус зөвхөн тодорхой бүлгүүдэд нэр бүхий вакциныг тарьж байгаа тохиолдолд ДЭМБ-н зөвшөөрөл олгосон эсэх статусыг харж шийдвэр гаргаж байгаагаас вакцинжуулалт удааширч, халдварын хүндрэлтэй нөхцөл байдлыг дагуулсаар байна. Хэрэв ямар нэг улс төрийн болон өөр эмнэл зүйн бус шалтгаанаар эдгээр вакцинд зөвшөөрөл өгөх үйл явц удааширч байгаа бол энэ үйл явдлыг нэн даруй таслан зогсоох шаардлагатай байна.

<sup>258</sup> <https://feature.undp.org/covid-19-and-the-sdgs/>

<sup>259</sup> Gostin, L. O., Karim, S. A., & Mason Meier, B. (2020). Facilitating access to a COVID-19 vaccine through global health law. *The Journal of Law, Medicine & Ethics*, 48(3), 622-626.

<sup>260</sup> [https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status\\_COVID\\_VAX\\_23April2021.pdf](https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status_COVID_VAX_23April2021.pdf)

## COVID-19-Т ХАРИУ ҮЗҮҮЛЭХЭД НҮБ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ<sup>261</sup>

### *(Ulku Halatci Ulusoy)*

Олон улсын энхтайван, аюулгүй байдлыг хангах, хамгаалах үндсэн үүргийг хүлээсэн НҮБ бусад олон асуудлын нэгэн адил COVID-19-т хариу өгч чадахгүй байна. НҮБ-ын төрөлжсөн байгууллага болох Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) 114 болон түүнээс олон улсад гарсан тул шинэ коронавирусийн халдвар КОВИД-19 өвчнийг 2020 оны 3-р сарын 11-ний өдөр цар тахал гэж зарласан. ДЭМБ энэхүү мэдэгдэлийг хожимдуулж хийсэн бөгөөд үр дүнтэй арга хэмжээ авч чадахгүй байна гэсэн шүүмжлэлд өртсөн. АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп цар тахлын зохицуулалттай холбогдуулан ДЭМБ-ын санхүүжилтийг зогсоов. Тэрбээр НҮБ-ын агентлагийг Хятадад вирус илэрсний дараа түүний тархалтыг буруу удирдаж, нуун дарагдуулж байна гэж буруутгав.

НҮБ өнгөрсөн зуунд тулгарсан хамгийн том аюул заналхийлэл гэж үзсэн COVID-19-тэй тэмцэхэд туйлын идэвхгүй байсаар ирсэн нь урам хугалав. Аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар АНУ-ын шаардлагаар COVID-19 буюу "Хятадын вирус" ба "Ухань вирус"-ийг хэлэлцэхийг Хятад, Орос эсэргүүцэж хойшлуулав. НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөл нь олон улсын энхтайван, аюулгүй байдлыг хангах, хамгаалах үндсэн үүрэгтэй. НҮБ-ын дүрмийн 39-р зүйлд зааснаар "Аюулгүй байдлын зөвлөл нь энхтайван байдалд заналхийлэх, энхтайвныг зөрчих, түрэмгийлэл үйлдэх эсэхийг тодорхойлж, зөвлөмж гаргах, эсхүл олон улсын энхтайван, аюулгүй байдлыг хадгалах, сэргээхэд 41, 42 дугаар зүйлд заасны дагуу ямар арга хэмжээ авахаа шийднэ." гэж заасан. Аюулгүй байдлын зөвлөлөөс гадна Ерөнхий ассамблей, ерөнхий нарийн бичгийн дарга нар НҮБ-ын бусад албан газар, байгууллагуудтай хамт чухал үүрэг гүйцэтгэдэг.

Эцэст нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Гутерреш НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийг COVID-19-ын эсрэг хурдан хариу арга хэмжээ аваагүй хэмээн шүүмжилж, цар тахлын эсрэг тэмцэх, үүнд нэгдэхийг уриалав. НҮБ-ын гэрээний 99-р зүйлд заасны дагуу Ерөнхий нарийн бичгийн дарга олон улсын энхтайван, аюулгүй байдлыг хамгаалахад аюул учруулж болзошгүй асуудлыг Аюулгүй байдлын зөвлөлийн анхааралд оруулах бүрэн эрхтэй.

Энэ асуудлаар олон улсын байгууллагын анхны хуралдаан дээр Гутерреш үг хэлэхдээ: "Аюулгүй байдлын зөвлөлийн оролцоо нь цар тахлын энхтайван, аюулгүй байдлын үр дагаврыг багасгахад чухал үүрэг гүйцэтгэнэ" гэж онцолжээ. Тэрбээр бүх улсууд коронавирусийн цар тахлын хүнд нөхцөл байдалтай тэмцэж, олон мянган хүн нас барж, эмнэлгүүд хүч барагдаж, эрүүл мэндийн ажилтнууд энэ ачааллыг үүрч, тэмцэж байгааг цохон тэмдэглэв. Тэрбээр хурцадмал байдал, хууль ёсны асуудал, хүчирхийлэл зөрчилдөөнийг өдөөх, террорист заналхийлэл, биологийн террорист халдлага болон хүний эрхийн зөрчлийг онцлон тэмдэглэв. "Аюулгүй байдлын зөвлөлийн оролцоо нь тахал өвчний улмаас энхтайван, аюулгүй байдалд заналхийлэхээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ" гэж хэллээ. Гуттерешийн хэлснээр ийм түгшүүртэй үед Зөвлөл эв нэгдэлтэй байж, шийдэл олох нь маш чухал гэдгийг илэрхийлсэн.

### ***Эбола вирусийн тархалтын сургамжууд***

2014–2016 онд Эбола тахал хурдацтай тархсаны улмаас дэлхийн хэмжээнд олон талт онцгой нөхцөл байдал, гэнэтийн бэрхшээлийг дагуулсан юм. Ерөнхий нарийн бичгийн дарга асан Бан Ги Мун Гвиней, Либери, Сьерра-Леонд хяналтгүй байсан эболагийн

<sup>261</sup> <https://www.abdn.ac.uk/law/blog/role-of-the-united-nations-in-responding-to-covid19/>



дэгдэлттэй холбогдуулан НҮБ-аас анх удаа НҮБ-ын Эболагийн Онцгой байдлын үеийн төлөөлөгчийн газар (UNMEER) байгуулжээ. НҮБ-ын Ерөнхий ассамблей 2014 оны 9-р сарын 19-ний өдрийн 69/1 тоот тогтоолыг санал нэгтэй баталсны дараа НҮБ-ын Эболагийн Онцгой байдлын үеийн төлөөлөгчийн газрыг байгуулсан.

Нэмж хэлэхэд, Ерөнхий Ассамблейн үйл ажиллагаанаас гадна Аюулгүй байдлын зөвлөл 2014 оны 9-р сарын 18-ны өдөр 2177 тоот тогтоолоор Баруун Африкт эбола вирусын тархалт хурдацтай тархаж байгаатай холбогдуулан олон улсын энхтайван, аюулгүй байдалд заналхийлж байна гэсэн үндэслэлээр шийдвэр гаргасан. Энэхүү шийдвэр нь Аюулгүй байдлын зөвлөлийн хувьд нийгмийн эрүүл мэндийн асуудал анх удаа олон улсын энх тайван, аюулгүй байдалд заналхийлж байна гэж үзсэн чухал үйл явдал болсон. Аюулгүй байдлын зөвлөлөөс 2010, 2011 онд ХДХВ/ДОХ-той холбоотой шийдвэрүүдийг гаргасан боловч аюулгүй байдлын аюул занал нь эбола вирусийн халдвартай холбоотой шийдвэрүүдийн нэгэн адил байгаагүй.

Нийгмийн эрүүл мэндийн аюул заналхийлэлтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаа 2014 оны 2177 тоот тогтоолыг санал нэгтэй гаргаж, улс орнуудыг олон улсын энхтайван, аюулгүй байдалд заналхийлж буй эбола тахал өвчнөөс урьдчилан сэргийлэхэд туслахыг уриалав. Зөвлөлийн шийдвэрийн оршил хэсэгт "...Африкт урьд өмнө тохиолдож байгаагүй Эбола вирусийн тархалт олон улсын энхтайван, аюулгүй байдалд заналхийлж байна" гэжээ. Гэсэн хэдий ч Зөвлөл 2177 (2014) тоот тогтоолын дагуу гүйцэтгэх үйл ажиллагааг зөвшөөрөөгүй ч эбола вирусийн дэгдэлтийн аюулгүй байдалтай холбоотой үр дагаврын талаар гаргасан шийдвэр нь норматив нөлөө үзүүлж, Зөвлөлийн Баруун Африктай холбоотой НҮБ-ын дүрмийн VII бүлэгт заасан үйл ажиллагаанд шууд бусаар нөлөө үзүүлсэн.

Нөгөөтэйгүүр, Зөвлөлөөс 2014 оны 12-р сарын 9-ний өдөр Либери дэх тодорхой зорилтот газруудын эсрэг зэвсэглэл, аялалын хориг арга хэмжээний тухай 2188 (2014) тогтоолыг батлав. Зөвлөл эбола нь бүс нутгийн улс төрийн тогтвортой байдалд нөлөөлж, энхтайвны бүтээн байгуулалтын ололтоо алдаж болзошгүй гэсэн болгоомжлолын үүднээс тухайн үед хүчин төгөлдөр хэрэгжүүлж байсан хориг арга хэмжээгээ сунгах шийдвэр гаргасан. Гэсэн хэдий ч холбогдох шийдвэрүүдэд эрүүл мэндийн эрхийг хэрэгжүүлэх талаар улс орнууд үүрэг хүлээгээгүй болно. Энэ нь улс орнууд хүний эрх, ялангуяа эрүүл мэндийн эрхийн талаар хүлээх үүргийг дурдаагүй нь томоохон дутагдал болсон гэж үзсэн.

Олон улсын энхтайван, аюулгүй байдалд заналхийлж буй COVID-19-ийг тогтоосноор халдвараас зайлсхийж байгаа нь эргэлзээгүй бөгөөд аюулгүй байдал нь халдвараас зайлсхийхийг эрмэлзэж буй улс орнуудад харилцан адилгүй ашигтай байж болох нь эргэлзээгүй юм. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Анна "Эрх чөлөөний том тайланд" (2005) "Хорин нэгдүгээр зууны энхтайван, аюулгүй байдалд заналхийлж байгаа нь олон улсын дайн, мөргөлдөөн төдийгүй иргэний хүчирхийлэл, зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм, үй олноор хөнөөх зэвсэг орно. Мөн ядуурал, үхлийн аюултай халдварт өвчин, хүрээлэн буй орчны доройтол зэрэг нь сүйрлийн үр дагаварт хүргэж болзошгүй юм." гэж цохон тэмдэглэжээ.

Дэлхий нийтийн нөхцөл байдлаас шалтгаалан цар тахлын эсрэг тэмцэлд улс хоорондын хамтын ажиллагаа, эв санааны нэгдэл маш их ач холбогдолтой юм. Улс орнуудын хил хязгаараа хаах талаар авч буй нэг талын арга хэмжээ нь хямралыг даван туулахад хангалтгүй юм. Улс орнууд эдийн засаг, худалдааны асуудлаар бие биендээ хэрэгтэй байгааг харгалзан COVID-19-ийн асуудлуудаар мэдээлэл солилцох, ил тод байх ёстой.

COVID-19-ийн үүсгэж буй нийгэм, эдийн засгийн хямралыг удирдахад НҮБ чухал үүрэг гүйцэтгэж, улс орнуудыг удирдан чиглүүлж, тэднийг дэмжих ёстой.

VII бүлэгт заасан Эбола вирусийн халдварын талаарх Аюулгүй байдлын зөвлөлийн тогтоолоор COVID-19-тэй тэмцэх талаар зааварчилгаа өгөх боломжтой. 2177 тоот тогтоолыг (2014) санал нэгтэй баталж, 130 орчим улс оронд дэмжсэн бөгөөд энэ нь Зөвлөлийн түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлт болсон. Үүний эсрэгээр, өнөөдрийг хүртэл Аюулгүй байдлын зөвлөлд COVID-19-ийн талаар өгсөн зөвлөмжөөс дүгнэлт гараагүй байна.

### ***Аюулгүй байдлын зөвлөлийн Вето бэрхшээлийг хэрхэн даван туулах вэ***

Аюулгүй байдлын зөвлөлийн байнгын гишүүд дэлхийн хэмжээнд тохиолдож буй COVID-19 тохиолдлын бараг 50% -ийг эзэлж байгаа боловч энэ асуудлаар санал зөрөлдөөнтэй байгаа нь COVID-19-тэй тэмцэх шийдвэр гаргахад саад болж байна.

НҮБ-д суугаа АНУ-ын Байнгын төлөөлөгч Келли Крафт олон нийтийн эрүүл мэндийн мэдээллийг ил тод байлгаж, цаг тухайд нь хуваалцахыг уриалав. АНУ Хятад улсыг буруутгаж байгаа тул Аюулгүй байдлын зөвлөлд зөвшилцөлд хүрэх боломжгүй байна. Энэ нөхцөл байдалд юу хийж болох вэ? Энэ тохиолдолд НҮБ-ын Ерөнхий Ассамблей тоглолт хийж магадгүй юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2020 оны 4-р сарын 2-ны өдөр 74/270 тоот тогтоолыг баталж, COVID-19-тэй тэмцэхэд "олон улсын хамтын ажиллагаа", "олон талт байдал" -ыг уриалж, дэгдэлт эхэлснээс хойш олон улсын байгууллагаас анхны бичвэрийг гаргасан. Тэрхүү 74/270 тоот тогтоолд 193 гишүүнтэй НҮБ-ын Ерөнхий Ассамблейд дэлхий даяар тархсаар байгаа COVID-19-ийн улмаас хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдалд аюул учирч байгаад "маш их санаа зовж байна" гэж тэмдэглэжээ.

НҮБ-ын тогтоол нь дэлхийн эрүүл мэнд, эдийн засгийн хямралд гол үүрэг гүйцэтгэхийг онцлон тэмдэглэв. Үүнийг 193 улсаас 188 улс буюу Швейцар, Индонез, Сингапур, Норвеги, Лихтенштейн, Гана зэрэг улсууд баталсан.

Энэ нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас дэлхий нийтийг хамарч, дэлхийн түгшүүр төрүүлж буй цар тахлын талаар гаргасан анхны тогтоол юм. Цар тахлын улмаас НҮБ-ын Ерөнхий Ассамблей хуралдахгүй байгаа бөгөөд чимээгүй горимоор батлав.

Дараагийн шатанд COVID-19-ийн талаар улс орнууд шийдвэр гаргах ёстой. Энхтайвны төлөө нэгдэх тогтоол гэгддэг Ерөнхий Ассамблейн 377 (V) тогтоол нь энэ талаарх удирдамж болно.

1950 онд батлагдсан тогтоолд Аюулгүй байдлын зөвлөл, байнгын гишүүд санал нэгдээгүйгээс олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах шаардлагын дагуу ажиллах үндсэн үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Ерөнхий Ассамблей олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сэргээх зорилгоор гишүүн орнуудад зөвлөмж өгөх асуудлыг нэн даруй авч үзнэ. Хэрэв чуулганд оролцоогүй бол Ерөнхий Ассамблей нь COVID-19-ийн яаралтай онцгой хуралдааны механизмыг ашиглан хуралдаж болно. Тиймээс НҮБ цар тахлын эсрэг бүхий л чадавхаа аль болох богино хугацаанд хэрэгжүүлэх ёстой юм.

## COVID-19 ЦАР ТАХЛЫН ШАЛГАЛТ БА НҮБ-ЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ<sup>262</sup>

*(Bruno Charbonneau)*

### *Хураангуй*

НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөл (НҮБАЗ) нь цар тахлын эсрэг харилцан хамтын ажиллагааг дэмжих эсхүл нөхцөлдүүлэх зэргээр ажиллаж чадаагүй тул COVID-19 –ын шалгалтанд бүдэрлээ. КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах талаар олон улсын хамтын ажиллагаа нэн шаардлагатай байгаа цаг үед үүнийг эхлүүлэх эсхүл хязгаарлах зэргээр ажиллах ёстой байсан НҮБ-ын гол байгууллага ийнхүү ажиллаж чадаагүй нь санаа зовоож байна. Ийнхүү НҮБ-ын Аюулгүйн зөвлөл нь COVID-19 цар тахлын эсрэг зохистой хариу арга хэмжээ авч чадаагүй нь тухайн зөвлөлийн олон улсын хамтын ажиллагааны форум талбар болохын хувьд түүхэн хязгаарлагдмал талуудыг нь харуулж өгч байна. Мөн энэ нь НҮБАЗ-ийн шинэчлэлийн талаар дэвшүүлэн авч үзэх, мэтгэлцэх зэрэг нь хангалттай биш, бүр цаашид ялангуяа дэлхий нийтийн хамтын ажиллагаа шаардагдах цар тахал, цаг уурын өөрчлөлт зэрэг тулгамдсан асуудлуудын хүрээнд ч үр бүтээлтэй арга замаар урагшлан дэвшихэд ч хангалтгүй гэж үзэх үндэс байж болзошгүй байна.

Энэхүү КОВИД-19 цар тахал нь дэлхий нийтийн хэмжээний эрүүл мэндийн их гамшиг тул өөр хоорондоо харилцан хамаарал бүхий улс үндэсний бодлого болон дэлхийн засаглалын янз бүрийн олон хямралын зангилаа болж байна.

Хэдийгээр анагаахын шинжлэх ухаан COVID-19 өвчинтэй тэмцэх эмчилгээний болон бусад холбогдох аргуудыг олж боловсруулсан, цаашдаа ч улам бүр боловсруулан хөгжүүлсээр байх боловч тэдгээр арга шийдлүүдийн чухам алийг нь хэрхэн сонгох, хэрэгжүүлэх вэ гэдэг нь засаглах эрх мэдэл, эдийн засаг, нийгмийн харилцааны асуудал юм. Улс төрийн бодлого ба засаглал нь тухай тухайн улс орны засгийн газар, нийгэм ба олон улсын байгууллагуудын бэлэн байдал, хариу арга хэмжээний бодит байдлыг тайлбарлах үндэс болно. COVID-19 цар тахлын дэгдэлт, тархалт нь дэлхийн засаглалын хэв шинжийг илчилсэн төдийгүй КОВИД-19 цар тахлын эсрэг зохистой хариу арга хэмжээ авч чадаагүй, тэр бүү хэл олон улсын хямралын менежментийн хүрээнд ч манлайлал үзүүлж огт чадаагүй НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн үнэн дүр төрхийг сайн илчилж өглөө.

НҮБ-ын аюулгүй байдлын түүхэн хязгаарлагдмал байдал, сүүлийн үеийн хурцадмал байдал зэргийг бодолцон үзвэл энэхүү бүтэлгүйтэл нь тийм ч гайхмаар зүйл биш байж магадгүй юм. Гэсэн хэдий ч НҮБАЗ-ийн ач холбогдол, тодорхой хэлбэл, олон улсын хамтын ажиллагааг эхлүүлэх эсхүл хязгаарлах чадамжтай НҮБ-ын нэгэн гол байгууллага гэдэг үүднээсээ түүний энэхүү бүтэлгүйтэл санаа зовнихоор асуудал мөн юм. НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөл бол НҮБ-ын гишүүн орнуудын хүрээнд хууль ёсны шийдвэр гаргах, улмаар НҮБ-ын дүрмийн VII бүлэгт заасны дагуу эдгээр шийдвэрийг хориг тавих эсхүл цэргийн хүч хэрэглэх зэргээр хэрэгжүүлэх эрх бүхий НҮБ-ын цорын ганц байгууллага юм. Энэ нь түүнийг НҮБ-ын олон улсын хамтын ажиллагааны хамгийн хүчирхэг байгууллага, форум болгодог билээ. Иймээс түүний үйл ажиллагаа, холбогдох бодлогууд нь түүний гишүүдийн- ялангуяа хориг тавих эрхтэй байнгын таван гишүүн

---

<sup>262</sup> <https://journals.sagepub.com/doi/10.1177/0020702020986897>- The COVID-19 test of the United Nations Security Council

орны хоорондын харилцааны нөхцөл байдлын талаар, улмаар хамтын ажиллагаа, дэлхийн эрүүл мэндийн асуудлын хувьд хамтын зохицуулалттай бөгөөд амжилттай хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломж, бололцооны талаар бидэнд их зүйлийг хэлж өгч чадна.

2020 оны эхний хагаст НҮБАЗ нь КОВИД-19 цар тахалтай хэрхэн тэмцэх, түүний олон улсын энх тайван ба аюулгүй байдалд үзүүлэх үр нөлөөг хүлээн зөвшөөрөх талаар дотроо гүнзгий санал зөрөлдөөнтэй байв. 2020 оны 3-р сарын 23-нд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антониу Гутерреш *"зэвсэгт мөргөлдөөнийг хорьж, бүх нийтээрээ амьдралын төлөөх жинхэнэ тэмцэлд анхаарлаа төвлөрүүлэхийн"* тулд *"дэлхийн хэмжээнд нэн даруй гал зогсоохыг"* уриалав. Энэхүү уриалга нь аливаа дайн байлдаан нь халдварт өвчнийг улам бүр тархаах нөхцөл болохын зэрэгцээ цар тахлын үр нөлөөний эсрэг хийж буй орон нутгийн болон олон улсын хариу арга хэмжээний чадамж боломжийг бууруулж байна гэх үзэл санаанд тулгуурласан юм. Дэлхий нийтийг хамарсан цар тахал нь урьд өмнөх нэн идэвхтэй зөрчилдөөн тэмцэлдээнүүдийг улам бүр хурцатгаж мэдэхээр байв. Гутеррешийн уриалга нь угтаа олон улсын эрүүл мэндийн гамшигийн нөхцөлд энхийн үйл ажиллагааг дэмжих боломж байсан юм. Уриалгын цаадах онол ийм байв.

Дэлхийн хэмжээнд гал зогсоох тухай энэхүү уриалгаар Гутерреш манлайлал үзүүлсэн боловч НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөл нь 7 дугаар сарын 1-ний өдөр 2532 дугаар тогтоолыг баталсан боловч хамаг эрч хүчийг нь алдагдуулсан байв. Учир нь мөргөлдөөний бүсүүдэд ямар ч бодит үр дүн гараагүй юм. Гутеррешийн санаачлагыг ийнхүү дэмжиж чадаагүй нь голчлон байнгын таван гишүүний хоорондох АНУ болон БНХАУ-ын хоорондох нэг нь нөгөөгөө буруутгах асуудал хурцадмал байснаас үүссэн үр дүн юм.

Хэд хэдэн шинжээчид болон олон улсын байгууллагууд COVID-19 нь мөргөлдөөний динамикт нөлөөлж, тогтворгүй байдлыг бий болгоно гэж таамаглаж байсан бол түүний үр нөлөө одоог хүртэл хязгаарлагдмал байна. НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн хувьд, Гутеррешийн гал зогсоох уриалгын байлдааны ажиллагааг түр зогсоох, энх тайвны үйл явцад НҮБ-ын дипломат ёсыг бэхжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг дэмжих боломжийг алдсан юм. COVID-19 нь цаашдаа ч удаан үргэлжлэх ноцтой үр дагавар бүхий сорилт бөгөөд асуудал юм. Үүнд НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн *"уламжлалт бус"* аюулгүй байдлын сорилтуудтай нүүр тулах нь гарцаагүй юм. Эдийн засгийн өсөлт, нийлүүлэлтийн сүлжээ, хүнсний аюулгүй байдалд шууд болон ойрын ба ирээдүйд үзүүлэх үр дагаврууд нь ихээхэн ноцтой, зөрчил мөргөлдөөн, тогтворгүй байдлыг ч үүсгэж болзошгүй байгаа юм.

COVID-19 нь олон улсын хамтын ажиллагааны институт болох НҮБ-ын түүхэн болон хязгаарлагдмал дүр төрхийг тодруулж өгөв. Цар тахлын улмаас урьд өмнөх асуудлууд улам хурцдаж, ялангуяа геополитикийн өрсөлдөөн эрс нэмэгдэж, НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөл ба НҮБ-ын Ерөнхий Ассамблейн (UNGA) хоорондын харилцаан дахь үзэл бодлын зөрүү, тэгш бус байдал мэдэгдэхүйц нэмэгдсээр байна. Энэ нь мөн НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн дотоодод, ялангуяа АНУ, БНХАУ-ын хоорондох урьд өмнөх хурцадмал байдлыг улам нэмэгдүүлж, АНУ-ын НҮБАЗ дэх нөлөөг хурдацтай муутгаж байна гэж хэлж болно.

COVID-19-ийн энэхүү "шалгалт" нь олон талт оролцооны хүрээнд үүссэн хямралын явцад илүү томоохон хэв маяг, чиг хандлагыг эрэлхийлснээр үл барам, дэлхий нийтийн хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай буйг харуулж байна. Тиймээс ийм хамтын ажиллагааг НҮБАЗ-ийн дотоодод эсхүл гадна бэхжүүлэх арга замыг хайж олох

шаардлагатай болохыг ч мөн харуулж байна. COVID-19 цар тахал бол зөвхөн эхлэл юм. Алсдаа үүнээс өөр олон олон цар тахал тохионо, уур амьсгалын өөрчлөлт ч гарсаар байх болно. *COVID-19-ийг дэлхий нийтийн хамтын ажиллагааны механизмыг шинээр зохион бүтээх, дахин хөрөнгө оруулах ёстой гэсэн сэрүүлэг гэж үзэж болохоор байна.* COVID-19-ийн нөхцөл байдлаар харахад, энэ мэт тулгамдсан сорил бэрхшээлийг шийдвэрлэхэд түр зуурын хямралын менежментийн арга хэмжээ биш харин урт хугацааны төлөвлөлт, тууштай байдал шаардлагатай нь тодорхой байна. Гэтэл НҮАБЗ-ийн үйл ажиллагаа түр зуурын хямралын менежментийн шинжтэй байсаар ирлээ. Саад бэрхшээл гэдэг элдэв олон янз боловч давах аргагүй эсвэл зайлсхийх боломжгүй зүйл биш юм. Үүнчлэн COVID-19 нь цөөнгүй жилийн хугацаагаар дэлхийн хэд хэдэн үйл ажиллагааг хямраасан хэвээр, хүнд асуудал хэвээр байж болох ч бас хүн төрөлхтөнд сайн ч бай, муу ч бай дэлхий нийтийн эмх цэгцийг дахин бодож, нягтлан үзэх боломжийг олгож байна.

Гэсэн хэдий ч НҮБАЗ гэх НҮБ дахь байгуулга нь дэвшүүлсэн асуудалд хэзээ ч дүгнэлт хийдэггүй, эсхүл өөрийн статус квотыг өөрчлөх, ялангуяа өөрийн гишүүдийнхээ хориг тавих эрх мэдлийг өөрчлөхийг оролдоггүй тул энэхүү дэлхийн байгуулал, эмх цэгцийг эргэн бодох асуудлыг бараг НҮБАЗ-гүйгээр, түүнээс гадуур гүйцэтгэх шаардлагатай болж магадгүй.

### **UNSC ба цар тахал**

НҮБ-ын дүрмийн V бүлэгт НҮБ-ын гишүүд “Аюулгүй байдлын зөвлөлд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах үндсэн хариуцлагыг даатгаж, тус зөвлөл нь энэхүү үүргээ гүйцэтгэхдээ тэдний нэрийн өмнөөс үйл ажиллагаагаа явуулахыг зөвшөөрнө” гэсэн байна. Энэхүү мэдэгдэлд “олон улсын энх тайван, аюулгүй байдалд” заналхийлж буй зүйл юу вэ гэсэн асуулыг нээлттэй үлдээсэн байдаг. Үүнийг ийнхүү нээлттэй, уян хатан үлдээсэн нь НҮБАЗ-ийг улс төрийн шийдвэр гаргах нөхцөлд тохируулан зохицуулах боломжийг бий болгосон хэрэг байв.

НҮБ-ыг үүсгэн байгуулагч гишүүд нь “болзошгүй бүх аюулаас хамгаалахын төлөө ажиллах Аюулгүй байдлын зөвлөлийг”, “онолын хувьд хязгааргүй цар хүрээтэй, аль ч цаг үед, ямар ч арга хэлбэрээр тохиолдож болзошгүй бүх аюул заналд” хариу арга хэмжээ авах чадамжтай тийм байгууллагыг хүсцгээж байжээ.

Гэтэл бодит байдал дээр тус зөвлөлийн байнгын гишүүд нь энэхүү уян хатан байдлыг аливаа болзошгүй аюул заналд хариу арга хэмжээ авах ямарваа үүргээс зайлсхийхэд л ашигласаар ирэв. Үүнээс гадна хэдийгээр 1946 онд батлагдсан ДЭМБ-ын Үндсэн хуулийн өмнөх үгэнд эрүүл мэнд болон аюулгүй байдлын уялдаа холбоог хүлээн зөвшөөрсөн байдаг ч тухайн үеийн хүйтэн дайны нөхцөл байдал нь НҮБАЗ-ийн хэлэлцэх аюулгүй байдалд заналхийлж буй асуудлуудын хүрээг улам бүр хумиж хязгаарлаж өгсөн байдаг. Ингээд зуун солигдох зааг үеэс “уламжлалт бус” буюу уур амьсгалын өөрчлөлт, цар тахал, терроризм ба цахим халдлага зэрэг үндэстэн дамнасан аюул заналхийллийн асуудлуудыг илүү анхаарч эхэлснээр цар тахлыг дахин НҮБАЗ-ийн хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж ирсэн байна. 2000 онд НҮБАЗ-ийн хуралдааны үеэр АНУ-ын зүгээс ХДВХ/ДОХ өвчин нь “Африкт ноцтой аюул заналхийлэл” болоод байна гэсэн асуудлыг дэвшүүлжээ. Үүний үр дүнд 1308 дугаар тогтоолыг батлан гаргасан боловч энэ нь ердөө “олон улсын энхийг сахиулагчдын эрүүл мэндийг хохироож болзошгүй ХДВХ/ДОХ-ын” асуудлыг хүлээн зөвшөөрч, хөндөн үзэх, ерөнхий нарийн бичгийн даргыг “ХДВХ/ДОХ-ын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх талаар “сургалт зохион байгуулах цаашдын арга хэмжээ авахыг” хүсэх төдийхөнөөр хязгаарлагдсан байдаг. Энэ бол хэд хэдэн гишүүн



улсын зүгээс НҮБАЗ-ийн дэлхий нийтийн эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх чадамжийн талаар асуулга тавьсаны дүнд хүрсэн үйл явц байсан юм.

Баруун Африкт 2014 онд дэгдсэн Эбола вирусийн өвчлөл нь НҮБ-ын хамгийн анхны эрүүл мэндийн онцгой байдлын ажиллагаа ба илүү хүчтэй хариу арга хэмжээ авах шалтгаан болсон. Гэвч энэ нь зарим улс орны засгийн газрууд болон ДЭМБ-ын амжилтгүй үйл ажиллагааны дараагаар хийгдсэн байдаг. Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мун НҮБАЗ ба НҮБ-ын Ерөнхий Ассамблейд хандсан албан захидалдаа: “НҮБ-ын Эболатай тэмцэх ажлыг хийхийн тулд ДЭМБ-ын “маш сайн ложистик, үйл ажиллагааны чадавх бүхий стратегийн зорилт, үзэл санаатай мөр зэрэгцэн явах шаардлагатай байна” гэж өгүүлжээ. Ингээд үүнийг дэмжиж НҮБАЗ-өөс 2144 дүгээр тогтоолыг даруйхан гаргажээ. Энэхүү тогтоолыг 130 орон дэмжиж, Баруун Африкийн энэхүү халдварт өвчин нь “олон улсын энх тайван, аюулгүй байдалд заналхийлж байна” гэж үзжээ.

..Гэсэн ч Эбола тахал өвчин халдвар тархсан улс орнуудын тогтвортой байдлыг алдагдуулж, АНУ-д халдварын тохиолдол бүртгэгдэхийг хүртэл энэ өвчний талаарх урьдчилсан бөгөөд маш тодорхой сануулга сэрэмжлүүлгийг үл ойшоосоор байсан байдаг. Ингээд ДЭМБ болон халдвар тархсан улс орнууд энэ өвчний дэгдэлт тархалтын эсрэг хүчин мөхөсдөж буйгаа нотолсны дараа л Ерөнхий нарийн бичгийн дарга нь UNMEER-(UN Mission for Ebola Emergency Response-Эболагийн онцгой байдалд хариу арга хэмжээ авах НҮБ-ын миссион)-ыг хүчээр үүсгэн байгуулсан байдаг.

...Эбола болон UNMEER-ийн үйл ажиллагаа нь ДЭМБ нь хүчирхэг улс орнуудын нөөц баялаг, ашиг сонирголоос хамааралтай байдгийг тодорхой харуулж байна. Тиймээс ДЭМБ нь Дэлхийн Хойд хэсгийн улс орнуудын ашиг сонирхол ба аюулгүй байдлыг эрхэмлэдэг байна. Учир нь тэд өвчний халдвар тархалтын менежмент ба хариу арга хэмжээ зэрэг нь “хэврэгхэн төр” бүхий Дэлхийн Өмнөд хэсгийнхэнд илүү шаардлагатай гэсэн ойлголт төсөөллөөр ажилладаг ажээ... Гэтэл КОВИД-19 цар тахал нь Дэлхийн Хойд хэсэгт илүү хүчтэй бөгөөд хурдацтай тархаж, улмаар газар сайгүй тархсан нь энэхүү ойлголт төсөөллийн хязгаарыг дэлгэн харуулсан хэрэг болсон юм. Үүнээс илүүтэйгээр ДЭМБ-ын бүтэц, санхүүжилт хангалтгүй нь хамгийн гол шалтгаан болжээ. Түүний жилийн төсөв 2,5 тэрбум ам.доллар байна гэх боловч үүнийхээ зөвхөн 20 хувийг л авдаг байна. Энэ мэт түүхэн хязгаарлагдмал талуудыг нь хүлээн зөвшөөрч ДЭМБ-ыг шинэчлэх тухай яриа хэлэлцээр 2020 оны 8 дугаар сард Женев хотноо зохион байгуулагджээ. Энэ үеэр Франц, Германы төлөөлөгчид тус байгууллагыг бэхжүүлэх шаардлагатай байгаа, хөрөнгө санхүүжилт хангалтгүй байгаа тухай, хууль эрх зүйн чадамжгүй болон хэт их гадны нөлөөлөлтэй байгаа зэрэг асуудлуудыг нь хөндсөн хамтын санал дүгнэлтийг бусад төлөөлөгч нарт түгээн илэрхийлж байсан.

Эбола өвчний хямрал, КОВИД-19 цар тахлын аль нь ч дэлхий нийтийн цар тахлын талаарх олон улсын бодлого нь бэлгэ тэмдгийн шинж чанартай ба чухамдаа Майкель Барнеттийн либериад олон улсын дэг ёсны (order) золиослох практик гэж нэрлэсэнтэй адил байдаг ажээ: “хүн төрөлхтөний шатлан захирах бүтэц гэдгийг хүний амь насны харьцангуй үнэ цэнэ, хэний зовж буй асуудал бусдынхаас илүү вэ гэдэг тодорхойлолт, гол төлөв зах зээлийн зарчмаар ажилладаг, ялангуяа цар тахлын үеэр маш тодорхой харагддаг үр дагавруудаар илэрхийлэгдэнэ”. Барнеттийн үзлээр бол “олон улсын дэг ёс зохих хэмжээний золиос шаардаж байхад либериад дэг ёсонд бүх амь нас адилхан бөгөөд адил асаргаа авах эрхтэй хэмээх хүн төрөлхтөн ба хөгжил дэвшлийн итгэл үнэмшилд суурилдаг тул өөрийн үхснийг хүлээн зөвшөөрөхдөө маш хэцүү байна”, хүн



бүр “аливаа өвчин зовлонг” арилгах “үүрэг харицлагатай” байна. КОВИД-19 нь Эболатай адилгүйгээр олон улсын дэг ёсыг дорвитой сорьж буй шалгалт болж байна. Барнеттийн үзсэнээр бол энэ нь бас “Олон улсын харилцааны салбарт олон улсын дэг ёс хэмээх ойлголтыг хэрхэн сонгож бүрэлдүүлэх вэ гэдгийг сорьж байна гэжээ.

### ***НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл КОВИД-19-ийн шалгуур***

2020 онд НҮБАЗ дээр эрүүл мэндийн хамтын ажиллагааны байгууллага нь Ерөнхий нарийн бичгийн даргын дэлхий нийтээр дайны галыг зогсоох тухай уриалгыг идэвхтэй дэмжих нь зүйтэй байлаа. Дайтагч улс орнуудын зарим нь энэхүү уриалгыг нааштайгаар хүлээн авсан байна. Зөрчилдөж буй талуудын яг хичнээн нь гал зогсоох тухай саналын талаар бодсон нь тодорхойгүй. НҮБАЗ уриалгыг дэмжсэн хэдий ч дайтагч талуудыг шаардан, энхийн хэлэлцээрт хөтлөх боломжтой байлаа. Адаглаад энэ нь КОВИД-19 цар тахлын хямралыг давах олон талт зохион байгуулалтын ажлыг дэмжих дэмжлэг болох байв.

Харин эсрэгээрээ НҮБАЗ үүргээ гүйцэтгэсэнгүй. Батлагдсан тогтоол нь байнгын тавд өчүүхэн төдий, бүр огтоос эрсдэлгүй байсан. НҮБАЗ-ийн тогтоолыг дэмжих гэрээ нь БНХАУ, АНУ болон ОХУ-ын үзэл бодлын зөрүүнээс шалтгаалж хойшлогдсон юм. АНУ болон ОХУ нь дайны галыг зогсоох тухай энэхүү шийдвэр нь Ирак, Афганистан, Сир улсуудад тус тус явуулж буй алан хядагчдын эсрэг үйл ажиллагаанд нь ямар хор уршиг тарьж болох талаар санаа зовцгоож байв. АНУ КОВИД-19 цар тахлын дэгдэлтэд БНХАУ болон ДЭМБ-ыг буруутган, 2021 онд ДЭМБ-аас гарахаа мэдэгдэн Их 7, Их 20, НҮБ болон ДЭМБ-тай хамтран хэрэгжүүлэх олон талт ажиллагааг мухардуулж байлаа. Харин энэ үеэр БНХАУ КОВИД-19 цар тахлын дэгдэлтийг хязгаарлах тус улсын үйл ажиллагааны талаарх олон улсын шүүмжлэлийг үгүйсгэхээр хичээнгүйлэн ажиллаж байсан юм. КОВИД-19 цар тахлын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар хэдэн сарын турш үргэлжилсэн маргааны үеэр хоёр улс нь НҮБ-ын системийг тэргүүлэх боломжгүй бөгөөд хүсэлгүйгээ илэрхийлж байлаа.

Эцэст нь 3 сарын дараа 2532-р тогтоолыг батлав. Франц болон Тунис зэрэг улсууд уг тогтоолыг батлуулахын тулд шаргуу ажиллав. Тогтоолд КОВИД-19 нь олон улсын энх тайван, аюулгүй байдалд заналхийлэх боломжтой бөгөөд дараагийн 90 хоногийн хугацаанд галаа зогсоохыг шаардсан байна. Гэвч гал зогсоох үйл ажиллагаа хэрэгжээгүй ба Исламын улс, Ал Каида болон бусад холбоотой бүлгийнхний эсрэг цэргийн үйл ажиллагааг гүйцэтгэсэн. Дэлхий нийтээр галаа зогсоох тухай 2532-р тогтоолоор баталсан уриалга нь түүхэндээ анх удаа хийгдсэн хэдий ч хэрэгжээгүй юм.

1945 оноос хойш НҮБАЗ-ийн байнгын гишүүн 5 орон өөрсдийн эрх ашиг, үзэл бодлын зөрөлдөөний улмаас байнга хурцадмал байдалд, зөрчилдөөнтэй байсаар ирсэн. НҮБАЗ-ийн КОВИД-19 цар тахлын эсрэг арга хэмжээ авч чадаагүй байдал нь одоогийн улс төрийн нөхцөл байдал төдийгүй тус байгууллага дотор үүсэн бий болсон шударга бус байдлыг харуулж байгаа хэрэг юм. Ялангуяа одоогийн гишүүнчлэл болон хориг тавих бүрэн эрх нь дайны үеийн холбоотнуудыг эрх мэдэл бүхий олигархиуд болгон хувиргасны үр дүн юм.

КОВИД-19-ийн тархалт нь мөн НҮБ дахь бүтцийн маргаантай асуудлыг ил болгов. Ерөнхий нарийн бичгийн даргын гал зогсоох уриалгыг дэмжин ажиллаагүй болон цар тахалтай дэлхий нийтээрээ нэгдэн тэмцээгүй зэрэг НҮБАЗ-ийн удаа дараа гаргасан алдаанууд нь НҮБ-ын тогтолцоонд гажуудал үүссэн болохыг харуулж байна. Үүний илрэл нь НҮБАЗ, ерөнхий нарийн бичгийн дарга болон НҮБ-ын Ерөнхий Ассамблей хоорондын

хамтын ажиллагааны асуудал. Дүрэмд зааснаар ерөнхий нарийн бичгийн дарга болон Ерөнхий Ассамблей нь НҮБАЗ-д үүрэг өгч ажиллана.

Ерөнхий нарийн бичгийн дарга Гутеррешийн тэмдэглэн хэлснээр “КОВИД-19 нь бидний бүтээн байгуулсан нийгмийн хэврэг суурь бүтцийг рентген туяагаар харж байгаа мэт нэвт харуулж чадлаа. Алдаа дутагдал, худал хуурмаг байдал хаа сайгүй байна: Чөлөөт зах зээл нь хүн бүрт эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх боломжтой гэсэн нь худал болохыг, үнэ төлбөргүй асран сувилах ажил нь ажил биш гэсэн нь үлгэр болохыг, бид арьс өнгөөр ялгаварлан гадуурхдаггүй дэлхийд амьдарч байна гэсэн нь төөрөгдөл болохыг, бид бүгд нэгэн завин дээр яваа гэсэн нь эндүүрэл болохыг мэдэж авлаа. Учир нь бид нэгэн далайд хамт сэлж байна гэж үзвэл зарим нь супер дарвуулт завиар сэлж байхад зарим нь салхинд туугдан яваа модны хэлтэрхийнээс зууран явна” гэв. КОВИД-19 нь НҮБ-ын өмнөх болон одоо үеийн бүтцийн тэгш бус байдлыг илрүүлэн, НҮБАЗ-ийн хүлээсэн үүрэг, эрх хэмжээ, холбоо хамаарлыг тогтоон, гишүүн орнуудын хамтын ажиллагаанд шинэчлэлт, өөрчлөлт шаардлагатай болохыг харууллаа.

### **Дүгнэлт**

НҮБ-ын Аюулгүй Байдлын Зөвлөлийн өмнөөс КОВИД-19-ийн талаар хэрэгжүүлж буй олон улсын бодлогыг авч үзвэл ачааны хүндийг АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсон Жое Байден болон түүний шинээр бүрдсэн засаг захиргаа үүрч байна гэж үзэхээр байна. Цагаан ордны тэргүүн солигдох нь НҮБАЗ-ийн баримтлах чиг хандлагад нөлөөлөх нь гарцаагүй боловч энэ нь БНХАУ-АНУ хоорондын харилцаанд нөлөөлнө гэсэн хэрэг биш юм. АНУ-ын шинээр байгуулагдсан засаг захиргаа нь олон улсын хэмжээнд баримталж байсан хуучин бодлогоо баримтлах бол энэ нь, Трампын баримталж байсан олон талт бодлогоос үүдэлтэй олон асуудлуудыг шийдвэрлэх шийдлийг санал болгох бус харин КОВИД-19-ийн өмнө болон Трампаас өмнө баримталж байсан хуучны, АНУ-ын тэргүүлдэг хийгээд гол ашгийг нь хүртдэг либерал олон улсын бодлого байх болно. Эцсийн эцэст либерал олон улсын бодлого нь биднийг одоо байгаа газарт маань авчирсан (биднийг хямралаас урьдчилан сэргийлж эсхүл түүнээс гаргаж чадсангүй).

Бид “энгийн” буюу КОВИД-19-ийн өмнөх нөхцөл байдал руугаа эргэн очих боломжгүй, учир нь нэг талаараа коронавирус хүмүүсийг үхүүлсээр байх бөгөөд бусад төрлийн вирусуд ч үүсч бий болно, нөгөө талаар дэлхий ертөнц хувьсан өөрчлөгдсөөр байна. Энэхүү хувирал, өөрчлөлтийн цар хүрээ, явц байдал нь бидэнд ил байх хэдий ч, хамгийн гол нь өөрчлөлтийн учир шалтгааныг бид анхааралтай авч үзэх шаардлагатай.

НҮБАЗ дээрх КОВИД-19-ийн талаарх маргаан дээр тэгш бус байдлыг бий болгон, түүнийгээ үргэлжлүүлэн авч явсаар байгаа олон улсын харилцаан дахь голлон тоглогчдын талаар цохон тэмдэглэсэн байна. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Гутеррешийн хэлснээр “колонилол өв залгамжлагдан үргэлжилсээр байна”. Үүнээс үзвэл, цар тахал болон цаг уурын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ авч болохоор хэмжээний хугацаа өнгөрсөн хэдий ч хангалттай арга хэмжээ аваагүй НҮБ-ын Ерөнхий Ассамблей нь 1974 онд Олон улсын эдийн засгийн шинэ горимыг баталсан тунхаглалаараа тэгш бус байдлыг бий болгосон шигээ колонилолыг үргэлжлүүлэх талбар хэвээр үлдэх үү? Бид ийм дэлхийг хүсэх үү?

Олон улсын харилцааны онол нь дэлхийг олон улсын дайн болон олон улсын хамтын ажиллагаа, эмх замбараагүй байдал болон дэг журам, реализм болон идеализм гэсэн 2 туйлт ойлголтоос цааш төсөөлөхдөө муу байдаг. НҮБАЗ-ийн КОВИД-19-тэй холбоотой бүтэлгүйтэл болон уур амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтын хүрээнд, үзэл

баримтлал, бүтцийн хувьд урьдны адил байхад НҮБАЗ-ийн шинэчлэлийн талаар ярилцах нь цаг үрсэн хэрэг юм. НҮБ-ын систем бүхэлдээ өөрийн үүсгэн байгуулсан бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулна гэдэг нь тун бүрхэг асуудал юм. Харин НҮБАЗ нь тус байгууллага дотор өөрчлөлт, шинэчлэлт шаардлагатай ганц бүрэлдэхүүн хэсэг нь биш бөгөөд дэлхий ертөнцийг төсөөлөх шинэ арга зам, улс орнуудын хамтын ажиллагааны шинэ хувилбаруудыг эрэлхийлэх шаардлагатай байна.

**ДЭЛХИЙН УДИРДАГЧДЫН УУЛЗАЛТААР ТОМООХОН УЛС ГҮРНҮҮДИЙН ДУНД ТЭГШ БУС БАЙДАЛ ӨСӨН НЭМЭГДЭХИЙН ХЭРЭЭР ХУРЦАДМАЛ БАЙДАЛ ДААМЖИРЧ, УЛМААР НҮБ-ЫН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР ТОХИРОЛЦООНД ХҮРЭХЭД УЛАМ БҮР ХҮНДРЭЛТЭЙ БОЛЖ БАЙГААГ ОНЦОЛЖ БАЙНА**<sup>263</sup>

Нэгдсэн Үндэстний Байгууллага (АН) - Бараг 1 сая хүний амь насыг авч одсон коронавирус НҮБ-ын улс орнуудыг нэгтгэж чадаагүй бөгөөд дэлхийн байгууллагыг шинэчлэх уриалга гаргаснаар дэлхийн өнцөг булан бүрд өөр өөр сорилтуудыг даван туулж байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш: "Цар тахал бол олон улсын хамтын ажиллагааны тод сорилт бөгөөд бидний үр дүнтэйгээр даван туулах нь шалгуур болох юм." Мөн тэрээр "Манлайлал ба эрх мэдлийн хоорондох холбоо тасарч байна" гэж хэлээд, 21 дүгээр зууны харилцан шүтэлцээтэй ертөнцөд "эв нэгдэл бол бидний ашиг сонирхол юм", "хэрэв бид энэхүү бодит байдлыг ойлгож чадахгүй бол бүгд хохирол амсах болно" гэдгийг сануулсан юм.

Ерөнхий Ассамблейд анх удаа дэлхийн удирдагчдын виртуал уулзалт болж, томоохон улс гүрнүүдийн хооронд үүссэн хурцадмал байдал, баян, ядуу орнуудын тэгш бус байдал улам бүр нэмэгдэж, НҮБ-ын 193 гишүүн орнууд томоохон асуудлаар тохиролцоход улам хүнд болж байгааг онцоллоо. Дэлхийн 2 дугаар дайны үнс нурман дундаас 50 гишүүнтэйгээр өндийн боссон НҮБ нь тэр үеэс хойш эрс өргөжөн тэлсэн билээ. Эдгээр үүсгэн байгуулагч улсууд АНУ-ын Сан Франциско хотод "хойч үеэ дайны гамшгаас хамгаалах болно" хэмээн тангараг өргөж, НҮБ-ын Дүрмийг баталснаас хойш 75 жилийн дараа тэгш бус байдал, өлсгөлөн, уур амьсгалын асар их хямралд автсан, дэлхий даяар зэвсэгт мөргөлдөөн үргэлжилсэн хэвээр байна.

Швейцарын Ерөнхийлөгч Саймонетта Соммаруга: "Бид үүнд НҮБ-ыг шүүмжилж болох боловч НҮБ-ыг буруутгахдаа бид хэний тухай яриад байна вэ?" хэмээн асуугаад, "НҮБ гэдэг бол түүний гишүүн орнууд гэсэн үг. Тийм учраас бид өөрсдийнхөө тухай ярьж байна гэсэн үг. Гэхдээ бас НҮБ-ын үйл ажиллагаанд саад болох гишүүн улс ч бас нэлээд байна." гэж хэлсэн юм.

Аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан дээр хориг тавьсан таван байнгын гишүүний хоёр нь АНУ, Хятад улсууд байсан бөгөөд тэд бие биенээ коронавирусийг үл тоомсорлож, улс төржсөн гэж буруутгах үед хурцадмал байдал тодорхой харагдаж байсан. ОХУ сүүлийн жилүүдэд ойрын холбоотон Бээжинг дэмжиснээр олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй НҮБ-ын хамгийн хүчирхэг байгууллага илүү гүнзгий хямарч, Сири дэх зэвсэгт мөргөлдөөн зэрэг томоохон асуудлыг шийдвэрлэх боломжгүй болжээ.

Францын Ерөнхийлөгч Эммануэл Макрон: НҮБ нь "жигжиг зүйл дээр ч тохиролцоход маш

<sup>263</sup> <https://apnews.com/article/virus-outbreak-antonio-guterres-archive-united-nations-united-nations-general-assembly-0848c358291362abfdce330b7b5e6420>

их бэрхшээлтэй", "хүчгүйдэх эрсдэл өндөр" болсон гэж хэллээ. "Манай нийгэм хэзээ ч ийм харилцан хамааралтай болж байгаагүй. Энэ бүхэн болж байгаа энэ цаг мөчид бид хэзээ ч ийм зохицолгүй, уялдаа холбоогүй байж болохгүй" гэдгийг тэрээр нэмж хэлэв.

Кени Улсын Ерөнхийлөгч Ухуру Кениатта: "75 настай НҮБ нь гишүүн орнуудынхаа ихэнхээс, ялангуяа дэлхийн хүн амын 96 хувиас ахмад" болохыг цохон тэмдэглэв. Мөн тэрээр "Мэдээж хэрэг дэлхийн хүн амын дийлэнх нь өнөөдөр үүсээд буй нөхцөл байдалтай холбоогүй" гэж хэлээд, "Өнөөдрийн дэлхийд үүсээд буй нөхцөл байдал юунаас болж байна вэ?" гэсэн асуултыг тавилаа.

Олон удирдагчдын хувьд, НҮБ-ын хамгийн чухал үүрэг болох зохицуулах эрх мэдэл нь бүх үндэстнүүдийг нэг дор цуглуулж, ярилцах явдал юм. Гэхдээ дүрмийнхээ талаар олон бухимдалтай байдаг 193 улстай 75 жилийн ойд зориулсан тунхаглал зэрэг гол баримт бичгийнхээ талаар харилцан зөвшилцөх гэж хэдэн сарын турш хэлэлцээр хийсэн. 1979 оноос эхэлж 40 жилийн турш эцэс төгсгөлгүй үргэлжилсэн хамгийн маргаантай мэтгэлцээн бол Аюулгүй байдлын зөвлөлийг шинэчлэх асуудал байв. Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлд АНУ, Хятад, Орос, Франц, Их Британи гэсэн байнгын таван гишүүнээс тус олон улсын хүчний бүтэц бүрдсэн байдаг. Зөвлөлийн бусад 10 орон тоонд бусад гишүүн улс хоёр жилийн хугацаатайгаар ээлжлэн суудаг. Дэлхийн өнөөгийн бодит байдлыг харгалзан 15 гишүүнтэй энэхүү зөвлөлийг шинэчлэн сайжруулахыг өргөн хүрээнд дэмжиж байгаа боловч хүчин чармайлт нь үндэсний болон бүс нутгийн өрсөлдөөнд автсан хэвээр байна. 2005 онд, гүн хуваагдал нь Ерөнхий ассамблейг өргөжүүлэх тухай гурван өрсөлдөгчийн тогтоолыг хүчингүй болгоход хүргэсэн юм. Герман, Япон, Бразил, Энэтхэг зэрэг улсын хувьд 25 гишүүнтэй зөвлөлд хориг тавих эрхгүй нэг байнгын орон тоотой байхыг хүссэн. Итали, Пакистан зэрэг дунд зэрэглэлийн орнуудын бүлэг байнгын бус 10 суудалтай, 25 гишүүнтэй болгохыг хүсэж байв. Харин Африкийн холбоо нь 26 гишүүнтэй болгож, зөвлөлд зургаан байнгын гишүүний орон тоо нэмэхийг хүссэн бөгөөд үүнээс хоёр нь хориг тавих эрхтэй Африкийн, тав нь байнгын бус байх ёстой гэж үзсэн. Тэр үед дэлхийн удирдагчид зөвлөлийг "илүү өргөн хүрээнд төлөөлөлтэй, үр ашигтай, ил тод" байлгахын тулд даруйхан шинэчлэхийг уриалсан юм.

Гэгээн Люсиагийн Ерөнхий сайд Аллен Частанет: бусад улс орнуудтай "бичвэрт суурилсан хэлэлцээрийг хөхүүлэн дэмжиж, шинэчлэлийн ажлыг түргэсгэх болно" гэдгээ илэрхийлэв.

Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Мод: "НҮБ-ын шийдвэр гаргах бүтцээс гадуур Энэтхэгийг хэр удаан байлгах вэ?" 1.3 тэрбум хүнтэй Энэтхэг бол дэлхийн хамгийн том ардчилал бөгөөд дэлхийн хүн амын 18 хувийг эзэлдэг "энэхүү агуу байгууллагын хамаарлыг хадгалахын төлөө" тууштай ажиллана гэдгээ илэрхийллээ.

Намбиагийн Ерөнхийлөгч Хэйж Гейнгоб: өнгөрсөн жилийн Ерөнхий ассамблейн уулзалтын үеэр 75 жилийн ой нь зөвлөлийн шинэчлэлийг хийх "боломж" олдоно гэж найдаж байсан боловч ийм зүйл болоогүйд харамсаж байгаагаа хэлэв.

Аргентины Ерөнхийлөгч Альберто Фернандес: "НҮБ-ын хувьд Аюулгүй байдлын зөвлөлийн шинэчлэл төдийгүй бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд шинэ эрч хүч хэрэгтэй" гэж хэллээ. Мөн тэрээр "Бидэнд үндэстний үнэт зүйлсэд суурилсан, технологийн асар том өөрчлөлтийг багтаасан, илүү хүмүүнлэг, илүү ардчилсан, илүү хүртээмжтэй нийгмийг бий болгох НҮБ 4.0 хэрэгтэй байна" гэж нэмж хэлсэн юм.

Германы Канцлер Ангела Меркель: "Тодорхой шийдвэр гаргах шаардлагатай үед Аюулгүй байдлын зөвлөл гацаанд орчихдог", НҮБ-д шинэчлэл хийх хэрэгцээ шаардлага

нь “21 дүгээр зууны дэлхийн сорилтуудтай хөл нийлүүлэх” явдал юм гээд, "Төгсгөлд нь, НҮБ-ын гишүүд нэгдмэл байхын хэрээр үр дүнтэй ажиллаж чадна" хэмээн онцлон тэмдэглэв.





## Хоёрдугаар хэсэг: НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 2030 хөтөлөр ба Монгол Улсын талаарх товч мэдээлэл

### МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ - 2030

“Тогтвортой хөгжлийн зорилт-2030” нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг юм.

Дэлхийн Тогтвортой Хөгжлийн Зорилт (ТХЗ)-ын 17 зорилго, 169 зорилт нь манай улсын ТХҮБ-2030-ын 4 бүлэг, 44 зорилт дараах байдлаар уялдаж байгаа юм. Дэлхийн ТХЗ-ын шалгуур 241 үзүүлэлтээс МУ-д хамааралгүй 13 үзүүлэлтийг хасч, үлдсэн 228 үзүүлэлтийг 335 үзүүлэлт болгон өргөтгөсөн.



### **ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд үндэсний хэмжээнд хийж буй үйл ажиллагааны талаар**

- Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор УИХ-аас МУ-ын “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” хуулийг 2015 оны 11-р сард баталсан.
- Монгол Улсын хэрэгжүүлэх яамдын сайд нарыг оролцуулсан Ерөнхий сайдаар ахлуулсан Тогтвортой хөгжлийн үндэсний хороог 2016 онд байгуулсан.
- ТХЗ-уудын үндэсний үзүүлэлтийг тодорхойлох, суурь болон хүрэх зорилтот түвшинг тодорхойлох 8, аргачлал, арга зүйг боловсруулах 1, нийт 9 ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд тус ажлын хэсгээр Монгол Улсын хэмжээнд 326 үзүүлэлтүүдийг тодорхойлох боломжтой гэсэн үр дүн гарсан байна.
- УИХ-ын 2016 оны 7 дугаар сарын 21-ны өдрийн 12 дугаар тогтоолоор төрийн захиргааны байгуулалтын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн баталж, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Үндэсний хөгжлийн газар”-ыг байгуулсан.



- ТХЗ-ын дэд хороог УИХ-ын нийгмийн бодлого боловсрол соёл шинжлэх ухааны байнгын хорооны дэргэд байгуулан ажиллаж байна.
- ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийн гарах бэлэн байдал Үндэсний Статистикийн хороо, НҮБХХ-тэй хамтарсан болон ҮСХ-ноос бие даасан 3 удаагийн үнэлгээг хийсэн.

### ***Тогтвортой хөгжлийн зорилтын 17 зорилтын хүрээнд хийгдсэн ажил***

#### ***1. Ядуурлыг устгах (7 зорилт 14 үзүүлэлт)***

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилтууд нь Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулсан

Төрөөс авч буй арга хэмжээ:

- Хүүхдийн мөнгө (Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.5-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны, хүүхдийн мөнгөн тэтгэмж авах хүсэлт гаргасан хүүхэд бүрд сар бүр бэлэн мөнгөөр олгох УИХ-ын № 96 тогтоол)
- “Цалинтай ээж” хөтөлбөр хэрэгжүүлэх, Өрх толгойлсон эх /эцэг/-ийн нийгмийн хамгааллын хуулийг 2018 онд баталсан.
- Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолын хавсралт)

#### ***2. Өлсгөлөнг зогсоох (8 зорилт 13 үзүүлэлт)***

Тогтвортой хөгжлийн “Өлсгөлөнг зогсоох” талаарх 2-р Зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтүүд тухайлбал, Хоол тэжээлийн дутагдлын тархалт (2.1.1) болон Хүнсний баталгаат байдлын алдагдлыг тооцсон хэмжүүрт үндэслэн хүн амын дундах хүнсний баталгаат байдлын дунд болон хүнд хэлбэрийн тархалт (2.1.2)-ыг одоогийн байдлаар Монгол улсын хэмжээнд тогтоогоогүй байгаа бөгөөд энэ талаар холбогдох байгууллагууд НҮБ-ын ХХААБ-тай хамтран ажиллаж байна.

Төрөөс авч буй арга хэмжээ:

- Монгол Улсын Засгийн Газраас “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.
- Өсөлтийн хоцрогдолтой 5 хүртэлх насны хүүхдийн дунд хоол тэжээлийн дутагдлын тохиолдлыг 2000-2017 онд 29,8 хувиас 2,3 хувь болгож бууруулсан.

#### ***3. Эрүүл мэндийг дэмжих (13 зорилт 23 үзүүлэлт)***

Төрөөс авч буй арга хэмжээ:

- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 77 дугаар тогтоолоор баталж, ХЗДХ-ийн сайдаар ахлуулсан Үндэсний хороог байгуулсан.
- Засгийн газраас сүүлийн 20 жилийн хугацаанд “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний дөрвөн хөтөлбөр (1997-2016), “Эхийн эндэгдлийг бууруулах стратеги” (2001-2004, 2005-2010), “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн аюулгүй

байдал, тогтвортой хангамж стратеги” (2009-2013), “Эх, нярайн эрүүл мэнд стратеги” (2011-2015), “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх стратеги” (2014-2020), “Нярайн тандалт, шинжилгээний хөтөлбөр” (2014-2020) зэрэг 10 гаруй бодлогын баримт бичгийг хэрэгжүүлсэн.

- “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.
- Хүн амын эрүүл мэндийн талаар Монгол Улсын төрөөс баримтлах бодлого болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан нь Монгол Улсын Засгийн газар болон бусад оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж байна. Эдгээр хүчин чармайлтын үр дүнд уушгины хатгалгаанаас сэргийлэх вакцин (PCV)-ы дархлаажуулалт, бичил тэжээл, жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийг худалдан авах хөрөнгө Монгол Улсын 2019 оны эрүүл мэндийн салбарын төсөвт тусгагдсан.

#### **4. Чанартай боловсролыг дэмжих (10 зорилт 11 үзүүлэлт)**

- Сургуулийн өмнөх боловсролын сайжруулсан хөтөлбөр (2019-2020) хичээлийн өмчийн хэлбэр харгалзалгүй авч хэрэгжүүлсэн.
- ЕБС-ийн багш нарт зориулсан Мэдээллийн технологийн чадавхын үндэсний стандарт боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран Техник мэргэжлийн боловсрол, сургалт болон ур чадварын сургалтын талаарх бодлогод үнэлгээ хийж бодлогын баримт бичгийн төслийг боловсруулсан.
- Монгол Улсын дээд боловсролын байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, тэдний олгож байгаа мэргэжил мэргэшлийн стандартыг олон улсын түвшинд зөвшөөрөгдөх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр НҮБ-аас дэмжлэг үзүүлж байна.

#### **5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах (9 зорилт 14 үзүүлэлт)**

Төрөөс авч буй арга хэмжээ:

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, 2017-2021 батлагдсан.
- Жендэрийн үндэсний хорооны ажлын албыг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллуулах болсон.

#### **6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах Жендерийн эрх тэгш байдлыг хангах**

- “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл” хэрэгжүүлж байна.

#### **7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх(5 зорилт 6 үзүүлэлт)**

Төрөөс авч буй арга хэмжээ:

- Үндэсний зорилтот хувь нэмэр зорилгын хэрэгжилтийг МУ-ын Засгийн газраас Эрчим хүчний дунд хугацааны хөтөлбөр баталсан. (2018 оны 325-р тогтоол)

#### **8. Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих Жендерийн эрх тэгш байдлыг хангах (12 зорилт 17 үзүүлэлт)**

Төрөөс авч буй арга хэмжээ:

- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санд 2016 онд 56.7, 2017 онд 50.6, 2018 онд 65 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн.
- 2018 онд 136 төсөлд 3%-ийн хүүтэй зээл олгосон.

### **9. Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх (8 зорилт 12 үзүүлэлт)**

Төрөөс авч буй арга хэмжээ:

- Инновацийн тухай хуулийн 6.1.1, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.29-д Инновацийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулан гаргахаар заасны дагуу инновацийг хөгжүүлэх үндсэн зорилго, зорилт, үйл ажиллагааны гол чиглэлийг тодорхойлсон “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”-ыг боловсруулсан.

### **10.Тэгш бус байдлыг бууруулах(10 зорилт 11 үзүүлэлт)**

Төрөөс авч буй арга хэмжээ:

- “Ядуурлын үндсэн үзүүлэлтийг тооцох болон өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэх, судалгааг 2018 онд хийсэн.

### **11.Ээлтэй хот иргэдийн оролцоог дэмжих(10зорилт 15 үзүүлэлт)**

Төрөөс авч буй арга хэмжээ:

- МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр-ийн Барилга, хот байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.89-д Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасан.
- УИХ-аас 2017 оны 3 дугаар сард батлан гаргасан “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”-ийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд Засгийн газар онцгой анхаарал ажиллаж байна.

### **12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих(11 зорилт 13 үзүүлэлт)**

Төрөөс авч буй арга хэмжээ:

- “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах хог хаягдлын бүртгэл, мэдээллийг нарийвчлан авч байх асуудлыг 2014 оноос эхлэн хэрэгжүүлэхээр шийдвэр гарсан.

### **13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах (5 зорилт 8 үзүүлэлт)**

Төрөөс авч буй арга хэмжээ:

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээрт 2016.09 сард нэгдэн орсон.
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай үндэсний хөтөлбөр 2011-2021
- Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр 2010-2020 нь 2 үе шаттайгаар 9 дэх жилдээ хэрэгжиж байгаа бөгөөд БОАЖЯ-ны сайдаар ахлуулсан Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо ажилладаг.

- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого 2015-2030
- “АЛТ-2” Үндэсний хөтөлбөр (2017-2020)
- Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого 2018-2027 хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

#### **14. Далай тэнгисийн нөөцийг хамгаалах(12 зорилт 14 үзүүлэлт)**

Төрөөс авч буй арга хэмжээ:

- АМТХ-иар хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгохоор заасан, хүсэлт гаргасан дарааллаар олгох болсон.

#### **15.Хуурай газрын экосистемийг хамгаалах(12 зорилт 14 үзүүлэлт)**

Төрөөс авч буй арга хэмжээ:

- Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц, Биологийн төрөл зүйлийн тухай конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын ерөнхий конвенц, Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын ерөнхий конвенцийн Киотогийн протокол зэрэг хүрээлэн буй орчны эрхийн асуудлыг тусгасан олон улсын 18 гэрээнд нэгдэн орж, мөн тогтвортой хөгжлийг дэмжих Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөтөлбөр болох Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл хөтөлбөрт нэгдэн орсон анхны оролцогч улсын нэг болсон.

#### **16. Энхтайван, шударга ёсыг цогцлоох(12 зорилт 23 үзүүлэлт)**

Төрөөс авч буй арга хэмжээ:

- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хүүхдийн эсрэг гэмт хэрэг бүхий бүлгийг 2015 онд нэмж оруулсан.
- Хүүхдийн эрхийн тухай хуулийг 2016 онд батлахдаа аливаа хэлбэрээр хүүхдийг хүчирхийлэхийг хориглож, хүүхэд бүхий л орчинд зодож шийтгүүлэхээс ангид байх эрхийг тусгайлан баталгаажуулсан болно.
- 2017 онд Хүүхэд хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг баталсан.
- Монгол Улс Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх дэлхийн түншлэлд нэгдсэн.

#### **17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх(19 зорилт 27 үзүүлэлт)**

Төрөөс авч буй арга хэмжээ:

- “Тулгамдаж байгаа гадаад өрийн асуудлыг эдийн засаг, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр бүтцийг өөрчлөн зохицуулж, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2020 он гэхэд 58.6 хувиас, 2025 он гэхэд 50 хувиас, 2030 он гэхэд 40 хувиас хэтрүүлэхгүй байж, өрийн зохистой түвшинг хангах” гэж тусгагдсан.

#### **Засгийн газраас цар тахлын нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулах иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр авсан арга хэмжээний тойм**

Засгийн Газрын 2020 оны 01-р сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30-р тогтоол баталсанаас хойш Монгол Улсын хэмжээнд нийтдээ коронавирусийн цар

тахалтай холбоотой 1 хууль, УИХ-ын 4 тогтоол, Засгийн газрын 36 тогтоол батлагдсан байна. Тухайлбал,

1. Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль: Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах юм.

2. УИХ-ын 2020 оны 04-р сарын 09-ний өдрийн 21-р тогтоол: Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай тогтоолыг баталсан.

3. УИХ-ын 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 32-р тогтоол: Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай

4. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03-р сарын 27-ны өдрийн 114-р тогтоол: Эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээг баталсан.

5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 05-р сарын 06-ны өдрийн 167-р тогтоол: Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед төсвийн Зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай

6. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11-р сарын 18-ны өдрийн 183-р тогтоол: Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай


7. Нийгмийн эмзэг бүлгийг эдийн засгийн хямралаас хамгаалах хөтөлбөрийн хоёр дахь багц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энэ удаа зорилтот бүлгийн ард иргэдэд туслах зорилгоор дотоодын нийт бүтээгдэхүүний 2%-тай тэнцэх хэмжээний санхүүгийн туслалцаа үзүүлэх төсөв батлав. (2020.05.06) Энэхүү олгогдож буй мөнгөн тусламжийн арга хэмжээнүүдийг Засгийн газраас бусад зардлаа танах замаар нөхнө хэмээн заасан байна.

8. Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар Ковид-19 үеэр авч хэрэгжүүлж буй эдийн засгийн арга хэмжээг дахин сунгасан. (2020.08.05)

### ***Эдийн засгийн тогтвортой хүрээнд хийгдсэн ажил***

Үүнд:

- Зарим импортын хүнсний бараа бүтээгдэхүүн мөн эм эмнэлгийн хэрэгслүүдийг татвараас чөлөөлөх,
- Хүүхдийн мөнгө, ажилгүйдлийн тэтгэмжийг нэмэгдүүлэх,
- 2020 оны 9 дүгээр сарыг дуустал аж ахуйн нэгжүүдийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх,
- Хөгжлийн банкнаас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлийн батлан даалт гарган, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авсан. ( 2020.03.27)
- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг цаашид нэмэгдүүлэх,
- Хүнсний талон олгох,



- Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон эцэг эхчүүд болоод бүтэн болон хагас өнчин хүүхдүүдэд олгох нийгмийн халамжийн тэтгэмжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.
- Хүүхдийн мөнгийг 100,000 төгрөг хэвээр үлдээх,
- Аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас чөлөөлөх,
- Түрээсийн орлогын албан татвараас чөлөөлөх,
- Импортын зарим бараа бүтээгдэхүүнийг гаалийн болон нэмүү өртгийн албан татвараас чөлөөлөх
- Хүнсний талоны хүрэлцээг нэмэгдүүлэх,
- Нийгмийн халамжийн тэтгэмжийг нэмэгдүүлэх,
- Нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлсэн бөгөөд эдгээрт дотоодын нийт бүтээгдэхүүний 7.5 орчим хувьтай тэнцэх төсвийг УИХ 2020 оны 8 дугаар сарын 28-ний өдөр батлан гаргав.
- 12 дугаар сарын 1-ний өдрөөс ирэх оны 7 дугаар сарын 1 хүртэл төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, уул уурхайн олборлолт, боловсруулах чиглэлийн ААН, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч, согтууруулах ундаа, тамхи үйлдвэрлэгч зэрэг 9 байгууллагаас бусад ААН-үүдийн цахилгаан, дулаан, дулааны уур, усан хангамж, хогны төлбөрийг тэглэсэн,
- 100 хүртэл м.кв талбайтай сууцтай айл өрхүүдийн дулааны төлбөрийг тэглэсэн бөгөөд 100 м.кв-аас дээш талбайтай сууцтай айл өрхүүдийн хувьд үлдсэн төлбөрийг өөрсдөө төлөхөөр зааж өгсөн. Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдэд шахмал түлшийг 25 хувийн үнээр олгох болсон.(2020.12.23)

### **Төсвийн болон мөнгөний бодлогын хүрээнд авсан арга хэмжээ**

#### 1) Монголбанкнаас гаргасан мэдэгдэлд:

- Бодлогын хүүг 100 суурь пунктээр 10 хувь болгон бууруулах
- Банкуудын төгрөгийн 3 БН-ыг 200 нэгжээр бууруулж, 8.5 хувь болгон бууруулах
- Бодлогын хүүгийн коридорыг  $\pm 1$  хувь болгон нарийсгах болсноо мэдэгдсэн бөгөөд 3БН шалгуурын өөрчлөлт нь банкны системд 324 тэрбум төгрөг (ДНБий 0.8 хувь) нэмэлт хөрөнгийг чөлөөлөв.

2) Монголбанкнаас гаргасан мэдэгдэлд бодлогын хүүг 100 суурь пунктээр 9 хувь хүртэл бууруулж, одоо байгаа хэрэглээний зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө 12 дугаар сар хүртэл хойшлуулах боломжийг ард иргэдэд олгов.

3) Монголбанк энэ оны 7 дугаар сард дуусах байсан санхүүгийн хөнгөлөлтийн арга хэмжээг түр сунгах болсноо 2020 оны 8 дугаар сарын 7-ны өдөр зарлав.

4) Монголбанк бодлогын хүүг 100 нэгжээр бууруулж 8 хувь болгов.

5) Монголбанк бодлогын хүүг 200 нэгжээр бууруулж 6 хувь болгож, төгрөгийн 3БН-ийн шаардлагыг 250 нэгжээр 6 хувь болгон бууруулж, бусад арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1 хүртэл үргэлжлүүлэн сунгасан. Монголбанкны мөнгөний бодлогын хорооны хуралдаанаар:

- Бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх;
- Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх;



- Эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
- Жижиг дунд үйлдвэр, уул уурхай бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх багц шийдвэрийг гаргасан.

### **Боловсролын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Монгол Улс КОВИД-19 цар тахлын тархалтыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль болон боловсролын бусад байгууллагуудаа хаасан. Үүнд 1,454 цэцэрлэг, 839 ерөнхий боловсролын сургууль, 88 их, дээд сургуулийн 1,093,034 суралцагчид, 50,043 багш, олон мянган ажилтан өртөөд байна. Сургуулиудыг хааснаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын суралцагчдад цахимаар болон теле хичээлээр, их дээд сургуулийн оюутнуудад цахимаар алсын зайн сургалтыг зохион байгуулж байна.

### **КОВИД-19 цар тахлын үед дэх УИХ хянан шалгах чиг үүрэг**

УИХ-аас Ковид-19 цар тахлын үед Засгийн газар болон УОК-ын үйл ажиллагаанд шаардлагатай эрх зүйн орчин бий болгож, хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Улсын Их Хурал нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т зааснаар “УИХ хууль тогтоох, төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үндсэн чиг үүрэгтэй бөгөөд Ковид-19 цар тахлын үед хянан шалгах чиг үүрэг дараах байдлаар хэрэгжүүлж байна.

### **Түр хороо байгуулав:**

#### **УИХ-ын тогтоол 2020.05.13 №49**

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороо байгуулахаар заасны дагуу Түр хороо байгуулсан.

Тус заалтын дагуу байгуулагдсан түр хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодын дарга нар болон Улсын Их Хурал дахь Ардчилсан нам, Шинэ намын төлөөлөл орсон.

#### **УИХ-ын тогтоол 2020.10.29 №31**

“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороо”-г байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Баттөмөр ажиллаж байна.

Түр хороо 5 удаа хуралдсан бөгөөд түр хорооны хуралдаанаар дараах асуудлыг

хэлэлцсэн.

2020.11.03. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлт болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар мэдээллийг сонссон.

2020.11.24. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлт, Монгол Улс дахь цар тахлын нөхцөл байдал болон Засгийн газар, Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа бодлогын арга хэмжээ болон цар тахлын үед зохицуулалтын салбарын санхүүгийн зах зээл дээр хийж, хэрэгжүүлж буй ажлууд

2020.12.23. Монгол Улсад коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тохиолдол бүртгэгдэж, Засгийн газраас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Засгийн газар, Улсын онцгой комиссоос Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл, банк, банк бус санхүүгийн байгууллагуудын зээл, зээлийн хүү, зээлийн эргэн төлөлтийн талаар.

2021.03.04. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмчилгээний арга тактик, цар тахлын голомтыг хумих талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын вакцины хангалт, нийлүүлэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон цар тахлын үед гадаадад байгаа иргэдийн татан авалтын талаар

2021.03.31. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын нөхцөл байдал, цар хүрээ, хязгаарлалтын дэглэм, вакцины ханган нийлүүлэлт болон коронавируст халдвар цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг бусад Байнгын хороогоор хэлэлцүүлэх санал гаргах, Засгийн газрын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх тус тус хэлэлцсэн.

**УИХ-ын тогтоолууд батлав:** (4 тогтоол батлав)

**УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоол:** Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай. Энэхүү тогтоолын хүрээнд:

1.Хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж, үүнд шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвт зохицуулалт хийх, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн нэмэлт эх үүсвэр бүрдүүлэх замаар санхүүжүүлэх;

2.Зарим шаардлагатай оношилгоо, эмчилгээний хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх;

3.Төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажилладаг иргэдээс бусад иргэдийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр

эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх;

4.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон, мөн 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжүүд ажлын байрыг хадгалж байгаа бол уг аж ахуйн нэгжийн даатгуулагч иргэнд 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгох;

5.Сайн дураар даатгуулсан иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд түүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлж, даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцох;

6.Үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалсан, мөн хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн төрийн байгууллагаас бусад хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцох;

7.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад албан татвар төлөгчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон орлогод ногдуулан тайлагнасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг чөлөөлөх;

8.2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд ногдуулж тайлагнасан боловч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан торгох шийтгэлээс чөлөөлөх;

9.2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд татвар төлөгчийн хуулийн дагуу ногдуулан тайлагнасан төлбөл зохих татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас тухайн татвар төлөгчийг нэг удаа чөлөөлөх;

10.2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлсэн албан татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан тохиолдолд бууруулсан хэмжээгээр түрээсийн орлогод ногдуулах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэх;

11.2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд стратегийн зарим хүнсний барааг импортлоход гаалийн болон импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх;

12.Ариутгал, халдваргүйжүүлэлт, эрүүл ахуйн горимд иргэдийг эрүүл, аюулгүй орчинд үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлсэн үйлдвэр, үйлчилгээний газруудыг үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжоор хангаж ажиллах;

13.Эдийн засгийг төрөлжүүлэх, дэмжих, ажлын байр бий болгох, нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээг идэвхжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, эх үүсвэр бүрдүүлэх гэрээ, хэлэлцээрийг байгуулах;

14.Дотоодын аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хийхдээ нэн тэргүүнд үндэсний үйлдвэрлэгчийг шалгаруулах зарчим баримтлах зэрэг зохицуулалт болно.

**УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоол:** Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай

Монгол Улсын урт хугацааны тогтвортой өсөлтөд дэмжлэг үзүүлж, үүсэх эрсдэлээс хамгаалж, санхүүгийн чадвартай байх, эрүүл, тогтвортой, зохистой засаглал бүхий банкны салбарыг бий болгох шинэчлэлийн хөтөлбөрийг гаргаж, хэрэгжүүлэх, зээл, санхүүжилтийн хүү болон эх үүсвэрийн зардлыг бууруулах, цар тахлын үед төрөөс нийгмийн шаардлагатай хэсэгт хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх, хүн амын эрүүл мэнд улсын аюулгүй байдлын төлөө эрсдэл гарган тасралтгүй ажиллаж байгаа төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагчдад ипотекийн зээлийн тусгай бүтээгдэхүүн гаргах, жижиг дунд үйлдвэрийн зээлд төрөөс гаргах батлан даалт болон улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, банкны бус санхүүгийн салбарыг зохицуулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор ноолуурын түүхий эдийн нөөц бүрдүүлэх, ноолуурын үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох, ноолуурын экспортыг дэмжих чиглэлээр ноолуурыг хилийн бүх боомтуудаар саадгүй нэвтрүүлэх, холбогдох хураамжуудын хэмжээг “0” болгох, малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20 000 төгрөгийн урамшууллыг малчин өрх бүрд олгохоор заасан.

**УИХ-ын 2020 оны 36 дугаар тогтоол:** Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, өвчлөлийн цар хүрээ нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад тулгарах хүндрэлийг хохирол багатай даван туулахад чиглэсэн бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Үүнд:

1.гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулах, цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх саналаа Улсын Их Хуралд танилцуулах;

2.иргэдийн эрүүл мэндэд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулж удирдлагаар хангахыг Эрүүл мэндийн сайдад үүрэг болгох;

3.коронавируст халдвар /КОВИД-19/-ын эмчилгээ, оношилгооны төвийг бүсчилсэн

хэлбэрээр аймаг орон нутагт байгуулж, оношлуурын багаж, тоног төхөөрөмжөөр /PCR/ хангах;

4.коронавируст халдвар /КОВИД-19/-ын вакциныг эхний ээлжинд худалдан авах чиглэлээр олон улсын холбогдох байгууллагуудтай гэрээ хэлэлцээр байгуулах;

5.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацааг сунгах эсэх тухай саналаа Улсын Их Хуралд танилцуулж, шийдвэрлүүлэх гэсэн дэд заалтуудыг тусгасан.

**УИХ-ын 2020 оны 49 дүгээр тогтоол:** Ковид-19 цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх тухай.

**Ерөнхий сайдад асуулт, асуулга тавьж, хариуг сонсов:**

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн бодит байдлыг үнэлж, учрах эрсдэлийг бууруулах хүрээнд Засгийн газар, Монголбанкнаас хамтран ямар арга хэмжээ авч, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ажлын талаар
2. Манай улсад коронавирус (КОВИД-19)-ын халдварын тархалтын эрсдэл өндөр хэвээр байгаатай холбогдуулан нийгэм, эдийн засагт сөргөөр нөлөөлж буй хор уршгийг үнэлэн тооцоолох, ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг сэргээх, гамшгийн бэлэн байдлыг сайжруулах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар
3. Монгол Улсын Шадар сайдад хандан “Коронавируст цар тахлын улмаас хилийн чанадаас иргэдээ татаж авах, цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд зарцуулж буй хөрөнгийн зарцуулалт, уг тахлаас урьдчилан сэргийлэх ажлын талаар” тавьсан асуулга
4. Эрүүл мэндийн сайдад хандан "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үед хандивлагч орнуудын илгээж буй хандив, тусламж хэрхэн үр ашигтай зарцуулагдаж байгаа талаар" тавьсан асуулт
5. “Цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх” талаар МУ-ын Ерөнхий сайдад тавьсан асуулга
6. "Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын улмаас гадаадад гацсан иргэдийг эх орондоо ирэх нөхцөлөөр хангах, бодит дэмжлэг үзүүлэх талаар" МУ-ын Ерөнхий сайдад тавьсан асуулга
7. Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хандан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, дархлаажуулах талаар хэрэгжүүлж байгаа ажлын явцын талаар” тавьсан асуулга

**Ерөнхий сайдын мэдээлэл сонсов:**

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар”, “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр”,

“Бүх шатны боловсролын байгууллагын чанар, хүртээмж, сургууль, цэцэрлэгт



хамрагдалтын байдал, хичээл, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж байгаа арга хэмжээний талаар”

АБГББХ- Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар-Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийг татан авах үйл ажиллагааны талаар

Хүний эрхийн дэд хороо-коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас шалтгаалан Монгол Улсын иргэд өөрийн эх орондоо ирж чадахгүй олон сараар гадаад улсад саатах, эдийн засгийн хүндрэлд орох, Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх зэрэг сөрөг үр дагавар гарч байгаатай холбогдуулан саатсан иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэднийг эх оронд нь шуурхай ирүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар хуралдсан бөгөөд “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” дэд хорооны 2021 оны 01 дүгээр тогтоолыг баталж, Засгийн газарт хүргүүлсэн.

**Нэмэлт мэдээлэл:**

### **2021 оны Төсвийн тухай хууль**

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх замаар эрсдэлийг бууруулах, эрүүл мэндийн салбарын реформыг хэрэгжүүлэх зорилгоор эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг өмнөх онуудаас эрс нэмэгдүүлэн 1 их наяд 400 орчим сая төгрөгөөр батлав.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эдийн засгийн сөрөг үр дагавар аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг бүрэн сэргэх хүртэл нөлөөлөх шинжтэй байгааг харгалзан 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ийг хүртэл өдрийг хүртэлх хугацаанд 17 хувьд буюу шимтгэл “хөнгөлөх” арга хэмжээнд хамрагдсан аж ахуйн нэгж, даатгуулагчийн төлөх шимтгэлийг ажил олгогч 8.5 хувь, даатгуулагч 8.5 хувь буюу 3-5 пунктээр бууруулсан.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлыг урьдчилан төсөөлөх боломжгүй нөхцөлд хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, ургамлын тос импортлоход 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлсөн.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын урьдчилан төсөөлөх боломжгүй нөхцөлд хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, ургамлын тосыг 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай хуулийн хүрээнд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд хуульд заасан хугацаандаа тайлангаа ирүүлсэн боловч шимтгэлээ төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлд тооцох алданги, торгуулиас чөлөөлсөн

### **ОУ-ын гэрээ:**

**“Ковид-19 цар тахлын эсрэг шуурхай хариу арга хэмжээ авах хөтөлбөр”-ийн**



### **зээлийн хэлэлцээр**

Монгол Улс болон Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээр /КОВИД-19 цар тахлын эсрэг шуурхай хариу арга хэмжээ авах хөтөлбөр/-ийн дагуу Монгол Улсад Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкнаас олгох 100.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл нь цар тахалтай тэмцэх, эдийн засгийг эрчимжүүлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг дэмжихэд зориулагдах юм.

### **Санхүүжилтийн хэлэлцээр**

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй эдийн засгийг эрчимжүүлэх багц арга хэмжээний хүрээнд Монгол Улс болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын 20 сая ам.долларын санхүүжилтийн хэлэлцээр “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийг баталсан. Энэхүү санхүүжилт нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэх хэсгийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, ур чадварын шинэчлэл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зориулж 6.5 сая ам.доллар, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд шаардлага хангасан ажилчдад түр хугацааны дэмжлэг олгоход зориулж 10 сая ам.доллар тус тус зарцуулна.

### **Зээлийн хэлэлцээр**

Монгол Улсын Засгийн газар болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд “КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний яаралтай тусламжийн зээл”-ийн хэлэлцээрийг баталсан бөгөөд Монгол Улсад коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа эдийн засгийг эрчимжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, төсвийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас 25.0 тэрбум иенийн /ойролцоогоор 233.0 сая ам.доллар/ яаралтай тусламжийн зээлийн санхүүжилт олгоно.

## “Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд Парламентын хүлээх үүрэг”

### Парламентын гарын авлага

Авлигын эсрэг парламентчидын олон улсын байгууллага (Global organization of parliamentarians against corruption-GOPAC), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP) болон Исламын Хөгжлийн Банк хамтран “Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд Парламентын хүлээх үүрэг” Парламентын гарын авлага (“Parliament’s Role in implementing The Sustainable Development Goals” A Parliamentary Handbook)-ыг 2017 онд боловсруулан гаргасан байна.

Тус гарын авлагыг ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд парламентын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор парламентчидад зориулан боловсруулсан байна. Парламентчид бол Үндсэн хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд ТХЗ-ын хэрэгжилтийг дэмжих, түүнд хяналт тавьж ажиллахад чухал үүрэг гүйцэтгэх боломжтой юм. “ТХЗ 2030 хөтөлбөр” (The 2030 Agenda for SDG)-т “Улс орны парламентууд нь хууль тогтоох, төсөв батлах онцгой эрхийнхээ дагуу ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт тавих боломжтой” гэсэн байна. Парламентын гишүүд нь ард иргэд болон төрийн байгууллага хоорондын холбоос болж нэг ч иргэнийг төрийн бодлогын гадна орхихгүйн төлөө хүн төвтэй бодлого боловсруулж, хууль тогтоомж баталж ажиллах өвөрмөц алба хашиж буй хүмүүс юм.

Аливаа улс орон ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд тухайн орны парламент нь голлох үүрэг гүйцэтгэх ёстой. ТХЗ-ыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжуудыг парламент нь нарийвчлан хэлэлцэж, батлах шаардлагатай. ТХЗ-ын хэрэгжилтэд шаардагдах санхүүжилт олгох жил бүрийн улсын төсвийг мөн парламентаас хэлэлцэн батална. Түүнчлэн парламентчид нь засгийн газрын хэрэгжүүлж буй ТХЗ-ын хэрэгжилтэд, ялангуяа, зорилтууд нь үндэсний болон орон нутгийн түвшинд тохирч буй эсэхэд хяналт тавин, тойргийн ард иргэдээ төлөөлж буйн хувьд ТХЗ-ын хэрэгжилтэд иргэдийн оролцоог хангаж ажиллах шаардлагатай.

Тус гарын авлага нь 3 үндсэн зорилгыг агуулж байна. Үүнд:

- Парламентчидад ТХЗ-ын талаар мэдээлэл олгох;
- Улс орны парламентууд болон парламентчид ТХЗ-ыг хэрэгжүүлэх үүргээ хэрхэн гүйцэтгэж буй талаарх бусад орны туршлагыг хуваалцах;
- Улс орны парламентууд болон парламентчидад ТХЗ-ын өнөөгийн хэрэгжилтийг болон цаашид хэрхэн үр дүнтэй ажиллаж болохыг үнэлэн, дүгнэх хэмжигдэхүүний талаар танилцуулах зэрэг болно.

Парламентаар шийдвэрлэх шаардлагатай ихэнх асуудлууд нь ТХЗ-д багтсан байдаг учир энэхүү гарын авлагаар парламент, парламентчид болон парламентын ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагаа нь ТХЗ-той салшгүй холбоотой болохыг ойлгуулахыг зорьсон.

Парламентын хууль тогтоох, хянан шалгах, төлөөлөх үндсэн чиг үүргийн хүрээнд, дэлхийн улс орнуудын парламентчид өөрийн төлөөлж буй иргэдэд ТХЗ-ын хэрэгжилтийн үр дүнг хэрхэн хүргэн ажиллаж буй онцлог, жишиг болохуйц арга, туршлагыг мөн тус гарын авлагад багтаасан байна.

ТХЗ нь зөвхөн нэг байгууллагын хариуцан гүйцэтгэх ажил биш бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус олон байгууллагуудын хамтын ажиллагаа чухал

болохыг онцолж, харин үүнд парламентын үүрэг юу болох, хэрхэн тэргүүлж ажиллах талаар зөвлөгөө, мэдээллийг өгчээ.

Гарын авлага нь дараах 11 бүлгээс бүрдэж байна:

- I. Парламент болон ТХЗ хоорондын уялдаа
  - a. Парламент болон тогтвортой хөгжил
  - b. Парламентчидыг 2030 хөтөлбөрт багтаах нь
  - c. Парламентчидын зорилго: ТХЗ 16
- II. ТХЗ-ыг хангах, үр дүнтэй хөгжилд хүрэхэд парламентын гүйцэтгэх үүрэг
- III. Хэрэгжилтийг нэмэгдүүлэхийн тулд хамтарч ажиллах
  - a. ТХЗ-ыг нэн тэргүүнд тавьж, хэрэгжилтийг хангахад засгийн газрын харьяа байгууллагуудтай хамтарч ажиллах
  - b. Хяналт шалгалтын бусад байгууллагуудтай хамтарч ажиллах
  - c. Үндэсний статистикийн байгууллагуудтай хамтрах
  - d. Олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай хамтрах
- IV. Хууль тогтоох: ТХЗ-д хүрэх хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх
  - a. Шинэчлэх шаардлагатай хууль тогтоомжийг тодорхойлох
- V. ТХЗ-ын хэрэгжилтэнд шаардагдах төсвийг төсөвлөх
  - a. Улсын жилийн төсөв
  - b. ТХЗ-ын төсөв болон зардлыг хянах
- VI. ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт тавих
  - a. ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт тавих хороо
  - b. Парламентын асуулга
  - c. Бичгэн болон аман асуулт
- VII. Төлөөлөх: Олон нийтийн оролцоог хангах
  - a. Хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох оролцоог дэмжих
  - b. Төсөв хэлэлцэхэд оролцоог хангах
  - c. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналтанд иргэдийн оролцоог бий болгох
  - d. Орон нутгийн түвшин дэх ТХЗ-ын хэрэгжилтэнд иргэдийн оролцоог дэмжих
- VIII. ТХЗ-ыг улс орны нөхцөл байдалтай уялдуулахад парламентын гүйцэтгэх үүрэг
- IX. Парламентын ажилтнуудын үүрэг
- X. Парламент дахь улс төрийн намын бүлгүүдийн үүрэг
- XI. Парламентчид болон парламентын ажилтнуудын ТХЗ-ын талаарх мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх.

**“КОВИД-19” ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА  
ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ  
(АВЛИГЫН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ХАМААРАЛТАЙ ЭСЭХ)**

(Лавлагаа, мэдээлэл)

*Д.Аюуш, Ш.Батцэнгэл*

**АГУУЛГА**

**НЭГ. УИХ-ААС “КОВИД-19” ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ  
БУУРУУЛАХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- УИХ-аас гаргасан шийдвэрүүд
- Хууль
- Тогтоол
- Түр хорооны үйл ажиллагаа
- УИХ-аас өгсөн чиглэлийн дагуу Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

**ХОЁР. “КОВИД-19” ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХЭД ЗОРИУЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА  
ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ**

- Арга хэмжээ, санхүүжилт

**ГУРАВ. АВЛГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС БА ТӨСВИЙН ЗАРЛАГЫН  
САНХҮҮЖИЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ**

**ХАВСРАЛТ МЭДЭЭЛЭЛ**

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**



## **НЭГ. УИХ-ААС “КОВИД-19” ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах асуудлаар Монгол Улсын Их Хурлаас 1 хууль, 5 тогтоол гарсан байна. Түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 1 зөвлөмж, Ерөнхийлөгчөөс 1 зарлиг, 1 уриалга, Засгийн газраас 53 тогтоол, Шадар сайдаас 32 тушаал, Улсын Онцгой Комиссоос 12 тогтоол, 50 тушаал, 5 албан даалгавар тус тус гарчээ. (2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар)<sup>264</sup>

### **УИХ-аас гаргасан шийдвэрүүд**

#### **Хууль**

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсад анхны коронавируст халдвар илэрсэний дараахан 2020 оны 4 сард **“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”**<sup>265</sup> гарган мөрдөж, дотоодод коронавируст халдвар эрчимтэй нэмэгдсэний дараахан 2020 оны 12 сард нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ хууль нь коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

#### **Тогтоол**

УИХ-аас 5 удаагийн тогтоол гаргаж УИХ-ын чуулганы хэвийн ажиллах нөхцөл боломж, цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай, “Ковид-19” цар тахлын эсрэг хуулийн биелэлтийг хангах, хяналт тавих зорилготой түр хороог байгуулсан.

**Багц арга хэмжээ** (УИХ-ын 2020 оны 21 болон 32 дугаар тогтоолоор)

#### **Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:**

1. хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж, үүнд шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвт зохицуулалт хийх, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн нэмэлт эх үүсвэр бүрдүүлэх замаар санхүүжүүлэх;
2. коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортоор оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх.

#### **Иргэдийн орлогыг хамгаалах чиглэлээр:**

1. Монгол Улсын иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн оргогод

<sup>264</sup> Коронавируст халдвар (Ковид-19)-ын Монгол Улс дахь нөхцөл байдал, хариу арга хэмжээний явцын 2020 оны тайлан, мэдээ, Онцгой байдлын ерөнхий газар, Улаанбаатар, 2021 он, 23-р хуудас

<sup>265</sup> <https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312>

ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх бөгөөд үүнд дараах орлогод ногдох хувь хүний орлогын албан татвар хамаарахгүй. Үүнд:

а/төрийн албан хаагчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;

б/төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажилладаг хувь хүний цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;

в/гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэх тендерт шалгарч, тус ажлыг хийж гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд ажилладаг хувь хүний зөвхөн уг ажилтай нь холбоотой олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого.

2. коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгох;
3. Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан сайн дураар даатгуулсан, нийгмийн даатгалын байгууллагатай мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан сайн дураар даатгуулахаар гэрээ байгуулсан Монгол Улсын иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд түүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлж, даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцох.

#### **Ажлын байрыг хадгалах чиглэлээр:**

1. коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн дараах хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчаас бусад даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагч /Монгол Улсын иргэн/-ийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно:

а/төрийн байгууллагад ажиллаж байгаа даатгуулагч;

б/төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагч;

в/гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсний төлбөрөөс цалин авч нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөх даатгуулагч.



2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон орлогод мөн хуулийн 20.1, 20.2.7-д заасны дагуу ногдуулан тайлагнасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг чөлөөлөх;
3. 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд ногдуулж тайлагнасан боловч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан торгох шийтгэл, мөн зүйлийн тайлбарын хоёр дахь өгүүлбэрт заасан алдангиас тус тус чөлөөлөх;
4. 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд татвар төлөгчийн хуулийн дагуу ногдуулан тайлагнасан төлбөл зохих татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас тухайн татвар төлөгчийг нэг удаа чөлөөлөх;
5. 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлсэн албан татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан нь гэрээ болон Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан төлбөрийн баримтаар нотлогдсон тохиолдолд бууруулсан хэмжээгээр түрээсийн орлогод ногдуулах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэх;
6. 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд элсэн чихэр, ургамлын тос, бүх төрлийн хүнсний будаа, 15.0 /арван таван/ мянган тонн элит үрийн улаан буудай, 160.0 /нэг зуун жаран/ мянган тонн хүнсний улаан буудайг импортлоход гаалийн болон импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх.

#### **Эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр:**

1. ариутгал, халдваргүйжүүлэлт, эрүүл ахуйн горимд иргэдийг эрүүл, аюулгүй орчинд үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлсэн үйлдвэр, үйлчилгээний газруудыг үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжоор хангаж ажиллах;
2. эдийн засгийг төрөлжүүлэх, дэмжих, ажлын байр бий болгох, нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээг идэвхжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, эх үүсвэр бүрдүүлэх гэрээ, хэлэлцээрийг байгуулах, түүнийг Монгол Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх;
3. дотоодын аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хийхдээ нэн тэргүүнд үндэсний үйлдвэрлэгчийг шалгаруулж байх зарчим баримтлах;
4. дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг нэвтрүүлж төр, хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчийг цахимаар ажиллах нөхцөлийг хангах,

боловсролын алсын зайн сургалтын үйлчилгээг үзүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах хяналт бүхий цахим худалдааг дэмжих, импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодод үйлдвэрлэдэг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хангамжийг сайжруулах зэрэг арга хэмжээнд шаардлагатай үнэ, тарифын хөнгөлөлтийг үзүүлэх, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5. сахилга, дэг журам, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх, эдийн засгийн сөрөг үр дагавраас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх.

**Санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эдийн засгийг идэвхжүүлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх чиглэлээр:**

1. эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй банкны тогтолцоог хөгжүүлж, банкны салбарын реформ хийх;
2. банкны зээлийн хүүг болон зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах;
3. мөнгө хүүлэлтийг хязгаарлах замаар зээлдэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
4. жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх;
5. банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх;
6. төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагчдад зориулсан ипотекийн зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргах хүрээнд түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны тусгай хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх, орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
7. гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх;
8. Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, банкны эрх хүлээн авагч нартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, татан буугдсан банкны чанаргүй активыг шуурхай барагдуулах, төлбөрт хураагдсан үл хөдлөх эд хөрөнгө болон улсын орлогод хураагдсан эд хөрөнгөөс олсон орлогыг эдийн засгийн эргэлтэд оруулж, эмнэлэг, сургууль, улсын хэрэгцээнд ашиглах;
9. төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх;
10. иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх арга хэмжээний хүрээнд банканд байршуулсан нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг чөлөөлөх;
11. эдийн засгийг идэвхжүүлэх, хямралын эсрэг тусгай зорилтот сан байгуулах.

**Малчдын орлогыг нэмэгдүүлэх, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах чиглэлээр:**

1. ноолуурын түүхий эдийн нөөц бүрдүүлэх, ноолууран бүтээгдэхүүнийг экспортлохтой холбогдуулан ноолуурын үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагааг яаралтай зохион байгуулах;
2. ноолуурын экспортыг дэмжих чиглэлээр ноолуурыг хилийн бүх боомтуудаар саадгүй нэвтрүүлэх, холбогдох хураамжуудын хэмжээг “0” болгох асуудлыг шийдвэрлэх;
3. малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20 000 /хорин мянган/ төгрөгийн

урамшууллыг Малын генетик нөөцийн тухай хуульд заасан малчин, мал бүхий этгээд бүрд олгох;

4. ноолуурын зах зээлд өрсөлдөөнийг бий болгож, бодит үнэ тогтоох зорилгоор гадаад улсын худалдан авагч нарыг ноолуур бэлтгэх үйл ажиллагаанд татан оролцуулах ажлыг шуурхай зохион байгуулах.

### **Түр хорооны үйл ажиллагаа**

Улсын Их Хуралд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороог байгуулсан.

Түр хороо байгуулагдсан цагаас хойш 2020.11.03, 2021.03.31-нд 2 удаа хуралдаж Засгийн газар, УОК, холбогдох яам зэрэг байгууллагуудаас мэдээлэл сонсож, асуулга асууж, Засгийн газар болон УОК-т чиглэл өгсөн.<sup>266</sup>

### **УИХ-аас өгсөн чиглэлийн дагуу Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Засгийн газар болон Улсын Онцгой Комиссоос бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан айл өрх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх болон эдийн засгийг дэмжих чиглэлээр авч буй зарим арга хэмжээ:<sup>267</sup>

(Засгийн газрын 2020 оны 183, 188, 211 дүгээр тогтоолоос)

1. Хүүхдийн мөнгө, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн үйлчилгээг түргэн шуурхай, иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүйгээр олгох. Хүүхдийн мөнгийг 2021 оны 07 дугаар сарын 01 хүртэл үргэлжлүүлэн олгох;
2. 2021 оны 07 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд Нийгмийн даатгалын шимтгэлээ хуульд заасан хугацаанд төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллагыг алданги торгуулиас чөлөөлөх;
3. 2021 оны 07 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд албан татвараа хуульд заасан хугацаанд төлөөгүй бол алданги, торгуулиас чөлөөлөх;
4. 2021 оны 07 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд худалдааны төв, худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлсэн албан татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан нь нотлогдсон бол татварын хөнгөлөлт үзүүлэх;
5. 2021 оны 07 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд бүх төрлийн хүнсний будаа, ургамлын тос, өвс, мал, амьтны тэжээл, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх, дотооддоо боловсруулан борлуулсан ургамлын тос, өвс, мал амьтны бүх төлрийн тэжээл, хүнсний будааг НӨАТ-аас чөлөөлөх;
6. Хүнсний бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, савлалт, хүргэлт, тараалт, борлуулалтыг хэвийн явуулах;
7. Төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны ипотекийн зээлийн 2021 оны 07 дугаар сарын 01 хүртэлх хугацааны үндсэн болон хүүгийн төлбөрийг зээлдэгчийн

<sup>266</sup> [http://parliament.mn/n/8csyn?fbclid=IwAR07E3X7v5Mt7OGkoBn2RUMxi1GHffgk1HqslZkbrPz1z3IU9MjaPqohX\\_s](http://parliament.mn/n/8csyn?fbclid=IwAR07E3X7v5Mt7OGkoBn2RUMxi1GHffgk1HqslZkbrPz1z3IU9MjaPqohX_s)

<sup>267</sup> Коронавируст халдвар (Ковид-19)-ын Монгол Улс дахь нөхцөл байдал, хариу арга хэмжээний явцын 2020 оны тайлан, мэдээ, Онцгой байдлын ерөнхий газар, Улаанбаатар, 2021 он, 37-р хуудас

- хүсэлтээр хойшлуулах, үлдэгдэл төлбөрийг хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр гэрээний хугацааг сунгах;
8. Банк, банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршооноос олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хойшлуулах хүсэлтийг шийдэхдээ нэмэгдүүлсэн хүү, торгууль, алданги ногдуулан хүүг нэгтгэж тооцох зэргээр нэмэлт дарамт үүсгэхгүйгээр гэрээг өөрчилж хугацааг сунгах;
  9. Ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүн экспортлодог аж ахуйн нэгжүүдийг халдвар хамгааллын онцгой дэглэмд шилжүүлж, халдвар, хамгааллын аюулгүй нөхцөл бүрдүүлэх;
  10. Хилийн боомтуудыг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд бүрэн хүчин чадлаар ажиллуулах, Тавантолгойн бүлэг орд, Нарийнсухайтын бүлэг орд, Оюутолгойн ордын хүрээнд байгуулагдсан ариутгал, халдваргүйжүүлэлт, хамгаалалтын аюулгүйн бүсийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай уялдуулан Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор тээвэрлэлт хийж байгаа жолооч нарыг шинжилгээнд бүрэн хамруулж, эдгээр боомтыг “Ногоон бүс” болгон зарлаж, тээвэрлэлтийн дараалал үүсгэхгүй байхаар зохион байгуулах;
  11. 2021 оныг дуусталх хугацаанд импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортын гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх;
  12. Бүх төрлийн шуудан илгээмжийг ариутган халдваргүйжүүлэх;
  13. Татвар төлөгчийн 2020 оны жилийн эцсийн татварын тайлангаар гарсан алдагдлыг татварын дараалсан 4 жилийн хугацаанд Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан журмын дагуу хасаж тооцох;
  14. Татвар, гаалийн байгууллагын цахим шинэчлэлийг эрчимжүүлж, гаалийн бүрдүүлэлт хийх, татварын тайлан гаргах, татвар төлөх, иргэдэд үйлчлэх үйл ажиллагааг цахимжуулж, иргэдтэй аль болох зайнаас харьцаж ажиллах;
  15. Татвар төлөгчийн хүсэлтээр тухайн татвар төлөгчийн улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн авлага, бусад илүү төлөлтийг татварын өрөнд тухай бүр суутган тооцох;
  16. Зээлийн батлан даалтын сан бизнесийг сэргээхэд ажлаа чиглүүлэх, идэвхжүүлэх;
  17. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчигээ нийцүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлбөрийг түргэн шуурхай барагдуулах;
  18. Дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авч байх;
  19. Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох тэгж боломжоор хангах зорилгоор бэлэн байдал зарласан хугацаанд хүлээн авах бүх төрлийн сонгон шалгаруулалтын хугацааг 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хүртэл сунгах;
  20. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас өгч байгаа зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх, олон нийтийн сэтгэл зүйг дэмжих, соён гэгээрүүлж, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх нэвтрүүлэг, контентыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах, нэвтрүүлэх, хүн хооронд 2 метрийн зай барих, амны хаалт тогтмол зүүлгэх, үйлчлүүлэгч, ажилчдын биеийн халууныг тогтмол үзэх, ариутгах бодисыг байршуулах, ариутгал халдваргүйжүүлэлтийг өдөр тутам хийх ажлыг зохион байгуулах;
  21. ЕБС-ийн үдийн цай, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсэнд зарцуулахаар нөөцөлж, төлбөрийг нь бүрэн барагдуулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсролын байгууллагын гаргасан судалгааны дагуу цэцэрлэг, сургуулийн насны хүүхэдтэй, хүнсний дэмжлэг үзүүлэх шаардлагатай зорилтот бүлгийн өрхөд түгээх;

22. Цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уур, цэвэр, бохир усны эх үүсвэр болон шугам сүлжээ, түгээлтийн техникийн хүчин чадлын боломжит хэмжээтэй уялдуулан үйлчилгээний төлбөр, хураамжийг төрөөс хариуцан төлөх хэрэглээг өмнөх оны мөн үеийн хэрэглээтэй жишиж, энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг одоо мөрдөгдөж байгаа батлагдсан тарифт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар тооцох;
23. Салбарын хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэвийн явуулах саналыг Улсын онцгой комиссын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх;
24. Айл өрхийн болон аж ахуйн нэгж байгууллага (9 чиглэлээс бусад)-ын цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр (орон сууцны 100 метр квадрат хүртэл), цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөр арга хэмжэг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх. Хөнгөлөлтөд хамрагдахгүй аж ахуйн нэгж, байгууллагын чиглэл:
1. төсөвт байгууллага
  2. төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээд
  3. уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр
  4. банк, банк бус санхүүгийн байгууллага
  5. криптовалютаар холбогдох үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, хувь хүн
  6. газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч
  7. интернэт, үүрэн холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч
  8. согтууруулах ундаа, тамхи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч
  9. өнгөт металл болон хар төмөрлөг, цементийн үйлдвэр
- Төлбөр, хураамжийг төрөөс хариуцахад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг нийгмийн хариуцлагын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын цэвэр ашгаас тооцож, санхүүжүүлнэ.
25. Төсвийн хэмнэлтийн горимыг үргэлжүүлэн, цалин, тэтгэвэр, нэг удаагийн тэтгэмжээс бусад зарлагыг эрэмблэн санхүүжүүлэх;
26. Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хэмнэлтийн горимд ажиллуулж, үр ашгийг дээшлүүлэх, халдвар, хамгааллын онцгой дэглэмийг чанд баримтлах, халдвараас хамгаалах, урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
27. Төрийн байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг төлөвлөсөн хэмжээнээс буулгахгүй, өөр зардалд шийлжүүлэхгүйгээр цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагад шууд шилжүүлэх;
28. Нийслэлийн гэр хорооллын иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сайжруулсан шахмал түлшний нэг тонн тутмын үнийг 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс 50, 12 дугаар сарын 14-ний өдрөөс 25, нийт 75 хувиар хөнгөлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн.



## ХОЁР. “КОВИД-19” ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХЭД ЗОРИУЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ

### Арга хэмжээ, санхүүжилт

Дэлхийн улс орнуудын төр, засгийн газар цар тахлын үр нөлөөг саармагжуулах, эдийн засгийн үр дүнгийн үзүүлэлтүүд болон нийгмийн амьдралын чанарыг муутгахгүйн тулд ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байгаагийн зэрэгцээ халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, хөл хорио тогтоох, иргэдийг вакцинжуулах, цар тахлын халдварын хүрээг хумихтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлж, ихээхэн хэмжээний зардал санхүүжилтийг гаргаж ажиллаж байна. Монгол Улсын хувьд цар тахлын сөрөг үр дагаврыг саармагжуулах зорилгоор хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээг санхүүжилтийн хамт дараах зурагт харуулав.

Зураг 40. Засгийн газраас цар тахлын сөрөг үр дагаврыг саармагжуулах зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээ




Эх сурвалж: Монгол Улсын Сангийн яам ([mof.gov.mn](http://mof.gov.mn))

2020 оны байдлаар цар тахлын сөрөг үр дагаврыг бууруулах, халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн Монгол Улсын засгийн газрын зардлын санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувь 7.9<sup>268</sup> байгаа бөгөөд энэ үзүүлэлт нь дэлхийн 182 орноос 32-р байранд, хөгжиж буй (emerging markets) 78 орноос 9-р байранд тус тус орж байна.

<sup>268</sup> [Fiscal Policies Database \(imf.org\)](http://Fiscal Policies Database (imf.org))



Зураг 41. Засгийн газрын зүгээс өрхүүд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлсэн дэмжлэг



Эх сурвалж: Сангийн яам ([mof.gov.mn](http://mof.gov.mn))

Манай улсын засгийн газар цар тахалтай тэмцэх үйл ажиллагааг төсвийн орлогоороо болон гадаадын зээл, тусламжийг ашиглан санхүүжүүлж байна.

Хүснэгт 30. Гадаадын зээл, тусламж, зориулалт

Санхүүжүүлэгч	Зээлийн дүн	Санхүүжилтийн эх үүсвэр	Тусламжийн дүн	Тусламжийн зориулалт	Нийт санхүүжилт (гүйцэтгэлээр)
ADB	157.6 сая ам. доллар	Төсвийн дэмжлэг, эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр, нийгмийн хамгааллын төслийн зээл	2.5 сая ам. доллар	СТ томограф тоног төхөөрөмж, эмнэлгийн ажилтнуудын илүү цагийн цалин, PCR шинжилгээний төхөөрөмж	128.1 сая ам. доллар
БНХАУ-ын ЗГ		Буцалтгүй тусламж	0.7 сая ам. доллар	Оношлуур, амны хаалт	0.7 сая ам. доллар
Европын холбоо		Буцалтгүй тусламж	50.8 сая евро	Хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэл	16 сая евро

Дэлхийн банк	69 сая ам. доллар	Цахим эрүүл мэнд төсөл, боловсролын чанар шинэчлэл төсөл, цар тахлаас урьдчилан сэргийлэх, хөдөлмөр эрхлэлтийн төслийн зээл	1 сая ам. доллар	Амны хаалт, бээлий, нүүрний хамгаалалт, нүдний шил	34.6 сая ам. доллар
Япон улсын газар		Буцалтгүй тусламж	9.3 сая ам. доллар	Оношлогооны төхөөрөмж	-
USAID		Буцалтгүй тусламж	2.5 сая ам. доллар	Гар ариутгагч, эрүүл ахуйн хэрэгслээр хангах, орлого багатай айл өрхийг дэмжих	2.5 сая ам. доллар
ХБНГУ-ын ЗГ		Буцалтгүй тусламж	1.5 сая ам. доллар	Цахим сургалт, мэдээллийн платформыг хөгжүүлэх	1.5 сая ам. доллар
НҮБ		Буцалтгүй тусламж	2.6 сая ам. доллар	Эм, багаж, тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгсэл	2.6 сая ам. доллар
АХБ, ОУВС, АДБХОБ <sup>269</sup> , Япон улсын ЗГ	532.6 сая ам. доллар	Цар тахалтай холбоотой төсвийн дэмжлэг			532.6 сая ам. доллар

*Эх сурвалж: Ковид-19 цар тахалтай холбоотой авч буй гадаадын зээл, тусламжийн дүн, зарцуулалт /2020 оны жилийн эцсийн байдлаар/ - САНГИЙН ЯАМ (mof.gov.mn)*

Дээрх хүснэгтэд оруулсан гадаадын зээл, тусламжийг ашигласан зориулалтаар нь ангилж үзвэл:

Зориулалт	Мөнгөн дүн	Санхүүжилтийн эх үүсвэр
СТ томограф тоног төхөөрөмж, эмнэлэгийн ажилтнуудын илүү цагийн цалин, PCR шинжилгээний төхөөрөмж, амны хаалт	167.8 сая ам. доллар	Гадаадын зээл
Хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэл, цахим сургалт, мэдээллийн платформыг хөгжүүлэх	16 сая евро, 1.5 сая ам. доллар	Буцалтгүй тусламж
Төсвийн дэмжлэг	532.6 сая ам. доллар	АХБ, ОУВС, АДБХОБ <sup>270</sup> , Япон улсын ЗГ-аас авсан төсвийн дэмжлэг

**Зээл:** 695.3 сая ам. доллар

**Тусламж:** 6.6 сая ам. Доллар, 16 сая евро

<sup>269</sup> Азийн дэд бүтэц хөрөнгө оруулалтын банк

<sup>270</sup> Азийн дэд бүтэц хөрөнгө оруулалтын банк

## ГУРАВ. АВИЛГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС БА ТӨСВИЙН ЗАРЛАГЫН САНХҮҮЖИЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Монгол улсын Засгийн газраас дэлхий даяар Ковид-19 цар тахал дэгдэж эхэлсэн цаг хугацаа буюу 2019 оноос хойш авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний санхүүжилтийн үзүүлэлтийг авилгын төсөөллийн индексийн бүрэлдэхүүн, шударга ёсны үзүүлэлтийн зарим индексүүдтэй харьцуулж, ямар нэгэн хамаарал байх боломжтой эсэхийг харахыг зорилоо. Хугацааны интервалыг 2019 (ковидгүй үе) оныг 2020 (ковидын санхүүжилт хийгдсэн үе) онтой харьцуулж авсан.

<p>2020 онд <b>Буурсан үзүүлэлтүүд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ <b>Авилгын төсөөллийн индекс</b> (Corruption perception Index): 2020 онд 35 оноогоор 111-р байранд жагсаж өмнөх оноос 6 байр ухарсан.</li> <li>✓ <b>Шударга ёсны индекс</b> (Justice index): Авилгал болон шүүх эрх мэдэл дэх улс төрийн нөлөөг тооцдог үзүүлэлтээр Монгол улс ухарсан үзүүлэлттэй.</li> <li>✓ Улсын эрсдэлийн үйлчилгээ (Country Risk Service): <b>Засгийн газрын өр төлөх чадвар</b>, валютын ханш, банкны эрсдэл, улс төрийн нөлөөлөл, улс төр, эдийн засаг, өр төлбөрийн ирээдүйн төлөв зэрэг үзүүлэлтүүдийг авч үздэг үзүүлэлтээр ухарсан.</li> <li>✓ Глобаль эрсдэлийн тайлан (Global Risk report): Хүрээлэн буй орчин, нийгмийн эрүүл мэнд, цар тахалтай тэмцэх чадвар зэрэг үзүүлэлтүүдээр ухарсан.</li> <li>✓ Засгийн газрын үр дүнтэй байдлын индекс /Government effectiveness index/ 2019 оны байдлаар энэ үзүүлэлтээр Монгол Улс дэлхийн 193 орноос 109-р байранд орж байна.</li> <li>✓ Засаглалын үр ашигт байдлын индекс /Governance efficiency index/ энэ үзүүлэлтээрээ 2020 оны байдлаар<sup>271</sup> Монгол улс 180 орноос 97-р байранд орж байна.</li> </ul> <p><b>Өсөлт гарсан үзүүлэлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Ардчилал ба өрсөлдөх чадварын индекс өссөн.</li> </ul>	<p>2020 онд Засгийн газрын төсвийн зардал өмнөх онтой харьцуулахад <b>2446.2</b> тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.</p> <p>2020 онд Монгол Улсын Засгийн газар цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор нийт <b>2.4 их наяд</b> төгрөгийг дараах зориулалтаар төсвөөс зарцуулсан:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Хүүхдийн мөнгө</li> <li>✓ НДШ</li> <li>✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр</li> <li>✓ Татварын чөлөөлөлт</li> <li>✓ Бусад хөнгөлөлт</li> </ul> <p>2020 онд ковидтой тэмцэхтэй холбоотойгоор авсан зээл тусламж:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Тоног төхөөрөмж, эмнэлэгийн ажилтнуудын илүү цагийн цалин, PCR шинжилгээний төхөөрөмж, амны хаалт (<b>167.8 сая ам. доллар</b>)</li> <li>✓ Хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэл, цахим сургалт, мэдээллийн платформыг хөгжүүлэх (<b>16 сая евро, 1.5 сая ам. доллар</b>)</li> <li>✓ Гаднаас авсан төсвийн дэмжлэг (532.6 сая ам. доллар)</li> </ul>
---	---

<sup>271</sup> [Global Governance Index \(solability.com\)](http://Global Governance Index (solability.com))

Монгол Улсын нэгдсэн төсөв 2020 онд 2,074.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч энэ хэмжээгээр Засгийн газрын өрийн хэмжээ нэмэгдсэн байна. Энэ дүнд ковидтой тэмцэхтэй холбоотойгоор авсан 695.3 сая ам.долларын гадаад зээл багтаж байгаа бөгөөд үүнээс 532.6 сая ам. долларын зээл нь төсвийн дэмжлэгийн зориулалтаар авсан зээл байна.

**Таамаглал:** Дээрх индексүүд болон санхүүжилтийг ерөнхийд нь харьцуулж харвал, ковидын санхүүжилттэй холбоотой дараах зардлуудыг анхаарал татахуйц хэмээн үзэж болох юм. Үүнд:

- эм, эмнэлгийн хэрэгсэл, амны хаалт, оношлогооны төхөөрөмжийн **худалдан авалтын** санхүүжилтэнд зарцуулсан **(167.8+1.5) сая ам. доллар, 16 сая евро,**
- ЗГ-ын зардлын хэтрэлтээс ковидын сөрөг үр нөлөөг саармагжуулах зориулалтаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний санхүүжилтийг хасахад ковидын бус зориулалтаар ашигласан **(2446.2-2400.0)=46.2 тэрбум** төгрөг байна.

## ХАВСРАЛТ

### ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ҮЗҮҮЛЭЛТ

#### Авлигын төсөөллийн индекс<sup>272</sup>

“Транспаренси Интернэшнл” байгууллагаас жил бүр гаргадаг авлигын төсөөллийн индексээр 2020 онд Монгол Улс 35 оноо авч 111 дүгээр байранд жагссан. Энэ нь 2019 оноос зургаан байраар ухарсан үзүүлэлт бөгөөд тус онд 35 оноо авч 105 байранд жагсаж байв. Сүүлийн 5 жилд:

Д/д	Огноо	Оноо	Байр	Өөрчлөлт
1	2015	39	87	Хэвэндээ
2	2016	38	87	Хэвэндээ
3	2017	36	103	16 байраар ухарсан
4	2018	37	93	10 байраар урагшилсан
5	2019	35	105	12 байраар ухарсан

Эх сурвалж: *Corruption Perceptions Index - Wikipedia*

Авлигын төсөөллийн индекс нь шүүх дэх улс төрийн нөлөө, хүрээлэн буй орчин, нийгэм, эрүүл мэнд, эдийн засгийн эрсдэл, гадаад өрийн эрсдэл, банкны салбарын эрсдэл, эдийн засгийн бүтцийн эрсдэл, улс төрийн эрсдэл гэсэн үзүүлэлтүүдээс бүрддэг.

#### Засгийн газрын үр дүнтэй байдлын индекс /Government effectiveness index/

Засгийн газрын үр дүнтэй байдлын индекс дэлхийн банкнаас боловсруулж гаргадаг бөгөөд энэ нь төрийн үйлчилгээний чанар, улс төрийн тогтвортой байдал, бодлого, зохицуулалтын чанар, хэрэгжилт, **авлигалын хяналт** гэсэн дэд үзүүлэлтүүдээс бүрддэг байна. 2019 оны байдлаар энэ үзүүлэлтээр Монгол Улс дэлхийн 193 орноос 109-р байранд орж байна.<sup>273</sup>

#### Засаглалын үр ашигт байдлын индекс /Governance efficiency index/

Түүнчлэн улс орнуудын засаглалын үр ашигт байдлын индексийг (Governance efficiency index) Швед, Солонгосын хамтарсан менежментийн зөвлөхийн үйлчилгээ үзүүлдэг Solability Sustainable Intelligence нэртэй судалгааны институт тооцож гаргадаг бөгөөд энэ үзүүлэлтээрээ 2020 оны байдлаар<sup>274</sup> Монгол улс 180 орноос 97-р байранд орж байна. Засаглалын энэ индексийг засгийн газрын байгууллагуудын уялдаа холбоо, дэд бүтэц, бизнесийн орчин, **авлигал**, санхүүгийн тогтвортой байдал гэсэн үзүүлэлтүүдээр хэмждэг байна.<sup>275</sup>

#### 2020 оны “Транспаренси Интернэшнл” байгууллагын “Авлигын төсөөллийн индекс” тайлангийн үр дүн, зөвлөмж

2020 онд Берлинд төвтэй олон улсын “Транспаренси Интернэшнл” байгууллагаас 2020 оны “Авлигын төсөөллийн индекс”-ийг танилцуулсан. 2020 оны Авлигын төсөөллийн индексийн дүнгээс харахад авлига нь КОВИД-19 эсрэг арга хэмжээг үр дүнгүй болгож, дэлхий даяарх цар тахлын эсрэг тэмцэл удааширч байгааг мэдээллийн эхэнд онцолсон.

<sup>272</sup> [Mongolia Corruption Index | 1999-2020 Data | 2021-2023 Forecast | Historical | Chart \(tradingeconomics.com\)](#)

<sup>273</sup> [Government effectiveness by country, around the world | TheGlobalEconomy.com](#)

<sup>274</sup> [Global Governance Index \(solability.com\)](#)

<sup>275</sup> [Global Governance Index \(solability.com\)](#)

**Транспэрэнси интернэшнл байгууллагын ТУЗ-ын дарга хатагтай Дэла Фэррэира Рубио** “Ковид-19 цар тахал бол зөвхөн эрүүл мэнд, эдийн засгийн хямрал биш бас авлигын хямрал бөгөөд бид ялагдаж байна. Өнгөрсөн жил улс орнуудад урд өмнө байгаагүй сорилт боллоо. Авлига өндөртэй улс орнууд энэхүү сорилтод бүдэрч байна. Мөн Авлигын төсөөллийн индексийн оноо өндөр авлига улс орнууд авлигатай тэмцэхэд бусдадаа туслах үүргээ гүйцэтгэхийг уриалж байна” гэж мэдэгдсэн.

Авлига өндөр улс орнууд КОВИД-19-ийн үед иргэдээ ялгаварлаж, шударга бус шийдвэрүүд гаргаж байгаа онцгой байдлын үед ил тод байдал, хариуцлага ба авлигын эсрэг механизм чухал болохыг харуулж байна.

#### **Авлига өндөр орнуудын хувьд:**

- Авлигын гэмт хэргийн өндөр үзүүлэлттэй улс орнууд КОВИД-19 цар тахлын үед хууль дээдлэх ёс болон ардчилсан институцийг хамгийн их зөрчигч улс байх хандлагатай байна гэж дүгнэв.
- Авлига өндөр орнууд эрүүл мэндийн салбартаа маш бага хэмжээний хөрөнгө оруулалт хийдэг. Үүний зэрэгцээ эрүүл мэндийн салбар дахь авлига, гадаадын тусламжийг завших зэрэг авлигын гэмт хэргүүд КОВИД-19-ийн үед ихээр гарч байна. Авлигын гэмт хэрэг мөн эрүүл мэндийн салбарын худалдан авах ажиллагаанд их байна.
- Авлига индекс оноо бага орнуудад хавдрын нас баралт ба зүрх судасны нас баралт мөн амьсгалын замын шалтгаант нас баралт өндөр байна.
- Авлига индекс оноо бага орнуудад эрүүл мэндийн тусламж үйлчлэгээний бүх нийтийн хамралт сул байна.

#### **Зөвлөмж**

Цар тахалтай 2020 он авлигын индексийн хамгийн өндөр оноо авдаг хүчирхэг улс орнуудад хүртэл шударга байдлын том шалгуур боллоо. Транспэрэнси интернэшнл байгууллага дэлхийн улс орнуудад авлигыг бууруулах болон дахин тохиолдож болох хямралын хариу арга хэмжээний хүрээнд дараах саналыг хүргүүлж буй аж. Үүнд:

- Хөрөнгө, санхүүжилт хамгийн шаардлагатай хүмүүст хүрч байгааг бататгахын тулд хяналтын байгууллагуудаа бэхжүүлэх. Авлигатай тэмцэх болон аудит ба бусад хяналтын байгууллагууд өөрийн үүргээ биелүүлэхэд хангалттай санхүүжилт, хүний нөөцтэй байж мөн эрх зүйн хувьд хараат бус байх
- Хууль бус үйлдэлтэй тэмцэх, ашиг сонирхлын зөрчлийг олж тогтоох болон шударга хямд үнэ тогтоох үүднээс худалдан авалтын гэрээ байгуулахад нээлттэй, ил тод байдлыг хангах
- Төр засагт хариуцлага хүлээлгэх бололцоог хангахын тулд ардчилал болон иргэний нийгмийн орон зайг хамгаалах
- Олон нийтэд хүртээмжтэй, цаг тухайд нь мэдээллийг хүргэх үүднээс холбогдолтой мэдээллийг нийтэлж мэдээлэл авах боломжоор хангах



## ХАВСРАЛТ 2. ТОГТООЛ ШИЙДВЭРҮҮД

### 1. Хууль

№	Батлагдсан огноо	Хуулийн нэр
1	2020.04.29 /2020.12.31-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан /	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай

### 2. УИХ-ЫН ТОГТООЛ

№	Огноо /дугаар	Тогтоолын нэр
1	2020.04.09 №20	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
2	2020.04.09 №21	Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай
3	2020.04.29 №32	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай
4	2020.10.29 №31	Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай /Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэх/
5	2020.12.03 №36	"Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай"

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (mlsp.gov.mn)
- Монгол улсын хууль | авлигатай тэмцэх газар. Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа. (iaac.mn)
- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Коронавируст халдвар (Ковид-19)-ын Монгол Улс дахь нөхцөл байдал, хариу арга хэмжээний явцын 2020 оны тайлан, мэдээ, Онцгой байдлын ерөнхий газар, Улаанбаатар, 2021 он
- Монгол Улсын Сангийн яамны цахим хуудас /ковид-19 цэс/  
<https://mof.gov.mn/article/covid19>
- Авлигатай тэмцэх газар. Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа. (iaac.mn)
- Anti-corruption reforms in Mongolia welcome,transparency.org
- Www.legalinfo.mn - хуулийн нэгдсэн портал сайт
- Difference between corruption and bribe
- Mongolia - transparency.org
- <Http://documents1.worldbank.org/curated/en/113281515516828746/pdf/wps8299.pdf>
- <Https://www.montsame.mn/en/read/262183>

## **БҮЛЭГ III**

---

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ**

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УЛСЫН БОЛОН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ДУНДАЖ  
ЦАЛИНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА**

*Д.Халиун, Р.Нургүл, И.Жаргалзаяабямба*

**АГУУЛГА**

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УЛСЫН БОЛОН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ДУНДАЖ  
ЦАЛИНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА

1.Улсын болон уул уурхайн салбарын дундаж цалин

- Австрали Улс
- Бүгд Найрамдах Казахстан Улс
- Бүгд Найрамдах Чили Улс

2.Уул уурхайн салбарт ажиллагсдын цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөлийн талаар

- Австрали Улсын уул уурхайн салбарын ажилтны цалин, хөлсний доод хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл /Mining Industry Award 2020/

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

**Судалгааны зорилго:** Улсын Их Хурлын 2020 оны намрын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хөдөлмөрийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаатай холбогдуулан захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу гадаадын зарим орнуудын улсын болон уул уурхайн дундаж цалин, уул уурхайн салбарт ажиллагсдын цалин хөлс, нэмэгдэл, ажлын цагийн талаарх мэдээлэл, лавлагааг бэлтгэв.

**Судалгааны хамрах хүрээ:** Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Австрали, Казахстан, Чили улсуудын дундаж цалин болон уул уурхайн салбарын дундаж цалингийн хэмжээний талаарх лавлагаа, мэдээллийг бэлтгэхдээ тухайн орнуудын статистикийн байгууллагын албан ёсны мэдээллийг ашигласан болно.

Судалгаанд захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Австрали, Казахстан, Чили улсуудын туршлагыг авч үзэв. Судалгаа нь 2 хэсгээс бүрдэнэ.

**1 дүгээр хэсэгт** Австрали, Казахстан, Чили улсуудын дундаж цалин болон уул уурхайн салбарын дундаж цалингийн хэмжээний талаарх лавлагаа мэдээллийг бэлтгэсэн. Үүнд тухайн орнуудын статистикийн байгууллагын албан ёсны мэдээллийг ашигласан болно.

Австралийн дундаж цалингийн талаарх мэдээллийг Австралийн статистикийн хорооны мэдээллээс авсан бөгөөд 2020 оны 8-р сарын 13-ны байдлаар оруулав (Тус хороо нь мэдээллээ 2 болон 8-р сард гаргадаг).

Казахстан Улсын холбогдох тоон мэдээллийг Үндэсний статистикийн хорооны 2020 оны 3-р улирлын мэдээллээс авав.

Чили Улсын статистикийн байгууллагын мэдээлэл нь олдоогүй тул salaryexplorer.com цахим хуудасны Чилийн 2020 оны дундаж цалин хөлсний талаарх тоон мэдээллээс авсан болно.

Монгол Улсын холбогдох тоон мэдээллийг 1212.mn цахим хуудаснаас авсан бөгөөд 2020 оны 3-р улирлын байдлаар оруулсан.

**2 дугаар хэсэгт** уул уурхайн салбарт ажиллагсдын цалин хөлс, нэмэгдэл, ажлын цагийн талаар лавлагаа мэдээллийг бэлтгэсэн бөгөөд Чили, Казахстан улсуудын мэдээлэл олдоогүй тул зөвхөн Австрали Улсын Австрали Улсын уул уурхайн салбарын ажилтны цалин, хөлсний доод хэмжээ, хөдөлмөрийн нөхцөлийг 2020 онд шинэчлэн тогтоосон баримт /Mining Industry Award/-аас хөдөлмөрийн хөлсний хэмжээ, хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой хэсгийн албан бус орчуулгыг тус тус оруулав оруулав.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УЛСЫН БОЛОН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА

#### 1. Улсын болон уул уурхайн салбарын дундаж цалин

##### Австрали Улс

Австралид 2020 оны 8-р сарын 13-ны байдлаар улсын дундаж цалин (насанд хүрсэн хүний 7 хоногийн бүтэн цагийн ажлын хөлс) \$1714 австрали доллар байна. Уул уурхайн салбарт ажиллагсдын дундаж цалин хамгийн өндөр буюу \$2698 австрали доллартой (7 хоногийн) тэнцүү байна.<sup>276</sup>

##### Бүгд Найрамдах Казахстан Улс

2020 оны 3-р улирлын байдлаар сарын дундаж нэрлэсэн цалин 204330 тенге байна. Казахстаны уул уурхайн салбарт ажиллагсад хамгийн өндөр дундаж цалинтай буюу 448500 тенге байна.<sup>277</sup>

##### Бүгд Найрамдах Чили Улс

Чили Улсад сарын дундаж цалин 1870000 чили песо (473000-8340000 чили песогийн хооронд) байна<sup>278</sup>. Уул уурхайн салбарт ажиллагсдын сарын дундаж цалин 1680000 чили песотой (612000-3890000 чили песогийн хооронд) тэнцэж байна.<sup>279</sup>

Австрали, Казахстан, Чили улсуудын сарын дундаж цалин болон уул уурхай салбарт ажиллагсдын дундаж цалин, мөн Монгол Улсын холбогдох дундаж цалингийн хэмжээг дараах хүснэгтэд төгрөгөөр харуулав.

	Улсын сарын дундаж цалин		Уул уурхайн салбарын сарын дундаж цалин	
	валют	төгрөгөөр*	валют	төгрөгөөр*
<b>Монгол</b> <sup>280</sup>		<b>1 124 300</b>		<b>2 590 000</b>
Австрали	6856 AUD	13 994 467	10792 AUD	22 028 630
Чили	1870000 CLP	7 485 663	1680000 CLP	6 724 844
Казахстан	204330 тенге	1 346 535	448500 тенге	2 955 615

\*2020 оны 8-12-р сарын Монголбанкны ханш: Австралийн доллар (AUD)<sup>281</sup> - 2,041.20 төг, Казахстаны тенге<sup>282</sup> - 6.59 төг, Чили песо<sup>283</sup> 1870000 CLP = 2627 USD, 1680000 CLP = 2360 USD, ам.доллар<sup>284</sup> - 2,849.51 төг

Хүснэгтээс харахад Монгол, Австрали, Казахстан улсуудын уул уурхайн салбарын дундаж цалин улсын дундаж цалингаас өндөр байна. Австрали Улсад уул уурхайн салбарын дундаж цалингийн хэмжээ улсын дундаж цалингаас 57%-иар буюу 1.6 дахин,

<sup>276</sup> <https://www.abs.gov.au/statistics/labour/earnings-and-work-hours/average-weekly-earnings-australia/latest-release>

<sup>277</sup> <https://www.gov.kz/memleket/entities/stat/press/news/details/119682?lang=kk>

<sup>278</sup> <http://www.salaryexplorer.com/salary-survey.php?loc=43&loctype=1>

<sup>279</sup> <http://www.salaryexplorer.com/salary-survey.php?loc=43&loctype=1&job=39&jobtype=1>

<sup>280</sup> [http://1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NSO\\_0400\\_022V1&Salbar\\_select\\_all=0&SalbarSingleSelect= 1 103&Gender\\_select\\_all=0&GenderSingleSelect= 1&YearQ\\_select\\_all=0&YearQSingleSelect= 202003&YearY\\_select\\_all=0&YearYSingleSelect= 2019&viewtype=columnchart](http://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0400_022V1&Salbar_select_all=0&SalbarSingleSelect= 1 103&Gender_select_all=0&GenderSingleSelect= 1&YearQ_select_all=0&YearQSingleSelect= 202003&YearY_select_all=0&YearYSingleSelect= 2019&viewtype=columnchart), 2020 оны 3-р улирлын байдлаар

<sup>281</sup> 2020 оны 8-р сарын 13-ны өдрийн Монголбанкны ханш

<sup>282</sup> 2020 оны 9-р сарын 30-ны өдрийн Монголбанкны ханш

<sup>283</sup> <https://www.currency.me.uk/convert/clp/usd>


<sup>284</sup> 2020 оны 12-р сарын 30-ны өдрийн Монголбанкны ханш



Казахстан Улсад 120%-иар буюу 2.2, Монголд 130%-иар буюу 2.3 дахин их байна. Харин Чили Улсын хувьд уул уурхайн салбарын дундаж цалин улсын дундаж цалингаас 10.2%-иар бага байна.

Судалгаанд авсан орнуудаас Монголд Улсын дундаж цалин Австрали Улсынхаас 12.5, Чили Улсынхаас 6.7 дахин бага байна. Харин Казахстан Улсын дундаж цалин манай улсынхаас 20%-иар их байна.

Зураг 1. Гадаадын зарим орны улсын болон уул уурхайн салбарын дундаж цалин, 2020 он



## 2. Уул уурхайн салбарт ажиллагсдын цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөлийн талаар

### Уул уурхайн салбарт ажиллагсдын ажил/амралтын горим<sup>285</sup>

Уул уурхайн салбарын ажлын онцлог нь олон хоногоор гэрээсээ хол ажиллах шаардлагатай байдаг. Энэ салбарын ажлын байрууд нь FIFO буюу "Fly In Fly Out", DIDO буюу "Drive In Drive Out" ажлын төрөлд хамаардаг.

FIFO - ажилтны гэр болон ажлын байр хол зайтай тохиолдолд ажилтан хуваарьт ажиллах хугацаандаа онгоцоор нисэн ирж, компанийхаа ажилчдын байранд байрлаж ажиллах бөгөөд амрах хугацаа нь эхлэхэд гэртээ онгоцоор нисэн харьж амралтаа эдэлнэ.

DIDO - ажилтны гэр болон ажилладаг компани харьцангуй ойрхон зайтай тохиолдолд хуваарьт хугацаандаа ажилдаа ирэх болон амрахаар гэртээ харихдаа машин ашиглана.

Уул уурхайн компанид ажиллагсдын ажил, амралтын цаг нь компаниасаа хамааран харилцан адилгүй байдаг. Ростер буюу ажил, амралтын хугацаа нь 2-3 долоо хоног

<sup>285</sup> <https://www.thebalancecareers.com/fifo-mining-jobs-2367454>

ажиллаж, 1 долоо хоног амрахаар зохицуулагдсан байдаг /эсхүл ажлын хоногийг 9, амралтын хоногийг 6 хоногоор нэмэгдүүлж болно/. Нэг өдөрт ажиллах цаг ердийн цагаас урт байх бөгөөд ихэнхдээ 12 цаг байна.

FIFO болон DIDO ажлын төрлүүд олон жилийн турш Латин Америкийн орнуудад, мөн Баруун Австралид нэлээд түгээмэл байна.

Уул уурхайн салбарт ажиллагсад нь хүнд нөхцөлд ажилладаг тул цалин өндөртэй. Нэмэгдэл цалингийн хэмжээ нь цалингийн 30-50 хувь байх бөгөөд зарим компаниуд түүнээс ч илүүг санал болгодог байна.

Түүнчлэн компаниуд ажилчдынхаа ажлын дараах амралт чөлөөт цагаа тав тухтай өнгөрүүлэх нөхцөлийг хангахад ихээхэн хөрөнгө оруулалт хийдэг болсон. Тухайлбал, дээд зэргийн тав тухтай байраар хангах, мөн интернэт холболт, биеийн тамирын заал, бассейн, снукер, кино театр зэрэг үйлчилгээгээр хангадаг байна.

### **Австрали Улсын уул уурхайн салбарт ажиллагсдын цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл**

Австралийн Холбооны Улсын хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх зэрэгтэй холбоотой асуудлыг Шударга хөдөлмөрийн тухай (Fair Work Act)<sup>286</sup> хуулийн дагуу Амбан захирагчийн харьяаны Шударга хөдөлмөрийн Комисс (Fair Work Commission)<sup>287</sup> тогтоох, зохицуулах эрхтэй юм. Энэ хүрээнд тус Комисс нь салбарын ажилтнуудын цалин, хөлсний доод хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл (award)-ийг тогтоох юм. Харин тус комиссоос баталсан ажилтны цалин, хөлсний доод хэмжээ, хөдөлмөрийн нөхцөлийг тогтоосон баримт нь ажил олгогч ажилчныг бүртгэлтэй гэрээгээр<sup>288</sup> ажиллуулж буй нөхцөлд хамаардаггүй байна.<sup>289</sup>



<sup>286</sup> <https://www.legislation.gov.au/Details/C2017C00323>

<sup>287</sup> <https://www.fwc.gov.au>

<sup>288</sup> Enterprise agreements and other **registered agreements** set out minimum employment conditions and can apply to:

- one business
- a group of businesses, or
- an individual employee (but these types of agreements can't be made anymore).  
When a workplace has a registered agreement, the award doesn't apply. However:
- the base pay rate in the registered agreement can't be less than the base pay rate in the award
- the National Employment Standards still apply
- any terms about outworkers in the award still apply.

Registered agreements apply until they are terminated or replaced.

<sup>289</sup> <https://www.fairwork.gov.au/awards-and-agreements/awards>

**Австрали Улсын уул уурхайн салбарын ажилтны цалин, хөлсний доод хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл<sup>290</sup> /Mining Industry Award 2020/<sup>291</sup>**

**3.1.** Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний стандарт ба энэхүү баримт бичиг нь энэхүү баримт бичгийн хамрах хүрээнд багтах ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, нөхцөлийг тогтооно.

**2 дугаар бүлэг. 8 дугаар зүйл. Ажлын эрхлэлтийн төрөл**

**8.1 дэх хэсэг.** Энэхүү баримт бичигт хамаарах ажиллагсдыг дараах төрөлд ангилна.

- (а) Үндсэн ажилтан;
- (б) цагийн ажилтан /цагаар ажиллах/;
- (в) /casual/ түр гэрээт ажилтан.

**9 дүгээр зүйл.** Үндсэн ажилтан.

Үндсэн ажилтан нь долоо хоногт дунджаар 38 цаг ажиллана.

**10 дугаар зүйл.** Цагийн ажилтан.

**10.1 дэх хэсэг.** Цагийн ажилтан нь:

- (а) долоо хоногт дунджаар 38-аас бага цагаар ажил эрхлэх;
- (б) ижил төрлийн ажил эрхэлж буй үндсэн ажилтны цалин хөлстэй адил тэнцүү хэмжээний нөхцөл, цалин хөлсөөр хангагдана.

**10.2 дахь хэсэг.** Ажил олгогч нь цагийн ажилтанд дараах зүйлийг заавал мэдэгдэнэ.

- (а) ажилтны ердийн ажлын цаг; ба
- (б) ажил эхлэх болон дуусах цаг хугацаа;

**10.3 дахь хэсэг.** Хуулийн 10.2-т зааснаар илүү цагаар ажилласан тохиолдолд ажилласан илүү цагийн хөлсийг зохих хувиар тооцож олгоно.

**11.3 дахь хэсэг.** Түр гэрээт ажилтны ажилласан ердийн цагийн 1 цагийн хөлсийг дараах байдлаар тооцож олгоно.

- (а) тэдгээрийн ажиллаж байгаа ангилалд хамаарах цагийн тариф дээр нэмж;
- (б) /casual loading/ нэмэгдэл 25%.

**13 дугаар зүйл.** Ростерийн зохицуулалт /уртын ээлж/

**13.1 дэх хэсэг.** Энэхүү баримт бичигт хэрхэн тусгагдсанаас үл хамааран уртын ээлжээр ажиллах шаардлага бүхий ажилчдад дараах зохицуулалтыг хэрэглэнэ.

(а) Ажилчдыг ажлын болон ажлын бус өдрүүдэд ээлжээр ажиллуулах горимд хамруулж болно.

(б) уртын ээлжээр ажиллах ажлын цаг нь 38 цагийг нийт ажлын өдөр (ээлжинд гарсан) болон ажлын бус өдөрт (ээлжинд гараагүй) үржүүлж, 7-д хувааснаас хэтрэхгүй байна.

<sup>290</sup> [http://awardviewer.fwo.gov.au/award/show/MA000011#P486\\_42956](http://awardviewer.fwo.gov.au/award/show/MA000011#P486_42956)

<sup>291</sup> **Awards** (modern awards) are legal documents that outline the minimum pay rates and conditions of employment.

Awards apply to employers and employees depending on the industry they work in and the type of job worked. Every award has information about who it covers. To work out which award applies, read:

- the coverage clause (usually clause 4)
  - the job classifications (usually in the pay clause or a schedule).
- Awards don't apply when an employer has a registered agreement in place.

(i) ээлжинд гарсан цагийг ажилтан ажлын байран дээр ажил эхлүүлэхээр ажил олгогчийн тогтоосон газар бүртгүүлснээр эхэлнэ.

(ii) ээлжинд гараагүй цаг нь ажилтны сүүлчийн ээлжийн ажлыг дуусгавар болгосноос эхэлнэ.

### 13.2 дахь хэсэг. Ростерийн өөрчлөлт

(а) Ажил олгогч нь ажилчны ажлын эхлэх, дуусах хугацааг үйл ажиллагааны хэрэгцээ, шаардлагатай уялдуулж, 48 цагаас доошгүй хугацаанд, эсхүл ажил олгогч ба хувь ажилчин хоёрын харилцан тохиролцсоны үндсэн дээр дээрхээс богино хугацаанд мэдэгдэж, өөрчилж болно.

(б) Ажилтан ээлжийн ажил гүйцэтгэж байгаа тохиолдолд ажил олгогч ээлжийн хуваарийг өөрчлөх, эсхүл ажилтанд 48 цагийн мэдэгдэл өгч өөр ээлжинд ажиллуулж болно.

(в) 13.2 дахь (б)-д заасан хугацааг дараах тохиолдолд багасгаж болно. Үүнд:

(г) ажил олгогч ба ажилтан хоорондоо тохиролцсон; эсхүл

(д) ажлын нөхцөл байдлын улмаас, ажил олгогчийн заавраар.

(г) 29 дүгээр зүйлд заасны дагуу ажил олгогч нь 13.2 дахь хэсэгт заасан өөрчлөлт орох тохиолдолд тухайн зохицуулалтад хамаарах ажилчинтай уртын ээлж, ажлын цагийн асуудлаар зөвлөлдөх ёстой.

### 13.3 дахь хэсэг. Онцгой байдлын үед.

Онцгой байдлын үед 13 дугаар зүйлд заасныг үл хамааран ажил олгогч нь уртын ээлжийг нэн даруй өөрчилж, эсхүл түдгэлзүүлж болно.

### 4 дүгээр бүлэг. Цалин хөлс.

#### 15 дугаар зүйл. Доод хувь хэмжээ ба ангилал

##### 15.1 дэх хэсэг. Насанд хүрсэн ажилтны цалингийн тариф

(а) Ажил олгогч нь насанд хүрсэн ажилчдад ажилласан цагийн цалин хөлсийг дараах доод тарифаар тооцон төлнө:

Түвшин	Ажилтны ангилал	Үндсэн ажилтны 7 хоногийн цалингийн доод хэмжээ \$	Цагийн хөлсний доод хэмжээ \$
Анхан шат	Шинэ	781.40	20.56
Түвшин 1	Үндсэн	820.00	21.58
Түвшин 2	Дунд	851.60	22.41
Түвшин 3	Туршлагатай	877.60	23.09
Түвшин 4	Ахисан	936.30	24.64
Түвшин 5	Ахисан дэвшилт	997.20	26.24
Түвшин 6	Мэргэшсэн	1046.00	27.53
Түвшин 7	Мэргэшсэн нөлөөлөх	1088.50	28.64

##### 15.2 дахь хэсэг. Өсвөр насны ажилчны хөлс

(а) Уул уурхайн салбарт өсвөр насны ажилчин ажиллахыг хуулиар зөвшөөрсөн тохиолдолд өсвөр насны ажилчинд насанд хүрэгчдийн долоо хоногийн тарифын (эсхүл цагийн ажилчин, түр гэрээт ажилчдын хувьд цагийн хөлсөөс тооцох) хувь хэмжээгээр хөлсийг тооцож олгоно.

Дараах байдлаар ангилсан байна:

Насны байдал	Насанд хүрэгчдийн хувь хэмжээ
16 нас ба түүнээс бага жил	75%

17 настай	85%
18 настай	100%

**15.5 дахь хэсэг.** Дагалдан /насанд хүрсэн/

(а) 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагалдангаар ажиллах насанд хүрсэн ажилчин 1 дэх жилдээ ажиллаж байгаа бол дараах эрхийг эдэлнэ:

(i) 15.1 дэх хэсгийн 3 дугаар түвшний 80%; эсхүл

(ii) дагалдангийн ажилласан хугацаанд тохирох жилийн 15.4 дэх хэсгийн (d)-т заасан хувь хэмжээгээр.

(б) 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагалдангаар ажиллах насанд хүрсэн ажилчин 2 дахь жилдээ ажиллаж байгаа бол дараах эрхийг эдэлнэ:

(i) 15.1 дэх хэсэгт заасны дагалдан насанд хүрэгчдийн доод ангилал; эсхүл

(ii) дагалдангийн ажилласан хугацаанд тохирох жилийн 15.4 дэх хэсгийн (г)-т заасан хувь хэмжээгээр.

(в) Сургалтын гэрээ байгуулахын өмнө ажил олгогч энэхүү баримт бичгийн дагуу тухайн байгууллагад үндсэн ажилтнаар 6 сарын хугацаанд (эсхүл 12 сарын хугацаанд цагийн ажилтан, түр гэрээт ажилтнаар) ажиллаж байгаа ажилтан, насанд хүрсэн дунд шатны дагалданийн сургалтын гэрээ байгуулснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бууруулах ёсгүй. Зөвхөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоохдоо насанд хүрсэн дунд шатны түвшингийн дагалдан суралцагчдад сургалтын гэрээг байгуулахдаа 15.1 дэх хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үргэлжлүүлэн авах ёстой.

**16 дугаар зүйл.** Цалин хөлс олгох

**16.1 дэх хэсэг.** Цалин, торгууль, тэтгэмжийг олгох давтамжийн хугацаа сараас хэтрэхгүй байна.

**16.2 дахь хэсэг.** Ажил олгогч нь ажилтны цалинг банк, эсхүл тухайн ажилтны өгсөн санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр шилжүүлнэ.

**16.3 дахь хэсэг.** Ажил олгогч нь ажилтанд төлөх ёстой цалингаас шимтгэлийн хэмжээг суутгана.

**16.4 дэх хэсэг.** Хөдөлмөр эрхлэлт дуусгавар болсны төлбөр

(а) Ажил олгогч нь ажилтны хөдөлмөр эрхлэлт дууссан өдрөөс хойш 7 хоногийн дотор төлбөрийг олгоно.

(i) ажилтныг ажлаас халагдсан өдрийг дуустал бүрэн ба бүрэн бус хугацааны туршид энэ хуулийн дагуу цалин хөлс;

(ii) энэхүү баримт бичиг болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний стандартын дагуу ажилчинд төлөх ёстой бусад бүх төлбөр;

(б) энэхүү баримт бичиг, эсхүл хуульд заасны дагуу 16.4 дэх хэсгийн (а)-д заасан цалин хөлсийн төлөх шаардлагаар Комисс болон ажил олгогч шийдвэрлэж, хууль, эсхүл энэхүү баримт бичигт заасан шийтгэлийг тооцно.

**17 дугаар зүйл.** Жилийн цалин

**17.1 дэх хэсэг.** Цалин хөлсний доод хэмжээний оронд жилээр хөлс тооцох

(а) Ажил олгогч нь 17.1 (в)-т заасны дагуу үндсэн ажилтанд дараах байдлаар жилээр тооцон цалин хөлсийг тооцож болно.

(i) 15-р зүйл — Хамгийн доод хувь хэмжээ, ангилал;

(ii) 18-р зүйл —Тэтгэмж;

- (iii) 20-р зүйл - Илүү цаг;
- (iv) 21-р зүйл. Шилжих ажил болон шимтгэлийн хэмжээ; ба
- (v) 22.3-р зүйл. Ээлжийн амралтын олговор.

(б) Жилээр тооцох цалин хөлсийг олгохдоо ажил олгогч нь ажилтанд бичгээр өгч, дараах зүйлийг тэмдэглэж авна.

- (i) нийт төлөх жилийн цалин хөлс;
- (ii) энэхүү баримт бичигт тусгасан аль зохицуулалт хамаарч байгаа;
- (iii) жилээр тооцох цалингийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг тооцоолоход ашигласан аргачлал, үүнд илүү цаг, шимтгэл, торгууль орно;

(iv) хуулийн дагуу шимтгэлийн хувь хэмжээг төлөхөд шаардагдах энгийн цагийн дээд хэмжээ, ажилтанд цалин хөлс олгох, эсхүл жагсаалтын циклд ажилтанд шаардагдах илүү цагийн дээд хэмжээ, 17.1 дэх хэсгийн (в)-д заасны дагуу жилийн цалингаас хэтрүүлсэн бол;

(в) Хэрэв цалин хөлс олгох бүртгэлийн циклд ажилтан 17.1 дэх хэсгийн (б) (iv) - т заасны дагуу тогтоосон хязгаараас хэтрүүлэн хэдэн цагаар ажилласан бол жилийн цалин хөлсийг тооцохгүй тул тусад нь хийх ёстой. Зөвхөн энэхүү хуулийн холбогдох заалтын дагуу төлнө.

#### 17.2 Жилийн цалин ажилчны нөхцөлийг дордуулахгүй байх

(а) Жилийн цалин хөлс нь нийт жилд олгосон цалин, гүйцэтгэсэн ажил энэхүү хуулийн дагуу авах ёстой хэмжээнээс багагүй байна. (эсхүл хөдөлмөр эрхлэлт хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд, ажилласан хугацаагаар).

(б) Ажил олгогч нь жилээр тооцох цалин хөлсийг ажил эхэлснээс хойш 12 сар тутамд, эсхүл ажил эрхлэлт дууссанаас дараа энэхүү бичиг баримтад заасны дагуу ажилтанд зохих хугацаанд төлөх цалин хөлсийг тооцож, бодитоор төлсөн жилээр тооцох цалингийн хэмжээтэй харьцуулна. Бодитоор олгосон цалин хөлж нь өмнөх дүнгээс бага байвал ажил олгогч ажилтанд дутуу тооцсон хэмжээг 14 хоногийн дотор төлнө.

(в) Ажил олгогч нь 17.2 (б) -т заасан харьцуулалтыг хийхдээ жилээр тооцож олгох хөдөлмөрийн хөлснийг тооцоход хамрагдсан ажилтан бүрийн ажил эхлэх, дуусах хугацаа, цалингүй чөлөө авсан зэргийг тэмдэглэсэн байх ёстой. Энэ тэмдэглэлд ажилтан цалин олгох хугацаа, эсхүл уртын ээлж бүр гарын үсэг зурж үнэн зөвийг баталгаажуулна (бичгээр болон цахим хэлбэрээр).

**17.3 дахь хэсэг.** Жилээр тооцох цалин хөлсний ажиллагсдын цалингийн тарифын хувь. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний стандартын дагуу цалин хөлс авдаг ажилтны цалингийн суурь, хувь хэмжээ нь 15 дугаар зүйлд заасан хамгийн доод хэмжээ, урамшуулал, мөнгөн тэтгэмж, илүү цаг, шимтгэл зэргээс бүрдэнэ.

#### 18 дугаар зүйл. Тэтгэмж

**18.1 дэх хэсэг.** Ажил олгогч нь ажилтанд 18 дугаар зүйлд заасны тэтгэмжийг ажилтанд төлөх ёстой. Ажилтанд цагаар нь цалин хөлс олгодог тохиолдолд тэтгэмж нь долоо хоногийн 1/38-ны хооронд байх болно.

#### 18.2 дахь хэсэг. Цалинтай холбоотой тэтгэмж

- (б) Салбарын тэтгэмж
  - (i) Ажилчдад долоо хоногт 32.47 ам.долларын тэтгэмж олгоно.
  - (ii) Салбарын тэтгэмж нь тухайн салбар дахь бүх төрлийн ажил, түүний дотор уул



уурхайн үйл ажиллагааны байршил, шинж чанараар хязгаарлагдахгүй хувцас, шороо, нойтон, өндөр, утаа, дулаан, хүйтэн, хязгаарлагдмал орчинг хамрах ба 18 дугаар зүйлийн дагуу бусад бүх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулаагүй.

(в) Лицензийн тэтгэмж - цахилгаанчин [18.2

Ажилтнууд нь цахилгааны техникч (эсхүл түүнтэй адилтгах) лицензтэй байх ажил олгогчоос шаардсан тохиолдолд долоо хоногт 39.93 ам.долларын тэтгэмж олгоно. Энэхүү тэтгэмжийг бүх зорилтот төлөх болно.

(г) Өрөмдлөг, хайгуул, хайгуулын ажлын тэтгэмж

Дараах тэтгэмжийг зөвхөн өрөмдлөг, хайгуул, хайгуулын ажил гүйцэтгэх шаардлагатай ажилтанд хамруулна.

(i) Алслагдсан байршилд (уурхайн талбайгаас хол) буудаллах, ирэх, очих шаардлагатай ажилчдад ажил олгогч дараах байдлаар тэтгэмж олгоно.

- Ажил олгогч нь өдөрт хоолгүй бол 29.75 ам.доллар;
- Ажил олгогч нь өдөрт хоол өгдөг бол 16.41 ам.доллар.

(ii) Ажил олгогч нь байр, хоолоор хангасан, ажилтан амралтын өдрөөр гэртээ харих, ирэх, зардлыг өөрөө төлсөн тохиолдолд тэтгэмж олгох шаардлагагүй. Уул уурхайн салбартай холбоотой ажлын хүрээнд зохицуулалт хийдэг. [18.2 (d)

(iii) Тогооч, тогоочийн туслах зэрэг ажилтнуудад ажил олгогч нь ээлжээр ажиллуулах ба долоо хоногт 9.39 ам. долларын тэтгэмжийг олгоно.

(iv) Ажил олгогч нь ажилтнаас дараах байдлыг шаардагдсан тохиолдолд:

- нэг газраас нөгөө ажлын байранд шилжүүлэх; эсхүл
- энгийн ажлын байрнаас түр хугацаагаар ажиллах, тээврийн зардлыг нөхөн олгох бөгөөд ажилчдын энгийн цагийн тарифаар 8 цаг хүртэлх хугацааны төлбөрийг төлөх болно (хэрэв ажил олгогч нь тээврийн хэрэгслээр хангасан тохиолдолд нөхөн төлбөр олгохгүй).

(д) Анхны тусламжийн тэтгэмж

(е) Сент Жонн түргэн тусламж болон түүнтэй адилтгах байгууллагаас анхны шатны мэргэшсэн ажилтантай бол ажил олгогчоос яаралтай тусламжийн багт оролцох, анхны тусламжийн үүрэг гүйцэтгэхээр томилогдсон ажилтанд долоо хоногт 17.55 ам. долларын анхны тусламжийн тэтгэмжийг олгоно.

(е) Удирдах албан тушаалтны тэтгэмж

Удирдах албан тушаалтны тэтгэмжийг долоо хоногт доорх байдлаар олгоно.

Хариуцсан ажилтны тоо	Долоо хоногийн тэтгэмж \$
3–10 ажилчид	38.61\$
11–20 ажилчид	49.15\$
20 ба түүнээс дээш ажилчид	66.08\$

(ж) Төмөр замын ажилтны тэтгэмж

Үндсэн чиглэлийн ажилд чадварлаг гэж үнэлэгдсэн, ажил олгогч нь зүтгүүрийн машинистыг томилж, үндсэн чиглэлд ажиллуулах тохиолдолд ажилтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 30% -ийн тэтгэмжийг олгоно.

(h) Газар доор ажиллагсдын тэтгэмж

Гүний уурхайчны ангилалд багтсан ажилчдаас бусад ажилтанд ажил олгогч нь

газар дор ажиллуулах тохиолдолд цагт 1.62 ам.долларын тэтгэмжийг олгоно.

**18.3 дахь хэсэг.** Зардалтай холбоотой тэтгэмж

(а) Илүү цагаар ажиллагсдын хоолны мөнгө

Ажилтан нь илүү цагаар ажиллахдаа амрах завсарлага авсан, ажил олгогч нь хоол өгөх, хоол хийх нөхцөлийг бүрдүүлсэн тохиолдолд тэтгэмж олгохгүй тохиолдолд мөн ажилтанд илүү цагаар ажиллуулахаа өмнөх өдөр буюу ээлжид гарахын өмнө хожуу мэдэгдсэн бол 17.29 ам.долларын хоолны мөнгийг олгоно.

(б) Багаж хэрэгслийн тэтгэмж

Ажил олгогчоос ажлын гүйцэтгэлд шаардлагатай багаж хэрэгслийг нийлүүлж, хадгалахыг шаардсан ажилтанд долоо хоногт 15.96 ам.долларын тэтгэмжийг олгоно.

**5 дугаар бүлэг. 20 дугаар зүйл.** Илүү цаг ба шимтгэлийн хувь хэмжээ

**20.1 дэх хэсэг.** Байнгын ээлжээр ажиллагсдын илүү цаг

20 дугаар хэсэгт өөрөөр заагаагүй бол байнгын ээлжийн ажилчин бус ажилтанд бүх ажлын хөлсийг ердийн ажилласан цагаас гадна дараах хэмжээгээр олгоно.

Ажилласан илүү цаг	Үндсэн болон цагийн ажилтан	Энгийн ажилтан
	Ердийн цагийн хувь хэмжээ %	Ердийн цагийн хувь хэмжээ %
Давааг- Бямба гарагийн 12 цаг хүртэл-эхний 3 цаг	150%	150%
Давааг- Бямба гарагийн 12 цаг хүртэл-сүүлийн 3 цаг	200%	200%
Бямба гарагийн 12 цаг, Ням гарагийн бүх цаг	200%	200%
Олон нийтийн амралтын өдрүүд	250%	250%

**20.2 дахь хэсэг.** Байнгын ээлжийн ажилчинд ажилласан цагийн хөлсийг ердийн цагийнхаас гадна дараах хэмжээгээр төлнө.

Илүү ажилласан цаг	Үндсэн болон цагийн ажилтан	Энгийн ажилтан
	Ердийн цагийн хувь хэмжээ %	Ердийн цагийн хувь хэмжээ %
Даваа-Ням гарагийн бүх цаг	200%	200%

**20.3 дахь хэсэг.** Ажил олгогч нь ажлын гарсны дараа илүү цагаар буцаж ажиллах тохиолдолд (ажилтанд ажлаас гарахаас өмнө болон дараа нь мэдэгдсэн эсэхээс үл хамаарна) ажилтанд дараах байдлаар олгоно.

(а) доод тал нь 4 цаг ажиллах; эсхүл

(б) ажилтан 4-өөс доошгүй цагаар ажиллахаар тохиролцсон бол, илүү цагийн доод хэмжээ 4 цаг ажилласан тохиолдолд.

**20.4 дэх хэсэг.** Тооцоолох арга

(а) Илүү цагийн төлбөрийг тооцохдоо ажилласан өдөр, гарсан ээлж бүрийг тус тусад нь тооцно.

(б) 20 дугаар зүйлд заасан илүү цагийн төлбөрийг, 21 дүгээр зүйлд заасан

ээлжийн ажил болон шимтгэлийн хувь хэмжээ, бусад алдангийн хэмжээг тооцно.

**20.5 дахь хэсэг.** Илүү цагийн төлбөрийн оронд чөлөө эдлэх тухай

(а) Ажил олгогч нь ажилтанд илүү цагийг төлбөр олгохын оронд цалин хөлс чөлөө эдлэх тухай /бичгээр / ажилтанд зөвшөөрнө.

(б) Ажилтан өөрийн ажилласан илүү цагийг төлбөр авахын оронд чөлөөгөөр эдлэх тухай 20.5 дахь хэсэгт заасны дагуу гэрээ байгуулах ёстой.

(в) Гэрээнд дараах зүйлийг тусгасан байна.

(i) хамаарах илүү цагаар ажилласан, ажиллуулах хугацаа

(ii) ажил олгогч ба ажилчин илүү цагийн төлбөр авахын оронд чөлөө эдлэх тухай хүлээн зөвшөөрсөн байх;

(iii) хэрэв ажилчин хүсэлт гаргасан бол ажил олгогч нь гэрээнд тусгасан ч чөлөө эдлэх талаар тооцоогүй үлдээсэн, илүү цагийн төлбөрийг заавал тооцох ёстой;

(iv) 20.5 дахь хэсэг (с) (iii) -т дурдсанаар аливаа төлбөрийн хүсэлтийг дараагийн хугацаанд заавал хийх ёстой.

**ЖИШЭЭ:** 20.5 дахь хэсэгт заасны дагуу гэрээ хийснээр илүү цагаар 2 ажилласан ажилтан 2 цаг ажиллахгүй байх эрхтэй.

(е) Завсарлага авах хугацаа:

(i) илүү цагаар ажилласнаас хойш 6 сарын хугацаанд;

(ii) ажилтан, ажил олгогчийн хооронд тохиролцсон 6 сарын хугацаанд нэг удаа, эсхүл.

(е) Ажилтан 20.5 дахь хэсэг болон гэрээнд заасны дагуу илүү цагаар ажилласан төлбөрийг ажил олгогчоос нэхэмжилж, ажил олгогч нь ажилтны илүү цагийн төлбөрийг хугацаанд нь төлөх ёстой.

(ж) 20.5 дахь хэсгийн (д) дурдсанаар 6 сарын хугацаанд илүү цагаар ажилласны оронд чөлөө эдлэх эрхээ аваагүй тохиолдолд ажил олгогч ажилтанд илүү цагаар ажилласны дараа 6 сарын цалин хөлс олгох ёстой.

(h) Ажил олгогч нь 20.5 дахь хэсэгт заасны дагуу байгуулсан гэрээний хувийг ажилтны бүртгэлд хадгалах ёстой.

(i) Ажил олгогч нь илүү цагаар ажилласны төлбөр төлөхийн оронд чөлөө эдлэх тухай, эсхүл гэрээг байгуулахгүй байх, ажилтанд хэт их дарамт үзүүлэх ёсгүй.

(к) Ажилтан хуулийн 65 дахь хэсэгт заасны дагуу илүү цагаар ажилласны төлбөр, чөлөө эдлэх тухай ажил олгогч болон ажилтны хоорондоо тохиролцож болно. ажилтан. Хэрэв ажил олгогч хүсэлтийг хүлээн зөвшөөрвөл 20.5 дахь хэсэг хүчин төгөлдөр болно. Үүнд 20.5 дахь хэсгийн (б) -д зааснаар бичгээр байгуулсан гэрээний нөхцөл, илүү цагаар ажилласан бүрийг хамруулна.

(к) Хэрэв ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцлахад 20.5 дахь хэсэг хамаарах бөгөөд ажилтан илүү цагаар ажилласан хугацааны чөлөө эдлэх эрх үүсээгүй бол ажил олгогч нь илүү цагаар ажиллуулах ёстой.

**21.2 дахь хэсэг.** Ээлжийн ажилчин эсвэл байнгын ээлжийн ажилчинд дараах төлбөрийг төлөх ёстой:

(а) үдээс хойш буюу шөнийн ээлжинд ажилласны дараа тэдний ердийн цагийн цалингийн хэмжээг 115%;

(б) байнгын шөнийн ээлжинд ажиллахдаа цалингийн ердийн цагийн хөлсний

хэмжээг 130%.

### 21.3 дахь хэсэг. Долоо хоногийн амралтын өдрүүд, бүх нийтийн амралт

Бямба, Ням гараг эсхүл бүх нийтийн амралтын өдрүүдэд ажилласан энгийн цагаар ажилтанд дараах төлбөрийг олгоно.

Илүү ажилласан цаг	Ердийн цагийн хувь хэмжээ
Бямба гаригийн үдээс өмнө 12 цаг - эхний 3 цаг	150%
Бямба гараг 12 цагаас өмнө – сүүлийн 3 цаг	200%
Бямба гараг 12 цагаас хойш, ням гарагийн бүх цагаар	200%
Бүх нийтийн амралт	250%

#### Б.1.3 Үндсэн болон цагийн ажилчдын энгийн ба шимтгэлийн хувь хэмжээ

	Өдөр	Үдээс хойш ба шөнө	Байнгын ээлжинд	Бямба гарагийн 12 цагаас өмнөх		Бямба гарагийн 12 цагаас хойш, Ням гараг	Бүх нийтийн амралт
				Эхний 3 цаг	Сүүлийн 3 цаг		
Ердийн цагийн хувь хэмжээ							
	100%	115%	130%	150%	200%	200%	250%
	\$	\$	\$	\$	\$	\$	\$
Entry level	21.41	24.62	27.83	32.12	42.82	42.82	53.53
Level 1	22.43	25.79	29.16	33.65	44.86	44.86	56.08
Level 2	23.26	26.75	30.24	34.89	46.52	46.52	58.15
Level 3	23.94	27.53	31.12	35.91	47.88	47.88	59.85
Level 4	25.49	29.31	33.14	38.24	50.98	50.98	63.73
Level 5	27.09	31.15	35.22	40.64	54.18	54.18	67.73
Level 6	28.38	32.64	36.89	42.57	56.76	56.76	70.95
Level 7	29.49	33.91	38.34	44.24	58.98	58.98	73.73

#### Б.1.4 Байнгын ажилчдаас бусад үндсэн болон цагийн ажилчдын илүү цаг

	Бямба-Ням гараг		Бямба 12 цагийн дараа, Ням	Бүх нийтийн амралт
	Эхний 3 цаг	Сүүлийн 3 цаг		
Ердийн цагийн хувь хэмжээ				
	150%	200%	200%	250%
	\$	\$	\$	\$
Entry level	32.12	42.82	42.82	53.53
Level 1	33.65	44.86	44.86	56.08
Level 2	34.89	46.52	46.52	58.15
Level 3	35.91	47.88	47.88	59.85
Level 4	38.24	50.98	50.98	63.73
Level 5	40.64	54.18	54.18	67.73
Level 6	42.57	56.76	56.76	70.95

Level 7	44.24	58.98	58.98	73.73
---------	-------	-------	-------	-------

Б.1.5 Үндсэн ба цагийн ажилчид- ээлжээр ажилладаг хүмүүс - илүү цаг

	Даваа-Ням гараг
	Ердийн цагийн хувь хэмжээ
	200%
	\$
Анхан шатны	42.82
Түвшин 1	44.86
Түвшин 2	46.52
Түвшин 3	47.88
Түвшин 4	50.98
Түвшин 5	54.18
Түвшин 6	56.76
Түвшин 7	58.98

Б.2.3 Энгийн ажилчид -ердийн ба шимтгэлийн хувь хэмжээ

	Өдөр	Үдээс хойш &шөнө	Тогтмол ээлжинд	Бямба гараг 12 цагаас өмнөх		Бямба гараг 12 цагаас хойш, Ням гараг	Бүх нийтийн амралтын өдөр
				First 3 hours	After 3 hours		
	Ердийн цагийн хувь хэмжээ						
	100%	115%	130%	150%	200%	200%	250%
	\$	\$	\$	\$	\$	\$	\$
Анхан шат	26.76	30.77	34.79	40.14	53.52	53.52	66.90
Түвшин 1	28.04	32.25	36.45	42.06	56.08	56.08	70.10
Түвшин 2	29.08	33.44	37.80	43.62	58.16	58.16	72.70
Түвшин 3	29.93	34.42	38.91	44.90	59.86	59.86	74.83
Түвшин 4	31.86	36.64	41.42	47.79	63.72	63.72	79.65
Түвшин 5	33.86	38.94	44.02	50.79	67.72	67.72	84.65
Түвшин 6	35.48	40.80	46.12	53.22	70.96	70.96	88.70
Түвшин 7	36.86	42.39	47.92	55.29	73.72	73.72	92.15

Б.2.4 Энгийн ажилчид, байнгын ээлжийн ажилчдаас бусад илүү цаг

	Даваа- Бямба гараг		Бямба гараг 12 цагаас хойш, Ням гараг	Бүх нийтийн амралт
	Эхний 3 цаг	Сүүлийн 3 цаг		
	Ердийн цагийн хувь хэмжээ			
	150%	200%	200%	250%
	\$	\$	\$	\$
Анхан шат	40.14	53.52	53.52	66.90
Түвшин 1	42.06	56.08	56.08	70.10
Түвшин 2	43.62	58.16	58.16	72.70

Түвшин 3	44.90	59.86	59.86	74.83
Түвшин 4	47.79	63.72	63.72	79.65
Түвшин 5	50.79	67.72	67.72	84.65
Түвшин 6	53.22	70.96	70.96	88.70
Түвшин 7	55.29	73.72	73.72	92.15

#### Б.2.5 Энгийн ажилчид – байнгын ээлжийн ажилчид - илүү цаг

	Даваа- Ням гараг
	Ердийн цагийн хувь хэмжээ %
	200%
	\$
Анхан шат	53.52
Түвшин 1	56.08
Түвшин 2	58.16
Түвшин 3	59.86
Түвшин 4	63.72
Түвшин 5	67.72
Түвшин 6	70.96
Түвшин 7	73.72

#### С.1 Цалинтай холбоотой тэтгэмж

Тэтгэмжүүд	Хэсэг	Стандарт хувь хэмжээ %	\$	Төлөх ёстой
Салбарын тэтгэмж	18.2(b)(i)	3.7	32.47	7 хоног
Лиценз тэтгэмж-цахилгаанчин	18.2(c)	4.55	39.93	7 хоног
Өрөмдлөг, хайгуул, хайгуулын тэтгэмж -хоолгүй	18.2(d)(i)	3.39	29.75	7 хоног
Өрөмдлөг, хайгуул, хайгуулын тэтгэмж -хоолтой	18.2(d)(i)	1.87	16.41	7 хоног
Өрөмдлөг, хайгуул, хайгуулын тэтгэмж-тогооч, тогоочийн туслах – Ээлжийн	18.2(d)(iii)	1.07	9.39	7 хоног
Анхан тусламжийн тэтгэмж	18.2(e)	2.0	17.55	7 хоног
Удирдах албан тушаалтан 3-10 ажилтантай	18.2(f)	4.4	38.61	7 хоног
Удирдах албан тушаалтан 11-20 ажилтантай	18.2(f)	5.6	49.15	7 хоног
Удирдах албан тушаалтан 20-оос дээш ажилтантай	18.2(f)	7.53	66.08	7 хоног
Газар доорх ажиллагсад, газар доорх уурхайчдаас бусад	18.2(h)	7.0	1.62	7 хоног

С.2.1 18.3 дахь хэсэгт заасны дагуу ажилчдад дараах зардалтай холбоотой тэтгэмжийг олгоно.



Тэтгэмж	Хэсэг	\$	Төлөх ёстой
Илүү цагаар ажилласан тохиолдолд хоолны мөнгө	18.3(a)	17.29	Хоол бүр
Багаж хэрэгслийн тэтгэмж	18.3(b)	15.96	7 хоног

#### С.2.2 Зардалтай холбоотой тэтгэмжийг тохируулах

Тэтгэмж	Хэрэглэгчийн үнийн индекс
Хоолны тэтгэмж	Түргэн хоол, хоолны бүлэг
Багаж хэрэгслийн тэтгэмж	Багаж хэрэг ба гэр ахуйн цахилгаан хэрэгсэл байшин цэцэрлэгийн багаж хэрэгсэл

#### Д.4 Дэмжигдсэн цалингийн хэмжээ

Д.4.1 Энэхүү хуваарьт хамаарах ажилтнуудад дараах хуваарийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний холбогдох хувийг олгоно.

Үнэлгээний чадвар (хэсэг <u>Е.5</u> ) %	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний цалин %
10	10
20	20
30	30
40	40
50	50
60	60
70	70
80	80
90	90

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <https://www.abs.gov.au/statistics/labour/earnings-and-work-hours/average-weekly-earnings-australia/latest-release>
- <https://www.gov.kz/memleket/entities/stat/press/news/details/119682?lang=kk>
- <http://www.salaryexplorer.com/salary-survey.php?loc=43&loctype=1>
- <http://www.salaryexplorer.com/salary-survey.php?loc=43&loctype=1&job=39&jobtype=1>
- [http://1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NSO\\_0400\\_022V1&Salbar\\_select\\_all=0&SalbarSingleSelect=\\_1\\_103&Gender\\_select\\_all=0&GenderSingleSelect=\\_1&YearQ\\_select\\_all=0&YearQSingleSelect=\\_202003&YearY\\_select\\_all=0&YearYSingleSelect=\\_2019&viewtype=columnchart](http://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0400_022V1&Salbar_select_all=0&SalbarSingleSelect=_1_103&Gender_select_all=0&GenderSingleSelect=_1&YearQ_select_all=0&YearQSingleSelect=_202003&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2019&viewtype=columnchart)
- <https://www.currency.me.uk/convert/clp/usd>
- <https://www.mongolbank.mn/dblistofficialdailyrate.aspx>
- [http://awardviewer.fwo.gov.au/award/show/MA000011#P486\\_42956](http://awardviewer.fwo.gov.au/award/show/MA000011#P486_42956)

**МОРИН ТОЙРУУЛГЫН БООЦООТ УРАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛСАН  
СУДАЛГАА**

**(Г.Алтан-Оч (Ph.D), Б.Батцэцэг)**

**АГУУЛГА**

ОРШИЛ

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

- Монгол
- БНСУ
- Макао
- Герман
- АНУ
- Франц

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## ОРШИЛ

Судалгааны захиалгын дагуу бооцоот морин уралдааны тухай Монгол Улсын эрх зүйн зохицуулалт болон бооцоот уралдаан, тэмцээн зохион байгуулахыг зөвшөөрдөг улс орнуудын туршлагын талаарх харьцуулсан судалгааны ажлыг гүйцэтгэв.

Бооцоот морин уралдаан нь олон улсын түвшинд Betting on Horse Racing буюу мөрийтэй тоглоомын нэгэн төрөлд хамаардаг. Ийм учраас энэ төрлийн бооцоог ихэнх улсад the gambling law, the betting law буюу мөрийтэй, бооцоот тоглоомын тухай хууль тогтоомжоор зохицуулдаг ажээ.

**Судлагдсан байдал:** Тус хүрээлэнд уг сэдвийг хамруулан “Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай Монгол Улсын эрх зүйн зохицуулалт болон казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг гадаадын зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг (СТ-14/212) Ц.Болормаа нар 2014 онд хийж гүйцэтгэжээ. Энэхүү судалгаанд казино, бооцоот уралдаан, тэмцээний газрыг байгуулахыг зөвшөөрдөг улс орнуудын эрх зүйн зохицуулалт, түүнчлэн казиногийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, үр дагавар, казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаанаас олох жилийн орлого, эдийн засагт эзэлж буй хувь хэмжээ зэргийг судлажээ. Ингэхдээ АНУ, БНСУ, Макао, Сингапур улсуудын эрх зүйн ерөнхий зохицуулалт, түүнчлэн казиногийн эдийн засаг болон нийгмийн салбарт үзүүлэх эерэг, сөрөг үр нөлөө, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагавраас хамгаалах механизм зэрэг мэдээллийг хамруулсан аж.

## СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

- Бооцоот морин уралдаан нь спортын бооцоот тоглоомын төрөлд багтана.
- Бооцоот морин уралдааны эрх зүйн орчныг мөрийтэй, бооцоот болон хонжворт тоглоомын тухай ерөнхий хууль бүрдүүлж байна.
- Бооцоот морин уралдаан зохион байгуулагч нь концессийн гэрээ болон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг байна. Төрийн зохицуулах алба ажилладаг.
- Бооцоот уралдаан зохион байгуулагч нь концессийн эрхийн болон тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр төлдөг байна. Түүнээс гадна орлогын шимтгэлийн хэмжээ 10% (АНУ), 12-22% (Сингапур), 16.5% (Франц), 20% (БНСУ), 35-39% (Макао) тус тус байна.
- Бооцоонд оролцогч хувь хүний бооцооны татвар 5% (Герман), 7% (Сингапур), 11% (АНУ), 12% (Франц) тус тус байна.
- Бооцоот морин уралдаан нь мөнгө угаах гэмт хэрэгт ашиглагдах эрсдэлтэй байдаг байна.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### Монгол

Манай улсын хувьд мөрийтэй тоглохыг хориглосон байдаг бөгөөд Зөрчлийн тухай хуулийн<sup>292</sup> 5.7 дугаар зүйл “Мөрийтэй тоглоом тоглох”-ийн 1 дэх хэсэгт “Олон нийтийн газар ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом тоглосон бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж, Эрүүгийн хуулийн<sup>293</sup> тусгай ангийн 20.17 дугаар зүйл “Мөрийтэй тоглоом зохион байгуулах”-ийн 1 дэх хэсэгт “Олон нийтийн газар, эсхүл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж тус тус хуульчилсан байна.

Гэхдээ манай улсад ашиг хонжоо олох зорилгоор бооцоот морин уралдаан зохион байгуулахыг зөвшөөрсөн захиргааны хэм хэмжээ тогтоосон акт бий. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 155 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах журам”<sup>294</sup>-ын 1.2.2-д бооцоот тоглоом гэдэгт тоглоомын үр дүн нь тоглогчийн мэдлэг, ур чадвараас хамаарах буюу урьдчилан тооцоолох магадлалтай боловч зөвхөн мэдлэг, ур чадвар байснаар ялагч болдоггүй, бооцоо тавин тоглодог, ашиг олох зорилгоор зохион байгуулах морин болон авто уралдаан, бөхийн таавар, билльард, шагай харвах болон эдгээртэй төсөөтэй бусад тоглоомыг ойлгоно гэж заасан бөгөөд иргэн, хуулийн этгээд энэхүү үйл ажиллагааг гагцхүү тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх эрх зүйн зохицуулалттай байна.

Улаанбаатар хотод 1950-60-аад оны үед морин тойруулга буюу ипподром ажиллаж, бооцоот морин уралдаан тогтмол явагддаг байжээ. Мөн Улаанбаатарын гудамжинд албан байгууллагууд лотто тоглуулан ажилтнууддаа зориулсан хуримтлал үүсгэхийг зөвшөөрдөг байсан байна.<sup>295</sup>

Тус хүрээлэнгийн судалгааг үндэслэн БНСУ, Сингапур, Макао гэсэн Зүүн Азийн тэргүүлэх зэргийн казино тоглоомын үйл ажиллагаа эрхлэгч улсуудын бооцоот тоглоомын төрөл, тухайн асуудлыг хариуцах төрийн эрх бүхий байгууллага болон татварын хэмжээ зэрэг мэдээллийг дараах хүснэгтэд харьцуулан үзүүлэв.

<sup>292</sup> ...: [www.Legalinfo.mn](http://www.Legalinfo.mn) - Хуулийн нэгдсэн портал сайт ...

<sup>293</sup> ...: [www.Legalinfo.mn](http://www.Legalinfo.mn) - Хуулийн нэгдсэн портал сайт ...

<sup>294</sup> ...: [www.Legalinfo.mn](http://www.Legalinfo.mn) - Хуулийн нэгдсэн портал сайт ...

<sup>295</sup> “Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай Монгол улсын эрх зүйн зохицуулалт болон казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг гадаадын зарим орны туршлага” СТ-14/212 (Харьцуулсан судалгаа), УИХТГ-ын судалгааны эмхэтгэл XVIII, 2014 он, 77-99 х.

**Хүснэгт.** Бооцоот тоглоомын төрөл, оногдуулах татварын хэмжээ (БНСУ, Сингапур, Макао)

Улс	Бооцоот тоглоомын асуудал эрхлэх эрх бүхий байгууллага	Бооцоот тоглоомын төрөл	Татвар
1. Бүгд Найрамдах Солонгос Улс  Эх Сурвалж: <a href="http://gaming.unlv.edu/abstract/south_kore">http://gaming.unlv.edu/abstract/south_kore</a> <b>HYPERLINK</b> "http://gaming.unlv.edu/abstract/south_kore a.html"a.html	Үндэсний Бооцоот Тоглоомыг Хянах Хороо-National Gambling Control Commission	-казино -хонжворт сугалаа, <b>-морин</b> болон дугуйн <b>уралдаан</b> , (авто уралдаан зэрэгт спортын уралдаан тэмцээний бооцоо орно)	Татварын бодит хувь хэмжээ /Effective tax rate/ 20%.
2. Бүгд Найрамдах Сингапур Улс  Эх Сурвалж: <a href="http://gaming.unlv.edu/abstract/singapore.html">http://gaming.unlv.edu/abstract/singapore.html</a>	Казиногийн Зохицуулах Газар-Casino Regulatory Authority	-хонжворт сугалаа (үүнд хөл бөмбөг болон авто уралдаан зэрэгт <b>спортын уралдаан тэмцээний бооцоо</b> орно) -казино	Татварын бодит хувь хэмжээ 12-22%. Татварын хоёр шатлалтай: Бооцоот тоглоомоос олох нийт орлого /Gross Gaminig Revenue-GGR/-ын татвар хэмжээ: премиум үйлчлүүлэгчээс*сарын 5%, бусад үйлчлүүлэгчээс сарын 15%; (Казиногийн хяналтын тухай хууль, 33А Бүлэг 146 дугаар зүйл.) Мөн түүнчлэн бүх төрлийн бооцоот тоглоомоос олсон орлогод 7% бараа, ажил, үйлчилгээний татвар ногдуулна.
3. Макао  Эх Сурвалж: <a href="http://gaming.unlv.edu/abstract/macau.html">http://gaming.unlv.edu/abstract/macau.html</a>	Бооцоот Тоглоомыг Хянах болон Зохицуулах Товчоо-Gaming Inspection and Coordination Bureau	-казино -pari-mutuel /тотализатор/ -хонжворт сугалаа -спортын уралдаан тэмцээний бооцоо	Татварын бодит хувь хэмжээ 38-39%. GGR-ын татвар: 35% (1.6%-ийг Макао Санд, 1.4% (SJM)**-д эсхүл 2.4%-ийг (бусад) дэд бүтэц/аялал жуулчлал/ нийгмийн халамжийн санд тус тус төвлөрүүлнэ.)

### **БНСУ**

Бооцоот тоглоомыг зарчмын хувьд хориглосон хэдий ч хязгаарлагдмал (аялал, жуулчлалыг нэмэгдүүлэх г.м.) хүрээнд тусгай хууль батлан бооцоот тоглоомын зарим хэлбэрийг хүлээн зөвшөөрсний дотор морин уралдаан багтсан байна. Бооцоот морин уралдааны асуудлыг Хүнс, хөдөө болон ойн аж ахуйн яам хариуцдаг аж.



## **МАКАО**

Макаод мөрийтэй тоглоомын эрх зүйн орчныг хэд хэдэн тусгай хуулиуд бүрдүүлэх ба гол хууль нь Мөрийтэй тоглоомын ерөнхий хууль юм. Морин уралдааны монополь концесс эзэмшигчийн жилийн төлбөр 15 сая MOP (2005-2015 он хүртэл), татварын хэмжээ нийт тоглоомын орлогын 25% байдаг аж. Харин казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэгч нь ААН-ийн орлогын албан татвар төлдөггүй байна.

## **ГЕРМАН**

Хатирч (Trab) морин тойруулгын замын урт 1000 м орчим байдаг бол хурдан (Galopp) мориных 1800-2900 м байдаг.<sup>296</sup>

Бооцоот морин уралдааны эрх зүйн орчныг Уралдааны бооцоо болон лоттоны тухай хуулиар зохицуулдаг бөгөөд энэ нь нэг төрлийн татварын хууль аж.

2017 оны байдлаар, Германд энэ төрлийн үйл ажиллагаанаас 1,837 тэрбум еврогийн татварын орлого бүрдүүлжээ. Бүх төрлийн бооцоот спортын уралдаан, тэмцээний (морин уралдаан үүнд багтана) бооцооны татвар<sup>297</sup> 5% байдаг аж. Спорт бооцооны татварын орлого<sup>298</sup> 2015 оны байдлаар 554 сая евро байсан байна.

*Макро эдийн засгийн ач холбогдол.* Морин уралдааны бооцооны системийг ашиглан мөнгө угаах эрсдэл бий. Учир нь бооцоонд тавих мөнгөний эх үүсвэр тодорхойгүй байдаг. Морин уралдааны бооцооны нийт эргэлтийн хэмжээ Германд харьцангуй бага учраас энэ нь асуудал болдоггүй аж.

## **АНУ**

АНУ-ын хувьд Калифорни, Нью-Йорк, Кентакки, Флорида, Мэрилэнд, Иллинойс зэрэг мужууд хамгийн том морин тойруулгатай бөгөөд хурдан морины уралдаанд бооцоо тавих хэлбэр нь муж улс бүрд харилцан адилгүй байжээ. 19-р зууны сүүлчээр АНУ-д 300 гаруй морин тойруулга үйл ажиллагаа явуулж байсан боловч 20-р зууны эхээр мөрийтэй тоглоом эсэргүүцэгчдийн нөлөөгөөр бооцоот морин уралдааныг ихэнх мужид хориглох болсон байна. Харин 1908 онд “Parimutuel”<sup>299</sup> бооцоог нэвтрүүлснээр АНУ-д бооцоот морин уралдааны салбарыг цэцэглэн хөгжүүлсэн гэж үздэг бөгөөд энэхүү бооцооны систем нь өнөөг хүртэл тус улсын 32 мужад хууль ёсны дагуу явагдаж байгаа юм.

### **Эрх зүйн орчин:**

АНУ-д одоогоор спортын бооцоотой холбоотой харилцааг холбооны дараах суурь хуулиар нэгдмэл байдлаар зохицуулж байна.<sup>300</sup> Үүнд: АНУ-д тодорхой төрлийн мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг хориглох тухай 1961 оны хууль (The Federal Wire Act<sup>301</sup>), Мэргэжлийн болон сонирхогчдын спортыг хамгаалах тухай 1992 оны хууль, Хууль бус интернэт мөрийтэй тоглоомыг хориглох тухай 2006 оны хууль (The Unlawful Internet

<sup>296</sup> Морин уралдаан-Pferderennen (Pferderennsport)-*германаар* <https://de.wikipedia.org/wiki/Pferderennen>

<sup>297</sup> Морины бооцоо-Pferdewetten-*германаар* <https://www.liga-zwei.de/sportwetten/sportarten/pferdewetten/#beiwelchem-buchmacher-kann-ich-in-deutschland-pferdewetten-online-spielen>

<sup>298</sup> Уралдааны бооцоо боло лоттоны хууль-Rennwett- und Lotteriegesetz-*германаар* [https://de.wikipedia.org/wiki/Rennwett-\\_und\\_Lotteriegesetz](https://de.wikipedia.org/wiki/Rennwett-_und_Lotteriegesetz)

<sup>299</sup> “Parimutuel betting” гэдэг нь тодорхой төрлийн бүх бооцоог хамтад нь байршуулах бөгөөд татвар болон house-take буюу зохион байгуулалтын зардлыг хасаж тооцсоны дараах бүх мөнгийг хонжворын мөрийд хувь тэнцүүлэн олгох систем юм.

<sup>300</sup> [Betting Laws In The USA - United States Federal Gambling Laws \(bettingusa.com\)](https://www.bettingusa.com/)

<sup>301</sup> [https://en.wikipedia.org/wiki/Federal\\_Wire\\_Act](https://en.wikipedia.org/wiki/Federal_Wire_Act)

Gambling Enforcement Act of 2006), Муж улс хоорондын морин уралдааны тухай 1978 оны хууль (Interstate Horseracing Act of 1978)<sup>302</sup>, Хууль бус мөрийтэй тоглоомыг хориглох тухай 1970 оны хууль (Illegal Gambling Business Act of 1970)<sup>303</sup> –аар тус тус зохицуулж байна. Конгресс уралдааны морьдын эмийн эмчилгээний хяналт, допингийн эсрэг бодлого, морин уралдааны аюулгүй байдалтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор 2020 оны 12 дугаар сард Морин уралдааны шударга болон аюулгүй байдлын тухай хууль (Horseracing Integrity and Safety Act)-ийг баталжээ. Уг хуулийн дагуу уралдааны морьдын хэрэглэж буй эм бэлдмэл, допингийн асуудлаар хяналт тавьдаг, морин тойруулгын аюулгүй байдлын наад захын стандартыг нэгдсэн журмаар хангуулдаг Удирдах газрыг байгуулсан байна.

Муж улс хоорондын морин уралдааны тухай хууль:

- Муж улсууд дотооддоо зохион байгуулах хууль ёсны мөрийтэй тоглоомын хэлбэрийг тодорхойлох үндсэн үүрэгтэй;
- Холбооны засгийн газар нь муж улсууд бие биенийхээ мөрийтэй тоглоомын бодлогод хөндлөнгөөс оролцохоос урьдчилан сэргийлэх, мөн нийт үндэстний ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаа явуулах;
- Муж улс хооронд уралдааны морьдыг зөөвөрлөх хязгаарлагдмал бүсэд муж улс хоорондын хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хангахын тулд Холбооны үйл ажиллагаа шаардлагатай байгааг зохицуулах зорилготой байна.

Хууль бус мөрийтэй тоглоомыг хориглох тухай хууль:

Үндэстэн дамнасан Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд 1970 онд батлагдан гарсан байна. Өнгөрсөн хугацаанд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд сахиулагчийг чадавхжуулахын зэрэгцээ хууль зүйн арга замыг сайжруулуухад нэгэн зэрэг анхаарч ирсэн байна.

Хууль бус мөрийтэй тоглоомыг хориглох тухай хуулийн гол зорилго нь мөрийтэй тоглоомын бизнесийг зохион байгуулалтах, хяналттай байлгахад оршино. Энэхүү хориглолт нь муж улсын хуулиар зохицуулагдах зөрчил байдаг бөгөөд тав ба түүнээс дээш хүмүүсийг оролцуулсан, санхүү, зохион байгуулалт, зорилго чиглэлээ нэгтгэсэн бизнесийг хамааруулдаг.

Хууль бус интернэт мөрийтэй тоглоомыг хориглох тухай 2006 оны хууль:

АНУ-ын хувьд морин уралдааны бооцоог цахим буюу интернэт хэлбэрээр зохион байгуулах нь түгээмэл болсон тул 2006 оны 10 дугаар сард тус улсын Ерөнхийлөгчийн саналаар Хууль бус интернэт мөрийтэй тоглоомыг хориглох тухай хуулийг баталжээ. Энэ хууль нь цахим орчин дахь бооцоог хянах, хориглох төрлийг тодорхойлох зорилготой. Тус хуулиар цахим орчинд бооцоо тавихыг гэмт хэрэгт тооцоогүй боловч гадаад улсаас зохион байгуулж буй хууль бус интернэт бооцооны санхүүжилт, хүмүүсийн оролцоог хянадаг.

Хууль бус интернэт мөрийтэй тоглоомыг хориглох тухай хуулиар товчхондоо интернэт орчинд хууль бус бооцоо тавихаас урьдчилан сэргийлэхээс гадна аж ахуйн нэгжүүд мэдсээр байж санхүүгийн гүйлгээг нь хийсэн бол хууль бус болно. Энэхүү хуулийн хүрээнд хууль бус цахим бооцоог үр дүнтэй таслан зогсоох үйл ажиллагаа хязгаарлагдмал явагдаж байгаа боловч мөнгөн хуримтлал бий болгох нийтлэг арга замыг

<sup>302</sup> <https://www.congress.gov/bill/116th-congress/senate-bill/4547/text>

<sup>303</sup> <https://www.law.cornell.edu/uscode/text/18/1955>

үр нөлөөтэй тасалдуулж чадсан байна.

### **Мөрийтэй тоглоом ба татвар:**

Холбооны хуулиар мөрийтэй тоглоомоос 600-аас дээш долларын хонжвор хожсон бол Дотоодын орлогын алба (Internal Revenue Service)-д мэдэгдэж, 5,000-аас дээш долларын хонжворынхоо 25 хувийг татварт суутгуулах үүрэгтэй. Жишээ нь, хэн нэгэн jackpot хожиж, 389 сая долларын нэг удаагийн хонжвортой болвол, 97.25 сая долларыг Дотоодын орлогын албанд тушаана.

Ихэнх муж улсад мөрийтэй тоглоомын хонжворт мужийн орлогын албан татвар ногдуулдаг бол суутган тооцох татварын хэмжээ нь харилцан адилгүй байх боловч Калифорния, Делавэр, Пенсильвани зэрэг орлогын албан татваргүй муж ч бас байдаг.

### **Пари-Мүтүл бооцоо:**

“Пари-Мүтүл бооцоо” буюу “Parimutuel betting” гэдэг нь тодорхой төрлийн бооцоог бүхэлд нь нэг байршуулах бөгөөд татвар болон house-take буюу зохион байгуулалтын зардлыг хасаж тооцсоны дараах бүх мөнгийг хонжворын мөрийд хувь тэнцүүлэн олгох систем юм. Одоо АНУ-д морин уралдааны бооцоо бүхэлдээ энэ системээр явж байгаа бөгөөд морин тойруулга буюу бооцоо цуглуулагч нь бооцооны нийт үнийн дүнгийн 10 хувийн шимтгэлийг house-take буюу зохион байгуулалтын зардалд тооцож авдаг. Харин татварын хэмжээ нь нийт пари-мүтүл бооцоо тус бүрийн 11% байдаг. Жишээлбэл, 2.00 долларын бооцооны татвар нь 22 цент байна.

### **Бүртгэлийн гэрчилгээ:**

Пари-мүтүл бооцооны системийг ажиллуулах, явуулах, удирдах хүсэлтэй, эсвэл пари-мүтүл системийн агентлагаар дамжуулан бооцоо авахыг хүссэн хэн боловч хуулийн дагуу хүчин төгөлдөр бүртгэлийн гэрчилгээ авах ёстой. Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчийн хаяг, холбоо барих хүмүүс, албан тушаалтанд гарсан өөрчлөлтийн талаар Татварын хэлтэст заавал мэдэгдэх ёстой. Гэрчилгээг нэг хүнээс нөгөөд шилжүүлэх боломжгүй.

## **ФРАНЦ**

Францын бооцоот морин уралдааны салбар нь дэлхийд томоохонд тооцогдох бөгөөд Европын хамгийн баян морин тойруулгатай. Японы дараа дэлхийн хамгийн баян ширэгт зүлгэн дээрх уралдаан болох Лонгчампын морин тойруулгад зохиогдсон алдарт “Prix de l'Arc de Triomphe” тэмцээн нь 4 сая евро (ойролцоогоор 5,2 сая ам.доллар)-ийн шагналын сантай. Францын бооцоот морин уралдааны удирдах байгууллага нь Франц Галоп<sup>304</sup> юм.

### **Эрх зүйн орчин:**

Франц Улсад мөрийтэй тоглоом, бооцооны үйл ажиллагааг Иргэний хууль (Civil Code)<sup>305</sup>, Дотоодын аюулгүй байдлын тухай хууль (Homeland Security Code)<sup>306</sup>, Онлайн тоглоомын тухай (Gambling law France)<sup>307</sup> хуулиар зохицуулдаг. Казиногийн мөрийтэй тоглоом, спортын бооцоо, морин уралдааны бооцоо, мөн сугалааг Дотоод хэргийн яам болон Сангийн яам хянаж, зохицуулдаг. 2010 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 2010-476 тоот мөрийтэй тоглоом, онлайн мөрийтэй тоглоомын өрсөлдөөн, салбарын зохицуулалтыг

<sup>304</sup> [https://en.wikipedia.org/wiki/France\\_Galop](https://en.wikipedia.org/wiki/France_Galop)

<sup>305</sup> [https://www.legifrance.gouv.fr/codes/article\\_lc/LEGIARTI000006436117/1804-02-17](https://www.legifrance.gouv.fr/codes/article_lc/LEGIARTI000006436117/1804-02-17)

<sup>306</sup> <https://thelawreviews.co.uk/title/the-gambling-law-review/france>

<sup>307</sup> <https://www.gamblingsites.org/laws/france/>

нэвтрүүлэх тухай хуулийг Францын мөрийтэй тоглоомын тухай хууль<sup>308</sup> гэсэн нэртэй батлан гаргасан байна.

Зохицуулалтын үндсэн салбар болох яамдаас гадна мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд хяналт тавих тусгай комисс болох үндсэн хоёр байгууллага байдаг. PMU (Pari Mutuel Urbain) ба FDJ (Française des Jeux). PMU нь морины уралдааны үйл ажиллагааг эрхэлдэг бөгөөд FDJ нь бооцоот тоглоом, сугалааг хариуцдаг бөгөөд төрийн мэдэлд байдаг. Харин 2019 оноос энэ хоёр байгууллагыг нэгтгэн Хяналтын шинэ байгууллага болох Үндэсний мөрийтэй тоглоомын газар NGA<sup>309</sup> (National Gaming Authority) -ийг байгуулсан байна.

Үндэсний мөрийтэй тоглоомын газрын (NGA) хяналтын байгууллага нь Ерөнхийлөгчийн зарлигаар 6 жилийн хугацаатайгаар байгуулагддаг бөгөөд 9 гишүүний бүрэлдэхүүнтэй удирдах зөвлөлтэй ажил үүргээ УИХ-д тайлагнадаг байна. Тус байгууллага нь Европын болон олон улсын байгууллагуудтай нягт уялдаатай ажилладаг.

*Эрх, үүрэг:*

- онлайн операторууд лиценз олгох хууль дүрмийг дагаж мөрдүүлэх;
- тоглогчийг хамгаалах, донтолттой тэмцэх;
- мөрийтэй тоглоомын үйл ажиллагааны аюулгүй байдал, үйл ажиллагааны шударга ил тод байдлыг хангах;
- хууль бус сайтуудтай тэмцэх;
- залилан мэхлэх, мөнгө угаахтай тэмцэх.

#### **Бүртгэлийн гэрчилгээ:**

Дотоод хэргийн болон Сангийн яамны хэд хэдэн хорооноос мөрийтэй тоглоомын тодорхой үйл ажиллагаатай холбоотой асуудлыг зохицуулах онцгой эрх мэдэлтэй байдаг. Дотоод хэргийн яам мөрийтэй тоглоомын лицензийг олгодог бол Үндэсний мөрийтэй тоглоомын газрын хяналтын байгууллага (NGA) нь цахим мөрийтэй тоглоомын лицензийг олгодог.

Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль тогтоомжийн дагуу мөрийтэй тоглоомын операторууд нь сэжигтэй үйл ажиллагааны талаарх мэдээллийг Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх газар (TRACFIN)-т мэдээлэх үүрэг бүхий төлөөлөгчийг томилон ажиллуулж, дотоод хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй. Хэрэв энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэл болно.

#### **Татвар:**

Мөрийтэй тоглоомын хувьд бооцоот тоглоомын үйл ажиллагааны төрлөөс хамааран өөр өөр татвар ногдуулдаг. Татварыг бооцоо, эсвэл мөрийтэй тоглоомын нийт орлого дээр үндэслэдэг.

#### **Мөрийтэй тоглоомын операторуудад ногдуулах татвар**

Татварын олон янзын хэлбэр, шимтгэлийг FDJ-ийн зарж борлуулдаг сугалааны тасалбар дээр ногдуулдаг бөгөөд энэ нь тэдний зардлын 25 орчим хувийг эзэлдэг. Мөрийтэй тоглоомын нийт орлогын хэмжээнээс хамаарч татвар нь өөр өөр байдаг. Тоглогч 1,500 еврогоос дээш хэмжээний ашиг олсон тохиолдолд 12 хувийн татвар ногдуулдаг.

<sup>308</sup> <https://thelawreviews.co.uk/title/the-gambling-law-review/france>

<sup>309</sup> <https://anj.fr/english>

### Спортын бооцооны операторуудад ногдуулах татвар

Тоглогчдын хийсэн бооцооны зөрүү, тоглогчдын ашиг зэргээс үүссэн бодит эргэлтэд үндэслэн татвар ногдуулдаг. Харин морины бооцоот операторууд болон онлайн покерын операторуудын татвар ногдуулалт нь бооцооны нийт дүнгээс хамаарна. Мөн гадаадаас ирсэн Францын морин уралдааны арга хэмжээнд мөрий тавьсан дүнгээс Францын компаниудын олсон шимтгэлд тодорхой татвар ногдуулдаг.

Спортын бооцооны оператор бүр үндэсний болон орон нутгийн түвшинд ногдуулдаг төрөл бүрийн татвараас гадна тухайн холбооноос нь операторын төлөх "бооцооны эрх"-ийн зардлыг тодорхой зааж өгсний үндсэн дээр гэрээ байгуулсан байх ёстой. Спортын бооцоо тавьсан бүх бооцоонд 8.5%, онлайн казинод 33% корпорацийн татвар, покер тогоондоо 2%, морин уралдааны бооцоонд 8% нэмэлт татвар төлөх ёстой байна.

Бооцоот болон мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааны орлого нь НӨАТ-аас чөлөөлөгдөнө (Татварын тухай хуулийн 261 дүгээр зүйл) харин ашиг орлогоос НӨАТ-ын 20%-ийг төлөх ёстой. Орлогын татварыг тоглогчдод хожсон мөнгөө төлсний дараа үлдэх дүнгээр тодорхойлдог байжээ. (ашиг=үйл\_ажиллагааны\_орлого-татвар-тоглогчдод\_олгосон\_хожил). Харин 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байгаа татварын хуулийн нэмэлт өөрчлөлтөөр спортын бооцоо, сугалаа тоглоомын татварыг тоглогчдын мөрий дээр суурилагаа больж, харин тоглолтын нийт орлого (операторуудын бодит эргэлт) дээр үндэслэн татварын хэмжээг тогтоохоор болсон байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- “Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай Монгол улсын эрх зүйн зохицуулалт болон казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг гадаадын зарим орны туршлага” СТ-14/212 (Харьцуулсан судалгаа), УИХТГ-ын судалгааны эмхэтгэл XVIII, 2014 он, 77-99 х.
- Морин уралдаан-Pferderennen (Pferderennsport)-*германаар*  
<https://de.wikipedia.org/wiki/Pferderennen>
- Морины бооцоо- Pferdewetten-*германаар*  
<https://www.liga-zwei.de/sportwetten/sportarten/pferdewetten/#bei-welchem-buchmacher-kann-ich-in-deutschland-pferdewetten-online-spielen>
- Уралдааны бооцоо боло лоттоны хууль-Rennwett- und Lotteriegesetz-*германаар*  
[https://de.wikipedia.org/wiki/Rennwett- und Lotteriegesetz](https://de.wikipedia.org/wiki/Rennwett-_und_Lotteriegesetz)
- “Parimutuel betting” гэдэг нь тодорхой төрлийн бүх бооцоог хамтад нь байршуулах бөгөөд татвар болон house-take буюу зохион байгуулалтын зардлыг хасаж тооцсоны дараах бүх мөнгийг хонжворын мөрийд хувь тэнцүүлэн олгох систем юм.
- [Betting Laws In The USA - United States Federal Gambling Laws \(bettingusa.com\)](http://bettingusa.com)
- [https://en.wikipedia.org/wiki/Federal\\_Wire\\_Act](https://en.wikipedia.org/wiki/Federal_Wire_Act)
- <https://www.congress.gov/bill/116th-congress/senate-bill/4547/text>
- <https://www.law.cornell.edu/uscode/text/18/1955>
- [https://en.wikipedia.org/wiki/France\\_Galop](https://en.wikipedia.org/wiki/France_Galop)
- [https://www.legifrance.gouv.fr/codes/article\\_lc/LEGIARTI000006436117/1804-02-17](https://www.legifrance.gouv.fr/codes/article_lc/LEGIARTI000006436117/1804-02-17)
- <https://thelawreviews.co.uk/title/the-gambling-law-review/france>
- <https://www.gamblingsites.org/laws/france/>
- <https://thelawreviews.co.uk/title/the-gambling-law-review/france>
- <https://anj.fr/english>
- www.Legalinfo.mn - Хуулийн нэгдсэн портал сайт



# КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

(Дүн шинжилгээ)

*О.Билгүүтэй*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

ХУРААНГУЙ

БҮЛЭГ I. КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- ХАЛДЛАГЫН АРГА ХЭЛБЭРҮҮД

БҮЛЭГ II. КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

- ДЭЛХИЙН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ИНДЕКС (GCI)
- BSA: ОЛОН УЛСЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО УЙЛ АЖИЛЛАГАА
- КИБЕР ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ БУДАПЕШТИЙН КОНВЕНЦ

БҮЛЭГ III. МОНГОЛ УЛС ДАХЬ КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ

БҮЛЭГ IV. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

- БНСУ
- МАЛАЙЗ УЛС

ХАВСРАЛТ

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Судалгааны мэдээллийг дараах 4 бүлэг асуудлын хүрээнд ангилан боловсруулсан:

1. Кибер аюулгүй байдал, халдлагын төрлүүд;
2. Олон улсын стандарт, бодлогын зөвлөмж, Будапештийн конвенц;
3. Кибер аюулгүй байдлын талаарх Монгол Улсад баримталж буй бодлого, зохицуулалтын орчин;
4. Бусад орнуудын туршлага (Солонгос, Малайз)

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Кибер аюулгүй байдал өнөө цагт хувийн аж ахуйн нэгжээс эхлээд эдийн засгийн салбар, цаашлаад үндэстний хэмжээнд яригддаг нийтлэг том сэдэв болж хувирсан ба техник технологийн хөгжлөөс үүдэлтэй жам ёсны асуудал юм. Нэг хүнээс нөгөө хүнд очих цахим мэдээ, мэдээлэл анхны агуулга шинжээ гээлгүй үнэн зөв дамжих ёстой. Гэвч мэдээллийн урсгалын зам зуурт хөндлөнгийн хүчин зүйлс нөлөөлснөөр мэдээллийн анхны шинж тэмдэг алдагдаж уг мэдээллийг хүлээн авагч талд сөрөг нөлөө үзүүлэх, нэг ёсны “цахим халдлага үүсэх” боломжтой.

Судалгааны нэгдүгээр бүлэгт, кибер аюулгүй байдлын талаар ерөнхий мэдээллийг тусгасан ба системийн сул талыг ашиглан хувь хүн, аж ахуй нэгж, цаашлаад нууцын зэрэглэлтэй мэдээлэл рүү хэрхэн нэвтэрч халдлага үйлддэг, үүнээс хэрхэн урьдчилан сэргийлж хамгаалдаг талаарх асуудлыг авч үзсэн.

Хоёрдугаар бүлэгт, олон улсад мөрдөж байгаа кибер аюулгүй байдалтай холбоотой стандарт, бодлогын зөвлөмж болон олон улсын гэрээ конвенцийн талаарх мэдээллийг оруулсан. Олон улсад кибер аюулгүй байдалтай холбоотой *ISO/IEC 27032:2012*, *ISO 27001* стандартуудыг мөрддөг бөгөөд дээрх стандартууд нь мэдээллийн аюулгүй байдлын менежментийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт юм. Аливаа улс орны цахим халдлагаас өөрийгөө хамгаалах чадамжийг Олон улсын харилцаа холбооны байгууллагаас (*International Telecommunication Union*) гаргасан кибер аюулгүй байдлын индексээр (*The Global Cybersecurity Index*) тодорхойлдог байна. Уг индексийг 1) хууль, эрх зүйн арга хэмжээ (*Legal*), 2) техникийн арга хэмжээ (*Technical Measures*), 3) байгууллагын зохион байгуулалтын арга хэмжээ (*Organization Measures*), 4) чадавх хөгжүүлэх арга хэмжээ (*Capacity Building Measures*), 5) хамтын ажиллагаа (*Cooperation Measures*) гэсэн үндсэн 5 шалгуур үзүүлэлтээр тодорхойлдог байна.

Мөн Олон улсын Програм хангамжийн холбооноос (*BSA*) зөвлөж буй кибер аюулгүй байдалтай холбоотой бодлого боловсруулахад засгийн газруудад шаардагдах 6 тулгуур зарчмыг тодорхойлсон. Түүнчлэн 2004 оноос хэрэгжиж эхэлсэн Будапештийн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенцийн үзэл баримтлал, зорилго, нэгдэн орсноор үүсэж болох давуу талуудыг мөн энэ бүлэгт тоймлон оруулсан.

Гуравдугаар бүлэгт, Монгол Улс дахь кибер аюулгүй байдлын хууль, эрх зүйн орчин, кибер аюулгүй байдалтай холбоотой үндэсний аюулгүй байдлын стратеги, мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан байгууллага, түүний чиг үүргийн талаарх мэдээллийг оруулсан.

Дөрөвдүгээр бүлэгт, кибер аюулгүй байдлын индексээр тэргүүлэх байр суурь эзэлдэг

сайн туршлагатай орнуудын жишээ болгож Солонгос болон Малайз улсын туршлага, цахим гэмт хэрэгтэй тэмцэх тухай бие даасан хууль болон холбогдох бусад хуулиудын талаарх мэдээллийг оруулсан.

**Түлхүүр үг:** Кибер аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдал, Кибер аюулгүй байдлын индекс, Будапештийн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенц

**Keywords:** Cybersecurity, Information security, Global cyber security index, Budapest cybersecurity convention,

## БҮЛЭГ I. КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ

**Мэдээллийн аюулгүй байдал** гэдэг нь мэдээлэл болон мэдээллийн системд зөвшөөрөлгүй хандах, мэдээллийг ашиглах, ил болгох, өөрчлөх, хуулах, устгах, мэдээллийн системийн үйл ажиллагааг тасалдуулах, гаднаас хяналт хийхээс хамгаалахыг хэлнэ.<sup>310</sup>

**Кибер аюулгүй байдал гэдэг нь** кибер гэмт хэргээс систем, сүлжээ, өгөгдлийг хамгаалахад зориулагдсан технологи, үйл явц, арга хэмжээнээс бүрддэг.<sup>311</sup> Кибер аюулгүй байдал нь кибер халдлагын эрсдэлийг бууруулж, систем, сүлжээ, технологийг санаатайгаар ашигласаар байгаа хүмүүсээс аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийг хамгаалахад чиглэгддэг. Кибер халдлагууд нь олон янзын хэлбэртэй байна. (жишээ нь програмын довтолгоонууд, malware, ransomware, фишинг гэх мэт). Кибер халдлага нь ихэвчлэн хулгайгаар (төлбөрийн картын өгөгдөл, хэрэглэгчийн мэдээлэл, компаний нууцлал, оюуны өмчийн эрхийг зөрчих гэх мэт) сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэн хохирогч этгээдэд санхүүгийн болон нэр хүндийн хохирол учруулах зорилгоор хийгддэг ажиллагаа юм. Кибер халдлагууд улам бүр боловсронгуй болсоор байгаа ба олон улсад аливаа улсын засгийн газрын мэдээллийн санд халдаж улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах, цэрэг, стратеги, улс төрийн салбарт чиглэсэн аюул занал учруулах явдал түгээмэл болж байна. Эдгээрээс зарим нэг нийтлэг аюул заналыг дурдвал:

- **Cyber terrorism** нь террорист бүлэглэлүүдээс засгийн газрын үзэл суртлын болон улс төрийн хөтөлбөрт нэвтрэн орж тодорхой зорилгоор мэдээллийн технологийг ашигладаг хэлбэр юм. Сүлжээнүүд, компьютерийн систем, харилцаа холбооны дэд бүтцэд нэвтрэх халддаг.<sup>312</sup>
- **Cyber warfare** нь улс үндэстний сүлжээнд нэвтрэх, мэдээллийн технологийг доголдуулдаг. Cyber warfare довтолгоонууд нь үндсэн сүлжээг эвдэх ба тухайн сүлжээний хэвийн ажиллагааг тасалдуулах чухал өгөгдлийг боогдуулах замаар халдлага үйлддэг.<sup>313</sup>
- **Cyber espionage** нь эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр нууц мэдээллийг олж авах тагнах хэлбэр юм. Cyber espionage нь стратегийн, эдийн засгийн, улс төрийн, цэргийн давуу талыг олж авахад ашиглагддаг.<sup>314</sup>

### ХАЛДЛАГЫН АРГА ХЭЛБЭРҮҮД

Кибер гэмт хэрэгтний зүгээс халдлага үйлдэх хэд хэдэн арга хэлбэрүүд байдаг бөгөөд тэдгээр нь хортой програмыг компьютерт оруулах, эсхүл өгөгдлийг хулгайлах зэрэг олон арга замаар хэрэгждэг байна. Үүнд:

- **Social engineering**- Хувь хүний сул талыг ашиглан хортой холбоос дээр даруулах, эсвэл хууран мэхлэх замаар компьютерт нэвтрэх эрх олж авах арга;
- **Phishing /өгөөш хаях замаар хохирогчийг удирдах/-**Хуурамч аж ахуйн нэгж байгуулах, эсхүл тэднийг төлөөлөх замаар хэрэглэгчийн мэдээллийг олж авахыг оролдох үйлдэл;

<sup>310</sup> Мэдээллийн аюулгүй байдлын газар

<sup>311</sup> Төрийн мэдээлэл холбооны газар

<sup>312</sup> [https://www.nato.int/cps/en/natohq/topics\\_140739.htm?](https://www.nato.int/cps/en/natohq/topics_140739.htm?)

<sup>313</sup> <https://www.dcaf.ch/sites/default/files/publications/documents/OnCyberwarfare-Schreier.pdf>

<sup>314</sup> <https://www.vmware.com/topics/glossary/content/cyber-espionage>

- **Pharming /Интернэт залилан/-**Вэб сайтын мэдээллийн урсгалыг өөр зүгт чиглүүлэх, хуурамч вэбсайт үйлдэх зэргээр хувь хүний мэдээллийг хулгайлах халдлага;
- **Drive-by /жолоодох/-**Систем доторх тодорхой сул талуудыг ашиглаж халдах;
- **Man in the middle /зуучлагч/-** Талуудын харилцаанд хөндлөнгөөс оролцож үр дүнд нь хакер хоёр талыг хоёуланг нь удирдах, хохироох боломжтой болох арга.

**Malware** нь компьютерийн системийг тасалдуулах, гэмтээх, зөвшөөрөлгүй нэвтрэх зорилгоор тусгайлан бүтээсэн програм хангамж бөгөөд эдгээр нь дараах хэлбэртэй байдаг:

- **Ransomware** нь компьютерийн систем дээр хортой программаар кибер халдлагыг эхлүүлсний дараа төлбөр шаарддаг хэлбэр юм. Энэ төрлийн хорт програм нь гэмт хэрэгтнүүдийн дунд түгээмэл болж, жил бүр сая сая байгууллагыг хохироож байна.
- **Viruses** (Вирус) нь нэг компьютерээс нөгөө компьютерт өөрөө өөрийгөө хуулбарлах боломжтой жижиг хэмжээний код юм.
- **Worms** (Өт) нь бусад компьютеруудад тархахын тулд өөрийгөө хуулбарладаг бие даасан хортой програм юм.
- **Trojans** (Троян) вирус нь нэг функц (жишээлбэл, вирус арилгах) мэт харагддаг програм боловч яг үнэндээ үйлдэл хийх үед системийг гэмтээдэг байна.
- **Spyware/adware** төрөл бүрийн файл хавсаргадаг ба үүнийг нээх холбоос дээр дарах эсвэл хортой програмыг татаж авах үед системд нэвтэрч хохирол учруулдаг.

### ХАЛДЛАГА ҮЙЛДЭХ СУВГУУД

- Хортой програм (код)-аар дамжин халдаах
- Цахим шуудан, мессежээр дамжин халдаах
- Цахим хуудас, нийтийн сүлжээгээр дамжин халдаах
- Нууц үг тайлах
- Төлбөртэй программыг эвдэж ашиглах



## БҮЛЭГ II. КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

Олон улсын стандартчиллын байгууллагаас (ISO) кибер аюулгүй байдлын ойлголт, шалгуур, боловсронгуй болгох зарчмуудыг багтаасан *ISO/IEC 27032:2012 Information technology (Мэдээллийн технологи)* Олон улсын стандартыг 2012 оны 7 дугаар сард тогтоосон байна.<sup>315</sup> Уг стандартад кибер аюулгүй байдал, сүлжээний аюулгүй байдал, хэрэглээний аюулгүй байдал, интернэтийн аюулгүй байдал, дэд бүтцийн аюулгүй байдал гэх мэт нэр томъёонуудыг тодорхойлсон байна. Түүнчлэн ISO 27001 нь мэдээллийн аюулгүй байдлын менежментийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт юм. Энэхүү стандартыг хэрэгжүүлснээр мэдээллийг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой арга хэмжээг шалгуур үзүүлэлт болгон талуудад баталгаа өгдөг байна.

### ДЭЛХИЙН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ИНДЕКС (GCI)

Америк, Англи, Герман тэргүүтэй өрнөдийн хөгжингүй орнууд кибер аюулгүй байдлаараа дэлхийд тэргүүлж байна. Цахим халдлагаас өөрийгөө хамгаалах чадамжийг Олон улсын харилцаа холбооны байгууллага (*International Telecommunication Union*)-аас гаргасан Дэлхийн кибер аюулгүй байдлын индексээр (*The Global Cybersecurity Index*) тодорхойлдог. Уг индекс (GCI) нь дэлхийн улс орнуудын кибер аюулгүй байдлын түвшинг тодорхойлсон итгэмжлэгдсэн лавлагаа болдог байна.<sup>316</sup>

Кибер аюулгүй байдал нь олон салбарын огтолцлолд оршдог тул улс орнуудын кибер аюулгүй байдлын хөгжлийн түвшинг дараах 5 тулгуур шалгуураар үнэлдэг байна.

- Хууль, эрх зүйн орчин (Legislative environment)
- Техникийн арга хэмжээ (Technical Measures)
- Байгууллагын арга хэмжээ (Organization Measures)
- Чадавх хөгжүүлэх арга хэмжээ (Capacity Building Measures)
- Хамтын ажиллагааны орчин (Cooperation Measures)

Эдгээр шалгуур тус бүрт тухайн орны кибер аюулгүй байдлын түвшинг үнэлэх дараах тодорхой үзүүлэлтүүд багтдаг байна. Үүнд:<sup>317</sup>

#### **Хууль эрх зүйн орчин**

- Кибер аюулгүй байдлын тухай хууль
- Кибер аюулгүй байдлыг зохицуулах арга хэмжээ
- Спам, халдлагыг хязгаарлах хууль эрх зүй

#### **Техникийн арга хэмжээ**

- CIRT-(Computer Incident Response Team) Компьютерын гэмтлийн хариу арга хэмжээний баг
- CERT-(Computer Emergency Response Team) Компьютерийн түргэн тусламжийн баг
- CSIRT-(Computer Security Incident Response Team) Компьютерийн аюулгүй байдлыг хангах хариу арга хэмжээний баг

<sup>315</sup> <https://www.iso.org/standard/44375.html>

<sup>316</sup> <https://www.itu.int/en/ITU-D/Cybersecurity/Pages/global-cybersecurity-index.aspx>

<sup>317</sup> <https://www.secureworldexpo.com/industry-news/countries-dedicated-to-cybersecurity>



- Стандарт хэрэгжүүлэх стратеги
- Стандартчиллын байгууллага
- Спам халдлагыг арилгахад чиглэсэн техникийн механизм, чадавх
- Кибер аюулгүй байдлын зорилгод үүлэн технологи ашиглах
- Хүүхэд багачуудыг онлайнаар хамгаалах механизм

#### **Байгууллагын арга хэмжээ**

- Үндэсний кибер аюулгүй байдлын стратеги
- Кибер аюулгүй байдлын агентлаг
- Кибер аюулгүй байдлын хэмжигдэхүүн (Cybersecurity metrics)

#### **Чадавх бэхжүүлэх**

- Олон нийтийг мэдээллээр хангах
- Кибер аюулгүй байдлын мэргэжилтнийг гэрчилгээжүүлэх, магадлан итгэмжлэх тогтолцоо
- Кибер аюулгүй байдлын талаар мэргэжилтэн бэлтгэх
- Кибер аюулгүй байдлын боловсролын тухай мэргэжлийн багшийн сургалт
- Кибер аюулгүй байдлын эрдэм шинжилгээ, судалгааны хөтөлбөр (цахим дэд бүтцийг хамгаалах хөтөлбөр)
- Урамшууллын механизм

#### **Хамтын ажиллагаа**

- Хоёр тал хүлээн зөвшөөрсөн байх
- Олон тал хүлээн зөвшөөрсөн байх
- Олон улсын оролцогч талуудтай байх
- Олон нийтийн болон хувийн хэвшлийн оролцогч талудтай байх
- Хамтрагч агентлагуудтай байх
- Сайн туршлага, үйл ажиллагаатай байх

Олон улсын харилцаа холбооны байгууллагын дээрх 5 шалгуур үзүүлэлтээр үнэлж, индексийг тодорхойлсноор тухайн улс кибер халдлагаас урьдчилан сэргийлэх чадамжтай эсэхийг тодорхойлох ба бодлогын түвшинд дээрх шалгууруудыг тогтоохыг зөвлөмж болгодог байна.

#### **КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШАЛГУУР ХАНГАСАН ШИЛДЭГ 10 УЛС**

Олон улсын харилцаа холбооны байгууллага (ITU)-аас гаргасан судалгаагаар цахим аюулгүй байдлын 5 шалгуурыг хангасан цахим халдлагаас урьдчилан сэргийлэх чадавх өндөр улсуудын индекс<sup>318</sup> ( $0 \leq N \leq 1$ ):

Улс	Индекс GCI score	Хууль Legal	Техник Technical	Байгууллага Organizaional	Чадавх Capacity building	Хамтын ажиллагаа Cooperation
Singapore	0.92	0.95	0.96	0.88	0.97	0.87
USA	0.91	1	0.96	0.92	1	0.73
Malaysia	0.89	0.87	0.96	0.77	1	0.87
Oman	0.87	0.98	0.82	0.85	0.95	0.75

<sup>318</sup> <https://www.cyberdb.co/top-10-countries-best-prepared-cyber-attacks/>

Estonia	0.84	0.99	0.82	0.85	0.94	0.64
Mauritius	0.82	0.85	0.96	0.74	0.91	0.70
Australia	0.82	0.94	0.96	0.86	0.94	0.44
Georgia	0.81	0.91	0.77	0.82	0.90	0.70
France	0.81	0.94	0.96	0.60	1	0.61
Canada	0.81	0.94	0.93	0.71	0.82	0.70

(Эх сурвалж: International Telecommunication Union 2017)

CyberDB судалгааны платформ нь<sup>319</sup> дэлхий даяар цахим салбарын шинэ технологи шийдлүүдийн талаар мэдээлэл судалгаа, дүн шинжилгээ хийдэг ба уг байгууллагаас кибер аюулгүй байдлаар дээрх жагсаалтад ороогүй орнууд болон тэргүүлэгч улсуудыг дараах байдлаар тодруулсан байна.

**Америк:** Жил бүр асар их хэмжээний кибер халдлагад өртөж буй орнуудын нэг бол Америкийн Нэгдсэн Улс юм. Тийм ч учраас кибер аюулгүй байдлын компаниудын 58 орчим хувь нь Америкт байрладаг бөгөөд кибер халдлагатай тэмцэх шинэ арга замуудыг судалсаар байна.<sup>320</sup>

**Израиль:** Кибер аюулгүй байдлын тогтолцоо сайтай улс<sup>321</sup> бөгөөд кибер аюулгүй байдлын чиглэлээр олон шинэ стартап компаниуд үүсч их хэмжээний санхүүжилт татаж байна.<sup>322</sup>

**Орос:** ОХУ-ыг цахим тагнуул, улс төрийн цахим халдлагад ихээхэн буруутгадаг ба цахим халдлагаас өөрсдийгөө маш сайн хамгаалах чадавх, боловсон хүчин, технологитой байна.

**Хятад:** 2017 онд Хятад улс Кибер аюулгүй байдлын тухай шинэ хууль баталж, кибер аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлаа хамгаалахыг зорилго тавьсан юм.

**Эстони:** Цахим засаглалаараа (e-governance) дэлхийд танигдсан бөгөөд 2007 оноос эхлэн цахим халдлагатай үр дүнтэй тэмцэж кибер аюулгүй байдлын сайн туршлагатай орнуудад тооцогддог.

### ЦАХИМ ХАЛДЛАГАД ХАМГИЙН ИХ ӨРТДӨГ УЛСУУД

Symantec (Security research firm) судалгааны байгууллагаас цахим халдлагад хамгийн их өртдөг улсуудыг тодорхойлсон байна. Ингэхдээ дараах 6 түгээмэл халдлагыг шалгуур үзүүлэлт болгон дүн шинжилгээ хийсэн байна.<sup>323</sup>

1. Компьютерийн халдлага (Malicious computer activity)
2. Хортой кодоор халдах (Malicious code)
3. Спам (Spam zombies)
4. Өгөөш хаях замаар халдах (Phishing web site hosts)
5. Бот ашиглах (Bot)
6. Эх үүсвэрт шууд халдах (Attack origin rank)


<sup>319</sup> <https://www.cyberdb.co>

<sup>320</sup> <https://cyberdb1.wpengine.com/database/usa/>

<sup>321</sup> <https://www.cyberdb.co/top-10-countries-best-prepared-cyber-attacks/>

<sup>322</sup> <https://cyberdb1.wpengine.com/database/israel/>

<sup>323</sup> <https://www.broadcom.com/products/cyber-security>



### BSA: ОЛОН УЛСЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сүүлийн жилүүдэд кибер аюулгүй байдлыг хангасан бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэхээр дэлхийн бүх засгийн газрууд хичээн ажиллаж байна. Жил бүр кибер гэмт хэрэг дэлхийн эдийн засгаас хэдэн зуун тэрбум долларыг залилж, бизнесийн үйлчилгээг тасалдуулж, инновацийг саатуулж, ажлын байрны өсөлтийг царцааж байна<sup>324</sup>. Дэлхийн Засгийн газрууд эдгээр аюулыг үр дүнтэй даван туулах нь кибер аюулгүй байдлын талаарх тэнцвэртэй, цогц ухаалаг, үр дүнтэй бодлого боловсруулахаас хамаарна хэмээн үзэж байна.

BSA | Програм хангамжийн холбоо ([www.bsa.org](http://www.bsa.org)) нь дэлхийн засгийн газрууд болон олон улсын зах зээл дээрх програм хангамжийн компаниудыг нэгтгэсэн олон улсын байгууллага юм. Уг байгууллага нь АНУ-ын Вашингтон хотод төвтэй бөгөөд дэлхийн 60 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг ба BSA нь хууль ёсны програм хангамжийг сурталчлах, технологийн шинэчлэлийг дэмжиж төрийн бодлогыг сурталчлах, олон улсын кибер аюулгүй байдлын бодлогын хүрээнд цахим аюулгүй байдлын цогц шийдлүүдийг санал болгодог байна.

BSA-гийн гаргасан бодлогын хүрээнд (Policy framework) засгийн газраас кибер аюулгүй байдлын бодлого явуулахдаа дараах үндсэн 6 зарчимд тулгуурлахыг зөвлөж байна.

- Бодлогыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн техникийн стандартад нийцүүлэх;
- Бодлого нь эрсдэлд суурилсан, үр дүнд чиглэсэн, төвийг сахисан технологитой байх;
- Бодлого нь зах зээлийн механизмд суурилах;
- Бодлого нь инновацийг дэмжих уян хатан, дасан зохицох чадвартай байх;
- Төр, хувийн хэвшлийн хосолсон хамтын ажиллагаанд суурилах;
- Бодлого нь хувийн нууцыг хамгаалахад чиглэсэн байх.

<sup>324</sup> BSA International Cybersecurity Policy Framework 2018

## **BSA: ҮНДЭСНИЙ КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДСЭН ЭЛЕМЕНТУҮД:**

### **ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ**

- Кибер аюулгүй байдлын асуудал эрхэлсэн үндэсний байгууллагатай байх;
- Оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;
- Байгууллага хоорондын уялдааг бий болгох;
- Үндэсний кибер аюулгүй байдлын стратеги боловсруулах;
- Кибер аюулгүй байдлын дэд бүтцийг бий болгох;
- Үндэсний кибер аюулгүй байдлын төлөвлөгөө, дэд бүтцийг байнга шинэчлэх;
- Салбарын нарийн төлөвлөгөө гаргах;
- Төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа оролцоог дэмжсэн бүтэц бий болгох;
- Засгийн газар болон холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааны механизмыг бий болгох.

### **КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЗАСГИЙН ГАЗАР**

- Үндэсний кибер аюулгүй байдлын яаралтай хариу арга хэмжээний баг бий болгох;
- Цаг тухайд мэдээлэл солилцох, түүнийг дэмжих;
- Халдлагын талаарх мэдээллийн дэд бүтэц бий болгох;
- Хувийн мэдээлэлд халдахад мэдэгдэх стандартыг тогтоох;
- Засгийн газрын үйл ажиллагаа ил тод, сул талуудаа засдаг байх.

### **ЗАСГИЙН ГАЗРЫН ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ**

- Техник төхөөрөмж худалдан авахдаа төвийг сахих;
- Лицензтэй програм хангамж ашиглах;
- Програм хангамжийг борлуулагчаар баталгаажуулсан эсэхийг шалгах;
- Үүлэн үйлчилгээний (Cloud service) аюулгүй байдлын давуу талыг ашиглах;
- Техник, төхөөрөмж худалдан авахдаа аюулгүй байдлыг хангах, шалгах;
- Мэдээллийн технологийн системийг ухаалаг, аюулгүй байдлаар удирдах.

### **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА**


- Кибер аюулгүй байдлын технологи, төхөөрөмж хэрэгслийн судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих.

### **КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХУВИЙН ХЭВШИЛ**

- Кибер аюулгүй байдлын үр дүнд төвлөрөх;
- Эрсдэлд суурилсан, уян хатан бодлоготой байх;
- Дотоодын стандартаас гадна кибер аюулгүй байдлын дэд бүтцийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарттай уялдуулах;
- Тэнцвэртэй, ил тод, олон улсын туршлагад суурилсан байх;
- Эх код, бусад оюуны өмчийг нууцлах;
- Бүтээгдэхүүн сонгохдоо зах зээлд суурилсан шийдлүүдийг ашиглах;
- Олон улсын дата ашиглах;
- Шинээр гарч ирж буй технологийг идэвхжүүлэх бодлогын орчинтой байх;

### **КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ИРГЭН**

- Кибер аюулгүй байдлын талаар олон нийтэд сурталчлах;



- Хэрэглэгчийн сонголтыг бүртгэх, мэдээлэх хэрэгсэл бий болгох;
- Боловсролын бүх түвшинд цахим аюулгүй байдлын мэдлэгийг суулгах;
- Кибер аюулгүй байдлын талаар боловсрол олгох сургалт зохион байгуулах;
- Кибер аюулгүй байдлын мэргэжилтнүүдийг олон талаар дэмжих.

#### КИБЕР ГЭМТ ХЭРЭГ

- Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай Будапешт конвенцид нийцсэн цогц хууль эрх зүйн орчинг бий болгох;
- Зөвхөн кибер халдлагад чиглэсэн тусгайлсан хууль эрх зүйн зохицуулалттай байх;
- Хууль сахиулах, хэрэгжүүлэгч байгууллагуудад техникийн сургалт, дэмжлэг үзүүлэх.

#### ОЛОН УЛСЫН ОРОЛЦОО

1. Кибер аюулгүй байдлын хамтын ажиллагааны гадаад бодлогод нэгдэх;
2. Олон улсын хамтын ажиллагаанд хамрагдах;
3. Экспортын хяналтын бодлогыг кибер аюулгүй байдлын хууль ёсны үйл ажиллагаанаас тусад нь авч үзэх;
4. Өөрийн орны нутаг дэвсгэрийг олон улсын кибер халдлагад ашиглахаас урьдчилан сэргийлэх;
5. Хувийн мэдээллийг хамгаалах, хүний эрхийг хамгаалах.

#### КИБЕР ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ БУДАПЕШТИЙН КОНВЕНЦ

Будапештийн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенц нь 2001 оны 11 сарын 23-нд батлагдаж 2004 оны 7-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Өнөөдрийг 7-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. 4 улс гарын үсэг зурж, нэгдсэн байна.<sup>325</sup> Гишүүн бус улсууд гарын үсэг зурж нэгдэхэд нээлттэй гэрээ юм.<sup>326</sup> Энэхүү конвенц нь Интернет болон бусад компьютерийн сүлжээгээр дамжуулан үйлдэгдсэн зөрчил, ялангуяа зохиогчийн эрх, компьютертай холбоотой залилан, хүүхдийн садар самуун, сүлжээний аюулгүй байдлыг зөрчсөн гэмт хэргийн тухай олон улсын анхны гэрээ юм. Энэхүү конвенц нь компьютерийн сүлжээг ашиглан үйлдэгдсэн олон төрлийн зөрчил, гэмт хэргийг зогсоох зорилготой. Түүнчлэн нийгмийг кибер гэмт хэргээс хамгаалахад чиглэсэн нийтлэг хууль эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх, ялангуяа зохих хууль тогтоомжийг баталж, олон улсын хамтын ажиллагааг дэмжихэд чиглэсэн байна. Уг конвенцийн 2 бүлгийн 1-10 дугаар заалтад голлох 4 төрлийн халдлага зөрчлийг тусгасан байна.<sup>327</sup>

- Компьютерийн мэдээллийн системийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Компьютертай холбоотой гэмт хэрэг, тухайлбал залилан, хуурамч баримт бичиг үйлдэх;
- Агуулгатай холбоотой зөрчил-хүүхдийн садар самуун бүхий агуулга гэх мэт;

<sup>325</sup> 2020 оны байлдлаар <https://www.crossborderdataforum.org/budapest-convention-what-is-it-and-how-is-it-being-updated/>

<sup>326</sup> <https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/185>

<sup>327</sup> <https://statesassembly.gov.je/scrutinyreviewresearches/2018/research%20-%20briefing%20paper%20on%20council%20of%20europe%20convention%20on%20cybercrime%20-%2031%20october%202018.pdf>

- Зохиогчийн эрхийн зөрчил.

Будапештийн конвенц нь цахим гэмт хэрэгтэй холбоотой хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчинг бүрдүүлэхээс гадна олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг үндэслэсэн хууль эрх зүйн баримт бичиг юм.<sup>328</sup>

Уг конвенцид нэгдэн орсноор тухайн улс конвенцийг дотоодын хууль тогтоомжийн чиглэл болгон ашиглаж болох ба дараах давуу тулууд үүснэ.

- Олон улсын хамтын ажиллагааны хууль эрх зүйн үндэс суурь болно.
- Нэгдэн орсон талууд цаашид конвенцийн хөгжилд нэмэлт санал, протокол оруулж болно.
- Конвенцид гишүүнээр орсон орнууд энэхүү гэрээний дагуу байгуулагдсан цэгүүдэд 24 цаг холбоотой байна.
- Талууд хувийн хэвшилтэй хамтын ажиллагаагаа сайжруулж туршлагажих боломжтой.
- Оролцогч талууд өөрийн хүсэлтээр тэргүүлэгч, чадавхыг бэхжүүлэх төв болж болно.

Будапештийн конвенцитай уялдуулан дотоодын хууль тогтоомжийг бий болгосноор олон улсын цахим гэмт хэрэгтэй тэмцэх шалгуурыг хангах нөхцөл бүрдэх юм. Энэхүү конвенц нь олон улсын хамтын ажиллагааг сайжруулах бөгөөд давхар хууль эрх зүйн шаардлагыг хангахад тусалдаг. Конвенцийн дотоод процедурын зарим эрх мэдэл нь олон улсын хамтын ажиллагааны бүлэгт тусгагдсан байдаг. (Хавсралт 2)



---

<sup>328</sup> <https://rm.coe.int/t-cy-2020-16-bc-benefits-rep-provisional/16809ef6ac#:~:text=The%20Budapest%20Convention%20requires%20States,cybercrime%20but%20any%20offence%20where>



### **БҮЛЭГ III. МОНГОЛ УЛС ДАХЬ КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

Монгол Улсын төр, засгаас харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх нь улс орны аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой гэдгийг онцгойлон анхаарч 1922 оноос эхлэн Дотоодыг хамгаалах газрын бүтцэд шуудан, телефон, радио, цифр холбооны нэгжийг байгуулж ирсэн нь Мэдээллийн аюулгүй байдлын газрын эх суурь болсон түүхтэй.

Техник технологи хурдтай хөгжиж буй өнөөгийн нийгэмд мэдээллийн аюулгүй байдал хурцаар тавигдаж байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Тагнуулын байгууллагын тухай хуулийн 11.1.6, Харилцаа холбооны тухай хуулийн 20.3-т төрийн байгууллагуудыг кибер халдлагаас хамгаалах тогтолцоог бүрдүүлэхийг заасан бөгөөд энэ чиг үүргийг Мэдээллийн аюулгүй байдлын газар хэрэгжүүлэн ажиллаж байна<sup>329</sup>.

Тус байгууллага нь төрийн мэдээлэл, харилцаа холбооны аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд:

1. Төрийн болон онц чухал мэдээллийн сүлжээ, харилцаа холбооны аюулгүй байдлыг хангах, цахим аюул, заналтай тэмцэх;
2. Кибер аюулгүй байдлын талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах;
3. Төрийн байгууллагуудад кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэлийн үнэлгээ хийх;
4. Кибер аюулгүй байдлын талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах;
5. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хэрэгцээнд ашиглагдах тусгай хэрэглээний шуудангийн үйлчилгээ үзүүлэх;
6. Төрийн болон төрийн захиргааны байгууллагуудын хооронд төрийн нууц мэдээ, мэдээлэл дамжуулах, солилцох үеийн нууцлал аюулгүй байдлыг хангах гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

#### **МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалд мэдээллийн аюулгүй байдлын талаар баримтлах бодлогыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

##### **3.6.Мэдээллийн аюулгүй байдал**

Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн.

##### **3.6.1.Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах.**

3.6.1.1.Үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орны хөгжлийг дэмжих, үндэсний үнэт зүйлийг хэвшүүлэх, нийгмийн оюун санааг төлөвшүүлэхэд мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдал нэн чухал ач холбогдолтой.

3.6.1.2.Нийгмийн сэтгэл зүй, тогтвортой байдал, хувь хүний ухамсар, ёс зүйд хөндлөнгөөс нөлөөлөх оролдлогыг хязгаарлана. Дайсагнал, ялгаварлан гадуурхах үзэл, үзэн ядалтыг сурталчилсан, дэмжсэн сурталчилгаа, мэдээллийг таслан зогсоох, саармагжуулах чадавхыг бий болгож, үл зөвшөөрөх сэтгэхүйг нийгэмд төлөвшүүлнэ.

<sup>329</sup> <http://isd.gov.mn/>

3.6.1.3. Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах аюулаас хамгаалах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах оролдлоготой тэмцэх чадавхыг бий болгоно.

3.6.1.4. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай хэвлэл мэдээллийн хэрэгсэл үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулбал үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарлаж болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна. Мэдээллийн хэрэгслээр үндэсний үнэт зүйлийг түлхүү нийтлэх, сурталчлахыг дэмжиж, гадны шашин, соёл, төрийн бодлогыг сурталчилсан агуулгатай мэдээллийг зохистой түвшинд хязгаарлана.

3.6.1.5. Мэдээллийн аюулгүй байдлын үндэсний хэмжээний бодлого, эрх зүйн зохицуулалт, стандарт, удирдлага, зохион байгуулалт, сургалтын тогтолцоог бий болгож нийгэм дэх ойлголт, мэдлэгийг төлөвшүүлнэ.

3.6.1.7. Төр, хувийн хэвшлийн байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дэг, эрсдэлийн удирдлага, дотоод аудит, үнэлгээний чадавхыг бий болгоно.

3.6.1.8. Мэдээллийн аюулгүй байдлын орчин үеийн дэвшилтэт, өртөг багатай шийдлийг зөвхөн эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр сонгон ашиглана. Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг өндөр түвшинд бэлтгэгдэж, итгэмжлэгдсэн үндэсний мэргэжилтнээр гүйцэтгүүлнэ.

3.6.1.9. Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулна.

3.6.1.10. Мэдээлэл, харилцаа холбооны технологи, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр үндэсний суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, сургалтыг онцгойлон дэмжинэ.

3.6.1.11. Кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх, аливаа гэмт хэргийг илрүүлэх, нотлоход тооцоолох хэрэгслийн криминалистик техникийн шинжилгээ ашиглах үндэсний чадавхыг бий болгоно.

3.6.1.12. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн орчинд сэргөлдөх аюулаас сэргийлэх, кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх чиглэлд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

## **ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ**

### **11 дүгээр зүйл. Тагнуулын ерөнхий газрын үүрэг**

11.1. Тагнуулын ерөнхий газар дараах үүрэг гүйцэтгэнэ:

11.1.6. Төрийн болон онц чухал мэдээллийн сүлжээ, харилцаа холбооны аюулгүй байдлыг хангах, цахим аюул, заналтай тэмцэх; */Энэ заалтад 2011 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

## **ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬ**

### **20 дугаар зүйл. Тусгай хэрэглээний холбооны сүлжээ**

20.1.Монгол Улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, гамшгаас хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хэрэгцээнд зориулан тусгай хэрэглээний холбооны сүлжээг байгуулан ажиллуулж болно. /Энэ хэсэгт 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

20.2.Тусгай хэрэглээний холбооны сүлжээ төрийн хамгаалалтад байна.

20.3.Тусгай хэрэглээний холбооны сүлжээ байгуулах, ашиглах журмыг Засгийн газар тогтооно.

20.4.Тусгай хэрэглээний холбооны сүлжээнд цахилгаан холбооны суваг, тоног төхөөрөмжийг үйлчлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ашиглана.

20.5.Харилцаа холбооны сүлжээгээр дамжуулах тусгай хэрэглээний холбооны мэдээллийн нууцлалт, хамгаалалтыг энэ хуулийн 20.1-д заасан байгууллага хариуцна

## БҮЛЭГ IV. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

### БНСУ

БНСУ 1980 оноос эхлэн үндэсний мэдээллийн аюулгүй байдал болон нийгмийн сүлжээн дэх асуудлуудыг зохицуулах хууль боловсруулж эхэлсэн ба 1986 онд Харилцаа холбооны сүлжээг сайжруулах тухай хууль (Expansion and promotion of utilization of communications network act) анх баталж байжээ<sup>330</sup>. Одоогоор кибер аюулгүй байдалтай холбоотой асуудлыг хэд хэдэн хуулиар зохицуулж байна. Тухайлбал<sup>331</sup>:

- Сүлжээний тухай хууль (Network act),
- Харилцаа холбооны нууцыг хамгаалах тухай хууль (Protection of communication secret act),
- Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хамгаалах тухай (The act on protection of information and communication infrastructure),
- Цахим засаглалын тухай хууль (Electronic government act),
- Үндэсний батлан хамгаалахын мэдээллийн дэд бүтцийг бий болгох, мэдээллийн нөөцийг удирдах тухай хууль (Act on Establishment of infrastructure for information of national defence and management of information resources for national defence),
- Зээлийн мэдээллийн ашиглалт, хамгаалалтын тухай хууль (Credit information use and protection act),
- Байршлын мэдээллийг хамгаалах тухай хууль (Act on protection use of location information),
- Үйлдвэрлэлийн технологийг хамгаалах тухай хууль (Act on Prevention of Divulgence and protection of industrial technology),
- Цахилгаан холбооны бизнесийн болон санхүүгийн луйврын тухай хууль (Telecommunication business act and special act on financial fraud) зэрэг хуулиуд багтдаг байна.

Үндэсний хэмжээнд кибер халдлагаас сэргийлэх зорилгоор “Кибер аюулгүй байдлын менежментийн зохицуулалтын (National cyber security management regulation) журам”-ыг Үндэсний Ассамблей баталсан байна. Уг журмаар Засгийн газрын байгууллагуудын

<sup>330</sup> Introduction to Korean cyber security Law

<sup>331</sup> <https://iclg.com/practice-areas/cybersecurity-laws-and-regulations/korea>

(Үндэсний тагнуулын албаны Үндэсний аюулгүй байдлын төв, Хөх ордон дахь үндэсний аюулгүй байдлын алба) эрх үүрэг, оролцоог тодорхойлсон байна<sup>332</sup>. Кибер халдлагаас хамгаалах мэдээллийн дэд бүтцийн тухай хууль нь үндэсний аюулгүй байдалтай шууд холбогддог ба нийгэмд өдөр бүр тулгардаг эрчим хүч, эрүүл мэнд, банк санхүүгийн цахим үйл ажиллагааг уг хуулиар зохицуулдаг байна. Солонгосын Засгийн газар 2002 онд Мэдээллийн дэд бүтцийг хамгаалах тухай хуулийг (Protecting critical information infrastrucutre act) баталсан байна. Уг хууль нь дараах бүтэцтэй байна.

## **МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ДЭД БҮТЦИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

(The Act On Protection Of Information And Communication Infrastructure)

1 дүгээр зүйл. Зорилго

Энэхүү хуулийн зорилго нь харилцаа холбооны нууц, нууцыг хамгаалах, харилцаа холбооны эрх чөлөөг тогтоох, зохих журмын дагуу шийдвэр гаргах замаар харилцаа холбооны эрх чөлөөг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Нэр томъёоны тайлбар

3 дугаар зүйл. Харилцаа холбооны нууцыг хамгаалах

4 дүгээр зүйл. Хууль бус хяналт шалгалтаар олж авсан мэдээлэл хууль бусаар чагнах, цахилгаан холбооны агуулгыг нотлох баримт болгон ашиглахыг хориглох тухай

5 дугаар зүйл. Эрүүгийн байцаалтын мэдээллийг хязгаарлах зөвшөөрлийн шаадлага

6 дугаар зүйл. Эрүүгийн байцаалтын мэдээллийг хязгаарлах зөвшөөрлийн арга хэмжээ авах эрх олгох журам

7 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдалд нийцүүлэн харилцаа холбооны хяналт

8 дугаар зүйл. Онцгой байдлын үеийн харилцаа холбоог хязгаарлах арга хэмжээ

9 дүгээр зүйл. Харилцаа холбоонд хяналт тавих арга хэмжээний хэрэгжилт

10 дугаар зүйл. Чагнах төхөөрөмжийн зөвшөөрөл олгох журам

11 дүгээр зүйл. Нууцлалын үүрэг

12 дугаар зүйл. Харилцаа холбооны арга хэмжээгээр олж авсан материалыг ашиглахыг хязгаарлах тухай

13 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаанд мэдээлэл өгөх журам

14 дүгээр зүйл. Бусдын нууцыг задруулах, зөрчих тухай

15 дугаар зүйл. Үндэсний ассамблейн хяналт

16 дугаар зүйл. Торгуулийн заалт

17 дугаар зүйл. Торгууль оногдуулах тухай

18 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхийг завдах тухай



## **МАЛАЙЗ УЛС**

Малайз улс кибер аюулгүй байдалтай холбоотой дараах цогц хуулиудыг баталсан байна. Үүнд:

- Зохиогчийн эрхийн тухай хууль (The Copyright (Amendment) Act),
- Тоон гарын үсгийн тухай хууль (The Digital Signature Act),
- Телемедициний тухай хууль (The Telemedicine Act),
- Харилцаа холбоо ба мультимедиа тухай хууль (The Communications and Multimedia Act),

<sup>332</sup> Ibid Page 28

- Цахим худалдааны тухай хууль ( Electronic Commerce Act),
- Төрийн цахим үйл ажиллагааны тухай хууль (Electronic Government Activities Act),
- Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (Personal Data Protection Act), Эрүүгийн хууль (Penal Code),
- Хуурамч мэдээллийн эсрэг хууль (The Anti-Fake News Act) гэх мэт

Малайз улс 1997 онд Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг (The Computer Crimes Act) баталсан ба 2011 оны 12-р сарын 1-нд дахин шинэчилсэн байна. Уг хуулиар зохицуулж буй харилцаа:<sup>333</sup>

## КОМПЬЮТЕРИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ, 1997 ("ССА")

Бүлэг 1.

1. Энэ хууль нь 1997 онд батлагдсан Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулиас эшэлсэн болно. Энэхүү хууль нь Ерөнхий сайдыг томилсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно
2. Нэр томъёоны тайлбар

Бүлэг 2.

### **Компьютерийн мэдээлэл рүү зөвшөөрөлгүй нэвтрэх**

Тухайн компьютер болон компьютерийн мэдээлэл (дата)-нд зөвшөөрөлгүй, санаатайгаар нэвтрэх

Энэ хэсэгт заасны дагуу гэм буруутай гэж үзвэл 50 мянган ринггитээс ихгүй торгууль ногдуулах буюу таван жилээс дээшгүй хугацаагаар хорих шийтгэл ногдуулна.

### **Үйл ажиллагаанд нэвтрэх эрхгүйгээр халдах**

Эрүүгийн хуулийн 573-р зүйлд зааснаар залилан мэхлэх, хохирол учруулах гэмт хэргийн үйлдэл,

### **Өөрөө болон бусад хүнээр халдлага үйлдэх,**

Энэ хэсэгт заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд 150 мянган ринггитээс ихгүй хэмжээний торгууль ногдуулах, эсхүл арван жилээс дээшгүй хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

### **Аливаа компьютерын өгөгдөл агуулгыг зөвшөөрөлгүй өөрчлөх**

Аливаа компьютерийн агуулгыг зөвшөөрөлгүй өөрчлөх үйлдэл хийсэн тохиолдолд гэм буруутайд тооцно.

Энэ хэсэгт заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн гэж үзвэл 100-500 мянган ринггитээс дээшгүй торгууль ногдуулах, эсхүл долоогоос арван жилийн хорих ялаар шийтгэнэ.

### **Зөвшөөрөлгүй харилцах**

-Компьютерт нэвтрэх дугаар, код, нууц үг эсвэл бусад хэрэгслийг шууд болон дам байдлаар мэдэгдсэн тохиолдолд гэм буруутай гэж үзнэ. Энэ хэсэгт заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 25 мянган ринггитээс дээшгүй торгууль ногдуулах, эсхүл гурван жил хорих ялаар шийтгэнэ.

### **Гэм буруутанд шийтгэл оногдуулах**

Энэхүү хуулийн дагуу гэмт хэрэг үйлдэхийг завдсан эсвэл үйлдсэн тохиолдолд гэм буруутай ба шийтгэлийг оногдуулна.

<sup>333</sup> <https://cyrilla.org/ar/entity/xqej2atn2lh?file=1568729651356shamgdeopv.pdf&page=5>

Аливаа компьютерт хадгалагдаж байгаа, програм өгөгдөл эсвэл бусад мэдээллийг хууль бусаар зөвшөөрөлгүй нэвтрэх,

### Бүлэг 3.

Нэмэлт болон ерөнхий заалтууд<sup>334</sup>

#### **Халдлагын цар хүрээ**

Энэхүү хуулийн заалтад гэмт этгээдийн иргэншил болон оршин байгаа харьяаллаас үл хамааран Малайзын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд энэ хуулийн дагуу гэмт хэрэг үйлдсэн этгээдийг Малайзын Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх хуулийн дагуу шийтгэдэг байна.

#### **Эрэн сурвалжлах, хураах, баривчлах бүрэн эрх**

Энэ хуульд заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн болохыг нотлох баримтанд үндэслэх эсвэл шүүгчийн шийдвэр гарвал, байцаагчаас дээш цолтой (above the rank of Inspector) албан хаагч гэмт хэргийн газар хүчээр нэвтрэх, шаардлагатай бол саатуулах, тэнд байгаа нотлох баримтыг хайх, хураах эрхтэй байдаг байна.

#### **Мөрдлөгт саад учруулах**

Уг хуульд заасны дагуу албан хаагчийн, эрх үүргийн дагуу мөрдлөг хийх явцад халдах, саад учруулах, байцаалтыг хойшлуулахыг хориглодог байна.

#### **Яллах**

Уг хуулийн дагуу яллах ажиллагааг Улсын яллагчийн албан ёсны шийдвэрээр яллахаас бусад тохиолдолд яллахгүй.



---

<sup>334</sup> <https://www.nacsa.gov.my/legal.php>



## ХАВСРАЛТ

### Хавсралт 1. Олон улсын кибер аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд<sup>335</sup>

Байгууллагын нэр	Холбоос	Хамрах хүрээ
United Nations Internet Governance Forum	<a href="https://www.intgovforum.org/multilingual/">https://www.intgovforum.org/multilingual/</a>	Global
United States National Cyber security and Communications Integration Center (NCCIC)	<a href="https://www.cisa.gov/about-cisa">https://www.cisa.gov/about-cisa</a>	National, Global
Messaging and Anti Abuse Working Group (MAAWG)	<a href="http://www.maawg.org">www.maawg.org</a>	Global
Anti-Abuse Working Group	<a href="http://www.ripe.net">www.ripe.net</a>	Global
Forum for Incident Response Security Teams (FIRST)	<a href="http://www.firest.org">www.firest.org</a>	Global
Asia Pacific Computer Emergency Response Team (AP CERT)	<a href="http://www.apcert.org">www.apcert.org</a>	Regional
Network Operators Groups (NOGs)	<a href="https://en.wikipedia.org/wiki/Internet_network_operators%27_group">https://en.wikipedia.org/wiki/Internet_network_operators%27_group</a>	Global
Asia Pacific Economic Cooperation (APEC)	<a href="http://www.apec.org">www.apec.org</a>	Regional
ICANN Security and Stability Working Group	<a href="http://www.icann.org">www.icann.org</a>	Global
Cooperative Cyber Defense and Center of Excellence (CCDCOE)	<a href="http://www.ccdcoe.org">www.ccdcoe.org</a>	Regional, Global
Council of Europe; Convention on Cybercrime	<a href="http://www.conventions.coe.int">www.conventions.coe.int</a>	Global
INTERPOL	<a href="http://Interpolnyc.com">Interpolnyc.com</a>	Global
Internet Society (ISOC)	<a href="http://www.internetsociety.org">www.internetsociety.org</a>	Global

UIH.MN  
СҮДАЛГААНЫ САН

<sup>335</sup> <https://www.itic.org/dotAsset/c/c/cc91d83a-e8a9-40ac-8d75-0f544ba41a71.pdf>

## Хавсралт 2. Будапештийн конвенцид нэгдсэн орнууд<sup>336</sup>

(2020 оны 6 сарын байдлаар)

Конвенцид нэгдэн орсон улсууд	
Andorra	Latvia
Argentina	Liechtenstein
Armenia	Lithuania
Australia	Luxembourg
Austria	Malta
Azerbaijan	Mauritius
Belgium	Republic of Moldova
Bosnia and Herzegovina	Monaco
Bulgaria	Montenegro
Cabo Verde	Morocco
Canada	Netherlands
Chile	North Macedonia
Colombia	Norway
Costa Rica	Panama
Croatia	Paraguay
Cyprus	Peru
Czech Republic	Philippines
Denmark	Poland
Dominican Republic	Portugal
Estonia	Romania
Finland	San Marino
France	Senegal
Georgia	Serbia Slovak
Germany	Republic Slovenia
Ghana	Spain
Greece	Sri Lanka
Hungary	Switzerland
Iceland	Tonga
Israel	Turkey
Italy	Ukraine
Japan	United Kingdom
	United States of America

<sup>336</sup> <https://rm.coe.int/t-cy-2020-16-bc-benefits-rep-provisional/16809ef6ac#:~:text=The%20Budapest%20Convention%20requires%20States,cybercrime%20but%20any%20offence%20where>

**Хавсралт 3. Будапештийн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенцийн бүтэц**

<b>Бие даасан хууль</b>	<b>Нотлох баримт, мөрдөн байцаахтай холбоотой процедурын хууль</b>	<b>Олон улсын хамтын ажиллагаа</b>
Art. 2 – Illegal access Art. 3 – Illegal interception Art. 4 – Data interference Art. 5 – System interference Art. 6 – Misuse of devices Art. 7 – Computer-related forgery Art. 8 – Computer-related fraud Art. 9 – Child pornography Art. 10 – IPR offences Art. 11 – Attempt, aiding, abetting Art. 12 – Corporate liability	Art. 14 – Scope of procedural provisions Art. 15 – Conditions and safeguards Art. 16 – Expedited preservation Art. 17 – Expedited preservation and partial disclosure of traffic data Art. 18 – Production order Art. 19 – Search and seizure Art. 20 – Real-time collection traffic data Art. 21 – Interception of content data	Art. 23 – General principles Art. 24 – Extradition Art. 25 – General rules Art. 26 – Spontaneous information Art. 27 – MLA in absence of treaty Art. 28 – Confidentiality Art. 29 – Expedited preservation Art. 30 – Partial disclosure traffic data Art. 31 – MLA accessing data Art. 32 – Transborder access Art. 33 – MLA collection traffic data Art. 34 – MLA interception content Art. 35 – 24/7 point of contact

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Мэдээллийн аюулгүй байдлын газар <http://www.isd.gov.mn/?lang=mn&cat=7>
- Төрийн мэдээлэл холбооны газар <https://www.cita.gov.mn/>
- Эрх зүй мэдээллийн систем <https://www.legalinfo.mn/>
- [https://www.nato.int/cps/en/natohq/topics\\_140739.htm](https://www.nato.int/cps/en/natohq/topics_140739.htm)
- <https://www.dcaf.ch/sites/default/files/publications/documents/OnCyberwarfare-Schreier.pdf>
- <https://www.vmware.com/topics/glossary/content/cyber-espionage>
- <https://www.iso.org/standard/44375.html>
- <https://www.itu.int/en/ITU-D/Cybersecurity/Pages/global-cybersecurity-index.aspx>
- <https://www.secureworldexpo.com/industry-news/countries-dedicated-to-cybersecurity>
- <https://www.cyberdb.co/top-10-countries-best-prepared-cyber-attacks/>
- <https://www.cyberdb.co>
- <https://cyberdb1.wpengine.com/database/usa/>
- <https://www.cyberdb.co/top-10-countries-best-prepared-cyber-attacks/>
- <https://cyberdb1.wpengine.com/database/israel/>
- <https://www.broadcom.com/products/cyber-security>
- BSA International Cybersecurity Policy Framework 2018
- <https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/185>
- <https://statesassembly.gov.je/scrutinyreviewresearches/2018/research%20-%20briefing%20paper%20on%20council%20of%20europe%20convention%20on%20cybercrime%20-%2031%20october%202018.pdf>
- <https://rm.coe.int/t-cy-2020-16-bc-benefits-rep-provisional/16809ef6ac#:~:text=The%20Budapest%20Convention%20requires%20States,cybercrime%20but%20any%20offence%20where>

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ,  
ДАГАЛДАХ ХУУЛЬ, ЖУРМУУДЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ**

*Р.Нургүл*

**АГУУЛГА**

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ, ДАГАЛДАХ ХУУЛЬ, ЖУРМУУДЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

НЭГ. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт 1. 1997 оны Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт (Энэ хууль одоо хүчингүй болно)

Хүснэгт 2. Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д 2008-2019 онуудад оруулсан нэмэлт, өөрчлөлт

Хүснэгт 3. Нэмэлт, өөрчлөлтийн тоо оноор (2008-2019 он)

ХОЁР. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙГ ДАГАЖ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХУУЛИУД

Хүснэгт 4. Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж өөрчлөгдсөн хуулиуд (2008-2019 онуудад)

ГУРАВ. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙГ ДАГАЖ БАТЛАГДСАН ЖУРМУУД

Хүснэгт 5. Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж батлагдсан журмууд

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Энэхүү судалгаанд Улсын Их Хурлын гишүүний захиалгын дагуу Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, дагалдах хууль, журмуудын талаарх мэдээлэл, лавлагааг УИХ-ын Тамгын газрын архивын мэдээлэл, Тамгын газрын дотоод сүлжээн дэх хуулийн сан болон бусад эх сурвалжийг ашиглан бэлтгэсэн болно.

Судалгааны арга зүй: Баримт бичгийн шинжилгээ хийх арга зүй ашиглав.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд 1997, 2008 оны Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон 2008 оны хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон хуулиуд, батлагдсан журмуудын талаарх мэдээллийг тус тусад нь он дарааллаар, хүснэгтээр гаргав.

### СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Анхны Ашигт малтмалын тухай хууль 1994 онд батлагдсан. Түүнээс хойш 1997, 2006 онуудад хуулийг 2 удаа шинэчлэн баталсан байна. 2006 оны 7-р сарын 08-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга) одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд түүнд 2008-2019 онуудад тасралтгүй 34 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Хуульд хийсэн нэмэлт, өөрчлөлтийн 77 хувь буюу 26 удаа бусад хуулийг дагаж өөрчлөгдсөн бол 23 хувь буюу 8 удаа хуульд өөрт нь нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

2008-2019 онуудад Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж дараах хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай
- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай
- Татварын ерөнхий хууль
- Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай зэрэг болно.

(Бусад хуулийг дагаж Ашигт малтмалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээллийг судалгааны дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү)

Түүнчлэн 2007, 2010, 2014, 2015, 2017-2019 онуудад Ашигт малтмалын хууль (Шинэчилсэн найруулга)-тай холбоотой журмууд батлагдан гарчээ. (Хүснэгт 5-аас үзнэ үү)

Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д 2008, 2013, 2018 онуудад тус бүр 1 удаа; 2010, 2011, 2012, 2017 онуудад тус бүр 2 удаа; 2009, 2016, 2019 онуудад тус бүр 4 удаа; 2014 онд 5 удаа; 2015 онд 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Доорх хүснэгтэд хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн тоог он дарааллаар харуулав.

#### Хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн тоо оноор (2008-2019 онуудад)

он	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	Нийт
Нэмэлт, өөрчлөлтийн тоо	1	4	2	2	2	1	5	6	4	2	1	4	34



## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

### НЭГ. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

Ашигт малтмалын тухай хууль анх 1994 оны 9-р сарын 03-ны өдөр батлагдсан бөгөөд хуульд 1995 оны 4-р сарын 17-ны өдөр өөрчлөлт оруулсан.(Энэ оны хууль, ямар өөрчлөлт орсон талаарх мэдээлэл олдоогүй болно.)

1997 оны 6-р сарын 05-ны өдөр Ашигт малтмалын тухай хууль 2 дахь удаа шинэчлэн батлагдснаар өмнөх хууль (1995 оны) хүчингүй болсон. Энэхүү шинэчлэн батлагдсан хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт ус, газрын тос, байгалийн хийгээс бусад бүх төрлийн ашигт малтмал хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулж байв. Тус хуульд 1999, 2000, 2001, 2002, 2003 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.<sup>337</sup> (Хүснэгт 1)

#### Хүснэгт 1. 1997 оны Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт (Энэ хууль одоо хүчингүй болно)

	Хуулийн нэр	Нэмэлт, өөрчлөлт
1.	1999.01.08 <u>Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай</u>	Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын "бүрэн төлөөгүй" гэсний дараа "буюу энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд лизенцийн төлбөр, алданги төлөөгүй" гэж; 47 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "ЗО хоногийн дотор" гэсний дараа "лизенцийн төлбөрийг, тогтоосон алдангийн хамт төлсөн, эсхүл" гэж тус тус нэмсүгэй. Ашигт малтмалын тухай хуулийн 52 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй: "3.Лиценз эзэмшигч нь лицензийн төлбөрийг энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан хугацаанд төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги төлнө."
2.	2000.09.01 Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, 53 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай: <b>6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:</b> "4/ашигт малтмалын тухай хууль тогтоомжид хяналт тавих үүрэг бүхий агентлагийг байгуулж ажиллуулах;" <b>53 дугаар зүйл:</b> <b>"53 дугаар зүйл. Геологи, уул уурхайн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих улсын хяналт</b> Хайгуул хийх, ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг улсын хэмжээнд мэргэжлийн хяналтын байгууллага, орон нутагт хяналтын албад эрхлэн зохион байгуулж хэрэгжүүлнэ."  Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "Геологи, уул уурхайн хяналтын албанд" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллагад", 18 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 10 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн "Геологи, уул уурхайн хяналтын алба" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллага", 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 54 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Геологи, уул уурхайн

<sup>337</sup> <https://legalinfo.mn/law/details/7069>

		хяналтын албанаас” гэснийг “мэргэжлийн хяналтын байгууллагаас”, 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Геологи, уул уурхайн хяналтын албаны” гэснийг “мэргэжлийн хяналтын байгууллагын” гэж тус тус өөрчилсүгэй.
3.	2001.12.27 <u>Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</u>	Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 17, 18 дахь заалт нэмсүгэй: “17/ “үндсэн орд” гэж геологийн хувьсал өөрчлөлтийн дүнд бүрэлдэн тогтож, анх үүссэн чулуулагтайгаа нэг орон зайд байрлаж байгаа эрдэс баялгийн хуримтлалыг; 18/ “шороон орд” гэж анхлан үүссэн чулуулаг, орон зайнаасаа өгөршил, элэгдэл, механик үйл явцын дүнд салж сарнин, дахин хуримтлагдаж, үе давхрага байдалтайгаар байгаа эрдэс баялгийн хуримтлалыг.” Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шороон ордоос олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан алтны хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь борлуулалтын үнэлгээний 7,5 хувьтай тэнцүү байна” гэсэн 2 дахь өгүүлбэр, мөн зүйлийн 1 дэх хэсэг болон 61 дүгээр зүйлд “төлбөрийг” гэсний дараа “төвлөрсөн болон” гэж тус тус нэмсүгэй. Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 16 дахь заалтаас “тус тус хэлнэ” гэснийг хассугай.
4.	2002-11-07 <u>Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай</u>	Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмсүгэй: 39 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг: “6. Лиценз эзэмшигч нь энэ хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг Үндэсний татварын албанаас баталсан маягтын дагуу улирал тутам өссөн дүнгээр гаргаж, дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны эхний сарын 20-ны дотор Үндэсний татварын албанд тушаана.”
5.	2003-01-02 <u>Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай</u>	Ашигт малтмалын тухай хуулийн 38.1., 61 дүгээр зүйлийн “төвлөрсөн” гэснийг “улсын” гэж тус тус өөрчилсүгэй.  Ашигт малтмалын тухай хуулийн 62 дугаар зүйлийн “төвлөрсөн” гэснийг хассугай.

Улсын Их Хурлаас Ашигт малтмалын тухай хуулийг 2006 онд 3 дахь удаа шинэчлэн найруулж баталсан бөгөөд 1997 оны Ашигт малтмалын тухай хууль хүчингүй болсон.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 2006 оны 7-р сарын 08-нд батлагдсан байна. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.<sup>338</sup> Хуулиар ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахаар заасан байна<sup>339</sup>.

Уг хуульд 2008-2019 онуудад жил бүр тасралтгүй нэмэлт, өөрчлөлт оруулжээ. (Хүснэгт

<sup>338</sup> Ашигт малтмалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 1 дүгээр зүйл, <https://www.legalinfo.mn/law/details/63?lawid=63>

<sup>339</sup> Ашигт малтмалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 3 дугаар зүйл, <https://www.legalinfo.mn/law/details/63?lawid=63>

2)

**Хүснэгт 2. Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д 2008-2019 онуудад оруулсан нэмэлт, өөрчлөлт**

	<b>Нэмэлт, өөрчлөлтийн огноо</b>	<b>Нэмэлт, өөрчлөлт</b>
1.	2008-12-19 “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” УИХ-ын 43-р тогтоолоор <sup>340</sup> Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт орсон.	Ашигт малтмалын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийн “Сорьцын улсын хяналтын албаар” гэснийг “сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар” гэж өөрчилсүгэй.
2.	2009-01-08 Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулсан.	Ашигт малтмалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “ашиглахтай” гэснийг “ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “56 дугаар зүйлд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан” гэснийг “53-56 дугаар зүйлд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл нь дуусгавар болсон, цуцлагдсан, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг хүлээлгэн өгсөн” гэж тус тус өөрчилсүгэй.  Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгийн “эрэл,” гэснийг болон 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон, түүнчлэн” гэснийг тус тус хассугай.
3.	2009-07-16 Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж нэмэлт орсон.	Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.3.3 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5.3 дахь заалтын “газар” гэсний өмнө “газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон” гэж, мөн зүйлийн 24.4.2 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.2.2 дахь заалтын “авсан,” гэсний дараа “ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон,” гэж, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “эзэмшигчийн” гэсний дараа “болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх” гэж, 56 дугаар зүйлийн 56.1.3 дахь заалтын “авч” гэсний дараа “, эсхүл тухайн талбайд ашигт малтмал хайх, ашиглахыг хуулиар хориглож” гэж тус тус нэмсүгэй.
4.	2009-07-16 Цөмийн энергийн тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.	Ашигт малтмалын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй: <b>4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт:</b> “4.1.2.“цацраг идэвхт ашигт малтмал” гэж уран болон торийн бүлийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс баялгийн хуримтлалыг;” <b>7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг:</b> “7.6.Цөмийн энергийн тухай хуулийн дагуу цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрөл олгох шалгаруулалт явуулахаар цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэл ирүүлсэн бол

<sup>340</sup> Энэ тогтоол одоо хүчингүй бөгөөд батлагдсанаас хойш хэд хэдэн удаа шинэчлэгдсэн бөгөөд хамгийн сүүлд УИХ-ын 2020 оны 07 сарын 07 өдрийн 07 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан.

		<p>тухайн талбай дээр уг асуудлыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй.”</p> <p><b>21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт:</b></p> <p>“21.1.2.хайгуулын талбайн хилийн дотор цацраг идэвхт ашигт малтмалыг цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрэх, хайх;”</p> <p><b>27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт:</b></p> <p>“27.1.2.тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа цацраг идэвхт ашигт малтмалыг цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглах;”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.15, 11.1.16, 11.1.20 дахь заалтын “тусгай” гэсний өмнө “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын” гэж, мөн зүйлийн 11.1.19 дэх заалтын “хайгуулын” гэсний өмнө “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын” гэж, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийн “болон” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтын “дагуу” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн” гэж, мөн зүйлийн 21.1.2 дахь заалтын “хэсэгт” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын” гэж, мөн зүйлийн 21.1.3 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтын “дээр” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалтын “тохиолдолд” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын” гэж, 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтын “байгаа” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн” гэж, мөн зүйлийн 27.1.3 дахь заалтын “олборлосон” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн” гэж, мөн зүйлийн 27.1.4 дэх заалтын “талбайд” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн” гэж, мөн зүйлийн 27.1.6 дахь заалтын “ашиглалтын” гэсний өмнө “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын” гэж тус тус нэмсүгэй.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “байгалийн хийгээс” гэснийг “байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмалаас” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “4.1.11-д” гэснийг “4.1.12-т” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.16 дахь заалтын “4.1.14-т” гэснийг “4.1.15-д” гэж, мөн зүйлийн 4.1.17 дахь заалтын “4.1.15-д” гэснийг “4.1.16-д” гэж, мөн зүйлийн 4.1.2-4.1.21 дэх заалтын дугаарыг “4.1.3-4.1.22” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.2-21.1.7 дахь заалтын дугаарыг 21.1.3-21.1.8 гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “21.1.4-т” гэснийг “21.1.5-д” гэж, 27 дугаар зүйлийн 27.1.2-27.1.10 дахь заалтын дугаарыг “27.1.3-27.1.11” гэж, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “27.1.6-д” гэснийг “27.1.7-д” гэж тус тус өөрчилсүгэй.</p>
5.	2009-10-15 Ашигт малтмалын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосон.	Ашигт малтмалын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.
6.	2010-07-01 Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай	<p>Ашигт малтмалын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:</p> <p><b>4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалт:</b></p> <p>“4.1.23. “бичил уурхай” гэж Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан</p>

	<p>хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p>	<p>зориулалтаар олгосон ашигт малтмалын үйлдвэрлэлийн бус агуулгатай эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, илрэл бүхий талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг.”</p> <p><b>11 дүгээр зүйлийн 11.1.23 дахь заалт:</b>  “11.1.23.энэ хуулийн 12.1.5-д заасны дагуу сум, дүүргийн Засаг даргын гаргасан хүсэлтийг хүлээн авч сонгосон газар нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоох.”</p> <p><b>12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт:</b>  “12.1.5.Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар олгохоор сонгосон газрын талаар энэ хуулийн 11.1.23-д заасан дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.”</p> <p><b>66 дугаар зүйлийн 66.1.9 дахь заалт:</b>  “66.1.9.бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг зөрчсөн иргэнийг 100000-300000 хүртэл, албан тушаалтныг 500000-1000000 хүртэл, хуулийн этгээдийг 1000000-2000000 хүртэл төгрөгөөр торгох.”.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:  “3.2.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална.”.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “11.1.22” гэснийг “11.1.23” гэж, “7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөлгүйгээр” гэснийг “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр” гэж тус тус өөрчилсүгэй.</p>
7.	<p>2010-11-25 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p>	<p>“47.4.Тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч энэ хуулийн 47.3.2-т заасан хувь дээр мөн хуулийн 47.5-д заасан хувийг нэмсэн дүнгээр тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулна.</p> <p>47.5.Энэ хуулийн 47.4-т заасан нэмэлт төлбөрийн хувийг дараах байдлаар тодорхойлно: /хүснэгтэд өөрчлөлтөд орсон/</p> <p>47.6.Энэ хуулийн 47.3.1, 47.3.2, 47.4, 47.5-д заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах аргачлалыг Засгийн газар батална.</p> <p>47.7.Ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний аль нэгд нь давхардуулахгүйгээр ногдуулна.</p> <p>47.8.Энэ хуулийн 47.5-д заасан хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлалыг геологи, уул уурхайн болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.”.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.2 дахь заалтын “төлбөр” гэснийг “төлбөрийн доод хэмжээ нь” гэж, мөн зүйлийн 47.4-47.7 дахь хэсгийн дугаарыг “47.9-47.12” болгон тус тус өөрчилсүгэй.</p>



8.	2011-02-10 Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж өөрчлөлт орсон.	<p>Ашигт малтмалын тухай хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p><b>18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалт:</b> “18.2.2.тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;”.</p> <p><b>22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалт:</b> “22.1.1.хайгуулийн тусгай зөвшөөрлийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;”.</p> <p><b>28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт:</b> “28.1.1. ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;”.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.3.1 дэх заалтын “нотариатаар гэрчлүүлсэн” гэснийг тус тус хассугай.</p>
9.	2011-12-23 Төсвийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдахад дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>Ашигт малтмалын тухай хуульд дор дурдсан агуулгатай 47<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:</p> <p><b>“47<sup>1</sup> дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр</b></p> <p>47<sup>1</sup>.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө.</p> <p>47<sup>1</sup>.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5-5 хувьтай тэнцүү байна.</p> <p>47<sup>1</sup>.3.Энэ хуулийн 47<sup>1</sup>.2-т заасан төлбөрийн хувь хэмжээг тухайн түгээмэл тархацтай ашигт малтмалын тархац, шинж чанар, байгаль орчинд нөлөөлөх байдлыг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.1 дэх заалтын “нүүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын” гэснийг “нүүрсний” гэж өөрчилсүгэй.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “болон орон нутгийн” гэснийг хассугай.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 58, 59 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.</p>
10.	2012-05-17 Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 56.1.6 дахь заалт нэмсүгэй:</p> <p>“56.1.6.стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль тогтоомжийг зөрчсөн.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэснийг өмнө “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө</p>



	хуулийг дагаж нэмэлт орсон.	оруулалтыг зохицуулах тухай хууль,” гэж нэмсүгэй.
11.	2012-05-17 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.	<b>Ашигт малтмалын тухай</b> хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсгийн “заасан хөрөнгийг түүнд” гэсний дараа “уурхайн хаалтын үе шатанд” гэж нэмсүгэй. <b>Ашигт малтмалын тухай</b> хуулийн дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай: <b>39 дүгээр зүйлийн 39.1.9 дэх заалт:</b> “39.1.9. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д заасны дагуу зохицуулна” <b>39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсэг:</b> “39.5. Энэ хуулийн 39.3-т заасан мөнгөн хөрөнгийг тухайн жилийн олборлолтын ажил эхлэхийн өмнө шилжүүлэх бөгөөд энэхүү шилжүүлэг хийгдсэн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ” <b>45 дугаар зүйлийн 45.1 дэх заалт:</b> “45.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаах бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасны дагуу зохих бэлтгэлийг хангаж дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.” <b>Ашигт малтмалын тухай</b> хуулийн 22.1.3, 25.1.6, 35.2.2, 35.3.4, 38.1.1, 38.1.4, 38.1.5, 38.3, 38.4, 39.1.1, 39.1.3-39.1.7, 39.1.7.3, 39.4, 39.9, 40.1, 40.2, 48.8, 57.4 дэх хэсгийн “байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө” гэснийг “байгаль орчны менежментийн төлөвлөгөө” гэж, 40 дүгээр зүйлийн гарчгийг “ <b>Байгаль орчны нөлөөллийн шинэчилсэн үнэлгээ, менежментийн төлөвлөгөөг хянуулах</b> ” гэж тус тус өөрчилсүгэй.
12.	2013-10-03 Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.	Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 47.13 дахь хэсэг нэмсүгэй: “47.13.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ бүхий-татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр ногдуулна.” Ашигт малтмалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль,” гэснийг “Хөрөнгө оруулалтын тухай хууль,” гэж өөрчилсүгэй. Ашигт малтмалын тухай хуулийн 29, 30, 65 дугаар зүйл, 56 дугаар зүйлийн 56.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
13.	2014-01-09 Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.	Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.19, 11.1.20 дахь заалтын “цацраг идэвхт” гэсний дараа “болон түгээмэл тархацтай” гэж тус тус нэмсүгэй. Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: “32.3.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон уурхайн талбайн гектар тутамд 15 америк доллар байх бөгөөд харин шохойн чулуу, нүүрс, дотоодын үйлдвэрлэлийн зориулалттай ашигт малтмалын хувьд гектар тутамд 5 америк доллар байна.” Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 47 <sup>1</sup> зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
14.	2014-01-24 Ашигт малтмалын тухай хуульд	Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

	<p>нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p><b>10 дугаар зүйлийн 10.1.10 дахь заалт:</b>  “10.1.10. ашигт малтмал хайх, ашиглах, боловсруулах, борлуулах үйл ажиллагаанд ил тод байдлыг бүрдүүлэх.”</p> <p><b>35 дугаар зүйлийн 35.6. дахь хэсэг:</b>  “35.6. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, бичил уурхайгаас алт олборлогч нь олборлосон алтаа тухайн санхүүгийн жилдээ багтааж тушаана.”</p> <p><b>47 дугаар зүйлийн 47.3.3 дахь заалт:</b>  “47.3.3. Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд энэ хуулийн 47.3.2-т заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2,5 хувь, энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.2 дахь заалтын “47.3.1-д зааснаас бусад” гэснийг “47.3.1, 47.3.3-т заасан Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтнаас бусад” гэж өөрчилсүгэй.</p>
<p>15.</p>	<p>2014-05-15  Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж нэмэлт орсон.</p>	<p>Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:</p> <p><b>40<sup>1</sup>, 40<sup>2</sup> дугаар зүйл:</b>  <b>“40<sup>1</sup> дүгээр зүйл. Соёлын өвийг хамгаалах</b>  40<sup>1</sup>.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 40<sup>2</sup>, 46 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ.</p> <p>40<sup>1</sup>.2.Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.</p> <p><b>40<sup>2</sup> дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг</b>  40<sup>2</sup>.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь соёлын өвийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:</p> <p>40<sup>2</sup>.1.1.соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, улсын хяналтын байцаагчид хайгуулын талбайд нэвтрэн орох, газар дээр нь шалгалт хийх бололцоо олгох;</p> <p>40<sup>2</sup>.1.2.ашигт малтмал эрэх, хайх явцад олж илрүүлсэн соёлын өвийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуульд заасны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх ба тухайн өвийг холбогдох байгууллагад хадгалуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ.”</p> <p><b>56 дугаар зүйлийн 56.1.7 дахь заалт:</b> “56.1.7.хайгуулын талбайд соёлын өв байгаа нь тогтоогдсон.”</p>
<p>16.</p>	<p>2014-07-01  Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж нэмэлт орсон.</p>	<p>Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай 35.7, 35.8 дахь хэсэг нэмсүгэй:</p> <p>“35.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нүүрс олборлох явцад метан хий илрүүлбэл газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.</p> <p>35.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 35.6-д заасан метан хийг ашиглахаар бол Газрын тосны тухай хуульд заасны дагуу ашиглалтын үйл ажиллагаа явуулж болно.”</p>

17.	2014-07-01 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:</p> <p><b>11<sup>1</sup> дүгээр зүйл:</b>  <b>“11<sup>1</sup> дүгээр зүйл.Үндэсний геологийн албаны чиг үүрэг</b>  11<sup>1</sup>.1.Монгол Улсын Үндэсний геологийн алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:  11<sup>1</sup>.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн зураглал, судалгаа, шинжилгээ хийх;  11<sup>1</sup>.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений судалгаа хийж, эрдэс баялгийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх;  11<sup>1</sup>.1.3.геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах, нууцын зэрэглэлд хамааруулснаас бусад мэдээллээр сонирхсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх;  11<sup>1</sup>.1.4.ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх.”</p> <p><b>3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг:</b>  “3.3.Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.”</p> <p><b>34 дүгээр зүйлийн 34.6, 34.7 дахь хэсэг:</b>  “34.6.Энэ хуулийн 34.2-т заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд тухайн жилд төлөх төлбөрийн үнийн дүнгийн 0.3 хувиар тооцон алданги ногдуулна.  34.7.Энэ хуулийн 34.6-д заасан хугацаа хэтэрсэн хоног 30 хүртэл байх бөгөөд энэ хугацаанаас хэтэрвэл мөн хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцална.”</p> <p><b>35 дугаар зүйлийн 35.9-35.12 дахь хэсэг:</b>  “35.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгоход тэргүүн ээлжинд стандартын шаардлага хангасан бараа, ажил, үйлчилгээ бүхий Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжид давуу эрх олгоно.  35.10.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техникийн гэнэтийн осол, саатал, давагдашгүй хүчин зүйл, шүүхийн шийдвэр, улсын байцаагчийн актаар үйл ажиллагааг нь зогсоосон болон бусад шалтгаанаар уурхайн бүтээн байгуулалт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоохдоо геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдээлнэ.  35.11.Олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр нийлүүлнэ.  35.12.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хаяг, цахим шуудан, утас, факсны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд 14 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.”</p> <p><b>48 дугаар зүйлийн 48.12 дахь хэсэг:</b>  “48.12.Энэ хуулийн 48.3-т заасан хайгуулын үр дүнгийн тайлан болон 48.6.1-д заасан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, тэдгээрт хийх хөндлөнгийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг мэргэшсэн мэргэжилтэн, эрх бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.”</p> <p><b>56 дугаар зүйлийн 56.8 дахь хэсэг:</b>  “56.8.Энэ хуулийн 56.1-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг цуцалсан шийдвэрийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэр хүчин</p>
-----	--	---

	<p>төгөлдөр болсон өдрөөс эхлэн тусгай зөвшөөрлийн хугацааг үргэлжлүүлэн тооцно.”</p> <p><b>4 дүгээр зүйлийн 4.1.24-4.1.26 дахь заалт:</b></p> <p>“4.1.24.“ашигт малтмалын баялаг” гэж геологийн зураглал, сэдэвчилсэн судалгаа, эрэл, хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн, эдийн засгийн ач холбогдол нь нарийвчлан үнэлэгдээгүй эрдсийн хуримтлалын хэсгийг;</p> <p>4.1.25.“ашигт малтмалын ордын нөөц” гэж хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдсон, үйлдвэрийн аргаар олборлох боломжтой, эдийн засгийн үр ашигтай, баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцөл нь тодорхойлогдсон ашигт малтмалын баялгийн хэсгийг;</p> <p>4.1.26.”мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч” гэж үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын төрийн бус байгууллагаас эрх олгогдсон иргэнийг.”</p> <p><b>9 дүгээр зүйлийн 9.1.9-9.1.13 дахь заалт:</b></p> <p>“9.1.9.Үндэсний геологийн алба байгуулах;</p> <p>9.1.10.энэ хуулийн 42.1-д заасан гэрээний загварыг батлах;</p> <p>9.1.11.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх;</p> <p>9.1.12. стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил заагийг тогтоох;</p> <p>9.1.13.ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээнд авах зорилгоор төрийн мэдэлд шилжүүлэн авч нөхөх олговрын асуудлыг шийдвэрлэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцэн тохирсоны үндсэн дээр энэ хуулийн 19.12, 26.9-д заасан талбайгаас тусгай зөвшөөрөл олгож болно.”</p> <p><b>10 дугаар зүйлийн 10.1.11-10.1.18 дахь заалт:</b></p> <p>“10.1.11.уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журмыг батлах;</p> <p>10.1.12.баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах;</p> <p>10.1.13.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх зорилго бүхий төрийн байгууллага, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагын төлөөллийн тэгш байдлыг хангасан орон тооны бус бодлогын зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг батлах;</p> <p>10.1.14.уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;</p> <p>10.1.15.геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг батлах;</p> <p>10.1.16.геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг батлах;</p> <p>10.1.17.ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг батлах;</p> <p>10.1.18.үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын төрийн бус</p>
--	---

	<p>байгууллагатай хамтран ашигт малтмалын баялаг, ордын нөөц, хайгуулын ажлын үр дүнг нийтэд нээлттэй тайлагнах журмыг батлах.”</p> <p><b>11 дүгээр зүйлийн 11.1.24, 11.1.25 дахь заалт:</b></p> <p>“11.1.24.хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргасан хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн мэдээллийн бүртгэл хөтлөх;</p> <p>11.1.25.ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайг солбицлоор тодорхойлох.”</p> <p><b>14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэг:</b></p> <p>“14.9. Энэ хуулийн 13.5, 14.8-д заасны дагуу чөлөөлөгдсөн талбайг урьд нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр эзэмшиж байсан этгээдэд үргэлжлүүлэн эзэмшүүлэхдээ тусгай зөвшөөрлийн хугацааг тусгай хэрэгцээ, нөөцөд байсан хугацаагаар сунгаж тооцно.”</p> <p><b>27 дугаар зүйлийн 27.1.12, 27.1.13 дахь заалт:</b></p> <p>“27.1.12.энэ хуулийн 48.6.1-д заасан тухайн ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлдээ тухайн уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх болон уурхайн нөхөн сэргээлт, хаалт зэрэгт шаардагдах хөрөнгийн талаар тодорхой тусгасан байх;</p> <p>27.1.13.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын асуудлаар тогтмол мэдээлэх үүрэг бүхий ажилтантай байх;”</p> <p><b>33 дугаар зүйлийн 33.1.4 дэх заалт:</b></p> <p>“33.1.4.тусгай зөвшөөрлийн 10-12 дахь жилд 10 америк доллар.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтын “нэмэгдүүлэх” гэсний дараа “баяжуулах,” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “хамааруулах” гэсний дараа “, хасах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын “хамааруулах” гэсний дараа “, хасах” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтын “зохион явуулах” гэсний дараа “, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргах” гэж, 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтын “факсны дугаар” гэсний дараа “, цахим шуудангийн хаяг” гэж, 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтын “факсны дугаар” гэсний дараа “цахим шуудангийн хаяг,” гэж, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “1,5 америк доллар” гэсний дараа “, 10-12 дахь жилд 5 америк доллар” гэж, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “эзэмшигч” гэсний дараа “болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч” гэж, 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтын “30 хоногийн” гэсний дараа “, дараагийн жилүүдэд тухайн оны төлөвлөгөөг 04 дүгээр сарын 15-ны” гэж, 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь заалтын “төлбөрийг” гэсний дараа “энэ хуулийн 34.7-д заасан” гэж, мөн зүйлийн 56.7 дахь хэсгийн “татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “болон мэргэжлийн хяналтын” гэж, 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийн “эсхүл” гэсний дараа “захиргааны хэргийн” гэж тус тус нэмсүгэй.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p><b>7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:</b></p> <p>“7.3.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. Байгалийн өнгөт болон үнэт чулууг түүх, олборлох үйл ажиллагааг ердийн ашигт малтмалын адил тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.”</p>
--	---



	<p><b>20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг:</b>  “20.1.Энэ хуулийн 53.1.1, 56.1.3-56.1.5-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл нь дуусгавар болсон, цуцлагдсан бол төрийн захиргааны байгууллага доор дурдсан журмын дагуу сонгон шалгаруулалт явуулж тусгай зөвшөөрлийг шинээр олгоно.”</p> <p><b>45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг:</b>  “45.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаах бол төрийн захиргааны төв байгууллагад нэгээс доошгүй жилийн өмнө мэдэгдэж, энэ хуулийн 10.1.14-д заасан журмын дагуу зохих бэлтгэлийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.”</p> <p><b>48 дугаар зүйлийн 48.3, 48.4 дэх хэсэг:</b>  “48.3.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайланг ашигт малтмал эрэх, хайх үйл ажиллагааны журам, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалд нийцүүлэн боловсруулж, шинжээчийн дүгнэлт гаргуулан төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.  48.4.Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 48.3-т заасан тайлан, 48.6.1-д заасан техник-эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилуулж, 90 хоногт багтаан хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны үндсэн дээр уг нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, хүлээн авах, тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана.”</p> <p><b>4 дүгээр зүйлийн 4.1.12, 4.1.23 дахь заалт:</b>  “4.1.12.”стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг;”  “4.1.23.“бичил уурхай эрхлэх” гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл ордын талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг;”</p> <p><b>10 дугаар зүйлийн 10.1.5, 10.1.9 дэх заалт:</b>  “10.1.5.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх жил бүрийн геологийн судалгааны ажлын төлөвлөгөө, төсөл, төсвийг батлах, тодотгох, үр дүнгийн тайланг хүлээн авсан тухай шийдвэр гаргах;”  “10.1.9.Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын тайлан, ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэшсэн мэргэжилтнээс бүрдсэн гишүүдтэй Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний дүрэм, шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлалыг батлах;”</p> <p><b>48 дугаар зүйлийн 48.1.2, 48.6.1- 48.6.3 дахь заалт:</b>  “48.1.2.хайгуулын ажлын жилийн тайланг төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;”</p>
--	---



	<p>“48.6.1.тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар хийлгэж ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор;</p> <p>48.6.2.дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд, уулын ажлын төлөвлөгөөг батлагдсан зааврын дагуу 12 дугаар сарын 01-ний дотор;</p> <p>48.6.3.ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нөөцийн зэрэглэлийг ахиулах ашиглалтын хайгуулыг тухай бүр хийж, ажлын төлөвлөгөө, тухайн жилийн болон хайгуулын ажлын үр дүнгийн тайланг энэ хуулийн 48.1.2-т заасны дагуу.”</p> <p><b>66 дугаар зүйлийн 66.1.2 дахь заалт:</b></p> <p>“66.1.2.энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан мэдээ, төлөвлөгөө, ашиглалтын үйл ажиллагааны тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “олговор” гэснийг “олговрыг нэг жилийн дотор” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Тусгай хэрэгцээ болон нөөцөд аваагүй” гэснийг “Монгол Улсын” гэж, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “400 мянган” гэснийг “150 мянган” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “2” гэснийг “3” гэж, 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтын “уурхайн эдэлбэрээс олборлосон” гэснийг “ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий хуулийн этгээд” гэж, 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийн “5” гэснийг “10” гэж, 66 дугаар зүйлийн 66.1.1 дэх заалтын “500000-1000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.3 дахь заалтын “100000-300000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “500000-1000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “1000000-2000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.4 дэх заалтын “100000-500000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “500000-1000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.5 дахь заалтын “200000-500000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “500000-1000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.6 дахь заалтын “100000-250000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “1000000-2000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.7 дахь заалтын “100000-250000” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.8 дахь заалтын “200000-500000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “500000-1000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дөч</p>
--	---

		<p>дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.1.9 дэх заалтын “100000-300000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “500000-1000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, “1000000-2000000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж, мөн зүйлийн 66.2 дахь хэсгийн “200000-300000 хүртэл” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний” гэж тус тус өөрчилсүгэй.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.</p>
18.	<p>2015-01-23 Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.</p>	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “0,1 америк доллар” гэснийг “145 төгрөг” гэж, “0,2 америк доллар” гэснийг “290 төгрөг” гэж, “0,3 америк доллар” гэснийг “435 төгрөг” гэж, “1,0 америк доллар” гэснийг “1450 төгрөг” гэж, “1,5 америк доллар” гэснийг “2175 төгрөг” гэж, “5 америк доллар” гэснийг “7250 төгрөг” гэж, 32.3 дахь хэсгийн “15 америк доллар” гэснийг “21750 төгрөг” гэж, “5 америк доллар” гэснийг “7250 төгрөг” гэж тус тус өөрчилсүгэй.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: “34.5.Энэ хуульд америк доллароор илэрхийлсэн зардлын тооцоог хийхдээ тухайн өдрийн Монголбанкнаас тогтоосон албан ёсны ханшийг баримтална.”</p>
19.	<p>2015-02-13 Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.</p>	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.15, 11.1.16 дахь заалт, мөн зүйлийн 11.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.3, 21.1.4 дэх заалт, 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.4-27.1.6 дахь заалтын “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.19, 11.1.20 дахь заалтын “цацраг идэвхт болон” гэснийг тус тус хассугай.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.</p>
20.	<p>2015-02-18 Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг дагаж нэмэлт орсон.</p>	<p>Ашигт малтмалын тухай хуульд дараах агуулгатай 56.1.8 дугаар заалт нэмсүгэй: “56.1.8.Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зүйл, заалт болон хуулийн дагуу байгуулсан гэрээний заалтыг зөрчсөн.”</p>
21.	<p>2015-02-18 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт орсон.</p>	<p>Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай 47<sup>2</sup> дугаар зүйл нэмсүгэй: “<b>47<sup>2</sup> дугаар зүйл.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр</b> 47<sup>2</sup>.1.Эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр стратегийн ач</p>

		<p>холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг гэрээний нөгөө талд шилжүүлэхээр талууд тохиролцсон тохиолдолд төрийн эзэмшлийн хувь, хэмжээг шилжүүлэн авч байгаа тал буюу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг энэ хуулийн 47.2-т заасан журмын дагуу тооцож улсын төсөвт төлнө.</p> <p>47<sup>2</sup>.2.Энэ хуулийн 47<sup>2</sup>.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална.</p> <p>47<sup>2</sup>.3.Энэ хуулийн 5.3-5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээ нь тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрэхээргүй байна.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 5.3-5.5 дахь хэсэгт “Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.</p>
22.	2015-06-04 Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p>“47.10.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүнд ногдох тухайн улирлын төлбөрийг дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор төсөвт төлнө.”</p>
23.	2015-12-04 Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж өөрчлөлт орсон.	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 66 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p><b>“66 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага</b></p> <p>66.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>66.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p><b>66.3.Холбогдох хууль, уул уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийг удаа дараа зөрчсөн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг хоёр сарын хугацаагаар зогсоох бөгөөд энэ хугацаанд зөрчлийг засаагүй бол тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу цуцална.</b></p> <p>66.4.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаандаа химийн хорт бодис, бэлдмэлийг хэрэглэхдээ хууль, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг дагаж мөрдөөгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд ноцтой хохирол учруулсан бол тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу цуцалж, 20 жилийн хугацаанд дахин тусгай зөвшөөрөл олгохгүй.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “энэ хуулийн 66.1.4-т заасан хариуцлага” гэснийг “Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага” гэж өөрчилсүгэй.</p>
24.	2016-02-04 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийн “төсөвт төвлөрүүлж” гэсний дараа “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох,” гэж нэмсүгэй.</p>

	нэмэлт орсон.	
25.	2016-02-04 Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж өөрчлөлт орсон.	Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсгийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 46.1.3-т” гэснийг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62.1.3-т” гэж өөрчилсүгэй.
26.	2016-11-10 Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийг дагаж Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:</p> <p><b>4 дүгээр зүйлийн 4.1.27, 4.1.28 дахь заалт:</b></p> <p>“4.1.27.“үүсмэл орд” гэж олборлолт, боловсруулалт, баяжуулалтын явцад ялгагдсан ашигт малтмалын тодорхой агуулга бүхий дахин боловсруулахад эдийн засгийн үр ашиг гаргаж болохуйц хүдэр, ашигт малтмалын овоолгыг;</p> <p>4.1.28.“үүсмэл орд ашиглах” гэж энэ хуулийн 4.1.27-д заасан хүдэр, ашигт малтмалын овоолго зэргээс ашигт малтмал ялган авах, боловсруулах, баяжуулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг.”</p> <p><b>9 дүгээр зүйлийн 9.1.14, 9.1.15 дахь заалт:</b></p> <p>“9.1.14.үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журмыг батлах;</p> <p>9.1.15.үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах.”</p> <p><b>26 дугаар зүйлийн 26.10, 26.11 дэх хэсэг:</b></p> <p>“26.10.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч гуравдагч этгээдэд үүсмэл ордыг ашиглуулах тохиолдолд уг гуравдагч этгээдтэй үүсмэл орд ашиглах тухай гэрээ байгуулж, энэ гэрээний талаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 14 хоногийн дотор мэдэгдэнэ.</p> <p>26.11.Энэ хуулийн 26.10-д заасан гэрээ, үүсмэл ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн дүгнэлт, шийдвэрийг үндэслэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаатайгаар олгоно.”</p> <p><b>47<sup>3</sup> дугаар зүйл:</b></p> <p><b>“47<sup>3</sup> дугаар зүйл.Үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр</b></p> <p>47<sup>3</sup>.1.Үүсмэл ордоос олборлосон бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2.5 хувь, энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү байна.</p> <p>47<sup>3</sup>.2.Энэ хуулийн 47<sup>3</sup>.1-д заасныг үл харгалзан алтанд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг энэ хуулийн 47.4, 47.5-д заасны дагуу ногдуулна.</p> <p>47<sup>3</sup>.3.Энэ хуулийн 47<sup>3</sup>.1, 47<sup>3</sup>.2-т заасан борлуулалтын үнэлгээг энэ хуулийн 47.2-т заасан зарчмаар тодорхойлно.”</p> <p><b>48 дугаар зүйлийн 48.13, 48.14 дэх хэсэг:</b></p> <p>“48.13.Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд ажлын төлөвлөгөөг энэ хуулийн 48.6.2-т, тухайн жилийн ажлын тайланг 48.1.2-т заасан</p>

		<p>хугацаанд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.</p> <p>48.14.Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 47<sup>3</sup> дугаар зүйлд заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг энэ хуулийн 48.9-т заасны дагуу татварын албанд тушааж 48.10-т заасны дагуу холбогдох мэдээллийг нийтэд мэдээлнэ.”</p> <p><b>53 дугаар зүйлийн 53.6 дахь хэсэг:</b></p> <p>“53.6.Тусгай зөвшөөрөл дуусгавар болсон талбайд үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсгийн "ашиглалтын тусгай зөвшөөрөл" гэсний дараа “болон үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл” гэж, 56 дугаар зүйлийн 56.7 дахь хэсгийн “ашиглалтын” гэсний дараа “болон үүсмэл орд ашиглах” гэж нэмсүгэй.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалтын "үүсмэл ордын" гэснийг хассугай.</p>
27.	2016-12-01 Төрийн болон албаны нууцын тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.	Ашигт малтмалын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсгийн “Төрийн нууцын тухай” гэснийг “Төрийн болон албаны нууцын тухай” гэж өөрчилсүгэй.
28.	2017-05-18 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.	Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.10 дахь хэсгийн “улсын байцаагчийн актаар” гэснийг “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу” гэж өөрчилсүгэй.
29.	2017-11-10 Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.	<p>Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:</p> <p><b>49 дүгээр зүйлийн 49.4.8 дахь заалт:</b></p> <p>“49.4.8.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.14 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу тооцсон үнэ, тайлбар, танилцуулга.”</p> <p><b>49 дүгээр зүйлийн 49.12 дахь хэсэг:</b></p> <p>“49.12.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-т заасан эцсийн эзэмшигч ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шууд бусаар шилжүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 49.4.8-д заасан баримт бичгийг харьяа татварын албанд шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор мэдэгдэнэ.”</p> <p><b>56 дугаар зүйлийн 56.1.9, 56.1.10, 56.1.11 дэх заалт:</b></p> <p>“56.1.9.Энэ хуулийн 49.1, 49.2, 49.3-т заасныг зөрчиж тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн бол;</p> <p>56.1.10.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 49.4.8, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.11, 16.14-д заасан аргачлалын дагуу холбогдох татварыг тайлагнаагүй, эсхүл үнэлгээ тооцоход шаардагдах мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан, худал мэдүүлж тайлагнасан;</p> <p>56.1.11.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11.1.12, 15.2.10, Татварын ерөнхий хуулийн 18.1.14-т заасны дагуу холбогдох байгууллагад үнэн зөв мэдээлээгүй бол.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хуулийн этгээдэд” гэсний дараа “энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгон шалгаруулалтын журмаар” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.11 дэх заалтын “хайгуулын” гэсний дараа “болон энэ хуулийн 24.1-т</p>



	<p>зааснаас бусад тохиолдолд ашиглалтын” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “26.9” гэсний дараа “, 60.9-д” гэж, 49 дүгээр зүйлийн 49.6.1 дэх заалтын “шалтгаангүй” гэсний дараа “бөгөөд холбогдох татварыг төлсөн тухай татварын алба тодорхойлолт гаргасан” гэж тус тус нэмсүгэй.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p><b>11 дүгээр зүйлийн 11.1.25 дахь заалт:</b></p> <p>“11.1.25.энэ хуулийн дагуу ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сонгон шалгаруулалтын талбайг солбицлоор тодорхойлох, батлуулах.”</p> <p><b>17 дугаар зүйл:</b></p> <p><b>“17 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шалгаруулалтын талбайг ялгах</b></p> <p>17.1.Энэ хуулийн 11.1.25-д заасны дагуу төрийн захиргааны байгууллага нь талбайн солбицлыг тодорхойлохдоо тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд талбайн зургийг хавсаргана.</p> <p>17.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 17.1-д заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч, 45 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасан үндэслэлээр татгалзсан хариу өгч болно.</p> <p>17.3.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг энэ хуулийн 17.2-т заасны дагуу ирүүлсэн зөвшөөрсөн санал болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.</p> <p>17.4.Энэ хуулийн 17.3-т заасны дагуу Засгийн газраас баталсан талбайн солбицлын хүрээнд төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг ялгаж, сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.</p> <p>17.5.Энэ хуулийн 17.4-т заасны дагуу ялгасан талбай нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>17.5.1.дөрвөн өнцөгт хэлбэртэй байх бөгөөд түүний хил нь уртраг, өргөргийн дагуух чиглэлтэй давхацсан шулуун шугамаар хүрээлэгдсэн байх;</p> <p>17.5.2.тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газар, нөөцөд авсан талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй байх;</p> <p>17.5.3.хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй байх.</p> <p>17.6.Энэ хуулийн 17.5.2, 17.5.3-т заасан давхцал гаргахгүйн тулд хүсэлтэд дурдсан талбайн дараах газар нутаг, талбайтай хиллэж байгаа хэсэг нь шулуун шугам биш байж болно:</p> <p>17.6.1.улсын хил;</p> <p>17.6.2.нөөцөд авсан талбай;</p> <p>17.6.3.тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газар;</p> <p>17.6.4.энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө олгогдсон тусгай зөвшөөрөлтэй бөгөөд энэ хуульд зааснаас өөр хэлбэр, байршил</p>
--	--



	<p>бүхий талбай;</p> <p>17.6.5.хайгуулын талбайд хамруулах боломжгүй гэж үзсэн нуур, цөөрөм зэрэг байгалийн тогтоц.</p> <p>17.7.Нэг тусгай зөвшөөрлөөр олгох хайгуулын талбайн хэмжээ 25 гектараас багагүй, 150 мянган гектараас ихгүй байна.”</p> <p><b>18 дугаар зүйл:</b></p> <p><b>“18 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргах, түүнийг бүртгэх журам</b></p> <p>18.1.Энэ хуулийн 7.1-д заасан хуулийн этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ энэ хуулийн 10.1.2-т заасан журмын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана:</p> <p>18.1.1.тухайн хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, утас, факсны дугаар, цахим шуудангийн хаяг;</p> <p>18.1.2.тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;</p> <p>18.1.3.үйлчилгээний хөлс төлсөн баримт;</p> <p>18.1.4.мэргэжлийн боловсон хүчин болон техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан талаархи мэдээлэл, тухайн талбайд гүйцэтгэх хайгуулын ажлын төрөл, хэмжээ, хугацаа, өртөг болон байгаль орчныг хамгаалах ажилд зарцуулах зардал бүхий төсөл, төсөв болон холбогдох бусад баримт бичгийг нэгтгэсэн техникийн санал;</p> <p>18.1.5.төрийн захиргааны байгууллагын баталсан маягтын дагуу үйлдэж, битүүмжилж ирүүлсэн үнийн санал;</p> <p>18.1.6.Монгол Улсад татвар төлөгчөөр бүртгүүлсэн тухай татварын албаны тодорхойлолт;</p> <p>18.1.7.Энэ хуулийн 10.1.2-д заасан журамд заасан бусад шаардлагатай баримт бичиг.”</p> <p>18.2.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 18.1-д заасан хүсэлтийг хүлээн авмагц доор дурдсан ажиллагааг явуулна:</p> <p>18.2.1.хүсэлтийг бүртгэлийн дэвтэрт бүртгэж, он, сар, өдөр, цаг, минут, бүртгэлийн дугаарыг тэмдэглэж, энэ тухай тодорхойлолтыг хүсэлт гаргасан этгээдэд өгөх;</p> <p>18.2.2.тухайн өдөр хамгийн түрүүнд болон сүүлд бүртгэгдсэн хүсэлтэд тусгай тэмдэглэгээ хийх.”</p> <p><b>20 дугаар зүйл:</b></p> <p><b>“20 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион байгуулах, тусгай зөвшөөрөл олгох</b></p> <p>20.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 10.1.2-д заасан журмын дагуу зохион байгуулж, доор дурдсан ажиллагааны аль нэгийг гүйцэтгэнэ:</p> <p>20.1.1.хүсэлт гаргасан хуулийн этгээдийн техникийн болон үнийн саналд энэ хуулийн 10.1.2-д заасан журмын дагуу үнэлгээ өгч, хамгийн өндөр үнэлгээ авсан оролцогчид тусгай зөвшөөрөл олгох боломжтойг мэдэгдэх;</p> <p>20.1.2.хэрэв 2 болон түүнээс дээш оролцогч адил үнэлгээ авсан бол хүсэлтээ хамгийн түрүүнд бүртгүүлсэн оролцогчид тусгай зөвшөөрөл олгох боломжтойг мэдэгдэх.</p> <p>20.1.3.хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 18.1-д заасан шаардлага хангаагүй бол сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй үндэслэл, шалтгааныг хүсэлтэд хавсаргасан</p>
--	--

		<p>баримт бичгийн хамт хүсэлт гаргасан хуулийн этгээдэд хүргүүлнэ.</p> <p>20.2.Энэ хуулийн 20.1-д заасны дагуу сонгон шалгаруулалт зарласан боловч хүсэлт ирээгүй бол сонгон шалгаруулалтыг дахин зарлаж болно.</p> <p>20.3.Энэ хуулийн 20.1.1, 20.1.2-т заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой бол сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг мөн хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөх тухай мэдэгдлийг сонгон шалгаруулалтад шалгарсан хуулийн этгээдэд хүргүүлнэ.</p> <p>20.4.Энэ хуулийн 20.3-д заасны дагуу мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд тусгай зөвшөөрлийг авах боломжгүй тухайгаа мэдэгдсэн, эсхүл сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, эхний жилийн төлбөрийг төлөөгүй бол төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.1.1, 20.1.2-т заасан мэдэгдлийг хүчингүй болгож, хүсэлт гаргасан хуулийн этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.</p> <p>20.5.Сонгон шалгаруулалтад шалгарсан хуулийн этгээд эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлсөн бол төрийн захиргааны байгууллага ажлын 3 өдөрт багтаан хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, хайгуулын тусгай зөвшөөрөл болон олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.</p> <p>20.6.Хайгуулын тусгай зөвшөөрөлд түүнийг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр, олгогдсон талбайн булангийн цэгийн солбицлуудыг тэмдэглэх бөгөөд уг тусгай зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна.</p> <p>20.7.Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.”</p> <p><b>24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:</b></p> <p>“24.2.Энэ хуулийн 24.1-д зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгохдоо энэ хуулийн 18 дугаар зүйл, 20.1-д заасан журмыг нэгэн адил баримтална.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтын “энэ хуулийн 19.12,” гэснийг “улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбай болон энэ хуулийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.16 дахь заалтын “хүссэн” гэснийг “олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “геологи, уул уурхай” гэснийг “үндэсний геологи” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “19.6” гэснийг “20.3” гэж тус тус өөрчилсүгэй.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “19.12,” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтын “үндэсний” гэснийг, 11.1.13 дахь заалтын “улсын төсвийн хөрөнгөөр илрүүлсэн эрдсийн хуримтлал бүхий талбайд” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.16 дахь заалтын “шийдвэрлэх” гэснийг, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “, 24.2” гэснийг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “, 24.2” гэснийг тус тус хассугай.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.</p>
30.	2018-06-21 Эд хөрөнгийн эрхийн улсын	Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

	<p>бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж нэмэлт орсон.</p>	<p><b>26 дугаар зүйлийн 26.12 дахь хэсэг:</b>  “26.12.Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд газар ашиглах эрхээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.”</p> <p><b>27 дугаар зүйлийн 27.1.14 дэх заалт:</b>  “27.1.14.газар ашиглах эрхээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байх.”</p> <p><b>49 дүгээр зүйлийн 49.13 дахь хэсэг:</b>  “49.13.Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авсан этгээдийн газар ашиглах эрх нь эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.”</p>
<p>31.</p>	<p>2019-03-26  Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:</p> <p><b>47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсэг:</b>  “47.12.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь энэ хуулийн 47.3.2-т заасан хувь хэмжээгээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тушаасан алтны борлуулалтын үнэлгээнээс суутган авч, улсын төсөвт шилжүүлнэ.”</p> <p><b>47 дугаар зүйлийн 47.13 дахь хэсэг:</b>  “47.13.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь энэ хуулийн 47.12-д заасны дагуу төсөвт шилжүүлсэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан, мэдээг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу дараа сарын 20-ны өдрийн дотор тус байгууллагад хүргүүлнэ.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p><b>47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг:</b>  “47.1.Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.”</p> <p><b>47 дугаар зүйлийн 47.3.2 дахь заалт:</b>  “47.3.2.Энэ хуулийн 47.3.1-т зааснаас бусад төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн доод хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5,0 хувь, Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд тушаасан алтанд ногдох энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү.”</p> <p><b>47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсэг:</b>  “47.7.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хүдэр, баяжмал, бүтээгдэхүүнд давхардуулахгүйгээр ногдуулна.”</p> <p><b>47 дугаар зүйлийн 47.10, 47.11 дэх хэсэг:</b>  “47.10.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээдээс бусад энэ хуулийн 47.1-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн ашигт малтмалд ногдох тухайн сарын төлбөрийг дараагийн сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайлангаар хийсэн эцсийн тооцоогоо дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор төсөвт төлнө.</p>

		<p>47.11.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээдээс бусад энэ хуулийн 47.1-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь тухайн улиралд олборлож худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан ашигт малтмалын тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээ, төлбөрийн нийт хэмжээг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу улирал тутам өссөн дүнгээр гаргаж, улирлын тайланг дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “ аргачлалыг” гэснийг “, тайлагнах, төлөх журмыг” гэж, мөн зүйлийн “47.12” дахь хэсгийн дугаарыг “47.14” гэж, “47.13” дахь хэсгийн дугаарыг “47.15” гэж тус тус өөрчилсүгэй.</p>
32.	<p>2019-03-22 Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ -ийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.</p>	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “санхүүгийн байгууллагад” гэсний дараа “, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн татварын өрийг хураах зорилгоор татварын албанд” гэж нэмсүгэй.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p><b>49 дүгээр зүйлийн 49.12 дахь хэсэг:</b></p> <p>“49.12.Татварын ерөнхий хуулийн 6.1.48-д заасан эцсийн эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд энэ хуулийн 49.4.8-д заасан баримт бичгийг Татварын ерөнхий хуулийн 26.10, 26.11, 26.12-д заасны дагуу харьяа татварын албанд мэдэгдэнэ.”</p> <p><b>56 дугаар зүйлийн 56.1.11 дэх заалт:</b></p> <p>“56.1.11.Татварын ерөнхий хуулийн 26.10, 26.11, 26.12-т заасны дагуу холбогдох байгууллагад үнэн зөв мэдээлээгүй бол.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4.8 дахь заалтын “16.14 дэх” гэснийг “18.8, 30.6 дахь” гэж, 56 дугаар зүйлийн 56.1.10 дахь заалтын “16.11, 16.14” гэснийг “18.8, 30.6” гэж тус тус өөрчилсүгэй.</p>
33.	<p>2019-05-02 Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.</p>	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p>“56.1.5.тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан;”</p>
34.	<p>2019-11-22 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	<p>“47.16.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь доор дурдсан үйл ажиллагаанд бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 47.7-д заасны дагуу давхардуулалгүй ногдуулж улсын төсөвт төлнө:</p> <p>47.16.1.худалдсан, худалдахаар ачуулсан;</p> <p>47.16.2.экспортолсон;</p> <p>47.16.3.өөрийн хэрэгцээнд ашигласан.</p> <p>47.17.Нүүрс, нүүрсний бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 47.3.3-т заасан хувь дээр тухайн бүтээгдэхүүний нэр төрөл, зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч доор дурдсан хувийг нэмэгдүүлж тооцно:</p>

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар/	Үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь
1	Боловсруулаагүй нүүрс	тн	Нүүрс	0-25 хүртэл	0.00
				25-50 хүртэл	1.00
				50-75 хүртэл	2.00
				75-100 хүртэл	3.00
				100-125 хүртэл	4.00
				125 ба түүнээс дээш	5.00
2	Баяжуулсан нүүрс (хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн)	тн	Нүүрс	0-100 хүртэл	0.00
				100-130 хүртэл	1.00
				130-160 хүртэл	1.50
				160-190 хүртэл	2.00
				190-210 хүртэл	2.50
				210 ба түүнээс дээш	3.00
3	Эцсийн бүтээгдэхүүн (хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн)	тн	Кокс	0-160 хүртэл	0.00
				160-190 хүртэл	0.50
				190-210 хүртэл	1.00
				210-240 хүртэл	1.50
				240-270 хүртэл	2.00
				270 ба түүнээс дээш	2.50

47.18.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон ашигт малтмал дамжуулан борлуулсан этгээд ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан тухай бүр татварын хууль тогтоомжид заасан төлбөрийн баримт үйлдэх бөгөөд уг төлбөрийн баримтад ашигт малтмалын нэр төрөл, ангилал, тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээ, ногдуулсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн дүнг тусгасан байна.

47.19.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй этгээдээс ашигт малтмал худалдан авсан энэ хуулийн 47.1.3-т зааснаас бусад төлбөр төлөгч нь худалдан авсан ашигт малтмалд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг суутган авах бөгөөд 47.10, 47.11-д заасны дагуу тайлагнаж төсөвт төлнө.”

Ашигт малтмалын тухай хуулийн 47.8 дахь хэсгийн “47.5” гэсний дараа “, 47.17” гэж нэмсүгэй.

Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар

	<p>өөрчлөн найруулсугай:</p> <p><b>47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг:</b></p> <p>“47.1.Доор дурдсан этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байна:</p> <p>47.1.1.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч;</p> <p>47.1.2.ашигт малтмал экспортолсон этгээд;</p> <p>47.1.3.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд.”</p> <p><b>47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсэг:</b></p> <p>“47.3.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг дараах хэмжээгээр ногдуулна:</p> <p>47.3.1.олборлож өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан нүүрсний нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2.5 хувь;</p> <p>47.3.2.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд худалдсан алтанд ногдох нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 5.0 хувь байх бөгөөд энэ хуулийн 47.5-д заасан хувиар нэмэгдүүлж тооцохгүй;</p> <p>47.3.3.энэ хуулийн 47.3.1, 47.3.2-т зааснаас бусад бүх төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5.0 хувь.”</p> <p><b>47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг:</b></p> <p>“47.6.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журмыг Засгийн газар батална.”</p> <p><b>47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсэг:</b></p> <p>“47.7.Ашигт малтмалыг шууд, эсхүл ашигт агуулгыг нэмэгдүүлэн баяжмал, бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлоход төлбөрийг давхардуулан ногдуулахгүй бөгөөд тухайн ашигт малтмалд төлбөр ногдуулах үнэлгээ, хувь хэмжээнээс хамаарч энэ хуулийн 47.18-д заасан төлбөрийн баримт, 47.19-д заасны дагуу суутган ногдуулсан тайланг үндэслэн өмнө нь ногдуулсан төлбөрийг хасаж тооцно.”</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 47.2 дахь хэсгийн “47.1” гэснийг “47.16” гэж, 47.5 дахь хэсгийн “47.4-т заасан нэмэлт төлбөрийн хувийг дараах байдлаар тодорхойлно:” гэснийг “47.3.3-т заасан хувь дээр тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч доор дурдсан хувийг нэмэгдүүлж тооцно:” гэж, 47.11 дэх хэсгийн “этгээдээс” гэснийг “хувь хүнээс” гэж, 47.14 дэх хэсгийн “биржийн нэрийг” гэснийг “биржийн, зах зээлийн үнийн эх сурвалжийн нэрийг” гэж тус тус өөрчилсүгэй.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>3</sup> дугаар зүйлийн 47<sup>3</sup>.2 дахь хэсгийн “47.4,” гэснийг хассугай.</p>
--	--

Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д 2008-2019 онуудад нийтдээ 34 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд үүнээс 26 удаад нь бусад хуулийг дагаж өөрчлөгдсөн байна. Тус хуульд дараах хуулиудыг дагаж нэмэлт, өөрчлөлт оржээ. Үүнд:

1. 2008-12-19 “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” УИХ-ын 43-р тогтоолоор Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт орсон. (Энэ тогтоол нь одоо хүчингүй бөгөөд хамгийн сүүлд 2020 оны 07 сарын 07 өдрийн 07 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан)



2. 2009-07-16 Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж нэмэлт орсон.
3. 2009-07-16 Цөмийн энергийн тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.
4. 2010-07-01 Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.
5. 2011-02-10 Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж өөрчлөлт орсон.
6. 2011-12-23 Төсвийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдахад дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.
7. 2012-05-17 Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг дагаж нэмэлт орсон.
8. 2012-05-17 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.
9. 2013-10-03 Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.
10. 2014-01-09 Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.
11. 2014-05-15 Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ыг дагаж нэмэлт орсон.
12. 2014-07-01 Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж нэмэлт орсон.
13. 2015-01-23 Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.
14. 2015-02-13 Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.
15. 2015-02-18 Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан тул дагаж нэмэлт орсон.
16. 2015-12-04 Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж өөрчлөлт орсон.
17. 2015-06-04 Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.
18. 2016-02-04 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж нэмэлт орсон.
19. 2016-02-04 Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж өөрчлөлт орсон.
20. 2016-11-10 Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.
21. 2016-12-01 Төрийн болон албаны нууцын тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.
22. 2017-05-18 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.
23. 2017-11-10 Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.
24. 2018-06-21 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж нэмэлт орсон.

25. 2019-03-22 Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж нэмэлт, өөрчлөлт орсон.
26. 2019-05-02 Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон.

Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д 2008, 2013, 2018 онуудад тус бүр 1 удаа, 2010, 2011, 2012, 2017 онуудад тус бүр 2 удаа, 2009, 2016, 2019 онуудад тус бүр 4 удаа, 2014 онд 5 удаа, 2015 онд хамгийн их буюу 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Нэмэлт, өөрчлөлтийн тоо оноор (2008-2019 он)

	<b>Он</b>	<b>Нэмэлт, өөрчлөлтийн тоо</b>
1.	2008	1
2.	2009	4
3.	2010	2
4.	2011	2
5.	2012	2
6.	2013	1
7.	2014	5
8.	2015	6
9.	2016	4
10.	2017	2
11.	2018	1
12.	2019	4
	<b>НИЙТ</b>	<b>34</b>

## ХОЁР. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙГ ДАГАЖ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХУУЛИУД

Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга) 2008-2019 онуудад ихэнх тохиолдолд (26 удаа) бусад хуулийг дагаж өөрчлөгдсөн бөгөөд хуульд өөрт нь 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Уг нэмэлт, өөрчлөлтүүд дараах онуудад хийгджээ.

1. 2009-10-15 Ашигт малтмалын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосон.
2. 2009-01-08 Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулсан
3. 2010-11-25 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.
4. 2014-01-24 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.
5. 2014-07-01 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.
6. 2015-02-18 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт орсон.
7. 2019-03-26 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.
8. 2019-11-22 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.

Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж дараах хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон байна.

### Хүснэгт 4. Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж өөрчлөгдсөн хуулиуд (2008-2019 онуудад)

	Хуулийн нэр, огноо	Нэмэлт, өөрчлөлт
<b>2009-10-15 Ашигт малтмалын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсон тооцох тухай хуулийг дагаж өөрчлөгдсөн хуулиуд</b>		
1.	2009-10-30 Татварын ерөнхий хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай	Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.
2.	2009-10-30 Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “тохиолдсон, эсхүл зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд заасан ашигт малтмалын дэлхийн зах зээл дэх үнэ огцом буурснаас” гэснийг “тохиолдсоны улмаас” гэж өөрчилсүгэй. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалтын “3.2.1,” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “, 8.2” гэснийг тус тус хассугай. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3.	2009-10-30 Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн зарим, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай <i>/Энэ хуулийн нэрийн хэсэгт 2009 оны 11 дүгээр сарын 25-ны</i>	Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай. <i><u>/Энэ зүйлд 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u></i>

	<u>өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u>	
4.	2009-10-30 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.14 дэх заалтын “болон зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн” гэснийг хассугай.
<b>2014-07-01 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад дагаж өөрчлөгдсөн хуулиуд</b>		
1.	2014-07-01 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “газар,” гэсний дараа “эртний ургамал, амьтны чулуужсан үлдэгдэл, давхаргазүйн тулгуур зүсэлт зэрэг эрдэс чулуулгийн ховор олдвор,” гэж нэмсүгэй.
2.	2014-07-01 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын дагуу байгуулсан ашиглалтын өмнөх гэрээг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын хугацаанд уг хуульд заасан журмын дагуу шинэчлэн бүртгэж, гэрээний хугацаанд хүчинтэйд тооцож тухайн үед мөрдөж байсан хуулийн дагуу төлбөр төлнө.
3.	2014-07-01 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай	2012 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Ашигт малтмалын хайгуулын зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.
<b>2019-11-22 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад дагаж өөрчлөгдсөн орсон хуулиуд</b>		
1.	2019-11-22 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	<b>2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд ашигт малтмалыг өөрийн хэрэгцээнд ашигласан, худалдсан, экспортолсон, эсхүл худалдахаар ачуулсан доор дурдсан этгээд нь 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу энэ хугацаанд хамаарах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцож улсын төсөвт төлнө:</b> 1.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч; 1.2. Ашигт малтмал экспортолсон этгээд; 1.3. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд.

#### **ГУРАВ. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙГ ДАГАЖ БАТЛАГДСАН ЖУРМУУД**

2007, 2010, 2014, 2015, 2017-2020 онуудад Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-тай холбоотой дараах журмууд батлагдсан гарсан.

**Хүснэгт 5. Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж  
батлагдсан журмууд**

	<b>Журмын нэр, эх сурвалж</b>	<b>Журам батлах үндэслэл</b>
1.	<b>Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам</b> (Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдөр 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт)  <a href="https://www.legalinfo.mn/annex/?lawid=2622">https://www.legalinfo.mn/annex/?lawid=2622</a>	Ашигт малтмалын тухай хуулийн 7.5, 60.8-д заасныг үндэслэн батлагдсан.
2.	<b>Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх журам</b> (Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 281 дүгээр тогтоол)  <a href="https://www.legalinfo.mn/law/details/2368">https://www.legalinfo.mn/law/details/2368</a>	Ашигт малтмалын тухай хуулийн 46.1, 46.2, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн батлагдсан.
3.	<b>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам</b> (Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын хавсралт)  <a href="https://www.legalinfo.mn/annex/details/6282?lawid=9859">https://www.legalinfo.mn/annex/details/6282?lawid=9859</a>	“Ашигт малтмалын тухай” хуулийн 39.8, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь хэсгийг үндэслэн батлагдсан.
4.	<b>Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар</b> (Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын хавсралт)  <a href="https://www.legalinfo.mn/annex/details/6899?lawid=11330">https://www.legalinfo.mn/annex/details/6899?lawid=11330</a>	Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.17 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн батлагдсан.
5.	<b>Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам</b> (Уул уурхайн сайдын 2015 оны 06 дугаар сарын 12- ны өдрийн 108 дугаар тушаалын хавсралт)  <a href="https://www.legalinfo.mn/law/details/11117">https://www.legalinfo.mn/law/details/11117</a>	Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 38, 41 дүгээр зүйлийг тус тус үндэслэн батлагдсан.
6.	<b>Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам</b> (Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 61 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт)  <a href="https://www.legalinfo.mn/annex/details/7693?lawid=12558">https://www.legalinfo.mn/annex/details/7693?lawid=12558</a>	Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.14, 9.1.15, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.22-т тус тус заасныг үндэслэн батлагдсан.
7.	<b>Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам</b> (Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 61 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт)  <a href="https://www.legalinfo.mn/annex/details/7694?lawid=12558">https://www.legalinfo.mn/annex/details/7694?lawid=12558</a>	Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.14, 9.1.15, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.22-т тус тус заасныг үндэслэн батлагдсан.
8.	<b>Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам</b> (Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 151 дүгээр тогтоолын хавсралт)  <a href="https://www.legalinfo.mn/annex/details/7870?lawid=12681">https://www.legalinfo.mn/annex/details/7870?lawid=12681</a>	Ашигт малтмалын тухай хуулийн 3.2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22.1.3-т заасныг тус тус үндэслэн батлагдсан.
9.	<b>Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам</b> (Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/19 дугаар тушаалын хавсралт)	Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.15 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Монгол Улсын Яамны эрх

	<a href="https://www.legalinfo.mn/annex/details/8250?lawid=13183">https://www.legalinfo.mn/annex/details/8250?lawid=13183</a>	зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалтыг тус тус үндэслэн батлагдсан.
10.	<b>Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам</b> (Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалын хавсралт)  <a href="https://www.legalinfo.mn/annex/details/8251?lawid=13184">https://www.legalinfo.mn/annex/details/8251?lawid=13184</a>	Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн батлагдсан.
11.	<b>Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам</b> (Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалын хавсралт)  <a href="https://www.legalinfo.mn/law/details/13224">https://www.legalinfo.mn/law/details/13224</a>	Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, Засгийн газрын 2018 оны “Журам батлах эрх олгох тухай” 14 тоот тогтоолыг тус тус үндэслэн батлагдсан.  <i>УУХҮС-ын 2020 оны А/16 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.</i> <a href="https://www.legalinfo.mn/additional/details/3716?lawid=13224">https://www.legalinfo.mn/additional/details/3716?lawid=13224</a>
12.	<b>Уурхай, уулын болон баяжуулах, үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам</b> (Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/16 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт)  <a href="https://www.legalinfo.mn/annex/details/9372?lawid=14119">https://www.legalinfo.mn/annex/details/9372?lawid=14119</a>	Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн батлагдсан.
13.	<b>Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам</b> (Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт)  <a href="https://www.legalinfo.mn/annex/details/10253?lawid=14752">https://www.legalinfo.mn/annex/details/10253?lawid=14752</a>	Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын 3.6.3 дахь заалт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн батлагдсан.
14.	<b>Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн маягт /т-15/-ыг нөхөх заавар</b> (Татварын ерөнхий газрын даргын тушаал 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, Дугаар А/164, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн маягт /ТТ-15/-ын 10 дугаар хавсралт)  <a href="https://www.legalinfo.mn/law/details/14695">https://www.legalinfo.mn/law/details/14695</a>	Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.10, 47.11 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 27 <sup>1</sup> дугаар зүйлийн 27 <sup>1</sup> .6.2, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 342 дугаар тогтоолоор батлагдсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ыг тус тус үндэслэн батлагдсан.
15.	<b>Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам</b> (Уул уурхай, хүнд	Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.12 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь



	<p>үйлдвэрийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/205 дугаар тушаалын хавсралт)</p> <p><a href="https://www.legalinfo.mn/annex/details/10183?lawid=14720">https://www.legalinfo.mn/annex/details/10183?lawid=14720</a></p>	хэсгийг тус тус үндэслэн батлагдсан.
16.	<p><b>Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам</b> (Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 465 дугаар тогтоолын хавсралт)</p> <p><a href="https://www.legalinfo.mn/annex/details/10505?lawid=14989">https://www.legalinfo.mn/annex/details/10505?lawid=14989</a></p>	Ашигт малтмалын тухай хуулийн 47.6, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн батлагдсан.
17.	<p><b>Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам</b> (Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр А-341 дүгээр тушаалын хавсралт)</p> <p><a href="https://www.legalinfo.mn/annex/details/11446?lawid=15851">https://www.legalinfo.mn/annex/details/11446?lawid=15851</a></p>	Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.16 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн батлагдсан.

Agarshilabiminsubitsamirginbssomilshirahmanrahim

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### УИХ-ын Тамгын газрын архивын материал

- Д-7, ХН-251 Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг
- Д-7, ХН-798 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг
- Д-8, ХН-837 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг
- Д-8, ХН-863 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг
- Д-8, ХН-1417 Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг
- Д-8, ХН-1380 Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг
- ХН-1687 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг
- Д-8, ХН-1401 Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг
- ХН-543 Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн хувийн хэрэг. Боть-10
- Д-7, ХН-1336 Төсвийн тухай хуулийн хувийн хэрэг. Боть-2
- Д-9, ХН-43, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийг дагалдан гарсан хууль, тогтоолын хувийн хэрэг, Боть-8

### Хуулийн сан

- УИХ-ын Тамгын газрын дотоод сүлжээний хуулийн сан
- [www.Legalinfo.mn](http://www.Legalinfo.mn)
- <https://mrapam.gov.mn/article/44/>
- <http://www.mmhi.gov.mn/public/files/id/7>

